ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ - 2016

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ - 2016

- 2017 оны 01 дүгээр сарын 12-13-ны өдөр
- ШУТИС-ийн ШУТТ Номын сангийн 604-н тоот хурлын танхим

Зохион байгуулагч:	ШУТИС-ийн БуХС-ийн Хүмүүнлэгийн салбар
Оролцогч байгууллагууд:	Шинжлэх Ухааны Академийн Түүх, Археологийн хүрээлэн
	МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхим
	Монголын Үндэсний Музей
	Улаанбаатарын Их Сургууль
	Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах Олон Улсын Хүрээлэн
	СУИС-ийн СУС-ын хүрээлэн
	Соёлын Өвийн Төв
	Ховд Их Сургууль

Улаанбаатар хот
2017 он

МОНГОЛЫН АРХЕОЛОГИ - 2016 ОН

Ерөнхий редактор:	Ю.Болдбаатар
Эрхлэн нийтлүүлсэн:	Л.Эрдэнэболд
Хэвлэлд бэлтгэсэн:	С.Бат-Эрдэнэ
Хэвлэлийн дизайнер:	С.Бат-Эрдэнэ
Цаасны хэмжээ:	176x250
Хэвлэлийн хуудас:	15,0 хх
Хэвлэсэн тоо	300 ш

ГАРЧИГ

Өмнөх үг

Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Н.Звинс,
Д.Базаргүр, П.Чарьлз, Д.Одсүрэн, Г.Ангарагдөлгөөн
Монгол-Америкийн хамтарсан төслийн 2016 хээрийн судалгааны үр дүн

Д.Одсүрэн, Б.Гүнчинсүрэн, М.Масойч,
Ю.Шикүлски, Г.Одпүрэв, Н.Энхтайван
Арц Богдын нурууны өвөр биед хийсэн чулуун зэвсгийн хайгуул судалгаа

Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Янз, А.Розен
"Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа" төслийн 2016 оны хээрийн шинжилгээний ажлын үр дүн

Я.Цэрэндагва, Ж.Шнейдер, А.Розен, Р.Коннорс, С.Далантай,
Ж.Фаркухар,П.Хадел, Р.Төрбат, С.Гиллиланд, Р.Чиолек-Торелло, Г.Олзбаяр
Монгол-Америкийн хамтарсан экспедици: Их Нартын Байгалийн нөөц газарт хийсэн археологийн судалгаа

Я.Цэрэндагва, Р.Төрбат, С.Далантай
Төв аймгийн Лүн сумын нутагт эртний судлалын хайгуул хийсэн тухай

Д.Хатанбаатар, Ц.Цэцэгжаргал, Д.Түмэн
"Дорнод Монгол" төслийн хүрээнд 2016 онд хийж гүйцэтгэсэн археологийн судалгаа

Ц.Амгалантөгс, Мияамото Казуо,
Н.Эрдэнэ-Очир, Л.Дэлгэрмаа, Л.Ишцэрэн
Монгол-Японы хамтарсан "Эртний Монгол хүн" төслийн хээрийн шинжилгээний ангийн товч үр дүн

Б.Цогтбаатар, Л.Ишцэрэн, Г.Батболд,
Э.Амарболд, Н.Ширайши, Т.Миякэ, Т.Сасада
Монгол-Японы хамтарсан "Шинэ зуун" төслийн 2016 оны хээрийн шинжилгээний ажлын товч үр дүн

Б.А.Базаров, Д.А.Миягашев
Новый этап исследований в хуннской археологии бурятии

Д.А.Миягашев. Б.А.Базаров
Место нахождение в пади Липовка – новый памятник Хунну в западном Забайкалье

Ю.Болдбаатар, Я.Цэрэндагва, Р.Төрбат
Улаанчулуутын руни бичээсүүд

С.Өлзийбаяр, Б.Очир, Г.Одмагнай
"Онон - 2016" хээрийн судалгааны урьдчилсан үр дүнгээс

Ю.Болдбаатар, Д.Хатанбаатар, С.Бат-Эрдэнэ, Ц.Бямба-Очир
Сарын гэзгийн Ханан, Ташгайн хадны зургийн танилцуулга

Ж.Гантулга, Г.Лхүндэв, Ж.Магай, К.Салисис
Монгол-Монакогийн хамтарсан "Хойд Тамир-Хүнүй" төслийн 2016 оны хээрийн судалгааны ажлын товч үр дүн

Ч.Мөнхбаяр, Г.Пүрэвдорж, Х.Бямбасүрэн, Б.Сүхбаатар
Үзүүр гялан, Цахир, Тошинтын хадны оршуулгын малтлага судалгааны урьдчилсан үр дүн

Г.Бүрэнтөгс, Б.Мягмарсүрэн
Үзүүр Гялангийн хадны оршуулга

Ц.Төрбат, Н.Баярхүү, С.Лепец, В.Бернард, А.Заззо
"Монгол Алтайн түрүү ба түүхэн үеийн оршин суугчдын цогц судалгаа" төслийн 2016 оны хээрийн шинжилгээний товч үр дүн

Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Е.П.Рыбин,
Д.Одсүрэн, А.М.Хаценович Г.Ангарагдөлгөөн, Г.Маргад-Эрдэнэ
Монгол-Оросын хамтарсан чулуун зэвсгийн судалгааны шинэ үр дүн

М.Эрдэнэ, Д.Хатанбаатар, Марк Хортон
"Хэрлэн голын сав газрын археологийн дурсгал" төслийн хүрээнд 2016 онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын товч үр дүн

Г.Эрэгзэн, С.Эрдэнэсувд, Б.Батдалай, Д.Мандах, С.Энхболд
Хэнтий аймгийн нутагт шинээр бүртгэсэн Хүннүгийн булш оршуулгын дурсгалт газрууд

Л.Эрдэнэболд, Ч.Ванчигдаш,
Ц.Бямба-Очир, З.Одбаяр, Г.Ариунболд
Бишрэлтийн Амны археологийн малтлага судалгааны урьдчилсан үр дүн

Г.Эрэгзэн
Шувуутайн хэрэм хэмээх дурсгалд шинээр хийсэн малтлага судалгааны үр дүнгээс

Г.Эрэгзэн, П.Алдармөнх, С.Энхболд
Чихэртийн зоо хэмээх хүннүгийн оршуулгын дурсгалт газарт хийгдсэн судалгааны үр дүн.

А. Очир, Б. Анхбаяр, Ж. Цамбагарав,
ЧэнЁнжи, Саранбилэг, ЧенФенпэй
Монгол- БНХАУ-ын хамтарсан археологийн судалгааны 2016 оны товч үр дүн

Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Л.Ишцэрэн,
Г.Галдан, П.Алдармөнх, Т.Сасада, И.Үсүки
2016 оны Монгол-Японы хамтарсан "Эртний монголчуудын үйлдвэрлэлийн түүх" төслийн хээрийн шинжилгээний ангийн товч үр дүн

Л.Эрдэнэболд, Ч.Ванчигдаш,
Д.Хатанбаатар, С.Бат-Эрдэнэ, С.Болормаа
Зүрхийн Үзүүрийн хүннүгийн дурсгалт газарт хийсэн археологийн малтлага судалгааны урьдчилсан үр дүн

Г.Эрэгзэн, П.Алдармөнх, С.Энхболд
Гуа-Довын дурсгалт газарт хийгдсэн байгалийн ухааны тандалт судалгаа ба шинээр илрүүлсэн археологийн дурсгалын тухай

Д.Цэвээндорж, А.Энхтөр, Д.Кыдырали, Б.Напил,
С.Далантай, К.Умиров, Ц.Буянхишиг, Н.Мөнхбат
Монгол-Казахстанийн хамтарсан "Шивээт Улааны археологийн дурсгалын малтлага судалгаа" экспедицийн 2016 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан

А.Очир, Л.Эрдэнэболд, Т.Мацукава, К.Мацуда, Х.Муроака
Монгол-Японы "Бичээс-2" төслийн үр дүн Халзан ширэг балгасны малтлага судалгаа

Ц.Баттулга, М.Эрдэнэ, Р.Мөнхтулга, Г.Батболд,
Б.Дашдорж, Ахмэт Ташагыл, Алпаслан Ашык, Адил Йылмаз
2016 онд Тоньюкукийн цогцолборт Монгол-Түркийн хамтарсан шинжилгээний ангийн гүйцэтгэсэн хээрийн судалгааны урьдчилсан үр дүн

Б.Цогтбаатар, Н.Эрдэнэ-Очир, Г.Лхүндэв,
Т.Осава, Д.Батдалай, Г.Ангарагдөлгөөн, Э.Амарболд
Монгол-Японы хамтарсан "Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа" төслийн 2016 оны малтлага судалгааны шинэ үр дүнгээс

Ц.Төрбат, Н.Батболд, Д.Батсүх
Жаргалантын Адгийн Ширээ, Рашааны Тээг ба Чулуут голд хийсэн хадны зургийн судалгаа

Ч.Амартүвшин, З.Батсайхан, Г.Галдан, Б.Батдалай,
Б.Бадма-Оюу, У.Ханичёрч, Ж.Врайт, Р.Нельсон
Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол археологийн хайгуул судалгаа” төслийн 2016 оны хээрийн судалгааны товч үр дүн

Л.Эрдэнэболд, Н.Н.Крадин,
А.Л.Ивлиев, С.А.Васютин, Р.Төгссайхан
“Монгол Улсын нутаг дахь хүннүгийн хот суурины судалгаа” төслийн 2016 оны археологийн малтлага судалгаа

У.Эрдэнэбат, К.Франкен, Т.Батбаяр, Х.Рооланд
Монгол-Германы “Орхон” экспедицийн 2016 оны хээрийн шинжилгээний товч дүнгээс

С.Чулуун, Ч.Энхтуул
"XVII зууны Монголын хотууд төсөл” Сарьдагийн хийд, Өвгөн хийдийн малтлага судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээс

Ц.Одбаатар, Ц.Эгиймаа
2016 онд айрагийн гозгорт явуулсан археологийн судалгааны танилцуулга

Д.Эрдэнэбаатар, Т.Идэрхангай, А.В.Варенов,
А.А.Ковалев, Э.Мижиддорж, Ж.Эрдэнэ, Б.Өнөрбаяр
Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Уу хөтлийн Цагаан толгой, Хүүшийн өвдөгт явуулсан археологийн малтлага судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээс

Ж.Баярсайхан, Жулиа Кларк,
Ч.Баяндэлгэр, Вильям Тэйлор, Т.Түвшинжаргал
Монгол-Америкийн хамтарсан “Умард Монгол” төслийн судалгааны танилцуулга

Б.Жаргалан, У.Гарднер
Монгол-Америкийн хамтарсан “Тарвагатайн хөндийн археологийн судалгаа” төслийн 2016 оны хээрийн шинжилгээний ангийн товч үр дүн

А.Очир, Ж.Цамбагарав
“Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн, угсаа гарлын цогц судалгаа” төслийн хүрээнд Босоогийн хонхорт явуулсан малтлага судалгааны товч үр дүн

Л.Эрдэнэболд, Р.Төгссайхан
“Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн, угсаа гарлын цогц судалгаа” төслийн 2016 оны хээрийн судалгааны урьдчилсан үр дүн

Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Б.Батдалай
Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн болон Монголчуудын угсаа гарлын цогц судалгаа” төсөл: Архангай, Өвөрхангай аймгийн нутагт хийсэн археологийн малтлага судалгааны товч үр дүн

Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү, Г.Энхбаяр
“Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн ба Монголчуудын угсаа гарлын цогц судалгаа” төслийн хүрээнд 2016 онд Төв аймгийн Мөнгөнморьт суманд хийсэн малтлагын үр дүнгээс

С.Өлзийбаяр, Б.Очир, Г.Одмагнай
“Монгол угсаатан бүрэлдсэн болон Монголчуудын гарал үүслийн цогц судалгаа” үндэсний төслийн хүрээнд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги Хэнтий, Дорнод аймгийн нутагт ажилласан хээрийн судалгааны урьдчилсан үр дүнгээс

Ж.Баярсайхан, Лукас Бартон,
Кристофер Морган, Т.Түвшинжаргал
Монгол-Америкийн хамтарсан “Увс нуурын сав дахь нэн эртний хүмүүсийн ахуй орчин” төслийн 2016 оны судалгааны товч үр дүн

Ч.Амартүвшин, Л.Ишцэрэн, Я.Муракамi
Ховд голын хөндийд хийсэн хайгуул судалгааны зарим үр дүнгээс

Г.Энхбат, Г.Анхсанаа, Б.Алтансүх
Соёлын өвийн төвөөс 2016 онд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын талаар явуулсан үйл ажиллагаа

З.Оюунбилэг, Г.Бүрэнтөгс, Б.Алтансүх,
П.Чинбат, Ж.Даваацэрэн, Г.Халиун, Кан Хён,
Т.Эрдэнэцогт, Пак Сон-Ху, Чон Чүн-Хуа, Ким Сон-Ми
Монгол-Солонгосын хамтарсан “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох барилга архитектурын дурсгалыг 3D-ээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах” төсөл: Архангай аймгийн Өлзийт сумын Өөлд бэйсийн хүрээ

М.Нямхүү, Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн
Газарзүйн мэдээллийн системийн технологийг археологийн судалгаанд ашиглан газрын зураг зохиох, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын үр дүнгээс

Г.Галдан, Б.Батдалай, Ч.Амартүвшин
Умард, Төв, Баруун бүсийн зарим нутгуудад археологийн мэдээ шалгасан тухай

Э.Мижиддорж, Д.Цэнд
Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн авран хамгаалах хайгуул судалгаа

Ж.Баярсайхан, Ц.Одбаатар, Ч.Баяндэлгэр, Т.Түвшинжаргал
МҮМ-н 2016 онд хийсэн археологийн авран хамгаалах судалгааны танилцуулга

Ч.Амартүвшин, Б.Батдалай, Д.Бөхчулуун
2016 онд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгээс зохион байгуулсан археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлын товч үр дүн

Н.Батболд, Д.Батсүх, Г.Энхбаяр
Монгол-Солонгосын хамтарсан "Соёлын өвийг судалж хамгаалах" төслийн 2016 оны хээрийн шинжилгээний ажлын үр дүн

Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Гантулга, У.Бросседер
Монгол-Германы хамтарсан "Баркор" төслийн 2016 оны хээрийн судалгааны ажлын товч үр дүн

А.Энхтөр, Я.Цэрэндагва, Д.Батсүх, Л.Мөнхбаяр, Т.Батбаяр,
Г.Батболд, Б.Эрдэнэ, Т.Хантөгс, С.Далантай, Б.Энхбаяр
"Баруун бүсийн босоо тэнхлэгийн автозамын хөгжлийн төсөл"-ийн хүрээнд гүйцэтгэсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны товч үр дүн

Б.Баатархүү, С.Өлзийбаяр, Б.Очир
ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, СУИС-ийн СУС-ын хүрээлэн хамтарсан "Хатны булгийн нууцаас" төсөл

Өмнөх үг

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Археологийн хээрийн судалгааны үр дүнг хэлэлцэх эрдэм шинжилгээний тайлангийн хурал Монгол улсын хэмжээнд археологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургууль, хүрээлэн, музей, соёлын өвийн төв зэрэг бүхий л байгууллагын эрдэм шинжилгээний нэгдсэн тайлангийн хурал болж өргөжиж байгаа нь судлаачид, судалгааны байгууллагуудын хувьд судалгааны үнэ цэнэтэй мэдээллээ солилцож, харилцан туршлагаасаа суралцах бодит нөхцлийг бүрэлдүүлэх болов. Энэ нь 2013-2015 онуудад "Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалыг авран хамгаалах малтлага судалгаа"-нд хамтран ажилласантай дүйхүйц Монголын шинжлэх ухааны байгууллагууд харилцан уялдаатай хөгжиж болохын нэг тод жишээ төдийгүй Монгол улсын түүх, археологийн судалгааны хөгжилд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болж байна.

"Монголын археологи – 2016" хурлыг ШУТИС-ийн БуХС-ийн Хүмүүнлэгийн салбар энэ удаа хариуцан зохион байгуулах болсон нь тус сургуулийн ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хийгдэж буй бүтээлч ажлуудын нэг болно.

2016 онд манай археологчдийн хийсэн хээрийн судалгаа нь Алтай таван Богдоос дорнын тал хүртэл, Хөвсгөлийн тайгаас өмнийн говь хүртэлх Эх орны өргөн уудам газар нутагт хуучин чулуун зэвсгийн доод үеэс, 18-р зуун хүртэлх олон үеийнхний булш оршуулга, тахилын байгууламж, бууц, хот суурин, сүм хийдийн туурийг малтлага судалгаа, хөшөө дурсгал, хадны зураг, бичээс нүүдэлчдийн аж ахуй, технологи, эд өлөг, материалын судлал, сэргээн засварлалт болон байгаль, цаг уур, хөрс, ургамал, амьтан зэрэг экосистемийн түүхэн өөрчлөлтийн чиглэлээр хийгдсэн байна.

Энэхүү эмхэтгэлд ирүүлсэн тайлангуудаас харахад манай судлаачдын судалгааны арга зүй жилээс жилд сайжирч, хамтран ажиллаж буй гадаад дотоодын эрдэмтэн судлаачдын мэдлэг, арга туршлагаас байнга суралцаж байгаа нь, судалгаандаа шинжлэх ухаан, технологийн орчин үеийн ололт амжилтыг бүтээлчээр ашиглах болсон, түүнчлэн хэрэгжүүлж буй төслүүдийн судалгаа нийгэм соёлын хүрээнээс хальж байгалийн шинжлэлийн олон ухааны уулзвар бэлчирт цогц байдлаар хийгдэх болсон шинэлэг хандлага ажиглагдаж байна.

"Монголын археологи-2016" эмхэтгэлд хэвлэгдэж буй тайлангуудын цөөнгүй нь шинжлэх ухааны нээлт болохуйц түвшинд асуудал дэвшүүлж байгаа нь бахархал төрүүлж байгаагийн зэрэгцээ олонх нь хийгдэж буй судалгааны явцын товч үр дүнгүүд учир цаашид тавьсан зорилгодоо хүрч өмнөх түүхийн бүрхэг ээдрээтэй олон асуудлуудын зангилааг тайлах түлхүүр болох, тэрчлэн цаашид дэвшигдэх олон олон онол таамаглалын эх үндсийг тавих шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой судалгаанууд болох нь эргэлзээгүй.

ШУТИС-ийн БуХС
Доктор(Ph.D), дэд профессор Ю.Болдбаатар

МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Н.Звинс, Д.Базаргүр,
П.Чарьлз, Д.Одсүрэн, Г.Ангарагдөлгөөн

Монгол-Америкийн хамтарсан "Төлбөр-16 дурсгалын малтлага: Монгол дахь дээд палеолитын эхлэл" төслийн хээрийн судалгааны ажлын хүрээнд өмнө жил сорьц малтлага хийсэн Шар хадны палеолитын суурингийн малтлагыг үргэлжлүүлэх, Хөвсгөл аймгийн зарим сумдын нутгаар чулуун зэвсгийн хайгуул хийх, Их Төлбөрийн голын палеолитын дурсгалт газруудын хөрсний дээж авахгэсэн гурван чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэсэн юм.

Малтлага судалгаа

Бидний судалгааны эхний чиглэл бол өмнө жил хийсэн Шар хадны палеолитын суурингийн малтлагыг үргэлжлүүлэх явдал юм. Сорьц малтлага хийсэн 2х1м-ийн хэмжээтэй хоёр талбайг хойш нь 1м-ээр сунган малтав. Энэхүү хоёр талбайн малтлагаар хөрсний 6 давхаргад чулуун зэвсгийн олдвор агуулагдаж байгаа тодорхой болсон юм.

Эндээс нийтдээ 815 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлэн олсоноос 683 ш олдворыг шигшүүрийн тусламжтайгаар илрүүлжээ. Шигшүүрээс илэрсэн олдворууд нь 5мм-ээс 20м-ийн буюу ихээхэн жижиг хэмжээтэй хагархай, хэлтэрхий байгаа ба тэдгээрийн дотроос үзүүр хэсэг нь хугарсан үзүүр мэс хэлбэрийн зэвсэг 1 ш олдсон байна.

Олдворуудын тодорхойлолт:

1-р талбайгаас нийт 474 ш чулуун зэвсгийн олдвор олдсон бөгөөд 410 ш эдлэлийг нь шигшүүрээс илрүүлэн олжээ. Эндээс ямар амьтны болох нь үл мэдэгдэх ясны үлдэгдэл 12 ш олдсон байна. Малтлагын талбайгаас олдсон 63 ш чулуун эзвсгийн олдвор илэрсэн бол харин хөрсний 2-р давхаргаас ямар нэг чулуун зэвсгийн олдвор илэрч олдоогүй юм. Эндээс илэрсэн зарим сонирхолтой олдворуудын тодорхойлолт үйлдэв.

Ирмэгийн 3/4-ыг ирлэсэн хусуур. Энэхүү хусуур зэвсэг нь 4-р давхаргаас илэрсэн бөгөөд дөрвөлжин хэлбэртэй залтас ашиглан бэлтгэжээ. Хусуур зэвсгийн нэг хажуу нь чулууны өнгөн бүрхүүлтэйгээ байх ба залтасны ирмэгийн 3/4-ыг жижгээр холтчин ирлэсэн байна. Нэг төгсгөл хэсгийг илүү өндөр, босоо ирээр зассан бол нөгөө төгсгөл хэсэгт шүдлэг маягийн ир гаргажээ (Зураг 1.*1*).

Үлдэц. Энэ үлдэц нь гурвалжиндуу хэлбэртэй бөгөөд 6-р давхаргаас илэрч олдсон байна. Хоёр талт цохилтын талбайг хоёр цуулалтаар бэлтгэжээ. Суурь хэсгийг хоёр талаас нь сөргүүлсэн цуулалтаар шовхлон зассан байна. Үлдцийн нэг талын

гадаргууны дийлэнх хэсэг чулууны өнгөн бүрхүүлээ хадгалан үлдсэн бол нөгөө талын гадаргууг суурь талаас том цуулалтаар хавтгай болгон засчээ. Мөн дахин цуулалт хийсэн нь амжилтгүй болсон байна. Харин цуулалтын гадаргуугаас ялтас цуулан авах оролдлого хийсэн ул мөр үлдсэн байх ба амжилгүй болсны улмаас цааш цуулалт хийлгүй орхисон бололтой (Зураг 1. *2*).

Сүх маягийн зэвсэг. Энэхүү эдлэлийг томоохон, баргил хагархайгаар бэлтгэсэн байх ба түүний хагас дугуй захыг хоёр талаас нь ирлэсэн байна. Нэг талаас олон эгнээ, шаталсан-хайрслаг ирээр ирлэсэн бол эсрэг талын зарим хэсэгт мөн хайрслаг ир гаргасан нь хурц ирмэг бий болгожээ. Энэхүү зэвсгийг зүсэх, огтлох болон хагачих, хугачих зориулалтаар ашиглаж байсан бололтой. Энэ нь 6-р давхаргаас илэрсэн сонирхолтой зэвсгүүдийн нэг юм (Зураг 1. *3*).

Үзүүр мэс. Мөн л 6-р давхаргаас илэрсэн бөгөөд уртавтар цуулдсаар бэлтгэжээ. Хоёр хажуу ирмэгийг жигд холтчин ирлэсэн байна. Нэг талын гүдгэр ирмэгийг хагас болсоо ирээр ирлэсэн бол нөгөө тууш ирмэгийг жижгээр холтчин суурь хэсэгт босоо, үзүүр хэсэгт хагас босоо ир гаргажээ. Уг эдлэлийн суурь болон үзүүр хэсэг хугарсан байна (Зураг 1. *4*).

2-р талбайгаас нийт 361 ш чулуун зэвсгийн олдвор илэрсэн бөгөөд 273 ш эдлэл нь шигшүүрээс илэрсэн байна. Эндээс шигшүүрийн тусламжтайгаар ямар амьтны болох нь үл мэдэгдэх ясны үлдэгдэл, үйрмэг 51 ш илрүүлэн олжээ. Малтлагын талбайгаас нийт 68 ш чулуун зэвсгийн олдвор олдсон байна. Эндээс илэрсэн сонирхолтой, онцлог бүхий олдворуудад тодорхойлов.

Бэлдэц. Энэхүү бэлдэц нь хөрсний 2-р давхаргаас илэрсэн бөгөөд ялтас цуулахад зориулагджээ. Түүний уртавтар, тэгш талыг цохилтын талбай болгон ашигласан байх ба нэг талын гадаргууг суурь хэсгээс хийсэн цуулалтаар зассан байна. Эсрэг талын гадагууг хэд хэдэн хөндлөн цуулалтаар засах оролдлого хийжээ. Энэхүү талын дийлэнх хэсэгт чулууны өнгөн бүрхүүл хэвээр үлдсэн байна (Зураг 1. *5*).

Өвөрмөц зэвсэг. Уртавтар, зузаан цуулдасны нэг төгсгөл хэсгийн буланг хагас босоо цуулах маягаар ирлээд, түүний ойр байх гүн хүнхэрийг ирлэлгүй орхижээ. Энэ зэвсэг нь мөн л 3-р давхаргаас илэрсэн байна (Зураг 1. *6*).

Ясан зүүлтний хугархай. Энэхүү эдлэлийг амьтны яас ашигласан бэлтгэсэн байх ба голын нүхний ул мөр үлдсэн байна. Эдлэлийн нэг талыг зүлгэж өнгөлсөн нөгөө талыг төдийлөн сайн засаагүй үлдээжээ (Зураг 1. *7*).

Хайгуул судалгаа

Хайгуул судалгааг 2016 оны 07-р сарын 26-наас 08-р сарын 07-ныг хүртэл 10 хоногийн хугацаатай гүйцэтгэсэн бөгөөд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумаас 2, Улаан уул сумаас 7, Эрдэнэбулган сумаас 1агуй илрүүлэн олсон юм. Эдгээрээс Хөгийн агуй-1(Зураг 2.), Мунгарагийн агуй-2, Шилүүсэн агуй, Ультын агуй болон Төмстэйн агуй

(Зураг 3.) зэрэг нь эртний хүн амьдрахад тохиромжтой том хонгил бүхий ажээ. Бид 2017 оноос зарим агуйд малтлага хийхээр төлөвлөж байна.

Дүгнэлт

Энэхүү хоёр багахан хэмжээний малтлагаар илэрсэн олдворууд нь Их Төлбөрийн голын дээд палеолитын дурсгалт газруудаас илэрч олдсон эдлэлүүдтэй хэв шинжийн хувьд ерөнхийдөө төстэй байна. Тухайлбал, Шар хадны 2-р талбайгаас илэрсэн хоёр талт цохилтын талбайтай, цуулалтын нэг гадаргуутай, хавтгай хэв шинжийн үлдэц нь Төлбөр-4; 15 палеолитын дурсгалт газрын доод давхаргуудаас илэрдэг үлдцүүдтэй тун төстэй ажээ [Цэвээндорж, Деревянко., 2006; Гладышев, Гүнчинсүрэн., 2011]. Үзүүр мэсний төрлийн зэвсгүүд нь мөн л Төлбөр-4 палеолитын суурингаас илэрсэн үзүүр мэс зэвсгүүдтэй хэлбэр, ирлэлтийн хувьд адил байна [Деревянко, Цэвээндорж., 2005]. Мөн эндээс галын ором, түүний ойр орчмоос амьтны ясны үлдэгдлүүд илэрсэн нь он цаг тогтоох чухал хэрэглэгдэхүүн болох юм. Шар хадны хэмээн нэрлэгдэх энэхүү палеолитын сууринд энэ жил хийсэн багахан хэмжээний малтлага судалгаа тодорхой үр дүнд хүргэх боломжтойг харуулж байгаа тул цааш үргэлжлүүлэн судлах шаардлагатай. 2014 онд Төлбөр-16 палеолитын суурингийн хөрсний 7-р давхаргаас илэрсэн ясны дээжүүдийн онц цаг 39.570±290 BP (MAMS 20982), 40.480±320 BP (MAMS 20985), 40.910±340 BP (MAMS 20983), 41.720±160 BP (MAMS 20984) жилийн тэртээд холбогдоно хэмээн гарсан нь Их Төлбөрийн голын хөндийн палеолитын суурингуудын он цаг цаашлах боломжтойг илтгэн харуулж байна. Хөвсгөл аймгийн нутагт хийсэн хайгуул судалгаагаар эртний хүний ул мөрийг хадгалсан байх боломжтой зарим нэг агуй олсоныг тэмдэглэх нь зүйтэй.

Ном зүй

1. А.П.Деревянко, Д.Цэвээндорж, Д.Олсен, Б.Гунчинсурэн, А.Н.Зенин, С.А.Гладышев, Е.П.Рыбин, А.А.Цыбанков, Т.Т.Чаргынов, А.В.Кандыба. Раскопки многослойного поселения Толбор-4 в 2005 году. // Проблемы археологии, этнографии, антропологии сибири и с определьных территорий. Материалы Годовойсессии Института археологии и этнографии СО РАН 2005 г. Том. X, ч. I. С. 85-96.
2. Д.Цэвээндорж, А.П.Деревянко, Ж.Олсен, А.Н.Зенин, С.А.Гладышев, Е.П.Рыбин, Я.Цэрэндагва, Ц.Болорбат, Т.Чаргынов Төлбөрийн голд 2006 онд хийсэн малтлага судалгааны урьдчилсан үр дүн. Археологийн судлал. Tom. XXIV. f. 6, тал 64-78. УБ., 2007.
3. С.А.Гладышев, Б.Гүнчинсурэн, Е.П.Рыбин, А.В.Табарев, Ц.Болорбат, Д.Одсүрэн, Д.Олсен. Итоги изучению многослойного палеолитического памятника Тулбэр-15 в 2010 году // Археологийн судлал. Tom XXX, f. 2, тал 21-50. УБ., 2011.

Хавсралт зураг



Зураг 1. 3/4-ыг ирлэсэн хусуур-1, үлдэц-2, сүх маягийн зэвсэг-3, үзүүр мэс-4, бэлдэц-5, өвөрмөц зэвсэг-6, ясан зүүлтний хугархай-7.

Зураг 2. Төмстэйн агуй

Зураг 3. Хөгийн агуй-1

АРЦ БОГДЫН НУРУУНЫ ӨВӨР БИЕД ХИЙСЭН ЧУЛУУН ЗЭВСГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГАА

Д.Одсүрэн, Б.Гүнчинсүрэн, М.Масойч,
Ю.Шикүлски, Г.Одпүрэв, Н.Энхтайван

Төв Азийн томоохон уул нуруудын нэг Алтайн нуруу, түүний салбар уулс плейстоцены үед хүн суурьшин амьдрах таатай уур амьсгал бүрэлдсэн нутаг байсан нь хуучин чулуун зэвсгийн үеэс шинэ чулуун зэвсгийн үеийг хамарсан том, жижиг олон суурин, дурсгалт газрууд илрэн олдож буйгаас харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Алтайн нуруу, түүний салбар Говь-Алтайн уулсын бүс нутаг нь чулуун зэвсгийн судалгаанд ихээхэн ирээдүйтэй, арвин баялаг хэрэглэгдэхүүний хөмрөг гэж хэлж болох юм.

Өнгөрсөн хугацаанд тухайн бүс нутгийн чулуун зэвсгийн дурсгалыг судлах ажлыг Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн палеолитын дурсгалыг судлах анги, Монгол-Орос-Америкийн хамтарсан "Монголын чулуун зэвсгийн үе" төслийн судлаачид гүйцэтгэж олон дурсгалт газар, илрүүлэн судалгааны эргэлтэнд оруулсан юм. Энэ судалгааны нэгээхэн хэсэг бол Говь-Алтайн нурууны зүүн эгнээний салбар уулсын нэг болох Арц Богдын нурууны орчмоос илрүүлсэн дурсгалууд юм. Эндээс МЗТСХЭ-ийн Чулуун зэвсгийн дурсгал судлах анги Их Булаг, Мухар Булаг [Деревнко и др., 2001], Арц Богдын нурууны зүүн хойд хэсэг [Деревянко, Петрин, Кривошапкин, 1996: 15-61], Эргийн хоолой [Окладников, Дорж – 1977: 3-13; Цэрэндагва, Одсүрэн, 2009: 11-21], Монгол-Орос-Америкийн хамтарсан "Монголын чулуун зэвсгийн үе" төслийн хээрийн шинжилгээний анги Цахиуртын хөндийн суурин-дархны газар [Деревянко и др., 2002] зэрэг хуучин чулуун зэвсгийн доод шатнаас дээд үед холбогдох боломжтой олон дурсгалуудыг илрүүлэн судалгааны эргэлтэнд оруулаад байна.

Харин 1990-ээд оны сүүлээс өнөөг хүртэлх хугацаанд тухайн бүс нутагт чулуун зэвсгийн судалгаа хийгдээгүй юм.

Тиймээс ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Бүгд Найрамдах Польш Улсын Врославын Их Сургуультай хамтарсан чулуун зэвсгийн хайгуул судалгааг 2016 оны 05 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 08-ны хооронд Говь-Алтайн нурууны салбар уулсын нэг болох Арц Богдын нурууны өвөр биед хийж гүйцэтгэв.

Судалгааны хэсгийн гол зорилго нь өмнөх судалгааны үр дүнд илрүүлсэн ил суурин-дархны газруудтай танилцах, шинэ дурсгалт газар, ялангуяа хүн урт хугацаанд суурьшин амьдарч байсан ул мөр бүхий агуйн дурсгалт газрыг илрүүлэх явдал байв.

Хайгуул судалгаанд Арц Богдын нурууны өвөр хоолойн Талингарын шал, Чавганцын шал (Цахиуртын хөндийн орчимд), Арц Богдын нурууны баруун өмнөд

хэсэг Шавартайн булгийн орчимд болон Арц Богдын нурууны өмнөд хэсгийн нутаг дэвсгэр хамрагдав.

Арц Богдын нурууны ерөнхий байдал нь хад цохио ихтэй цөлөрхөг болович олон тооны хавцал, гүн сайраар бут сөөг, арц зэрэг модлог ургамал элбэгтэй ажээ.

Арц Богдын нурууны өвөр бэлд баруун хойноос зүүн урагш чиглэсэн том хоолойг нутгийн иргэд нийтэд нь өвөр хоолой хэмээн нэрийдэх бөгөөд эртний нуурын сав, одоо заг, бут сөөг ургасан элсэрхэг хотосууд олон байх ажээ. Энд бид Талингарын шал, Чавганцын шал хэмээн нэрийдэх эртний нуурын сав газруудын дагуу хайгуул судалгааг хийж чулуун зэвсгийн олдворуудын бөөгнөрөл бүхий 46 газрыг илрүүлэн баримтжуулсан юм.

Талингарын шал, Чавганцын шалын чулуун зэвсгийн дурсгал. Арц Богдын нурууны өвөр хоолойд, Хоолойн Халзан тээг хэмээх хойд зүгт ирмэглэн сунаж тогтсон намхан гүвээний арын дов сондуул, заг, бударгана, баглуур ургасан элсэрхэг хотосыг Талингарын шал хэмээн нэрийднэ. Энэхүү хотосын төв хэсэг улбар шаргал өнгийн хатуу шаварлаг хөрс (шал) буй нь эрт цагт тогтоол нуур байсныг гэрчилнэ.

Талингарын шал

Гадарга дээр тархсан чулуун зэвсгийн олдворууд

Чулуун зэвсгийн олдворууд эртний нуурын савын эрэг хөвөө, намхавтар элсэн далангуудын дундах хотгоруудаар тархсан байх ба бид олдворуудын бөөгнөрөл бүхий 30 гаруй газрыг илрүүлэн тэмдэглэсэн юм. Чулуун зэвсгийн олдворуудыг энэ бүс нутагт элбэг тааралдах цахиур болон хасын төрлийн чулуугаар гол төлөв хийсэн байх бөгөөд үлдэц, төрөл бүрийн багаж зэвсгийн зүйл, ялангуяа хоёр талаас нь хөндлөн цуучин зассан хутга олон тааралдаж байна. Чулуун зэвсгийн цуулалтын арга барил, төрөл зүйлээс үзэхэд өөр өөр үеийн олдворууд газрын гадарга дээр холилдсон байдлаар оршиж буй соёлт давхаргагүй ил дурсгал гэдэг нь тодорхой юм. Хуучин чулуун зэвсгийн үед холбогдуулан үзэх боломжтой үлдэц, том баргил хянгар, хүнхэр ирт зэвсэг цөөн тааралдаж байна. Харин шинэ чулуун зэвсгийн үеийн олдворууд нь маш баялаг юм. Энэ үед хамаарах жижиг болон бичил ялтас цуулах зориулалт бүхий төрөл бүрийн үлдэцүүд, өөр өөр үүрэг зориулалт бүхий багаж зэвсэг, ялангуяа хоёр

талт хутга хэлбэрийн зэвсэг олон байгаа нь Арц Богдын нурууны зүүн өмнөд хэсгийн Эргийн хоолойн дурсгалтай ихэд төстэйг харуулж байна. Мөн самбар чулуу бүтнээрээ болон хагарч хэмхэрсэн байдлаар хэд хэд олдсоныг лабораторийн орчинд цаашид нарийвчлан судлах шаардлагатай юм.

Шавартайн чулуун зэвсгийн дурсгал. Арц Богдын нурууны зүүн бэлийн шаварлаг хөрс бүхий дэрстэй хагарлаас ундрах жижиг булгийг Шавартай хэмээн нэрийднэ. Энэхүү булгийн хажуугийн дэвсэг болон дэрсэн дунд чулуун зэвсгийн олдворууд сийрэг байдлаар тархсан байх бөгөөд бид олдворуудын бөөгнөрөл бүхий 3 газар илрүүлэн баримтжуулав. Эндээс илрүүлсэн олдворуудаас хар өнгийн цахиурлаг чулуу ашиглан хийсэн ооль олдсон нь ур хийц сайтай бөгөөд түүнийг ашиглаж хэрэглэж байсныг гэрчлэх элэгдлийн ул мөр ирэн хэсэгт нь ажиглагдаж байна. Ийм төрлийн зэвсэг Монгол орны шинэ чулуун зэвсгийн дурсгалуудад нэлээд таарalддаг бөгөөд нэг газраас хамгийн олноор илэрсэн нь Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уулын шинэ чулуун зэвсгийн суурин [Одсүрэн, Бөхчулуун, Янз, 2015: 72-96] юм.

Шавартайн чулуун зэвсгийн дурсгалт газар

Агуйн дурсгалт газруудын хайгуул судалгаа. Чулуун зэвсгийн дурсгалт газрын орших нэг хэлбэр нь агуйн дурсгалт газар юм. Нэн эртний хүмүүс байгалийн бэлэн агуй хонгилыг орон гэр болгон ашиглаж байсан бөгөөд тэдний ахуй амьдралын ул мөр бүхий агуй нь тухайн үеийн түүхийн судалгаанд үнэ цэнэтэй мэдээ баримт өгдөгөөрөө судалгаанд ихээхэн ач холбогдолтой билээ. Тиймээс бид Арц Богдын нурууны зүүн өмнөд хэсгийн уулсаар агуй, хонгил эрэн сурвалжилж Хөтөл ус, Сүмт Улаан зэрэг газруудаас шинээр агуй олж илрүүлэв.

Хөтөл усны агуй нь уулсын дундах, хуурай сайрын арын баруунаас зүүн зүгт сунаж тогтсон үргэлжилсэн уулын энгэрт байрлах бөгөөд агуйн ам баруун урд зүгт харжээ. Агуй нөмөр дулаан бөгөөд үүдний дусаалын шугамнаас мухар хүртлээ 5м орчим урт юм. Агуйд хурдас нэлээд хуримтлагдсан болович эртний хүний амьдралын

ул мөр болох чулуун зэвсгийн олдвор олдсонгүй. Гэвч Хөтөл Усны агуй байрлаж буй уулын зүүн үзүүрт, агуйгаас 100м зайд нэг дор бөөгнөрсөн байдалтай 10 орчим чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн. Эндээс улаан өнгийн хас чулуугаар хийсэн бэлдцүүд, цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут үлдэц, таргил үлдэц олдсон нь ихээхэн сонирхолтой бөгөөд чулуун зэвсгийн олдворуудын цуулалтын арга барил, хэв шинжид үндэслэвэл хуучин чулуун зэвсгийн дээд үед холбогдох боломжтой юм. Ирэх жилүүдэд бид Хөтөл усны агуйн орчимд хайгуул судалгааг үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.

Хөтөл усны агуй

Хөтөл усны агуйн дэргэдээс илрүүлсэн чулуун зэвсгийн олдворууд

Ном зүй

Деревянко, Петрин, Кривошапкин, 1996 – Деревянко А.П., Петрин В.Т., Кривошапкин А.И. Проблемы изучения палеолитических комплексов северо-восточного фаса Арц Богдо // Археологийн судлал. Tom.XVI, fasc. 3. Улаанбаатар.

Деревнко и др., 2001 – Деревянко А.П., Кривошапкин А.И., Ларичев В.Е., Петрин В.Т. Палеолит восточных предгорий Арц-Богдо. Новосибирск.

Деревянко и др., 2002 – Деревянко А.П., Зенин А.Н., Олсен Д., Петрин В.Т., Цэвээндорж Д. Палеолитические комплексы Кремневой Долины. Новосибирск.

Окладников, Дорж, 1977 – Окладниковын А.П., Дорж Д. Памятники каменного века на Юге МНР (по работам 1971-1972 гг) // Археологийн судлал. Tom. VII, fasc. 1. Улаанбаатар.

Одсүрэн, Бөхчулуун, Янз, 2015 – Одсүрэн Д., Бөхчулуун Д., Янз Л. Зүүн Монголын нутагт хийсэн шинэ члуун зэвсгийн судалгааны зарим үр дүн // Археологийн судлал. Tomus XXXV, fasc. 5. Улаанбаатар.

Цэрэндагва, Одсүрэн, 2009 – Цэрэндагва Я., Одсүрэн Д. Эргийн хоолойн шинэ чулуун зэвсгийн дурсгал // ActaHistorica.Tomus. X, fasc.2. Улаанбаатар.



Зураг-1. Самбар чулууны хагархай-1, 2, хатгуур-5 (Талингарын шал, FV-07); сийлүүр-6, ялтсан зэв-7, үлдэц-8 (Талингарын шал, FV-07); бифас-9 (Талингарын шал, FV-24); үлдэц-10 (Талингарын шал, FV-37); хутганы хугархай-11



Зураг-2. Бифас-1 (Талингарын шал, FV-27); хутга-2 (Талингарын шал, FV-24); самбар чулуу-(Талингарын шал, FV-38); хутга-4 (Талингарын шал, FV-37); үлдэц-5 (Талингарын шал, FV-32)

"ГОВЬ, ХЭЭРИЙН БҮСИЙН НЕОЛИТЫН СУДАЛГАА" ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН

Д.Одсүрэн, Д.Бөхчулуун, Л.Янз, А.Розен

Монгол орны говь, хээрийн бүс нутгаас шинэ чулуун зэвсгийн дурсгалт газруудыг илрүүлэн олох, малтан судлаж тухайн үеийн түүхийг шинэ мэдээллээр баяжуулах зорилго бүхий "Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа" нэртэй эрдэм шинжилгээний төслийг ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, АНУ-ын Аризонагийн Их Сургууль болон Канад улсын Трентийн Их сургуультай хамтран хэрэгжүүлж байгаа билээ. Уг төслийн хүрээнд 2013 онд Сүхбаатар аймгийн зарим сумдын нутаг дэвсгэрт хайгуул судалгааны ажлыг зохион байгуулсан бол 2015 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уулын шинэ чулуун зэвсгийн сууринд малтлага судалгаа хийсэн юм. Мөн Зараа уул орчмоос түүхийн өөр өөр үед холбогдох 160 гаруй дурсгалыг илрүүлэн баримтжуулаад [Одсүрэн нар., 2016] байна.

2016 онд хамтарсан төслийн хээрийн судалгааны хүрээнд Зараа уулын шинэ чулуун зэвсгийн сууринд хийж буй малтлага судалгааг үргэлжлүүлэх, тухайн бүс нутгийн эртний байгаль орчин, уур амьсгалыг тодруулах зорилготой геоархеологийн судалгааг хийж гүйцэтгэлээ.

Мөн тэртээ 1960-аад онд МЗТСХЭ-ийн Чулуун зэвсгийн дурсгал судлах анги Монгол орны дорнод хэсгээс илрүүлсэн зарим дурсгалтай танилцах, нягтлах, шинээр дурсгал илрүүлэх зорилгоор цөөн хоногийн хайгуул судалгааг хийв.

Судалгааны гол объект болж буй Зараа уул орчмын бүс нутаг нь ерөнхийдөө цөлөрхөг, хээрийн шинж төрхийг агуулсан газар юм. Зараа уул орчмоос одоогийн байдлаар чулуун зэвсгийн олдвор тархсан 14 газрыг илрүүлээд байна. Эдгээрийн нэг нь палеолит, бусад нь неолитын хэв шинж бүхий хоёр өөр цаг үеийн олдворуудыг агуулж байна.

Зараа уул тектоникийн гаралтай өргөн хөндийн баруун хэсэгт оршино. Энэхүү өргөн хөндийн баруун зах тунамал чулуулаг болон хүрмэн хад чулуугаар хүрээлэгдсэн бол хөндийн шал нэлэнхүйдээ плейстоцены үеийн шохойлог хөрсөнд хучигдсан байна. Геоархеологийн судалгаанаас үзвэл, энэ хөндий эрт цагт давслаг нуурын ёроол байсан бололтой. Одоогоос 13500 – 11700 жилийн өмнө болсон цаг уурын хувирамтгай байдал буюу гэнэтийн дулаарал, хүйтрэлээс үүдэн энэхүү нуурын ус хурдацтай татарсан бололтой. Харин 8000-4000 жилийн тэртээд (дунд голоцене) Ази тивд чийглэг дулаан уур амьсгал эргэн тогтсон байдаг. Зараа уулын орчимд дунд голоцений үед хур тунадас их унаж, хөрсний хурдасжилт эрчимтэй явагдаж байжээ. Ихээр орох болсон борооны улмаас түр зуурын гол горхиуд үүсэж орчны гадаргын тогтоцод багагүй өөрчлөлт орсон байна. Эдгээр урсац усаар тэтгэгддэг цэвэр усны тогтоц үүссэн

болохыг шохойлог хөрсний дээр тогтсон органик материалаар баялаг шаварлаг үе тодорхойлно. Мөн тус үед агуулагдах CaCO3 -ийн жижиг бөөгнөрлөөс харахад эдгээр нуурууд зарим улиралд хатаж байсан байна.

Голоцений сүүл үед цаг уурын өөр нэг томоохон өөрчлөлт гарсан нь одоог хүртэл үргэлжилж байх магадлалтай. Энэ нь плейстоцены үеийн гадаргын хөрсөн дээр тогтсон 15-20см зузаан бор өнгийн бүдүүн ширхэгтэй хөрснөөс тодорхой харагдана. Харин голоцены сүүл үед хамаарах нь ердөө хөрсний дээд давхаргад буй 3-5см зузаан хөрс юм. Үер ус, салхины нөлөөгөөр зөөгдөх шороо, чулуу зэрэг нь тухайн дурсгалт газрын хадгалалтанд сөргөөр нөлөөлсөн нь харагдаж байна.

Геоархеологийн судалгааны урьдчилсан үр дүнд тулгуурлан Зараа уул, түүнчлэн өнөөгийн Монгол улсын зүүн бүсийн нутаг дэвсгэр мөстлөгийн дараах үед чийглэг зөөлөн уур амьсгалтай, хүн суурьшин амьдрахад таатай нөхцөл бүхий газар байжээ.

Энэ оны малтлага судалгааг бид өмнө жил хийсэн малтлагыг баруун тал руу нь үргэлжлүүлэн нийт 4м^2 талбайд гүйцэтгэв. Чулуун зэвсгийн олдворууд, амьтны ясны хэлтэрхийнүүд хөрсний үе бүрээс илрэх бөгөөд олдворууд газрын өнгөн хөрснөөс доош 70см орчим гүнд хүртэл хадгалагдсан байна. Малтлагын явцад хөрсний 4 давхаргад эртний хүмүүсийн ахуй амьдралын ул мөр болсон олдворууд тархсаныг тогтоов. Гэвч байнгын салхи, бороо, үер ус зэрэг байгалийн хүчин зүйлийн нөлөөллөөр олдвор агуулсан соёлт давхаргууд хоорондоо ихээхэн холилдсон байна.

Малтлагын явцад илрүүлсэн чулуун зэвсгийн олдворуудын ихэнх нь жижиг залтас, ялтас хагархай хэлтэрхий боловч чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга ажиллагааг тодорхойлох сонирхолтой эдлэлүүд, тухайлбал төрөл бүрийн ялтас цуулах арга ажиллагааг харуулсан үлдцүүд, эртний хүмүүсийн өдөр тутмын ахуй амьдралын хэрэгсэл болсон хоёдогч боловсруулалт хийж зассан багаж зэвсэг илрэв. Малтлага судалгааны явцад өмнөх жилүүдийн судалгааны явцад эндээс олдож байгаагүй хоёр талаас нь холтчиж зассан сумны зэв хэд хэд гарсан нь тухайн дурсгалыг үлдээгчдийн ахуй амьдралд ан гөрөө тодорхой үүрэгтэй байсныг гэрчлэх баримт юм.

Хээрийн судалгааны явцад Зараа уулын зүүн хойд хэсгээс хуучин чулуун зэвсгийн дурсгалт газар илрүүлсэн бөгөөд энэ нь тухайн бүс нутагт хэдий үеэс хүн суурьшин амьдарч эхэлснийг баримжаалах чухал хэрэглэгдэхүүн юм.

Зараа уулын зүүн хойд хэсгийн өндөрлөгийн өвөр биед, баруунаас зүүн зүгт чиглэсэн нарийн жалганы эхэн хэсгийн зүүн урагшаа ялимгүй хазгай талбайд хуучин чулуун зэвсгийн хэв шинж бүхий олдворууд нэлээд шигүү тархсан дурсгалт газар байна.

Палеолитын олдворууд тархсан энэхүү талбай ар болон баруун хэсгээрээ хадан цохиогоор хүрээлэгдсэн нөмөр газар юм. Эртний хүмүүс энэхүү нөмөр газрыг

бараадан тэнд чулуун зэвсгийн үйлдвэрлэл явуулж байсан бололтой бөгөөд олон мянган жилийн туршид олдворууд газрын хэвгий даган аажим гулсаж шилжсэн байх магадлалтай юм. Геоархеологийн судалгааны үр дүнд бидний илрүүлсэн энэхүү хуучин чулуун зэвсгийн дурсгалт газрын олдворууд цагаан шаргал өнгөтэй, эртний нуурын эрэг захын элсэрхэг хөрсөнд хадгалагдаж байгааг тогтоосон.

Энэхүү палеолитын дурсгалт газрын чулуун зэвсгийн олдворуудыг гол төлөв цайвар саарал өнгийн тунамал чулуулаг ашиглан бэлтгэсэн байна. Түүвэр олдворын цуглуулганд чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн анхдагч цуулалтын арга ажиллагааг харуулах 6 ш эдлэл байгаа бөгөөд тэдгээр нь үлдэц (5 ш), техникийн цуулдас юм. Нийт дөрвөн үлдцийн цуулалтын арга барилаас харахад тэдгээрт леваллуагийн цуулалтын арга ажиллагаа ажиглагдана. Тэдгээрт цуулалтын эсрэг тал руу огцом налуу цохилтын талбайг бий болгосон бөгөөд хоёр хажуу болон ар талыг нь төв рүү чиглэсэн цуулалтуудын дунд бэлтгэжээ. Цуулалтын гадаргуу нь цохилтын талбайд хүчтэй цохилт даралт өгөх замаар том залтас, үзүүр мэс цуулан авсан ул мөрийг агуулж байна (зураг 1-*3, 4*). Эдгээр үлдцүүдийн цуулалтын арга барил, хэв шинжтэй адилсах төрлийн олдворууд Монгол болон хөрш зэргэлдээх бүс нутгуудын чулуун зэвсгийн дурсгалуудад элбэг тохиолддогийг тэмдэглэх хэрэгтэй.

Энэ дурсгалт газартай цуулалтын арга барилын хувьд адилсах боломжтой, орон зайн хувьд хамгийн ойр орших дурсгал бол Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт орших Ачаат уулын палеолитын дурсгалт газар юм. Геоморфологийн хувьд Зараа уултай нэг бүсчлэлд хамаарах энэхүү дурсгалт газраас улаан хүрэн өнгийн цахиурлаг чулуу ашиглан хийсэн олдворууд бүхий хуучин чулуун зэвсгийн дурсгалт газар илрүүлсэн бөгөөд судлаачид харьцуулсан судалгааны үндсэн дээр хожуу мустьен үеэс дээд палеолитын эхэн үед холбогдуулан үзсэн байна [Цогтбаатар, Пүрэвжал, 2014:15-25]. Ачаат уулын палеолитын цуглуулгын дунд төв рүү чиглэсэн цацарган цуулалт бүхий леваллуагийн хэв шинжийг илэрхийлэх үлдэц болон зэрэгцээ цуулалтын арга барил бүхий үлдцүүд, ялтас болон залтас нь Зараа уулын палеолитын суурьтай ихэд адилхан гэдгийг тэмдэглэе.

Мөн Хэрлэнбаян-Улаан уулын Ханзатын амны Ханзат-1 хэмээн тэмдэглэгдсэн хуучин чулуун зэвсгийн дурсгалт газрын үлдэц болон ялтсан цуулалтын арга ажиллагаа нь Зараа уулын дурсгалт газрын анхдагч цуулалтад хамаарах эдлэлүүдтэй үйлдвэрлэлийн аргын хувьд адил бөгөөд тус турсгалт газарт судалгаа хийсэн судлаачид Ханзат-1 дурсгалт газрыг дээд палеолитын эхэн үед холбогдуулан үзсэн байна.

Монгол оронд малтан судалсан соёлт давхарга бүхий дурсгалуудын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга барилыг Зараа уулын палеолитын дурсгалтай харьцуулахад Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Орхон голын зүүн эрэгт орших Орхон-1 болон 7-р суурьтай адилсах байдал ажиглагдаж байна. Орхон-7

дурсгалт газрын 3 дугаар малтлагын 3-р үеэс леваллуагийн чулуун зэвсэг цуулалтын арга ажиллагааны уламжлалыг хадгалсан үлдцүүд олон гарсан бөгөөд бидний толилуулан бүхий үлдцүүдтэй цуулалтын арга барилын хувьд ижилсэх юм. Орхон 7 дурсгалт газрын 3-р үеийн хөрсний бүтцэд хийсэн лабораторийн шинжилгээний дүнд 39970±819 жилийн өмнөх үед хамаарах [Деревянко и др., 2010: 31-33] он цагийн хамаарлыг зааж байна.

Дээр дурдсан дурсгалт газруудаас гадна Монгол орны бусад бүс нутгуудаас илрүүлсэн палеолитын ил суурингууд, тухайлбал Арц Богдын нуруу орчмын Их Булаг, Мухар булаг [Деревнко и др., 2001], Цахиуртын хөндий [Деревянко и др., 2002], Монгол Алтайн нурууны Олон нуур-1, 2, Баяннуур, Ховд аймгийн Ховд-1 [Деревянко и др., 1990], нууруудын хөндийд орших Байдрагийн голын 9-р суурин, Өлзийт сумын Нарийн голын 17г, 17е, 24б, 26б, 35-р суурингууд, Түйн голын хөндийн Их Булган зэрэг олон газраас илэрч олдсон бөгөөд он цагийг нь судлаачид дунд палеолит, дунд палеолитын төгсгөл болон дээд палеолитын эхэн үед хамааруулан үзжээ [Деревянко и др.., 2000: 37-39, 80-82, 86-87, 93-94, 95-96, 100-101].

Мөн Хятадын умард хэсгийн Шуйдунгоу хэмээх чулуун зэвсгийн суурингаас таргил үлдэц илэрдэг бөгөөд бусад олдвор, дээжинд хийсэн шинжилгээний дүнгээр 38000±2000, 34000±2000 хэмээн тогтоосон байдаг [Деревянко., 2011].

Мөн үлдэцнй өөр нэг төрөл болох зэрэгцээ цуулалтын зарчимт хавтгай үлдэц (зураг 1-2) нэг илэрсэн нь Монголын хойд хэсгийн Их Төлбөрийн голын 4 болон 15, 16-р суурингаас илэрсэн үлдцийн дийлэнх хувийг эзэлдэг. Төлбөр-4 суурингийн 6-р давхарга 37400±2600, 5-р давхарга 26700±300, Төлбөр-15 дурсгалт газрын 7-р давхарга 29150±320 жилийн тэртээд холбогдох боломжтойг лабораторийн шинжилгээгээр нарийвчлан тогтоосон байдаг. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын савд орших Дөрөлж-1, Дөрөлж-2 хэмээх соёлт давхарга бүхий суурингаас дээрх төрлийн үлдэц цөөнгүй илэрсэн бөгөөд тэдгээрийн доод давхаргаас илэрсэн шатсан модны үлдэгдэлд хийсэн он цаг тогтоох шинжилгээгээр 29910±310, 31880±800 жилийн тэртээд холбогдохыг тогтоосон байна [Jaubert et al., 2000: 35].

Хоёрдогч боловсруулалт хийсэн, тогтсон хэв маяг бүхий багаж зэвсгийн зүйл цөөн бөгөөд одоогоор ялтасны нэг гүдгэр ирмэгийг нүүрэн талаас нь налуу холтчин нямбай ирлэсэн мөртэй хутга (зураг 2-*2*), суурь хэсэг нь хугарсан налуу иртэй хянгар (зураг 2-*4*), ялтасны төгсгөл хэсгийг үзүүрлэн зассан хатгуур илрүүлээд байна. Харин хажуу зах ирмэгийг нь холтчин ирлэж зассан ялтас (5 ш) (зураг 1-*5, 6*), залтас (1 ш) (зураг 2-*1*), ирлэсэн цуулдас (зураг 2-*3*) тус тус илэрсэн. Эдгээрийг мөн дээд палеолитын эхэн үеийн чулуун зэвсэг цуулалтын арга барилаар үйлдсэн байна.

Цохилтын талбайн үлдэгдлээ хадгалсан цуулдас 4 байх бөгөөд тэдгээрийн нэг ялтас, нэг залтасны талбай нь холтчин засагдсан оромтой ажээ. Энэ нь тэдгээрийг

арагшаа налуудуу байдлаар зассан, леваллуагийн үйлдвэрлэлийн шинж төрхийг хадгалсан үлдэцнээс цуулан авсны илрэл юм.

Зараа уулын палеолитын дурсгалт газрын чулуун зэвсгийн үйлдвэрлэл нь ялтсан цуулалтын арга барилд суурилсан бөгөөд ялтаснууд харьцангуй том хэмжээтэй, цохилтын талбайн үлдэгдэл дээрээ холтчин зассан ул мөрийг хадгалж байгаа нь леваллуагийн үйлдвэрлэлийн уламжлалыг хадгалсан болохыг харуулж байна. Он цагийн хувьд дунд палеолитын төгсгөл, дээд палеолитын эхэн үед холбогдох бөгөөд цацарган цуулалтын арга барилаас ялтсан цуулалтын арга барилд шилжсэн шилжилтийн үеийн үйлдвэрлэлийн арга барилыг харуулах сонирхолтой дурсгал юм. Палеолитын цуглуулга дотор дээд палеолитын хожуу үеийн үйлдвэрлэлийн шинж төрхийг харуулах олдворууд байхгүй нь нэлээд сонирхолтой байгаа бөгөөд бидний илрүүлсэн энэхүү дурсгалт газар нь цаашид тухайн бүс нутгийн палеолитын үеийг нарийвчлан судлахад нэгэн хэрэглэгдэхүүн болно хэмээн үзэж байна.

Ном зүй

1. Деревянко и др., 1990 – Деревянко А.П., Дорж Д., Васильевский Р.С., Ларичев В.Е., Петрин В.Т., Девяткин Е.В., Малаева Е. Каменный век Монголии. Палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск
2. Деревянко и др.,2000– Деревянко А.П., Петрин В.Т., Цэвээндорж Д., Девяткин Е.В., Ларичев В.Е., Васильевский Р.С., Зенин А.Н., Гладышев С.А. Палеолит и неолит Северного побережья Долины Озер. 2000 Новосибирск
3. Деревнко и др., 2001 – Деревянко А.П., Кривошапкин А.И., Ларичев В.Е., Петрин В.Т. Палеолит восточных предгорий Арц-Богдо. Новосибирск.
4. Деревянко и др., 2002 – Деревянко А.П., Зенин А.Н., Олсен Д., Петрин В.Т., Цэвээндорж Д. Палеолитические комплексы Кремневой Долины. Новосибирск.
5. Деревянко и др., 2010 – Деревянко А.П., Кандыба А.В., Петрин В.Т. Палеолит Орхона. Новосибирск.
6. Деревянко., 2011 – Деревянко А.П. Верхний палеолит и Африке и Евразии и формирование человека современного анатомического типа. Новосибирск.
7. Одсүрэн нар., 2016 - Одсүрэн Д., Бөхчулуун Д., Янз Л. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уул: "Говь, тал хээрийн бүсийн неолитын судалгаа төсөл"-ийн хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар. ТАХБМТ.
8. Цогтбаатар, Пүрэвжал, 2014 – Цогтбаатар Б., Пүрэвжал Х. Ачаат уулын чулуун зэвсгийн дурсгал /Археологийн судлал. Tom. XXXIV. fasc. 2. Улаанбаатар.
9. Jaubert et al., 2000 – J.Jaubert, M.Jarry, S.Lacombe, C.Leroyer, B.Tsogtbaatar. Dörölj 1 et 2: La transition Paléolithique moyen-Paléolithique supérieur en Mongolie, rapport, 2000.ТАХБМТ.



Зураг-1. Үлдэц-1; зэрэгцээ цуулалтын зарчимт хавтгай үлдэц-2; леваллуагийн хэв шинжит үлдэц-3, 4; ирлэсэн ялтас-5, 6



Зураг-2. Ирлэсэн залтас-1; хутга-2; ирлэсэн цуулдас-3; хянгар-4; ялтас-5

МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН ЭКСПЕДИЦИ ИХ НАРТЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗАРТ ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

Я.Цэрэндагва, Ж.Шнейдер, А.Розен, Р.Коннорс, С.Далантай,
Ж.Фаркухар, П.Хадел, Р.Төрбат, С.Гиллиланд,
Р.Чиолек-Торелло, Г.Олзбаяр

Удирттал

Монгол-Америкийн хамтарсан экспедици 2010 оноос Их Нартын Байгалийн Нөөц газрын (ИНБНГ) археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулах, судлан шинжлэх ажлыг гүйцэтгэж байна. Энэ хугацаанд тухайн Байгалийн нөөц газраас 140 археологийн дурсгалт газрыг илрүүлэн олж бүртгэн баримтжуулсан байна. Тэдгээр дурсгалууд нь чулуун зэвсгийн үеэс дундад зууны үе хүртэлх түүхийн урт удаан хугацаанд холбогдох бөгөөд энэ утгаараа Их Нартын Байгалийн Нөөц газар нь Монгол орны археологийн дурсгалын томоохон бүс нутагт тооцогдоно.

Энэ жилийн хээрийн шинжилгээний ажил долоодахь удаагийнх бөгөөд 2016 оны хээрийн судалгааны ажил 6-р сарын 2-17-ны хооронд 14 хоногийн хугацаатай үргэлжлэв.

Судалгааны ангийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Я.Цэрэндагва, С.Далантай, МУБИС-ийн багш Р.Төрбат, МУИС-ийн магистр Г.Олзбаяр, МУИС-ийн оюутан Б.Солонго, Г.Нямдаваа, А.Золжаргал, АНУ-ын Калифорнын Үндэсний Паркын археологич, доктор Ж. Шнейдер (J.Schneider), Р.Коннорс (R.Connors), Техасын Их сургуулийн профессор А.Розен (A.Rosen), археологич Ж.Фаркухар (J.Farquhar), П.Хадел (P.Hadel), С.Гиллиланд (S.Gilliland) Р.Чиолек-Торелло (Richard Ciolek-Torello) болон бусад 10 сайн дурын судлаачид оролцов.

Археологийн судалгаа, шинжилгээ

2016 оны хээрийн судалгаа шинжилгээг хайгуул болон малтлага гэсэн үндсэн хоёр чиглэлээр явуулав.

Хайгуул судалгаанд шугаман хайгуулын аргыг хэрэглэв. Энэхүү аргаар 10 хэсэг газарт хайгуул хийж олон тооны түүвэр олдворыг илрүүлэн, сонголтын зарчмаар зарим олдворыг түүвэрлэсэн юм.

Саруулын дугуй, Саруулын усны ойролцоогоос чулуун зэвсгийн томоохон 3 суурин, хадны зураг, бичээс, дөрвөлжин булш бүхий дурсгалт газрыг илрүүлэн олов.

Илэрч олдсон булш, чулуун байгууламжуудын хэмжилтийг археологийн бүртгэлийн стандартын дагуу хийж гүйцэтгэлээ.

Хайгуулаар илэрч олдсон дурсгалт газрууд

Нарийвчилсан шугаман хайгуулыг Их Нартын Байгалийн нөөц газрын урд хэсэг Айраг сумын нутаг Ар хөндлөн, Майхант, Хөх хад, Нүцгэн Хонгорын ухаа, Хөмсөгтийн орчимд нийт 10 талбайд хийснээс 7 талбайгаас чулуун зэвсгийн дурсгал илэрч олдов. Их Нартын Байгалийн Нөөц газарт неолитын үеийн чулуун зэвсгийн дурсгал газрын хөрсөн дээр их хэмжээгээр тархсан нь дээрх талбайнуудад ажиглагдаж байна. Дээрх 10 талбайг хайгуулын тэмдэглэл, газрын зурагт латин үсгээр A-I хүртэл дугаарлан тэмдэглэсэн бөгөөд B талбайгаас ганц жадны үзүүр, C (Хөх хад) талбайгаас 6 чулуун зэвсэг (2 бичил үлдэц, шүдлэг зэвсэг, цоолтуур, хусуур, бичил ялтас), F талбайгаас 7 чулуун зэвсэг (1 бичил үлдэц, 6 хусуур), G талбайгаас (Хөмсөгт) 10 олдвор (2 хагархай, 2 хусуур, 1 цохиур чулуу, 5 ваарны хагархай), H талбайгаас (Хөмсөгтийн ар) 6 олдвор (2 хусуур, 1 бичил үлдэц, 1 иртэй залтас, 2 шаазан ваарны хагархай), J талбайгаас (Хонгор ухаагаас хойш 2 км) хоёр хэсэг газраас нийт 10 чулуун зэвсэг (1 хагархай, 7 хусуур, 2 ялтас) тус тус сонголтын зарчмаар түүвэрлэн цуглуулав.

Мөн гурван талбайгаас 3 дугуй булш, хоёр дугуй чулуун байгууламж, чулуу эгнүүлэн өрсөн тал саран хэлбэрийн байгууламж бүртгэсэн.

Саруулын дугуйн арын хадны хажуу хөндийгөөс олдсон чулуун зэвсгийн суурингаас (IKH-147) 138 олдвор хэрэглэгдэхүүн цуглуулсны дотор үлдэц (54 ш), цохиур чулуу (1 ш), хусуур (30 ш), жадны гилбэр (3 ш), сүх (2 ш), бифас (3 ш), хутга (2 ш), хянгар (1 ш), шүдлэг зэвсэг (1 ш), ирлэсэн ялтас (1 ш), ялтас (12 ш), залтас (10), хагархай (3ш), үр тариа цайруулах самбар чулуу (7 ш), нүдүүр чулуу (3ш), ваарны хагархай (2 ш), зоос (1 ш), төмөр эдлэл (1 ш) тус тус байна.

Чулуун зэвсгийн суурингийн арын боржин хадны дээр түвэд бичгийн маанийн үсэг олон тоогоор сийлэгдсэний зэрэгцээ1 мөр 10 үсэг бүхий орхоны руни бичээс байгааг шинээр илрүүлэн олов. Энэ бичээсний ойролцоо ац, сэрээ, сам, хайруулга, сүүл, онги болон эвэртэй онгин тамгад сийлэгджээ.

Саруулын усны сайрын дэнжид чулуун зэвсэг олон зуугаар тархсан томоохон суурин (IKH-151) илрүүлэн 30 олдвор хэрэглэгдэхүүнийг дээжлэн түүвэрлэв. Тэдгээрийг төрөлжүүлэн ангилахад үлдэц (11 ш), хусуур (4 ш), ооль (3 ш), үр тариа цайруулах самбар чулуу (10ш), нүдүүр чулуу (2 ш) байна.

Саруулын усны урдхан талын хадан хясааны ёроолд чулуун зэвсэг, самбар чулууд нэг доор бөөгнөрсөн байдлаар илэрч олдсон бөгөөд бид 36 олдворыг түүвэрлэсэн юм. Тэдгээр нь бэлдэц (2 ш), үлдэц (10 ш), хусуур (3 ш), зэв (1 ш), залтас (4 ш), ялтас (3 ш), хагархай (2 ш), үр тариа цайруулах самбар чулууны хагархай(5 ш), нүдүүр чулуу (3 ш), ваарны хагархай (3 ш) байна.

Саруулын усны арын дэнжээс 5 дөрвөлжин булш, Саруулын дугуйн зүүн талаас нэг жижиг дөрвөлжин булш илрүүлэн бүртгэн баримтжуулав.

Малтлага судалгаа

2016 оны судалгаагаар Бургасны энгэрийн 9 болон 28-р дурсгалт газарт малтлага, сорьц хийсэн юм.

9-р дурсгалт газар (IKH-9)

9-р суурингийн зүүн хойд хэсэгт хоорондоо 5 м-ийн зай бүхий 16-н цэгийг сонгон авч сондгой дугаартай цэгүүдэд хүрз, тэгш дугаартай цэгүүдэд "Auger" багаж ашиглан сорьц хийлээ.

Хүрзэн сорьцийг 6 цэгт 45х35, 50х40см-ийн хэмжээтэй хийж гүйцэтгэв. Тухайн цэгийн хөрсний давхаргазүйгээс шалтгаалан сорьцийг харилцан адилгүй түвшинд зогсоож байв (30-55см).

Сорьц хийх явцад 3-р сорьцын (TP-3)өнгөн хөрснөөс 5 ялтас, 7-р сорьцын (TP-7) 10-15 гүнээс 8 бичил ялтас, 30см-ээс шатсан модны нүүрс илэрч олдов. 2 сорьцыг (TP-7, TP-9) доош үргэлжлүүлэн "Auger" багажаар өрөмдсөн нь олдвор хэрэглэгдэхүүн илрээгүй болно.

"Auger" багаж ашиглан 8 цэгт өрөмдөгө хийж гүйцэтгэв. Өрөмдлөгийн гүн харилцан адилгүй (22-120см) байсан бөгөөд гарсан хөрсийг шигшүүрээр шигшин олдвор хэрэглэгдэхүүнийг илрүүлэх арга зүйг ашигласан.

Сорьц өрөмдлөгийн явцад 5 сорьцоос (TP-2, TP-8, TP-12, TP-14, TP-16) олдвор хэрэглэгдэхүүн илэрсэнгүй. Харин 4-р сорьцоос (TP-4) 10-20см-ийн гүнээс шаргал өнгийн цахиур чулуун ялтас, хүрэн өнгийн цахиур бүхий ялтас, 60см-ийн гүнээс ямар амьтных нь үл мэдэгдэх ясны хэлтэрхий, 6-р сорьцоос (TP-6) ганц бичил ялтас, 10-р сорьцоос (TP-10) ганц бичил ялтас тус тус илэрч олдсон.

Энэ суурind гурван талбайд 2х2см хэмжээтэй сорьц малтлага хийж гүцэтгэв. Малтлагын 5см-ийн гүнтэйгээр үелэн явуулсан ба 30см хүртэл гүн хүртэл малтан судалсан болно.

1-р сорьц малтлага (*IKH-9 TE-1*). Малтлагаас 376 ширхэг олдворын зүйл илэрч олдсон. 1-р үеэс (0-5см) 44 ширхэг, 2-р үеэс (5-10см) 101 ширхэг, 3-р үеэс (10-15см) 116 ширхэг, 4-р үеэс (15-20см) 43 ширхэг, 5-р үеэс (20-25см) 72 ширхэг олдвор малтан гаргав. Дээрх олдворуудыг төрөл зүйн хувьд ангилахад хусуур зэвсэг 6 ширхэг, сийлтүүр 1 ширхэг, хатгуур зэвсэг 1 ширхэг, шөвөг 1 ширхэг, ваар савны хэлтэрхий 4 ширхэг, залтас, ялтас, хагархайнууд 366 ширхэг байна.

2-р сорьц малтлага (*IKH-9 TE-1*). Малтлагаас 312 ширхэг олдвор хэрэглэгдэхүүн гарснаас 1-р үеэс (0-5см) 15 ширхэг, 2-р үеэс (5-10см) 53 ширхэг, 3-р үеэс (10-15см) 44 ширхэг, 4-р үеэс (15-20см) 75 ширхэг, 5-р үеэс (20-25см) 72 ширхэг, 6-р үеэс (25-30 см) 43 ширхэг чулуун зэвсэг, ваар савны хагархай одлоо. Төрөл зүйн хувьд ангилан ялгахад үлдэц (4 ш), хусуур (1 ш), зэвний суурь хэсгийн хугархай (1 ш), ваар савны хэлтэрхий (4 ш) байх ба үлдсэн хэсэг нь ялтас, залтас, хагархайнууд юм.

3-р сорьц малтлага (*IKH-9 TE-1*). Энэ талбайгаас нийт 144 чулуун зэвсгийн зүйл, 2 ваар савны хагархай илрүүлэн олов. 1-р үеэс (0-5см) 15 ширхэг, 2-р үеэс (5-10см) 28 ширхэг, 3-р үеэс (10-15см) 33 ширхэг, 4-р үеэс (15-20см) 70 ширхэг олдворыг малтан судлав. Олдворын дийлэнхийг хэмжээний хувьд жижиг залтас, ялтас, хагархай, хэлтэрхий (нийт 140 ш) бүрдүүлэх ба үлдэц, хусуур зэвсэг тус бүр 1, ваарны хагархай 2 байх ажээ.

28-р дурсгалт газар (IKH-28)

Бургасны энгэрийн энэ сууринд туршилтын сорьцийг 13 газарт явуулахаар анхлан төлөвлөсөн боловч судалгааны ажлын явцад 7 цэгт сорьцийг хүрз ашиглан хийлээ. Хүрз болон өрөмдөгийн аргыг хослуулах арга зүйг хэд хэдэн цэгт туршин үзэв. Энэ нь тухайн цэгт сорьцийг эхлээд хүрзээр явуулан, тодорхой түвшинд дуусгаад үргэлжлүүлэн “Aguer” багажаар өрөмдөх арга юм.

TP-6. 40х40см хэмжээтэй хүрзэн сорьц хийсэн. Бор шаргал өнгөтэй элсэрхэг хөрс үргэлжилсээр 30см-ийн гүнээс байгалийн хад гарч малтлагыг дуусгасан. Олдвор илэрч гараагүй.

TP-7. 36х28см хэмжээтэй сорьц. Хүрзээр 10см-ийн гүнтэйгээр үечлэн явуулсан. 1-р үеэс (0-10см) 11 ширхэг ялтас, 3-р үеэс (20-30см) 2 ширхэг залтас, 4-үеэс (30-40см) 1 ширхэг залтас тус тусгарсан. 40см-ийн гүнд боржин чулуун хаданд тулсан тул малтлагыг зогсоосон.

TP-8. Сорьцын хэмжээ 40х40см. 1-р үеэс (0-10см) 4 ширхэг ялтас, 2-р үеэс (10-20 см) 1 ширхэг ялтастус тусолдсон. Малтлагыг 50 см хүртэл үргэлжлүүлэн зогсоогоод доош 75см гүнд хүртэл “Auger” ашиглан өрөмдөж байгалийн хаданд тулгасан. Олдворын зүйл нэмж олдоогүй.

TP-10. Сорьцийн хэмжээ 40х40см. 1-р үеэс (0-10см) 11 ширхэг ялтас, 2-р үеэс (10-20см) 3 ширхэг ялтас, 4-үеэс (30-40см) ганц ялтас, 5-р үеэс (40-50см) 1 ширхэг ялтас тус тусолдсон. Малтлагыг 50см хүртэл үргэлжлүүлэн зогсоогоод доош 75см гүнд хүртэл “Auger”ашиглан өрөмдөж байгалийн хаданд тулгасан. Олдворын зүйл нэмж гараагүй.

TP-11. Сорьцийг 40х40см хэмжээтэй малтсан. 1-р үеэс (0-10см) 8 ширхэг ялтас, 2-р үеэс (10-20см) 1 ширхэг ялтас, 3-үеэс (20-30см) ганц ялтас тус тусолдсон. Малтлагыг 50см гүн хүртэл үргэлжлүүлсэн боловч нэмж олдвор илэрсэнгүй.

TP-12.Сонгосон цэгт 40х40см хэмжээтэй малтлагыг гүйцэтгэсэн. 1-р үеэс (0-10см) 10 ширхэг ялтас, 2-р үеэс (10-20см) 3 ширхэг ялтас гарсан. 30см-ийн гүнд байгалийн ургаа хад ил гарч малтлагыг зогсоосон.

TP-13. Сорьцийг 40х40см хэмжээтэй малтав. 1-р үеэс (0-10см) 10 ширхэг ялтас, 1 залтас илэрсэн ба бусад үеэс олдвор олдсонгүй. 50см-ийн гүн болоход байгалийн хаданд тулж малтлагыг зогсоосон.

Товч дүгнэлт

2016 оны хайгуул судалгааны ажлын үр дүнг дараах байдлаар товч дүгнэж байна. Үүнд:

- Судалгаанд бага хамрагдсан Их Нартын Байгалийн Нөөц газрын өмнөд хилийн дагуу 10 газрыг сонгон авч нарийвчилсэн шугаман хайгуулын ажил хийлээ. Эдгээр газруудаас археологийн дурсгал цөөхөн илэрсэн нь газар зүй, геологийн тогтоцтой холбоотой хэмээн үзэж байна.
- Шугаман хайгуул хийсэн таван талбайгаас неолитын үеийн чулуун зэвсгийн дурсгал илэрсэн бөгөөд олдвор хэрэглэгдэхүүн харьцангуй бага байгаа нь түр зуурын шинжтэй буудал болохыг илтгэн харуулна.
- Саруулын дугуй, Саруулын усны ойролцоогоос неолитын үеийн томоохон суурин илрүүлэн олж газрын гадарга дээр тархсан олон зуун чулуун зэвсгийн дурсгалуудаас сонголтын зарчмаар түүвэрлэлт хийж, бүртгэн боловсруулав. Энэ суурин нь Их Нартын Байгалийн Нөөц газрын нутаг дэвсгэрээс олдсон неолитын томоохон суурингийн нэг болохыг багаж зэвсгийн төрөл олон тоотой байгаа болон үр тариа цайруулах самбар чулуу хэдэн арваар олдсноор тодорхойлогдоно.
- Саруулын дугуйн арын боржин хадан цохионоос орхоны руни бичээсийн дурсгал шинээр нээн олсон нь эрдэм шинжилгээний хувьд чухал ач холбогдолтой юм.
- Туршиц, сорьц малтлагыг тусгай арга зүйгээр явуулсан нь үр дүнгээ өгөв. Неолитын үеийн соёлт давхарга бүхий хэд хэдэн газрыг илрүүлсэн нь говийн бүс нутагт цаашид чулуун зэвсгийн соёлт давхарга бүхий суурин илрүүлэх судалгаа, арга зүйн чухал туршиц судалгаа болсон хэмээн үзэж байна.
- Саруулын усны арын дэнжээс 5 дөрвөлжин булш, Саруулын дугуйн зүүн талаас нэг жижиг дөрвөлжин булш, Хөмсөгтөөс хэд хэдэн чулуун байгууламж илрүүллэн олсон нь хүрэл зэвсгийн үеийн соёл үлдээгсдийн томоохон төв нь Их нарт байсан гэсэн урьд урьдын таамаглалыг улам баталгаажуулсан явдал болов.

Талархал

Их Нартын Байгалийн Нөөц газрын археологийн дурсгалыг судлах ажлыг бүх талаар дэмжин тусалсан ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн захирал С.Чулуун, Денверийн Зоологийн сангийн Монголын хөтөлбөрийн захирал Ж.Ганчимэг (GanaWingard), Монголын ховор амьтныг хамгаалах эвслийн гүйцэтгэх захирал Т.Сэлэнгэ, ИНБНГ-ын Хамгаалалтын захиргааны дарга С.Амгаланбаатар, жолооч Ё.Батсайхан, Ц.Уламбаяр, С.Бат-Амгалан, тогооч Д.Жавзансүрэн, Б.Цэцэгбаяр, камп менежер Р.Өлзийдүүрэн, МУИС-ийн оюутан Б.Солонго, Г.Нямдаваа, А.Золжаргал, хайгуул судалгааны ажилд үлэмж тус хүргэсэн

Eartwatch хүрээлэнгийн сайн дурын судлаачид Brierty Peter Skye, Brierty Rebecca Skye, Brierty Bernadette, Villescaz Christiane Alene, White Mary Lou, Deibler Lance, Everson Lisa Danielle, Everson George Dicken, Comeau Brad, Ciolek-Torello Richardнар болон Их Нартын Судалгааны төвийн нийт судлаачид, байгаль хамгаалагч нартчин сэтгэлийн талархал илэрхийлэхэд таатай байна.

Хамтарсан экспедицийн үйл ажиллагааг дэмжин тусалдаг Eartwatch хүрээлэн, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Denver Zoo, Trust for Mutual Understanding байгууллага, ИНБНГ-ийн Хамгаалалтын захиргаа, Монголын ховор ан амьтныг хамгаалах эвсэл, АНУ-ын Монгол улс дахь Элчин сайдын яам, зэрлэг амьтныг хамгаалах "Аргаль" төв, California State Parks, Anza Borrego Desert State Park экспедицийн нийт судлаачдын өмнөөс талархал дэвшүүлье.

Зураг 1. 2016 оны судалгааны ангийн бүрэлдэхүүн

Зураг 2. Шугаман хайгуулын явц



Зураг 3. Дурсгалын баримтжуулалт хийж буй байдал

Зураг 4. Хайгуулын ажлын халуун мэтгэлцээн

Зураг 5. Өрөмдлөгийн “Auger”багажаар туршилтын сорьц хийж байгаа байдал

Зураг 6. Эртний тамга бүхий хад

Зураг 7. Дурсгалын баримтжуулалт

Зураг 8. Дөрвөлжин булш

Зураг 9. Бичил үлдэц

Зураг 10. Хусуур зэвсэг

Зураг 11. Үр тариа цайруулах самбар чулуу

Зураг 12. Ялтас цуулсан бичил үлдэц

Зураг 13. 9-р суурингийн 1, 2-р малтлага

Зураг 13. 9-р суурингийн малтлага

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМЫН НУТАГТ ЭРТНИЙ СУДЛАЛЫН ХАЙГУУЛ ХИЙСЭН ТУХАЙ

Я.Цэрэндагва, Р.Төрбат, С.Далантай

Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр багийн нутагт эртний судлалын хайгуул судалгааны ажлыг 2016 оны 5-р сарын 5-12-ний хооронд хийж гүйцэтгэв.

Судалгааны ажлын зорилго нь Төв аймгийн Лүн сумын нутагт буй Элстэйн давааны хадны зургийн дурсгалыг бүртгэн баримтжуулах, хуулбар хийх, тухайн дурсгалын ойр орчмын археологийн дурсгалыг судлах, нутгийн ардын аман мэдээг шалгах байв.

Цөөн хоногт хийсэн судалгааны дүнд Элстэйн даваа, Улаанчулуутын өвөлжөө, Цувраагийн хадны зургийн дурсгал, Улаанчулуут уулын баруун амны хүннү булш, Улаанхудагийн амны тахилийн байгууламж, дөрвөлжин булшны цогцолбор, Мааньтийн өвөлжөөний бүлэг дурсгал, Хангай уулын өврийн хүннү булш зэрэг олон дурсгалыг бүртгэн баримтжуулж судлав.

Элстэйн давааны хадны зураг

Хадны энэ зураг Төв аймгийн Лүн сумын төвөөс баруун тийш 16км зайд орших Элстэйн даваа хэмээх давааны орой дээр оршино. Даваан дээрх овооны хойд талын наран ээвэр, өмнө зүг харсан том толигор хаднуудад эртний хүмүүс дурсгалаа мөнхлөн үлдээжээ. Тухайн дурсгалт газрыг МУБИС-ийн багш Р.Төрбат анх 2010 оны эхээр олж илрүүлэн, цөөн тооны дүрслэлийг хуулбарлан МУБИС-ийн оюутны эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж байв[1]. 2013 онд Соёлын өвийн судалгааны төвийн судлаачид мөн очиж үзэн хуулга хийсэн байдаг[2]. Энэ хадны зургийн зарим дүрслэлийг Я.Цэрэндагва, Р.Төрбат нар судлан, өгүүлэл бичжээ[3].

Энд нийтдээ 29 хэсэг хаданд зураг байгаа ба бүх талбайгаар нь хонхойлж цохих, биеийн ерөнхий тэгийг хөвөөлөн цохих аргаар зурснаас гадна зарим дүрсийг хурц үзүүртэй зүйлээр цоолборлон дүрсэлжээ.

Элстэйн давааны зургийн гол сэдэв нь ан амьтан, ан агнуур, сүсэг бишрэлийн холбогдолтой зан үйл болно.

---

[1] *Р.Төрбат. Элстэйн давааны хадны зарим зургийн онцагийн тухайд. МУБИС-ийн оюутны эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. УБ., 2010.*

[2] *Хангайуулын Элст хөтөлийн хадны зураг. Соёлын өвийн мэдээ, мэдээлэл. №7. УБ., 2013, Тал. 28-29*

[3] *Я.Цэрэндагва, Р.Төрбат. Элстэйн давааны хадны зургийн зарим дүрслэлийн тухайд. – Нүүдэлчдийн өв судлал. T.XV. F. 4. УБ., 2013. Тал 30-35.*

Улаанчулуутын хадны зураг

Улаанчулуут нь Төв аймгийн Лүн сумаас баруун хойш 8-10км-т байх сүрлэг тогтоцтой уул юм. Энэ уулын өвөрт Лүн сумын Өгөөмөр багийн малчин М.Даваажавын өвөлжөө байх ба хадны зургийн дурсгал өвөлжөөний арын, баруун хойноос зүүн урагш чиглэлтэй, үеэлсэн тогтоц бүхий занарлаг хаданд бөөн байдлаар сийлэгджээ. Нийтдээ 31 хэсэг хаданд ганц нэгээс авахуулаад олон тооны дүрслэл, бичээсийг сийлбэрлэн үлдээсэн байна. Он цагийн хувьд хүрэл зэвсгийн үеэс дундад эртний улсуудын үе хүртэлх цаг хугацааны өргөн хүрээлэлд хамаарна.

Улаанчулуутын өвөлжөөнөөс шинээр илрүүлэн судалгааны эргэлтэд оруулж буй хадны зураг болон орхоны руни бичээсийн дурсгалууд түүхийн тодорхой зааг ялгаатай цаг үед бүтээгдсэн байна. Хамгийн эрт хүрлийн эхэн үеэс энэ газрын хаднаа хүмүүс зураг сийлж эхэлсэн байх ба дундад эртний үе хүртэл үргэлжилжээ.

Эрт үед холбогдох зургууд бодит байдалтай, амьтны хөдөлгөөн, онцлогийг тод илэрхийлсэн байх бол хүрэл зэвсгийн сүүл төмөр зэвсгийн үеэс амьтдыг загварчлан дүрслэх хандлага бий болсныг харж болно. Амьтныг загварчлан дүрслэх арга бугааас гадна янгирыг дүрслэхдээ тодорхой хэмжээгээр дэлгэрсэн нь Улаанчулуутын загварчилсан хэв шинжтэй янгирын дүрсээс тодорхой мэдэгдэнэ.

Тамга тэмдэгийн дурсгал Улаанчулуутын хадны зургийн дотор онцгой байр суурь эзлэж байна. Тамганы хэв загвар, төрөл зүйл олон байгаа бөгөөд зарим тамга хүрэл зэвсгийн сүүл үеэс анхлан зурагдсан байх магадлалтай ба хүннү, дундад эртний улсын үеийг дамнан сийлэгджээ.

Хэдийгээр Улаанчулуутын өвөлжөөний хадны зургийн дурсгал тодорхой зохиомж, өгүүлэмжит зураг цөөвтөр хэдий ч дүрслэлийн арга барил, дүрийн хэв шинж зэргээр судалгааны чухал ач холбогдолтой дурсгал юм. Хадны зураг урлалын үндсэн хоёр арга барил эндхийн хадны зурагт тод илрэх төдийгүй зарим тохиолдолд зүлгэж сийлэх аргыг ашигласан байдал ажиглагдлаа.

Цувраагийн хадны зураг

Лүн сумын төвөөс баруун хойш 8км, Туул голын тохойноос 1км гаруй зайд зүүн хойноос баруун урагш Туул гол руу чиглэсэн дэл байх бөгөөд Цувраагийн дэнж хэмээн нэрлэдэг. Дэлийн төв хэсэгт нэгэн хадтай толгой онцгойдуухан дүнхийх ба саарал өнгийн цул мөхлөгт хадан тогтоцтой. Хадны гадаргуу нь нар, салхины нөлөөгөөр ихээхэн өгөршсөн байдалтай. Энэ толгойн орой болон зүүн хажуугийн хадаар хадны зургийн дурсгал байна.

Хадны зургийн хадгалалтын байдал маш муу бөгөөд ихэнх зураг элэгдэж өгөршиж, зарим дүрслэл, зохиомж мэдэгдэхгүй болжээ.

Энд нийт 17 хэсэг хаданд хадны зургийн дурсгал байх ба дүр дүрслэлүүдээс янгир голлоно, мөн түүнчлэн, морь, буга, хүн, үл танигдах дүрслэл байна. Зохиомжийн хувьд авч үзвэл тодорхой өгүүлэмжит зохиомжит зураг тун ховор, харин

олон тооны янгирыг нэг дор, бугыг тойруулан үл танигдах дүрслэл сийлсэн зэрэг өгүүлэмж тодорхой бус зохиомжууд байна.

Мааньтийн өвөлжөөний хадны зураг

Цувраагийн хаднаа зүүн тийш орших Мааньтийн өвөлжөөний арын хадтай уулын боржин цохио хадны дөрвөн хэсэг газарт хадны зураг байна. Энд мөчрөн эвэртэй хэд хэдэн буга, олон янгир. Өвөлжөөний арын хадтай уулын боржин цохио хадны 4 хэсэг газарт хадны зурагтай.

1-р зураг. Айлын гэрийн буурийн дээхэн талын хавтгай цохио хадны урд талын тэгш хавтгайд нэг мөчрөн эвэртэй буга, олон янгир сийлжээ.

2-р зураг. Том үхэр чулуун хаданд нэг дор 6 буга сийлжээ. Төв хэсгийн дүрслэлүүд ихэд бүдгэрсэн байдалтай харагдана.

3-р зураг. Үхэр чулуун боржин хадны хажууд 5 буга сийлжээ

4-р зураг. Том боржин хадны урагш харсан хавтгай дээр ганц том буга сийлжээ.

Улаанчулуут уулын баруун амны бүлэг булш

Улаанчулуут уулын баруун амны дэвсэг дээр хоорондоо тодорхой зайтай байрлах 26 хүннү булш, нэг том хиргисүүр илрүүлэн бүртгэн баримтжуулав. Эдгээр хүннү булшууд 3-8,5м хэмжээтэй бөгөөд цагираг чулуун дараастай, зарим булшны дараас хөрсөөр хучигдсан, тоногдсон шинж байхгүй байна. Хиргисүүр дөрвөлжин хүрээтэй, зүүн талдаа 6 тахилын, баруун талдаа 6 цагирган байгууламжтай.

Улаан худагийн амны бүлэг дурсгал

Цувраагийн зүүн хойд талын хөндийг Улаанхудагийн ам хэмээн нэрлэдэг. Мөн нутгийнхан Бургасны хар гэж нэрлэх нь бий. Сонин хангай уулын баруун талын тохойрсон уудам хөндий. Энэ хөндийд археологийн олон тооны дурсгалтай. Энд түрэгийн үеийн хашлага чулуут тахилын байгууламж (9), дөрвөлжин булшны цогцолбор бий. Тахилын байгууламжийг ганцаар болон нэг дор олноор эгнүүлэн цогцлоосон байна. Дөрвөлжин булшны хувьд 13 байна.

Мааньтийн өвөлжөөний дурсгал

Мааньтын өвөлжөөний баруун талын хадтай толгойн ар шилээс зүүн зүг чиглүүлэн (101°) хөшөө чулуудыг зэллүүлэн босгожоо. Нийт 65 хөшөө чулуу байгаагаас 56 нь босоо, 9 нь унасан байдалтай. Баруунаас 6 дахь хөшөө чулуун дээр 5 янгир сийлээстэй байна. Мөн нэг хөшөөн дээр хөмөргөн ширээтэй дором тамга сийлээстэй бий. Зэл чулууны ойролцоо 4 дугуй хүрээтэй хиргисүүр, 5 дөрвөлжин булш байна.

Дүгнэлт

Төв аймгийн Лүн сумын нутагт хийсэн хайгуул судалгааны үр дүнд Элстэйн давааны хадны зургийг бүрэн баримтжуулан тодорхойлж, Улаанчулуутын өвөлжөө, Цувраагийн хадны зургийг шинээр бүртгэн, Хүрэл зэвсгийн үедхолбогдох хиргисүүр

6, дөрвөлжин булш -13, дугуй булш -1, Хүннүгийн булш -26, эртний улсуудын үед холбогдох тахилын байгууламж -9, зэл чулуу -1-ийг тус тус илрүүлэн баримтжууллаа.

Илэрч олдсон дурсгалуудын элэгдэл өгөршил, хадгалалт, хамгаалалтын байдал харилцан адилгүй байдалтай байна.

Булш хиргисүүрүүд тоногдсон шинж байхгүй байгаа бөгөөд харин тахилын байгууламжуудын хувьд механик үйлдлийн нөлөөгөөр нурж унасан, хашлага, хөшөө чулууд анхны байрлалаа алдсан нь нийтлэг байв.

Хадны зургийн дурсгалын хувьд элэгдэл өгөршилд их хэмжээгээр өртсөн байдалтай. Энд байгалийн нөлөө их хүчин зүйл болсны дээр хүний болон малын нөлөө их хэмжээгээр нөлөөлсөн байна. Тухайлбал, Элстэйн давааны хадны зарим зурагтай байсан байж болохуйц хавтангуудыг ховхлон авч явсан нь илт байна. Улаанчулуутын өвөлжөөний хадны зураг, бичээсийн дурсгал өвөлжөөн дээр байх тул газраас гарсан гарш хадан дээр дүрслэгдсэн зураг, бичээсүүд маш ихээр элэгдэж зарим нэг нь мэдэгдэхгүй болсон байв. Цувраагийн хадны зургийн хувьд байгалийн нар, салхины нөлөөнөөс шалтгаалан хадны зургууд ихэд бүдгэрсэн байх ажээ.

Цаашид Улаанчулуутын амны эртний орхон бичээсийн дурсгалыг нэг бүрчлэн тусгай арга зүй боловсруулан хуулбарлан авах шаардлагатай хэмээн үзэж байна. Тэдгээр бичээс нь Монголын эртний бичээсийн судалгаанд шинээр бүртгэгдэн эрдэм шинжилгээний эргэлтэд орж байгаа нь бидний хайгуул судалгааны чухал үр дүн юм.

Булш, хиргисүүр, тахилын байгууламжууд олон янз байгаа нь энэ бүс нутагт эртнээс үе дамжин нүүдэлчид нутаглан ирсний баталгаа юм. Бидний бүртгэн баримтжуулсан дурсгалаас гадна Элстэйн даваан өвөрт 40 гаруй хүннү булштай томоохон дурсгалт газар байв. Цаашид энэ газарт нарийвчилсан хайгуул, малтлага судалгаа хийхэд судалгааны ач холбогдлын хувьд сонирхолтой байж болох юм.

Төв аймгийн Лүн сумын нутаг Туулын тохойн ойр орчим, Хангай уул, Улаан чулуут уул, Сонин хангай уулсын орчмын бүс нутагт археологийн өргөн хэмжээний хайгуулыг хийвэл урьд өмнө илэрч олдоогүй шинэ шинэ дурсгалт газрууд илрэх магадлал ихтэйг цөөн хоногт явуулсан бидний хайгуулын ажлын үр дүн илтгэн харуулж байна.

Зураг 1. Элстэйн давааны хадны зураг

Зураг 2. Элстэйн давааны хадны зураг

Зураг 3. Элстэйн давааны хадны зураг

Зураг 4. Улаан чулуутын хадны зураг

Зураг 5. Улаан чулуутын хадны зураг

Зураг 6. Цувраагийн хадны зураг

Зураг 7. Мааньтийн өвөлжөөний хадны зураг

Зураг 8. Мааньтийн өвөлжөөний хадны зураг

Зураг 9. Улаан чулуутын баруун амны хүннү булш

Зураг 10. Улаан худагийн амны тахилын байгууламж

Зураг 11. Улаан худагийн амны хашлагат тахилын байгууламж

Зураг 12. Улаан худагийн амны дөрвөлжин булш

Зураг 13. Маааньтийн өвөлжөөний зэл чулуун байгууламж

Зураг 14. Маааньтийн өвөлжөөний зэл чулуун дээрх тамганы дүрслэл

“ДОРНОД МОНГОЛ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 2016 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

Д.Хатанбаатар, Ц.Цэцэгжаргал, Д.Түмэн

МУИС-ийн “Дорнод Монгол” төслийн хээрийн судалгааны анги Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уулын Адгийн гол дахь эртний оршуулгын цогцолборт 2015 оны 6-р сарын 26-наас 7-р сарын 7-н хүртэл 18 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав. Энэ хугацаанд 6 дурсгалыг малтан судалснаас гадна Адгийн гол дахь хүрэл зэвсгийн үеийн оршуулгын газрын дэвсгэр зургийг шинэчлэх ажлыг гүйцэтгэлээ.

Судалгааны энэхүү төсөл нь 2008 оноос Дэлгэрхаан ууланд төвлөрөн ажиллахдаа хүрэл зэвсгийн үеийн булш оршуулгын дурсгалуудыг судлах зорилгоор уг уулын Улаан зуух, Булгийн гол, Адаг голын дурсгалт газруудад тогтмол малтлага судалгаа явуулж байгаа билээ. Адаг голын дурсгалт газрын хувьд 2012 онд хийгдсэн шинэчилсэн хайгуулаар бүртгэж, 21, 23-р булшийг малтан судалсан болно. Бид энэ удаад Адгийн голын оршуулгын газрын хойд хэсэгт орших 112, 113, 114, 115 дугаарт цувраа дурсгал болон тэдгээрээс арай зайдуу орших 116, 117 буюу нийт 6 дурсгалыг малтан судлав.

Эдгээр дурсгалууд нь Дэлгэрхаан уулын бусад газар орших хүрэл зэвсгийн үеийн дурсгалуудтай үндсэндээ ижил боловч газар зүйн байршлын хувьд жижиг толгодын орой хэсгээр гол төлөв тархсанаараа онцлогтой. Хэмжээний хувьд томгүй их төлөв ганц нэгээр тархан байрласны зэрэгцээ 4–өөс илүүгүй дурсгал бүлэг булш болох тохиолдол ажиглагдаж байна. АГ 112-115 дурсгал нь өөр хоорондоо нийлсэн 4 жижгэвтэр байгууламж ба оршуулгын газрын хамгийн хойд талд оршино. Нийт 18м урт, 6м өргөн талбайгаар цэвэрлэн малтав. АГ 116-117-р дурсгал нь оршуулгын газрын зүүн хэсэгт бусдаас арай зайдуу, зэрэгцэн оршино. Уг 2 дурсгалыг 9х8м хэмжээгээр нийт талбайгаар нь тэг татаж цэвэрлэв. Уг дурсгалаас зүүн хойд зүгт 9м зайд хэсэг чулууг босгож зоосон байдалтай байна.

Бид ийнхүү хагас сарын хугацаанд 6 дурсгалыг иж бүрэн, бүх талбайгаар малтан судлав. Малтан судалсан бүх дурсгалууд нь тахилга, мөргөлийн зориулалтаар хийгдсэн байлаа. Энэхүү судалгаа нь Дэлгэрхаан уулнаа орших хүрлийн үеийн дурсгалууд нь бүгд оршуулгын зориулалтаар хийгдээгүй болохыг харуулав.

Адгийн голын 117-р дурсгалыг цэвэрлэх явцад харьцангуй хожуу үед холбогдох вааран савны жижиг хагархай илэрснийг эс тооцвол ямар ч эд өлгийн зүйл, хойлго хийсэн ул мөр ажиглагдсангүй. Ийм төрлийн дурсгалууд нь оршуулгын бус тахилгын зориулалтаар, зарим тохиолдолд төөрөгдүүлэх зорилгоор хийгдсэн байдаг тул гадаад хэлбэр адил хэдий боловч ямар нэгэн эд өлөг хийлгүй, зан үйл гүйцэтгэх төдий хийгдсэн байдаг.



"Дорнод Монгол 2016". Адаг гол 112-115. Гар зураг

"Дорнод Монгол 2016". Адаг гол 112-р дурсгал

"Дорнод Монгол 2016". Адаг гол 115-р дурсгал

МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН "ЭРТНИЙ МОНГОЛ ХҮН" ТӨСЛИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН ТОВЧ ҮР ДҮН

Ц.Амгалантөгс, Мияамото Казуо,
Н.Эрдэнэ-Очир, Л.Дэлгэрмаа, Л.Ишцэрэн

2009 оноос эхлэн Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн, Япон улсын Кюүшүгийн Их Сургуультай хамтран "Эртний Монгол хүн" төслийг амжилттай хэрэгжүүлж байна.Уг төслийн хүрээнд Монголын хүрэл зэвсгийн үед холбогдох дөрвөлжин булш, шоргоолжин булш, хиргисүүрийн малтлага судалгааг Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Дарам уул, Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Тэвш уул, Баянхонгор аймгийн Богд сумын нутаг Бор овоо, Говь-Алтай аймгийн Тонхил смын нутаг Хяр хараач хэмээх газруудад хийсэн.

Тус төслийн 2016 оны хээрийн шинжилгээний анги 7-р сарын 25-наас 8-р сарын 7 хүртэл нийт 14 хоногын хугацаатай үргэлжилсэн бөгөөд хээрийн судалгааны ажлын гол зорилго нь Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг Эмээл толгой хэмээх хүрэл зэвсгийн үед холбогдох цогцолбор дурсгалуудаас 2 дурсгалыг сонгон малтах,дурсгалт газрын дурсгалуудыг нарийвчлан бүртгэн баримтжуулж, дэвсгэр зургийг хийх, малтлага судалгаанаас илэрсэн хүн малын ясанд изотопи болон он цаг тогтоох лабораторийн нарийвчилсан судалгааг явуулахад оршиж байлаа.

Хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд: Монголын талаас тус хүрээлэнгийн Археологийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан докторант, Ц.Амгалантөгс, Л.Дэлгэрмаа, Хүрэл, төмрийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан доктор, Н.Эрдэнэ-Очир, Хүннү ба эртний түүхийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан Л.Ишцэрэн Японы талаас Кюүшүгийн Их Сургуулийн доктор, профессор К.Мяамото тэргүүтэй 4 судалаачид оролцон ажилласан.

Судалгаа явуулсан дурсгалт газар нь Баянхонгор аймгийн Галуут сумын төвөөс баруун зүгт 22км-т 4-р баг буюу Баяннуур багийн нутагт байрлана. Дурсгалт газрын ерөнхий тогтоц нь Өвөр тээлийн голын зүүн хойно 3км орчимдулаан хүрэн өнгийн боржин хадтай уулынурд үзүүрт цайвар өнгийн том том боржин хад бүхий сондгой толгойг Эмээл толгой хэмээн нэрийднэ. Эмээл толгойн орчимдхуучин чулуун зэвсгийн үеэс эхлэн хүрэл зэвсгийн үед холбогдох дугуй, дөрвөлжин хэлбэрийн хүрээтэй дөрвөн талдаа хөшөө чулуутай хиргисүүр, буган чулуун хөшөө, хөшөө чулуу, тахилын байгууламж, шоргоолжин булш зэргээс бүрдсэн томоохон цогцолбор дурсгалт газар юм.

Малтлага судалгаа: Малтлага судалгааг Эмээл толгойн баруун урд талын бүлэг дурсгалт газарт явуулж 30,40 хэмээн дугаарласан хоёр дурсгалыг сонгон малтсан.

30-р хиргисүүр: Уг дурсгал нь дугуй хэлбэрийн хүрээтэй, дөрвөн талдаа хөшөө чулуутай, голдоо овгор чулуун дараастай, хүрээний голч 19м, голын дараасны голч 7м. Малтлагын явцад 42см гүнээс хүний гавлын ясны хагархай болон хөл, гарын ясны хугархай хэсгүүд гарсан. Малтлагаас илэрсэн ясны байрлалд тулгуурлан үзэхэд тухайн оршуулгыг үйлдэхдээ нас барагчийн толгойг баруун хойд зүг хандуулан тавьсан болох нь тодорхой байна. Энэхүү дурсгал нь эрт үед тоногдожхүний ясны ихэнх хэсэг тарж үгүй болсон хэдий ч хөл, гарын урт мөчдийн ясны байрлал анх тавьсан байдлаа алдаагүй байлаа.

Малтлагаас илэрсэн хүний яс (дунд чөмөг)

Малтлагаас илэрсэн хүний яс (тахилзуур яс)

30-р хиргисүүр. (өнгөн хөрсийг цэвэрлэсний дараах байдал)

40-р хиргисүүр: Дугуй хэлбэрийн хүрээтэй, дөрвөн буландаа хөшөө чулуутай, голын дараасыг хүрээтэй ижил төвшинд жижиг чулуугаар битүү чигжиж даржээ. Хэмжээ 8мх8м. Малтлагын явцад 40см гүнээс баруун хойд зүг хандуулан тавьсан оршуулга илэрсэн. Хүний оршуулга хөндөгдөөгүй маш сайн хадгалагдсан байна. Хүний ясны судалгаагаар 30-35 орчим настай эрэгтэй, биеийн өндөр дунджаар 176.8см байлаа.



30-р хиргисүүр. (Хүний яс)

Малтлагаас илэрсэн хүний яснаас дээж авч Япон улсын Кюүшүгийн Их Сургуулийн лабораторид илгээн холбогдох он цаг болон бусад нарийвчилсан судалгааг хийж байна.

40-р хиргисүүр.(өнгөн хөрсийг цэвэрлэсний дараах байдал)

40-р хиргисүүр.(оршуулгын дараас чулуу)

40-р хиргисүүр. (оршуулга)

Хайгуул судалгаа: 2016 оны хээрийн судалгааны ажлын хүрээнд малтлага судалгаанаас гадна тухайн дурсгалт газар бүрэн хэмжээний хайгуул судалгаа хийн нийт 124 дурсгалуудыг бүртгэн баримтжуулж зарим дурсгалуудын 3D зураглал хийсэн.



Дурсгалуудын ерөнхий байршил

Түүвэр олдвор: Эмээл толгойн орчимд хуучин болон шинэ чулуун зэвсгийн үед холбогдох чулуун зэвсгийн дурсгалууд өнгөн хөрсөн дээр тархсан байх бөгөөд бид малтлага болон хайгуул судалгааны явцад цөөн тооны чулуун зэвсэг түүвэрлэн авсан.

түүвэр олдвор (Шинэ чулуун зэвсэг)

Тодорхойлолт-1. Эдгээр дотор үлдцийн төрлийн эдлэл 2 ш, залтас 1 ш, ялтасны хугархай 1 ш байгаа нь шинэ чулуун зэвсгийн үед хамаарна. Эхний үлдэц нь тайрдсан төрөлд хамаарах ба цохилтын талбайг холтчих маягаар гаргаад, суур хэсгийг хоёр талаас цуулалх замаар шовхолжээ. Энэхүү тайрдсан үлдцийн бүх талаас янз бүрийн хэмжээтэй ялтас салган авах оролдлого хийсэн байна. Хоёр дахь үлдэц нь жижгэвтэр хэмжээтэй бөгөөд шаантган үлдцийн төрөлд хамаарах ажээ. Цуулалтын талаас 4 ш бичил ялтас цуулан авсан байх ба эсрэг талыг нэг талаас хөндлөн цуулах замаар хурцсалсан бол нөгөө талыг цохилтын талбайгаас цуулах замаар зассан байна. Харин суурийг хоёр талаас холтчин шовхолжээ.

Тодорхойлолт-2. Үлдсэн эдлэлүүд нь хэв шинжийн хувьд хуучин чулуун зэвсгийн үед холбогдох бөгөөд зэвсгийн төрөлд 3 ш эдлэл хамаарах бол бусад нь цуулдас үйлдвэрлэл багтана.

Эхний эдлэлийгийг ялтсан цуулдасны доод хэсгийн хугархай ашиглан бэлтгэсэн байх ба нэг талын тууш ирмэгийг хагас босоо цуулалтаар том ир гаргаад, дараа нь жижгээр холтчих замаар дахин ирлэсэн бол нөгөө ирмэгт налуу ир гаргасан нь хусуур хэлбэртэй болжээ. Хоёр дахь эдлэл нь анхдагч цуулдасны хугархай бөгөөд нэг тууш захад холтчих маягаар тохиолддлыг хүнхэр ир гаргасан байна. Үлдсэн эдлэлийн нэг муруй захад тохиолддлын ир гаргажээ.

түүвэр олдвор (Хуучин чулуун зэвсэг)

Дүгнэлт

2016 оны хээрийн судалгааны ажлын хүрээнд малтлага судалгаанаас гадна дурсгалуудын 3D зураглал хийж, дурсгалт газарт бүрэн хэмжээний хайгуул хийж дурсгалуудын дэвсгэр зургийг нарийвчлан хийлээ. Малтлага судалгаагаар дөрвөн буландаа хөшөө чулуутай дугуй хэлбэрийн хиргисүүр хоёрыг малтан судалсан бөгөөд малтлага судалгааны үр дүнд дээрх 2 дурсгалаас баруун хойд зүг хандуулан тавьсан оршуулга илэрсэн. 30-р дурсгалын оршуулга хөндөгдөж, хүний ясны хэрэглэгдэхүүн тарж үгүй болсон хэдий ч цөөн тооны ясны үлдэгдэлээс нас биед хүрсэн хүнийг оршуулсан болохыг мэдэж болохоор байна. Харин 40-р дурсгалаас бараг бүтэн оршуулга илэрсэн нь бидний малтлага судалгааны гол үр дүн байлаа. Малтлагаас илэрсэн хүн болон малын яснаас дээж авч Япон улсын Кюүшүгийн Их Сургуулийн лабораторид илгээн холбогдох он цаг болон бусад нарийвчилсан судалгааг хийж байна.

Ном зүй

Амартүвшин нар., 2004 – Амартүвшин Ч., Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б., Цэрэндагва Я., Ерөөл-Эрдэнэ Ч., Болдхуяг Д., Мөнхтулга Д., Хүрэлсүх С., Эрдэнэ-Очир., Номгуунсүрэн С., Чинзориг Б. Говь-Алтай аймгийн Тайширын УЦС-ийн Улаан боом нэртэй талбайд авран хамгаалах малтлага судалгааны ажлын тайлан. Улаанбаатар. ТАХГБСХ.

Амартүвшин нар., 2010 – Амартүвшин Ч., Эрдэнэ-Очир Н., Амгалантөгс Ц., Галдан Г. Ховд аймгийн Цэцэг, Дарви сумын нутаг дахь "МОН-ЭНКО" ХХК-ний "ХӨШӨӨТИЙН УУРХАЙ" ашиглалтын талбайд хийсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны тайлан. Улаанбаатар. ТАХГБСХ.

Амгалантөгс, 2014 – Амгалантөгс Ц. Хиргисүүрийн судалгааны сүүлийн үеийн үр дүн //Хүрэл, түрүү төмрийн үе ба Хүннүгийн өмнөх соёлын судалгааны асуудал. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар.

Амгалантөгс нар., 2007-2009 – Амгалантөгс Ц., Эрдэнэ Б., Дэлгэрмаа Л., Мандах Д. Хөвсгөл аймгийн нутагт ажилласан Монгол-Америкийн хамтарсан "Монголын Био-археологи" төслийн хээрийн шинжилгээний ангийн тайлан. Улаанбаатар. ТАХГБСХ.

Амгалантөгс нар., 2013 – Амгалантөгс Ц., Дэлгэрмаа Л. Монгол-Японы хамтарсан "Эртний Монгол хүн" төслийн археологийн малтлага судалгааны ажлын тайлан. Улаанбаатар. ТАХГБСХ

Амгалантөгс нар., 2015 – Амгалантөгс Ц., Батболд Н., Дэлгэрмаа Л., Амарболд. Монгол-Японы хамтарсан "Эртний Монгол хүн" төслийн археологийн малтлага судалгааны ажлын тайлан. Улаанбаатар. ТАХГБСХ.

William M.Bass. Human osteology**.** A laboratory and field manual. Third edition. 1987.

МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН "ШИНЭ ЗУУН" ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Б.Цогтбаатар, Л.Ишцэрэн, Г.Батболд, Э.Амарболд
Н.Ширайши, Т.Миякэ, Т.Сасада

Монгол-Японы хамтарсан "Шинэ зуун" төслийн хээрийн шинжилгээний анги нь 2001 оноос эхлэн Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь "Хэрлэний Хөдөө арал"-ын орчны бүсийн археологийн дурсгалын бүртгэл, хадгалалт хамгаалалт, чулуун зэвсгийн бууц суурин, хүрэл, төмөр зэвсгийн үе, Монгол гүрний үеийн хот суурин, булшны судалгаа зэрэг чиглэлээр хайгуул болон малтлага судалгааг амжилттай гүйцэтгэж ирсэн билээ.

2016 оны малтлага судалгааны ажил нь"Аваргын балгас"-ын туурийн талбайн малтлага, "Гурван дов"-д булшны малтлага судалгаа гэсэн үндсэн 2 хэсэгт хийгдсэн юм.

1. Гурван Довд малтлага судалгаа

Гурван Дов хэмээх дурсгал нь Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт Аурагын балгаснаас баруун өмнө зүгт 8км орчим зайд Хэрлэн гол, Аурагын гол хоёрын уулзварын баруун талд оршино. Уг Гурван Дов хэмээх дурсгал нь хоорондоо зэрэглдээ шороог дэлдэж өндөрлөсөн дурсгал юм. Бид хамгийн том буюу 30м голчтой довыг Дов-1 хэмээн дугаарласан бөгөөд Дов-1 ээс баруун тийш 40 метр зайд Дов-2 орших бөгөөд голч нь 20 метр өндөр нь 1 метр орчим юм. Дов-3 хэмээх дурсгал нь хоёр ойролцоо довоосоо баруун тийш 150 орчим метр зайд байрлах бөгөөд 25м голч, 0,5 метр өндөр юм.

Бид геофизикийн судалгаа хийдэг "ЛАЙЛИ" ХХК компаниар геофизикийн ВЭЗ-ийн арга буюу хэт урт үелзлэлийн долгионы аргаар Дов-1, 2 т хөндлөн болон босоо зүсэлт хийлгэсэн юм. Уг тандалт судалгааны үр дүнгээр Дов-1, 2-ыг төвлөсөн том хөндий юм уу, суларсан хөрс байна хэмээх үр дүн гарсан юм. Энэхүү мэдээллийн дагуу Дов-1-ийг сонгож малтлага судалгаа явуулахаар болсон юм.

Уг Дов-1 нь зөв дугуй хэлбэртэй бөгөөд Заамарын Шороон Дов, Баяннуурын Шороон Бумбагар шиг үүдэвчний дараас хэмээн ил мэдэгдэх зүйлгүй учир урд ба хойд зүгийн чиг зүсэлт хийж үзэхээр шийдсэн юм. Дов-1 урдаас нь хойш чиглэлтэйгээр 30 метр урт, 1 метр өргөн зүсэлт хийхээр шийдсэн бөгөөд энэхүү дурсгал хэрэв бунхант булш байвал үүдэвч уг зүсэлтээр илэрч болох бөгөөд уг зүсэлтээр тус дурсгалыг хэрхэн үйлдсэнийг мөн давхар тодруулах зорилготой байв.

Зүсэлтийг шороон довын урд талд 15м, хойд талд 15м байхаар хувааж тэнхилэг татсан бөгөөд урд талын зүсэлтийн баруун хана, хойд талын зүсэлтийн зүүн ханатай нэг шугманд байрлахаар хоёр зүсэлтийг зөрүүлэн татсан юм. Малтлага эхлэхэд уг

шороон довд хэсэг хугацаанд мэрэгчийн дош болж байсан шинжтэй хуучин нүхүүд илэрч байсан боловч шороог үелүүлэн дэлдсэн ором тодорхой мэдэгдэж байв. Мэрэгчийн нүхнээс гадна тонуулын бололтой дэлдсэн шороо том хэмжээтэй эвдэгдсэн байгаа нь мөн ажиглагдаж байв. Зүсэлтийн 20:20см-ээр хиймэл үе үүсгэн доош малтсан бөгөөд мэрэгчийн яс, зохион байгуулалт нь тодорхойгүй хүний ясны хэсэг, малын яс зэрэг зүйлс илэрч байсан бөгөөд эдгээр олдворууд голчлон довын төв орчимоос илэрч байв. Зүсэлтийн хамгийн гүн хэсэг 160см болоход өнгөн хөрс бололтой бор шороон хөрс илэрч байсан бөгөөд өмнө талын зүсэлтэнд хөндлөн буюу зүүн хойд зүгт хандуулж тавьсан хоёр оршуулга илэрсэн юм. Бид урд талаас нь Булш-1 хэмээн дугаарласан бөгөөд үүнээс хойш илэрсэн булшнуудыг илэрсэн дараалалаар нь дугаарласан юм.

Зүсэлтийг хийж дуусахад ямар нэгэн үүдэвч хэмээн үзэх байгууламж илрээгүй бөгөөд өмнө талын зүсэлтээс хоёр оршуулга илэрсэн бол Довыг төвлөсөн хэсэг буюу хойд зүсэлтэнд 4х1м орчим том толбо илэрсэн юм. Бид ханын зүсэлтийг гар зураг болон гэрэл зургаар баримтжуулан урд талын илэрсэн хоёр оршуулгын талбайг боломжит талруу нь сунгах малтлага хийсэн бөгөөд хойд зүсэлтийн илэрсэн нүхний толбыг бүтэн гаргах зорилготойгоор зүүн тийш 5х5 метр талбай нэмэж сунгасан юм. Энэхүү сунгалтаар зүүн тийш 3 метр орчимд дээрх толбо бүтэн илэрсэн тул талбайг багасган 4х3м болгон ул хүртэл малтсан юм.

Энэхүү томоохон толбо илэрсэн 4х2 метр орчим булшны нүх байсан байж болохуйц зөв хэлбэртэй зүүн хойд зүгт үл ялиг хазгай чигтэй байв. Бид энэ толбыг хөөж малтахад оршуулга илрээгүй ч хүний гараар үйлдсэн нүх болох нь тодорхой болов. Дээрх дэлдсэн шороог малтах явцад хүн болон малын яс тарсан байдалтай илэрч байсан нь магадгүй уг булшийг тонох явцад гаргасан байж болохоор байна. Тиймээс магадгүй энэ дов уг булшинд зориулагдаж үйлдэгдсэн байж болохоор байна. Учир нь дэлдсэн шорооны зүсэлтээс үзэхэд нүхний дээд хэсэгт үелэсэн цагаан шороо зөрж байгаа явдал юм. Энэ нь магадгүй уг оршуулгын нүхийг эхлэн үйлдээд дараа нь түүнийг тойруулан довыг дэлдэж өндөрлөөд оршуулгын нүхэнд хүнээ тавьж үлдсэн зайг сүүлд дэлдсэнээс үүдэж үе зөржээ хэмээн үзэх боломжтой байна.

Булш-1 Сорилын малтлага-1 буюу урд зүсэлтээс илэрсэн хоёр булшны хамгийн урд талын илэрсэн булшийг булш-1 хэмээн дугаарласан юм. Уг булш нь зүүн хойд зүг үл ялиг хазайсан оршуулга илэрсэн бөгөөд булшны нүх нь 2 метр урт өргөн нь 0,5 метр оршуулгын нүхэнд хүнээ тэнгэр байдлаар тавьсан бөгөөд бргийн яс болон шувууны яс хөл орчимд нь тавьж дагалдуулсан байна. Уг булшнаас илэрсэн шувууны ясыг шувуу судлаач Ш.Болдбаатар ангир шувууны яс болохыг тодорхойлсон юм.

Булш-2 Тэнхилгийн төвөөс 5 метр орчим зайд илэрсэн булш юм. Уг зүсэлтийн малтлагаар 50см орчим өргөн нүхэнд зүүн хойд зүгт хандуулсан нүхэнд хүнээ тавиад дээд талд нь нүхний ирмэг дээр дарж хөндлөн нарийн банзнуудаар тагласан байна.

Бид уг булшийг бүтэн гаргахаар баруун тийш 2 метр сунгасан боловч хүний бүсэлхийнээс дээш хэсэг илэрсэнгүй тоногдсон байна. Энэ булшнаас хүрэл бүсний чимэглэл илэрсэнээс өөр дагалдуулсан эд өлгийн зүйл илэрсэнгүй.

Булш-3 Хойд зүсэлтийг баруун тийш 5х3м хэмжээтэй сунгах явцад зүүн хойд зүгт хандуулсан 95х35см нүхэнд бага насны хүүхэд 40х60см нүхэнд өнгөн хөрснөөс доош 30 орчим см гүнд зүүн хойд зүгт хандуулан тавьсан нярайн яс илэрэв.

Булш-4 Баруун тийш хийсэн зүсэлтнээс 6 метр зайд хүний хүзүү болон нурууны яс илэрсэн нь мэрэгчийн нүх бололтой сул шорооноос гарч байв. Нүхийг хөөж урд зүгт 4 метр сунган малтахад мэрэгчийн нүхэнд оруулж тавьсан бололтой зүүн хойд зүгт хандуулсан 12 орчим насны хүүхэд илэрсэн юм.

Булш-5 Баруун тийш тэлж 1х15 метрийн зүсэлт хийхэд 5-р булш илэрсэн юм. Уг булш 9 метрийн төгсгөлөөс газрын гүн 65 см-ээс хүнээ зүүн хажуугаар нь атийлган хоёр хөлийг нь нуглан толгойг нь зүүн тийш хандуулсан булш илрэв. Уг булшинд тавьсан хүний бүсэлхий орчимд төмөр хутга, чулуун билүү дагалдуулснаас өөр эд өлгийн зүйл илрээгүй байна. Хүний ясны хадгалалт нилээд муу байв.

Бид 3-р булш буюу нярайн оршуулгаас бусад дөрвөн булшны хүний ясны дээжийг Япон улсын "Accelerator Analysis Limited" хүрээлэнгийн лабораторид радиокарбоны (AMS) шинжилгээ хийлгэсэв. Энэхүү шинжилгээний дүнд бүх булш өөр он цагт үйлдэгддсэн нь тодорхой болсон бөгөөд хамгийн эртний он цаг нь 5-р булшных НТ 210 гэж гарсанаас харахад, ямартай ч уг дурсгал нь НТ 210 оноос өмнө үйлдэгддсэн дурсгал бөгөөд хожуу үеийн нүүдэлчид уг дурсгалд оруулмал булш үйлдсэн бололтой. Бид урьдчилсан байдлаар уг дурсгал нь булшинд зориулагдсан шороон дараас бөгөөд уг дурсгалын гол булш эрт цагт юу ч үгүй тоногдсон хэмээн үзэж байна.

Гурван Довын булшнаас илэрсэн хүний ясанд хийсэн C^{14} он цагийн хүснэгт

	δ^{13}C補正なし		暦年較正用(yrBP)	1σ暦年代範囲	2σ暦年代範囲
	Age (yrBP)	pMC (%)			
IAAA-160220 (булш-1)	1,350 ± 20	84.54 ± 0.24	1,488 ± 23	557calAD - 604calAD (68.2%)	541calAD - 634calAD (95.4%)
IAAA-160221 (булш-2)	1,100 ± 20	87.25 ± 0.24	1,242 ± 23	690calAD - 750calAD (52.6%) 761calAD - 777calAD (13.1%) 794calAD - 800calAD (	685calAD - 779calAD (71.9%) 790calAD - 870calAD (23.5%)

				2.6%)	
IAAA-160222 (булш-4)	1,770 ± 20	80.18 ± 0.24	1,891 ± 24	78calAD - 130calAD (68.2%)	59calAD - 176calAD (91.0%) 191calAD - 212calAD (4.4%)
IAAA-160223 (булш-5)	1,650 ± 20	81.40 ± 0.23	1,773 ± 23	234calAD - 260calAD (27.1%) 280calAD - 325calAD (41.1%)	144calAD - 155calAD (1.2%) 168calAD - 195calAD (3.6%) 210calAD - 339calAD (90.6%)

Гурван Дов хэмээх дурсгалын дэвсгэр зураг.



Дов-1-ийн малтлага хийсэн талбай, илэрсэн оруулмал булшнууд



2. Аваргын балгасын малтлага судалгаа

“Аваргын балгас-ын малтлага судалгаа нь 2016-оны 8-р сарын 22-30-ны өдөр хүртэл хугацаанд үргэлжилсэн бөгөөд хотын туурийн баруун урд хэсэгт байх Loc.2 талбай (зураг 1) дахь барилгын туурийн бүтэц зохион байгуулалтыг тодруулах зорилготой ажилласан юм.

Энэ хэсэгт 1968 онд нэрт археологич Х.Пэрлээ “Гурван гол”-ын хээрийн шинжилгээний ангийн хүрээнд малтлага судалгааг хийсэн байдаг.

Малтлага судалгааг талбайн төв хэсэг болон хойд хэсэгт хийсэн бөгөөд тайланд дурдсанаар өмнө нь “хорин найман баганат ордон” хэмээн үзэж байсан барилгын орыг нэмэн малтаж дөрвөн дам нуруутай дөчөөд баганатай дан модон барилга гаргалаа. Малтлагаар ёроолдоо тамга-зурагтай шавар аяганцар, XII зууны үеийн зоос зэрэг гарсан хэмээн өгүүлжээ.

Дээрх Loc.2 талбай нь Аваргын балгасны хоёрдугаарт орох томоохон шороон овоолго бөгөөд зүүнээс баруун тийш 35м, урдаас хойш 30м, 1.5м өндөр нэгэн барилгын туурь баруун урд хэсэгт оршино.

Энэ жилийн малтлага судалгааныцаг хугацаа богино байсан тул бид "Total station" багажаар талбайн бүтэн дэвсгэр зургийг хийж гүйцэтгэн багахан хэмжээтэй хоёр талбайд малтлага судалгааны ажлыг хийлээ.

Малтлага судалгааг туурийн зүүн урд хэсэгт 5х5м хэмжээтэй H6, I6, J6 гэсэн талбайд хийсэн бөгөөд тус гурван талбай нь барилгын туурийн зүүн урд хэсэг юм (зураг 2). Тус барилга нь гадуураа дагтаршуулсан улаан шороон ханатай, түүний гадна талаар мөн дагтаршуулсан улаан болон цагаан шороон ханатай, барилгын суурийг хийхийн өмнө мөн шороо дагтаршуулж байсан нь малтлага судалгааны явцад тодорхой болсон (зураг 3).

Дагтаршуулсан улаан шороон ханын дотор талыг цагаан өнгийн шавраар доторлон өнгөлж байсны ул мөр барилгын урд талын ханын хэсэгт үлдсэн байна. Малтлага судалгаа хийсэн талбайгаас нийт 4 ширхэг баганын суурь чулуу илрэв. Эдгээр суурь чулуунууд нь хоорондоо 3-3.5м зайтай ба 60см дөрвөлжин боржин чулууг засаж баганы суурийг хийсэн бөгөөд чулууны доод талд жижиг чулуу чигжиж хөдөлгөөнгүй болгосон ажээ (зураг 4).

Барилгын тууриас гарсан модны нүүрснээс дээж аван Япон улсад C^{14} шинжилгээ хийлгэв. Судалгааны үр дүнд тус барилгын туурь нь 1189calAD – 1247calAD (68.2%) буюу XIII зууны эхэн үеийнх болох нь тодорхой боллоо (*хүснэгт 1*).

Ирэх жилийн судалгаагаар дээрх хоёр талбайгаас баруун тийш нэмэлт талбайд малтлага судалгааг хийж барилгын үүдэн хэсгийг тодорхойлох зорилготой энэ жилийн малтлага судалгааг дуусгав.

Тус төслийн хүрээнд Хэрлэний хөдөө арлын археологийн дурсгалуудыг нарийвчлан бүртгэн баримтжуулж дэлхийн соёлын өв (ЮНЕСКО)-ийн урьдчилсан жагсаалтанд 2014 онд амжилттай бүртгүүлсэн бөгөөд цаашид "Хөдөө арал дахь Монголын эзэнт гүрний археологийн дурсгал, түүнийг хүрээлсэн соёлын дурсгалт газар" гэсэн номинацаар нэр дэвшүүлэх бэлтгэлийг хангахад чиглэсэн судалгааны ажил жил бүр хийгдэж байна.

Хүснэгт



Хүснэгт 1. Барилгын тууриас гарсан модны нүүрсний он цаг



Зураг 1. Аваргын балгасны дэвсгэр зураг

Зураг 2. I6 талбайн малтлага

Зураг 3. H6 талбайн малтлага

Зураг 4. Малтлага судалгаан ерөнхий байдал

НОВЫЙ ЭТАП ИССЛЕДОВАНИЙ В ХУННСКОЙ АРХЕОЛОГИИ БУРЯТИИ

Базаров Б. А., Миягашев Д. А.

В статье приведены предварительные результаты полевого сезона 2015 г., полученные в ходе исследовательских (междисциплинарных) работ на памятниках археологии хуннской культуры Забайкалья (могильники Ильмовая падь и Гуджир Мыгэ).

Ключевые слова: археология хунну, культура, поселение, могильник, Ильмовая падь, Гуджир Мыгэ.

THE NEW STAGE OF RESEARCH XIONGNU ARCHAEOLOGY IN BURYATIA

Bazarov B. A., Miyagashev D. A.

The article is devoted to present the preliminary results of the expeditionary research of 2015 year, obtained during the research (multidisciplinary research) on the Xiongnu sites of Transbaikalia – the barrows at Il'movaya Pad' and Gudzhir Myge.

Keywords: Xiongnu archeology, culture, settlement, barrow, Il'movaya Pad', Gudzhir Myge.

Наличие на территории Западного Забайкалья оседлых поселений, а также большого количества могильников, в т. ч. с захоронениями элиты, говорит о тесной интеграции этой территории в экономику и политику Хуннского государства. Однако до сих пор мало изучена роль региона в его экономике и место Западного Забайкалья в распределении политической власти в общеимперской системе. Для этого необходимо заняться целенаправленным анализом памятников хунну в их территориальной автономности, выделением локальных групп в отдельных районах их распространения.

На решение обозначенных выше задач были направлены исследовательские работы 2015 г. Обследованию подверглись памятники хунну, расположенные южной части Республики Бурятия (Кяхтинский и Джидинский районы) (рис. 1).

Могильник Ильмовая Падь (Кяхтинский район). Суджинский хуннский некрополь в Ильмовой пади является хорошо известным памятником археологии, имеющим достаточно длительную историю изучения. Могильник находится на юго-западе Забайкалья вблизи г. Кяхты, у российско-монгольской границы. Могилы расположены на северном пологом склоне пади, изрезанном кое-где поперечными балками. Первые раскопки на площади памятника произвел Ю.Д. Талько-Грынцевич в 1896-1897: были исследованы 32 рядовых погребения и предпринята попытка (оказавшаяся неудачной) раскопать один из больших курганов. Ю.Д. Талько-Грынцевич разделил территорию могильника на отдельные площади – A, B, C, D и E

[5, С. 20]. Как было отмечено П.Б. Коноваловым, такое деление являлось условным и продиктовано было скорее рельефом местности [2, С. 27].

Новый план могильника был составлен в 1955 г. под руководством А.П. Окладникова при участии В.П. Шилова, А.В. Давыдовой, Н.П. Рябова, Н.Н. Мамоновой и Р.Ф. Тугутова, заново сверен и дополнен П.Б. Коноваловым в ходе работ в Ильмовой пади в 1971-1972 годах [2, С. 29]. П.Б. Коноваловым на этом памятнике было раскопано 13 рядовых могил и 1 царский курган [2; 3]. В 2001 г. в Ильмовой Пади проводила работы Байкальская археологическая экспедиция под руководством Б.Б. Дашибалова, была проведена инструментальная топографическая съемка площади могильника. В результате был составлен план в масштабе 1:2000, на который были нанесены 188 хуннских погребений: 11 княжеских и 177 рядовых [1, С. 298].

Археологические работы ИМБТ СО РАН в 2015 г. были сосредоточены на западной окраине могильника (рис. 2), где имеется обособленная группа могил. Большинство могил этой группы раскопаны: из 11 могил (№№ 22-31 по сквозной нумерации Б.Б. Дашибалова) раскопкам подверглись 7 объектов (№№ 22-26, 28-29), не считая сезон 2015 г. Раскопанное нами погребение № 21 (по сквозной нумерации) находится в 30 м восточнее основной группы и было представлено едва видимой кольцевидной каменной выкладкой с западиной посередине. Каменная надмогильная конструкция в плане овальной формы, длина – 3,5 м, ширина – 3,3 м. Интересной её особенностью является наличие ряда вертикально установленных плит камня с северной стороны, похожей на сохранившуюся часть дугообразного ограждения верхнего уровня могильной ямы (рис. 3). Следует отметить, что надмогильная кладка сохранилась частично из-за грабительских действий, также нами была зафиксирована грабительская яма, в заполнении которой обнаруживались фрагменты кости и дерева, камни, уголь. Находки появляются на уровне 280-290 см, а само захоронение находится на уровне 3,3 м. Дно могильной ямы на уровне 3,5 м находится на кровле литологического слоя, представленной зоной дезинтеграции скальной породы. Общая длина обнаруженного сруба – 280 см. В срубе в анатомическом порядке сохранились тазовые кости и кости ног человека. Остальные кости перемешаны и находились в северной части сруба. Череп относительно плохой сохранности, и, по всей видимости, принадлежит европеоидному антропологическому типу (определение антрополога, к.и.н. Бураева А.И.).

Сопроводительный инвентарь представлен костяными наконечниками стрел с расщепленным насадом. Также обнаружены два изделия с отверстиями: одно из них выполнено из кости (так называемая, ворворка), второе из дерева и плохой сохранности. Далее в ходе работ зафиксированы костяная накладка на лук очень плохой сохранности, мелкие фрагменты лаковых изделий, артефакты из железа также

очень плохой сохранности (некоторые из них очевидно элементы конской сбруи, другие – поясные пластины).

Помимо прочего, в юго-западной части, сбоку у самой границы могильной ямы и материка, выше могильного ложа была найдена серьга (рис. 4). Необычное положение находки – результат ограбления захоронения и смещение предмета от первоначального положения. Серьга выполнена из металлической проволоки желтого цвета (золота – ?) и состоит из двух частей – чуть сплюснутого с боков основного кольца изделия диаметром 1,6см и оваловидной дужки длиной по длинной оси в 1,4см. Общая длина серьги – 3см. Обе части выполнены из проволоки разного сечения: сечение кольца колеблется от 0,2 до 0,3см, сечение дужки равномерно и равно 0,15см. Вес изделия равен 3,1 грамма.

Ювелирные изделия были и остаются неизменным атрибутом, символом статуса, положения, принадлежности к определенной социальной группе. По археологическим данным ношения серег у мужчин известно со времен скифов и было широко распространено в кочевых обществах евразийского пояса степей.

В могильном заполнении были обнаружены кости домашних животных двух видов – кости лошадей (фаланги копыт трех особей), крупного рогатого скота (2 особи – череп, кости копыт передних и задних ног, хвостовые позвонки).

Как уже выше было сказано, раскопанное нами погребение, оказалось по своему антропологическому типу европеоидным. Проведенные ранее генетические исследования мт ДНК костных материалов погребений № 70 (25) и № 71 (28), также расположенных на западной окраине могильника (материалы раскопок Б.Б. Дашибалова), показали наличие гаплогрупп U7 и U2a. Эти гаплогруппы связаны с популяциями Западной Индии, Передней Азии и Ближнего Востока [4]. Исходя из вышесказанного, нами предварительно оформлена гипотеза о наличии планиграфических особенностей размещения могил на некрополе Ильмовая падь в зависимости от различий в принадлежности погребенных к тому или иному антропологическому (расовому) типу. В связи с этим, необходимо отметить, что в северо-восточной Монголии в могильнике Дурлиг Нарс археологами было раскопано погребение, в котором был захоронен представитель европеоидной расы [5, С. 115].

Могильник Гуджир Мыгэ (Джидинский район). В марте 2014 г. Б.А. Базаровым был осмотрен правый берег реки Джиды напротив улуса Дэрэстуй. В стенке обрывистого берега местными жителями были обнаружены два целых глиняных сосуда и керамические фрагменты трех. Глиняные сосуды по форме относятся к кувшинообразным – узкое, четко выраженное горло и плечики, украшенные орнаментом (волнистая прорезная линия, обрамленная горизонтальными полосами) и со следами вертикального лощения. Само грунтовое захоронение находилось в стенке обрывистого, почти отвесного, берега. Глубина

залегания – до двух метров. Часть гроба находилась внизу, на песчаной осыпи. На поверхности и в стенке обрыва надмогильная конструкция не была выявлена.

Памятник археологии находится на правом берегу р. Джида, напротив Дэрэстуйского Култука, на песках, которые тянутся на протяжении 10-12 км. Могилы грунтовые, разрушенные. Памятник открыт Ю.Д. Талько-Грынцевичем в 1900 г. Им было раскопано до 30 могил. В 1949 г. А.П. Окладников и Р.Ф. Тугутов раскопали 4 могилы. В 1961 г. памятник осматривал П.Б. Коновалов, в 1965 г. повторно посещал его в порядке наблюдения за состоянием.

На территории объекта археологического наследия «Дырестуй. Могильник III (Гуджир Мыгэ)» специалистами Геологического института СО РАН совместно с археологами ИМБТ СО РАН в 2014 г. были проведены опытно-методические работы, направленные на оценку возможностей геофизических методов в целях выделения неоднородностей, связанных с археологическими объектами (рис. 5). По итогам геофизических работ удалось выделить известное захоронение, отмечающееся комплексной аномалией пониженных значений магнитного градиента и зоны разуплотнения, регистрируемой георадаром и сканером. Также выделено 9 перспективных объектов, требующих дальнейшей детализации и изучения с помощью археологических методов.

В полевой сезон 2015 г. было зафиксировано полное разрушение захоронения в результате обрушения береговой кромки р. Джиды. Проведенными раскопочными работами в песчаной осыпи удалось обнаружить только бедренную кость человека, каменный оселок (рис. 6:1), остатки деревянной внутримогильной конструкции (поперечная доска гроба с пазом и квадратным отверстием), небольшой глиняный целый сосуд со следами вертикального лощения (рис. 6:2), фрагменты керамики также со следами вертикального лощения и декором в виде волнистой линии, остатки хозяйственного отсека с костями животных. В остатках хозяйственного отсека зафиксированы кости домашних животных трех видов и фрагмент птичьей кости – остатки крупного рогатого скота, баранов и домашней собаки.

В заключение хотелось бы отметить, что для решения комплекса назревших проблем требуется не только поиск и исследование новых памятников хунну, но и более углубленное изучение имеющихся материалов наших предшественников на уровне современных достижений научно-методических практик отечественной и мировой археологии. Дальнейшими шагами в хуннской археологии можно считать поиски новых памятников, картографирование, обнаружение поселенческо-погребальных комплексов, изучения их во взаимосвязи, выявление локально-территориальных групп, вопросы микрохронологии памятников на территории Байкальской Сибири.

Литература:

1. Аюрова, М.Б., Норбоева, В.Г., Шармашкеева, Н.Ш. План княжеского хуннского некрополя Ильмовая падь // Культурология и история древних и современных обществ Сибири и Дальнего востока – мат-лы 42-й региональной археолого-этнографической студенческой конференции. – Омск, 2002. – С. 298-299.

2. Коновалов, П. Б. Хунну в Забайкалье (Погребальные памятники). – Улан-Удэ: Бурят. кн. изд-во, 1976. – 248 с.

3. Коновалов, П.Б. Усыпальница хуннского князя в Суджи (Ильмовая падь, Забайкалье). – Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2008. – 98 с.

4. Пилипенко, А.С., Полосьмак, Н.В., Коновалов, П.Б., Журавлев, А.А. Генофонд митохондриальной ДНК хунну Забайкалья // Проблемы археологии, этнографии, антропологии Сибири и сопредельных территорий. – Новосибирск: Изд-во Ин-та археологии и этнографии СО РАН, 2011. – Т. XVII. – С. 222-225.

5. Крадин, Н.Н. Актуальные проблемы археологии хунну // Вестник Бурятского научного центра СО РАН. - № 1 (5). – 2012. – С. 108-122.



Рис 1


N
E
W
S
30
31
лес сосна, ильм
30.0
21
22
24
23
27
29
25 (70)
28 (71)
лесополоса
25.0
пашня
лесополоса
20.0
пашня
0 20 40 60 80 100 м

Рис 2

Рис 3

1 2

Рис 4


Известное захоронение
вертикальный градиент магнитного поля
50.6137
50.6136
50.6135
50.6134
50.6133
50.6132
50.6131
106.091
106.0911
106.0912
106.0913
106.0914
106.0915
106.0916
106.0917
106.0918

Рис 5



1

2

Рис 6

МЕСТО НАХОЖДЕНИЕ В ПАДИ ЛИПОВКА –НОВЫЙ ПАМЯТНИК ХУННУ В ЗАПАДНОМ ЗАБАЙКАЛЬЕ
PAD' LIPOVKA –NEW SITE OF XIONGNU IN WESTERN TRANSBAYKALIA

Д. А. Миягашев, Б. А. Базаров
D. A. Miyagashev, B. A. Bazarov
E-mail: silker10@yandex.ru; bazar-b@ngs.ru

Падь Липовка – известное еще с конца XIX века хуннское «место» на территории Западного Забайкалья, исследование которого не получило своего дальнейшего развития. Первый случай обнаружения на этом месте ингумации ребенка в сосуде относится к 1898 году, материалы которого были спустя некоторое время опубликованы Ю.Д. Талько-Грынцевичем. В 1964 годуслучайным образом было найдено второе детское захоронение в глиняном сосуде, изучавшееся П.Б. Коноваловым. В 2005 году Базаровым Б.А. и Дашибаловым Б.Б. на этом местонахождении были выявлены материалы, интерпретированные ими как поселенческие. В 2015 году авторами статьи был обследован небольшой участок оврага, где были найдены фрагменты хуннской керамики. Был выявлен еще один (третий) дополнительный факт ингумации ребенка в сосуде. Несмотря на имеющуюся серию на этом местонахождении детских погребений в сосудах, обнаруженных в разное время, этих материалов пока явно недостаточнодля достоверной идентификации памятника в качестве поселения или могильника, либо в качестве и того и другого. В данной работе очерчивается предварительный круг вопросов.

Западное Забайкалье, Бурятия, археология хунну, детское погребение.

Pad' Lipovka is a Xiongnu sitein Western Transbaikaliaknown since the end of XIX century, research of which was not continued. The first child's grave was found there in 1898, materials of this site was published by Yu.D. Tal'ko-Gryncevich. In 1964 there was found child's grave in weasel, researched by P.B. Konovalov.In 2005 B.F. Bazarov and B.B. Dashybalov found at this site the artifacts, interpreted as typical for settlement.In 2015 the authors of the article explored a ravine around of which was found Xiongnu pottery. There was found the third child's grave in weasel. Despite of series children's grave inweasels found in different time, the data not enough toidentify the site as settlement or cemetery, or both. In the article authors point out the questions which opens this site.

Western Transbaikalia, Buryatia, archaeology of Xiongnu, child's grave.

Падь Липовка расположена в кяхтинском районе Республики Бурятия, в 3-х км к западу от известного могильника Ильмовая падь и входит в Усть-Кяхта-Царам-Суджинский комплекс Селенгинской территориальной группы памятников хунну. Падь Липовка определяется как вытянутый с севера на юг узкий распадок шириной

около 0,5км и длиной 3км. Местность эта изрезана системой оврагов, на дне которых в некоторых местах бьют ключи. В южной части из этих оврагов выходит речка Суджи. Основная площадь пади представляет собой песчаное плато с редкой растительностью, а склоны возвышенностей, образующих распадок, заняты сосновым лесом (рис. 1).

В 1898 г. здесь было обнаружено разрушенное захоронение ребенка 8-10 лет. В развалах погребения были найдены фрагменты керамики серого цвета и следы бревен, надмогильная конструкция отсутствовала [Талько-Грынцевич, 1999, с. 92]. По собранным фрагментам керамики был реконструирован довольно крупный сосуд пифосообразной формы с низкой шейкой, длинным и широким в верхней части туловом, с сужением к низу сосуда. Высота – 78 см, диаметр дна – 24 см, диаметр устья – 23 см, наибольший диаметр - 172 см (рис 2). Плечики сосуда орнаментированы двумя параллельными налепными валиками с волнистой линией между ними. В нижней части сосуда имеется семь пар симметрично расположенных отверстий и одно отдельное отверстие [Талько-Грынцевич, 1999, табл. XIII].

В 1964 г. почвоведами БКНИИ было найдено еще одно детское погребение, устроенное в глиняном сосуде. Место находки было осмотрено П. Б. Коноваловым. Другие погребения ему тогда обнаружить не удалось, но в котловинах дефляции им были зафиксированы фрагменты керамики хуннского типа. В 2005 г. памятник осматривали Б.А. Базаров и Б.Б. Дашибалов, которые в предварительном ключе определили объект как неукрепленное поселение-сателлит [Базаров, 2008; Базаров, 2010]. В последующие годы (2006-2007-е годы) Б.Б. Дашибалов производит на этом месте дополнительные подъемные сборы фрагментов керамических сосудов, ныне хранящихся в фондах института.

В 2015 г. нами был совершен осмотр памятника в целях определения перспективных участков для поиска и выявления культурного горизонта предполагаемого хуннского поселения. Как было установлено, культурный материал восновном концентрируется в северной части пади, в бортах оврага, на дне которого бьет ключ. Севернее оврага проходит грунтовая дорога, за которой идет песчаное плато, поросшее редкой степной растительностью. Первоначально, на дне оврага в результате поисковых работ было найдено скопление нескольких фрагментов светло-серой хуннской керамики. Это послужило основанием для организации врезки в борт оврага, прямо напротив того места, где были сделаны находки. По мере углубления, на уровне 35 см,в заполнении супеси бурого цвета, проявились крупные фрагменты керамики (рис.3). Дальнейшая зачистка позволила выявить разбитый сосуд вазообразного типа относительно крупных размеров. По всей поверхности сосуда нанесены вертикальные лощеные полоски. Плечики орнаментированы тройным рядом накладного валика, треугольного в сечении, между средней и нижней рядами

проходит волнистая линия. В завалах сосуда был обнаружен скелет ребенка возрастом 5-7 лет (возраст определен антропологом А.И. Бураевым). Тело умершего ребенка было уложено в сосуд на спине, ногами в сторону донной части сосуда. Погребение ориентировано головой на северный сектор. У изголовья, с левой стороны были установлены два маленьких горшочка. Один вазообразного типа, с отогнутым наружу венчиком, второй со слабо выраженными плечиками и округлым туловом. Оба горшка без орнамента. Первый раскололся, но сохранил форму.Второй сосуд практически целый, но у него были намеренно отколоты часть горлышка и венчик.Все три сосуда типично хуннского облика, аналогичная керамика встречается в материалах Иволгинского городища [Давыдова, 1995, табл. 7-4; 25-1; 25-7; 26-4; 68-2; 68-6].

Характер развала крупного сосуда указывает на то, что для устройства погребения он был специально расколот в продольном направлении. Нижняя половина сосуда была ориентирована, как и тело ребенка, устьем на северо-запад. Верхняя половина была уложена в противоположном направлении, устьем в сторону донной части сосуда. По краям половинок сосуда видны парные отверстия для стягивания ёмкости. В таком виде сосуд с телом ребенка был уложен, очевидно, на древнюю дневную поверхность, а затем обложен каменными плитами.

Предварительные результаты раскопок были нами изложены в печати [Базаров, Миягашев, 2015; Коновалов, Базаров, Миягашев и др., 2016, с. 16-18]. Цель настоящей публикации – обозначить круг вопросов, которые открывает новый памятник.

Первый вопрос связан с определением характера памятника. В разное время здесь было исследовано три детских погребения. Характер подъемного материала (фрагменты крупных сосудов, кости домашних животных) указывает на вероятность размещения здесь поселения, хотя явных признаков его не фиксируется. Косвенно на вероятность размещения здесь поселения может указывать выход на дневную поверхность каменной конструкции, похожей на отопительный дымоход (кан), расположенного в 100 метрах западнее обнаруженного захоронения. Как известно, стоянки хунну группируются в двух зонах: летние расположены вблизи водных источников, зимники – на возвышенной части, в предгорьях,в отдалении от реки [Крадин, 2012, с. 112].

Места размещения могильников хунну также находятся в некоторой зависимости от топографических особенностей местности: часть могильников расположена рядом с реками (Дырестуйский Култук, Иволгинский могильник), другие невдалеке от берегов на плоских возвышенностях (Царам, Оргойтон, Цаган Усун, Енхор), третьи – в вершинах падей (Ильмовой, Черемуховой). В археологии хунну не известны могильники, содержащие только детские погребения. Наибольшее

количество детских погребений было изучено по материалам памятников Западного Забайкалья – Иволгинского городища и могильника [Давыдова, 1995; Давыдова, 1996], а также поселения у с. Дурены [Давыдова, Миняев, 2003]. Анализ показывает, что детей до года хоронили в глиняных сосудах под полом жилищ, детей в возрасте от года до пяти лет хоронили на общем могильнике в глиняном сосуде [Давыдова, 1985, с. 34]. Три известных нам детских погребения и косвенное указание на четвертое (в 2015 году на дороге, проходящей возле оврага, был найден фрагмент детского черепа) наводит на мысль о вероятности размещения здесь детского кладбища хунну, хотя такого рода памятники еще не были зафиксированы.

Второй вопрос касается связей этого памятника с расположенными неподалеку могильниками хунну в Ильмовой и Черемуховой падях? Эти памятники, вероятнее всего, относятся к кочевнической части населения Империи хунну, в то время как грунтовые погребения ассоциируются с оседлым населением. В социальной структуре хунну кочевническая часть населения занимала более высокую ступень, по сравнению с оседлым населением [Крадин, Данилов, Коновалов, 2004]. Если основываться на допущении, что неравенство может отражаться в размерах, формах и украшениях посуды [Крадин, 2012, с. 113], то крупные сосуды, в которых были совершены детские погребения, могут указывать на возможность размещения здесь летней стоянки высокорангового домохозяйства. Вероятно, население этой летней стоянки, в том числе, захоранивало своих умерших соплеменников на могильниках в Ильмовой и Черемуховой падях.

Третий аспект связан с самой традицией погребения в глиняных сосудах. В культурах эпохи бронзы – плиточных могил и курганов-керексуров – не было такой традиции. Все известные погребения в сосудах были найдены на территории поселенческих комплексов (Иволгинское городище, Дурёны) и могильниках, связанных с этими поселениями (Иволгинский могильник).

Практика детских погребений в глиняных сосудах-урнах была распространена в неолитическое время на территории Китая – это культура яншао. Погребальные сосудыэтой культуры имели богатое художественное оформление,они украшались рельефными зооморфными изображениями и сложными по композиции росписями, включая полноценные сюжетные сцены, предположительно на темы охоты и некие религиозные темы. Такое художественное оформление имеют часть урн (всего 136 единиц), найденные в 1989 г. в комплексе Хуншаньмяо, находящемся в центральной части Хэнани и относящемся к началу Мяодигоу. Практика захоронения детей в урнах, которые по внешним признакам совпадают с категорией кухонных (для приготовления пищи) сосудов, могла служить магическим способом воздействия на плодоносность женщин (для восполнения понесенной кланом демографической утраты) [Кравцова, 2007, с. 83].

На территории Японии погребения в сосудах были характерны для культуры яёй (VIII в. до н.э. – III в. н.э.). Здесь при погребении в кувшинообразных гробах умерших либо кремировали, либо в сосуд помещались деформированные остатки. Также бывали и случаи, когда умерших помещали в большой сосуд без предварительной подготовки. Есть случаи использования в качестве гроба в двух составленных друг с другом венчиками сосудах. Положение погребенных в сосудах не всегда одинаковое, встречаются захоронения вверх и вниз головой. Различны и способы устройства могил – имеются случаи, когда сосуды для захоронений зарывались в землю, а сверху это место обозначалось каменными плитами. Разнообразны и типы глиняных сосудов, которые использовались для захоронения [Деревянко, 1975, с. 141].

В период Iв. до н.э. – III в. н.э. традиция захоронения детей в сосудах была распространена на территории Средней Азии – северной Бактрии– Тохаристана – погребения в хумах (могильник Туп-хона, раскоп IX, погребения 200, 202, 203, 204) [Литвинский, Седов, 1984, с. 25-28].

В хуннской археологии этому вопросу не было уделено должного внимания. Исследователи обращались к нему только лишь в связи с исследованиями, связанными с изучением специфики и структуры общества. Между тем он крайне интересен в связи с разработкой проблематики религиозных верований у хунну. Этнографические материалы показывают, что у сибирских народов сосуд и женский детородный орган (или утроба) воспринимаются как семантически близкие категории. В таком случае, помещение покойника в сосуд воспроизводит акт возвращения умершего в материнское лоно для нового рождения в рамках основной идеи погребальной обрядности – идеи жизненного круговорота [Косарев, 2010, с. 37].

Четвертый вопрос касается изучения самих глиняных сосудов, в которых совершались погребения. Использовались ли для этого специально изготовленные сосуды или допускалось применение любого подходящего по размерам сосуда? Детские погребения поселенческих комплексов (Иволгинского городища и у с. Дурены) устраивались в обычных кухонных сосудах [Давыдова, 1995, табл. 50-20; табл. 84-8; Давыдова, Миняев, 2003, с. 17]. Погребения, исследованные на могильнике, совершались в крупных пифосообразных сосудах [Давыдова, 1996, с. 15]. Эти различия, очевидно, связаны с возрастом детей. На стенках сосудов нет следов нагара, соответственно они не использовались для приготовления пищи. Судя по размерам, они могли использоваться для хранения сыпучих продуктов – просо или ячменя. Однако это могли быть и специально изготовленные для похорон сосуды. Для решения этого вопроса необходимо проведение дополнительных исследований с целью выявления технологических особенностей их производства, а также анализов поверхности сосудов на предмет выявления остатков пыльцы.

Таким нам видится предварительный круг основных вопросов, возникающих в связи с изучением этого неординарного памятника. Дальнейшее изучение этого объекта, как мы надеемся, внесет определенный вклад в развитие хуннской археологии.

Список литературы

1. Базаров Б.А. Археология Западного Забайкалья (регионоведческий аспект) // Труды Первого Всероссийского съезда историков-регионоведов (Санкт-Петербург, 11-13 октября 2007 года): в 3 т. Т. 2. – СПб.: Президентская библиотека имени Б.Н. Ельцина, 2010. – С. 86-95.

2. Базаров Б.А. Изучение археологического наследия как один из факторов национально-культурного возрождения // Вестник Бурятского государственного университета. – № 7. – 2008. – С. 54-56.

3. Базаров Б.А., Миягашев Д.А. Об одном из вариантов топографической характеристики расположения хуннских могильников // Вестник БГУ. Серия Востоковедение. – 2015. - Вып. 8 (1). – С. 115-117.

4. Давыдова А. В. Иволгинский археологический комплекс. Т. 2: Иволгинское городище. Археологические памятники сюнну. Вып. 2 – СПб.: Центр «Петербургское Востоковедение», 1996. – 176 с.

5. Давыдова А. В. Иволгинский археологический комплекс. Т.1: Иволгинское городище. Археологические памятники сюнну. Вып. 1 – СПб.: Фонд «АзиаТИКА», 1995. – 290 с.

6. Давыдова А.В., Миняев С.С. Комплекс памятников у с. Дурены. – СПб.: Фонд «Азиатика», 2003. – 164 с.

7. Деревянко А.П. Культура яёй и её связи с материковыми культурами // Археология Северной и Центральной Азии. – Новосибирск: «Наука», 1975. – С. 138-149.

8. Коновалов П. Б., Базаров Б.А., Миягашев Д.А., Клементьев А. М., Именохоев Н. В.Хуннская археология в Бурятии: история и новый этап исследований // Вестник Бурятского научного центра СО РАН. – 2016. – № 1 (21). – С. 9-26.

9. Косарев М. Ф. Мировоззренческие аспекты традиционной погребальной обрядности (по сибирским материалам) // Краткие сообщения Института археологии. Вып. 224. – М.: Языки славянской культуры, 2010. – С. 33-51.

10. Кравцова М.Е. Народные верования и государственные культы // Духовная культура Китая: энциклопедия.– М.: Вост. лит., 2007 – Т. 2. Мифология. Религия. – С. 78-89.

11. Крадин Н. Н. Актуальные проблемы археологии хунну // Вестник Бурятского научного центра СО РАН. – 2012. – №1 (5) . – С. 108-122.

12. Крадин Н. Н., Данилов С. В., Коновалов П. Б. Социальная структура хунну Забайкалья. – Владивосток: «Дальнаука», 2004. – 106 с.

13. Литвинский Б.А., Седов, А.В. Культы и ритуалы Кушанской Бактрии. Погребальный обряд. – Москва: «Наука», 1984. – 239 с.
14. Талько-Грынцевич Ю.Д. Материалы к палеоэтнологии Забайкалья. Археологические памятники сюнну, вып. 4 – СПб.: Фонд "Азиатика", 1999. – 123 с.

Рис. 2. *Сосуд в из детского погребения в пади Липовка (по Ю. Д. Талько-Грынцевич, 1999).*

Рис. 3. *Развал сосуда с детским погребением, падь Липовка 2015 г.*

УЛААНЧУЛУУТЫН РУНИ БИЧЭЭСҮҮД

Ю.Болдбаатар, Я.Цэрэндагва, Р.Төрбат

Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр багийн нутаг дахь Элстэйн даваа, Улаанчулуутын өвөлжөө, баруун амны хүннү булш, Цувраагийн хадны зургийн дурсгал, Улаанхудагийн амны тахилийн байгууламж, дөрвөлжин булшны цогцолбор, Мааньтийн өвөлжөөний бүлэг дурсгал, Хангай уулын өврийн хүннү булш зэрэг олон дурсгалыг ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн доктор (Ph.D) Я.Цэрэндагва, судлаач Р.Төрбат, С.Далантай нарын судлаачид 2016 оны 5-р сарын 5-12-ны хооронд бүртгэн баримтжуулж судалсаны дотор Улаанчулуутын өвөлжөөнөөс YIII-IX зууны үед холбогдох орхоны руни бичгийн 4 дурсгалыг илрүүлж хуулбарлан, гэрэл зургаар баримтжуулсан байна.

Эдгээр руни бичээс нь Лүн сумаас баруун хойш 8-10км-т байх сүрлэг тогтоцтой Улаанчулуут уулын өвөр дэх Өгөөмөр багийн малчин М.Даваажавын өвөлжөөний арын, баруун хойноос зүүн урагш чиглэлтэй, үелэсэн тогтоц бүхийзанарлаг хаданд бөөн байдлаар дүрслэгдсэн хадны зургийн цогцолбор дунд оршино. Эдгээр дурсгал бүхий хад нь эртний далайн ёроолд уусч тунасан лаг шаврын мөхлөгүүдээс үүсч тогтсон нарийн мөхлөгт үелсэн тунамал чулуулаг болох занарын төрөл учир ихээхэн зөөлөн шинж чанартай. Тиймээс тэдгээр хадны зураг, бичгийн дурсгалууд байгаль болон хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр элэгдэлд ихээхэн өртөж байгаа ажээ.

Бичээснүүдийн хамгийн олон үсэг зурлагатай бидний “Улаанчулуутын I рунибичээс” хэмээн нэрлэсэн дурсгал хадны хажуу энгэрт тод сийлэгдсэн учир байгаль, цаг уурын эрсдэлд элэгдэн буй ч хүн, малын хөлд элэгдэлгүй харьцангуй сайн хадгалагдаж байна. Харин Улаанчулуутын II, III, IY руни бичээсүүд өвөлжөө бууцны орчим дахь газраас цухуйх дээш харсан хавтгай хаднаа дүрслэгдсэн учир малын туруу, туурайнд ихээхэн элэгдэж, үсэг зурлага, тамганууд нь ихээхэн эвдрэлд оржээ. Үүнд уг дурсгалуудыг нарийн, нягт нямбай судалж байж бичээсний эх зурлагыг зөв сэргээх шаардлагатай байна. Чингэснээр уншиж тайлах судалгаа зөв зохистой хийгдэх боломжтой болно.

Юутай ч бид энэ удаа унших боломжтой эхний бичээсийг уншиж тайлсан эхний судалгаа болон бусад 3 дурсгалын талаарх эхний танилцуулгыг хийж байна.

Улаанчулуутын I руни бичээс

Энэхүү бичээсийг анх манай судалгааны багийн гишүүн Р.Төрбат 2010 онд Улаанчулуутын хадны зургийн дурсгалыг олж илрүүлэх явцдаа үзжээ.

Нийт 4 мөр, 45 үсэг зурлагатай уг бичээс YIII-IX зууны Түрэг, Уйгарын үед холбогдох орхоны руни бичгийн дурсгал болох нь үсэг зурлагын хэлбэр, хэв шинжээсээ тод

ажиглагдаж байна. (Зураг 1, 2) Бичээсний 4 мөрийг доороос дээш дугаарлав. Ийнхүү дугаарласан нь нэгдүгээрт: 2, 3-р мөрийн утга, өгүүлэхүүн, өгүүлэгдэхүүний байрлал, хоёрдугаарт: 1-р мөрийн үсэг зурлага ур дүй муутай байснаа 3 үгээр тодотгол аван баяжигдаж бүтнээр хуулбарлагдсан 4-р мөрөнд үсэг зурлагын бичигдлийн хэв шинж илүү сайжирсанд дулдуйдсан хэрэг болно.

Зураг 1,2 Улаанчулуутын I руни бичээс

<u>*Бичээсний руни үсэг зурлага:*</u>

I мөр: 𐰴𐰖𐰀: 𐰆𐰞𐰍𐰯: 𐰖𐰞𐰢𐰴𐰖

II мөр: 𐰋 𐰃𐰠𐰏𐰀𐰲𐰆𐰺

III мөр:𐰋𐱅𐰓𐰢

IY мөр: 𐰴𐰖𐰀𐰲𐰆𐰺: 𐰘𐰼𐰓: 𐰆𐰞𐰍𐰀: 𐰖𐰞𐰢𐰴𐰖𐰀: 𐰼𐰢𐱁

<u>*Бичээсний үсгийн галиг:*</u>

I мөр: [QYa:WLGp:YLmQY]

II мөр:[bilgečWR]

III мөр:[btdm]

IY мөр:[QYačWR: yrd: WLGa: YLmQYa: rms]

<u>*Бичээсний үгийн галиг:*</u>

I мөр: [q(a)ya:ul(a)γ(.):y(a)l(i)mq(a)y(a)]

II мөр: [bilg(ä)čur]

III мөр: [b(i)t(i)d(i)m]

IY мөр: [q(a)yačur:y(ä)r(i)d(ä):ul(a)γ(.):y(a)l(i)mq(a)y(.)(ä)rm(i)s]

<u>*Мөрүүдийг монгол хэлнээ хадаж хөрвүүлэх нь:*</u>

I мөр: *Хад. Өндөр, цавчим хад.*

II мөр:*Билгэчүр*

III мөр:*бибичлээ.*

IY мөр:*Хад, ургаа /бүрэлдэж тогтсон/. Газарт, өндөр, цавчим хад оршино*

<u>*Бичээсний дэлгэрэнгүй хөрвүүлэг:*</u>

"Өндөр цавчим хад цохио. Билгэчүр би бичлээ. Газар дэлхий дээр эгц цавчим ургаа хад оршино."

Улаанчулуутын I руни бичээсний үгсийн сан:

I мөр:

1. aDK[q(a)ya]*"хад"* гэсэн үг бөгөөд 1, 4-р мөрөнд тус бүр 2 буюу нийт 4 удаа тэмдэглэгджээ.
2. PXlo :[ul(a)γi] улаг, улуг – гэдэг нь *"том, их, өндөр"* гэсэн овор хэмжээ заасан тэмдэг нэр бөгөөд ташрамд орчин цагийн монгол хэлэн дэх үлэг гүрвэлийн *"үлэг"*, *"үлэмж"*-ийн *"үлэ(г)-"* нь үүнтэй гарвал адил үгс болно. Энэ үг бичээсэнд өгүүлэгдсэн хадны онцгой шинжийг тодотгож буй тэмдэг нэр учир *"өндөр"* хэмээн хөрвүүлэв. Энэ үг доорх "эгц цавчим", "хад"гэх үгсийн хамт төгсгөлийн 4-р мөрөнд давтагджээ.
3. mlD [y(a)l(i)m] *"эгц"* буюу *"цавчим"* хад хэмээн хөрвүүлэв. Энэ нь уг хадны онцгой шинжийг улам бүр тодруулж буй басхүү тэмдэг нэр болно.
4. DK[q(a)y]*"хад"*

II мөр:

1. GLiB [bilg(ä)] "Билгэ" энэ цол болно.
2. roc[čur] "Чур" энэ нь Түрэг, Уйгаруудад хэрэглэгдэж байсан цол бөгөөд "Билгэчур" гэдэг нь "Билгэ хаган" гэдгийн адил хоёр цол болно.

III мөр:

m}tb [b(i)t(i)d(i)m] "бичлээ би". Энд [biti -] буюу "бич-" гэсэн үйл үндсэн дээр [-ti] гэсэн өнгөрсөн цагийн нөхцөл мөн үйлийн 1-р биед хамаатуулах ганц тооны [-m] нөхцөлийг залган "Мөнх орших хадыг онцгойлж Билгэчур ***би бичлээ***" хэмээн тэмдэглэсэн байна. Энэ нь "Билгэ хааны бичээсийг Йолаг Тигин бичлээ би" (Билгэ хааны гэрэлт хөшөөний X I), (Малов, 1959, 19) (Айдаров, 1966, 71), болон Булган аймгийн Гурванбулаг сумын Гурвалжин уулын руни бичээс дэх [t(ä)nri quli bit(i)d(i)m] буюу "Тэнгэрийн боол бичлээ би" гэдгийн адил болно. (Кляшторный, 1975, 155; Болд, 1990, 23-24.)

IY мөр:

1. aDK: [q(a)ya]"хад"
2. roc[čor] энэ үгийг хэрвээ дээрх Билгэчурын адил эртний Түрэг, Уйгарын үеийн "Чур" цол хэмээн үзвэл ***Хад*** нэртэй ***чур*** цолтон болж "***Хадчур газар дэлхий дэх өндөр цавчим хаднаа оршино***" хэмээн хөрвүүлэгдэх агаад чингэхүл Хад нэрт Чур цолтон газар дэлхий дэх өндөр цавчим хаданд оршин буйг (оршуулагдсан) Билгэ Чур цолтон бичиж тэмдэглэн үлдээсэн хэрэг болно. Энэ нь Монголын нууц товчооны 175–р зүйлд Хуйлдарыг Халх голын Ор нугын Хэлтгий хаднаа оршоов гэдэгтэй адил мэдээлэл агуулж байгаа болно. Гэвч энэхүү 4-р мөрөн дэх [čur] "чур"-ыг цолны [čur]-аар бус [čor]-оор галиглавал эртний түрэг хэлний "бүрэлдсэн, тогтсон" гэх Махмуд Кашгарын тольд /МК495:14,15/ тэмдэглэсэн утгатай болно. (Древнетюркский словарь, 1968, 154) Энэ утгаар бичигдсэн гэж үзвэл монгол хэлнээ "***бүрэлдэж тогтсон хад***" буюу өөрөөр хэлбэл "***ургаа хад***" хэмээн хөрвүүлэгдэх бүрэн боломжтой болно.

3. }RJ[y(ä)r(i)d(ä)] Руни бичгийн дурсгалуудад газрыг [y(ä)r] гэх ба энд уг үг [-dä] гэсэн оршихуйн тийн ялгалын нөхцлөөр нөхцөлдөж "газарт" буюу утга дэлгэрүүлвээс "газар дэлхий дээр" гэсэн утгыг илэрхийлжээ.
4. iXlo:[ul(a)γi] – өндөр,
5. mlD: [y(a)l(i)m] - цавчим,
6. aDK[q(a)ya]–хад. Энэ 3 үг 1-р мөртэй ижил:
7. SmR: [(ä)rm(i)s] бай-, бол-, орш- гэсэн хийсвэр ухагдахуунт үйл үг бөгөөд газар дэлхийд хад чулуу мөнх оршихуйн утгыг илэрхийлж байна.

Энэ нь Енисейн 39 дэх руни бичээс /Е-39/ буюу Сулекийн хаднаа ***мөнх хад*** гэхийн ***мөнх***-ийн эхний уруулын гийгүүлэгчийг [m, b]-ээр сэлгэн *бенкю, менкю* [b(e)ŋk(ü) q(a)ja], [m(e)ŋk(ü) q(a)ja] /Кызласов И.Л. 1994:186, 292-293/ 138-р бичээсэнд 3 удаа, Е-39 [k(ö)r **b(e)ŋk(ü) taš b(e)ŋk(ü) j(e)r** (a)j kü …] гэх зэргээр тэмдэглэсэн байдагтай утга агуулга ижил болно.

Бичээсний тамга:

Бичээсний дундах тамганы хувьд Говь-Алтай аймгийн Чандмань сумын Шаахарын түрэг бичээс (Болдбаатар, 2001, 171), Ханан хадны, Архангай аймгийн Их Тамир сумын Тайхар чулуу мөн Енисейн 60-р бичээсний холбогдох тамгуудтай ижил төстэй байна. (Самашев, 2010, 148) Энэ нь Билгэчурын гарвал болон харьяалж, харъяалуулж байсан овог, аймгийн, нүүдэл суудал, түүх, соёлын судалгааг тодруулах чухал хэрэглэгдэхүүн болох болов уу.

Улаанчулуутын II руни бичээс

Өвөлжөө орчмын дээш харсан хавтгай хаданд ан амьтны дүрслэл бүхий зургийн доод талд руни үсгийн нэлээд үсэг зурлага ажиглагдаж байна. (Зураг 3, 4) Эдгээрийн дотор орхоны руни бичгийн [P, J, B, Q, m, r, l] үсгүүд ажиглагдаж байгаагийн зэрэгцээ дээрх Iбичээсний голд тод дүрслэгдсэн янгирын дүрслэлээс үүдэлтэй тамга басхүү давтагдаж байна. Энэ нь I, II бичээсний эзэд овог аймгийн хувьд нэг гарвалтайг, тэрчлэн нэгэн үед холбогдох ямар нэгэн харилцан хамаарал бүхий дурсгал болохыг гэрчилж байгаа болов уу. Мөн энд Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын Жиримийн руни бичээсэн дэх 8-ын тоо хэлбэрт тамга дүрслэгдсэн байж болох байна. Энэхүү дурсгалыг цаашид тухайлан нарийн нягтлан шинжилж, зөв зохистой хуулбарлан, үсэг зурлагын анхны хэв шинжийг зөв тогтоон уншиж тайлах шаардлагатай байна. Улаанчулуутын II руни бичээс нь байгаль, цаг уурын болон хүн, малын хөлөөр ихээхэн эвдрэлд орсон дурсгал байна. Мөн доод ирмэгээрээ эмтэрч хагарсан байж болохоор байна. Уг дурсгалыг яаралтай авран хамгаалах шаардлагатай байна.

Зураг 3,4 Улаанчулуутын II руни бичээс

Улаанчулуутын III руни бичээс

Ихээхэн эвдрэлд өртсөн дундаа тамга бүхий 3-4 мөр руни бичээс. Эвдрэлээс шалтгаалж унших боломж хязгаарлагдсан дурсгал. Нарийн, нягт нямбай судалгааны үндсэн дээр зөв сэргээн унших шаардлагатай дурсгал. Бичээсний үсэг зурлагын дотроос [T, t, L, l, d, m, s] үсгүүд ажиглагдаж байна. (Зураг 5, 6)



Зураг 5,6 Улаанчулуутын III руни бичээс

Улаанчулуутын IY руни бичээс

Мөн ихээхэн элэгдэлд орсон дурсгал. Дээрээ Увс аймгийн Бөхмөрөн сумын Ачит нуурын руни бичээсний крилл үсгийн “х” үсгийн бичмэл хэлбэртэй төстэй тамгатай, мэдэгдэж буй 5 үсэг зурлага бүхий руни бичээс. (Зураг 7) Мөн зөв хуулбарлаж, нягтлан шинжлэх, авран хамгаалах шаардлагатай дурсгал.



Зураг 7 Улаанчулуутын IV руни бичээс

Дүгнэлт

2016 онд Монгол улсын Төв аймгийн Лүн сумын нутаг дахь Улаанчулуутын өвөлжөөнөөс шинээр 4 руни бичээс олов. Бичээсийг олдсон газрын нэрээр Улаанчулуутын руни бичээс хэмээн нэрлэв. Хамгийн олон 45 үсэг зурлагатай, 4 мөр бичээсийг бид Улаанчулуутын I руни бичээс хэмээн нэрлэж анх уншиж тайлах судалгааг хийв.

Бичээс нь үсгийн хэв шинжээрээ YIII-IX зууны Түрэг, Уйгарын үед холбогдох Орхоны руни бичгийн дурсгал байна. Бичээсний үсэг зурлага гүн, тод бөгөөд эртний түрэг хэлээр бичигдсэн байна. Эхний мөрний 5 үг төгсгөлийн 4-р мөрөнд давтагдаж байгаа ч бичвэрийн утгын байрлал, үйлийг 3 үгээр нэмэн илүү тодорхой болгосон байна.

Бичээсийг: I мөр: *Хад. Өндөр, цавчим хад.*

II мөр: *Билгэчур*

III мөр: *бичлээ би.*

IY мөр: *Ургаа хад. Газарт өндөр, цавчим хад оршино."* хэмээн уншлаа.

Энэ нь өндөр цавчим ургаа хадыг Билгэчур цолтон өөрөө онцгойлон тэмдэглэсэн бичээс байна. Бичээсний ерөнхий утга агуулга нь тухайн цагийнхны газар дэлхийг шүтэх шүтлэгийн тод илрэл болох онцгой содон өвөрмөц тогтоцтой хад чулууг мөнх оршихуйн бэлгэдэл хэмээн үзэж байсан үзлийг илтгэж байна.

Энэ нь YIII-IX зууны Түрэг, Уйгарын үед холбогдох Орхон (Гурвалжин уулын руни бичээс) болон Енисейн (Е-39) гэгдэх руни бичгийн зарим дурсгалын утга агуулгатай адил байна.

Бичээсийг бичсэн Билгэчур нь тухайн нийгэмд тодорхой байр суурь эзэлж байсан сурвалжтан болох нь "***Билгэ*** *бас хүү* ***Чур***" гэсэн давхар цолноос нь харагдаж байна. Тэрвээр хаант төрөөс өөрт эзэмшүүлсэн нутгийн дээсийг эсвээс өөрийн өвөлжөөгөө баталгаажуулж тэмдэглэсэн байх аль нь боловч газрыг шүтэх шүтлэг газрын эзэнд (савдагт) хандаж буй хандлагаараа "Өөрийгөө газрын эзэн савдагт даатган баталгаажуулж буй зан үйл" болох нь илэрхий байна. Энд бас Согдуудаар тээгдэн ирсэн Манихейн шашны хос үүтгэлт үзлийн /dualism/ нэг бүтээгч нь газар дэлхий хэмээн үзэх үзлийн нөлөө зохих хэмжээгээр туссан байна.

Улаанчулуутын II, III, IY руни бичээсүүдийн хувьд өвөлжөө бууцны орчим дахь газраас цухуйх дээш харсан хавтгай хаднаа дүрслэгдсэн учир малын туруу, туурайнд ихээхэн элэгдэж, үсэг зурлага, тамганууд нь ихээхэн эвдрэлд оржээ. Үүнд уг бичээсний эх зурлагыг цаашид зөв сэргээж байж дараагийн уншиж тайлах судалгаа шинжлэх ухааны хувьд үнэн хийгдэх боломжтойн учир юуны өмнө дурсгалуудыг нягт нямбай судлан сэргээх хэрэгтэй байна. Мөн хүн малын хөлд байнга өртөж буй эдгээр дурсгалуудын эрсдлийг тооцон эхийг музейд авчрах, хуулбарыг өвөлжөөнд тавих зэргээр яаралтай авран хамгаалах шаардлагатай байна.

Ном зүй:

1. Айдаров Г. "Язык Орхонского памятника Бильгэ- Кагана", Алма-Ата, 1966
2. Болд Л. "БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс", Улаанбаатар, 1990
3. Болдбаатар Ю. "Шаахарын түрэг бичээс", /ALTAICA - ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. Ред. Л.Болд/, Улаанбаатар, 2001
4. "Древнетюркский словарь", Ред: Наделяев В.М, Насилов Д.М. бусад … /НАУКА/, Ленинград, 1968
5. Малов С.Е. "Памятники древне тюркской письменности Монголии и Киргизии", /Из.Академии наук СССР/, Москва-Ленинград, 1959
6. Кляшторный С.Г. "Наскальные рунические надписи Монголии", ТС-1975, Москва, 1975
7. Кызласов И.Л. "Рунические письменности Евразийских степей", /Восточная литература РАН/, Москва, 1994
8. Самашев З., Базылхан Н., Самашев С. "Древнетюркские тамги", /АБДИ Компани/, Алматы 2010

"ОНОН-2016" ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮНГЭЭС

С.Өлзийбаяр, Б.Очир, Г.Одмагнай

2015-2017 онд хэрэгжүүлж буй ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Хүннү ба эртний түүхийн судалгааны салбарын "Эртний Дотоод Азийн түүхэн орон зай дахь монгол аймгууд" суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд тус экспедицийг зохион байгуулсан бөгөөд Хэнтий аймгийн Биндэр сумын нутаг Ламын ухаа, Онон-Хурхын бэлчирт, Батширээт сумын нутаг Эрхий толгой, Баянголын адагт орших зарим дурсгалуудад он цаг тогтоох сорилтын малталт хийхээр төлөвлөв.

Баянголын дурсгал: Баян голын ард тэгш тал дээр хойноос урагш тал саран хэлбэр үүсгэн цуварсан том жижиг 9 байгууламжийн хамгийн урд талд байрлана. (Зураг №1 байгууламжийн гадаад бүтэц, малтлагын явц) Бусдаасаа харьцангуй том бөгөөд хашлага нь ганцаараа уртраг өргөрөг дагуу чиглэлтэй 7х7м хэмжээтэй аж. Хашлагын доторхийг 50см өндөр болтол чулуугаар дүүргэжээ. Мөн босоо хашлагын дотор талаар хавтгай чулуудыг эгнүүлэн тавьж зулсан байна. Хашлага доторхи чулуунуудыг талбайгаар нь авч тэгшлээд талбайн төвд зүүнээс баруун чиглэлтэй 1.5х2м хэмжээтэй дөрвөлжин талбай сонгон 20см-т тэгшлэн үзэхэд энэхүү дөрвөлжингийн баруун хэсэгт 20х40см болон зүүн хойд булан хэсэгт 20см голч үүсгэсэн гурван чулуу бүхий чигжээс илрэв. Уг чигжээсүүдийн дагуу цааш малтлагыг үргэлжлүүлэхэд чигжээс чулуу нь цагариг хүрээ үүсгэн өргөдсөн бөгөөд түүнийг хүрээлсэн 40см голчтой дугариг толбо илрэв. Үүнээс доош малтахад толбо хумигдан 25см болсон бөгөөд саарал үнс маягийн зүйл, түүнийг хүрээлсэн ямар нэгэн төмөр маш нимгэн сав бололтой зүйлийн үлдэгдэл зураас төдий үлдсэнээс өөр зүйл илэрсэнгүй. Баянголын орчимд хийсэн малтлагаар оршуулгын зан үйл илрээгүй боловч тэдгээрийн гадна хэлбэр, зэл чулуу босгосон байдал болоод түүний үрчимд түрэг хүн чулуу байгаа, урьд өмнө түүний орчмоос түрэг оршуулга илэрч байсан зэрэг нь монгол нутагт МЭ VI-VIII зууны эхээр оршиж байсан эртний түрэгийн үлдээсэн тахилын онгон байж болох гэж дүгнэлт хийв.

Зураг №1 гадаад бүтэц, малтлагын явц

Эрхий толгой – 2

Чингисийн хэрмийн урд Өглөгчийн голын ар дээрхи сондгой ганц овоотой толгойг Эрхий толгой хэмээнэ. Эрхий толгойгоос хойд зүгт 200м зайд буюу Чингисийн хэрэм Эрхий толгойн хад чулуугүй тэгш дэвсэг дээр хүний гараар өрөгдсөн бололтой энд тэнд босоо болон хавиргалсан хэвтээ чулуудын ирмэг цухуйна. Зуны цагт хангай газрын уулын аманд өвс их ургасан тул чулуун дараасын хэлбэр хэмжээг хараад мэдэхэд бэрх байв. Тус чулуудыг хамруулан зүүнээс баруунш сунасан 4х8 м харьцаатай хүрээ татаж оноолдсон чулуун дараасыг гаргаж, хөрсийг 30см хуулж цэвэрлэн, малтлагыг цааш үргэлжлүүлэхэд талбайн урд хэсгээс шатсан модны нүүрс түүнтэй барьцалдсан төмөр цагариг, мөн баруун хэсэгт нь 60х90см хэмжээтэй нэлээд зүйл шатаасан бололтой нүүрсэн толбо илэрснээс өөр эд өлгийн зүйл илрээгүй юм.

Зураг №2 Малтлагын явц

Ламын ухаа: Энд бид 3 газар сорилтын малтлага хийсэн бөгөөд 1 гэж дугаарласан малтлагаас үнсний ором илэрснээс өөр зүйл гарсангүй, харин №2 малтлагаас барилгын хөх тоосго, хайлж шатсан шавар, төмөр хадаас, зэс, гуулин эдлэлийн хэлтэрхийнүүд, цүүц, 4см диаметрийн амсартай зэс цөгц, 2см диаметрийн амсар бүхий бичгийн янтай олдсон. Эд бүгд Ламын хүрээний үеийн эд зүйлс байна.

Зураг №3 Зэс цөгц, Шавар янтай

Мөн бид Онон хурх голын бэлчирт 3 газар сорилтын малтлагыг хийсэн бөгөөд энэ хэсэг газраас хэдийгээр олдвор хэрэглэгдэхүүний зүйл илрээгүй боловч эртний байгууламж байж болохуйц хэлбэр төрхтэй бөгөөд талбайд өргөн хэмжээний малтлага хийх шаардлагатай гэж үзэж байна

САРЫН ГЭЗГИЙН ХАНАН, ТАШГАЙН ХАДНЫ ЗУРГИЙН ТАНИЛЦУУЛГА

Ю.Болдбаатар, Д.Хатанбаатар, С.Бат-Эрдэнэ, Ц.Бямба-Очир

ШУТИС-ийн БуХС-ийн судалгааны баг 2016 оны 10 сарын 22-23-нд Баянхонгор аймгийн Жинст сумын нутаг, Сарын гэзгийн Ханан, Ташгай зэрэг газарт хадны зургийн хайгуул судалгааг хийж гүйцэтгэв. Уг дурсгал бүхий газар нь Баянхонгор аймгийн төвөөс урагш 60 орчим км, Жинст сумын төвөөс хойш 35 км зайд, Улаан багийн төвөөс баруун хойд зүгт 8 км-т оршино. Гүний нурууны урд, Түйн голын баруун талд далайн түвшнээс дээш 1882м өндөр Сар уулын зүүн ард байрлана. Сар уулыг нутгийнхан бас Сар хайрхан хэмээн нэрлэх бөгөөд хайрхнаас хойш үргэлжилсэн намхан дэл уулсыг Сарын гэзэг хэмээнэ.

Соёлын өвийн төвийн 2015 оны судалгаагаар Баянхонгор аймгийн Жинст сумын Ташгай орчимд 300 орчим хадны зураг, бичгийн дурсгал бүртгэгдсэн[1] ажээ.

Сар хайрханы ард баруун хойноосзүүн урагш байрлалтай Ханан, Ташгайн хадны зургуудыг бүртгэх, буулгах ажлыг цаг уурын хатуу нөхцөл, давчуу хугацаанд хийжгүйцэтгэлээ. Энэ орчмын газарзүйн тогтоц нь Мезопротерозой (МР) (1600-1000 сая.жил) эриний хувирмал чулуулаг буюу кварц, серицит, карбонат, хлорит, эпидот, ногоон занараас тогтох ба баруун хойноос зүүн урагш Түйн гол хүртэл 26км уртсуналттай, өмнөөс хойш хамгийн 15км өргөн үргэлжлэх ажээ.

Ханан, Ташгайн хадны зургуудын дийлэнх сийлмэл зураг бөгөөд он цагийн хувьд хүрлийн үед холбогдох ба өвөрмөц дүрслэлтэй зураг цөөнгүй аж. Тухайлбал: Хүн, адуу, үхэр, гахай, янгир, буга зэрэг амьтдаас гадна мөчрөн эвэрт буга, араатан, тэдгээрийн үржил, хурдан морь унасан хүүхэд, өвөрмөц хийц бүхий 2 дугуйт тэрэг зэрэг содон дүрслэлүүдийг дурьдаж болно.

Зургийн хувьд бүх талбайгаар нь зүлгэх, хонхойлгон зурах арга голчилсон ба цөөн хэдэн зурагт цоолборлох, хөвөөлөх аргыг ашиглажээ. Мөн өмнө зурагдсан зургийн дээрээс давхарлаж зурсан нь байна.

Эдгээр зургуудаас Ташгайн хадны 12-р зураг хамгийн сонирхолтой бөгөөд уг дурсгалын давхарласан дүрслэлүүдийг нягтлан судлаж ялган шинжилвээс магадгүй голоценээс өмнө амьдарч байсан арслан заан, тахийн зураг байхыг үгүйсгэх аргагүй байна.

---

[1] *2015 онд Баянхонгор аймгийн нутагт түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллого хийсэн ажлын тайлан. Баянхонгор аймгийн ЗДТГ. Соёлын өвийн төвийн Улсын нэгдсэн бүртэл мэдээллийн сан. Улаанбаатар, 2015*

Хавсралт

Зураг 1. Ташгай /Урд талаас/

Зураг 2. Ханан хад

Зураг 3.

Зураг 4

Зураг 5.

Зураг 6.

Зураг 7.

Зураг 8. Тээгийн өвөр

Зураг 9.



Зураг 10.

Зураг 11.

Зураг 12. Ташгайн хадны зураг

МОНГОЛ-МОНАКОГИЙН ХАМТАРСАН “ХОЙД ТАМИР-ХҮНҮЙ” ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Ж.Гантулга, Г.Лхүндэв, Ж.Магай, К.Салисис

Монгол-Монакогийн хамтарсан “Хойд Тамир-Хүнүй” төслийн хээрийн шинжилгээний анги 2016 оны 07-р сарын 05-наас 08-р сарын 02-ныг хүртэл нийт 28 хоног Архангай аймгийн Их Тамир, Батцэнгэл сумдын нутаг Хойд Тамирын голын хөндийд ажиллав.

Энэ жил Авдар хад хэмээх газарт чулуун зэвсгийн болон хүрэл, түрүү төмрийн үед холбогдох бууц сууринд малтлага судалгааг үргэлжлүүлэн хийв. Мөн Баянцагааны хөндийн адагт орших B10-р хиргисүүрт холбогдох хоёр төрлийн нийт 36 тахилгын байгууламж, түүний урд байрлах буган хөшөөний тахилгын цогцолбороос нэг байгууламж, Хөрөөгийн үзүүр хэмээх газарт хүрэл, түрүү төмрийн үеийн 2 булш зэргийг малтан шинжилсэн.

Авдар хадны суурингийн малтлага судалгаа. Авдар хадны чулуун зэвсгийн сууринд өмнөх жилийн малтлагын талбайг баруун тийш өргөтгөн судалсан болно. Малтлагын талбайд B4,B7,C8, A4, D7 өргийн B4a, B4b, B4c, B4d,B7a, B7b, B7c, B7d,C8a, C8b, C8c, C8d,A4c, D7a хэсэг багтсан нь нийт 3.5м.кв талбай эзэлнэ. Малтлагаас 230 ш олдвор илэрсний 163 ш нь чулуун зэвсгийн, 67 ш нь амьтны ясны үлдэгдэл байв.

Анхдагч цуулалтын хувьд үлдэц, техникийн цуулдас зэрэг эдлэл олдсон. Эхний үлдэц нь цохилтын нэг талбайтай нөгөө нь цохилтын хоёр талбайтай, цуулалтын нэг гадаргуутай юм. Эдгээр нь уртавтар ялтас цуулж авахад зориулагдсан үлдцүүд болно. Зэвсгийн төрлийг үзүүр мэс, хусуур, хянгар, хүнхэр зэвсэг, хутга, иртэй ялтас, иртэй цуулдас, хэлбэр нь тодорхойгүй зэвсгийн хугархай хэмээн ангилж болно. Тэдгээрийг гол төлөв уртавтар ялтас болон цуулдас ашиглан хийжээ. Чулуун зэвсгийн ихэнх хувийг чулуу боловсруулах явцад гарсан болон ялтас, залтасны хагархай эзэлнэ.

Малтлагын явцад соёлт давхаргаас чулуун зэвсгийн олдворын хамт амьтны ясны үлдэгдэл нэлээд хэмжээтэй илэрдэг. Тэдгээр амьтны ясыг зэрлэг адуу (Equus ferus), зэрлэг үхэр (Bos)-ийн төрөл болохыг тогтоосон нь тухайн үеийн анчид тэдгээр амьтдыг хоол хүнсэндээ өргөн ашиглаж байсныг илэрхийлж байна.

Тухайн дурсгалт газарт леваллуа аргаар чулуун зэвсэг хийх арга зонхилж байсныг илтгэх янз бүрийн хэлбэр, хэмжээтэй үлдэц, түүнээс хэлтэлж авсан төрөл бүрийн хэмжээтэй, тэгш хэмт ялтас, цуулдасууд ихээр олддог. Түүнчлэн малтлагаас илэрсэн амьтны ясанд хийсэн он цаг тогтоох /Beta analytic Inc./ шинжилгээгээр 20270 CalBP, 25110 CalBP, 28330 CalBP болон 31690 CalBP жилийн өмнө холбогдохыг тогтоосон нь дээд палеолитын дунд үетэй дүйцэх бөгөөд бидний чулуун зэвсгийн олдворуудын

харьцуулсан судалгаан дээр үндэслэсэн таамаглалтай ч тохирч байгаа билээ. Ийнхүү тухайн дурсгалт газарт чулуун зэвсэг үйлдэх леваллуа аргыг голлон хэрэглэж байсан эртний анчид дээд палеолитын дунд үеийн туршид суурьшин амьдарч байсан суурин-дархны газар болохыг тогтоосон юм(Зураг 1).

Энэ жил Авдар хадны хүрэл, түрүү төмрийн үед холбогдох бууц сууринггын B8, A'8, B'7, B'8, C'8, D'8 өргүүдийн нийт 25м^2 талбайд малтлага судалгаа хийсэн. Малтлага судалгаагаар хээтэй, хээгүй вааран савны хагархай, төмрийн баасны үлдэгдэл, чулуун шанаганы хугархай, хавтгай дугуй чулуун эдлэл, түүний хугархай, чулуун зэвсгийн зүйлс зэрэг сонирхолтой хэрэглэгдэхүүн илрүүлэн олсон (Зураг 6-11).

Хиргисүүрийн тахилгын байгууламж. Баянцагааны хөндийд малтан судалсан B10-р хиргисүүрийн 36 тахилгын байгууламжийн 18 нь цагирган хэлбэрт, 18 нь битүү чулуун дараастай байв. Битүү чулуун дарааст тахилгын байгууламжууд нь дунджаар 200-360см голчтой, харин цагирган байгууламж нь 117-214см голчтой байна.

Битүү чулуун дарааст байгууламжийн 15-аас нь (19-34см гүнээс) хоншоорыг нь зүүн (зарим тохиолдолд зүүн хойшболон зүүн урагш хазайлттай) тийш чиглүүлэн тавьсан адууны толгой, хүзүү, нуруу, туурайн яс гарсан бол 1 байгууламжаас хөх саарал өнгөтэй, босоо хээтэй ваарны хагархай, үлдсэн 2 байгууламжаас ямар нэг тахилгын ул мөр илрээгүй.

Цагирган хэлбэрт байгууламжийн 17–гоос нь 12-28см гүнээс шатсан яс, галын ором, нүүрсний үлдэгдэл зэрэг илэрсэн бол үлдсэн нэг байгууламжаас зөвхөн модны нүүрсний үлдэгдэл гарав. Хиргисүүрийн битүү чулуун дарааст тахилгын байгууламжинд зөвхөн нэг адууны толгой, хүзүү, туурайн яс гардаг бол 5 буюу 321-р тахилгын байгууламжаас 2 адууны толгой илэрсэн нь сонирхолтой юм. Адууны ясны хадгалалт маш муу байв (Зураг2,3, Хүснэгт 1). Эдгээр хоёр төрлийн тахилгын байгууламжаас гадна B10-р хиргисүүрийн урд талд 3-4 ш чулуу ашиглан хийсэн жижиг хэмжээтэй, зэрэгцэн орших 3 байгууламжийг малтан шинжлэхэд ямар нэгэн тахилгын ул мөр илрээгүй болно.

Буган хөшөөний тахилгын байгууламж. B10-р хиргисүүрийн урд байрлах буган хөшөөний тахилгын цогцолбороос битүү чулуун дарааст нэг байгууламжийг сонгон малтав. Уг цогцолбор нь B10-р хиргисүүрийн урд талд оршино. Энэхүү дурсгал битүү чулуун дарааст тахилгын байгууламжуудын төв хэсэгт байрлах ба дараасны дундаас вааран савны хагархай, байлдааны зээтүү дүрсэлсэн хавтгай боржин чулуу (буган хөшөө (?)-ний хугархай)-ны хагархай, тахилга өргөсөн адууны толгой, туурайн яс зэрэг зүйлс илрүүлэн олсон.

Энэ жилийн судалгаагаар нэг хиргисүүрт холбогдох нийт 30 тахилгын байгууламж малтан судалж тэдгээрийн он цагийг лабораторийн судалгаагаар тодорхойлохоор төлөвлөж байгаа болно. Улмаар дээрх тахилгын байгууламжийг хиргисүүртэй нэг цаг үе бүтээсэн үү, хожим үйлдсэн зүйлс үү гэдгийг тодруулахад

дөхөм болно хэмээн найдаж байна. Түүнчлэн адууны ясыг нарийвчлан судалснаар нас, хүйс, үүлдэр угсаа төдийгүй тахилга үйлдсэн улирал зэргийг тодорхойлох боломжтой болно.

Булшны малтлага. Хөрөөгийн үзүүрт хүрэл, түрүү төмрийн үед холбогдох хоёр булш малтан шинжилсэн болно. Эхний буюу 207-р булш нь уулын бэлд орших ба дараас нь дугуй хэлбэртэй, 490х524см хэмжээтэй. Дараасны голд зүүн хойш буюу75° чиглэлтэй, 286х365см хэмжээтэй намхан хашлагатай. Малтлага судалгааны 25.5см гүнд хашлаганы зүүн талаас 2 бод (үхэр ?), 1 бог (хонь ?)-ийн толгойн яс гарав. Хоёр бодын толгойг зүүн хойшоо буюу 55° чиглэлд хандуулж зэрэгцүүлэн тавьсан бол богийн эрүү нь доошоо харсан байдалтай, аман хүзүүг нь салгаагүй байв.

Дээрх дөрвөлжин хэлбэртэй хашлаганы голд том хавтгай чулуугаар 76х211см хэмжээтэй давхар хашлага хийжээ. Булшны нүхний толбо тодорхой ялгарч мэдэгдсэнгүй, хүний яс хашлаганы дунд 22.5-95см гүнээс эмх замбараагүй байдалтай гарсан болно. Булшны бүтэц зохион байгуулалт болон хүн, малын ясны байдлаас харахад уг дурсгал нь дөрвөлжин булш бололтой бөгөөд эрт цагт тоногдож сүйджээ(Зураг 4, 5, Хүснэгт 2).

Малтан судалсан хоёр дахь дурсгал нь намхан толгойн энгэрт байрлах дөрвөлжин хэлбэртэй, 4 буландаа хөшөө чулуутай, 221-р булш юм. Дараас нь 590х660см хэмжээтэй ба чулууны зарим хэсэг уулын налууг дагангулгаж эдвэрсэн, 3 булангийн хөшөө чулуу газарт унаж шороонд дарагдажээ. Малтлага судалгааны 15см-ийн гүнд дараасны төв хэсэгт хад ухаж хийсэн 145х186см хэмжээтэй булшны нүх илэрсэн нь 245° чиглэлтэй. Булшны нүхний толгой талаас хүний өрөөсөн дунд чөмөг, шилбэний яс, 2 шүд тус тус илэрсний зэрэгцээ ясан (?) зүүлтний сондорын жижиг хагархай гарав.

Уг булш тоногдсон шинж тэмдэггүй, гүехэн нүхтэй тул ихэнх яс хадгалагдан үлдээгүй бололтой,үлдсэн цөөн яс нь мэрэгчийн хөлөөр зөөгдөж эмх замбараагүй болжээ(Хүснэгт 2).

Дээрх малтлага судалгаанаас гадна зарим дурсгалын зургийг дроноор авч баримтжууллаа. Агаарын зураглалд нэг дор харьцангуй олноор бөөгнөрсөн хэсэг болох Цац толгойгоос Улаан толгойн хоорондох 1.4х6км хэмжээтэй талбайг сонгон авч DJI Phantom 3 Pro, Altizur, Agisoft PhotoScan Pro, ArcGIS 10.2 программын тусламжтайгаар зургийг боловсруулсан болно.

Хүснэгт 1

B10-р хиргисүүрийн тахилгын байгууламжуудын товч мэдээлэл

№	*Дараасны хэлбэр*	*Дараасны хэмжээ(см)*	*Байршил, координат /Decimal degrees/*	*Гүн (см)*	*Чиглэл*	*Малын яс, олдвор хэрэглэгдэхүүн*	*Хадгалалт*
01 (1085)	●	280x285	Хүрээний баруун урд талд 47.75375, 101.37443	28	130°	Адууны толгой, эрүү	Муу
02 (1093)	●	230x290	Хүрээний баруун урд талд 47.75370, 101.37440	29.5	120°	Адууны толгой, эрүү	Муу
03 (880)	●	260x270	Хүрээний баруун урд талд 47.75357, 101.37434	28	110°	Адууны толгой, хүзүү, нүүрсний үлдэгдэл	Муу
04 (876)	●	250x310	Хүрээний баруун урд талд 47.75357, 101.37434	24.5	-	-	-
05 (321)	●	270x310	Хүрээний урд талд 47.75361, 101.37549	24	105°	2 адууны толгой, хүзүү, нуруу, туурай	Муу
06 (559)	●	240x270	Хүрээний урд талд 47.75347, 101.37548	19	-	Адууны шүд, нуруу	Муу
07 (849)	●	340x365	Хүрээний урд талд 47.75329, 101.37550	23.5	-	Хээтэй ваарны хагархай	Дунд
08 (301)	●	310x320	Хүрээний урд талд 47.75329, 101.37550	26	40° 115°	2 адууны толгой, эрүү	Муу
09 (901)	●	340x350	Хүрээний зүүн талд 47.75329, 101.37550	34	85°	Адуун толгой, хүзүү, нуруу, туурай	Муу
10 (252)	●	290x296	Хүрээний зүүн талд 47.75404, 101.37740	26	115°	Адуун толгой, хүзүү, нуруу, туурай	Муу
11 (780)	●	355x360	Хүрээний зүүн талд 47.75463, 101.37677	25.5	90°	Адууны шүд, хүзүү	Муу
12 (217)	●	200x256	Хүрээний зүүн талд 47.75462, 101.37752	31.5	105°	Адууны эрүү, шүд, чамархайн яс	Муу

13 (760)	●	250x280	Хүрээний зүүн талд 47.75461, 101.37782	24	-	-	-
14 (500)	●	230x235	Хүрээний зүүн талд 47.75400, 101.37776	30	90°	Адууны толгой8 хүзүү, туурай	Муу
15 (744)	●	290x317	Хүрээний зүүн талд 47.75520, 101.37778	27	90°	Адууны толгой, эрүү, шүд	Муу
16 (593)	●	310x335	Хүрээний зүүн талд 47.75556, 101.37674	33.5	110°	Адууны шүд, чамархайн яс	Муу
17 (712)	●	300x320	Хүрээний зүүн талд 47.75463, 101.37677	21.5	60°	Адууны эрүү, шүд	Муу
18 (1004)	●	260x275	Хүрээний зүүн талд 47.75463, 101.37677	34	90°	Адууны толгой, эрүү, хүзүү	Муу
101 (538)	○	150x170	Хүрээний баруун талд 47.75408, 101.37391	14	-	Шатсан яс	Дунд
102 (538)	○	160x167	Хүрээний баруун талд 47.75434, 101.37389	19.5	-	Шатсан яс, нүүрсний үлдэгдэл	Дунд
103 (592)	○	145x172	Хүрээний баруун талд 47.75481, 101.37394	19.5	-	Шатсан ясны үлдэгдэл	Муу
104 (612)	○	166x175	Хүрээний баруун талд 47.75498, 101.37395	28	-	Шатсан яс, галын ором	Дунд
105 (640)	○	160x170	Хүрээний баруун талд 47.75537, 101.37399	15	-	Шатсан ясны үлдэгдэл	Дунд
106 (817)	○	175x180	Хүрээний баруун талд 47.75574, 101.37408	19	-	Модны нүүрсний үлдэгдэл	Дунд
107	○	156x163	Хүрээний зүүн талд 47.75475, 101.37882	15	-	Шатсан яс, нүүрсний үлдэгдэл	Дунд
108 (04)	○	183x185	Хүрээний зүүн талд 47.75475, 101.37882	22	-	Шатсан яс, нүүрсний үлдэгдэл	Дунд

109	○	156x165	Хүрээний зүүн талд 47.75479, 101.37843	12	-	Шатсан яс, галын ором, нүүрсний үлдэгдэл	Дунд
110	○	160x165	Хүрээний зүүн талд 47.75483, 101.37823	15	-	Шатсан ясны үлдэгдэл	Дунд
111	○	173x175	Хүрээний хойд талд 47.75656, 101.37538	23	-	Шатсан яс, нүүрсний үлдэгдэл	Дунд
112	○	131x135	Хүрээний хойд талд 47.75646, 101.37552	23.5	-	Шатсан ясны үлдэгдэл	Дунд
113 (289)	○	196x200	Хүрээний хойд талд 47.75632, 101.37543	19	-	Шатсан яс, галын ором	Дунд
114 (144)	○	180x180	Хүрээний баруун талд 47.75488, 101.37281	20.5	-	Шатсан яс, нүүрсний үлдэгдэл	Дунд
115 (776)	○	210x214	Хүрээний баруун талд 47.75494, 101.37345	19.5	-	Шатсан ясны үлдэгдэл	Муу
116 (720)	○	130x152	Хүрээний урд талд 47.75294, 101.37556	15	-	Шатсан ясны үлдэгдэл	Муу
117 (723)	○	140x141	Хүрээний урд талд 47.75294, 101.37556	16	-	Шатсан ясны үлдэгдэл	Дунд
118	○	117x165	Хүрээний урд талд 47.75268, 101.37568	20	-	шатсан ясны үлдэгдэл	Дунд

Хүснэгт 2

207 ба 221-р булшны товч мэдээлэл

№	Дурсгалын дугаар	Дурсгалын төрөл	Дараасны хэмжээ (см)	Хашлаганы хэмжээ (см)	Булшны нүх			Хүний яс	Малын яс	Олдвор
					Хэмжээ (см)	Чиглэл	Гүн (см)			
1	207	Дөрвөлжин булш ?	490x524	286x365, 76x211	50x170	70°	95	Дал, эгэм, сүүж, гар, хөлийн үе, хавирга	2 бод, 1 богийн толгой, эрүү, шүд, шатсан ясны үлдэгдэл	-
2	221	Сагсай хэлбэрийн булш	590x660	165x236	145x186	245°	15	Дунд чөмөг 1 ш, шилбэ 2 ш, шүд 2 ш	-	Ясан зүүлтний сондорын хэсэг 1 ш



Зураг 1. Авдар хадны чулуун зэвсгийн суурингийн 2016 оны малтлагаас олдсон чулуун зэвсгийн зүйлс

1. Үлдэц, 2. Хүнхэр зэвсэг, 3. Үзүүр мэс, 4. Төгсгөл хусуур, 5. Үзүүр мэс,
6. Хянгар, 7. Техникийн цуулдас, 8. үлдэц



Зураг 2. B10-р хиргисүүр, түүний хоёр төрлийн тахилгын байгууламж



Зураг 3. B10-р хиргисүүрийн малтан шинжилсэн тахилгын байгууламжуудын байршил

Зураг 4. 207-р булшны 3-р үе (Agisoft Photoscan 1.2 програмаар боловсруулсан зураг)

Зураг 5. 207-р булшны 3-р үеэс илэрсэн бод, богийн толгой



Зураг 6. Малтлагын талбай (бор: 2014; шаргал: 2015; ногоон: 2016)

Зураг 7. Хээтэй ваарны амсар

Зураг 8. Хавтгай дугуй чулуун эдлэл

Зураг 9. Хээтэй ваарны хагархай

Зураг 10. Төмөр зэв



Зураг 11. Чулуун шанаганы хугархай

ҮЗҮҮР ГЯЛАН, ЦАХИР, ТОШИНТЫН ХАДНЫ ОРШУУЛГЫН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮН

Ч.Мөнхбаяр, Г.Пүрэвдорж, Х.Бямбасүрэн, Б.Сүхбаатар[1]

Монгол Алтайн бүс нутагт эртний булш, оршуулга нэлээд хадгалагдаж бидний үед уламжлагдан ирсний нэг бол хадны оршуулга юм.

Энэхүү өгүүлэлд Ховд аймгийн Мөнххайрхан сумын нутаг Үзүүр гялан, Тошинт, Мянгад сумын хадны оршуулгын судалгааны эхний үр дүнгийн талаар өгүүлэхийг зорилоо.

Төв Азийн хэмжээнд анхны иж бүрэн олдвор бүхий Үзүүр гялангийн хадны оршуулгыг Ховд аймаг өөрийн санхүүжилтээр аймгийнхаа судлаачдын нэгдсэн багаар анх удаа археологийн авран хамгаалах малтлагыг хийлгэлээ.

2010 онд нутгийн иргэд барагшунгийн баас олборлох үед олсон уг оршуулгыг Ховд аймгийн музей, Мөнххайрхан сумын соёлын төв, Мөнххайрхан сумын ЗДТГ-ын хамтарсан тус сумын нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын хээрийн судалгааны баг 2015 оны 10-р сард орон нутгийн иргэн Д. Мөнхцоож, Ч.Алагаа нарын мэдээллийн дагуу бүртгэн баримжуулан ажилласан байна.

Уг хайгуул судалгааны ажлын үргэлжлэл болон 2016 оны 4 сарын 1–3-нд уг хадны оршуулгыг устаж үгүй болхоос өмнө археологич, НХУС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Түүх, эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D) Ч.Мөнхбаярын удирдлаган дор Ховд их сургууль, Ховд аймгийн музейн хамтарсан судалгааны баг 1 археологийн авран хамгаалах малтлагыг хийж гүйцэтгэлээ.

Мөнххайрхан сумын Борт багийн нутаг Үзүүр Гялангийн хадны оршуулга нь Мөнххайрхан сумын төвөөс баруун хойш 35км-т, ХӨ.46°55,926', ЗУ.091°46,844' солбицолд ДТД 2803м өндөрт Мөнххайрхан уулын Бортын голын баруун тал, Шуурхайн эсрэг талын (Хортын хөдөөгийн) нар ээсэн уулын бэлд орших Үзүүр гялан хэмээн газар тус сумын Борт багийн малчин Я.Цэрэндоржийн хаваржааны зүүн урд талд 300м-т орших том хадны хөмөгт байрладаг. Уг хадны баруун доод талаас ороход хүний хатмал оршуулгын дагз, хүзүү сээр нурууны хэсэг ил харагдаж байв. Хүнийг улаан өнгийн хувцастай гадна талаар нь 3 давхар цагаан эсгийнд ороож оршуулсан байна. 2015 оны 10-р сард үзэхэд (зур. 1.-1) байсан хатмал оршуулгын нурууны хэсгийн эсгий боолгоо, хувцас урагдаж, мал болон мэрэгчид идэж гадна талын анхны хэв байдлыг алдагдуулсан (зур. 1.-2) байна.

---

[1] *Түүх, эрх зүйн тэнхимийн эрхлэгч доктор (Ph.D) Г.Пүрэвдорж, Ховд аймгийн Музейн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Х.Бямбасүрэн, Бүртгэл мэдээллийн санч Б.Сүхбаатар, жолооч Б.Батжин, Мөнххайрхан сумын Соёлын төвийн ажилтан П.Сэмбэдорж нарын бүрэлдхүүнтэй судалгааны баг*

Бид олдворыг бүрэн гаргаж авах зорилгоор хадны (зур. 1.-3) хойт талын чулуун дараас хийж шороогоор дарсан хэсгээс малтлагыг эхлүүлэв (зур. 1.-4, 5). 150см ухахад дээс, адууны хойт хөлний жижиг яс гарав. Цааш малтахад 150см гүнээс хонины ноос улмаар адууны толгой, хонины толгой болон доош хөмрөн тавьсан модон тэвш гарав (зур. 1.-6). Цэвэрлэгээг үргэлжлүүлэхэд хоёр ширхэг хавтгай чулуун дээр зүлдлэн авсан 4-н шийртэй улаан хоолой багалзуур бүхий толгойтой хонины бүтэн арьсыг нөмөргөн түүний дээр бүтэн хүрэн зүсмийн 15–16 настай адууны толгойг дэрлүүлэн хэвтүүлэн оршуулжээ (зур. 1.-7, 8; 3.-1). Адууны дээд тал маш сайн, доод хэсэг муудсан байна (зур. 1.-9). Адууны хүзүүний орчимд (хааны дээд хэсэгт) өөрөөсөө дөрвөн дугуй хөл сийлбэрлэн модоор урласан тэвш/таваг ихэд урлагтай хийгджээ (зур. 3.-1, 6). Адууны толгойн орчмоос ац бүхий модтой цоохор дээс (зур. 3.-1–4) гарав. Энэ нь адууг аргамжиж байсан эдлэлүүд бололтой юм. Адууг хоёр хавтан чулуун дээр нөмрөгсөн дээрх зүлдэлсэн хонины арьсан дээр толгойг дэрлүүлжээ. Уг хэсэгт хонь болон адууны толгойн дээр улбар шар (оренж) өнгийн зос цацсан байна (зур. 1.-9). Адуу болон хонины чихийг газаг эмээр эмнэсэн байна. Эдгээр тахилгын амьтдыг авч малтлагын дараагийн үед 190см гүнд 10см орчим шороон дараасыг авахад дөрвөн том 30х40см хэмжээтэй 5-10 зузаантай хавтангийн доор ташуур (зур. 3.-2–18) гарсанаар хүний эдлэж хэрэглэж байсан эд зүйл гарч эхлэв. Эхлээд 200см гүнд эмээлийн мөрөвчтэй өвлийн зузаан өмд (зур. 2.-1) түүний доор улаан өнгийн бөс давууны дээр шагайт чөмөг (зур. 2.-2, 3), түүний доор тохом нөмрөг болохтой цэцгэн (очир хээ) хээгээр урласан цагаан эсгий олбог, бүрэн эмээл (зур. 2.-4), модон аяга (зур. 2.-5), бод малын хүзүүний арьсаар хийсэн ширэн сав (зур. 2.-6), хазаар (зур. 2.-7; 3.-9) гарав. Эмээлд хударга болон хөмөлдрөгийг хазааранд хийсэн товруу болон уялганы адил арга барилаар хийж чимэглэн тоногложээ (зур. 2.-4; 3.-8). Хазаар нь загасны дүр бүхий эвэр зуузай болон мушгимал амгайтай (зур. 3.-9). Улаан өнгийн сүлжмэл жолоо болон бор, цагаан өнгийн хонины ноосоор эрчилж хийсэн дээсэн цулбууртай[2]. Түүний хажууд жижиг бор савхин амсартай бор эсгий уут бүхий үйл хийх зориулалттай эдлэлүүд (бөс утас, нимгэн бор, ногоон болон цагаан эсгийний өөдөс, дугуй шир, хээний элгээр хийсэн үлгэр, улаан шар өнгийн амьтны (хүний?) хэсэг хялгас бүхий арьс, бор элгэн уутанд дөрвөн ширхэг болор чулуу, зүү болон шөвөг хурцалж байсан ул мөр бүхий бэлүүний хар хөх өнгийн жижиг чулуу, улаан өнгийн хатгамал хээ бүхий савхин хавтага, модны жижиг мөчирний хугархай, утас, шөрмөс зэрэг олдвор) (зур. 2.-7; 3.-7)гарав.

Улмаар нэхий болон хоёр бөс давуун (нэг нь бор өнгийн даавуугаар бор өнгийн эсгийнцэрээр доторлосон, нөгөө нь цайвар бор шаргал өнгийн давуугаар өнгөлсөн,

---

[2] *Мөнхбаяр Ч., Пүрэвдорж Г., Бямбасүрэн Х., Сүхбаатар Б. Үзүүр гялангийн түрэг хадны оршуулгын малтлага судалгааны урьдчилсан үр дүнгээс // Мөнххайрхан, Булган гол-Их онгогийн байгалийн цогцолборт газар - 2016. ЭШ-ний II бага хурлын эмхэтгэл. Vol. 2. F.1. УБ., 2015. Т. 164–187.*

хар өнгийн үзүүрсгэн хонины арьсан дээл) дээл (зур. 3-2–12) гарав. Хүрэн өнгийн дээлний завсар улаан шар өнгийн зос цацсан ул мөр мэдэгдэж байна. Түүнийг авахад хүний оршуулгын хэсэгрүү нэвтэрч толгойн баруун талд мод, шавар сав (зур. 2-8; 3-3, 4), толгойн зүүн талд төмөр сав(зур. 3-5), бор өнгийн эсгий богцонд хонины нуруу болон ямааны олон яс годон (зур. 3-10) хийсэн байдалтай олдов.

Бүх олдворыг баримжуулан гар (зур. 3-1, 2) болон гэрэл зургаар баримжуулан хэмжилт хийж тодорхойлолт үйлдсэний дараа хүний хатмал шарилыг бүтнээр нь авлаа. Уг шарил барагшунгийн баасаар хучигдсан нь хадгалалтанд сайнаар нөлөөлсөн ч малтлага хийх явцад хатсан цемент мэт сайн барьцалдсан нь ихэд хүндрэл учруулж байлаа. Чингээд бүтэн хатмал шарилыг 220 (хөл хэсэг) (зур. 2-10) –230 см (цээжин хэсэг) (зур. 2-9) гүнээс гаргаж авсны дараа (зур. 2-11) оршуулгын хэсгийг шалгаж үзэхэд уг оршуулгын он цагийг тогтоох чухал хэрэглэгдхүүн болон хар бор өнгийн эсгийнцэрээр хийсэн шовгор юүдэн малгай гарав. Оршуулгын хэсэгт шалгалт хийсний дараа оршуулгын нүхийг булж аюулгүй болгон анхны хэв байдалд орууллаа (зур. 2-12).

Хүнд улаан өнгийн урт хормойтой хувцас, улаан өнгийн хээ бүхий элгэн ултай урт түрүү, цэцгэн болон саран хээ дүрс бүхий төмөрлөг чимэглэл бүхий суран олонтой гутал өмсгөж тавьжээ. Зүүн талын гуталны ил гарсан олонгийн нэг хээ нь унасан болох нь түүний тавьснаас харагдаж байна. Түүнчлэн хүний бүсэлхийний орчимд зүүн ташааны орчимд бүснээс сураар оосорлосон гадна талаараа бүрээс (бог малын нарийн гэдсээр?) бүхий модон хуйнд дүрсэн эвэр бариултай хутгыг зүүжээ(зур. 2-10; 3-2). Хүнийг ороосон эсгий өлгий нь цагаан хонины ноосоор урлагдсан бөгөөд түүний ирмэгийг цагаан өнгийн зээгээр хүрээлэн оёжээ.

Бидний малтлага судалгааны дараагийн шатны ажил дурсгалын сэргээн засварлалт, он цаг болон эд өлгийн дурсгалын эдийн судалгааны ажлын шат байлаа.

2016 оны 4 сарын 6-ны өдөр Ховд аймгийн Өв соёлын хүрээлэнд олдвороо нээж ажлын үр дүнгээ аймгийн удирдлагад танилцуулав. Энэ үеэр Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбатад мэдээлэл илгээж, улмаар БСШУЯ-ны сайд Г.Гантөмөрт санал уламжилж ажлын хэсэг байгуулж, сэргээн засварлах, зөөвөрлөх ажлуудыг шийдвэрлэв.

2016 оны 4 сарын 24-27-ны өдрүүдэд Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат ахлагчтай судалгааны баг Ховд аймгийн Музейн өв соёлын хүрээлэнд хадгалагдаж буй уг хадны оршуулгыг БШСУ-ы сайдын гаргасан тушаал ёсоор, Ховд аймгийн Засаг даргын А88 дугаар бүхий захирамжийн дагуу гаргасан ажлын хэсгийн 10 хүний бүрэлдхүүнтэй багтай хамтран ажиллаж түүх соёлын дурсгалыг зөөвөрлөх журмын дагуу хайрцаг сав, баглаа боодлыг хийж Улаанбаатар хотруу авто машинаар зөөвөрлөн авч явсан билээ. Эдүгээ уг хадны оршуулгын бэхжүүлэлт, судалгаа шинжилгээний ажил ид явагдаж байна.

2016 оны 6 сарын 14–20-ны хооронд Ховд аймгийн Засаг даргын хүсэлтээр Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (ТИКА)-ын сонгон илгээсэн Туркийн 5 судлаач Улаанбаатар хотод Соёлын өвийн төвд ирж Үзүүр гялангийн хадны оршуулгын судалгааг явууллаа. Уг эдийн болон хүн, амьтан судлалын судалгааны ажлын өмнө соёлын өвийн төвийн судлаачид мөнхүү хадны оршуулгыг сэргээн засварлах явцад хувцас, гутлыг тайлах явцад шинэ хэрэглэгдхүүн илэрч судалгааны багийг гайхшруулж байлаа. Тухайлбал, оршуулгын эсгий өлгийг авч хувцасыг тайлах үед, гутлыг тайлахад зүүн талын гуталны түрүүнээс эсгий хавтганд хийсэн ясан сам, дөрвөлжин хэлбэртэй хүрэл тольны хугархай, эсгий өлгийний дотор талд шарилд өмсгөсөн шаргал даавуун дотортой улаан даавуун дээлний дотор бор саарал өнгийн мөрөвчтэй өмд байгаа болох нь тодорхой болов. Дурсгалаас авсан 9 дээжид АНУ-д он цаг тогтоолгох радиокарбоны шинжилгээ явуулж X зуун буюу Киргизийн хаант улсын үед холбогдох болохыг тогтоосон[3] байна.

Хүний нүүрний хэсгийг нээх үед урьд хожид түрүү дундад зууны булш оршуулганд тохиолдож байгаагүй нүүрний боолт, үсээ дээш шуун ороож эсгий утсаар боосон байдалтай арьсаар бүрхэгдсэн хүний толгой ил гарав. Хүний нүүрийг тусгайлан бэлдсэн даавуун боолтоор хоёр давхарлан боож, эрүүний хэсгийг олон тоогоор хэлхсэн ногоон өнгийн сувс, нэг ширхэг алтадсан сувсаар чимэглэсэн боолтоор ороожээ. Эдүгээгийн Мусальман хүнийг оршуулахдаа цагаан бөс даавуугаар ороодог зан үйлийн улбаа энэхүү нүүрний боолт бололтой юм. Уг нээлт нь хэд гурваар олддог түүвэр олдворын үүрэг зориулалтыг тодруулж бүтнээрээ олдсоноороо гайхагдаж буй Үзүүр гялангийн оршуулгын 18-25 настай (Сонгдо эмнэлэгт томографийн шинжилгээгээр тогтоосон) авхайг эрт цагт түрэгчүүдийг (киргизүүдийг?) оршуулдаг байсан оршуулгын зан үйлийг сэргээн үзэх гагцхүү эх сурвалж болж өгч байгаагаараа судлаачдыг алмааруулж байна. Магадгүй бусад морьтой булшны толгойн орчмоос олдсон сувс гоёл чимэглэлийн зүйлс нь дээрх нүүрний боолтны хэрэглэгдхүүн байж болох талтай.

Мөрөвч бүхий нимгэн даавуун өмдтэй адил зузаан хүйтний улиралд өмсөх зориулалт бүхий мөрөвчтэй өмд булшны эх хэрэглэгдхүүний дээрээс илэрснийг онцлон тэмдэглэж байна. Үүнийг бид өмнөх хайгуул судалгааны урьдчилсан үр дүнг нийтлэхдээ эмээлийн тохом байх хэмээн таамаглаж байсны үнэнийг өчиж байна. Энэхүү мөрөвч бүхий өмд нь эртний нүүдэлчдийн хувцасны түүхэн дэх цоо шинэ олдвор болж байна.

Уг археологийн авран хамгаалах малтлагыг санхүүжүүлэн дэмжсэн Ховд аймгийн засаг дарга, асан Д.Цэвээнравдан, түүний орлогч Ч.Чинбат, бидний ажилд гүн туслалцаа үзүүлсэн Мөнххайрхан сумын Борт багийн малчин Я. Цэрэндорж,

[3] http://www.ikon.mn/n/uj1*Б.Бямбасүрэн. Үзүүр Гялангийн олдвор МЭ X зууны үеийнх болох нь тогтоогджээ. iKon.mn*

Мөнххайрхан сумын Соёлын төвийн ажилтан П.Сэмбэдорж, хяналт тавин ажилласан Мөнххайрхан сумын Борт багийн засаг дарга Я.Очир, тус сумын байгаль орчны байцаагч Б.Булганчимэг, хадны оршуулгын нүхийг булахад тусалсан нутгийн малчид болох Я.Цэрэндорж, Х.Айлтгүй, Ч.Алагаа, Г.Атарсайхан, Д.Баянбат, Б.Шаржаа нарт гүн талархал илэрхийлье.

Зээрэн нуурын Цахирын хадны оршуулга

ХИС-ийн НХУС-ийн БШТС-ийн захирал доктор, дэд проф Б.Гантөмөр, Мянгад сумын харьяат Тулга нарын мэдээллийн дагуу Ховд аймгийн ЗДТГ-ын санхүүжилтээр жолооч Бямбаа, Мянгад сумын уугуул Тулга, Хүрэлмөнх нарын хамт Зээрэн нуурын Цахирын хадны оршуулгыг малтан судлав. Зээрэн нуурын баруун талд орших дундуураа хөтлөөр хуваагдсан хоёр Цахир өнгөтэй уулын хойт талын уулын нуурлуу харсан хүүш талын бэлийн дунд орчимд ХӨ. 48°35,02,9''; ЗУ. 91°51,46,7'' огтолцолд ДТД 1344м өндөрт байрлах нэгэн хамарт орших хадны хөмөгт эртний оршуулгыг тавьжээ(зур. 4.-1).

Цахирын хадны оршуулга руу зүтгэж байх замд хүний гарын шууны хувхайрсан яс хадны хөмгийн зүүн доод талаас (зур. 4.-5), хүзүүтэй холбогддог сээрний хоёр яс хөмгийн доод талаас нэлээд дороос гарав. Хөмгийн хөлд хүний хавирга болон эгэмний яс тэмдэглэгдэв. Энэ нь хадны оршуулгыг тоногдсон болохыг бэлхэнээ харуулна. Хөмгийн дээд талын хадны завсар Тулга гуайн өмнө хавчуулсан дээлний торго даавууны үлдэгдэл газар унасан байдалтай байв. Дээлийн шар торго, нэхий дотор нь улаан өнгийн Үзүүр гялангийн түрэгийн үеийн хадны оршуулгаас гарсан дээлний улаан өнгийн зузаан өнгийн бөс даавуутай адил материал зүүж хийсэн дээлний бүсэлхий орчмын хэсэг байв(зураг 4.-4, 7).

Хадны хөмөг баруунаас зүүн тийш сунаж тогтсон. Амсараар нь нэг хүн багтах зайтай. Өндөр нь 130-140см ажээ. Хадны оршуулгыг ашиг хайсан тонуулчид анхны хэв байдлыг нь алдагдуулан самарч хаяжээ. Хүний гавлын яс эрүү, хүзүүтэйгээ хамт салсан байв(зураг 4.-2). Гавлын хэлбэрээс харвал өргөн шанаатай, шүд бүрэн эмэгтэй хүн бололтой байв. Хүний хоёр далыг анхны байрлалынх нь түвшинд хөмгийн урд талд, түүний доор аарцагны яс, олон ясыг гаргасан байна. Цээжний орчимд хөх цоохор торгоор өргөн имжсэн шаргал өнгийн цаанаасаа цэцгэн хээ бүхий нэхээстэй бөс даавуун дээлний үлдэгдэл тэмдэглэгдэв. Хөмгийг цэвэрлэвэл хүний толгойг зүүн шанаагаар баруун талруу хандуулж, хөлийг өвдөгөөр нь нугалж зүүн талаар, их биеийг дээш харуулан хэвтүүлсэн бололтой (зураг 4.-3) хүний яс байсан болох нь үлдэгдэл ясны байрлалаас илт байна. Хөмгийн доод хэсэг байгалиас цоорхойтой бөгөөд Тулга гуай сонгуулийн өмнө 6 сард ирэхдээ тэр цоорхойг бараан өнгийн том чулуугаар бөглөсөн гэх боловч тонуулчид түүнийг нь унагааж хүн багтахаар томсгосон байна. Яг энэ хэсэгт хийсэн цэвэрлэгээнээс хүний баруун талын хавирга, бүдүүн дэрсний үлдэгдэл нэлээд гарав. Хүний нурууны яс шалтайгаа наалдсан анхны

байрлалд доороо дээлний үлдэгдэл болон эсгийний үлдэгдлийн хамт хадгалагдаж үлджээ. Үүнээс оршуулгыг эсгийнд ороож хувцастай нь оршуулсныг харж болохоор байна.

Оршуулгыг цэвэрлэх явцад бүдүүн дэрсний үлдэгдэл, тэдгээрийг хооронд нь бэхлэсэн тэмээний ноосон бололтой утасны үлдэгдэл гарсан нь дэрсэн хаяавч эсвэл дэрсэн туурганд хүнээ эсгийнд хулдан ороож тавьсан байсан болов уу гэж үзэхэд хүргэж байна. Уг оршуулгын хүний сээрний хоёр яс хөмгийн доор байсныг Г.Пүрэвдорж доктор хөмөгрүү өгсөх замд олсон нь 6 сарын сонгуулийн өмнө Тулга гуайг ирсний дараа уг хадны оршуулгыг тонуулчид нэлээд сандаачсан болохын гэрч юм. Энэ нь нар салхинд ил гаргаж хаясан гарын шууны ясны хувхайрч цайснаас харагдаж байна(зураг 4. -3, 5). Хөмгийн доор шидэгдсэн сээрний яс гарын шууны ясыг бодвол багахан зэрэг цайсан ажээ. Зээрэн нуурын эргэн тойронд олон Цахир уул байх бөгөөд тунамал чулуулгаас тогтсон уг газрыг орог цайвар хүрэн өнгөтэй учир Цахир хэмээн нэрлэсэн бололтой. Нүүдэлчид ийм өнгөтэй тунамал чулуулаг бүхий газрыг хадны оршуулга хийхдээ түгээмэл ашигладаг байсан бололтой. Монголын төв нутагт ийм нэртэй газар хадны оршуулгыг олноор нь хийсэн тохиолдол олон байдаг билээ.

Малтлага цэвэрлэгээний явцад бүсэлхийний орчимд хөмгийн урд талаас хар чулуугаар хийсэн сувс илрэв. Энэ нь гоёл чимэглэлийн зориулалтай голдоо нүхтэй, бөөрөн дээрээ тэгш өнцөгт хэлбэртэй зориудаар сийлбэрлэсэн ул мөртэй ажээ. Гэхдээ анхны байрлал нь хаана байсан. Бусад хос эдлэлүүд нь яасан болох, хувь заяа нь тонуулчдаас болоод бүрхэг хэвээр үүрд үлдлээ. Ганцаар олдож байгаа нь XIII зууны үеийн монгол эхнэрийн богтог малгайн урд талд байдаг гоёл гэж таамаглахад хүргэж байна. Малтлагын дараагийн шатанд хүний ясны үлдэгдлийг сайтар цэвэрлэвэл нурууны яс зүүн талын хавиргатай анхны байрлалаас хөдлөөгүй байв. Бид хүний сээрний доош шидэгдсэн хоёр ясыг нуруу болон хүзүү бүхий гавлын ястай байрлалд нь тавьж гэрэл зургийг дарж баримтжуулан авав(зураг 4.-3). Хоёр ширхэг богино сээрний ясны доод талын яс нурууны буюу урт сээрний ястай зөөлөн мөгөөрсөн эдээр углуурганд орж байгаа мэтээр эвээрээ нийлж байв. Дээлний үлдэгдэл хэсгийн баримтжуулах явцад эсгий болон бөс даавуунд нарийн нийлэг туузаар бүч холбож хийсэн гэмээр эдлэл (зураг 4.-6) гарав. Дээл нь шар өнгийн торго (зураг 4. -7), улаан өнгийн даавуугаар хийгдэж, хөх өнгийн торгоор өргөн эмжигдсэн байна. Энэ нь Дугуй цахирын оршуулгаас гарсан дээлтэй харьцуулах боломжтойг харуулж байна. Цахирын хадны оршуулга, түүнээс олдсон хүний яс нь нас, он цаг, ДНХ-г тогтоох, бусад олдвор нь уг оршуулгын соёлын онцлогийг цаашид харьцуулалт хийж шинжлэх боломжтой ихээхэн чухал хэрэглэгдэхүүн бүхий дурсгал юм. Ийнхүү бидний малтлага хүний яс олдворыг баримжуулсны дараа, хайрцаг саванд авч хийснээр дуусгавар болов.

Тошинтын хадан дахь морины оршуулга

2010 онд нутгийн иргэд Ховд аймгийн Мөнххайрхан сумын Борт багийн нутаг Тошинт хэмээх газар адууны оршуулга байгаа талаар дурдсан ч тухайн үедээ уг хадны оршуулгаас олдсон мөнгөн гинжийг авсан малчин шөнө унтуулахгүй болохоор нь буцааж байранд тавьж, дараагаар нь нутгийн иргэн Д. Мөнхцоож ирж эмээл бүхий бүтэн адууны яс байгаа болохыг үзсэнээр уг мэдээлэл намжжээ. Харин ХИС-ийн оюутан бидэнд уг мэдээллийг мэдэгдсэнээр Тошинтын хадны оршуулгыг малтан судлах болсон билээ.

2016 оны 10 сарын 22–24-нд уг хадны оршуулгыг устаж үгүй болохоос өмнө НХУС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, археологич, Түүх, эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D) Ч.Мөнхбаярын удирдлаган дор Ховд их сургууль, Нүүдлийн соёл иргэншлийн хүрээлэн болон Ховд аймгийн музейн хамтарсан хээрийн судалгааны баг археологийн хайгуул, авран хамгаалах малтлагыг хийж гүйцэтгэлээ [4]. Үүний үр дүнд дараах олдворуудыг мөнхүү хадан дахь морины оршуулгаас илрүүлэн баримтжуулан хамгаалалтанд авлаа. Үүнд: эмээлийн бүүрэг, модны хагархай, ховдны бололтой үйсэн дээр тогтоосон төмөр цагираг, төмөр тээг, үйс зэрэг олдвор олдлоо.

Мөнххайрхан сумын Борт багийн Тошинтын хадны оршуулга нь Мөнххайрхан сумын төвөөс баруун урагш 37 км-т, ХӨ. 46°52, 01,2'', ЗУ.092°01,46.0'' солбицолд ДТД 2781 м өндөрт Мөнххайрхан уулын Бортын голын зүүн эрэг, Хар говийн хөдөөгийн урд талаас харах уулын хойт бэлд оршино. Уг оршуулга уулын хормойгоос дээш 300 метрт орших том хадны завсар байв(зур. 5.-1, 2). Оршуулга буй газар нь 3 м өндөр улаан өнгийн боржин чулуунаас тогтох бөгөөд уг хадны завсар 180х110 см хэмжээтэй зайнд адууг хийж дээрээс нь чулуугаар дарж орхисон (зураг 5. -3) байна.

Уг хадны оршуулгыг 6 жилийн өмнө ирж үзэхэд адууны яс бүрэн анатомын байрлалдаа байжээ. Биднийг ирж үзэх үед дал болон хойт хөлний дунд чөмөгний яс доош 10 орчим метрт шидэгдсэн. Чулуун дараасыг авч ясыг байрнаас нь хөдөлгөсөн, уг хадны завсар нь доогуураа битүү байсан бол онгорхой болж, доод талын 120х120 см хэмжээтэй хадны хөмгөөс эмээл, ховдны төмөр эдлэл олдсон байдалтай байлаа(зур. 5.-4).

Бид адууны оршуулгад сорилтын малтлага хийж цаашид өргөн хэмжээний малтлага хийх шаардлагатай эсэхийг тодруулан дараас чулууг авахад уг адууны ясны толгойг зүүн тийш хандуулан хоньчлон эмээл болон үйсэн ховдыг дагалдуулан оршуулсан (зур. 5.-5) болох нь мэдэгдэж цаашид малтлага хийх шаардлагагүй болсон тул бидний малтлага өндөрлөсөн юм. Адууны оршуулга болохыг гэрчлэх олдвор

---

[4] *Уг археологийн хайгуул, авран хамгаалах малтлагын багт Нүүдлийн соёл иргэншлийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга А.Очир, Ховд аймгийн Музейн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Х.Бямбасүрэн, жолооч н.Батжаргал нар багтан ажиллав.*

морины оршуулгын зүүн талын доош цоорон, түүний доод хэсэгтэй холбогдсон хадны хөмгөөс олдсон үйс бүхий төмөр цагираг, ховдны үйсний үлдэгдэл, баруун талын дараас чулууны орчмоос илэрсэн эмээлийн бүүрэг, мод, төмөр тээг (зур. 5.-5) зэргээс шууд харагдаж байна.

Уг археологийн хайгуул, авран хамгаалах малтлагыг санхүүжүүлэн дэмжсэн Нүүдлийн соёл иргэншлийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга А.Очир, бидний ажилд гүн туслалцаа үзүүлж газарчилж тусласан Мөнххайрхан сумын Борт багийн малчин Д. Мөнхцоож, Мөнххайрхан сумын Соёлын төвийн ажилтан П. Сэмбэдорж, бидний ажилд хяналт тавьж, дэмжиж хамтран ажилласан Мөнххайрхан уулын цогцолбор газрын дарга Т. Лхагвадорж, байцаагч Н.Баянмөнх болон бусад ажилтан нарт гүн талархал илэрхийлье.

Хадны оршуулгын төрөлд зөвхөн морь оршуулсан цөөн тохиолдлын нэг болсон Тошинтийн хадны морины оршуулга нь дагалдуулсан үйсэн эдлэл, ховд болон эмээлний тоног хэрэгсэлээр он цагийг харьцуулан урьдчилсан байдлаар тогтоовол дундад зууны монголын үеийн оршуулга бололтой. Бидний малтсан морины оршуулгад адууг зүүн зүг хандуулан эмээл болон үйсэн нум сумны ховдтой нь хамт оршуулсан байна. Энэ нь цаашид морины толгой хандсан чиглэл, дагалдуулсан эмээл болон үйсэн хоромсого, түүний цагираг болон тээгээр он цагийг харьцуулан нарийвчлан тогтоох боломжийг олгож байна. Малтлагаар илэрсэн адууны яс болон хялгасанд ДНХ-ийн шинжилгээ, он цаг тогтоох шинжилгээ явуулах нь цаашид чухал мэдээлэл өгөх ач холбогдолтой.

Зураг 1. Үзүүр гялангийн хадны оршуулгын анхны байдал, малтлагын I үе.

1 – Мөнххайрхан сумын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын баг мөнхүү оршуулгыг баримтжуулж байгаа нь (2015.10 сар); 2 – Хадны оршуулгын анхны байдал (хадны хөмөг, доод талаас); 3 – Оршуулга бүхий хад (баруун талаас); 4 – Хадны оршуулгын хойт хэсэг (Зүүн урдаас); 5 – Авран хамгаалах малтлагыг эхлүүлж байгаа нь (баруун хойт зүгээс); 6 -Адуун болон хонины толгой, модон тэвш илэрч байгаа байдал; 7 – Адууны ясыг бүрэн ил гарган цэвэрлэсэн байдал; 8 – Адууг гаргаж байгаа нь; 9 – Суран ногт (дөрвөөр гөрсөн цулбуур) бүхий адууг гаргасан байдал.

Зураг 2. Үзүүр гялангийн хадны оршуулгын малтлагын II үе нөхөн сэргээсэн байдал.
1 – Эмээлийн хэсэг, хударга, хөмөлдрөгө болон тохом; 2 – Улаан өнгийн ноосон нэхмэл тэг дөрвөлжин даавуун эдлэл болон цэцгэн хээтэй эсгий олбог илрүүд байгаа нь (зүүн талаас); 3 – Шагайт чөмөг, арьсан дээл; 4 – Эмээл илэрч байгаа нь; 5 – Модон аяга;6 – Аяганы ширэн уут илэрч байгаа нь; 7 –Хазаар болон үйлийн эдлэл бүхий эсгий уут; 8 – Хүний толгойн баруун талд байрлах модон болон эсгий гэр бүхий хар өнгийн ваар илэрч байгаа нь; 9 – Оршуулгын дээд хэсэг, хүний бүсэлхий орчимд бор эсгий богцонд хонины нуруу, ямааны олон яс чанаж хийсэн байдал; 10 – Хүний хөлний хэсэг; 11 – Хүний хатмал шарилыг гаргаж тавьсан анхны байдал; 12 – Нөхөн сэргээсэн байдал.



Зураг 3. Үзүүр гялангийн хадны оршуулгын малтлагын дэвсгэрзураг болон олдворууд.

1 – Үзүүр гялангийн хадны оршуулгын малтлагын I үеийн дэвсгэр зураг: 1.-1, 6 – Модон тэвш; 1.-2 – Модон эдлэл; 1.-3 – Хонины толгой; 1.-4 – Чавх хэлбэрийн ац мод бүхий дээс; 2 – Үзүүр гялангийн хадны оршуулгын малтлагын II үеийн дэвсгэр, олдвор (хэмжээсгүй)-уудын байршлын зураг: 2.-1 – Мөрөвчтэй өвлийн өмд; 2.-2 – Шагайт чөмөг; 2.-3 – Улаан ноосоор хийсэн нэхмэл олбог; 2.-4 – Цэцгэн хээтэй эсгий олбог; 2.-5, 8 – Эмээл; 2.-6, 9 – Хазаар; 2.-7 – Аяганы ширэн уут; 2.-8, 3 – Модон аяга; 2.-9, 7 – Үйлийн бор эсгийнцэр уут; 2.-10 – Арьсан дээл; 2.-11 – Бор өнгийн давуун дээл; 2.-12 – Шаргал тааран дээл; 2.-13, 10 – Бор эсгий хүнсний богц;2.-14, 3 – Модон сав; 2.-15, 4 – Шавар ваар; 2.-16 – Малгай; 2.-17, 5 – Төмөр тогоо; 2.-18 – Ташуур.



Зураг 4. Зээрэн нуурын хадны оршуулгын анхны байдал (2016.08.03) болон олдворууд. 1 – Зүүн хойноос харагдах байдал; 2 – Тоногдож үлдсэн анхны байдал; 3 – Цэвэрлэгээ хийж ясыг байрлалд нь оруулсан баримтжуулсан нь; 4 – Дээлний хормой хэсэг; 5 – Зүүн хойт этгээдэд шидэгдсэн гарын шууны яс; 6 – Дээлний их бие орчимд дарагдсан хэсэг; 7 –Дээлний хормой хэсэг.

Зураг 5. Тошинтын хадны оршуулгын анхны байдал болон олдворууд (2016.09.24).

1 –Зүүн талаас харагдах байдал; 2 – Баруун талаас; 3 – Тошинтын хадны адууны оршуулга (баруун талаас, дараас чулууны харагдах байдал); 4 – Зүүн доод талын доош цоорсон хадны хөмгөөс эмээл болон ховдны үйс, төмөр эдлэлийг илрүүлж байгаа нь; 5 – Зүүн доод талын доош цоорсон хадны хөмгөөс олдсон үйс бүхий төмөр цагираг, ховдны үйс баруун талын дараас чулууны орчмоос илэрсэн эмээлийн бүүрэг, мод, төмөр тээг.

ҮЗҮҮР ГЯЛАНГИЙН ХАДНЫ ОРШУУЛГА

*Г.Бүрэнтөгс *, Б.Мягмарсүрэн***

2016 оны 4 дүгээр сард Ховд аймгийн Мөнххайрхан сумын Борт багын нутагт орших Үзүүр гялан хэмээх газраас доктор Ч.Мөнхбаяр ахлагчтай Ховд Их сургууль, Ховд аймгийн музейн хамтарсан судалгааны баг уг оршуулагд авран хамгаалах археологийн малтлагын ажлыг хийжээ.

Үзүүр гялангийн оршуулгын гадна орчны зураг

2016 оны 04-р сарын 11-ний Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төрийн нарийн бичгийн даргын А175 дугаар тушаалаар Соёлын өвийн төвд цэвэрлэх, бэхжүүлэх, сэргээн засварлах зорилгоор татан авчирсан ба нийт анхан шатны бүртгэлээр 25 олдвор эд өлгийн зүйлсийн жагсаалтыг ирүүлжээ. Үүнээс, мод ашиглаж хийсэн 7, арьс ширээр хийгдсэн 6, эсгий ашиглаж хийсэн 4, даавуу ашиглаж хийсэн 2, төмөр металл ашиглаж хийсэн 1-2, шавар ашиглаж хийсэн 1, амьтны болон хүний арьс, яс бүхий 3 ширхэг олдворууд байна. Эдгээр 25 ширхэг олдвор нь зөвхөн ил харагдаж тоолж болохуйц анхан шатны жагсаалтаар бүртгэгдсэн тоо бөгөөд судалгаа шинжилгээ, сэргээн засварлалтын явцад тоо нэмэгдэж байна. Олдворуудыг БСШУЯ-ны удирдлагуудад нээж үзүүлэн танилцуулсны дараа цэвэрлэх, бэхжүүлэх, сэргээн засахад шаардлагатай бэлтгэл ажлыг тухай бүрд нь хангаж ажиллаж байна (зураг 1, 2).

Сэргээн засварлалтын явц (зураг 1, 2)

*Соёлын өвийн төвийн үл хөдлөхийн мэргэжилтэн.

**Соёлын өвийн төвийн сэргээн засварлагч.

Соёлын Өвийн Төвийн сэргээн засварлагч Б.Мягмарсүрэн, О.Оюунчимэг, Д.Нямдорж, Э.Батжаргал, Н.Бат-Эрдэнэ, Үл хөдлөхийн мэргэжилтэн Г.Бүрэнтөгс нарын бүрэлдэхүүнтэй сэргээн засварлах баг 2016 оныг дуустал Үзүүр гялангийн хадны оршуулгаас олдсон олдворуудын сэргээн засварын ажлыг үргэлжлүүлж байна.

Сэргээн засварлах ажлыг хийх явцад эдгээр олдвор дотроос металл ашиглаж хийсэн 6 ширхэг эд өлгийн зүйлс гарч ирснийг тус төвийн сэргээн засварлагч Д.Нямдорж лабораторид бүтцийн судалгаа хийсэн ба гарсан үр дүн мэдээллийг олдвор олдсон орчмын бүс нутгаас илэрч, судалгаа шинжилгээнд хамрагдсан зарим металл эд өлгийн зүйлсийн өгөгдөлтэй харьцуулан судалсан.

Сэргээн засварлалтын ажил 80 орчим хувьтай үргэлжилж байгаа бөгөөд үлдсэн олдворуудыг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан дуусгаж улмаар холбогдох үзэсгэлэнг Улаанбаатар хотод гаргах болно.

Сүүлийн жилүүдэд археологийн малтлага судалгааны явцад олдсон даавуу, зөөлөн эдлэлийг Соёлын өвийн төвийн сэргээн засварлалтын хэлтсийн хамт олон сэргээж байгаа нь тус төвийн мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэхэд үр дүнгээ өгч байна.

Эртний үед холбогдох энэхүү хадны оршуулгын олдворууд дээр археологи, түүх, угсаатан, хүн судлал талаас нь эрдэмтэн судлаачид судлан эхний байдлаар дүгнэлтүүд гарч байна.

БНТУ-ын судалгааны баг Америкийн “BETA Analystic” хэмээх лабораторид шинжилгээнд явуулсан бөгөөд шинжилгээний хариунаас харахад цаг хугацааны хувьд X зуунд холбогдох нь тогтогдов. Урьдчилсан байдлаар энэхүү дүгнэлт гарсан ба судалгааны явцад он цаг тодорхой болно.

Сэргээн засварлалтын ажил дууссаны дараа Соёлын Өвийн төвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэн баримтжуулж оруулахаар төлөвлөөд байна.

Хавсралт 1.

№	Сэргээн засварын өмнө	Сэргээн засварын дараа	Гар зураг
1			
2			
3			
4			

"МОНГОЛ АЛТАЙН ТҮРҮҮ БА ТҮҮХЭН ҮЕИЙН ОРШИН СУУГЧДЫН ЦОГЦ СУДАЛГАА" ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТОВЧ ҮР ДҮН

Ц.Төрбат, Н.Баярхүү, С.Лепец, В.Бернард, А.Заззо

Монгол-Францын хамтарсан экспедици нь "Монгол Алтайн түрүү ба түүхэн үеийн оршин суугчдын цогц судалгаа" төслийн хүрээнд 2014 оноос Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт малтлага судалгааны ажлыг хийж байгаа билээ. 2014 онд тус сумын нутаг, Их Хатуугийн голд, 2015 онд Бургастын голд ажилласан бол 2016 онд мөн Бургастын голд үргэлжлүүлэн ажиллав.

2015 оны тухайд дээрх цогцолбор дурсгалын баруун хэсэгт орших Түрэгийн үед холбогдох зэрэгцээ байрласан 4 тахилын онгон, түүний баруун талд зэрэгцээ байдлаар орших 7 булш, нэг байгууламж, эдгээрээс зүүн хойш 500 орчим метрт орших бас нэг байгууламжийг тус тус малтан судалсан билээ. 2015 онд бидний малтан судалсан уг булшнуудын харьцуулсан он цаг ба хүн, малын яс, шатсан модны нүүрснээс авсан дээжээр Сяньбийн үед холбогдохыг Франц Улсын Үндэсний Байгалийн Түүхийн Музейн лабораторит хийсэн судалгаагаар тогтоосон юм.

2016 онд Бургастын голын хөндийд өмнөх жилийн судалгааг үргэлжлүүлсэн бөгөөд үндсэндээ 4 хэсэг газарт төвлөрч ажиллав (Зураг 1).

1-р хэсэг: 2015 оны малтлага судалгаа хийсэн бүлэг булшны баруун урд талд бас нэг бүлэг булш байсан бөгөөд үүнийг судалснаар өнгөрсөн жилийн судалгаатай харьцуулан судлах, хоорондоо ижил төстэй зүйл буй эсэх, ялангуяа дурсгалын эзэд төрөл садны холбоо сүлбээтэй эсэхийг мэдэх нь чухал шаардлагатай, сонирхолтой ажил байсан тул уг дурсгалыг сонгосон билээ.

Анх өнгөн хөрсөн дээр 7-8 булш байх магадлалтай байсан боловч өнгөн хөрсний цэвэрлэгээгээр хөрсөнд дарагдаж мэдэгдэхээ болисон зарим дурсгалууд нэмж илэрснээр нийт 30 гаруй байгууламж байгаа нь тодорхой болов. Эдгээр байгууламжийн зарим нь хүүхдийн булш, зарим нь насанд хүрсэн хүний булш байсан бөгөөд мөн нэлээд олон байгууламж нь булш мэт хэлбэртэй боловч ямар нэг оршуулгагүй байв. Ийхүү нийт 7-8 хүүхдийн оршуулга, 8-9 насанд хүрсэн хүний нийт 16 булш оршуулгыг илрүүлэн олж малтан судалсан болно (Зураг 2). Энэ бүлэг булшны гадаад зохион байгуулалтын онцлог нь хоорондоо тодорхой хэмгүйгээр нэлээд ойрхон байрласан тул ихэнх хэсэгтээ дараас чулууд нь нийлсэн байдалтай байв. Мөн хүүхдийн оршуулгуудыг том хүний булшны нэгэн адил газрын хөрсөн доор мод, чулуугаар хийсэн авсанд оршуулсан нь ой хүрэхгүй бага балчир хүүхдээс өсвөр насны хүртэл хүүхдүүд байсан атал бараг бүгдийнх нь яс нэлээд сайн хадгалалттайгаар бүрэн бүтэн хадгалагдан үлдсэн нь сонирхолтой. Учир нь нас биед хүрээгүй хүүхдийн ясны бэхжилт, хөгжил бүрэн боловсроогүй байдаг тул газрын хөрсөнд он удаан жил тэсч үлдсэн нь маш ховор тохиолдол болно. Үүнээс гадна уг

бүлэг оршуулгын хоёроос тухайн үеийн торго даавуугаар хийсэн хувцас бараг бүтнээр илэрсэн нь урд өмнө илэрч байгаагүй гайхамшигт олдвор болно. Тодруулбал, модон ховдонд оршуулсан нэгэн хүүхдийг малгай, дээл, бойтгийг нь өмсгөж оршуулсан нь бараг хэвээр илэрсэн бол өөр нэг булшинд насанд хүрсэн хүнийг мөн адил малгай, дээл хувцас, оршуулгын идээ шүүстэй нь оршуулжээ.

Түүнчлэн эдгээрийн зүүнтэй холгүй орших Түрэгийн үеийн 4 тахилын онгоныг 2015 онд малтан судалсан бөгөөд үүний зүүн урд талд байх 2, зүүн хойд талд байх 1 нийт 3 тахилын онгоныг малтан судлав (Зураг 3). Учир нь өнгөрсөн жилийн дурсгалтай харьцуулан судлах зорилготой байсан боловч дээрх зүүн урд талын 2 тахилын онгоноос ямар нэг эд зүйл, хүн малын яс, эсвэл модны үлдэгдэл илрээгүй ба харин зүүн хойд талынхаас бага хэмжээний шатсан модны нүүрс, малын ясны хэлтэрхий төдий зүйл илэрсэн юм.

2-р хэсэг: Дээрх булшнаас хойш хагас км-т хүрлийн үеийн хөшөө чулууд байх ба уг хөшөө чулууны он цагийг тогтоох зорилгоор хөшөө тус бүрийн урд байх ойролцоогоор 50×50см орчим хэмжээтэй 3 ширхэг дөрвөлжин хашлага болон түүний зүүн урд байх 4 ширхэг ойролцоогоор 1,2м орчим голчтой цагариг хэлбэрийн байгууламжийг малтан судлав (Зураг 2). Эдгээр байгууламжуудаас маш бага хэмжээний шатсан модны нүүрс, шатсан ясны үйрмэг төдий зүйлс гарсан ба он цаг тогтоох зорилгоор Франц Улсын Үндэсний Байгалийн Түүхийн Музейн лабораторид илгээгээд байна.

3-р хэсэг: Энэ орчимд тархсан нийт дурсгалын төв хэсэгт байрлах дөрвөлжин хүрээтэй 1 хиргисүүр, түүний дагуул байгууламж болох 11 байгууламж буюу цагариг хэлбэрийн 4 дагуул нь хиргисүүрийн баруун талд, үлдэх битүү дараастай 7 дагуул байгууламж нь хиргисүүрийн зүүн талд байсан юм. Баруун талын цагариг хэлбэрийн 4 байгууламжаас ямар нэг эд зүйл, хүн малын ясны зүйл илрээгүй бөгөөд харин зүүн талын 7 байгууламжаас адууны эрүү, хүзүүний ганц нэг үе дагалдуулсан байсан нь тус тус илрэв. Мөн хиргисүүрийн төв хэсгийн овоолго доороос дагалдах ямар нэг эд өлгийн зүйлгүй боловч нэг хүний оршуулга илэрсэн болно (Зураг 4).

Түүнчлэн хиргисүүрийн хойд талын хүрээн дээгүүр тавьсан булш, мөн дагуул байгууламжуудын зүүн талд байсан нэг булш зэргийг малтан судлахад хоёул Түрэгийн үед холбогдох морьтой оршуулга байв (Зураг 4).

4-р хэсэг: Энэ орчмын бүлэг дурсгалаас зүүн урагш км орчим зайд голын өндөр дэнж дээр байрлах бүлэг дурсгал. Тэнд нийтдээ чулуугаар овоолж хийсэн харилцан адилгүй хэлбэр, хэмжээтэй 30 гаруй байгууламж байгаа бөгөөд бид чухам аль үед холбогдох дурсгал болохыг тогтоох зорилгоор жижиг болон дунд хэмжээний, мөн гурван өөр хэлбэртэй 3 дурсгалыг малтан судалсан боловч ямар нэг эд өлгийн зүйл, хүн, малын яс илрээгүй тул буцааж нөхөн сэргээв.

Урьдчилсан үр дүн

Монгол-Францын хамтарсан хээрийн шинжилгээний анги нь 2016 онд ихээхэн амжилттай ажилласан бөгөөд малтлага судалгааны гол үр дүнг тоймлон дурдвал:

1. Сяньбийн үеийн томоохон оршуулгын газрыг нээн илрүүлж бүрэн хэмжээгээр малтан судалсан нь уг оршуулгын газрыг үүсгэсэн цаг хугацаанаас эхлүүлээд бүхий л талаар нарийвчилсан судлагаа хийх боломжтой болж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр олдворууд нь тухайн үеийн нийгмийн давхраажил, тэдний шүтлэг бишрэл, ёс заншил, эдэлж хэрэглэж байсан хувцас, гоёл чимэг, тэдний идэж уух, хоол хүнс, цаашлаад хүн амын насжилт, өвчлөл гэх мэт олон талын судалгааг нэхэн гаргах бололцоог олгож байна.

2. Баруун Монголд төдий л сайн судлагдаагүй байгаа хиргисүүр, түүний дагалдах байгууламжуудыг хамтад нь бүрэн хэмжээгээр малтан судалсан нь бидний хийсэн бас нэг чухал судалгаа болно. Учир нь өнөөг хүртэл хиргисүүр нь тахил тайлгын байгууламж аль эсвэл булш оршуулгын дурсгал гэдэгт эрдэмтдийн санал бүрэн нэгдээгүй хэвээр байгаа тул үүнийг шийдвэрлэхэд бага ч болов хувь нэмэр оруулах үр дүнтэй судалгаа юм.

3. Мөн археологийн мэдээлэл багатай байдгаас төдий л сайн судлагдаагүй Хүрлийн үеийн хөшөө чулууны дагалдах байгууламжуудын малтлага судалгааг хийсэн нь он цагийг нарийвчилж тогтоох боломжтой болж байна.

Ийнхүү Монгол-Францын хамтарсан судалгааны анги 2014-2016 оны хооронд Монгол нутагт төдий л сайн судлагдаагүй Сяньбийн үед холбогдох хоёр хэсэг газарт бүлгээр орших нийт 20 гаруй булшийг, нэг хиргисүүр, түүний дагалдах байгууламжууд, хүрлийн үеийн хөшөө чулууны дагуул байгууламжууд, мөн хүннүгийн үеийн тахилын байгууламж нэгийг, харьцангуй бага судалсан түрэгийн үеийн тахилын онгон 8, түрэг булш 3-ыг тус тус малтан судлав. Өөрөөр хэлбэл, малтлага судалгаа бараг хийгдэж байгаагүй Сийлхэмийн нурууны зүүн урд бэлээр 3 жилийн хугацаанд тогтвортой, тодорхой зорилготой судалгааг хийснээр хүрлийн үеэс эртний түрэг хүртэлх үеүдийг хамарсан, давхардсан тоогоор нийт 40 гаруй булш, тахил тайлгын байгууламжийг малтан судлаад байна.

Малтлага судалгааны ажлыг 2016 оны 09-р сарын 02-нээс 09-р сарын 29-ний хооронд хийж гүйцэтгэв. Дээрх хугацаанд малтан судалсан бүх дурсгалыг бүрэн нөхөн сэргээсэн бөгөөд судалгааны явцад Монгол Алтайн Нурууны Улсын Тусгай Хамгаалалттай Газрын судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, Улсын байцаагч М.Жукан болон тусгай хамгаалалттай газрын Улсын байцаагч А.Хайрат нар хүрэлцэн ирж биечлэн үзэж танилцан, зохих дүрэм журмын дагуу хяналт тавьж ажилласан болно.



Зураг 1. 2016 онд малтлага судалгаа хийсэн газрууд



Зураг 2. 2016 онд малтсан бүлэг Сяньби булшны дэвсгэр зураг



Зураг 3. 2016 онд малтсан бүлэг Сяньби булш ба түрэгийн тахилын онгонууд



Зураг 4. 2016 онд малтан судалсан хиргисүүр ба түрэг булшны дэвсгэр зураг

МОНГОЛ-ОРОСЫН ХАМТАРСАН ЧУЛУУН ЗЭВСГИЙН СУДАЛГААНЫ ШИНЭ ҮР ДҮН

Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Е.П.Рыбин, Д.Одсүрэн, А.М.Хаценович, Г.Ангарагдөлгөөн, Г.Маргад-Эрдэнэ

Монгол орны умард хэсэгт, Сэлэнгэ мөрний дунд урсгалын сав нутагт хамаарах Их Төлбөрийн голын хөндийд Төв Азийн бүс нутгийн эртний хүмүүсийн нүүдэл, суурьшил, соёлын уламжлал болон өөчлөлтийн асуудлуудыг тодруулахад үнэ цэнэтэй мэдээлэл өгөх хуучин чулуун зэвсгийн соёлт давхарга бүхий томоохон дурсгалт газрууд олон бий. Өнгөрсөн хугацаанд Их Төлбөрийн голын хөндийд хийсэн судалгааны үр дүнд эндэхийн дурсгалт газрууд дээд палеолитын янз бүрийн үед холбогдох нь тогтоогдсон. Сүүлийн жилүүдэд малтлага судалгааны ажил хийж буй Төлбөр-21 хэмээн судалгааны хүрээнд тэмдэглэгдсэн Уургын амны дурсгалт газрыг бид Монголын умард хэсэгт орших соёлт давхарга бүхий дурсгалуудаас илүү эрт үед холбогдох магадлалтай хэмээн урьдчилсан байдлаар үзэж байна.

Төлбөр-21 сууринг Монгол-Оросын хамтарсан “Умард Монголын чулуун зэвсгийн үе” төслийн 2011 оны хээрийн судалгааны явцад анх илрүүлсэн бөгөөд гадаргуугийн байдал, чулуун зэвсгийн олдворуудын тархалтанд тулгуурлан хоорондоо 30м зайтай 2 сорьц малтлагыг хийсэн юм [Табарев и др., 2012]. Сорьц малтлагуудын хөрсний давхарга адил бөгөөд чулуун зэвсгийн олдворууд 150-200 см гүнд хадгалагдах ба дээд үеүдээс цөөн тооны олдвор илэрчээ [Табарев и др., 2012: 29]. Малтлагын явцад илрүүлсэн амьтны ясны хэлтэрхийд хийсэн лабораторийн судалгааны үр дүн 39.000-45.000 жилийн өмнөх үед холбогдох хамаарал гарсан байна.

2014 онд тус дурсгалт газрын хөрсний бүрдлийг тодорхойлох зорилгоор уулын налуу дэвсэг дээр 4x1м хэмжээтэй талбайд малтлага судалгааг гүйцэтгэсэн. Малтлагыг өнгөн хөрснөөс доош 2.5м хүртэл хийсэн бөгөөд хөрсний 6 давхаргад агуулагдсан 4 соёлт үе байгааг тогтоосон. Эхний 3 үе нь дээд палеолитын янз бүрийн үед холбогдох боломжтой бол доод үеийн хөрсний бүтэц, олдворуудын цуулалтын байдлаас үзвэл, харьцангуй эрт үед буюу дунд палеолитын үед холбогдуулан үзэж болно [Рыбин и др., 2014].

2015 онд өмнөх жилд малтлага судалгаа хийсэн талбайг баруун тал руу нь өргөтгөн 8м^2 талбайд судалгааг гүйцэтгэсэн. Малтлагын явцад чулуун зэвсгийн олдворууд, амьтны ясны жижиг хэсгүүд агуулсан 6 соёлт үе илэрсэн. 1-р үе нь дөрөвдөгчийн сүүл, голоцены эхэн үед хамаарна. 2-р үе нь палеолитын сүүл үед, 3, 4-р үе нь дээд палеолитын эхэн үед холбогдох бол 5, 6-р үеэс төрөл зүйлийн хувьд хязгаарлагдмал цөөн тооны олдвор илэрсэн тул аль үед холбогдохыг эцэслэн тогтоох боломжгүй байна. Гэвч энэ давхаргаас илрүүлсэн ясны хэлтэрхийд хийсэн C^{14}

шинжилгээний үр дүн 44640±690 (MAMS-14933) жилийн өмнөх үед холбогдохыг зааж байна.

2016 онд тус төслийн хүрээнд өмнөх малтлагуудаас зүүн зүгт, уул уруудсан жалганы ирмэг дээр 12м^2 талбай сонгон судалгааг хийлээ. Малтлага судалгааг 170см гүнд хүртэл гүйцэтгэсэн. Мөн хөрсний бүтэц, олдворын тархалт зэргийг тодорхойлох зорилгоор малтлагын талбайн зүүн хэсэгт, жалганы налууг дагуулан 1м өргөнтэйгээр жалганы ёроол хүртэл шатлан малтав. Үүнийг бид хээрийн судалгааны баримтжуулалтанд “Суваг-1” хэмээн тэмдэглэсэн. Эндээс хойд зүгт 20м зайд жалганы эхэн хэсэгт 2 дахь сорьц малтлагыг хийсэн бөгөөд “Суваг-2” хэмээн баримтжуулсан.

2016 оны малтлагаас хөрсний дөрвөн өөр давхаргад 5 соёлт үе агуулагдаж байгааг тогтоосон (зураг 1а) бөгөөд чулуун зэвсгийн олдворууд 170см хүртэлх гүнээс гарав.

1-р давхарга (10-0см). Хүрэн өнгөтэй өнгөн хөрс бөгөөд эртний хүний ул мөр бүхий 1-р үе хамаарна.

2-р давхарга (10-60см). Энэ давхарга хөрсний 2 өөр бүрдлийг агуулжээ. Дээр байрлах цайвар өнгийн нарийн ширхэгтэй шаварлаг хатуу үе нь 10-15см зузаан. Энэ давхаргыг 2А хэмээн тэмдэглэсэн бөгөөд чулуун зэвсгийн олдвор агуулсан соёлт үеийг мөн 2А хэмээн тэмдэглэв. Түүний доод талыг 2Б хэмээн тэмдэглэсэн. Энэ хөрсний давхаргад агуулагдах олдворт үеийг мөн 2Б хэмээн тэмдэглэв. Энэ давхарга нь жижиг хайрга чулуу ихтэй цагаан шаргал өнгийн элсэрхэг хөрснөөс тогтох бөгөөд 40-45см зузаан ажээ.

3-р давхарга (60-150см). Энэ давхаргын дээд хэсгийг 3А хэмээн тэмдэглэсэн бөгөөд налуу даган удаан хугацаанд урсаж орж ирсэн усны урсгалын явцад тогтсон элсэрхэг болон шаварлаг хөрснөөс бий болсон 10см зузаантай. Хөрсний энэ бүрдэлд хадгалагдаж буй соёлт үеийг 3А хэмээн тэмдэглэж баримтжуулсан. Үүний доор 3Б давхарга залгах бөгөөд 70см хүртэлх зузаан. Энэ нь удаан хугацаанд хур тунадасны нөлөөгөөр бий болжээ. Энэ давхаргын дээд хэсэгт 20-30см зузаантай соёлт үе бий.

4-р давхарга (150-170см). Химэрлэг элсэрхэг хөрснөөс тогтох ба хагархай хэлтэрхий, жижиг чулууны үйрмэгийг агуулжээ.

Эдгээр давхаргуудаас 5000 орчим чулуун зэвсгийн олдвор малтан гаргасан.

1-р давхаргаас цөөн тооны олдвор илэрсэн бөгөөд олдворуудын ихэнх нь хагархай хэлтэрхий, жижиг залтас юм.

2-р давхарга нь хоёр соёлт үед хуваагдах бөгөөд дээд хэсэгт нь орших эхний үеэс (2А) ганц нэг зэвсгийн төрлийн олдворууд, цуулдаснууд илэрч байв. Харин доод үе нь (2Б) нэлээд баялаг олдворыг агуулж байна. Эндээс дундаж хэмжээтэй залтаснууд, ялтас болон ялтсанцар, хагархай хэлтэрхий, хайрс олон гарсны зэрэгцээ чулуун зэвсэг үйлдвэрлэлийн анхдагч цуулалтын арга ажиллагааг илэрхийлэх цацарган болон ташуу, зэрэгцээдүү цуулалттай хавтгай болон призм хэлбэрийн

үлдэцнүүд хэд хэд илэрсэн (зураг. 2-*7;* 3-*5, 6*). Призм хэлбэрийн жижиг үлдцийг жижиг ялтас болон ялтсанцар гарган авахад зориулж бэлтгэсэн байна (зураг. 2-*6*). Зэвсгийн төрөл зүйлд ирлэсэн залтас, залтас ашиглан хийсэн хянгар (зураг. 2-*8;* 3-*7*), ирлэсэн ялтаснууд (зураг. 3-*1-3;* 3-*2*), хатгуур зэвсэг болон хусуур, харуул (зураг. 2-*4, 5;* 3-*3, 4, 8*) хамаарна.

3-р давхаргын дээд үеэс (3А) 5 ш үлдэц илрүүлсэн. Тэдгээр нь хэв шинжийн хувьд цохилтын хоёр талбайт, цуулалтын нэг болон хоёр гадаргуут үлдэц (2 ш)(зураг. 2-*13*); цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут үлдэц (1 ш), цохилтын хоёр талбайт, цуулалтын хоёр гадаргуут призм хэлбэрийн үлдэц (1 ш) хэмээн ангилагдана. Эдгээр үлдцүүдийн цуулалтын гадаргууд зэрэгцээдүү болон сөргүүлсэн цуулалтууд хийж богино ялтас, тэгш өнцөгт хэлбэртэй залтас цуулан авсан оромтой бөгөөд ар талын зарим хэсэгт нь чулууны өнгөн бүрхүүл хэвээр хадгалагдан үлдсэн байна (зураг. 3-*10*). Төв рүү чиглэсэн цуулалтын арга барил бүхий үлдэц нэг илэрсэн нь жижиг хэмжээтэй, зууван хэлбэртэй бөгөөд төв хэсгээрээ ялимгүй гүдгэр. Түүний зах ирмэгийн дагууд төв рүү чиглэлтэй цуулалт хийж жижиг залтаснууд салган авч байжээ. Нөгөөтэйгээр энэхүү эдлэл өндөр хэлбэрийн хусууртай ихэд төстэй(зураг. 2-*15*).

3А үеэс хоёрдогч боловсруулалт хийсэн зэвсэг багажийн ангилалд хамаарч болохуйц 21 ш олдвор илрүүлсэн. Тэдгээрийг төрөл зүйлээр нь ангилан ялгавал, тууш шулуун хянгар (1 ш) (зураг. 2-*12*) хажуугийн хусуур (2 ш) (зураг. 2-*11*), төгсгөл хусуур (2 ш) (зураг. 2-*14;* 3-9), хагархай ашиглан бэлтгэсэн өндөр хэлбэрийн хусуур (1 ш) (зураг. 3-*11*) байна. Мөн зэвсгийн төрөлд ирлэсэн залтас (1 ш), ирлэсэн ялтас (1 ш), ирлэсэн ялтсанцар (1 ш), хажуу захад нь мохоо ир гарсгасан ялтас, ялтсанцар (зураг. 2-*10*), налуу холтчин ирлэсэн ялтас (1 ш) (зураг. 2-*16*), хатгуур (5 ш), бариул бүхий үзүүр мэс (1 ш), үзүүр мэсийн төгсгөл хэсгийн хугархай (1 ш), хутга (1 ш), хүнхэр ирт зэвсэг (1 ш) тус тус илэрсэн байна.

3Б үеэс 2 галын ором илрүүлсэн бөгөөд тэдгээр нь 5-10см орчим зузаантай (зураг. 1b), хадгалалт нэлээд сайтай. Галын ормын эргэн тойронд чулуун зэвсгийн олдворууд, амьтны ясны жижиг хэлтэрхийнүүд тархсан байгаа нь энд гал голомт байсныг гэрчилнэ.

Өмнөх үетэй харьцуулахад чулуун зэвсгүүдийн дунд хоёр тууш ирмэгтэй ялтасны эзлэх хувь 10-20 хувиар нэмэгджээ. Ялтаснуудын дунд том хэмжээтэй, хажуу ирмэгүүд нь үзүүр рүүгээ налж нийлсэн гурвалжиндуу хэлбэртэй болон холточсон цохилтын талбайн үлдэгдэл (зураг. 4-*1*) бүхий эдлэлүүд олширч байна.

Анхдагч цуулалтын ангилалд цуулалт бүхий түүхий эд (2 ш), бэлдэц (6 ш), цохилтын нэг талбайт призм хэлбэрийн үлдэц (1 ш), цохилтын хоёр талбайт призм хэлбэрийн үлдэц (5 ш) байна. Эдгээр нь гүдгэр цуулалтын гадаргуутай бөгөөд хажуу ирмэгүүдийн хоёр талаас цуулалтууд хийж зассан байх ба цуулалтын гадаргуудаа том

уртавтар ялтас цуулсан оромтой (зураг. 4-*6*). Хоёр үлдэц цуулалтын хоёр гадаргуутай. Тэдгээрийн нэг нь зууван хэлбэртэй бөгөөд хөндлөн огтлол нь хавтгай - гүдгэр. Нэг талд нь тэгш цуулалтын гадаргууг бэлтгэсний дараа зэрэгцээдүү цуулалтууд хийсэн оромтой (зураг. 3-*12*). Нөгөө үлдэц нь (зураг. 4-*10*) эсрэг байрлах цуулалтын гадаргуутай бөгөөд талуудыг нь холтчин зассан оромтой. Цохилтын нэг талбайтай хоёр үлдэц 2-р галын ормын дэргэдээс олдсон (зураг. 3-*17*). Зэрэгцээ цуулалтын арга барилт тайрдсан хэв шинжийн үлдэц 4 ш илрүүлсэн бөгөөд гурав нь цохилтын нэг талбайтай, нэг нь хоёр талбайтай ажээ. Эдгээр үлдэцнүүд бүгд боловсруулалтын анхан шатандаа байна. Мөн анхдагч цуулалтын ангилалд хамаарах эдлэлүүдэд төврүү чиглэсэн цуулалт бүхий үлдэц 4 ш хамаарна (зураг. 3-18; 4-9).

Багаж зэвсгийн төрөл зүйлд хамаарах эдлэлүүд нийт 44 ш илэрсэн бөгөөд бүх зэвсгүүдийн 45 хувийг ялтсан цуулдас ашиглан бэлтгэсэн байна. Зэвсгийн төрөл зүйлд ирлэсэн залтас (13 ш), ирлэсэн ялтас (5 ш) хамгийн олон байна.



Зураг. 1. Төлбөр-21. 3Б үе. Галын ором, чулуун зэвсгүүд

Төгсгөл хусуур (4 ш)-уудыг хийхдээ ялтас ашигласан байх бөгөөд ялтасны нэг төгсгөл хөндлөн ирмэгийг холтчин ирлэж зассан байна (зураг. 4-*8*). Хосолмол зэвсгүүдийн (3 ш) хоёр нь төгсгөл хусуурын үндсэн элементийг агуулжээ. Тэдгээрийн нэг нь хусуур болон хатгуур (зураг. 4-*4*), нөгөөх нь төгсгөл хусуур болон хутганы (зураг. 4-*2*) ирийг хослуулан гаргасан байна. Хүнхэр ховилтой зэвсэг (1 ш)-ийг(зураг. 4-7) өргөн ялтас ашиглан бэлтгэсэн байна.

Бифас хоёр байгаагийн эхнийх нь зууван хэлбэртэй (зураг. 3-*13*). Түүнийг том хэмжээтэй хагас анхдагч залтсаар бэлтгэсэн бөгөөд залтасны ар болон нүүрэн талаас нь төв рүү чиглүүлэн холтчих аргаар зассан байна. Хоёр дахь нь навчин хэлбэрийн бифастай төстэй (зураг. 4-*5*). Түүнийг мөн төв рүү чиглэсэн цуулалтуудын дүнд бэлтгэсэн бөгөөд зах ирмэгүүдийг нь шаталсан хайрслаг ирээр нэмэж зассан нь ажиглагдана.

Хянгар (4 ш)-уудыг баргил залтас ашиглан хийсэн байх ба хэв шижнийн хувьд ар талаасаа ирлэгдсэн хөндлөн шулуун дан ирмэгтэй (зураг. 3-*14*), тууш шулуун дан ирмэгтэй, нүүрэн талаасаа ирлэгдсэн тууш шулуун дан ирмэгтэй, гүдгэр ирмэгийг нь нямбай холтчин зассан хянгар-хутга (зураг. 4-*11*) хэмээн ангилагдана.

Багаж зэвсгийн бусад төрөл болох хатгуур (9 ш)(зураг. 3-*15*, *16*), анхдагч ялтасны үзүүр хэсгийг налуулан зассан эдлэл (зураг. 4-*3*), хүнхэр ирт зэвсэг (2 ш) тус тус илрүүлжээ.

Багаж зэвсгийн бүрдэлд Их Төлбөрийн голын хөндийн дурсгалуудаас тогтмол илэрдэг хатгуур зэвсэг, хянгар, төгсгөл хусуурууд олон гарсны зэрэгцээ өвөрмөц хэв шинж бүхий багаж зэвсгүүд, тухайлбал, навчин хэлбэрийн бифас, нямбай засаж боловсруулсан хянгар-хутга зэрэг сонирхолтой олдворууд энэ оны малтлагаас илрүүлээд байна.

Жалганы ирмэг дайруулан малтсан суваг хэлбэрийн талбайгаас мөн зарим сонирхолтой олдворууд илэрсэн бөгөөд тухайлбал, цацарган цуулалтад үлдэц (зураг. 4-*12*), цохилтын талбайг нь холтчин, хажуу захаас нь хөндлөн цуулалтууд хийж зассан бэлдэц (зураг. 4-*13*) зэргийг дурдаж болно.

Хөрсний үе давхаргууд болон чулуун зэвсгийн олдворуудын цуулалтын арга барилын харилцан хамаарал зэрэгт үндэслэн чулуун зэвсгийн олдвор агуулсан соёлт үеүдийн хамаарах он цагийг урьдчилсан байдлаар тодорхойлж болно.

Цөөн тооны чулуун зэвсгийн олдвор агуулсан 2А үеийг дээд палеолитын төгсгөл, голоцены эхэн үед хамаарна хэмээн үзэж байгаа бөгөөд Их Төлбөрийн голын хөндийн бусад дурсгалуудын дээд үетэй адил юм. 2Б үеэс илрүүлсэн чулуун зэвсгийн олдворуудын дунд бичил цуулалтын арга барил давамгайлах бөгөөд ирлэн зассан янз бүрийн ялтас, мохоо ирмэгтэй ялтсанцар зэрэгт тулгуурлавал 18-16 мянга орчим жилийн өмнө энэ үе бүрэлдсэн хэмээн таамаглаж байна.

3А үе дээд палеолитын эхэн үед хамаарах бөгөөл ялтсан цуулалтын арга барил олдворуудын дунд дийлэнх хувийг эзэлнэ. Гэвч ялтаснууд дундаж хэмжээтэй (65мм урт, 18мм өргөн).

3Б үеийн чулуун зэвсгийн олдворууд дээд 3А үетэй харьцуулахад харьцангуй том бөгөөд хамгийн урт ялтас нь 99 мм, өргөн нь 24 мм байна. 3Б үеэс дээд палеолитын эхэн үеийн хэв шинж бүхий зэрэгцээ цуулалтын арга барилт үлдэц, тайрдсан үлдэц, налуу үзүүр бүхий таслагч зэвсэг, навчин хэлбэрийн бифас зэрэг эдлэлүүд илэрсэн нь Өмнөд Сибир, Дундад Азийн мөн үеийн дурсгалуудаас илэрсэнтэй адил байна. Мөн Төлбөр-4 суурингийн 5-6 дугаар үе бидний 3Б хэмээн тэмдэглэсэн үетэй чулуун зэвсгийн цуулалтын арга барил, хэв шинжээрээ адилсана. Тиймээс бид 3Б үеийг дээд палеолитын эхэн үе буюу 38-39000 мянган жилийн өмнөх үед холбогдоно хэмээн үзэж байна.

Бид малтлага судалгааны зэрэгцээ Сэлэнгэ мөрний дунд урсгал орчмоор баруун талаас нь цутгах (Их Төлбөрийн голын зүүн талаар) Хужиртын гол, Арцатын голын сав дагуу бэсрэг хагуулын ажил зохион байгуулсан. Хайгуулын үр дүнд Хужиртын голын баруун гар талын намхан дэнжийн налуу гадаргуу дээр чулуун

зэвсгийн олдворууд сийрэг тархсан дурсгалт газрыг илрүүлсэн бөгөөд Хужиртын гол-1 хэмээн тэмдэглэсэн. Эндээс дээд палеолитын эхэн үеийн хэв шинж бүхий залтас, ялтсан залтас, ялтас, ирлэсэн ялтас, цуулдсан сийлүүр (зураг. 5-*1*), ирлэсэн залтас зэрэг зэвсгийн төрлийн олдворууд түүвэрлэн цуглуулсан.

Хужиртын голын хөндийн зүүн гар талаас залгасан нарийн амны эхэнд, араараа өндөр уулаар хүрээлэгдсэн намхан дэнжийн энгэрт дараагийн дурсгалт газрыг илрүүлэн Хужиртын гол-2 хэмээн тэмдэглэсэн бөгөөд гадаргуу дээр баргил ялтас (3 ш), леваллуагийн хэв шинжийн залтас (зураг. 3-*3*), хусуур (зураг. 3-*2*) зэрэг олдворууд тархсан байна.

Хужиртын гол-2 дурсгалт газрын байршил зүйн хувьд Монгол орны умард хэсгийн соёлт давхаргатай томоохон дурсгалт газруудтай адил тул энд 2 газарт сорьц малтлага хийв. 1-р сорьц малтлагаас тухайн дурсгалт газарт хөрсний 5 өөр давхаргатай болох нь мэдэгдсэн бөгөөд 1-р давхаргаас залтас (5 ш), ялтас (2 ш), ялтсанцар (1 ш) гарсан байна. 2-р давхаргаас нийт 11 олдвор илрүүлснээс 6 нь том хэмжээтэй ялтас болон ялтасны хугархай юм. Харин залтас (4 ш), хагархай (1 ш) гарчээ. 2-р үеийн цуглуулганд том хэмжээтэй хагас хавирган ялтас (зураг. 5-*7*), цохилтын талбай дээрээ холточсон оромтой тохиолдлын ир бүхий ялтас (зураг. 5-*5*), ялтсан сийлүүр (зураг. 3-*6*) зэрэг эдлэлүүд хамаарна. 3-р давхаргаас ялтасны хугархай гурав илэрсэн бөгөөд зарим нь цохилтын талбайн үлдэгдэл дээрээ холточсон ул мөртэй (зураг. 5-*4*).

Хужиртын голын баруун талаар Сэлэнгэ мөрөнд цутгах Арцатын гол хэмээх уулын түргэн урсгалт голын хөндийд хайгуул судалгааг үргэлжлүүлсэн бөгөөд ганц нэг чулуун зэвсгийн олдвор гадаргуугаас олсон боловч томоохон дурсгалт газар илрүүлээгүй.

Хамтарсан төслийн хүрээнд Төлбөр-21 дурсгалт газын малтлагаас хөрсний дээж болон амьтны ясны дээжүүдийг авч лабораторийн шинжилгээнд илгээгээд байгаа бөгөөд хөрсний давхарга, олдвор агуулсан соёлт үеүдийн он цагийн хамаарал, тухайн бүс нутгийн эртний уур амьсгал, байгаль орчины талаар илүү өргөн мэдээлэл өгнө хэмээн найдаж байна.

Ном зүй

1. Рыбин и др., 2015 – Рыбин Е.П., Звинс Н., Гунчинсурэн Б., Хаценович А.М., Харевич В.М., Болорбат Ц., Анойкин А.А., Одсурен Д., Павленок Г.Д., Шелепаев Р.А. Исследования многослойной палеолитической стоянки Толбор-21 (Северная Монголия) // Проблемы археологии, этнографии, антропологии Сибири и с определьных территорий: Материалы Итоговойсессии Института археологии и этнографии СО РАН 2015 года. – Новосибирск: Изд-во ИАЭТ СО РАН, Т. XXI. – С. 152-156.

2. Табарев и др., 2012 – Табарев А.В., Гунчинсурэн Б., Гиллам Дж.К., Гладышев С.А., Доганджич Т., Звин Н., Болорбат Ц.,Одсурэн Д. Комплекс памятников каменного века в долине р. Их-Тулбэрийн-Гол, Северная Монголия (разведочные работы с использованием ГИС-технологий в 2011 г.) // Археологийн судлал, – Т. XXXII. – С. 26–43.



Зураг 2. Төлбөр-21. 2-р үеийн олдворууд: 1 – 9; 3А үеийн олдворууд: 10 – 16.



Зураг 3. Төлбөр-21. 2-р үеийн олдворууд: 1 – 8; 3А үеийн олдворууд: 9 – 11; 3Б үеийн олдворууд: 12 – 18.



Зураг 4. Төлбөр-21. 3Б үеийн олдворууд: 1 – 11; Суваг-1-ийн доод үе: 12 – 13.



Зураг 5. Хайгуул судалгаа

A – Хужиртын гол-2. (зүүн урд талаас)

B –Хужиртын гол -1: 1; Хужиртын гол-2: 2–7

“ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 2016 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

М.Эрдэнэ, Д.Хатанбаатар, Марк Хортон

МУИС-ийн Антропологи, археологийн тэнхим 2009 оноос “Хэрлэн голын сав газрын археологийн дурсгал” судалгааны төслийг Английн Бристолын их сургуулийн Археологи, антропологийн тэнхимтэй хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хугацаанд Хэрлэн голынсав дагуу Төв аймгийн Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутагт байрлах хүрэл, хүннү, түрэг, монголын эзэнт гүрний үед хамаарах хэд хэдэн цогцолбор дурсгалт газруудыг илрүүлэн дэвсгэр зургуудыг гаргасан бөгөөд зарим дурсгалуудад малтлага судалгаа явуулаад байна.

2016 онд уг төслийн хамаарах нутаг дэвсгэрт археологийн хайгуулыг үргэлжлүүлэн явуулж, өмнө илрүүлсэн зарим дурсгалт газраа малтлага хийсэн ба 2014 онд Хэрлэнгийн зүүн хүрээний туурьд урьдчилсан байдлаар гаргасан тойм дэвсгэр зургаа дахин сайжруулж дроны технологи болон GPR хэмжилтийн аргуудаар судалгаа явууллаа.

Малтлага судалгаа. МУИС-ийн Антропологи, археологийн тэнхмийн Археологийн судалгааны баг 2016 оны 8 дугаар сарын 1-ээс 8 дугаар сарын 12-ны хооронд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг Жаргалантын хөндий, Аваргын гуу хэмээх газруудад археологийн малтлага судалгааг хийж гүйцэтгэлээ. Хээрийн судалгааны явцад Жаргалантын хөндийд хүрлийн үед холбогдох хоёр булш, Аваргын гууд Монголын дундад зууны үед холбогдох таван булшинд малтлага судалгаа явуулав.

Жаргалантын ам. Хэнтий аймаг, Цэнхэрмандал сумын II баг (Жаргалант)-ийн нутаг Жаргалантын ам нь Төв аймгийн Мөнгөнморьт сум, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдын нутгийн заагт, Хэрлэн голын зүүн талд, хойд талаараа Сантын уулсаар, урд талдаа Ногоон модот уулын салбар уулс болох Хавцал, Уст, Сэрүүн уулсаар хүрээлэгдэн, зүүнээс баруун, баруун урагш чиглэн 40 гаруй км үргэлжлэх уужим ам болно. Уг амны эхэнд Хэрлэн голд шахан байрласан хос толгойн (нутгийнхан Бор толгой хэмээн нэрлэнэ) өмнө бэлд хүрэл зэвсгийн үеийн олон тооны дурсгалууд байрлах ба нэгэн талбайд дөрвөлжин булш, хиргисүүр зэрэгцэн байрщдагаараа онцлогтой. 2011 онд МУИС, Английн Бристолын их сургуулийн хамтарсан судалгааны анги тус оршуулгын газрын дэвсгэр зургийг анх хийсэн ба нийт 26 дурсгалыг багтаасан болно[1].

---

[1] *Horton M., Tumen D., Erdene M. Kherlen valley survey, Eastern Mongolia (2009-2011). “Монгол болон Сибирийн Байгалын эртний соёл” ОУЭШ-ний 3-р хурлын илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар, 2012. х. 665-678.*

Бид энэ удаад уг оршуулгын газрын дэвсгэр зурагт 20 ба 9 хэмээн тэмдэглэгдсэн 2 дөрвөлжин байгууламжийг малтан судлав. Эдгээр байгууламжуудаас оршуулга болон ямар нэгэн эд өлгийн зүйл илрээгүй бөгөөд эрт цагт эвдэгдэн тоногдсон бололтой.

Аваргын гуу. Жаргалантын амнаас хойш 4км-т байрлах, Хэрлэн голын нэгэн салаанд зүүн талаас нь шахан орших хадтай толгойн урд амыг Аваргын гуу хэмээн нутгийнхан нэрлэнэ. Манай хээрийн шинжилгээний анги энэхүү хадтай толгойн урд болон баруун энгэрт 4 булш, Аваргын гууны эхэнд, замын урд талд байх, дээрээ овоо бүхий жижиг толгойн урд энгэрт нэг булш малтан судаллаа.

Булш 1.Гадаад зохион байгуулалт нь дунд зэргийн хэмжээтэй чулуугаар үйлдсэн зуувандуу хэлбэртэй битүү, дугуй чулуун дараастай булш бөгөөд газрын хөрснөөс дээш 10-20см өндөр байв. 4x3.5м талбайгаар цэвэрлэгээг хийж, дараас чулуудыг зайлуулан 3x2м талбайгаар доош 55см малтахад малтлагын нүхний төв хэсэгт баруун хойноос зүүн урагш чиглэсэн гонзгой дөрвөлжин хэлбэртэй оршуулгын толбо илрэв. Толбоны хэмжээ 1.1x0.6м. Толбыг дагуулан малтахад толгой талаас нэг ширхэг хар өнгийн сувс,нүхний цээж хэсгээс үйсэн эдлэлийн хэсэг, хөл хэсгээс бог малын нурууны яс олдов. 80см-т оршуулгын нүхний хойд захад маш муу хадгалагдсан, бага насны хүүхдийн толгойны яс олдов. 90см-т байгалийн хөрс гарсан тул малтлагыг зогсоон булшийг эргүүлэн дарж булав. Малтлагын нийт гүн 1.2м.

Булш3. Гадаад зохион байгуулалт нь дунд зэргийн хэмжээтэй чулуунуудаар үйлдсэн, битүү, гонзгой зууван чулуун дараастай булш бөгөөд гол хэсгээрээ бага зэрэг овгор, газрын хөрснөөс дээш 30-40см өндөр байв. Чулуун дараасны хэмжээ 2.5x2.1м. 3x3.5м талбайгаар тэг татаж, цэвэрлэгээг эхлүүлэв. Цэвэрлэгээний явцад ямар нэг эд зүйл илэрсэнгүй. Чулуун дараасыг зайлуулж 2.2м талбайгаар 20см гүн малтахад 1.6м урт, 0.75см өргөн, хөл хэсэгтээ цөөн хэдэн чулуу бүхий хүрэн өнгийн толбо илэрлээ. Доош 30см гүн малтахад нүхний толгой болон хөл талаар жижиг чулуун чигжээс үргэлжлэн гарсаар байв. Үйсэн эдлэлийн тасархай нүхний энд тэндээс илэрч байв. 80см-т оршуулгын нүхний хойд захад маш муу хадгалагдсан, бага насны хүүхдийн толгойны яс олдов. Зүүн шанааны орчмоос бог малын шагай, 1 төмөр зэвний үлдэгдэл, хөл талаас хоёр ширхэг жижиг ногоон чулуун сувс, мөн толгой орчмоос бог малын нурууны яс олдов. Нас барагчийг чулуун хашлаганд, үйс дэвсэж, хойд зүг чиглүүлэн оршуулсан бололтой байв. 90см-т байгалийн хөрс гарсан тул малтлагыг зогсоон булшийг эргүүлэн дарж булав.

Булш 4. Уг булшны дараасыг цөөвтөр хэдэн том чулуудаар хийсэн ба хагас цагариг хэлбэртэй мэт харагдана. Газрын дээд хэсгээрээ чулуу багатай. Зарим чулууд газрын уруу өнхөрсөн мэт харагдана. 5x4.5м талбайгаар тэг татаж, малтлагыг эхлүүлэв.

Дараас чулуудыг авч 3х3м талбайгаар 50см малтахад зүүн хойш чиглэлтэй, элс хайрга холилдсон 1.7х0.8м хэмжээтэй толбо илрэв. Энэхүү дурсгалаас ямар нэгэн эд өлгийн зүйл илэрсэнгүй явсаар 1.2м гүнд байгалийн хөрс тулав.

Булш 5. Уг булш нь Аваргын гууны арын бага шиг хадтай энгэрт, зэргэлдээ булшнаас зүүн тийш 10 орчим м зайд байрлана. Зүүн хойно орших уулын орой тийш чиглэсэн. Гол хэсгээрээ нэлээд овгор, битүү чулуун дараастай булш. Дараасыг том чулуудаар үйлдсэн, дараас 3х2.7м хэмжээтэй. Чулуун дараасыг авч 40см гүн малтахад гол хэсэгт 2.5х1.1м хэмжээтэй, зүүн хойд зүг чиглэсэн гонзгой дөрвөлжин хэлбэртэй, хөл хэсгээрээ цөөн хэдэн чулуу бүхий оршуулгын толбо илрэв. 70см-т маш муу хадгалагдсан хүний оршуулга илрэв. Хүний араг яс ерөнхийдөө анатомийн байрлалаараа боловч цээжин хэсгийг тонуулчид бүрэн сүйдлэсэн байв. Хүний толгойн баруун талд богийн шаант чөмгийг босоогоор нь тавьсан ба баруун гуяны гадна талд бог малын нуруу тавьсан байна. Ясны байрлалаас харахад хүнээ зүүн хойш хандуулан дээш харуулж тэнэгэр байдалтай оршуулсан ажээ. 90см-т байгалийн хөрс гарсан тул малтлагыг зогсоон булшийг эргүүлэн дарж булав.

Булш 6. Уг булш нь Аваргын гууны эхэн дэх оройдоо овоотой бага шиг толгойн энгэрт байрлана. Гадаад зохион байгуулалт нь дунд зэргийн чулуугаар үйлдсэн дугуй хэлбэртэй хавтгай. 20см-т малтлагын нүхний төв хэсэгт хойд зүг рүү чиглэсэн гонзгой дөрвөлжин хэлбэртэй оршуулгын толбо илрэв. 70см-т маш муу хадгалагдсан хүний оршуулга илрэв. Хүний араг яс нь анатомийн байрлалаараа байв. Ясны байрлалаас харахад нас барагчийг толгойгоор нь баруун хойш хандуулан дээш харуулж тэнэгэр байдлаар оршуулсан бололтой. Хүний толгойн баруун талд маш муу хадгалагдсан төмөр хутганы үлдэгдэл, баруун гарын орчмоос дэгээ хэлбэртэй зориулалт тодорхойгүй төмөр эдлэл, ногоон өнгийн цахиур чулуун залтас илрэв. 90см-т байгалийн хөрс гарсан тул малтлагыг зогсоон булшийг эргүүлэн дарж булав.

Аваргын гууд малтсан дээрх булшнууд нь гадаад зохион байгуулалт, дараасын хэлбэр, оршуулгын зан үйл болон дагалдуулсан эд өлөгийн зүйлсээс харахад он цагийн хувьд монголын үед холбогдох бололтой.

а. *б.*

Зураг 1.Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Жаргалантын аманд малтан судалсан дурсгалууд.
а. Булш 20, б. Булш 9.



а. *б.*

в. *г.* *д.*

Зураг 2. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Аваргын гууд малтан судалсан дурсгалууд.
а. Булш 1, б. Булш 3, в. Булш 4, г. Булш 5, д. Булш 6

Хэрлэнгийн Зүүн хүрээний турьд хийсэн судалгаа.

МУИС, Английн Бристолын их сургуулийн хамтарсансудалгааны анги 2016 оны 9 дүгээр сарын 12-оос 18-ны хооронд Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Суурингийн дэнж хэмээх газар дахь Хэрлэнгийн Зүүн хүрээнд археологийн хайгуул, GPR хэмжилт судалгааг хийж гүйцэтгэлээ. МУИС, Английн Бристолын их сургуулийн хамтарсан судалгааны анги 2014 онд тус дурсгалт газар хайгуул судалгаа хийн газрын хөрсөн дээр танигдаж болохуйц байгууламжийн үлдэгдлүүдийн байршлыг тодорхойлон улмаар дурсгалт газрын дэвсгэр зургийг тоймлон үйлдсэн болно.[2]

Хэрлэнгийн Зүүн хүрээг Өндөр гэгээн Занабазар 1711 онд суурийг тавьсан хэмээн үздэг ч энэ талаар түүхийн баримтуудад харилцан зөрөөтэй онуудыг тэмдэглэсэн байдаг. Археологийн судалгааны урьдчилсан дүнгээс харахад уг суурind харьцангуй урт хугацаанд хүн ам суурьшиж байсан бололтой. Бид 2016 оны хээрийн судалгаагаар Хэрлэнгийн Зүүн хүрээний дурсгалт газар мэргэжлийн дрон ***Phantom DJI Professional Drone*** ашиглан газрын гадаргаас дээш 100м-ийн өндрөөс 75%-ийн давхцалтай зураг авалт хийлээ. Нийт 260 кадр зураг авсан бөгөөд эдгээр дүрсүүдийг газрын зураг үйлдэх **Drone Deploy** (https://www.dronedeploy.com)программын тусламжтайгаар боловсруулан уг дурсгалт газрын дэвсгэр фото зургийг гаргалаа. Дроны тусламжтай үйлдсэн дэвсгэр зургийг 2014 оны хайгуулын явцад GPS-ийн тусламжтай үйлдсэн гар зурагтай харьцуулахад дроны зураг дурсгалын бүтэц зохион байгуулалтыг илүү тодорхой харуулж байна(*Зураг 3*).

Үүнээс гадна дроны технологийн тусламжтайгаар уг суурингийн газрын гадаргын ургамалжилтын ялгарлын индексийг (Normalized difference vegetation index, NDVI) тодорхойлсон болно. Энэ арга нь газрын гадарга дээрх ургамалжилтын ялгаагаар археологийн суурингийн бүтэц, зохион байгуулалт, байрлал, шинж чанарыг тодорхойлох боломж олгодог бөгөөд бидний хийсэн судалгаагаар Зүүн хүрээний төв хэсэгт хамгийн нягт ургамалжилттай, ургамалжилтын байдал хийдийн дуган, дацан, аймгуудын байршлыг тодорхой харуулж байлаа. Дроноос авсан зургийн мэдээлэл дээр тулгуурлан Зүүн хүрээний дурсгалт газрын 3D загварыг гаргасан нь уг дурсгалт газрын доторх байгууламжуудыг нарийн тодорхойлох боломж олгож байна. Түүнчлэн, ARCGIS программын тусламжтайгаар Зүүн хүрээний орчмын газар нутгийн өндөрлөгийн загварыг гаргасан бөгөөд үүгээр уг суурингийн төв хэсэг захын хэсгээс бараг 2м шахуу өндөр байгаа нь харагдсан болно.

Хэрлэнгийн Зүүн хүрээний дурсгалт газрын дэвсгэр зурагт Байгууламж 5, Байгууламж 21 хэмээн дугаарласан байгууламжууд дээр GPR(Ground penetrating radar) буюу газрыг цахилгаан соронзон туяагаар нэвтлэн хэмжих аргаар судалгаа

---

[2] *Horton M., Erdene M., Vito Pecchia, Parkers G., 2015. Survey results at DzuunKhuree monastic site, Eastern Mongolia. In: Ancient cultures of the Northern area of China, Mongolia and Baikalian Siberia. Beijing, Vol. 3, p. 1296-1313*

явууллаа. GPR хэмжилт нь газрын гадарга дээр ил харагдаж нүдэнд мэдрэгдэхгүй археологийн байгууламжийг хөрсний бүтцийн өөрчлөлтөөр илрүүлэн танихад ихээхэн үр дүнтэй болох нь бидний судалгаанаас харагдлаа.



Зураг 3. Хэрлэнгийн Зүүн хүрээний дроноор авсан болон GPS-ийн тусламжтай үйлдсэн гар зураг



Зураг 4. Хэрлэнгийн Зүүн хүрээний Байгууламж 5-ын газрын гадаргын GPR хэмжилтийн зураглал ба дроноос авсан зураг

ХЭНТИЙ АЙМГИЙН НУТАГТ ШИНЭЭР БҮРТГЭСЭН ХҮННҮГИЙН БУЛШ ОРШУУЛГЫН ДУРСГАЛТ ГАЗРУУД

Г.Эрэгзэн, С.Эрдэнэсувд, Б.Батдалай, Д.Мандах, С.Энхболд

Саяхныг хүртэл Хэнтий аймгийн нутгаас Борбулагийн ам, Дуурлиг нарс, Дуулга уул, Долоодын нарийны ам гэсэн Хүннүгийн булш оршуулга бүхий 4 дурсгалт газар илэрч мэдэгдээд байв. Эдгээрээс сүүлийн 3 газарт малтлага судалгаа хийгдэж, тодорхой үр дүнд хүрчээ.

2015 онд БСШУЯ-ны захирамжаар бүх аймаг, сумын нутагт буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого бүртгэлийн ажил хийгдсэн бөгөөд энэ хүрээнд Хэнтий аймгийн музейгээс хайгуул, бүртгэл хийх хээрийн шинжилгээний ангийг томилон ажиллуулсан байна. Энэхүү хайгуул судалгааны үр дүнд тус музейн ажилтнууд олон тооны үл хөдлөх дурсгалыг бүртгэж баримтжуулсны хамт 10 сумын нутгаас 15 газарт Хүннүгийн булш байх магадлалтай дурсгалуудыг шинээр илрүүлжээ.

Гэвч уг судалгааны багт мэргэжлийн археологич ажиллаагүйгээс тоолж бүртгэсэн дурсгалуудын холбогдох он цагийн асуудал найдвартай биш байсан тул ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнд нягтлаж үзэх хүсэлт тавьсан. Энэ хүсэлтийн дагуу тус хүрээлэнгийн нэр бүхий судлаачдаас бүрдсэн баг 7 хоногийн хугацаанд Хэнтий аймгийн нутагт шинээр илэрсэн дурсгалт газруудыг зорин очиж нягтлан үзсэний дээр зарим дурсгалт газарт буй булш оршуулгын тархацын дэвсгэр зургийг үйлдсэн юм.

Тус өгүүлэл нь шинээр бүртгэн баримтжуулсан Хүннүгийн булш оршуулгын дурсгалуудыг танилцуулах, тархацын зураг зэрэг мэдээллийг судалгааны эргэлтэнд оруулах зорилго агуулав.

Шинээр бүртгэж баримтжуулсан Хүннүгийн дурсгалт газрууд

Судалгааны баг Хэнтий аймгийн Мөрөн - Чингис хот - Дадал - Батноров – Баянхутаг – Галшар – Бор-Өндөр – Дархан – Баянмөнх – Дэлгэрхаан – Жаргалтхаан гэсэн маршрутын дагуу нийт 11 сумын нутгаар 3000 орчим км зам туулан, аймгийн музейн ажилтнуудын илрүүлсэн Хүннүгийн булш оршуулга бүхий дурсгалт газруудыг үзэж, боломжтой газруудад тархацын дэвсгэр зургийг үйлдэн, агаарын зураг, гэрэл зургийн баримтжуулалт хийсэн юм. Дэвсгэр зургийг GPS багажаар хийсэн хэмжилтийн мэдээллийг газарзүйн мэдээллийн систем (GIS) программд оруулах аргаар үйлдэв.

Дор бүртгэж баримтжуулсан дурсгалуудыг бүртгэсэн дарааллын дагуу товч танилцуулав.

1. Уртын амны хүннү булш (N47 26.704 E110 27.394)

Мөрөн сумын 3 дугаар багийн нутаг, сумын төвөөс зүүн хойд зүгт 22км-ийн зайд "Уртын ам" хэмээх жижиг голын хөндийд олон үеийн дурсгал тархжээ. Бид энэ газарт Хүннүгийн үед холбогдох цагариг хэлбэрийн чулуун дараастай 98 булшийг бүртгэн баримтжуулсан. Сонирхолтой нь эдгээр булшны зарим нэг булшны өмнө талд үүдэвч маягын чулуун байгууламж ажиглагдсан. Ийм үүдэвч маягийн чулуун байгууламж нийт 15 булшинд тохиолджээ. Уртын амны хүннү булшны жижиг нь 3м орчим, том нь 18м голчтой байв.

2. Өлийн давааны хүннү булш (N49 00.638 E111 35.492)

Дадал сумын Баян-Овоо багийн нутагт, сумын төвөөс баруун өмнө зүгт 2км зайд Өлийн даваа хэмээх газар байх бөгөөд энд нарсан ойн баруун захад Хүннүгийн үед холбогдох цагариг хэлбэрийн чулуун дарааст 8 булш байна. Хэмжээний хувьд жижиг нь 3м орчим, том нь 6м орчим голчтой юм.

3. Баян-Овоогийн Өндөрийн хүннү булш (N49 01.942 E111 37.301)

Дадал сумын төвийн хойно Баян-Овоогийн Өндөр хэмээх газарт нарсан ой дотор хоорондоо 100 гаруй м зайд 2 бүлэг болон тархсан 20 гаруй тооны Хүннүгийн үед холбогдох цагариг хэлбэрийн чулуун дарааст булш байна. Энэ дурсгалыг өмнө нь "Хажуу булгийн хүннү булш" нэрээр бүртгэсэн байна. Бид тархацын дэвсгэр зургийг үйлдэв. Булшны хэмжээ жижиг нь 5м орчим, том нь 15м хүрэх голчтой ажээ.

4. Шанага уулын хүннү булш (N47 37.483 E111 25.993)

Батноров сумын 5-р баг буюу "Идэрмэг" багийн нутаг, сумын төвөөс баруун урагш 50 орчим км зайд орших уулыг нутгийнхан Шанага хэмээнэ. Энэ уулын энгэрээр Хүннүгийн үед холбогдох цагариг хэлбэрийн чулуун дарааст 8 булшийг бүртгэн баримтжуулсан. Булшны хэмжээ бага нь 3м орчим, том нь 10м хүрэх голчтой ажээ.

5. Улаан ханангийн хүннү булш (N47 21.396 E111 22.672)

Баянхутаг сумын Жаргалант багийн нутаг, сумын төвөөс зүүн зүгт 60 орчим км зайд Баянхүрээ уулын баруун хэсэгт байрлах эгц цавчим өндөр хадан хясааг Улаан ханан хэмээнэ. Энэ хадан хясааны зүүн, баруун талд, мөн баруун өмнө талд 3 хэсэг газар Хүннүгийн үеийн цагариг хэлбэрийн чулуун дарааст булшнууд тархжээ. Хадан хясааны зүүн талд байрлах бүлэг булш нь Баянхүрээ уулаас буух жалганы баруун талын тэгш дэвсэгт байрлана. Энд нийт 32 булш бүртгэсэн. Булшны бага нь 4м, том нь 9м голчтой ажээ. Хадан хясааны баруун талын жалганы баруун талд, уулын зүүн энгэрийн налууд 3 бүлэг болгож тавьсан 30 булш байна. 2-р бүлэг булшнаас доош 300м орчим зайд жалганы баруун талын тэгш дэвсэг газарт мөн л 3 бүлэг болгосон байдалтай зүүн хойноос баруун өмнө тийш цувруулан тавьсан 39 булш байв. Эдгээр булшнуудын хамгийн том нь 12м голчтой бол жижиг нь 3м орчим голчтой юм.

6. Баянборын хүннү булш (N46 13.342 E110 54.448)

Галшар сумын Жаргалант багийн нутаг, сумын төвөөс зүүн урагш 10 орчим км зайд Баянбор хэмээх уул бий. Эл уулын баруун урд энгэрт баруун хойноос зүүн урагш цувруулан тавьсан Хүннүгийн үеийн цагариг хэлбэрийн чулуун дарааст 14 булш байна. Эдгээр булшны хамгийн жижиг нь 2м, том нь 5м голчтой ажээ.

7. Цацын цагаан өндөрийн хүннү булш (N46 21.045 E110 29.852)

Галшар сумын Арвин багийн нутаг, сумын төвөөс баруун хойд зүгт 35км зайд Цацын голын баруун талд Цацын цагаан өндөр хэмээх уулын урд энгэрт Хүннүгийн үеийн цагариг хэлбэрийн чулуун дарааст 8 булш байна. Уг булшнуудын 3 нь их жижиг, 5 нь дундаж хэмжээтэй юм. Жижиг булшны голч 2м орчим бол томынх нь 6м голчтой байна.

8. Ноён уулын хүннү булш (N46 20.840 E109 25.302)

Хэнтий аймгийн Дархан сумын 2-р баг буюу Хараат багийн нутагт, сумын төвөөс баруун өмнө зүгт 40 орчим км, Бор-Өндөр сумаас хойш 12км зайд Ноён, Баян нэртэй 2 уул бий. Зүүн талын уулыг Ноён хэмээх бөгөөд энэ уулын урд энгэрт Хүннүгийн үед холбогдох цагариг хэлбэрийн чулуун дарааст 19 булшийг бүртгэн баримтжуулсан. Эндэхийн булшнууд харьцангуй том хэмжээтэй юм. Бага нь 8м орчим, том нь 12м голчтой байна.

9. Авдар хадны булш (N46 58.315 E110 01.037)

Баянмөнх сумын Дулаан багийн нутаг, сумын төвөөс зүүн зүгт 20км зайд, Баянцогт уулын урд Хэрлэн голын урд эрэг дээр Авдар хад хэмээх дөрвөлжин хад бүхий толгой бий. Энэ хадат толгойн баруун дор тэгш дэвсэг дээр цагариг хэлбэрийн чулуун дараастай 19 булш байна. Эдгээр булшнуудын гадаад хэлбэр нь Хүннүгийн булштай төстэй ч шууд ялгаатай шинжүүд ч ажиглагдсан. Тиймээс бид уг дурсгалыг шууд Хүннүгийн үед холбогдуулах боломжгүй хэмээн үзсэн бөгөөд цаашид судлах шаарлагатай байна. Эндэхийн булшны бага нь 3 м, том нь 9 м орчим голчтой юм.

10. Баянцагаан уулын хүннү булш (N46 52.545 E109 52.623)

Баянмөнх сумын Дулаан багийн нутаг, сумын төвөөс зүүн урд зүгт 20 орчим км зайд байрлах онцгой уулыг Баянцагаан гэнэ. Энэ уулыг нутгийнхан эртнээс тахиж иржээ. Баянцагаан уулаас хойш 3км орчим зайд байх намхан гүвээний урд энгэрт Хүннүгийн үеийн цагариг хэлбэрийн чулуун дараастай 29 булш байна. Эдгээр булшнуудыг 3 бүлэг болгон тавьсан агаад жижиг нь 3м, том нь 7м голчтой ажээ.

11. Ханангийн энгэрийн хүннү булш (N47 03.502 E109 34.237)

Баянмөнх сумын Хэрлэн багийн нутагт, сумын төвөөс хойд зүгт 20 гаруй км зайд, Хэрлэн голын хойд талд Ханан хэмээх уул бий. Энэ уулын урд энгэрт Хүннүгийн үед холбогдох цагариг хэлбэрийн чулуун дараастай 12 булш байна. Эдгээр булшнуудаас 3 нь хойд хэсэгт салангид байдалтай, харин 9 нь нам дор хэсэгт бөөгнөрсөн байдалтай тавигджээ. Булшны бага нь 3м, том нь 8м голчтой байна.

12. Тоонотын хүннү булш (N47 00.593 E109 15.112)

Хэрлэн Тооно уулын баруун урд энгэрт хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүр, Түрэгийн үеийн тахилын байгууламж, Хүннүгийн үеийн булш бүхий дурсгалт газрыг хайгуулын явцад шинээр илрүүлэн бүртгэж, дэвсгэр зургийг үйлдэв. Энд Хүннүгийн үед холбогдох цагариг хэлбэрийн чулуун дарааст 21 булш, 2 хиргисүүр, 1 дөрвөлжин булш, 5 тахилын байгууламжийг бүртгэсэн. Хүннү булшнууд нь 4 бүлэг болж тавигдсан бөгөөд жижиг нь 3м, том нь 10м голчтой байна.

13. Шаширт энгэрийн хүннү булш (N47 00.820 E109 18.208)

Хэрлэн тооно уулын Шаширт аманд уулын энгэр газарт 3 бүлэгт хувааж тавьсан Хүннүгийн үеийн цагариг хэлбэрийн чулуун дарааст 49 булшийг бүртгэж тархацын зургийг үйлдсэн. Эдгээр булшны бага нь 3м, том нь 12м голчтой ажээ.

Хавсралт 1. Дурсгалын тоон үзүүлэлт

Дурсгалт газрын нэр	**Хэмжээ**			**Нийт**
	3-5 м	**5-8 м**	**10 м дээш**	
Авдар хад	6	12	1	**19**
Баянбор	11	1		**12**
Баян овоогийн Өндөр	1	10	9	**20**
Баянцагаан	10	19		**29**
Ноён уул		3	16	**19**
Өлийн даваа	5	3		**8**
Тоонот	5	12	4	**21**
Улаан ханан	16	70	15	**101**
Уртын ам	14	45	39	**98**
Ханангийн энгэр	12	4		**16**
Цацын цагаан өндөр	3	5		**8**
Шанага уул	1	7	1	**9**
Шашир тэнгэр	29	18	2	**49**
Нийт	**113**	**209**	**87**	**409**



1-р зураг. Хэнтий аймгийн нутагт шинээр бүртгэсэн Хүннүгийн булш бүхий дурсгалт газруудын байршил



2-р зураг. Уртын амны хүннү булшны тархацын дэвсгэр зураг



3-р зураг. Өлийн давааны хүннү булшны тархацын дэвсгэр зураг



4-р зураг. Баян-Овоогийн өндөрийн хүннү булшны тархацын зураг



5-р зураг. Шанага уулын хүннү булшны тархацын зураг



6-р зураг. Улаан ханангийн хүннү булшны тархацын зураг



6-р зураг. Улаан ханангийн хүннү булшны тархацын зураг (1-р бүлэг булш)



6-р зураг. Улаан ханангийн хүннү булшны тархацын зураг (2-р бүлэг булш)



6-р зураг. Улаан ханангийн хүннү булшны тархацын зураг (3-р бүлэг булш)



7-р зураг. Баянборын хүннү булшны тархацын зураг



8-р зураг. Цацын цагаан өндөрийн хүннү булшны тархацын зураг



9-р зураг. Ноён уулын хүннү булшны тархацын зураг



10-р зураг. Авдар хадны булшны тархацын зураг

11-р зураг. Баянцагаан уулын хүннү булшны тархацын зураг



12-р зураг. Ханангийн энгэрийн хүннү булшны тархацын зураг



13-р зураг. Тоонотын хүннү булшны тархацын зураг



14-р зураг. Шаширт энгэрийн хүннү булшны тархацын зураг

БИШРЭЛТИЙН-АМНЫ АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮНГЭЭС

Л.Эрдэнэболд, Ч.Ванчигдаш, Ц.Бямба-Очир, З.Одбаяр, Г.Ариунболд

“Туулын хөндийн соёлын өвийн судалгаа” төслийн хүрээнд ШУТИС-ийн Хүмүүнлэгийн Салбарын судлаачид Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дахь Бишрэлтийн-Амны хүннүгийн дурсгалт газарт 2016 оны 7-р сарын 08-аас 22-ны хооронд малтлага судалгааны ажил хийж гүйцэтгэлээ. Тус судалгааны ангийн бүрэлдэхүүнд төслийн ахлагч Л.Эрдэнэболд, судлаач Ч.Ванчигдаш, Д.Хатанбаатар, Ц.Бямба-Очир, С.Бат-Эрдэнэ, З.Одбаяр, Г.Ариунболд нар оролцон ажиллаа.

Тус судалгааны анги 2014 онд“Туулын хөндийн соёлын өвийн судалгаа” төслийн хүрээнд “Бишрэлтийн-Ам”-нд ажиллахдаа дэвсгэр зураг үйлдэж, нэг булшийг малтан судалсан юм. Энэ удаад 6 булш малтан судалсны 1 нь түрэг, 5 нь хүннү булш байв.

Дурсгал 6. Энэ дурсгал нь хойд талын эгнээний баруун талаас дөрөв дэх булш юм. Том чулуугаар дугуйруулан өрж хийсэн цагариг хэлбэрийн дараастай булш. Дараасны голч 8м, өндөр 0.3м. Дараасны төв хэсэгт 2x2.9м хэмжээтэй чулуугүй хэсэг байв. Цэвэрлэгээг 9x9м талбайд хийсэн бөгөөд цэвэрлэгээний явцад ямар нэгэн эд өлөг, тахилгын зүйл гарсангүй. Доош малтахад 0.85м гүнээс хар бараан өнгийн хөрстэй 2.6м голчтой дугуй толбо илэрлээ. 1.1м гүнээс толбоны хэмжээ аясаар нарийсч, азимутийн 90º хэмд чиглэсэн 2.6x1.7м хэмжээтэй болж өөрчлөгдлөө. Толбоны төв хэсэгт цөөн чигжээс чулуу байсныг зайлуулахад чулуун доороос адууны толгойн яс илрэв. Үргэлжлүүлэн малтахад 1.26м гүнээс зүүн тийш хандуулан тэнэгэр байдлаар тавьж, баруун гарыг хэвлий тус газар байрлуулсан анатомийн байрлалаараа байгаа хүний хэлхээ яс, биеийг нь баруун тийш хандуулан толгойг эргүүлж, хошууг нь зүүн зүгт хандуулан хэвтсэн байдалтай тавьсан адууны хэлхээ яс гарч ирэв.

Хүний баруун гарыг дагуулан хоромсого, зүүн ташааны орчимд ясан бэл, баруун гарын бугуйн дээр төмөр гарих, бүсэлхий орчимд хутга маягийн хэлбэртэй ясан эдлэл, хоёр талдаа сур гогцоолдон эргүүлээд бундан хэлбэрийн тавтай хүрэл хадаасаар хадаж тогтоосон хүрэл цагариг, зүүн бугалгын доор хоёр захдаа нүхтэй хавтгай модон эдлэл, будан хэлбэрийн товруугаар чимэглэсэн нарийн суран эдлэл тавьсан байлаа. Хүн адуу хоёрыг тусгаарлан гурван эгнээ боржин чулуун өрж таславч хийжээ. Адууны хошууг таславчны баруун захын чулуун дээр тавьсан байв. Адууны толгойн дороос хос төмөр дөрөө, оршуулгын нүхний баруун хананаас төмөр амгай, чагт, зуузай бололтой тэвх хэлбэрийн ясан эдлэл илэрлээ. Гадаад зохион байгуулалтын хувьд хүннүгийн жирийн иргэдийн булш шиг байх боловч дотоод зохион байгуулалт, оршуулгын зан үйл, эд өлгөөс харвал түрэгийн үед холбогдох дурсгал бололтой байна.

Дурсгал 13. Оршуулгын газрын төв хэсэгт байрлана. Цөөн тооны чулуутай жижиг булш. Цэвэрлэгээний явцад ямар нэгэн тахилын зүйлс, эд өлөг гарсангүй. Малтлагын гүн 0.5м болоход 0.5х1м хэмжээтэй хүрэн бор өнгөтэй толбо илрэлээ. Цааш малтахад 0.7м гүнээс хүүхдийн хохимойн үлдэгдэл, ваарын амсрын хагархай гарав. Түүнээс доош малтахад жижиг чулуун давхарга гарлаа. 1.5м гүнээс чулуун хашлаганы дундаас авсны үлдэгдэл гарч эхлэв. Оршуулгын баруун дээд хэсгээс хонины толгой гарч чулуун хашлаганы дундаас хүүхдийн яснууд эмх замбараагүй гарч ирэв. Оршуулгын толгой хэсэгт хүний ясыг бөөнөөр нь тавьсан байдалтай байв. 1.9м гүнээс байгалийн хөрсөнд тулж малтлагыг зогсоов.

Дурсгал 17. Оршуулгын газрын зүүн урд талаас 3 дахь булш. Том чулууг дугуйруулан өрж хийсэн 0.2м өндөр дараастай. Дараасны голд 1.6х2.6м хэмжээтэй чулуугүй хэсэг байв. Дараасны зүүн урд талын хэсэг харьцангуй их чулуутай. Захын чулуудыг хамруулан 8.4х9м хэмжээтэй талбайд цэвэрлэгээ хийлээ. Цэвэрлэгээний явцад дараасны зүүн урд захаас долгио хээтэй ваарын амсрын хагархай гарав. Дараасны хойд захаас хойш 8.3м зайд зэрэгцүүлэн зоосон 2 ширхэг чулуу байсан нь энэ оршуулгын газарт түгээмэл ажиглагдах 4-8 ширхэг чулууг хос хосоор нь булшны хойд талд зоодог уламжлалын нэг бололтой. Цэвэрлэсний дараа доош малтахад 0.65м гүнээс хүрэн бор өнгийн шороотой, голдоо хэдэн чигжээс чулуутай толбо илэрлээ. Цааш малтахад 0.98м гүнээс 2 дахь үеийн чигжээс чулуу, 1.96м гүнээс 3-р үеийн чигжээс чулууны хамт бог малын эрүү, хавирганы хамт гарч ирэв. Эрт цагт тонуулчдын гарт өртөж ихээхэн сүйдсэн бололтой. Үргэлжлүүлэн малтахад байгалийн хөрсөнд тулсанд малтлагыг зогсоов. Малтлагын эцсийн гүн 2м.

Дурсгал 22. Оршуулгын газрын урд талаар байрлах цуварсан дөрвөн булшны баруун талаас гуравдах булш. Том чулууг дугуйруулан өрж хийсэн дараастай. Дараасны төвд 1.7х2.2м чулуугүй хэсэг байв. Цэвэрлэгээ хийсний дараагаар хэмжихэд чулуун дараасны голч 7.5м байлаа. Дараас чулуу газрын уруу тал болох зүүн талдаа харьцангуй нягт болох нь ажиглагдаж байв. Малтлагын гүн 0.65м болоход 1.97х1.39м хүрэн бор өнгийн толбо илэрснийг дагуулан малтахад 1.55м гүнээс эхлээд 2.22м гүн хүртэл чигжээс чулуун үргэлжлэн гарч байлаа.

1.85 м гүнд болоход толбоны хэмжээ аясаар өөрчлөгдөж 1.38х1.97м болов. Үргэлжлүүлэн малтахад 2.38м гүнээс бугалгын яс, цааш малтахад 2.48м гүнээс авсны таг илэрч улмаар 2.6м гүнээс банзан австай тонуулчдын гарт өртөж ихээхэн сүйдсэн оршуулга илэрлээ. Авсны урт 130см, авсны толгой, хөл тал ижилхэн 30см өргөнтэй. Авсан дотор анатомийнхоо байрлалаа бүрэн алдсан хүний араг хэлхээ яс, авсны хөл хэсгээс ясан савны хагархай гарлаа. Мөн авсны толгой талд 0.5х0.4м хэмжээтэй хөө үнс бүхий тахилгын хэсэгт жижгэвтэр вааран тогоо, бутан ваар, хонины сээр, төмөр гархи, 4 ширхэг хавирга, баруун хойд талд хос ясан эдлэл, төмөр гархи, сумны зэв 3 ширхэг тавьжээ. Малтлагын эцсийн гүн 2.5м.

Дурсгал 28. Оршуулгын газрын баруун хойд захад тусгайдуу орших зэрэгцээ хоёр булшны зүүн урд байрлах багавтар булш. Хөрсөн дээр цөөн тооны чулуугаар дан эгнээгээр дугуйруулан өрж хийсэн цагариг хэлбэрийн дараас ажиглагдаж байсныг цэвэрлэж үзэхэд нэлээд олон чулууг дугуйруулан өрж хийсэн цагариг хэлбэрийн намхан дараастай булш болох нь мэдэгдлээ. Дараасны голч 6м бөгөөд баруун хойд тал сийрэг, зүүн урд тал харьцангуй шигүү, олон чулуутай ажээ. Дараасны төв хэсэгт 2.7х3.3м хэмжээтэй чулуугүй хэсэг байв. Малтлагын гүн 0.65м болоход голдоо чигжээс чулуу бүхий 1.85х2.6м хэмжээтэй бараан өнгийн шороотой толбо илрэв. Цааш малтахад 0.98м гүнээс хоёрдугаар үеийн чигжээс чулуу, 1.9м гүнээс гуравдугаар үеийн чигжээс чулуу тус тус гарлаа. Малтлагын гүн 2.5м болоход том чулуудыг босгон давхарлаж, оршуулгын нүхийг доторлох маягтай налуулан босгож өрсөн чулуун хашлаганы дотор талд маш муу хадгалагдсан модон авсны ором мэдэгдэж байв. Авсны зүүн талын ханыг 20см өргөнтэй хоёр банзыг зэрэгцүүлэн углуургадаж хийжээ. Хөл талыг гурван нарын шургааг давхарлан хийсэн байна. Тагийг нарийн шургаагуудыг хөндлөнгөөр нь эгнүүлэн өрж хийсэн болох нь авсны модны ормоос ажиглагдаж байлаа. Богийн баруун эрүү, гаднаа хөөтэй ваарын бөөрний 3 ширхэг хагархай, ёроолын 1 ширхэг хагархай, бодын 1 ширхэг шүд, хүний 1 ширхэг хавирга, тахилзуурын 1 ширхэг, богийн хавирга 1 ширхэг, хүний хөлийн хуруун 1 ширхэг үе гарав. Доош малтахад байгалийн хөрсөнд тулж малтлагыг зогсоов. Малтлагын эцсийн гүн 2м.

Дурсгал 29. Энэ булш нь оршуулгын газрын баруун урд захад байрлана. Дугуйвтар хэлбэрийн дараас ажиглагдаж байсан ч гадны нөлөөллөөр зөөгдсөн бололтой хэлбэр, хэмжээ нь тодорхой мэдэгдэхгүй болсон байлаа. Захын чулуудыг хамруулан цэвэрлэгээ хийсний дараа үзэхэд зүүн талаараа шигүү чулуутай, дугуй хэлбэрийн дараастай, дараасны голч 6 м болох нь мэдэгдлээ. Малтлагын гүн 0.53м хүрэхэд 0.98х1.67м хэмжээтэй голдоо ганц чигжээс чулуутай хүрэн бор өнгийн толбо илэрснийг дагуулан малтахад 0.97м гүнд 0.53х1.23м хэмжээтэй жижиг хашлага чулуу илэрч цааш малтахад 1.24м гүнээс хашлага бүрэн ил гарч ирэв. Хашлаганы хойд хагасаас хүний 5 ширхэг хавирга, зүүн сүүжний далбай яс, сарвууны 3 ширхэг үе, нуруу, аман хүзүүний нугалмын хугархай гарлаа. Хашлаганы ёроолд хавтгай чулуу тавьж шалласан байв. Хашлаганы гадна толгой талд ямааны толгой, мөн шийрний үе 8 ширхэг гарч ирэв. Малтлагын эцсийн гүн 1.3м

Түрэгийн үеийн нэг булшнаас насанд хүрсэн эрэгтэй хүнийг зэр зэвсгийн хамт тавьсан байлаа. Тус булшийг хүннүгийн булшны дунд гадаад зохион байгуулалтын хувьд хүннүгийн жирийн иргэний булштай төстэйгөөр үйлдсэн нь нууцлалын зорилготой байх талтай байна. Хүннүгийн үед холбогдох 5 булш малтан судалсан. Эдгээр булшны 4-өөс нь хүний оршуулга илэрсний 2 нь насанд хүрсэн хүнийх, 2 нь хүүхдийн оршуулга, 1 нь хоосон булш байлаа.

Тус судалгааны анги төлөвлөсөн хугацаандаа зорьсон зорилгоо биелүүлж, малтан судалсан булшаа буцаан булж, урьдчилсан тайлангаа орон нутагт хүлээлгэн өгсөн болно.

Хавсралт



Бишрэлтийн-Ам Хүннүгийн дурсгалт газар

Дурсгал - 6

Дурсгал - 13

Дурсгал - 17

Дурсгал - 22

Дурсгал - 28

Дурсгал - 29

ШУВУУТАЙН ХЭРЭМ ХЭМЭЭХ ДУРСГАЛД ШИНЭЭР ХИЙСЭН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

Г.Эрэгзэн

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Хүннү, Эртний түүхийн салбарын судлаачид 2013-2016 онд ШУТС-ын санхүүжилтээр "Хүннүгийн археологийн судалгаа" суурь судалгааны сэдэвт ажлыг хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд олон талт судалгаа, шинжилгээний ажил хийгдсний нэг нь Хүннүгийн үеийн хот суурины дурсгалт газрын судалгаа юм.

Одоогоор Монгол нутгаас Хүннүгийн үед холбогдох 16 хот суурин газрын үлдэгдэл болох дурсгал илэрсэн байна. Эдгээр дурсгалуудаас сүүлийн жилүүдэд Гуа дов, Тэрэлжийн дөрвөлжин, Бороогийн суурин, Талын гурван хэрэм, Дов дэрс, Барс хот-II, Баянбулагийн турь зэрэг дурсгалт газарт малтлага судалгаа хийгдэж үр дүнгийн талаарх мэдээллүүд хэвлэгдэн судлаачдын хүртээл болсоор байна.

Харин Шувуутайн хэрэм, Цэнхэрийн голын хэрэм гэх мэт хэдэн хэрэмт хотуудын үлдэгдэлд нэмэлт судалгааны ажил хийгдээгүй өдий хүрчээ. Эдгээр хотын дурсгалуудыг анх Х.Пэрлээ агсан үзэж, Хүннүгийн үед холбогдох боломжтой хэмээн таамагласан байдаг. Гэвч тухайн үед Х.Пэрлээ агсан дурдан буй дурсгалт газруудад бага хэмжээний сорил малтлага хийсэн боловч дурсгалын он цагийг нарийвчлан тодруулах хэрэглэгдэхүүн илрүүлж чадаагүй ба зөвхөн хэрмийн бүтэц зохион байгуулалтын зарим шинжүүдэд тулгуурлан "Хүннүгийн үе"-д холбогдох боломжтой хэмээх таамаглалийг дэвшүүлсэн ажээ.

Түүнээс хойш эдгээр дурсгалуудыг дийлэнх судлаачид Хүннүгийн үеийн хот суурин хэмээн бичиж ирсэн боловч доривтой нэмэлт судалгааны ажил хийгдээгүй тул холбогдох он цагийг батлах баримт нэмэгдээгүй өнөөг хүрсэн байна.Тиймээс зохиогч дурдан буй дурсгалуудад нэмэлт судалгаа хийж, холбогдох он цагийг баталгаажуулах шаардлагатай хэмээн үзсэн бөгөөд энэ удаа цаг хугацаа, хөрөнгө санхүүгийн боломжоос шалтгаалан Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Шувуутайн хэрмийг сонгон авч судалгаа хийхээр тогтсон юм.

Шувуутайн хэрэмд ажилласан баг нь зохиогчоос гадна тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С.Хантөгс, топографийн мэрэгжилтэн Д.Нямхүү, МУИС-ын Археологи-антропологийн тэнхим, Улаанбаатарын Их сургуулийн Археологийн тэнхимийн төгсөгчид болох Батбаяр, Алтаннаран, Дащдорж, Амгаланбаатар, Буян-Орших, нарын 6 туслах ажилтан, 3 жолооч, 1 тогоочийн бүрэлдэхүүнтэйгээр 2016 оны 10-р сарын 15-наас 22-ны өдөр хүртэл 7 хоногийн хугацаанд судалгаа хийсэн.

Энэ удаад цаг хугацаа давчуу байснаас бид дурсгалт газрын агаарын зургийг авч, топографийн зураглал хийсэн ба төв барилгын зүүн хойд булан болон хэрмийн

хойд хана зэрэг 2 газарт жижиг сорил малтлага хийсэн. Мөн ойр орчимд хайгуул судалгаа хийж зарим нэг дурсгалуудыг бүртгэн баримтжуулсан юм.

1. Шувуутайн хэрэм хэмээх дурсгалын байршил, судлагдсан байдал

Энэ дурсгал нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт, сумын төвөөс хойш 20 орчим км зайд, Баянхангай хэмээх Орхон голд цутгах Шувуутайн гол, Ангирын гол, Ямаатын гол гэсэн 3 жижиг гол бүхий уужим хөндийд оршино. Дурсгал нь Ангиртын голын хойд эрэгт байрлах бөгөөд нутгийн иргэд "Балгасан толгой" хэмээн нэрлэх ажээ. Харин археологийн ном зохиолд "Шувуутайн хэрэм" нэрээр бичиж хэвшжээ.

Дурсгал байрлах газар нь Ангиртын голын хойд эргийн нам дор хэсэг бөгөөд чанх хойд талд нь 5км зайд Баянхангай хэмээх сүрлэг өндөр уултай, зүүн талд нь Эрдэнэ уул хэмээх хойноос өмнө тийш сунаж тогтсон намхавтар уул байна. Харин өмнө тал, баруун хойд тал нь Баянхангайн хөндий тул задгай, баруун өмнө талд нь холгүйхэн зайд Ангиртын гол урсана. Ангиртын гол Маадай үзүүр хэмээх хойш намссан жижиг хошууны зүүн талаар урсаж, хойгуур нь ороон Шувуутайн голд цутгана. Энэ хэсэгт Шувуут хэмээх хойноос өмнө тийш бага зэрэг сунаж тогтсон цавчим өндөр уул 2 голын дундах тэгш нуга газарт ганцаар сондгойрон орших бөгөөд энэ уулын зүүн талаар урсах жижиг голыг Ямаат, баруугаар урсах голыг Шувуут хэмээнэ. Ямаат, Шувуут 2 гол Шувуут уулын ард холгүйхэн газарт гурвалжин арал үүсгэн нийлнэ. Шувуутайн голын баруун талын эрэг нь хэсэг газар өвс ургамал сайтай нуга бол түүний баруун талаар нь үргэлждээ намхан ч биш, өндөр ч биш урт гүвээ хүрээлэн тогтжээ. Энэ гүвээний доод хэсгийг Цагаан бумбын хошуу, дээд хэсгийг Цохио хэмээнэ. Шувуутайн гол нь хойш урсаж Баянхангай уулын баруугаар өнгөрөн 20км орчим урсаад Орхон голд цутгадаг ажээ. Баянхангайн хөндий нь олон гол горхитой үржил шимтэй хөрстэй тул тариа тарьж болох газруудыг нийтэд нь хагалж улаан буудай, арабис зэргийг тариалсан байна. Ерөнхийдөө дурсгал байрлах жижиг талбайг л үлдээж, бусад хэсгүүдийг хагалжээ.

Дурсгалын зүүн талаар 30 орчим метр зайд авто зам өнгөрөх бөгөөд энэ нь сумаас аймгийн төвийг зорих төв зам ажээ. Мөн дурсгалын зүүн хойно төв замд нийлэх нэгэн зам буй нь Заамар сумаас Булган хотыг чиглэх гол замын нэг ажээ.

Шувуутайн хэрмийг Х.Пэрлээ агсан 1954 онд ажлын далимд үзэж, хэмжиж тодорхойлолт хийжээ. Түүний хэмжснээр хэрэм нь өмнөд хана 225м, баруун хана 193м, зүүн хана 187м, хойд хана 265м байсан ба төв барилгын ором нь 30х40м хэмжээтэй байна. Мөн тэрээр хэрмийг 4 талдаа хаалгатай байсан бололтой. Бүтэц, хэлбэр нь Тэрэлжийн дөрвөлжинтэй зарим талаар төстэй, их хулширсан зэргээс үзэхэд Хүннүгийн үеийнх болов уу хэмээн таамагласан байдаг[1].

---

[1] *Х.Пэрлээ. Монгол Ард Улсын Эрт, Дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961 //Бүтээлийн чуулган I боть, УБ., 2012, тал 165.*

Х.Пэрлээ агсан Шувуутайн хэрэмд сорил малтлага хийсэн талаар огт дурдаагүй байна. Гэтэл биднийг очиход төв барилгын хойд талд төвийг дайруулсан байдлаар 6х5м орчим хэмжээтэй сорил малтлага хийсэн хулширсан ором байсан бөгөөд үүнээс үзэхэд хэрмийг хожим нэмж судлах ажил хийгдсэн бололтой. Гэвч энэ талаар ямар нэгэн тэмдэглэл үлдээгүй байна.

2. Шувуутайн хэрэмд шинээр хийсэн сорил малтлагын тухай

Дурсгалт газарт шинээр судалгаа хийж буй зорилго нь бүтэц, зохион байгуулалтыг нарийвчлан тодруулж топографийн зураг хийх, агаарын зургийн баримтжуулалт хийх, он цаг тогтоох биет хэрэглэгдэхүүн цуглуулах явдал байсан. Тиймээс эхний ээлжинд дурсгалын топографийн зураг хийсэн бөгөөд энэ хэмжилт судалгааны үр дүнд хэрмийн ерөнхий бүтэц, хэмжээ зэрэг тодорхой болсон. Хэрмийн талууд ертөнцийн зүгийг баримтласан бус, зүүн тийш бага зэрэг жишүү баригджээ. Дөрвөлжин хэлбэрийн шороо дагтаршуулан дэлдэж хийсэн хэрмийн үлдэгдэл тод ялгарч мэдэгдэж байна. Хойд, өмнөд хана ялимгүй урт, зүүн баруун хана бага зэрэг богино юм. Хойд хана 225м, өмнөд хана 235м, зүүн хана 180м, баруун хана 190м хэмжээтэй байв. Хэрмийн зүүн, өмнөд, хойд 3 талд хаалганы ором мэдэгдэх ба баруун хананд хаалга гэхээр тод ором мэдэгдсэнгүй. Хэрмийн хана 1м орчим өндөртэй үлдсэн ба өргөн нь 5-6м орчим байна. Хэрмийн хананы гадна талаар ус зайлуулах шуудуу мэдэгдэнэ. Шуудуу нь их өргөн бус 1.5м орчим өргөн ажээ. Зарим хэсэгт шуудуу мэдэгдэхгүй болжээ (Дурсгалын дэвсгэр зурагт шуудуу, хаалганы ором зэргийг тодорхой тэмдэглэсэн тул илүү дэлгэрэнгүй тайлбарласангүй).

Хэрмийн төвөөс бага зэрэг баруун хойно төв барилгын ором болох 3 м орчим өндөртэй дөрвөлжин хэлбэрийн шороон овгор байна. Уг барилгын ором нь 30х40м орчим хэмжээтэй юм. Үүнээс өөр барилгын ором хэрэм дотор мэдэгдэхгүй бөгөөд төв барилгын зүүн хойд булангаас хэрмийн хойд хана хүртэл үргэлжилсэн 1.3м орчим өргөн, 0.7м орчим өндөр шороон гүвгэр мэдэгдэх агаад энэ нь дотоод хэрмийн ханын үлдэгдэл бололтой.

Бид төв барилгын хэлбэр, бүтцийг мэдэх, хэрмийн бүтцийг ойлгох зорилгоор төв барилгын зүүн хойд буланд 6м урт, 2м өргөнтэй 2 сорил малтлага, хэрмийн хойд хананы дунд хирд хаалга байж магадгүй хэмээн таамагласан хэсгээс баруун тийш 2м зайд мөн 6м урт, 2м өргөнтэй сорил малтлагыг хийсэн.

Төв барилгын зүүн хойд буланд хийсэн сорил малтлагын үр дүнд барилгын ханын үлдэгдэл бололтой түүхий тоосго хэд хэдийг илрүүлсэн ба уг барилгыг анх 30см орчим зузаан дэлдэж дагтаршуулсан шороон тавцан дээр барьсан болохыг ажиглаж болохоор байв. Сорил малтлага хийх явцад өнгөн хөрсийг хуулахад их хэмжээний малын ясны үлдэгдэл илэрсэн ба 1 ш шавар ваарны хагархай олдов. Гэвч

эдгээр нь өнгөн хөрст давхаргаас илэрсэн тул дурсгалын он цагийг тогтооход эрсдэлтэй хэрэглэгдэхүүн болно.

Барилгын зүүн хойд буланд хийсэн зэрэгцээ 2 сорил малтлагын сувгаас түүхий тоосгот үе, дагтаршуулсан үе зэрэг зарим нэг анхаарал татахуйц хэрэглэгдэхүүн илэрсэн хэдий ч малтлагын талбай хэт жижиг байсан тул барилгын бүтцийг бүрэн тодорхойлоход хүндрэлтэй байна.

Хэрмийн хойд ханыг хөндлөн огтолсон байдлаар 6м урт, 2м өргөн суваг татаж малтлага хийсэн. Энэ малтлагын явцад хэрмийн гадна талаас ус зайлуулах шуудуу илэрсэн ба хэрмийн хананы гадна талын хэсэг нилээд тодорхой мэдэгдсэн.Тиймээс энэ сувгийн үргэлжлэл болгон хэрмийн дотор тал руу орсон байдлаар 7.5м урт, 2м өргөнтэй 1 суваг, анхны суваг болон нэмж татсан сувагтай зэрэгцүүлэн зүүн талд нь 2.5м урт, 2м өргөнтэй 2 жижиг суваг малтсан. Эдгээр сорил малтлагын үр дүнд хэрмийг анх 20см орчим зузаантай дагтаршуулсан өргөн зурвасын төвд 1.5 м өргөн, 1.2м өндөртэйгээр шавар шороог үелүүлэн дагтаршуулж барьсан нь мэдэгдсэн. Шавар, шороог дагтаршуулахдаа модон баганууд ашигласан ба хожим нь уг багануудыг суга татаж авсан оромнууд мэдэгдэж байв. Хэрмийн гадна 2м зайд 1.4м өргөн, 2м гүнзгий ус зайлуулах шуудуу байжээ. Бид сорил малтлагын талбайд орсон ийм шуудууны хэсгийг ёроолд нь хүртэл малтаж цэвэрлэж үзсэн юм. Шуудуу их нарийхан, мөн их гүнзгий биш тул бороо, үеэрийн уснаас л хамгаалах зориулалттай хийгдсэн бололтой байна. Хэрмийн хэсэгт хийсэн сорил малтлагын явцад өнгөн хөрст давхаргаас мал, амьтны яс их олон тоотой илэрсэн. Эдгээр нь дурсгалын он цаг тогтооход эрсдэлтэй тул зөвхөн гэрэл зургаар баримтжуулж, буцааж булсан. Харин 7.5м урттай сувгийн шалны хэсгээс бог малын ясны үлдэгдэл, 2.5м урттай сувгийн ёроол хэсгээс шавар ваарны хагархайгаар хийсэн ээрүүлийн дугуй зэрэг зүйлс олдсон. Эдгээрээс малын ясыг гадны лабораторид он цаг тогтоохоор илгээсэн. Ээрүүлийн дугуйн хувьд Хүннүгийн ваартай огт төсгүй байна.

Энэ удаад Шувуутайн хэрэм хэмээх дурсгалт газарт хийгдсэн судалгаа нь хэрмийг нарийвчлан хэмжиж топографийн зураг хийсэн, мөн агаарын зургийн баримтжуулалт хийсэн зэргээр ач холбогдолтой ажил болсон. Түүнчлэн хэдэн сорил малтлагын явцад барилгын ерөнхий бүтэц, хэрмийн бүтэц зэргийг таамаглаж болохуйц хэрэглэгдэхүүн цуглуулсан хэмээн бодож байна. Сорил малтлагаас илэрсэн ээрүүлийн дугуйг ажиглахад уг олдвор Хүннүгийн үеийнх биш болох нь тодорхой байна. Гэвч энэ олдвортой харьцуулан үзэх хэрэглэгдэхүүнийг бид хараахан олж үзэж амжсангүй. Сорил малтлагын явцад шалны хэсгээс илэрсэн малын ясыг он цаг тогтоох шинжилгээнд явуулсан бөгөөд уг дээжийн хариунд ихээхэн найдлага тавьж байна.

3. Шувуутайн хэрэм орчмын бусад дурсгалууд

Шувуутайн гол, Баянхангайн хөндийд археологийн дурсгалууд элбэг ажээ. Шувуутайн хэрмээс хойд зүгт 10км зайд Зараа толгой хэмээх хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр, дөрвөлжин булш олон тоотой тархсан дурсгалт газарт бий. Мөн хойд зүгт 4км орчим зайд Баянхангай уулын баруун өмнөд бэлд Манзуширын хийд хэмээх хийдийн туурь байна. Шувуутайн голын эхэнд Байшин толгой хэмээх дурсгал байрлах бөгөөд уг дурсгалыг Монгол-Хятадын хамтарсан шинжилгээний анги малтан судалжээ.

Шувуут уулын зүүн хажуугийн үелэсэн дэвсэг газарт олон тооны хиргисүүр тархжээ. Энд онцлууштай дурсгал нь Шувуут уулын зүүн өмнөд үзүүрийн гүехэн гуу бүхий бага зэрэг хэвгий газарт Хүннүгийн үеийн цагариг хэлбэрийн чулуун дараастай59 булш тархжээ. Эдгээр булшнуудыг өмнө нь илрүүлж тоолж бүртгэсэн байна. Бид тархацын дэвсгэр зургийг үйлдсэн юм. Булшнууд ерөнхийдөө газрын хэвгийг даган баруун хойноос зүүн өмнө тийш жалганы 2 талаар тархсан байна (Тархацын зураг үзнэ үү). Эдгээр булшнуудын бага нь 3м, хамгийн том нь 9м хэмжээтэй юм.



Зураг 1. Шувуутайн хэрмийн дэвсгэр зураг

Зураг 2. Шувуутайн хэрмийн агаарын зураг (чанх дээрээс)

Зураг 3. Шувуутайн хэрмийн агаарын зураг (хойноос)



Зураг 4. Шувуут уулын Хүннүгийн булшнуудын тархацын зураг

Зураг 5. Шувуут уулын Хүннү булш бүхий дурсгалт газар

ЧИХЭРТИЙН ЗОО ХЭМЭЭХ ХҮННҮГИЙН ОРШУУЛГЫН ДУРСГАЛТ ГАЗАРТ ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Г.Эрэгзэн, П.Алдармөнх, С.Энхболд

Төв аймгийн Баянцагаан сумын нутагт, сумын төвөөс өмнө зүгт 12км зайд Чихэртийн зоо хэмээх дурсгалт газар оршино. Дурсгалт газрыг анх 2013 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид археологийн авран хамгаалах хайгуул судалгааны үед илрүүлж бүртгэсэн байна.

Энэ дурсгалт газар нь говь, тал хээрийн заагт орших бөгөөд нэг дор маш олноор тархсан Хүннүгийн цагариг хэлбэрийн чулуун дарааст булшнууд юм. Эндэхийн булшны нэг онцлог нь ихэнх нь харьцангуй том хэмжээтэй ажээ.

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн нь БНСУ-ын Төвийн бүсийн Соёлын өвийн судалгааны хүрээлэн, Чүнбукын Их сургууль зэрэг байгууллагуудтай хамтран "Монгол-Солонгосын соёлын өвийн судалгаа, шинжилгээ" төслийг хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд 2016 онд Чихэртийн зоо хэмээх дурсгалт газарт судалгаа хийв.

Бид дурсгалт газрын тархацын дэвсгэр зургийг үйлдэж, нийт 287 булш бүртгэсэн бөгөөд эдгээрээс дунд хэсэгт хамаарах бүлэг булшнаас зэрэгцээ 2 булшийг сонгон малтлага хийсэн.

Малтлага судалгаа

1-р булш. Ойролцоох булшнуудаас хэмжээгээр том, цагариг хэлбэрийн чулуун дараастай. Өнгөн хөрсөн дээр ил харагдах байдлаар баримжаалахад голч нь 17м байв. Энэ нь Хүннүгийн цагариг хэлбэрийн дараастай булшнуудтай харьцуулахад томд тооцогдох юм. Чулуун дараасыг багтаан 20x20м талбайгаар өнгөн хөрсний цэвэрлэгээ хийн, талбайн төвийг дайруулан булшны (дотоод зохион байгуулалт) зүсэлтийн зураг үйлдэх зорилгоор 50см хөндлөн хамар үлдээж цэвэрлэв. Өнгөн хөрсний цэвэрлэгээний дараа дараас чулууг дахин хэмжиж үзэхэд хойноос урагш 16.8м, баруунаас зүүн тийш 17.1м орчим байв. Дараас нь голдоо чулуугүй цагариг хэлбэртэй, баруун зүүн талаараа сийрэг ба урд талдаа илүү бөөгнөрчээ.

Малтлагын гүн өнгөн хөрснөөс доош 7.5 метр орчимд баруун хойд булангаас модны үлдэгдэл илэрсэн. Модны үлдэгдлийг цэвэрлэхэд босоо байдалтай 0.9 м орчим урт, өргөн хэсэгтээ 0.2м орчим нимгэн банз байв. Нүхний ёроолыг мод гарсан түвшинд тэгшлэх явцад урд хана талаас галт уулын улаан хүрэн өнгийн хүрмэн чулууг зориуд хагалж 3-5см орчим жигд хэмжээтэй болгон бутласан чулуун чигжээс болон хашлагын хана модны хэсэг цухуйж эхэлсэн. Жижиглэсэн хүрмэн чулуун чигжээс нь дүнзээр хийсэн хашлагын гадна талаар чигжсэн байдалтай байв.

Дүнзэн хашлагын дотор талд цэвэрлэхэд авсны ул мөр мэдэгдээгүй. Хашлагын таг банзнууд зөвхөн зүүн талд хэсэг газарт л үлдсэн агаад төв хэсгээр нумран хотойж шалтайгаа нийлжээ. Тагны үлдэгдлийг цэвэрлэх явцад ойр орчмоос нь жижиг чулуун сувснууд, өргөн талд нь нүхэлсэн соёо хэлбэрийн хаш зүүлт, трапец хэлбэрийн гартаамын төрлийн чулуун зүүлт зэрэг олдворууд илэрсэн.

Дүнзэн хашлага доторхийг тонуулчид нийтэд нь бусниулж, хэрэгтэй зүйлээ авч явжээ. Хашлагын толгой талаас хүний яс болон ваарны хагархайнууд эмх замбараагүй нэг дор овоорсон байдалтай илэрсэн. Эндээс хоёр төрлийн ваарны хагархай болон гавлын яс, хавирга, бугалга, шууны яс, сүүж зэрэг хүний ихэнх яснууд гарсан бөгөөд мөн дунд мөчний яс 3 гарсан нь дээрээс гарсантай нийлээд дөрөв болж байгаа нь сонирхол татаж байгаа юм. Эндээс үзэхэд уг булшинд 2 хүнийг оршуулсан бололтой. Хүний ясны хэмжилтээс үзэхэд эрэгтэй, эмэгтэй хүнийг оршуулжээ.

Мөн урд талын хана болон булан хэсгийг цэвэрлэх явцад байгалын хөрсөн дээр булшны нүхны хэлбэрийг гаргахдаа хэрэглэж байсан багажны ул мөр тод үлдсэн байв. Багажны мөрнөөс үзэхэд нэг тал нь 1.0см нөгөө тал нь 0.5см өргөн хоёр хэлбэр зонхилж байсан нь хоёр мөртэй зээтүү маягийн багаж байсан байх магадлалтай юм.

Хашлагын гадна талаар чигжсэн чигжээс чулууг зайлуулан хашлагын сайн хадгалагдсан булангийн хэсгүүдийг хэмжихэд ойролцоогоор 0.95м байсан бөгөөд шал хэсэгт байгалын хөрсөн дээр нарийн ширхэгтэй элс дэвссэн байсан нь мэдэгдэж байна. Дүнзэн хашлагын баруун талаас төмөр эдлэлийн үлдэгдэл болон төмөр цагариг, төмөр амгай зуузайны үлдэгдэл цуварсан байдалтай гарсан юм.

Өнгөн хөрсөөс доош 9.0м хүрэхэд байгалын хөрсөнд хүрч малтлагыг зогсоосон.

2-р булш. Өмнөхбулшнаас зүүн тийш 13 метрийн зайд байрлана. Цагариг хэлбэрийн чулуун дараастай ажээ.Уг булшны өнгөн хөрсөн дээр ил харагдах дараас чулууны хэмжээ 7.9х7.2м байсан. Бид дараас чулууг бүгдийг багтаан 13х12м-ийн хэмжээгээр талбай авч өнгөн хөрсийг хуулж цэвэрлэсэн ба төвийг дайруулан 50 см-ийн хэмжээтэй нэмэх тэмдэг хэлбэрт хамар үлдээсэн.

Хамар үлдээн доош малтах явцад 1м орчим гүнд нүхний толбо (толбоны хэмжээ 4,1х4,70м) гэхээр хүрэн шаргал өнгийн хөрс голын чулуугүй хэсгээр ялгарч харагдаж байсан. Малтлагын гүн 1.5м хүрэхэд нүхний толбо багасаж 4.5х4м хэмжээтэй болсон.

Голын хөндлөн хамарыг авах явцад талбайн төвөөс бог малын толгойн яс мөн талбайн хойд талаас бог малын чөмөгний яс тус тус гарсан.

Малтлагын гүн 4 метр хүрэхэд нүхний хэмжээ 3.4х1.7м болж багассан ба зүүн хойш чиглэлтэй нүх болох нь тодорхой болсон. Малтлагын гүн 4.8м болоход нүхний хойд хананаас урагш 0.4м зайд модон эдлэлийн үлдэгдэл, чий будагтай савны ёроол тус тус илэрч олдсон.

Малтлагыг үргэлжлүүлэх явцад нүхний толгой тал (хойд тал) буюу чий будагтай сав, модон эдлэл зэрэг олдвор гарсан газраас байгалын ургаа хад гарсан мөн нүхний зүүн урд, урд хананаас дээрхитэй адил ургаа хад гарсан нь ихээхэн сонирхол татахуйц зүйл байлаа. Малтлагын гүн 5.1 метр хүрэхэд нийт талбайгаар зэвэрсэн төмөр эдлэлийн үлдэгдэл, бод, бог малын яснууд, нүхний баруун хойд талаас хүний гавлын яс, нүхний зүүн хойд талын булангаас нүүрэн талдаа чонын дүрст хазаарын хүрэл товруу 4 ширхэг, сагалдрагааны үзүүрийн дугтуй 1 ширхэг, дугуй хэлбэрийн товгор хээтэй хазаарын товруу 1 ширхэг тус тус илэрсэн. Өнгөн хөрсөөс доош 5.5м хүрэхэд байгалын хөрсөнд тулсан.



Зураг 1. Чихэртийн зоо хэмээх Хүннүгийн булш оршуулгын дурсгалт газрын тархацын дэвсгэр зураг



Зураг 2. 1-р булшны дараас чулуу өнгөн хөрсийг цэвэрлэсний дараа



Зураг 3. Модон хашлагын банз

Зураг 4. Дүнзэн хашлага ба чигжээс чулуу

Зураг 5. Сувс илэрч буй байдал

Зураг 6. Хүний ясны илэрсэн байдал

Зураг 7. Булшны нүхийг ухсан багажны ул мөр

Зураг 8. Булшны нүхний шал хэсэг

Зураг 9. 2-р булшны чулуун дараасыг цэвэрлэсний дараа

Зураг 10. Малтлагын явцын зураг

Зураг 11. Чий будагтай савны үлдэгдэл

Зураг 12. 2-р булшнаас илэрсэн хүрэл эдлэлүүд

МОНГОЛ, БНХАУ-ын ХАМТАРСАН АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ 2016 ОНЫ ТОВЧ ҮР ДҮН

А. Очир, Б. Анхбаяр, Ж. Цамбагарав
Чэн Ёнжи, Ч. Саранбилэг, Чен Пэнфэй

Монгол-Хятадын хамтарсан “Монгол улсын нутаг дахь нүүдлийн соёл иргэншлийн талаарх археологийн хайгуул малтлага судалгаа-3” төслийн хээрийн шинжилгээний анги Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт Талын гурван хэрмэнд 2014 оноос ажиллаж байгаа билээ. 2016 онд Баруун хэрмийн зүүн үүд, шороон гүвгэр, Дунд хэрмийн 1-р байгууламж, 3-р байгууламж, Өндөр улааны дурсгалд малтлага явууллаа. Малтлага судалгаанд Талын гурван хэрмийн зохион байгуулалтын бүрэлдэхүүн болгоноос төлөөлүүлэн оролцуулснаас гадна, Талын гурван хэрмийн баруун этгээдэд шинээр илрүүлсэн Өндөр улааны дурсгалд малтлага хийлээ.

Баруун хэрмийн судалгаа

Шороон гүвгэрийн малтлага. Гурван хэрэм бүрийн төвд буй том шороон овгор түүний өмнө зүгт холгүй орших жижиг шороон овгорыг холбосон шороон гүвгэр бий. Түүний хэлбэр, хэмжээ, үүрэг зориулалтыг ямар нэгэн хэмжээгээр тодруулах шаардлагатай байсан тул Баруун хэрмийн шороон гүвгэрийг сонгон авч жижиг малтлага хийлээ. Малтлагын дүнд 2 эгнээ зэрэгцүүлсэн олон нүх ухаж модон шон зоогоод, түүнийгээ модон хашлагаар холбож, тэр зайнд зориуд зөөвөрлөн авчирсан улаан шаварыг 3м өргөн асган үйлджээ. Шороон гүвгэрийн урттай харгуулж тооцвол ойролцоогоор 42 модон шон байжээ. Уг шороон гүвгэр хэрмийн төвд байгуулсан шороон байгууламжуудыг холбосон зам бололтой.

Хэрмийн үүдний малтлага. Аливаа хот суурины үүд нь олон мэдээлэлийг агуулдаг тул харьцангуй хадгалалт сайтай баруун хэрмийн зүүн үүдийг сонгон малтлаа. Малтлагыг хэрмийн үүдийг бүхэлд нь багтаасан тигт оруулаад бүх талбайгаар нь өнгөн хөрсийг цэвэрлэсний дараа өмнө талын дотор хэсэг, хойд талын гадна хэсгийн талбайг үргэлжлүүлэн малтав.

Өмнө талын дотор хэсгийн (EG1) малтлага. Бор, саарал өнгийн шороог овоолж үйлдсэн хэрмийн үүдний дэргэдээс 9 нүх мэдэгдэв. Тэдгээрийн 4 нь том бөгөөд гүн, ёроолдоо зориуд чулуу суулгасан бол үлдсэн 5 нүх жижиг аж.

Хойд талын гадна хэсгийн (EGN 2) малтлага. Үүдийг тойруулсан 3 нүх илэрсэн байна. Тэдгээр нь хэмжээний хувьд ойролцоо бөгөөд заримд нь мод үлдсэн байлаа.

Хэрмийн үүдийг шуудуунаас гаргасан шороогоор үйлдсэн, нийт 8м орчим урт, 5м зузаан, 1,4-1,6м өндөр хэмжээтэй, дундаа 5м зайтай гулдан хаалга байжээ. Хэрмийн үүдийг байгуулахдаа, олон нүх ухаж модон шон суулгаад өөр хооронд нь

модоор холбон хашлага үйлдээд, түүндээ шороо дүүргэн овоолсон ч дэлдсэнгүй. Тэрслэн шонгийн нүхнээс дотогш холгүй зайд ёроолд нь хавтгай чулуу суулгасан гүн том нүхүүд ухаад түүндээ дугуй болон дөрвөлжлөн зассан модон баганuудыг суулган бэхлээд шороотой хамт босгожээ. Жижиг нүхүүд шороон хэрмийг босгох үүрэгтэй ба дараа нь сугалж авдаг бол модон баганууд нь хэрмийн үүдний шороог бат бөх барих яс мод болоод зогсохгүй үүдний дээрх байгууламжийг тулах зориулалттай ажээ. Өөрөөр хэлбэл, үүдний дээр бүдүүн модон баганаар тулсан модон дээвэр бүхий модон байгууламж байжээ. Дээврийн хэмжээ бага бус байсныг олон багана тулдаг байснаар төсөөлөгдөж байна. Үүдний гадуур шуудуу байхгүй өөрөөр хэлбэл үүд рүү шууд орж гардаг ажээ. Тэрчлэн үүдний төв хэсэгт жигд дэлдэж хатууруулсан хөрс мэдэгдэж байлаа. Энэ нь үүд хаалганы орж гарах хэсэгт зориулсан шал бололтой.

Дунд хэрмийн судалгаа

1-р байгууламжийн малтлага. Дунд хэрмийн төвд бараг тэгшдөрвөлжин хэлбэртэй, сууриараа 46х46м, дээрээ тэгш дэвсэг бүхүй 25х22м, 3м өндөр хавтгай байгууламж бий. Түүний баруун зүүн талын дунд хэсэг илэрхий өндөр бөгөөд урт харагддаг. Шороон байгууламжийн өмнөд ,баруун хэсэгт болон, баруун дээд буланд тус тус сорилын малтлага хийлээ.

Шороон байгууламжийг үйлдэхдээ, сонгож авсан талбайд том нүхүүдийг дөрвөлжин хэлбэрт оруулан тойруулж ухаад түүндээ бүдүүн өндөр модон багана суулган чигжжээ. Дараа нь баганын гадуур түрүүчийнхээс нарийн жижгэвтэр олон нүх ухаж түүндээ модон шонгууд суулгаад хооронд нь модоор хашиж улаан, саарал өнгийн шаварлаг хөрсийг зөөвөрлөн авчраад сайтар хатууруулж дэлдсэн байна. Өөрөөр хэлбэл, жижиг нүхүүд нь шороон байгууламжийн хэлбэр, хэмжээг гаргахад зориулагдсан бол том нүхүүд нь нэг талаар уг байгууламжийг бэхлэх, нөгөө талаар шороон байгууламж дээрх нүсэр том модон дээврийг тулах даацын яс модон багана болгожээ. Модон баганы хамт улаан, саарал өнгийн наалдамхай шаварыг оролцуулан сайтар хатууруулан дэлдсэнээр шороон байгууламж, модон баганыг харилцан бат бөх хөдөлгөөнгүй барихаар тооцоолсон барилгын нарийн арга ухаан аж. Дараа нь шороон байгууламжийн баруун зүүн талын дунд хэсэгт мөн л модон шон хашлагаар улаан шавраар алсаас налуулж дэлдсэн гаруулыг нэмж үйлдсэн байна. Уг гаруулаар дамжиж байгууламжийн баруун зүүн талаас гардаг болно. Малтлагаас илэрсэн ханыг тооцоолж үзэхэд, уг байгууламж сууриараа 42х42м, дээд хавтгай дэвсэг нь 25х25м талбайтай ажээ. Шороон байгууламжийн ханаас гадагш тарж урссан хөх шавар их хэмжээгээр мэдэгдэж байлаа. Тэр нь байгууламжийн гадна талыг шавардан өнгөлөн чимэглэснийг харуулдаг. Шороон байгууламжийн дээрх тэгш хавтгай талбайд модоор үйлдсэн олон тасалгаатай барилга байсан болов уу хэмээн төсөөлж байна. Уг барилга сүйдэж нурсны дараа суларсан хөрсний хэлбэрээр дэрс ургасан байна.

3-р байгууламжийн малтлага. Дунд хэрмийн төвд буй том шороон байгууламжийн баруун урд, цувраа 3 байгууламжийн дундах шороон овгор нь малтлага хийсэн 3-р байгууламж юм. Энэ шороон овгор нь баруун хойноос зүүн урагшаа чиглэсэн зуувин дугуй хэлбэртэй, 40х31м хэмжээтэй, төвдөө 1,8м өндөр, бага зэрэг хавтгайдуу, бусад талруугаа налуу юм. Шороон хэрмийн зарим байгууламжид хийсэн геофизикийн судалгааны тайланд 3-р байгууламжид сонирхолтой гажил тэмдэглэгдсэн тулмалтлага явуулав. Тус шороон байгууламжийн төвөөр дайруулсан сорилын малтлага болон зүүн урд тал буюу 4/1 талбайг сонгон авч малтав.

Малтлагын байдлаас үзэхэд, хэрэм болон 1-р байгууламжтай адил өмнө зүг урт талаар нь хандуулсан 24х15м гонзгой дөрвөлжин хэлбэртэй, олон нүх ухаад модоор хашиж түүндээ улаан саарал өнгийн шавар асгаж үйлджээ. Уг байгууламж төвдөө 1,5м өндөр, захдаа 0,7м өндөр, сууриасаа дээш дотогшоо 10° налуу тэгш ханатай байжээ. Өөрөөр хэлбэлуг байгууламж дундаа тасалгаа, хаалга үүд байхгүй. Шороон байгууламжийн ханыг хөх шавраар нимгэвтэр шавж өнгөлсөн байжээ. Малтлагын явцад зүүн урд ханын орчмоос шавар ваар савны хүзүү, бөөрийн хагархай олдов.

Өндөр улааны дурсгалын судалгаа

Талын гурван хэрмээс баруун хойш 5км орчим зайд, Өндөр-Улаан уулын зүүн урд хормойд нэгэн шороон овгор байгууламж бий. Тус байгууламж хойноос урагш чиглэсэн зууван хэлбэртэй, 47х35м хэмжээтэй, 2,4м өндөр. Уг байгууламжийн үүрэг, бүтэц, зориулалтыг тодруулах малтлага хийлээ. Шороон байгууламж хэрэмгүй боловч ойр орчинд нь нарийвчилсан хайгуул хийх явцад баруун урд зүгт 0,8км зайд нэгэн том жалгын эргээс шороо авсан ухмал илрүүлэв. Шороон овгор байгууламжийн төвийг дайруулсан сорилын малтлага хийхэд шороог олон үе асгаж бага зэрэг хатууруулж үйлдсэн намхан босоо ханатай, төвдөө өндөр монгол гэр мэт бумбагар хэлбэртэй байгууламж болохыг тогтоов. Тэрчлэн байгууламж дээр болон зүүн урд талд хэд хэдэн малтлага хийлээ. Шороон овгор байгууламжийг үйлдэхдээ, модон шон суулгаж хашаад хөх шавраар шавж өнгөлснийг илтгэх хэд хэдэн баримт олдлоо. Шороон овгорын төвд 2,4м гүнээс нэгэн оруулмал оршуулга илрэв. Нас барагчийг модон авсанд хийгээд толгойгоор нь баруун хойд зүгт хандуулж тэнэгэр байдлаар тавьжээ. Оршуулгаас хүрэл хүзүүний зүүлт, төмөр хутга, хүрэл гоо заслын эдлэл, хүрэл чимэглэл бүхий суран бүс, шавар ваар, нумын наалт бөс даавууны тамтаг зэрэг зүйл олдлоо. Уг булшнаас гарсан олдвор хэрэглэгдэхүүний байдлаас үзвэл, Талын гурван хэрмийн Жужан булштай нэг үед холбогдох бололтой.

Өндөр улааны дурсгал нь Талын гурван хэрмээс холгүй орших боловч түүнтэй адил Хүннү улсын үед холбогдох бололтой. Харин түүнийг орхигдож баларсны дараа Жужанчууд нас барагчаа энд нутаглуулсан аж.



Дурсгалт газрын байршил

Малтлагын явц

Үүдний малтлага

Дунд хэрмийн 3-р байгууламжийн малтлагын явц

3-р шороон байгууламжийн зураглал Малтлагын явц

Үүдний малтлагын явц

2016 ОНЫ МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН “ЭРТНИЙ МОНГОЛЧУУДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТҮҮХ” ТӨСЛИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН ТОВЧ ҮР ДҮН

Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Л.Ишцэрэн, Г.Галдан,
П.Алдармөнх, Т.Сасада, И.Үсүки

Тус хамтарсан төслийн энэ жил судалгааны ажил Монгол улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2016 оны 4-р сарын 25-ны өдрийн А/161 тоот тушаалаар батлагдсан 16-01-24 дугаар бүхий Палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлага судалгааны ажил хийх зөвшөөрлийн дагуу доорхи байдлаар хийгдлээ. 2016 оны 7-р сарын 1-нээс 7-р сарын 10-ныг хүртэл нийт 10 хоногийн хугацаатай Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг Булагийн амны төмөр хайлуулах зуухны малтлага судалгаа, 2016 оны 9-р сарын 1-нээс 9-р сарын 10-ныг хүртэл Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Зүүн Байдлагийн голын хөндийд хайгуул, малтлага судалгаа, 9-р сарын 17-ноос 9-р сарын 25-ныг хүртэл Баян-Өлгий, Ховд аймгийн нутаг Ховд голын хөндийд хайгуул судалгааны ажлыг тус тус гүйцэтгэсэн болно.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг Булагийн амны хүннүгийн үед холбогдох төмөр хайлуулах зуух бүхий дурсгалт газрыг 2014 онд анх илрүүлэн олж, 2015 онд тус төслийнхөн туршиц судалгааны ажил эхлүүлэн он цагийг нарийвчлан тогтоосон билээ. Энэ жил тухайн дурсгалт газрыг бүрэн хэмжээгээр малтаж, зуухны хэлбэр, хэмжээ, хамрах хүрээг тодорхойлох ажлыг гүйцэтгэв.

Тус төслийн багийнхан Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Зүүн Байдлагийн голын хөндийд 2011 оноос эхлэн судалгааны ажлаа гүйцэтгэж байгаа билээ. Энэ жил Хустын булагийн төмөр хайлуулах зуух, Зүүн Байдлагийн голын шавар шатаах зуух, Намсрайн ухаагийн хүннү булшны оршуулгын газар, Зүүн Байдлагийн хөндийг хамарсан нарийвчилсан хайгуул судалгаа, Хэрлэнгийн баруун эрэгт орших XVII-XX зууны үед холбогдох Зүүн хүрээний агаарын дэвсгэр зураг гэсэн хэсгүүдэд төвлөрөн ажиллав.

Төслийн үндсэн зорилгын нэг бол эртний монголчуудын үйлдвэрлэлийн түүхийг тодруулах шинэ эх хэрэглэгдэхүүн цуглуулахад оршиж байгаа бөгөөд энэхүү зорилгын хүрээнд Баруун Монголын бүс нутаг тодруулбал Баян-Өлгий, Ховд аймгийн зарим сумын нутгаар дайран өнгөрөх Ховд голын хөндийд бэсрэг хайгуулын ажлыг зохион байгуулав.

Ийнхүү тус төслийн хээрийн шинжилгээний ангийн ажлын цар хүрээ улам бүр өргөжин тэлж, эртний монголчуудын төмөрлөг боловсруулалтын түүхэнд

холбогдох тодорхой хэмжээний шинэ эх хэрэглэгдэхүүнийг цуглуулсан чухал жил болж өнгөрөв.

Зүүн Байдлагийн голын хөндийд ажилласан тус хээрийн шинжилгээний ангид Монголын талаас Археологи, угсаатны авран хамгаалах салбарын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, Хүннү ба эртний түүхийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор Г.Эрэгзэн, Хүннү ба эртний түүхийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Л.Ишцэрэн, Археологийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Галдан, БНСУ-ын Сөүлийн Их сургуулийн зочин судлаач, магистр П.Алдармөнх, МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхимийн багш, профессор, доктор З.Батсайхан нар, Японы талаас Т.Сасада, И.Үсүки, К.Кияма, Х.Үчида, нар ажиллав. Хээрийн судалгааны ажлын туслах ажилтнаар Б.Амгаланбаатар, О.Алтаннаран, Б.Буян-Орших, Г.Баяржаргал, П.Анхтуяа, Э.Түвшин, Б.Солонго, Б.Дашзэвэг, М.Норовбанзад, Г.Нямдаваа нарын МУИС-ийн Археологийн IV дамжааны 10 оюутан, Д.Молор, Л.Ойдовдагва, Н.Батдэлгэр, Н.Мөрдорж нарын нийт 5 жолооч нийт 29 хүн бүрэлдэхүүнтэй ажиллав. Судалгааны багийн нийт бүрэлдэхүүн “Байгал Тур” ХХК-ны “Хаан Хэрлэн” жуулчны баазтай хамтран ажиллах гэрээний дагуу тав дахь жилдээ байрлав.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг Булагийн аманд хийсэн малтлага судалгааны ангид Монголын талаас Хүннү ба эртний түүхийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Л.Ишцэрэн, Археологийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Галдан, Японы талаас Эхимэгийн Их сургуулийн профессор, доктор Т.Сасада, туслах ажилтнаар МУИС-ийн Археологийн IV дамжааны оюутан Э.Түвшин, Баянгол дүүргийн Гурван эрдэм дунд сургуулийн 11-р ангийн сурагч О.Хатанбүүвэй, жолоочоор Л.Ойдовдагва нарын нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав. Судалгааны багийнхан Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгонд байрлав.

Баян-Өлгий, Ховд аймгийн зарим нутгаар дайран өнгөрөх Ховд голын хөндийд хийсэн хайгуул судалгаанд Монголын талаас Археологи, угсаатны авран хамгаалах салбарын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, Хүннү ба эртний түүхийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан Л.Ишцэрэн, Археологи, угсаатны авран хамгаалах салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр М.Алтаншагай, Японы талаас Эхимэгийн Их сургуулийн профессор, доктор Я.Мураками, жолоочоор Д.Молор нарын нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав.

Төмрийн хүдэр хайлуулах зуухны малтлага судалгаа

Хустын булагт хийсэн малтлага судалгаа

Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Зүүн Байдлагийн голын хөндий Хустын булагийн төмрийн хүдэр хайлуулж боловсруулах дурсгалт газарт жил бүр амжилттай малтлага судалгааг хийсээр ирлээ.

2011 оноос хойш хийсэн малтлага судалгаагаар төмрийн хүдэр хайлуулж боловсруулах зуухны үлдэгдэл 6, төмрийн хүдэр буталж жижиглэх газар 2, зуухны хаягдал агуулсан нүх 6 ширхэгийг тус тус илрүүлээд байна. Мөн зуухны хана, салхи дамжуулах шавар хоолой, төмрийн хаягдал баас зэрэг эх хэрэглэгдэхүүнүүд их хэмжээтэй олдоод байгаа юм. Эдгээр зуухнуудаас авсан модны нүүрсний радиокарбоны он цагийн судалгаа болон хөрсний зааг ялгаанаас хамаарч дээд үе нь НТ I зуун, түүний дараачийн үе нь НТӨ I зуунд хамаарч байгаа юм. Харин Хүннүгийн үед холбогдох хэрэглээний ваар савны хагархай маш цөөхөн тохиолдож байгаа юм. Радиокарбоны холбогдох он цаг болон ваар савны хагархай зэргээс үзвэл Хүннү гүрний үед холбогдох дурсгал болох нь баттай болсон юм.

Бид нийт илэрсэн зуухны бүтэц зохион байгуулалт, хэмжээ зэргээс хамаарч гурван хэлбэрт хувааж үзсэн юм.

I хэлбэрийн зуух нь дөрвөлжин хэлбэртэй үүдэн хэсэгтээ зуйван хэлбэрийн хаягдал агуулсан нүхийг ухсан бөгөөд хөрсний үе болон он цаг тогтоох судалгаанаас үзвэл НТ I зуунд хамаарч байна.

II хэлбэрийн зуух нь том хэмжээтэй гонзгой хэлбэртэй бөгөөд Slag pit хэлбэрийн зуух юм. Мөн хөрсний давхрага болон он цаг тогтоох судалгаагаар НТӨ I зуунд холбогдож байгаа билээ. Ийм хэлбэрийн зуух одоогоор Хустын булагийн дурсгалт газраас бусад Хүннүгий үеийн төмрийн хүдэр хайлуулж боловсруулах дурсгалаас илрээгүй байна.

III хэлбэрийн зуух нь Slag pit хэлбэрийнх бөгөөд газар ухаж хийсэн зуухтай залгаад мөн хаягдал хийх зориулалт бүхий нүхийг ухсан ба доод ёроол хэсгээрээ нарийн хонгилоор холбосон ажээ. Энэхүү зуух нь мөн малтлагын доод хөрснөөс илрэх бөгөөд НТӨ I зуунд хамаарч байгаа билээ.

Эдгээр зуухын бүтэц зохион байгуулалт зэргээс үзвэл Хүннүгийн төмрийн хүдэр боловсруулах үйлдвэрлэлд Хан улсын нөлөө байхгүй харин Өмнөд Сибир болон баруун Азийн нөлөө байгаа нь судалгаагаар тодорхой болсон юм.

Хустын булагийн дурсгалаас нийт илэрсэн зуухны тоо цөөн, ялангуяа Хоёрдугаар хэлбэрийн зуух 1, гуравдугаар хэлбэрийн зуух 2012 оны малтлагын ханын зүсэлтээр болон 2015 онд малтсан талбайгаас тус бүр 1 илрээд байна.

Энэ жил малтлага судалгаа хийсэн Ex.15.01 талбайгаас төмрийн хүдэр хайлуулж боловсруулах зуух 3-ыг илрүүллээ. Эдгээр зуухны нуранги үлдэгдэл болох

зуухны ханын хэсгүүд, салхи дамжуулах шавар хоолой, төмрийн хүдэр, ваарны хагархай зэрэг эх хэрэглэгдэхүүнийг мөн илрүүлэн баримтжуулалт хийлээ.

7-р зуухнаас авсан модны нүүрсийг хийсэн он цаг нь 37-51 cal AD (5.6%) буюу НТ 1-р зуунд хэмээн гарсан (хүснэгт 1). Харин 8-р зуухнаас авсан модны нүүрсний үнэмлэхүй он цаг нь 103- 81 cal BC (9.7%) буюу НТӨ I зууны үед холбогдох нь тодорхой болсон юм (хүснэгт 2).

Дээрх нарийвчилсан он цаг нь Хустын булагийн дурсгалт газрын II хөрсний давхрага үе нь НТ I зуунд, харин III болон IV хөрсний давхрага нь НТӨ I зууны үед хамаарч байгаа нь давхар батлагдаж буй хэрэг билээ.

Манай төслийн хээрийн судалгааны хүрээнд 2016 оны 07-р сард Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг Булагийн амны дурсгалт газар хийсэн төмрийн хүдэр хайлуулах зуухны малтлагаар илэрсэн зуух нь мөн III хэлбэрийн нарийн хонгил бүхий зуух байсан юм. Монгол нутгаас илэрсэн төмрийн хүдэр хайлуулж боловсруулах дурсгалт газруудаас бидний ангилсан I хэлбэрийн зуу х нь зөвхөн Хустын Булагийн дурсгалаас л олдоод байгаа юм. Харин Өмнөд Сибирьт малтсан Тагарын соёлын үед холбон үздэг Трошеина ульс дурсгалт газраас бол илэрсэн байдаг

Энэхүү төмрийн хүдэр хайлуулж боловсруулах зуухны малтлага судалгааны үр дүнг нэгтгэн үзвэл Хустын Булагийн дурсгалт газраас хөрсний давхрага бүрээс буюу нэг дор олон хэлбэрийн зуух байгаа нь тус дурсгалын нэгэн онцлог хэмээн үзэж болно. Тус дурсгалт газарт хичнээн зуух аль зэрэг талбайг хамаарч байгааг тодорхойлох зорилгоос ирэх жилээс баруун тийш хамгийн захад олдсон төмрийн хаягдал баас бүхий газарт малтлага судалгааг хийхээр төлөвлөж байна.

Булагийн аманд хийсэн малтлага судалгаа

Сэлэнгэ Аймгийн Мандал сумын нутагт орших Булагийн аманд 2016 оны 07-р сарын 03-10-ны өдрүүдэд тус хамтарсан төслийнхөн малтлага судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хайгуул судалгаагаар илэрсэн төмрийн хүдэр хайлуулж боловсруулах зуухны үлдэгдэл нь Булагийн ам хэмээх жижиг голын хойд талын эргийн нурангиас олдсон бөгөөд бид голын эрэг дагуу зүүнээс баруун тийш 6 м, урдаас хойш 5 м хэмжээтэй талбайд судалгааг хийхээр төлөвлөн өнгөн хөрсийг хуулав.

Хөрсний бүтэц нь I-р үе: өнгөн хөрс, II-р үе: хар хүрэн болон хар шороон үе, III-р үе: бор хөрсөн үе, IV-р үе: хүрэн шаргал үе, V-р үе: цагаан хөрсөн үе буюу байгалийн хөрс хэмээн ангилсан юм.

Энэ удаагийн малтлага судалгаагаар 4 ширхэг зуухны үлдэгдэл, 2 ширхэг хаягдал агуулсан нүхийг малтлан судалсан юм. Эдгээр зуух болон хаягдал агуулсан нүхнүүд нь 3-р хөрсний үеэс илэрсэн. Эдгээр зуух нь булангууд нь дугуйрсан

дөрвөлжин хэлбэрийн газар ухаж хийсэн (Slag pit) хэлбэрийн зуух бөгөөд бидний ангилснаар 3-р хэлбэрийн зуухнууд болох нь тодорхой болсон.

Малтлага судалгаагаар гарсан хоёр ширхэг модны нүүрсэнд хийсэн радиокарбоны үнэмлэхүй он цагийн судалгаагаар 1 нь 128 cal BC (13.5%)、121- 19 cal BC (78.5%)、12- 1 cal BC (3.4%)、2 нь 93 cal BC-26 cal AD (95.4%)、буюу НТӨ I зуунд хамаарч байгаа юм.

Хустын булаг болон бусад дурсгалт газруудаас илэрсэн төмрийн хүдэр хайлуулж боловсруулах 3-р хэлбэрийн зуух нь НТӨ I зууны үеийнх байдаг бөгөөд Булагийн амны төмрийн хүдэр боловсруулах зуух ч мөн энэ цаг үед таарч байгаа нь судалгааны хувьд сонирхолтой зүйл боллоо.

Шавар шатаах зуухны малтлага судалгаа

Хустын булагийн ваар сав шатаах зуухны KBS 3 малтлагын талбай нь Зүүн байдлагийн голын адаг дэнж дээр байрлана. Өмнөх жилүүдэд малтлага хийсэн KBS 1 талбайгаас зүүн өмнө зүгт 3,3км орчим, KBS 2 талбайгаас зүүн хойд зүгт 0,8км зайд тус талбай орших бөгөөд Монгол-Солонгосын хамтарсан “Мон-Сол” төслийн малтлага судалгаа хийсэн талбайтай ойролцоо газарт энэ жил малтлага судалгааг хийхээр төлөвлөв.

2015 оны малтлага судалгаагаар их хэмжээний дээврийн ваар, модны нүүрс, шатсан хөрс зэрэг илэрсэн газрыг ваар сав шатаах зуухны хэсэг байх магадлалтай хэмээн үзсэн бөгөөд шатааж хийсэн шавар тоосгоны үлдэгдэл зэрэг гарснаас үндэслэн энэхүү дүгнэлтийг хийсэн билээ. Бид дээрх малтлагыг үргэлжлүүлэн 2016 онд 4х8 метр талбайд судалгааг хийсэн юм. Харамсалтай нь дээрх хар хөрсөн давхрага бидний энэ жилийн талдбайд бага хэмжээтэй үргэлжлээд дууссан тул зуух хэмээх таамаглал маань батлагдсангүй.

Үүний дараагаар бид малтлагын талбайн зүүн хана болон төв хэсэгт 50см өргөнтэй туршилтын малтлагыг хийлээ. Үүний үр дүнд дэнжийн налуу хэсгийн дээд талд нимгэвтэр хар хөрсөн үе давхрага байгааг илрүүлсэн бөгөөд тус ххар хөрсөн үеийн дагуу малтлагыг хийхэд эргийн налуу дагуу доошилж байсан ба доод хэсэгтээ бүр их зузаан болж байлаа. Малтлагаар дээврийн тосгуур болон нөмрөг ваарны хагархай, модны нүүрс, үнс, шатсан хөрсөн үе зэрэг холилдсон байсан бөгөөд малтлагын III үеийн хөрсөнд дээрээс доошоо асгасан байдалтай буюу хог хаягдлыг хаясан хэмээн үзэж болохоор ажээ.

Түүнчлэн тус хар хөсрний доод үе буюу IV хөрсөн үеийг хусаж тэгшилсэн гэж болохоор үнсэн саарал өнгийн элсэрхэг үе байх ажээ. Энэ хөрсөн үе нь зуухыг барих үед газрыг тэгшилж хөрсийг ухах үед гарсан шороог хаясан хаягдал хэмээн үзэж бас болохоор ажээ.

Дээрх малтлага судалгааны үр дүнг нэгтгэн үзвэл зээрх хаягдал нь зүүн хойд хэсгээс зуухны үүдэн хэсгийн хаягдлыг гаргаж хаясан байх магадлалтай өндөр хэмээн үзсэн юм. Бид дээрх таамаглалыг магадлан үзэх зорилготой дэнжийн дээд хэсэгт 1 метр өргөнтэй хоёр ширхэг туршилтын малтлагыг нээж үзсэн юм. Үүний үр дүнд байгалын хөрсийг ухсан нүх гарсан тул цааш үргэлжлүүлэн талбайн зүүн хойд булан болон төв хэсэгт 3х2 метр хэмжээтэй туршилтын талбайг нэмж малтлаа.

Энэхүү нэмж малтсаны үр дүнд 6 метр голчтой дугуй нүхний үлдэглийг илрүүллээ. Төв хэсэг дахь нүхний өмнөд ханыг доод хэсэг хүртэл 30см орчим гүн ухсан ба, хөрсний бүтэц хэрхэн давхраглагдсан зэргийг шалгаж үзээд газраас доош 70см орчимд зуухны үлдэгдэл байсан байх магадлалтай хэмээн үзсэн юм.

2016 онд малтлага судалгааны хугацаа бага байсан учир ирэх жил уг талбайд дахин малтлага судалгааг бүрэн хэмжээгээр хийхээр энэ жилийн малтлага судалгааг дуусгалаа.

Хайгуул судалгаа

Энэ жил манай төслийн хайгуул судалгааны багийнхан өнгөрсөн жилийн зорилгын хүрээнд үргэлжлүүлэн хийсэн ба өнгөрсөн жил энгийн гүймэг хайгуул болон боломжит газруудад сорилын малтлага судалгааны ажил хийж байсан бол энэ жил илүү нарийвчилсан арга зүйгээр хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Тодруулбал, хайгуулын багт нийт 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр 6км^2 талбайд хайгуул судалгааны ажил хийж гүйцэтгэлээ.

Арга зүй. Манай хайгуулын багийн зорилгын хүрээнд нарийвчилсан хайгуулын арга зүйг түлхүү ашиглана. Энэхүү арга зүйгээр газрын хөрсөн дээр болон доор буй хүний нүдэнд тэр болгон ажиглагдахгүй чулуун зэвсэг, шавар савны хагархай, зарим жижиг эд өлгийн зүйлсийг илрүүлэн олдог. Нарийвчилсан хайгуулын арга зүй нь манай орны археологийн судалгаанд хэрэгжиж эхлээд удаагүй байгаа боловч үндсэн зарчим, хэв маяг нь нэгэнт хэлбэршин тогтсон байна. Эхний ээлжинд хайгуул хийгдэх талбайн хиймэл дагуулаас авсан сансрын зургийг солбицлын дагуу байрлуулан 1х1км (зарим тохиолдолд энэ хэмжээ өөрчлөгдөнө) хэмжээтэй нарийвчилсан талбайд хуваан, явган самнах хайгуулын ажил эхлэнэ. Хайгуулын багийн гишүүд хоорондоо 30 м зайтай алхах ба энэ нь манай орны Эгийн голын савд өмнө хийгдсэн археологийн нарийвчилсан хайгуулын үр дүнд гарсан эртний нүүдэлчдийн отог, бууц суурингийн дундаж хэмжээнд үндэслэн тогтоосон зай болжээ. Мөн тухайн хайгуулын талбайн өнгөн хөрсний үзэгдэх байдлаас шалтгаалан хайгуулд ашиглах багаж хэрэгсэл нэмэгдэнэ. Хэрэв хайгуул хийгдэхээр сонгогдсон талбайн өнгөн хөрсний үзэгдэх байдал сайн байвал хоорондын зайг алдалгүйгээр алхан ажиглалт хийнэ. Бидний энэ жилийн хайгуул хийхээр төлөвлөсөн газрууд ургамлын бүрхүүл харьцангуй ба өнгөн

хөрсөн дээр зүйлсийн үзэгдэх байдал сайн байсанд бид зөвхөн хоорондын зайгаа алдалгүй самнан алхаж байсан болно.

Хайгуул судалгаа. 2016 оны хайгуул хийхээр төлөвлөгдсөн талбайд Тогос хайрхан уулын зүүн биеэс Зүүн Байдлагийн голын ай сав хүртлэх 4км² талбайгаас гадна Хэрлэн голын эргээс Зүүн Байдлагийн голын хойд эргийн дагуу нийт 2км² хэмжээтэй 2 хэсэг талбайд нарийвчилсан хайгуул судалгааны ажил хийв. Хайгуулын явцад нийт 9 дурсгал шинээр илрүүлсэн ба үүнд хүрэл зэвсгийн хожуу үед холбогдох буган чулуун хөшөө 1, төмрийн түрүү үед хамаарах дөрвөлжин булш 3-ийг илрүүлсэн бол он цаг тодорхойгүй чулуун байгууламж 3-ийг илрүүлжээ.

Харин Зүүн Байдлагийн голын хойд эрэгт тулсан налуу мөргөцгийн дээд тэгш дэвсэг газраас олон тооны шавар сав суулганы хагархай, төмөр болон хүрэл эдлэлийн хэсэг, нүүр болон дээвэр ваарны хэсэг зэрэг хүний амьдралтай холбоотой олдвор хэрэглэгдэхүүн бүхий газар илрүүлэв. Олдворын тархалт 0.2 га талбайд жигд тархсан байна. Түүвэрлэсэн дээврийн ваар, нүүр ваар зэргийг ажиглахад зэрэгцээ газарт малтаж байгаа шавар шатаах зуух болон "Тэрэлжийн дөрвөлжин" дурсгалт газраас илэрдэг нүүр, дээврийн ваартай ижил байна.

Мөн хэрэглээний шавар сав суулганы хагархайнууд хүннүгийн үед хамаарах булш оршуулга болон хот суурины дурсгалаас илэрдэгтэй адил байгаа нь энэхүү дурсгал магадгүй хүннүгийн үед холбогдож болохыг илтгэж байна. Бид дараа жилийн хээрийн шинжилгээний ажлаар энэхүү газарт хэд хэдэн шатны сорилын болон өргөн хэмжээний малтлага хийхээр төлөвлөж байна. Ингэснээр илүү найдвартай он цаг тогтоох баримттай болох боломжтой.

Булшны малтлага судалгаа

Төслийн булшны малтлага судалгааны баг 2016 онд Намсрайн ухаа хэмээх газарт буй Хүннүгийн үеийн цагариг хэлбэрийн чулуун дарааст 8 булш бүхий оршуулгын дурсгалт газарт 2 булшийг малтан судлах ажил хийсэн.

Уг дурсгалыг төслийн хайгуул судалгааны баг 2013 онд анх илрүүлсэн ба тэр жилдээ 1, 2014 онд мөн 1 булшийг тус тус малтан шинжилж, тархацын дэвсгэр зургийг үйлдсэн юм. Энэ жил малтлага хийсэн 2 булшнь тархацын дэвсгэр зурагт 4 болон 7-р булш хэмээн тэмдэглэгдсэн дурсгалууд болно.

4-р булшны хувьд цагариг хэлбэрийн чулуун дараастай, дараасын голч 5м хүрэх харьцангуй жижиг хэмжээтэй юм. Оршуулгын нүхийг 2 шатлаж ухсан байх агаад 1.6м гүнд модон авсанд хийж оршуулсан хүний ясны үлдэгдэл илэрсэн.

Булшийг эрт цагт тонож сүйтгэсэн байснаас хүний яс анхны байрлалаас нилээд хөдлөж эмх замбараагүй болсон байв. Авсны энд тэндээс төмөр эдлэлийн жижиг үлдэгдэл хэсгүүд илэрсэн бөгөөд эдгээрийг лабораторид цэвэрлэхэд жижиг төмөр

хутганы хэсэг нь бүрэн сэргээх боломжтой байсан. Бусад нь хэлбэр зориулалтыг мэдэх боломжгүй жижиг хэсгүүд байна.

7-р булшны хувьд гадаад чулуун байгууламж нь Хүннүгийн булштай төстэй байсан ч дараасыг зайлуулан цэвэрлэхэд нялх хүүхэд багтахаар жижиг нүхний толбо илэрч, шалгаж үзэхэд ямар нэгэн зүйл илэрсэнгүй. Энэ байгууламж нь 2013 онд тус газарт бид малтаж 1-р булш хэмээн нэрлэсэн чулуун байгууламжтай төстэй зүйл бололтой байна.

Хавсралт



Хустын булагийн дурсгал газрын малталага судалгаа хийсэн талбайн дэвсгэр зураг



Хустын булагийн дурсгал газрын малталага судалгаар илэрсэн зуухны тархалт



Ex.15.01 талбайгаас илэрсэн Хүннү ваарны амсар



Хустын булагийн Ex.15.01 талбайн дэвсгэр болон зүсэлтийн бүдүүвч



Булагийн амны EX.16.01 талбайн дэвсгэр болох зүсэлтийн зураг



Булагийн амны Ex.16.01 талбайн дэвсгэр болон зүсэлтийн зураг



Хустын булагт хийсэн хайгуулаар илэрсэн олдвор хэрэглэгдэхүүн

ЗҮРХИЙН ҮЗҮҮРИЙН ХҮННҮГИЙН ДУРСГАЛТ ГАЗАРТ ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮНГЭЭС

Л.Эрдэнэболд, Ч.Ванчигдаш,
Д.Хатанбаатар, С.Бат-Эрдэнэ, С.Болормаа

“Туулийн хөндийн соёлын өвийн судалгаа төсөл” -ийн хүрээнд ШУТИС, Монгол Цэргийн Музейн хамтарсан судалгааны анги Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Зүрхийн Үзүүрийн хүннүгийн дурсгалт газарт 2016 оны 7-р сарын 26-аас 8-р сарын 06-ны хооронд малтлага судалгааны ажил хийж гүйцэтгэлээ. Тус судалгааны ангийн бүрэлдэхүүнд төслийн ахлагч Л.Эрдэнэболд, судлаач Ч.Ванчигдаш, Д.Хатанбаатар, С.Бат-Эрдэнэ, С.Болормаа нар оролцон ажиллаа.

Тус судалгааны анги Зүрхийн Үзүүрийн хүннүгийн дурсгалт газарт ажиллахдаа дурсгалт газрын дэвсгэр зургийг үйлдэж, дөрвөн булшийг малтан судалсан юм.

Зүрхийн Үзүүрийн дурсгалт газар нь Булган аймгийн Дашинчилэн сумын төвөөс баруун урагш 39км зай орших Зүрхийн үзүүр гэх хамрын зүүн хормойд байрлана. Энд илэрхий мэдэгдэх 299 тооны булш байх бөгөөд ерөнхийдөө гурван хэсэгт бөөгнөрч байв. Бид хойд талаас нь эхлүүлэн A, B, C гэж дугаарлаад A хэсгээс 2, B хэсгээс 2 булш тус тус малтан судлав. C хэсэг буюу зүүн урд хэсэгтхэмжээний хувьд харьцангуй том бөгөөд үүдэвч бүхий тэгш өнцөгт хэлбэрийн гадаад байгууламжтай язгууртны булшууд байлаа.

Дурсгал A1. Оршуулгын газрын A хэсгийн толгой талаас хоёр дахь булш юм. Хөрсөнд дээр том хавтгай чулуугаар хийсэн цагариг хэлбэрийн дараас ажиглагдаж байв. Дараас чулуу хөрснөөс дээш 10см орчим цухуйсан байлаа. Өнгөн хөрсийг хуулж цэвэрлэгээ хийх явцад дараасны баруун хойд захаас бод малын тагалцгийн яс илрэв. Дараас чулууг зайлуулан доош малтахад 0.5м гүнээс 1.7х1.4м хэмжээтэй зууван дугуй толбо илэрснийг дагуулан малтахад 0.94м гүнээс толбоны хэмжээ нарийсч 1.1х1.92м хэмжээтэй болж өөрчлөгдөв. Толбоны хөл хэсэгт том хавтгай чулууг эгнүүлэн тавьсан 1-р үеийн чигжээс чулуу илэрлээ. Цааш малтахад 2.6м гүнээс булшны нүхний хөл талд нүхний ханыг дагуулан 4 ширхэг том хавтгай чулуу босгосон байв. Энэ хэсгээс 3 ширхэг богийн толгой, 3 ширхэг богийн хавирганы ясны хамт овоолон тавьсан байлаа. Зохион байгуулалтаас харахад модон австай, чулуун тагтай байсан бололтой. 2.8 м гүнд нүхний хөл хэсгээс хүний ясны хэсгүүдээс гадна бог малын эрүү, толгой хэсгээс төмөр эдлэлийн хэсгүүд, хоорондоо эвлэж магадгүй хар өнгийн хөө тортог бүхий вааран савны хэсгүүд гарч байв. 3.1м гүнд авсны шал тулсан бөгөөд хөл хэсгийн хашлага мэдэгдэх төдий үлджээ. Хөмгийн хэсгээс муу хадгалагдсан үхрийн толгойн хэсэг, ямааны толгойн хэсэг олдож байлаа. Нийт гүн 3.1м. Авс баруун хойш 350°

чиглэжээ. Авсны хэмжээ тойм байдлаар 180 орчим см урттай, 50 орчим см өргөнтэй байсан бололтой. Хөмгийн хэмжээ 60х40см. Нүхний нийт урт 2м орчим. Хөмөг дотроос 2 ижил төрлийн вааран савны хагархай, TLV хэв шинжийн хүрэл толины хэсэг олдов. Хүрээн дээр 3 бүтэн ханзны дүрс байна. Малтлагын эцсийн гүн 3.15м.

Дурсгал А2. Оршуулгын газрын А хэсгийн зүүн захад байрлана. Хөрсөн дээр том хавтгай чулууг дан эгнээгээр зэрэгцүүлэн өрж хийсэн цагариг хэлбэрийн дараас ажиглагдаж байлаа. Цэвэрлэгээний дараа харахад том, жижиг хавтгай чулууг давхарлан хэвтүүлж хийсэн цагариг хэлбэрийн дараас болох нь мэдэгдэв. Малтлагын явцад 0.9м гүнээс чанх хойд зүг буюу азимутийн 0˚ хэмд чиглэсэн (энэ чигт Зүрх уулын зүүн талын толгой буюу Дунд гозгор оршино), 1.6х2.9м хэмжээтэй, хүрэн бор өнгийн толбо илэрснийг дагуулан цааш малтахад олон том хавтгай чулууг бие биеийг нь даруулан, налуулж тавьсан байлаа. Эдгээр том чулууны доор 2.45м гүнд өмнөхийн адил нэлээд хэдэн том хавтгай чулууг эгнүүлэн өрж тавьсны голын хоёр чулуу босоо байв. Дээрх хоёр чулууны хоорондоос өмхөрч муудсан хавтгай модны хугархай, хүний баруун гарын бугалгын толгой гарснаас үзвэл тонуулчдын мөр бололтой. 3м гүнд толгой, чээжин хэсэг нь үгүй болж хөл хэсэг нь үлдсэн тагтай банзан авс илрэв. Авсны үлдсэн хэсгээс харахад хойд зүгт азимутийн 345˚ хэмд чиглэсэн, 195см урт, толгой талдаа 60см өргөн, хөл талдаа 43см өргөн, 28см өндөртэй авс байжээ. Авсны чээжин хэсэгт хүний чээж, нугалам нурууг овоолж орхисон байлаа. Хүний доод мөчдийн яс анатомийн байрлалаараа боловч авсны баруун хана руу шахагджээ. Хүний баруун сүүж анатомийн байрлалаараа, зүүн сүүж өвдөг тушаа байлаа. Дунд чөмгийн хооронд зэв маягийн төмөр эдлэл, төмөр эдлэлийн үлдэгдэл, өвдөгний орчмоос нумын бариулын наалт, шагай орчмоос гичрийн наалт илрэв. Авсны гадна толгой талд хохимой, эрүү хоёр цуварсан байдалтай байлаа. Хохимойн зүүн талд нумын гичрийн наалтын хугархай, эрүүний зүүн талд богийн өрөөсөн сүүжний яс байв. Булшны нүхний толгой тал руу 0.6м ухаж хөмөг гаргажээ. Хөмөг дотроос ямар нэг эд өлөг болон зан үйлийн ул мөр илэрсэнгүй. Малтлагын эцсийн гүн 3.05м.

Дурсгал В1. Оршуулгын газрын төв буюу В хэсгийн баруун захад байрлана. Хөрсөн дээр том хавтгай чулууг дугуйруулан өрж хийсэн намхан дараас ажиглагдаж байв. Хойд зүг чиглүүлэн хамар татаж, цэвэрлэгээг 10-15см гүнтэй хийж, гүйцэтгэв. Чулуун дараасыг дунд хэмжээний чулуугаар 2-3 үе өрж хийсэн байна. Дараас чулуудын төв хэсэгт 3х4м хэмжээтэй талбайгаар толбо хайх малтлагыг эхлүүлж 70см гүн малтахад талбайн төв хэсгээс том том чулуун чигжээс бүхий бага зэрэг зүүн хойш чиглэлтэй (ЗХ 10°), бор хүрэн өнгийн зөөлөн хөрс бүхий толбо илэрлээ. Байгалын хөрс шар өнгөтэй, хатуу хөрс байна. Оршуулгын нүхнээс том том чигжээс чулууд тасралтгүй үргэлжлэн гарсаар 193см гүнд хүрэхэд нүхний толгой тушаа гал гаргахаар үрж байсан ором бүхий бод малын шагай (нүхлэсэн) илрэв. 2.1м гүнд нүхний төв хэсгээс бод малын эврийн хугархай, хөл хэсгээс хүний хатан хүзүү болон бугын

эврийн хэсэг олдов. Оршуулгын нүх 3.1м гүнд 2.1х1.7м хэмжээтэй байна. Гол хэсгээрээ чулуу багатай, хөл болон толгой хэсгээрээ чулуутай байгаа нь тонуулчдын ул мөр бололтой. Оршуулгын тагыг 2 эгнээ өрж хийжээ. Хөл талын чулуудын завсар хоорондоос их муу хадгалагдсан бугын эврийн хэсэг олдож байна. 2.2м гүнд нүхний толгой хэсгээс хадгалалт муутай бог малын толгойн ясны хэсэг илрэв. Энэ түвшинд нүхийг битүү бүрсэн оршуулгын таг чулууд илрэв. Чээжин хэсгийн таг хугарч унасан байдалтай байна. Хүний хурууны үе болон хавирга яснууд болон бог малын толгойн яс эмх замбараагүй байдалтай илэрсээр байв.

Оршуулгын таг чулууг сөхөж малтлагыг үргэлжлүүлэхэд оршуулгын нүх хажуу хэсгээрээ багасаж, 2.9м гүнд модон авсны дээд ирмэг цухуйж байна. Нүхний төв хэсгээс цагариг хэлбэртэй төмөр эдлэлийн хэсэг, хөл хэсгээс хүний шилбэ, хавирга яснууд олдож байна. Модон авсны толгойн дээд түвшинд бөөр хэсэгтээ цоорхой том бутан хэлбэрийн вааран сав, төмөр тогоо, хөө тортог бүхий жижиг вааран тогоо зэргийг эгнүүлэн тавьсан байна. Эдгээрийн ойр орчмоос улаан өнгийн чий будагны хэсгүүд илэрч байна. 3м гүнд нүхний хөл хэсэгт хүний эгэм, дал, нуруу, хавирга, шилбэ яснууд эмх замбараагүй олдов. Тонуулчид хөл хэсгийн 2 таг чулууг сөхөн орж сүйдэлсэн нь ойлгомжтой болов. Энэ нүхээр хүний яс болон бусад зүйлсийг цувуулан хаяжээ. Мөн эндээс бүсний арал мэт хэлбэртэй төмөр эдлэл олдов. Авсны модноос дээж авав. Авсны хөл хэсгээс хүрэн өнгийн чулуун зүүлт, урт төмөр хадаас, цагариг хэлбэрийн төмөр эдлэл, суран оосортой хүрэл хонх, төмөр зэвний үлдэгдэл, төмрийн хэсгүүдийн хамт илэрлээ.

Дурсгал B2. Оршуулгын газрын төв буюу В хэсгийн төв хэсэгт байрлана. Хөрсөн дээр том хавтгай чулууг дугуйруулан орж хийсэн цагариг хэлбэрийн намхан дараас ажиглагдаж байлаа. Малтлагын явцад 0.3м гүнээс 3х2,9м хэмжээтэй, захаараа том хавтгай чулуутай, хүрэн бор өнгийн зууван дугуй хэлбэрийн толбо илрэв. Толбыг дагуулан малтахад 0.5м гүнээстолбоны хэлбэр, хэмжээ өөрчлөгдөж 2.6х2.1м хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэртэйболов. Толбоны дотор талд нүхний хананыг налуулан тавьсан том хавтгай чулуунууд үргэлжлэн гарсаар байсан бөгөөд толбоны төв хэсгээс цөөн тооны жижгэвтэр чулуу гарч байлаа. Чигжээс чулуун дундаас бог малын нурууны 2 ш нугалам илрэв. Цааш малтахад толбоны хэмжээ ахин багасаж 2.2х1.6м боллоо. Малтлагыг цааш үргэлжлүүлэхэд 1.8м гүнд нүхний хойд хэсгээс адууны толгойн яс түүний доор ихэд муудсан бод малын хэмэгт ясныүлдэгдэл илэрлээ. Цааш малтахад 2,2м гүнээс 100х100см, 80х66см, 86х65см хэмжээтэй гурван чулууг зэрэгцүүлэн тавьсан таг илэрснийг авч малтлагыг үргэлжлүүлэхэд 240см гүнээс 180х65см хэмжээтэй модон авс, авсны гадна талаар 40см өндөртэй хавтгай чулуугаар хашлага хийсэн байлаа. Модон авсны тагийг 192х17х4 см, 180х20х4 см хэмжээтэй 2 ширхэг банзаар хийжээ. Авсан дотор хүний эмх цэгцгүй хутгалдсан байлаа. Булшны нүхний толгой тал руу хөндийлж хөмөг гаргаад тэндээ 2 ширхэг

вааран сав богийн 7 нурууны 7 ширхэг нугалам, төл малын хавирганы яс 3 ширхэг, бодын сээрний нугалам 2 ширхэг мөн алтаар хийсэн чимэглэлийн зориулалттай бололтой эдлэлийн үлдэгдэл 4 ширхэг, хазаарын хүрэл товруу 1 ширхэг илэрлээ. Авсны талд, авс чулуун хашлага хоёрын хоорондоос шилэн зүүлт 4 ширхэг, төмөр эдлэлийн үлдэгдэл 1 ширхэг, хос нумын гичир, төмөр эдлэлийн хэсгүүд 6 ширхэг, төмөр зэв, мөсний үлдэгдэл, 5 ширхэг хүрэл гархи мөн 2 ширхэг хүний хавирганы яс илэрч. Малтлагын эцсийн гүн 2.45 м.

Зүрхийн үзүүрийн хүннүгийн дурсгалт газрын булшуудыг нягтарлаар нь А, В, С гэсэн гурван хэсэг болгож болох бөгөөд бид А, В хэсгээс тус бүр 2, нийт 4 булш (А1, А2, В1, В2) малтан судаллаа. А хэсэгт малтсан хоёр булшны эхнийх нь болох А1 булш эрт үед тонуулчдын гарт өртөж ихэд сүйджээ. Булшнаас маш муу хадгалагдсан банзан авсны үлдэгдэл, богмалын цөөн яс, хөөтэй ваарны хагархайнаас өөр зүйл илэрсэнгүй. А2 булш хэдий эрт цагт мөн тонуулчдын гарт өртөж сүйдсэн боловч хүний хэлхээ яс, нумын наалт зэрэг эд өлөг илэрч байлаа. В хэсэгт малтсан хоёр булш мөн эрт үед тонуулчдын гарт өртсөн боловч А хэсэгт малтсан булшнаас бага сүйтгэгдсэн байв.

Хавсралт зураг

Зүрхийн Үзүүрийн Хүннүгийн дурсгалт газар

Дурсгал - А2

Дурсгал - В1

ГУА ДОВЫН ДУРСГАЛТ ГАЗАРТ ХИЙГДСЭН БАЙГАЛИЙН УХААНЫ ТАНДАЛТ СУДАЛГАА БА ШИНЭЭР ИЛРҮҮЛСЭН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛЫН ТУХАЙ.

Г.Эрэгзэн, П.Алдармөнх, С.Энхболд

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, Солонгосын Үндэсний музей хамтран хэрэгжүүлж ирсэн Мон-Сол эрдэм шинжилгээний төслийн хээрийн шинжилгээний анги 2013 оноос Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт орших "Гуадов" хэмээх Хүннүгийн үеийн хотын турийг судлах ажлыг эхлүүлж, 2014, 2015 онд нийтдээ 3 жилийн хугацаанд археологийн малтлага судалгаа хийсэн билээ.

Археологийн малтлага судалгааны үр дүнд Гуа довын дурсгалт газар нь өмнө таамаглаж ирсэнчлэн шороон хэрмээр хүрээлэгдсэн тахилын зориулалттай газар биш болсон. Уг дурсгал нь сүрлэг том, 2 давхар, вааран дээвэр бүхий хаалгатай, олон багана бүхий вааран дээвэртэй саравчит хашаагаар хүрээлэгдсэн болох нь тодорхой болсон юм. Мөн нэмэлт ажиглалт тандалтын үр дүнд уг дурсгалт газрын зүүн өмнөд буланд хүний гараар бүтээсэн хиймэл нуур буюу цөөрөм байсан нь мэдэгдсэн. Тиймээс энэ дурсгалт газрыг бид Хүннүгийн үеийн язгууртан ихэсийн зуны орд өргөө хэмээн таамагласан.

Гэхдээ ийнхүү таамаг дэвшүүлэхэд хэд хэдэн асуудал бүрхэг хэвээр байсан. Энэ нь төв барилгын бүтэц, хэмжээг дахин тодорхойлох ажил хийгдээгүй, мөн хашаан дотор өөр барилга байгууламж бий эсэхийг тодорхойлоогүй, хашааны малтлага хийснээс бусад талууд төстэй бүтэц, зохион байгуулалттай эсэх зэрэг байв. Энэ бүхэнд хариулт өгөхийн тулд бид археологийн малтлага судалгааг үргэлжлүүлэх хийх хэрэгтэй байсан хэдий ч хамтрагч талаас дахин хэдэн жил үргэлжилсэн малтлага хийх сонирхолгүй байсан. Тиймээс бид хэлэлцээд энэ асуудлыг шийдэхэд хамгийн боломжит арга нь байгалийн ухааны тандалт судалгаа хэмээн үзсэн юм.

Энэ удаагийн байгалийн ухааны тандалт судалгааг Тэжон хотод байрлах Солонгосын Геологи, эрдэс баялагийн хүрээлэнгийн судлаачдын тусламжтайгаар гүйцэтгэсэн. Судалгаанд тус хүрээлэнгийн 4 ажилтан оролцсон бөгөөд гео-соронзон, гео-радар, цахилгаан соронзонгийн тандалт гэсэн 3 төрлийн судалгааг хийсэн.

Тандалт хийсэн судлаачдын газар дээр нь бидэнд өгсөн мэдээлэл, зарим нэг хэмжилтийн зураг зэргээс үзэхэд Гуа довын вааран дээвэрт хашаа бүхий хүрээлсэн дөрвөлжин байгууламж нь 4 тал тус бүртээ малтлага хийсэнтэй төстэй хаалгатай, хашааны бүх талууд нь вааран дээвэртэй болох нь мэдэгдсэн. Мөн төв барилгын үндсэн хэмжээг тодорхойлж болж байсан ба цөөрөм хэмээн таамагласан байгууламжийн хөрсний бүтэц байгалийн хөрснөөс харьцангуй нягтралтай байгаа зэргийг мэдэж болохоор байсан. Гэвч тандалт судалгааны баг судалгааны үр дүнг

нэгтгэсэн тайлангаа бидэнд хараахан ирүүлээгүй байгаа тул үүнээс илүү мэдээлэл өгөх боломжгүй байна.

Тандалт судалгаа хийх явцад Гуа довын дурсгалын ойр орчимд байрлах зарим дурсгалыг бүртгэн баримтжуулах ажлыг хийсэн. Гуа довын орчимд хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр, Түрэгийн үеийн тахилын байгууламж зэрэг дурсгалууд бий. Эдгээрээс өмнө нь бүртгэлд хамрагдаагүй зарим нэг дурсгалын талаар товч дурдав.

Тогос уулын тахилын онгон. Сумын төвөөсзүүн хойш 30 орчим км, Гуа довын дурсгалаас баруун хойш 5км орчим зайд орой нь зассан мэт тэгшхэн өвөрмөц тогтоцтой уул байхыг Тогос хэмээн нэрлэнэ. Энэ уулын зүүн урд талын хөндийд Эртний Түрэгийн үед холбогдох том хавтгай чулуугаар хийсэн тахилын онгон байх ажээ. Уг дурсгалыг сумынхан хамгаалж гадна талд нь төмөр хашаа барьсан байна. Харин энэ дурсгалын талаар археологийн ном зохиолд тэмдэглэгдсэн зүйл үзэгдээгүй тул энд зориуд дурдаж судлаачдын хүртээл болгохыг зорив.

Тахилын онгон нь 1.6-1.8м урт, 1.3м орчим өндөр засч янзласан том хавтгай чулуугаар хийсэн тахилын хашлага, түүнээс зүүн өмнө зүгт чиглүүлэн зоосон олон тооны балбал чулуудаас бүрдэнэ. Онгоны ойр орчимд хүн чулуун хөшөө үзэгдэхгүй байна. Тахилын хашлагыг сайтар зассан чулуугаар хийснээс гадна угалзарсан цэцэг, ургамлын дүрст хээ сийлж чимэглэсэн нь босоо үлдсэн хашлагаас харахад тодорхой мэдэгдэнэ. Уг нь хашлага чулуу 4 байх ёстойгоос газар дээрээ 3 нь үлджээ. Хашлагын төв хэсгийг ухаж сэндийлсэн тул хашлагын 1 нь л босоо үлдэж нөгөө 2 нь унасан байдалтай байв. Энэ дурсгалаас зүүн тийш 30 орчим м зайд цагариг хэлбэрийн нэгэн чулуун дарааст булш байгаа нь сонирхол татна.

Шар дэнжийн дурсгал. Гуа довын дурсгалаас өмнө тийш 20 орчим км зайд Хэрлэн голын баруун эргийн дэрс ургасан намгархаг газартай залгагдах дэнж хэсгийг Шар дэнж хэмээнэ. Энэ газрын баруун талаар баруун хойноос зүүн өмнө тийш чиглэлтэй үргэлжилсэн урт гүвээ байх бөгөөд энэ гүвээний дунд хирд сум явах авто замын урд талд 2м гаруй өндөр, 30м орчим голчтой дугуй хэлбэрийн өндөр чулуун байгууламж байна. Уг байгууламжийг бид эртний булш байж магадгүй хэмээн таамагласан бөгөөд сайн ажиглавал чулуун байгууламжийн захаар өрлөг маягтай үйлдсэн чулууд мэдэгдэнэ.

Уг дурсгалаас зүүн тийш нам дор хэсэгт олон тооны эртний чулуун байгууламжуудыг илрүүлсэн. Эдгээр нь хэлбэрийн хувьд дугуй, дөрвөлжин 2 янз байна. Дугуй нь 3-4 м орчим голтой байна. Ийм дугуй хэлбэрийн дурсгал 81 байгаагаас дийлэнх нь хүннү булштай төстэй голдоо чулуугүй боловч зарим нь битүү чулуун дараастай юм. Дугуй хэлбэрийн чулуун байгууламжуудын дунд таруу байрлалтай 18 тооны дөрвөлжин хэлбэрийн чулуун байгууламжийг бүртгэсэн. Эдгээр нь хэмжээний хувьд 1 м орчим харьцангуй жижиг хэмжээтэй. Эдгээр дурсгалуудын холбогдох он

цагийг одоогоор тодорхой хэлэх боломжгүй байна. Харин энэ дурсгалаас холгүйхэн газарт 14 тооны Түрэгийн үеийн тахилын хашлага байрлана.

Авдар хадны дурсгал. Гуа довын дурсгалаас өмнө тийш 33км зайд тус сумын Улаан-Ухаа багийн нутагт Баян Эрхэт уулын ард Авдар хэмээх хадтай уулын ойр орчимд олон тооны, хэд хэдэн цаг үед холбогдох дурсгал байна. Бид энэ газарт хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүр 5, дөрвөлжин булш 14, цагариг хэлбэрийн чулуун дарааст хүннү булш 1, он цагийг нарийн тодорхойлох боломжгүй дугуй хэлбэрийн чулуун дарааст булш 12, Түрэгийн үеийн дөрвөлжин хэлбэрийн тахилын хашлага 2 зэрэг нийт 44 дурсгал бүртгэн тархацын зургийг үйлдсэн.

1-р зураг. Гео соронзонгийн тандалт хийж буй нь

2-р зураг. Гео радарын тандалт хийж байгаа байдал

3-р зураг. Цахилгаан соронзонгийн тандалт судалгаа хийж буй байдал

4-р зураг. Тогос уулын Түрэгийн тахилын онгоны чулуун хашлага

5-р зураг. Шар дэнжийн эртний булшны агаарын зураг



6-р зураг. Шар дэнжийн орчимд бүртгэсэн эртний булшнууд

7-р зураг. Авдар хадны орчимд бүртгэсэн дөрвөлжин булш

8-р зураг. Авдар хад орчимд бүртгэсэн хиргисүүр

МОНГОЛ-КАЗАХСТАНИЙН ХАМТАРСАН "ШИВЭЭТ УЛААНЫ АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛЫН МАЛТЛАГА СУДАЛГАА" ЭКСПЕДИЦИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

Д.Цэвээндорж, А.Энхтөр, Д.Кыдырали, Б.Напил,
С.Далантай, К.Умиров, Ц.Буянхишиг, Н.Мөнхбат

2016 ОНЫ ХАЙГУУЛ БОЛОН МАЛТЛАГА СУДАЛГАА

Зорилго. Шивээт-Улаан хайрханы төв хэсэгт байрлах гол руу түрж орсон хошуу бүхий намхавтар уулын орой дээр эртний нүүдэлчдийн түүхэнд холбогдох нэгэн цогцолбор дурсгал байна.

Энэхүү хамтарсан экспедицийн археологийн малтлагын гол зорилго нь "Шивээт Улаан" тахилын онгон цогцолборын бүтэц, зохион байгуулалтыг нарийвчилан судлах явдал юм. Үүний тулд цогцолборын өмнөд үүдэн хэсгээс эхлэн хойд ханан хэсэг хүртэлх талбайн дагуу археологийн малтлагын ажлаа гүйцэтгэх явдал билээ.

Судалгааны ажлын хугацаа, бүрэлдэхүүн.

Судалгааны баг 07-р сарын02 - 08-р сарын 28-ний хооронд 58 хоногийн хугацаагаар ажилласан. Манай төслийн баг нь малтлага судалгааны ажлаа хийхийн зэрэгцээ тус сумын нутгийн зарим нэгэн газруудыг сонгон авч хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн юм. Малтлага судалгааны ажлын амралтын өдрүүдэд хайгуулын ажилд явах замаар цаг хугацааг зохицуулсан болно.

Судалгааны багт Монголын талаас Шинжлэх ухааны тэргүүлэх ажилтан, доктор, дэд профессор А.Энхтөр \Ph.D\ахлан ажиллсан. Зөвлөх археологчоор Түүх, археологийн хүрээлэнгийн Археологийн судалгааны төвийн захирал доктор профессор Д.Цэвээндорж ажилласан. Мөн судалгааны ажлын бүрэлдэхүүнд эрдэм шинжилгээний ажилтан С.Далантай, Ц.Буянхишиг, Н.Мөнхбат, туслах ажилтнаар МУБИС-ийн түүхийн ангийн 12 оюутан Казахстан улсын талаас Казахстан дахь Олон Улсын Түрэг Судлалын Академийн доктор Д.Кыдырали, Б.Напил, К.Умиров, нар оролцон ажиллав. Судалгааны ажлыг хайгуул болон малтлага судалгаа гэсэн үндсэн хоёр чиглэлийн хоёр улсын эрдэмтэн судлаачид 2 сарын турш хамтран ажиллаа.

Хайгуулын арга зүй.

Хайгуул судалгааны ажилд археологийн шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг тухайлсан газрыг сонгон авч хайгуул хийдэг сонголтын зарчмыг ашиглан хайгуул судалгааны ажлыг хийлээ. Ингэхдээ тус сумын нутагт орших эртний түүхт Хануй голын ойролцоох газруудыг сонгосон юм. Хануй голын дунд хэсгийн Цагаан олом, Их Хануйн эхэнд болон адагт цутгах Балигийн гол зэрэг газруудад хайгуулын ажил хийж

хүрлийн үеэс нүүдэлчдийн төрт улсуудын түүхэнд холбогдох Хиргисүүр 2 ш, Дөрвөлжин булш 6 ш, буган чулуун хөшөө 8 ш, тамга тэмдэг19 ш, хүннү булш 2 ш, нэг газарт 16 ш хадны зургийг бүртгэн баримжуулалт хийлээ.

Мөн энгийн самналт, автомашинаар тойрон хайх аргыг хэрэглэв. Илэрч олдсон булш, хадны зургийг археологийн бүртгэлийн стандартын дагуу хийж гүйцэтгэв.

Малтлага судалгааны арга зүй.

Малтлага судалгааны ажлыг Шивээт улааны цогцолбор дурсгалт газрыг бүтэн талбайгаар нь 120х60 хэмжээтэй хүрээ татаж 10м хэмжээтэйгээр торлон өрөгт хувааж урд талаас нь ABCDFE, зүүн талаас 1,2,3,4,5,6,7,8,9,10,11,12 хэмээн дугаарлаж малтлагын ажлыг явуулсан. Малтлагын ажлыг фото болон гэрэл зургаар баримтжуулалт хийсэн болно. Мөн сүүлийн үеийн тэвшилтэд технологи болох дрон ашиглан агаараас 100-400м өндрөөс фото зураг авч, ведио бичлэг хийж баримтжуулсан юм.

Шивээт Улаан хэмээх эртний нүүдэлчдийн түүхэнд холбогдох цогцолбор дурсгал

"Шивээт улаан" хэмээх олон хүн ба амьтадын дүрслэлтэй чулуун хөшөө, тамгатай гэрэлт хөшөө бүхүй дурсгал байна. Уг дурсгал нь Түрэг, Уйгурын үед (VII-IX зуунд) хамаарагдах хаад язгууртаны тахилын онгон цогцолбор юм.

Газарзүйн байршил, онцлог

Уг дурсгал Монгол улсын Булган аймагийн Баян Агт сумын нутагт Хануй, Хүнүй голын бэлчирт "Шивээт улаан " хэмээх улаан хүрэн өнгийн боржин чулуун тогтоцтой, зүүнээс баруун тийш сунаж тогтсон, далайн төвшинээс 1340 метрт байрласан бөгөөд газарзүйн солбилцолын хойд өргөрөгийн 48°47'53.27" дорнод уртрагийн 102°00'19.35" солбицолд оршдог.

Хануй гол нь Архангай аймгийн Чулуут сумын Хангайн нурууны Эгийн даваа, Модот уул оргилоос эх аван урсдаг.

Хүнүй гол нь Архангай аймгийн Өндөр улаан сумын Зүрх уулнаас эх авч, Шивээт улааны зүүн өмнөд талд Хануй голтой нийлэхдээ км урсдаг, цаашид Хүнүй гол нь зүүн өмнөд зүгээс урсч, Хануй гол нь баруун урд зүгээс баруун хойд зүгийг чиглэн урсан ирж нийлж Их Хануй гол болж 70км урсан Сэлэнгэ мөрөнд цутгадаг.

Шивээт улаан уулын баруун хойд талд нь Цагаан овоо, хойд талд нь Ихэр уул бараалана. Улаан уулын зүүн хормойгоор Их Хануй гол өроож урсдаг. Улаан уулын зүүн талд нь Хануй голын цаад эрэгт Оорцог уул, Хуст овоо нэртэй модтой уул байна. Харин Улаан уулын баруун талд нь Хэрэмтийн нуруу хэмээх уул байна. Хануй, Хүнүй голын өргөн талыг Хануй, Хүнүй голын бэлчирийн тал хэмээдэг. Улаан уулан дээрээс дөрвөн зүгт 20 км харах боломжтой өндөрлөг юм. Хоёр голын бэлчирийн амыг хаасан

мэт зүүнээс баруун тийш сунаж тогтсон боржин уул юм. Улаан уулын чанх урд талд нь Өндөр уул хэмээх уул байдаг. Улаан уулаас 12 км зайд Шарга нуур хэмээх давстай нуур байдаг.

Шивээт улааны эргэн тойронд галт уулын хүрмэн (базальт) чулуугаар бүтсэн байдаг. Хануй гол нь энэхүү өнө эртний галт уулын ан цавыг даган түргэн урсдаг гол юм.

Ургамалын бүрхэвч нь хойд хээр талын бүсэд ургадаг хялган, агь, ганга, монгол өвс голчилон ургадаг юм. Өндөр ууланд бургас, шинэс, боролзогоно, нохойн хошуу, хус ургадаг байна. Энэ бүс нутагт ойт хээр, тал хээрийн тарвага, зурам, дорго, өмхий хүрэн, хярс, мануул, чоно зэрэг араатан амьтад, өвсөн тэжээлт гөрөөс, буга, гахай, нохой зээх, халиу, суусар зэрэг амьтад байдаг.

Хануй голын усанд тул, зэвэг, шивэр хадран, алган, цуурхай, гутаарь, цулбуурт загастай байдаг.

Ойт талын хээрийн бэдчээрт хонь, ямаа, адуу, үхэр, сарлаг бэлчээрлэдэг.

Хануй голын бэлчирт эрт балар чулууны зэвсгийн үеэс хүн амьдаран суудаг байсан бөгөөд палеолитийн үеийн хүмүссийн ул мөр тодордог бөгөөд энэ нь маш эртний нутагыг харуулдаг бөгөөд далан км газарт Цагаан голын чулуун зэвсгийн суурин байдаг. Хүрэл зэвсгийн үеийн буган хөшөөд, дөрвөлжин булш, хиргисүүр олон тоогоор бүртгэгдсэн байна. Буган чулууны ихэнх загварт урлагийн байдлаар дүрсэлсэн байна. Үүнд Агуйт уулын буган хөшөө, Шивээт улааны буган хөшөө орж байна. Хүрэл зэвсгийн сүүл төмөр зэвсгийн түрүү үед хамаарах цагирган, дөрвөлжин, дугуйхүрээтэй, дөрвөн шонтой булшнууд олон буй. Үүний дараа Хүнүй голын сав дахь Хүннүгийн эзэнт гүрэний үед хамаарах Гол мод-1, 2 дурсгалуудыг онцлон дурдаж болно.

Шивээт улааны дурсгалд ойр Могойн шинэ ус, Уртын шуудуу зэрэг тахилын онгон, Бийбулаг 1,2,3 зэрэг хот балгас, Хар хул хааны балгас, олон тооны хүн чулууд зэрэг эртний түрэг, уйгурын үеийн дурсгалууд байдаг.

Судалгааны ажлын товч тойм

"Шивээт Улаан" дурсгалыг анхлан 1912 онд Финляндын эрдэмтэн Густав Иохан Фон Рамстедт олж илрүүлэн дэлхийн эрдэмтдийн сонорт хүргэжээ. Г.И. Рамстедт дурсгалын ерөнхий дэвсгэр зураг, сэргээсэн байдалын болон хүн, амьтны чулуун хөшөөд, тамгатай гэрэлт хөшөөний талаар гэрэл зураг аван, зарим гар зургуудыг үйлджээ. Тухайн үед зарим хүн чулуудын толгойн хэсгүүд нь одоогийн байршилдаа байсаныг гэрчилэх гэрэл зургууд нь түүний судалгааны өгүүлэлүүдэд хэвлэгдсэн байдаг. Г.И.Рамстедтийн энэхүү анхны судалгаа нь арвин мэдээллийг хадгалж байдгаараа их үнэ цэнэтэй юм. Түүний дараа Түүний дараа Шивээт Улааны дурсгалыг 1927 онд буриад эрдэмтэн Балжи Бамбаев газар дээр нь үзэж тэмдэглэсэн байна. Мөн онд нутгийн ард Дамдинсүрэн уг дурсгалын тухай тусгай захидалыг Судар

бичгийн хүрээлэнд ирүүлсэн байдаг. 1956 онд Ц.Доржсүрэн уг дурсгалыг үзэн, гэрэл зураг аван, зарим гар зураг үйлдэн тусгайлан судласан бөгөөд "Шивээт Улаан гэдэг юу вэ?" хэмээх өгүүлэл нийтлүүлсэн юм.

1976 онд Түүх, археологийн хүрээлэнгийн археологч эрдэмтэн Д. Цэвээндорж Шивээт улааны байгууламжийн дэвсгэр зурагыг үйлдсэн юм. Мөн онд Монгол Зөвлөлтийн түүх соелын хамтарсан экспедициийн (МЗТСХЭ) В.В. Волков, С.Н. Кореневский нар ч байгууламжийн дэвсгэр зургын талаар судалгаа хийсэн байна . 1977 онд С.Г. Кляшторный, С. Харжаубай, 1996 онд В.Е. Войтов , 1997 онд Д. Баяр, В.Д. Кубарев, 2005 онд Б.Напил, 2007 ба 2015 онд З.Самашев, Л.Цэвээндорж, Д.Баяр, А.Энхтөр. А.Онгар, Г.Киясбек, А. Мирхат, Б.Напил, 2015 онд Д. Кыдырали,Г.Бабаяров нарын судлаачид тусгайлсан судалгаануудаа хийсэн байна.

<u>Цогцолбор дурсгалын зохион байгуулалт болон малтлага судалгаа</u>

"Шивээт улаан" тахилын онгон цолцогбор нь уулын оройн хадыг тэгшилэн засаж түүн дээр өмсгөж барьсан бөгөөд зүүнээс баруун тийш сунасан гонзгой дөрвөлжин зохиомжтой хүрмэн чулуун хэрэм бүхүй барилга байгууламж юм. Уг байгууламжийн хэмжээ нь 120х45 метр. Тус цогцолборыг хэрмийн хаалга ба гэрэлт хөшөөний суурийн тавцан, хаалга, төв байгууламж хэмээн хуваан үзэж болох юм. Тус байгууламжийн хэрмийн хананд нэжгээд цонж байна. Дөрвөн буланд нэг нэгээр, хойд хананд нэг, зүүн болон баруун хананд гурав гурваар нийт 11 цонжтой байна.

Байгууламж нь төв дундуураа хойд ба өмнөд хоер хэсэгтэй болж хуваагдсан бөгөөд хойд хэсэг нь өмнөд хэсгээсээ 50-60 см өндөртэй юм. Энэхүү өндөрлөг нь уг байгууламжыг хоер хувааж байгаа юм. Энэхүү байгууламж нь зүүн зүгт хандсан хаалгатай юм. Хаалганы өмнө талд дөрвөлжин зохиомжтой тавцан нь хүрмэн чулуугаар өрсөн. 6,60х 6,50 метр хэмжээтэй, Энэхүү тавцангийн дээр нь тамгатай гэрэлт хөшөөний суурь хүрмэн чулуу байна. Хөшөөний суурийн хэмжээ нь 120х91х50см.

Байгууламжийн өмнөд хэсэг буюу зүүн талаас нь үзвэл чулуун өрлөгтэй тавцан түүнээс 4 метрийн зайд хаалга байна. Өмнөд хэсэгт байгаа хэрмийн хаалганы өргөн нь 4,96 метр юм. Хаалганы багана суурилах хэрмийн хана нь гадагш түрэн гарсан зориудаар бэхэлсэн чулуун өрлөгтэй юм. Өрлөгийн урт нь 6,95 метр, зузаан нь 2,1 метр юм. Түүнээс дотогш 17,9х4,58 см өргөнтэй баруун, зүүн талд хуваагдсан чулуу хорго байна. Энэ нь тахилгын үед зан үйлийн бэлтгэл хийдэг тусгай талбай бололтой юм. Энэ талбайн төв дунд тусгайлан шатлан өрсөн өрлөг байгаа бөгөөд талбайн төв хэсэгрүү орох зам байна.

Түүнээс цааш хоргоны шатан дээр гармагц хаалганы харалдаа тэгшхэмд хоорондоо 6,24 метр зайд дөрвөлжлөн зассан 10см өндөртэй чулуун өрлөг байгаа нь

хөшөөний суурь байсан гэж үзэж болохоор байна. Хаалганы ханын гадна ,дотно хатачинд баруун, зүүн талд дөрвөлжин суурь нийт 6 суурь байгаа юм. Эдгээр нь арслан, хонь мэт амьтадын дүрст чулуун хөшөөдийн тусгай сууриуд байсан гэж болно. Одоо тамгатай гэрэлт хөшөө, хүн ба амьтаны дүрстэй чулуун хөшөөд нь байгууламжийн дунд хэсэгт цуглуулан бариулсан байдалтай байна. Үүнийг 2009 онд Монголын Соелын өвийн төвөөс Баян Агт, Хайрхан сумаас, Булган, Эрдэнэт хотоос тусгайлан цуглуулж дурсгалын газарт нь байрлуулсан юм.

Байгууламжийг хоер хуваан заагласан 50 см өндөртэй чулуун өрлөг нь баруун болон зүүн хана хүртэл 35,30 метр үргэлжилэн хоёр цонжтой залгана. Өмнө талын тэгш талбайг анх байгалийн хад чулууг тэгшилж хонхор газруудыг чулуугаар дүүргэж тэгшилсээр хоёр талын хэрмийн ханатай тэнцүү тэгш тавцан болон засагдсан. Хойд хэрмийн доторхи хэрэм мөн адил байдлаар баригдаж өмнөд хэсгийн хэрмээс даруй 60 см өндөрт байгаа болно.

Төв байгууламжийг өмнө нь олон удаа гол хэсгээс нь малтан тоној сүйтгэсэн 6 нүх оромны үлдэгдэл тод ажиглагдаж байна. Одоо байгаа төв байгууламжийн дотор тал нь тогоо мэт хонхойсон бөгөөд 80 см орчим гүн, баруун хойд, хойд талын хана үгүй болж тоногдсон нь ажиглагдана. Эндээс хамгийн ойрын сүйтгэсэн жишээ нь 1970 оны үед сангийн аж ахуйн үтрэмийн байшинг байгуулахад хавтгай хүрмэн чулуудыг нь олноор зөөн авсан явдал юм. Энэ мэт олон удаагийн эвдэн сүйтгэх явцад төв байгууламжийн болон баруун хойд хэрмийн хэсгүүд ихээр сүйдгэгдсэн байна. (*Зураг 1.1*)

Малтлага судалгаа: Мөн төслийн багийн ажлын үндсэн чиглэл болох "Шивээт Улаан" цогцолбор дурсгалт газарт дараах байдлаар малтлага судалгааг явуулсан юм. Хэрмийн гадна талын хөшөө чулууны суурь, урд хэрмийн үүдний хэсэг, хойд хэрмийн урд хэсэг, гол байгууламж хэмээн нийтдээ 23 өрөгт малтлага судалгааны ажил хийж гүйцэтгэлээ.

Малтлага судалгааны ажлын үр дүнд дээрх байгууламжийн өмнөд хэсэг буюу зүүн талаас нь үзвэл чулуун өрлөгтэй тавцан байрлах ба түүнээс 4 метрийн зайд хаалга байгааг тогтоолоо. Өмнөд хэсэгт байгаа хэрмийн хаалганы өргөн нь 4,96 метр юм. Хаалганы багана суурилах хэрмийн хана нь гадагш түрэн гарсан зориудаар бэхэлсэн чулуун өрлөгтэй юм. Өрлөгийн урт нь 6,95 метр, зузаан нь 2,1 метр юм. Түүнээс дотогш 17,9х4,58см өргөнтэй баруун, зүүн талд хуваагдсан чулуу хорго байна. Энэ нь тахилгын үед зан үйлийн бэлтгэл хийдэг тусгай талбай бололтой юм. Энэ талбайн төв дунд тусгайлан шатлан өрсөн өрлөг байгаа бөгөөд талбайн төв хэсэгрүү орох зам байна. (Зураг. 9,10)

Түүнээс цааш хоргоны шатан дээр гармагц хаалганы харалдаа тэгшхэмд хоорондоо 6,24 метр зайд дөрвөлжлөн зассан 10см өндөртэй чулуун өрлөг байгаа нь

хөшөөний суурь байсан гэж үзэж болохоор байна. Хаалганы ханын гадна ,дотно хатачинд баруун, зүүн талд дөрвөлжин суурь нийт 6 байгааг шинээр илэрүүллээ.

Байгууламжийг хоёр хуваан заагласан 60см өндөртэй чулуун өрлөг нь баруун болон зүүн хана хүртэл 35,30 метр үргэлжилэн хоёр цонжтой залгаж байгаа юм. Өмнө талын тэгш талбайг анх байгалийн хад чулууг тэгшилж хонхор газруудыг чулуугаар дүүргэж тэгшилсээр хоёр талын хэрмийн ханатай тэнцүү тэгш тавцан болон засагдсан байна. Хойд хэрмийн доторхи хэрэм мөн адил баригдаж өмнөд хэсгийн хэрмээс даруй 60см өндөрт байгаа болно.

Өмнө талын хэрмээс хойд талын хэрэм орох тусгай хоер зам зассан байна. Малтлагын явцад хэрмийг заагласан хэрмийн өрлөг нь зүүн талруугаа нилээд нуран унасан нь ажиглагдаж байна. Энэ нь байгаль болон хүний явдлаас хамаарсан бололтой юм. энэхүү зассан зам нь хойд хэсэгт нэвтрэх баруун, зүүн талд тэгш налуу хавтгай гурваас дөрвөн үе чулуугаар өрсөн налуу зам болно.*(Зураг.8)*

Эндээс төв хэсгийн байгууламжруу ороход түүний өмнө голлосон байдалтай мөн 2,18х1,85 м хэмжээтэй тэгш дөрвөлжин өрлөгтэй тавцан байгуулсан нь тодорхой болсон. Магадгүй энэ тавцан дээр ямарваа нэгэн гэрэлт хөшөө эсвэл уг байгууламжийн эзний хөрөгтэй хүн чулуу суурилуулсан байсан агаад тэрхүү хөшөө нь алга болсон бололтой юм. Гэвч цаашдын бүрэн хэмжээний малтлагаар байгууламжийн бусад хэсгээс ч олох магадлал байгааг дурдвал зохино.

Төв байгууламжийг өмнө нь олон удаа гол хэсгээс нь малтан тоножсүйтгэсэн 6 нүх, оромны үлдэгдэл тод ажиглагдана. Одоо байгаа төв байгууламжийн дотор тал нь тогоо мэт хонхойсон. Баруун хойд, хойд талын хана үгүй болж тоногдсон нь мэдэгдэнэ.

Төв байгууламжийн өмнөд хэсгийг дөрвөн сектороор (D8-1,D8-2,C8-1) малтахад чулуугаар 1,5 м өндөр дөрвөлжин суурь засаж түүний дээр байгууламжийг найман талтай, одоогийн хадгалагдаж үлдсэн байдлаар хануудын тал бүрийн урт нь 7 метр хэмжээтэй,4 м өндөр ханатай чулуун ханатай, энэ жилийн үр дүнд тогтоолоо. Мөн найман талын тал бүрийг саарал өнгийн шаврарр шавж гадна талаар нь цагаан өнгийн шохойгоор зарим газар нь 1,5 см зузаанаар шохойдон өнгөлсөн байна. Магадгүй зарим газраар нь хар өнгийн будгаар хүрээ татаж чимэглэсэн болох нь олдсон шохойноос илт харагдаж байна. Ханын өрлөг нь дотогшоогоо 18-25 орчим хэм налуу. Байгууламжийн налуугаар тооцоолон үзвэл уг байгууламж нь анхандаа 14-15 м өндөртэй байсныг тогтоож болох юм. (Зураг 1.2-1,2,3)

<u>Хөшөө чулууд</u> (Зураг.4-7,11)

- *Хүн чулуун хөшөө:* Гол хэрмийн дунд байх найман талт байгууламжийн өмнө талд хоёр ширхэг хүн чулуу бий. Эхний хүн чулууг хөх саарал өнгөтэй хүрмэн чулуугаар урласан хүн чулууг урд зүгт харуулан байршуулжээ. Тус хүн чулууг бүсэлхий хүртэл газарт суулгасан. Цээжин хэсэгт хөө хуяг өмсүүлсэн бололтой дугуй цэг гарган

сийлбэрлэсэн нь мэдэгдэнэ. Хоёр гарыг тохойгоор нь нугалан цээжиндээ цөмбөгөр сав бариулсан. Ингэхдээ зүүн гараар савны ёроолоос атгуулсан байх бабаруун гарын эрхий хурууг цомны хажуугаас түшүүлж бусад хуруунуудыг зүүн гарын шууны дээр тавьснаар дүрсэлсэн байна. хөө хуягны дотор ташуу захтай хувцас өмссөн ажээ. Бэлхүүсээр гурван зураастай бүс дүрсэлсэн байна. Энэ нь даавуун бүсийг илэрхийлсэн байж магадгүй юм. Хуягны энгэрийг сав барьсан гараар хаасан бололтой мэдэгдэхгүй. Өндөр нь 48 см, цээжний өргөн 43 см, бэлхүүсийн өргөн 32 см хэмжээтэй. Баруун гарын бугалган дээр ямар нэг зүйлийг тэмдэглэсэн байж магадгүй тэмдэгтүүдтэй. Энэ нь чулууг цуулж засах явцад үүссэн зураасууд ч байж магадгүй.

- *Хүн чулуун хөшөө:* Ертөнцийн зүгээр хойд зүгт харуулсан. Хөх саарал хүрмэн чулууг түүхий эд болгон бэлтгэсэн. Хоёр гараа тохойгоороо нугалан ханцуйндаа хийж цээжиндээ байршуудсан. Ташуу энгэртэй хувцас өмссөн байна. Хувцасны гадуур цээживч??? өмсүүлснээр дүрсэлжээ. Тус хувцас хоёр эгнээ хагас дугуйруулан хөвөөлсөн ирмэг мэдэгдэнэ. Зүүн гарын бугалган дээр ташуу болон хөндлөн зураас бүхий тэмдэгтүүдтэй. Энэ нь чулууг засаж янзлах явцад үүссэн байж болох талтай.
- *Хүн чулуун хөшөө:* Урд хэрмийн хойд захад байрлана. Хөх саарал өнгөтэй хүрмэн чулуугаар бэлтгэсэн. Толгой байхгүй, ташуу захтай, шулуун энгэртэй хувцас өмссөн. Энгэрийг товгор зураасаар тэмдэглэсэн. Гар мэдэгдэхгүй.
- *Хүн чулуун хөшөө:* Хөх саарал өнгөтэй хүрмэн чулуугаар урласан. Гурвалжин захтай, захаа хоёр тийш нугалсан урт хувцас өмсүүлэн дүрсэлжээ. Өргөн бүс дүрсэлсэн. Баруун гараа тохойгоороо нугалан энгэртээ хундага барьсан ажээ. Зүүн гараа ташаандаа авч илдний бариулаас атгасан байна. Ингэхдээ гарыг тохойгоороо эргүүлэн буруу харсан мэтээр бариулан дүрсэлсэн бололтой юм. Ташаанд нь үзүүр хэсгээрээ бага зэрэг махир илд дүрсэлсэн. Баруун ташаандаа нарийн үзүүртэй хутга зүүсэн ажээ түүний хажууд хэт дүрсэлсэн нь мэдэгдэнэ. Хөл мэдэгдэхгүй.
- *Хүн чулуун хөшөө:* Хөх саарал өнгөтэй хүрмэн чулууг түүхий эд болгон ашигласан. Дэрэвгэр гурвалжин захтай задгай шулуун энгэртэй хувцас өмссөн байна. Захаа хоёр тал руу нь нугалсан байна. Хоёр гараа тохойгоороо нугалан цээжин хэсэгтээ цом бариулсан ажээ. Буруу харсан хувцас өмсөж дөрвөлжин аралтай бүс бүсэлсэн. Дээлэн дотуур дугуй захтай хувцас өмссөнөөр дүрсэлжээ. Ардаа шилтэй малгайтай байсан бололтой малгайн шилний хэсэг үлджээ. Толгой байхгүй.
- *Хүн чулуун хөшөө:* Толгой байхгүй. Хөх хүрмэн чулуугаар бэлтгэсэн. Захаа хоёр тийш нугалсан шулуун энгэртэй хувцас өмссөн байна. баруун ташаандаа нарийн үзүүртэй хутга зүүсэн. Түүний хэжууд хэт дүрсэлсэн. Бүсэнд тойруулан 4 ширхэг хавтага унжсан нь мэдэгдэнэ. Цээжин хэсэг байхгүй болсон.
- *Хүн чулуун хөшөө:* Хөх саарал хүрмэн чулуугаар бэлтгэсэн. Толгой байхгүй. Зүүн гараа дээш өргөн дээлээ ханцуйлах маягаар дүрсэлсэн бололтой юм. Гарын алга тэр чигтээ

хугарч алга болсон байна. Баруун гарыг унжуулан дүрсэлсэн боловч шууны талаас алга хүртэл хугарчээ.

- *Хүн чулуун хөшөө:* Хөх саарал хүрмэн чулуугаар урласан. Толгой байхгүй. Хоёр тал руугаа нугалсан задгай энгэртэй хувцас өмссөн. Өргөн бүстэй. Бүсэндээ 6 ширхэг хавтага зүүсэн. Хоёр гараа тохойгоороо нугалан цээжин хэсэгтээ цүлхэгэр бөөртэй сав барьснаар дүрсэлсэн ажээ. Ингэхдээ зүүн гарын эрхий, долоовор хурууг дэлгэн бусдыг нугалан савтай зүйлийн ёроолоос барьснаар дүрсэлсэн. Зүүн талдаа хутга зүүсэн.
- *Хүн чулуун хөшөө:* Хар хөх боржин чулуугаар дүрсэлсэн толгойгүй хүн чулуун хөшөө байна. Хоёр тийш нугалсан захтай шулуун энгэртэй хувцас өмссөн. Өргөн бүс бүсэлсэн. Зүүн ташаандаа хавтага зүүсэн ажээ. Дээлийн нугалааг маш сайн гаргасан. Хоёр хажуугийн нугалааг зураасаар тэмдэглэсэн. Хоёр гараа тохойгоороо нугалан ханцуйндаа хийж элгэндээ тэвэрсэн байдалтай дүрсэлжээ.
- *Шинээр олдсон хүн чулуун хөшөө.* Галт уулын гаралтай хөх өнгөтэй хүрмэн чулууг бүтэн талбайгаар нь засаж бэлтгэсэн. Хүн чулууны толгойн хугарсан бөгөөд хоёр тал руугаа нугалсан өргөн захтай шулуун энгэртэй дээлтэйгээр дүрсэлсэн амой. Захны нугалсан хэсгийн хоёр үзүүрт товгор бөөрөнхий товч урласан нь мэдэгдэнэ.Хоёр гараа холбон ханцуйлан цээжин тушаа нааж барьсан байна.Урт ханцуйн тунарсан хэлбэрийг нарийн ур хийцээр дүрслэн урлажээ. Бүсэнд ямар нэгэн чимэглэл байхгүй юм. Бүсний үзүүрийг ар талд хавчуулан нугалсан нь тод харагдана. Үүнээс үзвэл хүүхэд бололтой. Хэмжээ нь.....?
- *Арслан дүрст чулуунхөшөө:* Энэ чулуун хөшөөг саарал хүрмэн чулуугаар цоолборлон цохиж хийсэн байна. Хэмжээ нь : см. Арслангийн дүрийг хойд хөл дээрээ оцойн суусан байдалаар дүрсэлжээ. Арсланг амаа ангайлган сийлбэрсэн бөгөөд түүний шүд нь тодорхой харагдана. Түүний зогдорийн хоер шанааг хүзүүний тус газарт бодитойгоор дүрсэлсэн байна. Арслангийн суудал байдал нь цээжээ төвхийлгэн толгойгоо гэдийлгэсэн сүр бараатай юм. Нүдийг томоор , чихийг нь хойш улмайлган дүрсэлсэн. Арслангийн хамар хошуу болон зүүн урд талын шилбэний хэсэг нь хугарч унасан байна. Арслангийн эрүүний доорх сахал нь гурвалжин хэлбэртэй хүзүүг дагуулан дүрсэлсэн байна. Арслан хөшөөний суурийг их биенээс нь залгуулан дөрвөлжин хэлбэртэй хийсэн нь 12 см өндөртэй байна.
- *Арслан дүрст чулуун хөшөө:* Энэ арсланг мөн адил хүрмэн чулуугаар цоолборлон хийсэн агаад цээж төвгөр, толгой гэдгэр, урьд хөл нь бахим том цээж төвгөр хүчирхэг , хойд хөл дээрээ оцойн суусан байдалтай. Арслангийн хумс тахимыг тод сүүлийг ар нуруундаа шийдэж тавьсан байдалтай, дүрсэлжээ. Арслангийн зүүн гуяан дээр "Янгир" дүрст тамгыг сийлжээ. Арслангийн нүд хөмсөгийг тод дүрлэгэр байдалтай дүрсэлсэн агаад чих нь нүдний дээд талд хагас босоо байдалтай, суурийг нь 10 см өндөртэй дүрсэлсэн байна.

- *Арслан дүрст чулуун хөшөө:* Энэ чулуун хөшөөг саарал хүрмэн чулуугаар цоолборлон цохиж хийсэн байна. Хэмжээ нь : см. Арсланг хойд хөл дээрээ оцойн суусан байдалтай дүрсэлсэн Арслангийн толгой, зогдорыг маш тод, олон салаа нарийн үзүүртэй товойлгон дүрсэлсэнээр онцлог юм. Чих нүдийг нэг түвшинд, хөмсөг нүдийг тод сийлсэн. Арслангийн эрүүн доор нь гурвалжин хэлбэртэй сахалыг тод товойлгосон байна. Нуруун дээрээр сүүлээ агссан байдалтай. Урд хойд хөлийн хумс үеийг маш нарийн товойлгосон. Арслангийн сэлдийг бодитой дүрслэсэн агаад толгойн том, хоер төмсөгийг тод дүрсэлсэн байна. Арслангийн цээж нуруу хэсэгт 1,5см зайтай нарийн дүрсэлсэн нь түүнийг хуягласан байдалтай харагдуулана. Доод суурь дөрвөлжин см хэмжээтэй байна.
- *Арслан дүрст чулуун хөшөө:* Хөх саарал хүрмэн чулууг бүтэн талбайгаар нь цоолборлон засаж дээрх дурсгалыг бүтээсэн бөлгөө. Хойд хоёр хөл дээрээ оцойн суусан байдлаар урласан байна. Хоёр чихээ соотойлгон мөлийлгөж амаа ангайн архирсан байдлаар сийлбэрлэсэн. Ингэхдээ арслангын шүдийг тодоор дүрслэхийн сацуу эрүүн доор нь үзүүр хэсэгтээ шовхрон нарийссан урт гурвалжин сахалыг дүрсэлсэн нь тод харагдана. Арслангийн хоншоор хугарсан. Хүзүүний зүүн хэсэгт 4 ш, баруун талд 5 ш, угалзран эргэсэн өтгөн сагалгар зогдорыг гоёмсогоор урласан буй. Урд хоёр хөлийн баруун талынх нь 6, зүүн нь 5 сарвуутай юм. Сүүл мэдэгдэхгүй. Өндөр-80см, өргөн-40см, зузаан 23см хэмжээтэй.
- *Хонь-1.* Хөх саарал өнгөтэй хүрмэн чулууг хөвөөлөн засаж бэлтгэсэн. Цагирагласан том эвэртэй. Монхор том хамартай, нарийнхан урт хошуутай. Хамрын хоёр нүхийг цоолборлон дүрсэлсэн. Цагиргалсан хоёр эврийн дотор талд хоёр чихийг дугуйруулан дүрсэлсэн ажгуу. Хоёр хажуу руугаа нарийссан, гол хэсгээрээ өргөн зууван дугуй нүдийг тодоор дүрсэлсэн байна. Нүдний дээд хэсэгт сормуусны төвгөрийг гаргасан байна. Тус дурсгалыг хөлөө нугалан хэвтэж буй эцэг малын дүрийг тодоор гаргасан нь мэдэгдэнэ. Хоёр талын бөөрөн хэсгийг засаж янзлаагүй. Ар талд нарийн богино сүүлийг тодоор дүрслэн гаргасан. Урт-75см, Өндөр-65см, Толгой-30см, сүүл-23см, зузаан-20 см хэмжээтэй.
- *Хонь-2.* Хөх өнгөтэй хүрмэн чулуугаар бэлтгэсэн. Цагиргалсан эвэртэй данхар том толгойтойгоор урласан. Баруун талын эврийн үзүүр хэсэг хугарсан. Нарийн сүүлтэй юм. Нуруу хэнхэлдэгийг цоолборлон зассан. Хоёр талын бөөрөн хэсгийг засаж янзлаагүй байна. Хоёр хөлөө нугалан хэвтэж буй байдлаар дүрсэлсэн амой. Гуяны нугалааг тодоор сийлбэрлэжээ. Урт-80см, өндөр-63см, сүүл-13см, зузаан-25см хэмжээтэй юм.
- *Хонь-3.* Галт уулын гаралтай хөх саарал саарал хүрмэн чулууг засаж бэлтгэсэн. Толгой байгүй. Нуруу, сэрвээн хэсгийг уран гоёмсогоор цоолборлон сийлбэрлэсэн. Дунд зэргийн урттай нарийн сүүлтэйгээр сийлбэрлэсэн буй. Дөрвөн хөлөө нугалан хэвтэж

байгаагаар дүрсэлжээ. Ингэхдээ тус хонины цавь, суганы нугалааг уран чаминаар гарган өгсөн байна. Хэмжээ нь Урт-70см, Өндөр-40см, сүүл-15см, зузаан-23см.

- *Хонь-4.* Хөх саарал өнгөтэй хүрмэн чулууг түүхий эд болгон ашигласан. Толгойн хэсэг хугарч унасан. Хойд хоёр хөлөө нугалаж, зүүн талын урд хөлийг ургаш тэнийлгэн хэвтэж буй байдлаар дүрсэлсэн боловч богтос хэсгээр хугарсан ажээ. Цавьны нугалааг нарийн урлан гаргасан. Баруун талын урд хөл мэдэгдэхгүй. Нарийн сүүл дүрсэлсэн. Баруун талын хааны орчимд урд хоёр хөлөө нугалан хойд хоёр хөл дээрээ боссон, унжсан дэлдэн том чихтэй эхийнхээ хажууд хэвтэх гэж буй хургыг гоёмсгоор урласан нь гайхамшигтай тод харагдана. Хэмжээ нь Урт-60см, өндөр-55см, Хурга урт- 35см, өндөр-23см, зузаан-7см юм.
- *Хонь-5.* Галт уулын гаралтай хөх саарал өнгөтэй хүрмэн чулуугаар сийлбэрлэсэн. Толгой хэсэг хугарч алга болсон байна. Хөлөө нугалан хэвтэж буйгаар дүрсэлсэн. Нарийнхан сүүлийг сийлбэрлэжээ. Хонины эх биеийн зүүн хэсгийг цоолборлон засаж янзалсан боловч баруун талыг засаагүй байна. Зүүн талын хөлийн цавьны нугалааг тодоор сийлбэрлэсэн. Зүүн гуяндаа хонго руу харсан дан саран тамгыг дүрсэлсэн. Урт-55см, өндөр-50см, сүүл-16см, зузаан-18см хэмжээтэй.
- *Тамгатай хөшөө:* Уг байгууламжийн он цагийг тодорхойлоход тамгатай гэрэлт хөшөө болон х.н, амьтадын чулуун хөшөөд нь түрэгийн үеийн тахилга тайллагын онгон цогцолборуудад байдагтай адил дүрслэлтэй байгааг судлаачид (Д.Баяр нарын эрдэмтэд) онцлон дурдсан байдаг.

Дүгнэлт

Монгол улсын ШУА-н Түүх, археологийн хүрээлэн, Казахстан улсын Олон улсын Түрэг судлалын Академийн хамтарсан "Шивээт улаан-2016 " экспедици нь Булган аймгийн Баян-Агт сумын нутагт орших “Шивээт улаан" хэмээн нэрлэгдсэн эртний нүүдэлчдийн түүхэнд холбогдох тахилын онгон, цолцогбор дурсгалт газарт хоёр сарын туршид хайгуул болон малтлага судалгаа гэсэн үндсэн чиглэлийн дагуу ажил үүргээ амжилттай явууллаа.

Тусгайлан сонгосон гурван газарт хайгуул хийж Хиргисүүр 3 ш, Дөрвөлжин булш 8 ш, буган чулуун хөшөө 6 ш, тамга тэмдэг19 ш, хүннү булш 2 ш, нэг газарт 16 ш хадны зургийг бүртгэн баримжуулалт хийлээ.

Хэрмийн гадна талын хөшөө чулууны суурь, урд хэрмийн үүдний хэсэг, хойд хэрмийн урд хэсэг, гол байгууламж хэмээн нийтдээ 23 өрөгт малтлага судалгааны ажил хийж гүйцэтгэлээ.

Малтлагын ажлын үр дүнд урьд өмнө тодорхой бус байсан хөшөө чулуунуудыг суурийг тодорхой болгож өгсөн юм. Мөн тамгатай хөшөөний адил гэрэлт хөшөө байсан бололтой суурь байгууламжийг гол байгууламжийн өмнө талд шинээр илэрүүлсэн.

Өгүүлэн буй байгууламж нь тамгатай хөшөө түүнээс дотогш 4 м зайтай зүүн зүгт харсан 5 м орчим өргөн хаалгатай болохыг тогтоолоо.

Төв байгууламжийн өмнөд хэсгийг малтахад чулуугаар 1,5 м өндөр дөрвөлжин суурь засаж түүний дээр байгууламжийг найман талтай, одоогийн хадгалагдаж үлдсэн байдлаар хануудын тал бүрийн урт нь 7 метр хэмжээтэй,4 м өндөр ханатай чулуун ханатай, энэ жилийн үр дүнд тогтоолоо. Мөн найман талын тал бүрийг саарал өнгийн шавраар шавж гадна талаар нь цагаан өнгийн шохойгоор зарим газар нь 1,5 см зузаанаар шохойдон өнгөлсөн байна.

Малтлага судалгааны ажлын үр дүнд шинээр нэг хүн чулуу илэрүүлэн баримтжууллаа. Хөх саарал хүрмэн чулуугаар үйлдсэн бадам цэцгийг дүрсэлсэн чулуун эдлэл 1ш олдсон. Энэхүү чулуун эдлэл нь найман талт байгууламжийн оройн хэсэгийн бүрэлдэхүүн нь байсан байх магадлалтай. Энэ нь уг байгууламжийн хэлбэр төрхийг тодотгоход чухал хэрэглэгдэхүүн болно хэмээн таамаглаж байна.

Уг байгууламжийн он цагийг тодорхойлоход тамгатай гэрэлт хөшөө болон амьтадын дүрст чулуун хөшөөд нь түрэгийн үеийн тахилга тайллагын онгон цогцолборуудад байдагтай адил дүрслэлтэй байгааг урьд нь нэрт археологич [Д.Баяр] абугай онцлон дурдсан байдаг.

Хавсралт-1

Зураг 1.1. Малтлагын өмнөх агаарын зураг

Зураг 1.2. Малтлагын дараах агаарын зураг

Хавсралт-2

Зураг 1. 8-н талт байгууламжийн урд ханын зүүн булан

Зураг 2. 8-н талт байгууламжийн суурийн дөрвөлжин тавцан

Зураг 3. 8-н талт байгууламжийн үүдэнд байрлах хөшөөний суурь

Зураг 4. 8-н талт байгууламжийн суурийн дөрвөлжин тавцангийн дээр шинээр илэрсэн хүн чулуун хөшөө

Зураг 5. 8-н талт байгууламжийн үүдний хүн чулуун хөшөө

Зураг 6. Арслан дүрст домгийн амьтаны хөшөө

Зураг 7. Хургатай хонины хөшөө

Зураг 8. Хойд хэрэм орох шинээр илэрсэн чулуун шат

Зураг 9. Баруун хорго

Зураг 10. Зүүн хорго

Зураг 11. Тамгатай хөшөөний хэв авч буй байдал

МОНГОЛ-ЯПОНЫ БИЧЭЭС-2 ТӨСЛИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН ХАЛЗАН ШИРЭГ БАЛГАСНЫ МАЛТЛАГА СУДАЛГАА

А.Очир, Л.Эрдэнэболд, Т.Мацукава, К.Мацуда, Х.Муроака.

Төслийн танилцуулга.

Монгол-Японы хамтарсан ''Бичээс'' төсөл нь 1994 оноос эхэлж Монгол улсын нутаг дахь янз бүрийн хэл, бичгээр буй хөшөөд, хадны бичээсүүдийг шинээр олж илрүүлэх, судлах зорилгоор анх байгуулагдан ажиллаад өдгөө 20 гаруй жилийн нүүр үзэж байна.

Энэ хугацаанд "Бичээс" төслийн баг Сэлэнгэ, Дархан-уул, Төв, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Завхан, Булган, Архангай, Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор зэрэг Монголын бараг бүх аймгийн нутгаас дөрвөлжин, хятан, уйгар, түрэг (руни), согд, перс, хятад бичигтэй хөшөө, хадны бичээсүүд 20 гаруйг шинээр илрүүлэн судалж үр дүнгээр нь 5 ном Япон улсад нийтлүүлээд байна.

2014 оноос хамтарсан төслийнхөн Монгол улсын нутаг дэвсгэрт харьцангуй бага судлагдсан Монголын эзэнт гүрний үеийн түүхэнд холбогдох хот суурин, газар тариалангийн үлдэгдэлийн судалгааг гүнзгийрүүлэн судлах зорилгоор Говь-Алтай аймгийн Шарга сумын нутагт орших Халзан ширэг хэмээх эртний хотын туурьнд малтлага судалгаа хийж эхэлсэн билээ.

Энэ балгасны туурь нь Монгол улсын Говь-Алтай аймгийн Шарга сумын нутагт, Шаргын голын өмнөд хөвөөнөө, Шаргын цагаан нуурын зүүн өмнөд биед оршино. Эл туурийг судлаачид анх 2004 оны зун хайгуул судалгааны ажлын явцад олж, анхны дэвсгэр зураг, тодорхойлолт[1] сэлтийг үйлджээ.

Халзан ширэг балгасны туурь нь хойд өргөрөгийн 46^0 12' 518, зүүн уртрагийн 95^0 13' 429 хэмд далайн төвшинөөс дээш 996 метрт оршино.

Хотын туурь нь Шаргын говийн зүүн өмнөд захад байрлах бөгөөд баруун хойт талаар нь Дарвийн нуруу, өмнө талаар нь Хар азаргын нуруу, баруун талд нь Тэвх толгой, Цагаан хайрхан зэрэг уулс бараална. Уг балгас нь гадуураа шавар хэрэмтэй, дотроо цөөн барилгатай жижиг суурин аж. Түүний хэрэм нь ерөнхийдөө дөрвөлжин зохиомжтой бөгөөд төв дунд нь зүүнээс баруунш сунасан мэт зуувин зохиомжтой барилгын үлдэгдэл байна. Энэ барилгын үлдэгдэл нь баруун хэсэгтээ өндөрлөг бөгөөд зүүн хэсэг рүүгээ өргөсөн намссан байдалтай юм.

Хэрмийн дундуур хожим татсан газар тариалангийн сувгийн үлдэгдэл ажиглагдаж байна. Хэрэм нь ерөнхийдөө хэвгий газарт байрлах учир бороо хурын усанд нилээд идэгдэж, дотор талд нь хайрга, элсэрхэг хөрсөн бүрхэвч тогтжээ.

[1] *А.Очир, А.Энхтөр. Монгол японы хамтарсан "Бичээс-2" төслийн 2004 оны хээрийн хайгуул судалгааны ажлын тайлан. Монголын Үндэсний музейн номын сан. УБ., 2005.*

Хэрмийн төвд буй барилгын туурийн хамгийн өндөр цэг нь 1,4 метр орчим, намхан хэсгээрээ 0,6 метр орчим юм. Энэхүү балгасны гадуурх шороон хэрмийн зүүн талын ханын урт нь 190 метр, баруун хана нь 220 метр, хойт хана нь 190 метр, өмнөд хана нь 170 метр тэгш бус өнцөгт хэлбэртэй аж. /зураг.1/ Хэрмийн хаалга нь зүүн ханандаа байсан бололтой. Хаалганы бололтой сэтэрхийн өргөн нь 17 метр аж. Халзан ширэг балгасны дотор тал, барилгын туурь, түүний ойр орчмоос олон тооны ахуйн хэрэглээний шинжтэй ваар савны хагархай хэлтэрхий олдож байлаа. Тэдгээр нь долгион болон давхар долгион хээтэй, хар хүрэн, саарал, улаан өнгийн шавраар хийж шатаасан шатаалт сайтай ваар савны хагархайнууд зонхилно.

2004 оны үед анх эл балгасны туурьт хэмжилт судалгаа, дэвсгэр зураг хийх явцад дээрхтэй ижил олон тооны ваар савны хагархайнууд илэрч олдсоноос гадна ногоон өнгийн баргилт чулуугаар хийсэн чулуун онго, ваар савны хагархайнуудаас гадна Хэ Ци, Бай ци, Ци жоу, Жүн яао гэх мэт төрлийн цагаан, хөх шаазангийн хагархай цөөнгүй илэрч олджээ[2].

Зураг. 1. Халзан ширэг балгасны дэвсгэр зураг. /М.Ширайши, А.Энхтөр/

[2] *А.Очир, А.Энхтөр. Монгол японы хамтарсан "Бичээс-2" төслийн 2004 оны хээрийн хайгуул судалгааны ажлын тайлан. Монголын Үндэсний музейн номын сан. УБ., 2005.*

2016 оны археологийн малтлага судалгаа

Судалгааны багийнхан 2016 оны 09-р сарын 10-наас 25 хүртэл хугацаанд судалгааны обьектод ажиллалаа.

2016 онд тус хамтарсан төслийн багийнхан Халзан ширэг балгасанд 3 газарт багахан хэмжээний сорилын малтлагуудыг явуулсан юм. Бидний малтсан 1-р малтлага нь гол барилгын нурангийн төв хэсэгт 2014 онд явуулсан малтлага судалгааны үргэлжлэл байв.

2014 онд гол овгор барилгын төв хэсэгт хойноос урагш 12 метр, зүүнээс баруунш 18 метр хэмжээтэй сорилын малтлага явуулсан билээ. Барилгын бүтэц, зохион байгуулалт, хийц хэлбэрийг тодруулах, соёлт давхаргын зузааныг тодруулах зорилгоор өнгөрсөн малтлагын үеэр малтаж амжаагүй барилгын зүүн хэсэгт энэ удаагийн малтлагыг эхлүүлэв. Ингэхдээ өнгөрсөн 2014 оны малтлагын төв цэгээс зүүн тийш сорилын суваг татсан бөгөөд барилгын зүүн талын хана, өрөө тасалгааны бүтцийг тодорхойлоход чухал ач холбогдолтой байлаа.

2-р малтлага: Энэ малтлагыг барилгын төв хэсгийг дайруулан зүүнээс баруун тийш 10 метр, 1,0 метр өргөнтэйгээр эхлүүлсэн бөгөөд малтлагын явцад ажлын шаардлагаар талбайн зүүн хэсэгт хойд болон өмнө тийш нь тус бүр 3,0х30 метр хэмжээтэй 3 талбай сунган малтсан билээ.

Малтлагыг 1-р үеэс ерөнхийдаа бага зэрэг саарал, хар бараан ургамалын үндэс холилдсон шаргал хөрс гарч байсан бөгөөд эдгээр нь ихэвчлэн хожим бүрэлдсэн хөрс аж. Харин 3-5-р үе хүртэл буюу 30-50см хүртэл хөрсний өнгө нь нуугисан маш нарийн ширхэгтэй шар шавар байсан бөгөөд тэдгээрийн дундаас цөөн тооны малын яс болон ваар савны хагархай зэрэг олдвор хэрэглэгдэхүүн илрэн олдов.

Малтлагаар ханарч унасан хана байсан бололтой тоосгон өрлөг илэрсэн бөгөөд түүнийг ажиглавал 42см урт, 26см өргөн, 22см өндөртэй шар шаврыг цохиж хийсэн түүхий тоосгоор өрж хийжээ. Мөн өрлөг, түүний завсар хоорондыг нааж байсан шар шавар нь сайтар мэдэгдэж байв.

Сорилын сувгийн зүүн хэсгийн малтлага А-6 өрөг орчмоос зүүн тийш үргэлжлэх бөгөөд зүүн талын малтлагын цэгээс 1,5 метр орчим зайтай, малтлагын 2-р үеэс түүхий шавараар цохиж хийсэн баримлын бололтой хэсгүүд илэрсэн юм. Энэ нь хоёр ширхэг түүхий шавраар хийсэн маш муу хадгалалттай шавар баримлын гарын хэсэг, нэг ширхэг хурууны хугархай, бас нэгэн цац бололтой зүйл байлаа. Харин тэдгээрийн хажуугаас бурханы эсхүл ямар нэгэн баримлын бололтой зэрэгцээ хоёр хөлийн дүрслэл анхны байрлалаараа илэрсэн билээ. Суугаа эсхүл босоо дүрслэлтэй түүхий шавраар хийсэн, шатаагаагүй эдлэлийн дээд хэсэг нь малтлагын 2-р үе буюу 16 см-ийн гүнээс анх илэрч эхэлсэн бөгөөд бүрэн цэвэрлэж үзвэл 30 орчим см өндөр ажээ. Энэхүү шавар баримлын хөлийн тавхай хэсэг болон шилбэ хүртэлх хэсэг нь анхны байрлалаараа үлдэж хоцорчээ.

Шавар баримлын хоёр хөл хоорондоо 13см зайтай, 2 хөлийн нийт өргөн 33см, их биеийн бололтой өргөн нь 60см, зузаан нь 40см, зүүн хөлийн чигчий хурууны үзүүр нь хугарсан бусад хэсэг нь харьцангуй бүтэн. Шавар өрлөг бүхий хананд тулган барьсан байсан нь тодорхой мэдэгдэнэ. Учир нь шавар баримлын хойт талд нь тулгаж барьсан түүхий тоосгон өрлөг сайн мэдэгдэж байв. Шавар баримал нь дороо хавтгай суурьтай байсан нь мэдэгдэх бөгөөд суурь нь ихээхэн эвдэрчээ. Шавар баримлын хөрөг нь хүний дүрслэл байсан нь тодорхой бөгөөд хөл нүцгэн дүрслэлтэй, түүний шагайн дээд хэсэгт дээлийн бололтой хормойг нилээд тод томруун гаргасан. Шавар баримлыг анх хийхдээ 1см орчим голчтой бутлаг харгана модны голыг дотор талд нь бат бэх болгох рам маягтай хийж, түүнийгээ зуурсан шавраар шавардах аргаар босгосон байна. Харин дараа нь түүнийхээ гадаргууг сайтар өнгөлж, цагаан өнгийн шохойн лагшим маягийн шавраар 0,5см зузаан өнгөлж үзэмжтэй болгожээ. Шавар гар хурууны хэсгүүдийг мөн адил энэ аргаар хийсэн нь мэдэгдэнэ.

Малтлагаас илэрсэн нэгэн сонирхолтой зүйл нь 205x80см хэмжээтэй, 15см зузаан говийн харгана модлог ургамал бүхий хавтгай дагтаршуулсан зүйл илэрсэн юм. Энэ нь бидний таамаглаж буйгаар эл шавар барилгын дээр модон нуруу тавиад түүний дээр нь харгана, өвсөөр хучиж, ус чийгнээс хамгаалдаг байсан бололтой. Энэ бүс нутагт өдгөө хүртэл шавар байшин бариад түүнийхээ дээврийг өвс харганаар хучиж уснаас хамгаалдаг энэ аргыг хэрэглэсээр байгаа билээ.

Барилгын нуранги түүхий тоосгон хана илэрсэн хэсгээс бусад хэсэгт нь хөрс нь зөөлөн нуугисан шар шавар гарч байсан учир бид доош үргэлжлүүлэн малтаж үзвэл, малтлагын гүн 90-110см үргэлжлээд барилгын суурь болох дагтаршуулсан шавар тавцанд тулсан билээ. Барилгын зүүн хэсэгт барилгын хана туургыг бүрдүүлж байсан түүхий тоосгон өрлөг, ханарч нурсан байдалтай олдсон бөгөөд хэд хэдэн тасалгаа бүхий түүхий тоосгон ханатай, нарийн шургаагаар хийсэн дээвэртэй, түүний дээр зузаан харгана өвс тавьж дулаалан басхүү бороо уснаас хамгаалдаг байсан нь мэдэгдэв. Мөн барилгын зүүн ханын гадна хэсэгт хог хаягдал хийдэг байсан бололтой дугуй хэлбэрийн нүх илрэв.

3-р малтлага. Бид 2016 оны археологийн судалгааг хийхдээ уг сууринд буй төв барилгаас гадна хэрмийн дотор талд хүн амьдран сууж байсан ул мөр, соёлт давхаргын зузааныг тодруулах зорилгоор төв барилгын гол цэгээс өмнө тийш 20 метр зайд баруунаас зүүнш чиглүүлэн 10 метр урт, 2,0 метр өргөн сорилын сувгийг малтсан билээ.

Энэхүү сорилын сувгийн малтлагаас ажиглахад бүх үеүдийн турш хөрс нь үндсэндээ үнс нурам маш их холилдсон нарийн ширхэгтэй шар шавраар тогтох бөгөөд улаан хүрэн шатсан гэмээр шаварлаг хөрс ч илэрч байлаа. Малтлагын бүх үеэс ваар савны хагархай, мал амьтны яс их хэмжээгээр илэрсэн юм. Гэвч энд ямар нэгэн барилга байгаагүй нь тодорхой байна. Малтлагын гүн дунджаар 50-60см үргэлжлэв.

4-р малтлага. Энэхүү сорилын сувгийн малтлагыг Халзан ширэг балгасны хэрмийн зүүн урд хэсэгт буй бага зэрэг өндөрлөг хэсэгт явуулсан бөгөөд бидний урьд өмнөх хотын дэвсгэр зурагт тэмдэглэгдээгүй барилгын үлдэгдэл байж магадгүй хэмээн үзсэний үндсэн дээр малтлагыг явуулсан юм.

Энэ овгор нь 30х40 метр орчим хэмжээтэй, ойр орчмоосоо өндөр байв. Бид энэ хэсэгт хойт зүгийг баримжаа болгон зүүнээс баруунш чиглүүлэн 10 метр урт, 1,5 метр өргөн сорилын суваг малтсан юм. Малтлагын 1-р үеэс эхлэн өнгөн хөрс нь бага зэрэг чулуулагтай шар шавран хөрс гарч байсан бөгөөд цөөн тооны яс, улаан өнгийн ваар савны хагархай илрэв. Малтлагын 1-3-р үе хүртэл хөрсний бүтэц өөрчлөгдсөнгүй шар шавар хөрс гарсаар байсан бөгөөд зарим газар бага зэрэг дагтаршуулсан гэмээр шар шавар болон улаан хүрэн шатсан хөрс гарч байлаа.

Энэхүү сорилын малтлагын гүн нь дунджаар 50см үргэлжлээд байгалийн хөрсөнд туллаа. Энэ овгор өндөрлөг хэсэгт ямар нэгэн барилга байшин байсны ул мөр мэдэгдээгүй бөгөөд харин хүмүүс урт удаан хугацаанд эл хэрмийн дотор оршин амьдарч байсныг илтгэх олон арван ваар савны хагархай, хэлтэрхий, мал амьтны яс илэрч олдлоо. Энэхүү сорилын малтлагын гүн 3-р сорилын малтлагын гүнтэй бараг ижил төвшинд байгаа, нөгөө талаар илэрч буй олдвор хэрэглэгдэхүүн нь ижил байна. Энэхүү суурингийн хүн оршин амьдарч байсан соёлт давхаргын зузаан нь хэрмийн бүх хэсэгт ойролцоо дунджаар 50см бөгөөд малтлагын бүх үеүдээс ваар савны хагархай хэлтэрхий, мал амьтны яс, шатсан мод ургамалын үлдэгдэл гарч байлаа.

Төгсгөл

Говь-Алтай аймгийн Шарга сумын нутагт орших Халзан ширэг балгасанд ийнхүү багахан хэмжээний малтлага судалгаа явуулсанаар тодорхой үр дүнд хүрлээ. Юутай боловч Монгол улсын нутаг дэвсгэрт малтан судалсан хот суурины дурсгалуудын дотроос хамгийн баруун захад хийгдсэн судалгаа байснаараа онцлог байлаа. Урьд өмнө энэхүү бүс нутагт түүхэн аль ч үеийн хот суурины дорвитой малтлага судалгаа хийгдэлгүй ирсэн билээ. Тиймээс энэ хот суурины малтлага нь энэ бүс нутгийн хот байгуулалтын болон соёлын олон талт асуудлыг тодруулахад ихээхэн ач холбогдолтой болох юм.

2016 оны Халзан ширэгийн балгасанд явуулсан археологийн малтлага судалгаагаар нийт 130 орчим археологийн олдвор хэрэглэгдхүүн илэрлээ. Тэдгээрийг ангилбал,

1. Хээтэй ваар савны хагархай 11 ш
2. Ваар савны ёроолын хагархай – 7 ш
3. Хүрэл дэгээ 1 ш
4. Шилэн эдлэлийн хагархай 1 ш
5. Бүсний ясан арал 1ш

6. Ваар савны амсарын хагархай 10 ш
7. Ваар савны бариулын хагархай 2 ш
8. Ваар савны хээгүй хагархай – 74 ш
9. Хөх паалантай ваарны хагархай 1 ш
10. Төмрийн баас – 16 ш
11. Чулуун эдлэл 1 ш
12. Шавар эдлэл 4 ш
13. Үйсэн эдлэлийн тасархай 1 ш тус тус илэрч олдлоо.

Хэрмийн дотор талд буй барилга нь тэгш өнцөгт хэлбэртэй, шар шавар цохиж хийсэн түүхий тоосгон ханатай, хэд хэдэн тасалгаатай барилга байжээ. Барилгыг анх барихдаа шар шавар дагтаршуулан нүдэж хийсэн өндөр довжоог байгуулаад түүний гадуур нь 25-30см хүртэл зузаантай түүхий тоосгоор өрж хийсэн хана босгож дотор талын тасалгаануудыг 47х23х9см хэмжээтэй дутуу шатаасан тоосгоор өрж үйлдсэн байжээ. Гэхдээ барилгын дээвэр, хаалга гэх мэт бусад зохион байгуулалтын талаар тодорхой нарийн хэлэх боломжгүй аж. Учир нь малтлагаас барилгын нуруу гэмээр томхон хэмжээний мод, бусад зүйлс илэрсэнгүй. Гэхдээ бидний малтлага бол багахан хэмжээний сорилын малтлага байсан учир цааш цаашдын өргөн хүрээтэй малтлага судалгаагаар олон зүйлүүд тодорхой болох боломжтой.

Энэ суурин нь Шаргын голын хөндий дагасан жижиг хэмжээний тариачдын суурин байсан бололтой. Малтлагаас хэдийгээр тариа ногооны зориулалттай эд өлгийн зүйл илрээгүй боловч Шаргын говийн энэхэн хэсэгт тариа ногооны аж ахуй эрхлэх хамгийн тохиромжтой газар орон тул тариа ногооны ажил эрхэлж байсан хүмүүсийн суурин болов уу гэсэн таамаглалыг дэвшүүлж байна.

Энэ сууринггийн бүтэц, зохион байгуулалт, хэрмийн дотор талд хийсэн малтлага зэргээс үзвэл багагүй тооны оршин суугчид тодорхой урт удаан хугацаанд тасралтгүй оршин сууж байсан байж болохоор байна. Хэрмийн голд буй барилгын хэмжээ, зохион байгуулалт, зузаан зэрэг болон хэрмийн дотор талд урт удаан хугацаанд бүрэлдсэн бололтой соёлт давхарга зэрэг нь ийм дүгнэлтэнд хүргэж байна.

Малтлага судалгаа харьцангүй богино хугацаанд багахан талбайг хамруулан хийсэн хэдий ч энэхүү хот нь дундад эртний нүүдэлчдийн аж ахуйн хөгжлийн асуудлыг тодруулахад чухал ач холбогдолтой юм. Юуны түрүүнд энэхүү балгас нь малтлагаас олдсон олдвор хэрэглэгдэхүүнд тулгуурлан авч үзвэл Xll-Xlll зууны үед холбогдох боломжтой байна. Тухайн дурсгалын малтлагаас илэрч буй эд өлгийн зүйлс зэрэг нь уг дурсгалыг ийн үзэх боломж олгож байна. Хэдийгээр 2014, 2016 оны малтлага болон хайгуулын үед Xlll-XlY зууны үед холбогдох хятад шаазангийн хагархай хэлтэрхий олдоогүй боловч 2004 оны үед анх эл балгасны туурьт хэмжилт судалгаа, дэвсгэр зураг хийх явцад олон төрлийн цагаан, хөх шаазангийн хагархай

цөөнгүй илэрч олджээ[3]. Эдгээр нь Монгол газар хийгээгүй хэдий ч Xlll-XlY зууны үед хятад газар хийдэг байсан сонгодог шаазангууд учир эл балгасны он цагийн асуудлыг тодруулахад дөхөм болох боломжтой.

Малтлагаас цөөн тоотой монголын археологийн судалгаанд уйгурын үед хамааруулан авч үздэг ваар савны долгион болон давхар долгион хээтэй, басхүү ханан хээтэй, ромбо маягийн хээтэй ваар савны хагархайнууд илэрсэн боловч эдгээр нь эл хотыг шууд уйгурын үед холбогдуулан авч үзэх үндэслэл болохгүй байна. Учир нь уйгурын үед хамааруулан үздэг энэ төрлийн хээтэй ваар савны хагархай Xlll-XlY зууны үеийн Монголын хот суурины дурсгалуудаас басхүү олддог бөгөөд эзэнт гүрний үед суурин хот суурины газруудыг болон монголчуудын хэрэгцээний газар тариалангийн үйл ажиллагааг уйгур гаралтай хүмүүс эрхэлдэг байсантай холбоотойгоор тэдний ваар сав урлалын дурсгалууд үлдэж хоцорсон байх магадлалтай гэж үзэж байна. Нөгөөтэйгүүр энэ бяцхан сууринд уйгурчуудын дунд Vll-Vlll зууны үеэс боловсронгуй болж тогтсон хот суурин байгуулалтын онцлог огт ажиглагдахгүй байгаа нь дээрх таамаглалыг бататгаж байна. Гэхдээ энэ бүхэн бол малтлага судалгааны ажлын эхлэл төдийгүй одоогоор таамаг төдий зүйл бөгөөд малтлагаас илэрсэн мод, малын яс, шатаж түлэгдсэн үнс нурамны үлдэгдэлд хийсэн лабораторийн нарийвчилсан шинжилгээний үр дүнд бүх зүйл тодорхой болох буй заа.

[3] *А.Очир, А.Энхтөр. Монгол японы хамтарсан "Бичээс-2" төслийн 2004 оны хээрийн хайгуул судалгааны ажлын тайлан. Монголын Үндэсний музейн номын сан. УБ., 2005.*

Зур.1. Говь-Алтай, Шарга сум. Халзан ширэг балгас. Ерөнхий байдал /баруун урд талаас/

Зур.2. Говь-Алтай, Шарга сум. Халзан ширэг балгас. Малтлагын явцаас

Зур.3. Говь-Алтай, Шарга сум. Халзан ширэг балгас. Малтлагын явц болон судалгааны багийн бүрэлдэхүүн

2016 ОНД ТОНЬЮКУКИЙН ЦОГЦОЛБОРТ МОНГОЛ-ТҮРКИЙН ХАМТАРСАН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН ГҮЙЦЭТГЭСЭН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮН

Ц.Баттулга, М.Эрдэнэ, Р.Мөнхтулга, Г.Батболд, Б.Дашдорж,
Ахмэт Ташагыл, Алпаслан Ашык, Адил Йылмаз

Монгол-Түркийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний анги 2016 оны 06-р сарын 17-ноос 08-р сарын 20-ны хугацаанд Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг Баян Цогтын хөндийд орших Тоньюкукийн цогцолбор дурсгалыг малтав.

2015 оны малтлагаар баримтжуулалгүй үлдээсэн зарим талбайг энэ удаа дахин нээж баримтжуулалтыг гүйцээв. Цогцолборын зүүн хойд булан, үүдэн тал буюу зүүн хэсэг, баруун талд хэд хэдэн суваг шинээр татаж цогцолборын бүтцийг нэмэн тодруулав. (1-2-р зураг) Малтсан суваг бүрт 4 талт (гэрэл зураг, гар зураг, бичвэр, геодезийн зураглал) баримтжуулалтыг гүйцэтгэв. Малтлагын ажлыг хэрхэн гүйцэтгэсэн тухайд суваг бүрээр авч үзвэл дараах мэт болно.

XA суваг. Цогцолборын үүдэн хэсэгт X сувгийн үргэлжлэл болгон түүний зүүн талд энэ сувгийг татсан нь I сувгаас урагш 1м орчим зайд байна. Шалны тоосго үүдэн хэсэгт хэрхэн үргэлжилж буйг мэдэхийг зорьж маш гүехэн малтахад шалны дагтаршуулсан саарал шавар гарч ирэв. Түүнийг эвдэлгүй орхиж малтлагыг зогсоов. Анхны байрлалдаа буй тоосго илэрсэнгүй. (3-р зураг)

XIA суваг. Цогцолборын сувгийн дотор тал дахь тавцангийн баруун хойд буланд буй. 2015 онд малтсан XI сувгийн ард залгаж байрлана. XI сувгийн малтлагаар илэрсэн тоосгон шал хойш аль хүртэл үргэлжлэхийг тогтоож тавцангийн тоосгон шалны баруун хойд буланг олохын тул 1х1 м хэмжээтэй талбай үүсгэн нэг үе малтахад малтлагын талбайн зүүн хэсгээс, XI талбайд гарсан тоосгон шалны үргэлжлэл илрэв. Цааш хөөн малтахын тул талбайг хойд зүгт 0.3м тэлэхэд тоосгон шалны хойд зах гарав. XIA талбайн малтлагаар илэрсэн шалны тоосгонуудын хадгалалтын байдал муу байна. (4-р зураг)

XIB суваг. 2015 онд цогцолборын тавцангийн баруун хойд талд малтсан XI сувгийн үргэлжлэл болгож түүнээс зүүн тийш 0.4м-т XIB сувгийг нээн малтав. Сувгийн чиглэл З-Б, хэмжээ 3х1м. Малтлагын 3-р үед сувгийн зүүн үзүүрээс бусад талбайд тоосгон шалны хэсэг илэрлээ. Цогцолборт анх байсан том жижиг хоёр хашлагын хойд талынх буюу жижиг хашлага байсан талбайг урьд өмнө нь хүмүүс ухаж шороог нь тойруулан овоолсон нь манай малтлагын сувгийн зүүн талд байна. Сувгийн зүүн үзүүрийн шалны тоосгогүй хэсгийг 3-р үеэс доош дахин 3 үе малтаж үзвэл энэ нь хожим сул шороогоор дүүрсэн нүх байлаа. Үүний дотроос чулуу, тоосго, бодын эрүү гэх мэт малын яс гарав. Энэ нь сувгийн зүүн талд байсан хашлагыг малтахад гарсан нүхний үргэлжлэл бололтой. Нүхний ирмэгээр буй шалны тоосгоны байдлыг үзвэл энэ нь дугуй буюу зууван хэлбэрийн нүхний үргэлжлэл гэдэг нь

иэлрхий бөгөөд уг нүхийг ухахдаа тоосгон шалыг шууд цөм цохисон нь илэрхий байна. (5-р зураг)

XII суваг. Цогцолборын баруун хойд буланд буй. Тавцан, суваг, далан цогцолборын баруун хэсэгт хэрхэн үргэлжилж буйг тогтоохын тулд XIA талбайн хойд талд, XI сувагтай зэрэгцээ (параллель), З-Б чиглэлтэй, 14х1м хэмжээтэй урт суваг татав. Малтлагын сувгийн гол хэсэгт буй, цогцолборын сувгийн ёроол хүртэл уруудуулан шаталж нийт 10 зохиомол үе үүсгэн малтав. Малтлагын сувгийн хамгийн дээд цэг сувгийн 2-р нүдэнд буюу далан дээр, хамгийн доод цэг 8-р нүдэнд буюу цогцолборын сувгийн ёроолд байна. Энэ нь 2016 онд малтсан хамгийн урт суваг болно. (6-р зураг)

XIII суваг. Том хашлагын ормын хойд захыг дайруулан З-Б чиглэлтэй, 9х1м хэмжээтэй урт суваг татав. Үүгээр хашлагын ормын байдлыг тотодруулахын хамт түүний зүүн баруун хоёр хажууд тавцангийн тоосгон шал ямар байдалтай үргэлжилснийг мэдэхээр зорилоо. Сувгийн дотор, баруун талаас 3-8-р м-ийн хооронд хашлагын ором нүх байна. Түүний гол хавьд бяцхан овгор буй нь чулуу, тоосго овоолсноос үүссэн бололтой. Малтлагын 2-р үед сувгийн зүүн хэсэгт тавцангийн тоосгон шал илэрлээ. Хуучин малтлагаар түүний зүүн талаас, мөн зүүн талд буй шалны захаас баруун тийш хашлагын нүхний ором хүртэл хоёр талаас нь уруудуулан малтахдаа нүхний ёроолоос гарсан цагаан эх хөрсийг хоёр тийш нь гаргаж хаясан нь тодорхой байна. Сувгийн баруун үзүүрт тоосгон шалыг зориуд цөмлөн нүх ухсан нь хуучин шонгийн нүх болов уу. Ер энэ сувгаар илэрсэн шалны хэсгийн тоосго ихэд элэгдсэн нь хуучны малтлагын үеэр ил гаргаад байгалийн нөлөөнд удааснаас болсон мэт байна. Хашлагын нүхний ёроол хүртэл нийт 4 үеэр малтахад хашлагын хавтангийн том жижиг хэлтэрхий, тоосгоны хагархай, мөн зориуд хаясан байгалийн чулуу илэрч байв. Нүхний урд хананаас хашлагын таг хавтангийн хагархай цухуйж байлаа. Түүний зузаан 12см байв. (7-р зураг) Нүхнээс зүүн тийш сувгийн төгсгөл хүртэлх хэсэг аажим өгсүүр бөгөөд сувгийн төгсгөл хавьд бутархай тоосгоны маш цөөн хагархай байгаа нь хашлагын голыг малтахдаа энэ хэсгийн шалыг хуулан эвдсэнийг гэрчилнэ.

XIV суваг. Цогцолборын үүдэн хэсэгт, XA сувгаас урагш 0.5м, XIX сувгаас хойш мөн 0.5м-т У-Х чиглэлтэй, 2х1м хэмжээтэй маш гүехэн суваг татлаа. Энэ сувгаар тоосгон шал тавцангаас зүүн тийш хэрхэн үргэлжилснийг мэдэхийг зорив. Эндээс анхны байрлалдаа буй шалны тоосго илэрсэнгүй. Үүдэн хэсэг тул шалны дагтаршуулсан саарал шавар нь ихэд элэгдсэн байна. Шалны шаврыг эвдэлгүй хэвээр нь үлдээхийн тулд малтлагыг зогсоолоо. (8-р зураг)

XV суваг. Цогцолборын тавцанг тойрсон сувгийн зүүн хойд буланд, 2015 онд малтсан IV сувгаас хойш 6м-т У-Х чиглэлтэй, 2х4м хэмжээтэй 2 талбай үүсгэн малтлаа. Цогцолборын сувгийн зүүн хойд буланг эвдэлгүйгээр цэвэрлэн анхны байдлыг нь тодруулахын тулд сувгийн хана, ёроолыг дагуулан болгоомжтойгоор малтахыг хичээв. 2 талбайн голд хамар үлдээсэн нь малтлагын явцыг хянах, малтлагын үе давхаргыг анхааралтай ажиглах боломжийг олгов. XVA сувгийг 6 үеэр, XVB сувгийг 5 үеэр

малтав. XVA сувгийн ёроолоос урт нарийн саваа мод илрэв. Ер XV сувгаас дээврийн ваарын цөөн хэлтэрхий гарч байв. (9-10-р зураг)

XVI суваг. XVII сувгаас хойш 0.5м-т буй. Чиглэл З-Б. Хэмжээ 7х1м. Тавцангийн тоосгон шал энэ хэсэгт хэрхэн үргэлжилж буйг тогтоохын хамт 2016 онд гүйцэтгэсэн геофизикийн судалгаагаар гарсан үр дүнг шалгахыг зорив. Малтлагын 2-р үед тавцангийн тоосгон шалны зах, шалны захыг хашсан дагтаршуулсан хатуу саарал шавар гарсан нь XI сувгаас илэрсний үргэлжлэл байна. Шалны тоосгоны хадгалалтын байдал харьцангуй сайн байна. (11-12-р зураг)

XVII суваг. Цогцолборын баруун урд хэсэгт буй. Чиглэл У-Х. Хэмжээ 13х1 м. XVII сувгийн малтлагаар тавцан, суваг, далан цогцолборын энэ хэсэгт ямар байгааг мэдэхийг зорив. Цогцолборын сувгийн ёроол өнгөртөл нийт 10 үеэр малтсанд тавцангийн тоосгон шалны урд зах, түүний урдах, тоосгон шалыг хашсан дагтаршуулсан шаврын өргөн тодорхой болов. (13-р зураг)

XVIII суваг. XVII сувгаас урагш 0.5м-т түүнтэй зэрэгцээ байна. Хэмжээ 3х1м. 2015 онд хийлгэсэн геофизикийн тандалтаар эндээс дохио илэрсэн гэх тул шалгахын тулд малтлаа. Хожим ухсан, төмөр шонгийн бетон суурийн нүх сувгийн зүүн талыг эзэлнэ. Нийт 6 үеэр малтах явцад сувгийн баруун хагаст ч мөн шонгийн бетон суурийн нүх илрэв. Эх хөрсийг цөмлөн дөрвөлжилж ухсан тэр нүхийг бетон, цогцолбороос авсан тоосгоор дүүргэжээ. 2015 онд илэрсэн геофизикийн тандалтын дохио тэр нүхнээс илэрсэн байж болох юм. Шонгийн суурийн нүхнээс гарсан тоосгонууд нь хугархай боловч хадгалалтын байдал харьцангуй сайн. (14-р зураг)

XIX суваг. Цогцолборын уртын тэнхлэгээс урагш, I гэрэлт хөшөөнөөс зүүн тийш З-Б чиглэлд I сувагтай зэрэгцээ, түүнээс 6м зайд 8х1м хэмжээтэй суваг татав. 2015 онд I сувгийн малтлагаар илэрсэн ус дамжуулах хоолойн ижлийг хайх, энэ хэсэг дэх тавцангийн байдлыг мэдэхийг зорилоо. Малтлагын 2-р үед сувгийн зүүн хэсгээс зэл чулууны хугархай илрэв. Талбайн голд мөн төмөр шонгийн бетон суурийн нүх буй нь бетон, тоосго, чулуу, дээврийн ваараар дүүрчээ. Малтлагын 3-р үед талбайн голоос төмөр хадаас илрэв. Нийт 9 үеэр малтахад сувгийн ёроол, тавцангийн усыг суваг руу дамжуулан урсгах налуу хоолойн үлдэц ваар, тоосго зэрэг зүйл илрэв. Сувгийн ёроол, ваар хоолойн үлдэл зэргийг хадгалан үлдээхийн тулд баримтжуулаад буцаан булав. Энэ сувгийн малтлагаар, тавцанг тойрсон суваг руу уруудуулан тавьсан хоолой цогцолборын үүдэн хэсгийн 2 талд тэгш хэмтэй байсныг тодорхой болгов. (15-р зураг) Энэ малтлагын сувгийн голд, 68см гүнээс, нэг талд нь 2 дугуй хонхор зэрэгцүүлэн гаргасан жижиг шавар чимэглэл гарав. Үүний хэлбэр дүрс нь мөн үеийн тахилга, оршуулгын цогцолбороос илэрч байсан барилгын чимэглэлийн зориулалттай шавар хавтан дээрх амьтны нүүрийн дүрсийн хамрыг санагдуулна. (18-р зураг)

XX суваг. 2016 оны 08-р сарын 04-ний өдөр ТИКА-ийн суурийн төлөөлөгчийн хүсэлтээр, хамтарсан шинжилгээний ангийн малтлагын багийнхан, ШУА-ийн Түүх, археолгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, ТИКА-ийн суурийн төлөөлөгчийн оролцоотойгоор малтлагын талбайд хуралдсаны үндсэн дээр цогцолборын баруун талд 2 суваг шинээр нээн малтахаар болсон юм. Түүний нэг нь

том хавтант хашлагын ормын урдуур баруун тийш тавцангийн баруун зах өнгөртөл татсан, З-Б чиглэлтэй, 12х1м хэмжээтэй XX суваг болно. Нийт 2 үеэр малтахад тавцангийн баруун захад малтсан бусад сувгийн нэгэн адил захаар нь хайргатай бор хөрс, түүний зүүн талд хайргатай бор саарал холимог хөрс, залгаад зүүн тийш дагтаршуулсан шавар шал байх ба улмаар 8м урттай тоосгон шал үргэлжилж байна. Тоосгон шалны зүүн үзүүр нүхэнд дайрагдан ихэд эвдэрч байхгүй болжээ. Баруун талаас 9-р м-т урд хана руу шургаж орсон нүхний ором буй. Тоосгон шалны зүүн үзүүрийн хадгалалт харьцангуй сайн, харин үлдсэн хэсгийн ихэнх нь элэгдэж эвдэрсэн нь нэгэн хэсэг хугацаанд ил гаргаж байгалийн нөлөөнд байлгасных бололтой. Шалны тоосгоны хэлбэр, хэмжээ өмнө малтсан талбайгаас илэрсэн хийгээд одоо хөрсөн дээр ил буй шалны хэсгийнхтэй ижил болой. (16-р зураг) Сувгийн баруун хэсгээс, тоосгон шалан дээрээс бодын эрүүний яс илэрсэн нь эрт үед зориуд үйлдсэн тахилгын өргөл байж болох юм. Мөн энэ талбайн 1-р үед, тоосгон шалны баруун захаас “таван нүдэн” (“зоосон” хээ гэх нь ч бий) хээтэй нүүр ваар бүтнээрээ илрэв. (19-р зураг) Ийм хээтэй нүүр ваар зөвхөн Тоньюкукийн цогцолбор дурсгалаас илэрсэн байдаг.

XXI суваг. XX сувгийг нээн малтаад түүнтэй зөрүүлэн тавцангийн баруун захыг дагуулан У-Х чиглэлтэй, 11х1м хэмжээтэй суваг татлаа. 2 үеэр малтахад талбайн зүүн хагасын голоос зүүн тийш тавцангийн тоосгон шалны баруун зах, түүнээс баруун тийш нийт талбайд тоосгон шалыг хашин хамгаалсан хатуу саарал шавар гарав. Энэ талбайд хашлагын 1 хавтангийн булан, мөн 1 хавтангийн ихэнх хэсэг өртсөн боловч тэдгээрийн доодох газрыг ер малтаж хөндөлгүй орхисон билээ. (17-р зураг)

Бусад. Түүнчлэн 2015 онд малтсан I, III, IV, XI сувгуудыг дахин нээж дутуу үлдээсэн баримтжуулалтын ажлыг гүйцээв. Тухайлбал сувгуудын шал, 2 ханыг дахин цэвэрлэж гэрэл зургийг авав. 2 ханынх нь гар зургийг үйлдэж 3 хананаас хөрсний давхаргын үе бүрээс шорооны дээж авлаа.

Дүгнэлт

2016 оны малтлагаар бид археологийн баримтжуулалтын олон аргыг зэрэгцүүлэн хэрэглэсэн нь нэг нь нөгөөгөө нөхөх, тухайн аргын үр дүнд бий болсон гаргалгааг хянаж зөв бол батлах, буруу бол засах зэрэг ач холбогдолтой байсныг энд онцлон дурдах нь зүйтэй.

Түүнчлэн Тоньюкукийн цогцолборын бүтцийг тодруулах зарим шинэ баримтыг илрүүллээ. Тавцанг тойрсон сувгийн хоёр үзүүр тавцангийн зүүн талд үүдэн хэсгээр таслагддаг бөгөөд тэр хоёр үзүүрийн хойд талынх руу тавцангаас аажмаар уруудуулан тавьсан ус дамжуулах ваар хоолой анхны байрлалаараа 2015 оны малтлагаар илэрсэн юм. Тэгвэл 2016 оны малтлагаар яг түүн шиг байрлалтай ваар хоолойн үлдэл нөгөө үзүүрээс илэрсэн нь цогцолборын үүдэн хэсгийн 2 этгээдэд нэжгээд ваар хоолой байсны баримт боллоо.

2016 оны малтлагын үеэр Тоньюкукийн дурсгалын дэргэд иргэд хууль бусаар хашаа татах, хоёр дурсгалын хооронд блокон хашааны суурь ухах зэргээр дурсгалын

унаган дүр төрхөд шууд нөлөөлөх ноцтой аюулыг улам ихээр учруулж байсныг зориуд цохон дурдъя.

1-р зураг: Тоньюкукийн цогцолбор зүүн урдаас

2-р зураг: Тоньюкукийн цогцолбор эгц дээрээс

3-р зураг: XA сувгийн 1-р үе



4-р зураг: XIA сувгийн 1-р үе

5-р зураг: XIB сувгийн 3-р үе

6-р зураг: XII сувгийн 10-р үе

7-р зураг: XIII сувгийн 3-р үе, хашлагын таг хавтангийн хагархай

8-р зураг: XIV сувгийн 1-р үе

9-р зураг: XVA сувгийн 5-р үе

10-р зураг: XVB сувгийн 5-р үе

11-р зураг: XVI сувгийн 2-р үе



12-р зураг: XVI сувгийн 2-р үе

13-р зураг: XVII сувгийн 9-р үе

14-р зураг: XVIII сувгийн 6-р үе

15-р зураг: XIX сувгийн 8-р үе

16-р зураг: XX сувгийн 2-р үе

17-р зураг: XXI сувгийн 2-р үе

18-р зураг: Барилгын шавар чимэглэл

19-р зураг: XX сувгаас нүүр ваар илэрч буй нь

МОНГОЛ-ЯПОНЫ ХАМТАРСАН "ДОРНОД МОНГОЛЫН ЭРТНИЙ ТҮРЭГИЙН ҮЕИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА" ТӨСЛИЙН 2016 ОНЫ МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ШИНЭ ҮР ДҮНГЭЭС

Б.Цогтбаатар, Н.Эрдэнэ-Очир, Г.Лхүндэв, Т.Осава, Д.Батдалай, Г.Ангарагдөлгөөн, Э.Амарболд

2010 онд МУИС-ийн "Дорнод Монгол" төслийн хээрийн шинжилгээний анги хайгуул хийх явцдаа Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уулын орчимд олон хөшөө, цэцэг хээ дүрсэлсэн хавтан бүхий цогцолбор дурсгалыг илрүүлсэн тухайгаа тэмдэглэсэн байдаг.

2011 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаач, доктор Ц.Болорбатын удирдсан хайгуулын баг Дэлгэрхаан уулын хавьд хайгуул хийх үедээ уг дурсгалын хөшөөнд эртний түрэг бичээс буйг илрүүлжээ.

Улмаар 2013 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги уг дурсгалт газарт хоёр удаа гүймэг малтлага судалгаа хийж, хөшөө чулууны 20 гаруй хугархайг илрүүлэн, зарим хөшөөний цаасан хэв хуулгыг авч, ШУА-ийн Одон орон-Геофизикийн судалгааны хүрээлэнтэй хамтран георадарын тандалт судалгааг давхар гүйцэтгэжээ.

Судлаач Р.Мөнхтулга, Т.Осава нар зарим хөшөөний бичээсийг цаасан хэвэнд тулгуурлан урьдчилсан байдлаар уншиж, 72 мөр, 3857 үсэг, 1193 үг, 86 орчим тамга байгааг тодруулан, *"орд гэр минь ээ"*, *"ноён минь ээ"*, *"нутаг минь ээ"* гэх үгсийн олон давтан бичсэн болохыг тайлж, үсэгзүй, хэл зүйн онцлог, тамганы хэлбэр, хавтан чулууны дүрслэл зэрэгт үндэслэн уг дурсгалыг 735-745 оны үед Түрэгийн хожуу хаант улсын, хааны дараа орох ураг төрлийн холбоо бүхий хэд хэдэн ихэс язгууртанд зориулсан дурсгал болохыг урьдчилсан байдлаар тогтоосон билээ.

2015-2016 онд Монгол-Японы хамтарсан "Дорнод Монголын эртний Түрэгийн үеийн түүх, археологийн судалгаа" төслийн хүрээнд "Донгойн ширээ"-ний цогцолбор дурсгалын ерөнхий бүтэц, зохион байгуулалтыг бүрэн тодруулах, гэрэлт хөшөөдийг бүртгэн баримтжуулах, эртний бичээс болон тамганы хэв хуулга авах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Археологийн малтлага судалгаа болон хэв хуулга авах ажлууд цааш үргэлжлэх бөгөөд бид энэ удаа "Донгойн ширээ"-ний цогцолбор дурсгалын ерөнхий зохион байгуулалт, гэрэлт хөшөөдийн баримтжуулалт зэрэг судалгааны шинэ үр дүнгээс танилцуулж байна.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Мөнххаан сумдын заагт орших Дэлгэрхаан хэмээх овоо тахилгатай томоохон уулыг нутгийн зон олон эртнээс хүндэтгэн дээдэлж, тахин шүтэж иржээ. Боржин чулуун тогтоцтой энэхүү уулийн ам болгон булаг шандтай, өвс ургамал тэгширсэн, байгалийн өвөрмөц сонин тогтоцтой бөгөөд энд чулуун зэвсгийн балар эртнээс эдүгээг хүртэл хүн тасралтгүй оршин амьдарч байсныг гэрчлэх олон зуун түүх, археологийн дурсгалууд оршин байдаг. Дэлгэрхаан уулын баруун өмнө талд холгүй орших, хоёр тал руугаа эрэглэн (30-40м өндөр), хойноос

өмнө зүгт сунаж тогтсон тэгш дэвсэгийгнутгийнхан *Донгойн Ширээ* хэмээнэ. Энэхүү тэгш дэвсэг дээр эртний Түрэгийн үед хамаарах тахил тайлгын сүрлэг байгууламж илэрч олдсон билээ.

Малтлага судалгааны үр дүнд гадна талаараа ялимгүй товгор, баруун хойноос зүүн урагш чиглэлтэй эвдэрсэн дөрвөлжин далан, түүний дотор мөн баруун хойноос зүүн урагш чиглэлтэй дөрвөлжин суваг байгаа нь тодорхой болсон юм. Уг сувагны дотор талд мөн баруун хойноос зүүн урагш чиглэлтэй, тойрсон дөрвөлжин хэлбэртэй нийт 11 ширхэг хөшөөний хугархай ёзоор, 1 хөшөөний нүх илэрсэн бөгөөд эдгээр тойрсон хөшөөнүүдийн төв хэсэгт тогоо хэлбэрийн хоёр нүх тус тус илэрч мэдэгдсэн юм. Төв хэсгийн баруун хойд талын нүхний ирмэгт цэцгэн хээтэй тахилын хавтангийн жижиг хээтэй ёзоор анхны байдлаараа илэрч, зүүн өмнө талын нүхэнд чигжээс чулуу олноор илэрсэн нь энэхүү төв хэсэгт тахилын хавтан хашлага, түүний өмнө хамгийн том гэрэлт хөшөөг босгосон байсныг нотлон харуулж байна. Харамсалтай нь уг дурсгалыг сүйтгэн, хожим нь төв хэсгийг тонуулчид дахин ухаж тоносон болох нь малтлагаар тогтоогдсон юм. Судалгааны явцад 48 ш хөшөөний хугархай эмх замбараагүй байдалтай илэрсэн бөгөөд эдгээр нь өөр хоорондоо эвлэн нийлж нийт 14 гэрэлт хөшөө болж байна. 14 гэрэлт хөшөөний 11 хугархай ёзоор анхны байрандаа илэрч олдсон юм (Зураг 1-4, 6). Мөн цэцгэн хээтэй тахилын хавтан чулууг олон хэсэг болгон эвдэж, тараасан байсан бөгөөд хавтангийн том, жижиг хагархай 30 орчим олдсон нь эвээр нийлж бүтэн болох боломжгүй байна. Хөшөө чулуудыг магадгүй орон нутгийн гаралтай хэд хэдэн төрлийн боржин чулуу ашиглан хийсэн ба гол төлөв хажуу ирмэгийг нь мөлийлгөн зассан гонзгой, зууван эсвэл 3-4 талт хэлбэртэй ажээ. Хамгийн өндөр 7-р хөшөө нь 6.4м байна. Нийт 14 гэрэлт хөшөөнд руни бичээс, 11 хөшөөнд тамга, 2 хөшөөнд хятаны бага бичээс (хар бэхэн болон сийлмэл) байх ажээ. 11 хөшөөнд 17 төрлийн (дан болон үүсмэл) 79 тамга тодорхой мэдэгдэх бөгөөд онги, дором, дөрвөлжин, янгир, саран тамгыг хамгийн олон дүрсэлжээ. Нэг хөшөөнд 1-17 хүртэлх тооны тамга сийлэхдээ голчлон хөшөөний дунд хэсэгт дүрслэх боловч дээд, доод хэсэгт дүрслэх тохиолдол ч байна. Малтлагын явцад суваг болон талбайн бусад хэсгээс хонь, ямаа, адууны яс, шагай, ваар савны хагархайнууд харилцан адилгүй гүнээс илэрч байв. Ваар савны хагархай нь харьцангуй олон бөгөөд орц найрлага, хэлбэр төрх, хээ, шатаалт зэргээрээ ялгаатай 3-4 төрлийн хагархай хэсгүүд байна. Дээврийн ваар болон тоосгоны хагархай цөөн тоогоор илэрч байв.

Судалгааны үр дүнд “Донгойн ширээ”-ний цогцолбор дурсгалын ерөнхий бүтэц, зохион байгуулалтыг илүү нарийвчлан тодруулж, гэрэлт хөшөөдийн байрлал, тахил тайлга үйлдэж байсныг гэрчлэх баримт илрүүлж, он цагийг тодруулах нэмэлт хэрэглэгдэхүүн олж чадсан юм.

Бидний үзэж буйгаар анх баруун хойноос зүүн өмнө зүгт хандсан дөрвөлжин хэлбэрийн суваг гарган (түүнээс гарсан шороо нь тарж намхан далан үүсгэсэн), сувагны дотор талд 12 гэрэлт хөшөөг тойруулан дөрвөлжин хэлбэртэй, тэгш хэмтэйгээр суулган тэдгээрийн голд буюу хоймор талд цэцгэн хээтэй тахилын хавтан хашлага, түүний өмнө талд энэхүү цогцолборын хамгийн өндөр хөшөөг тус тус

цогцлоон, улмаар сувагны гадна далд зүүн урагш чиглэсэн зэл чулуу байрлуулсан байжээ (Зураг 6). Ийнхүү байгуулахдаа төв хэсэгт босгосон хамгийн өндөр хөшөөний дор тахил тайлгын зан үйлтэй холбоотой зүйлийгтавьсан нь хожим тонуулчдын гарт сүйтгэгдсэн байна.

Судлаачид руни бичгийн үсэгзүй, хэлзүйн онцлог, тамгын хэлбэр, хавтангийн дүрслэл зэрэгт үндэслэн уг дурсгалыг 735-745 оны үед эртний Түрэгийн хожуу хаант улсын, хааны дараа орох ихэс язгууртанд зориулан байгуулсан хэмээн урьдчилсан байдлаар үздэг. Бид тойрсон сувгийн гүнд илэрсэн малын ясны дээжийг Япон улсад илгээн лабораторийн он цаг (C^{14}) тогтоолгоход *79.2%-тай 654calAD-715calAD (2 sigma),* талбайн төв хэсэгт орших гүн нүхнээс илэрсэн малын ясны дээж *48.5%-тай 1801calAD-1894calAD (2 sigma)* гэсэн үр дүн гарсан нь дээрх он цаг болон малтлага судалгааны үр дүн ойролцоо болохыг харуулж байна (Зураг 5). Харин уг дурсгал X зууны 1-р хагасыг хүртэлх хугацаанд эвдэрч сүйдээгүй байжээ гэх сэтгэгдэл төрүүлдэг. Учир нь уг дурсгалт газарт анх 13 гэрэлт хөшөө бүхий тахилын хашлагыг цогцлоон босгосон бөгөөд хожим нь тэдгээрийн нэг дээр кидан бичгийг хар бэхээр бичиж үлдээснээр үл барам дахин нэг сийлмэл кидан бичиг бүхий хөшөөг шинээр босгосон байх бүрэн боломжтой байна. Уг дурсгалыг чухам хэдийд бүрэн сүйтгэсэн нь одоогоор тодорхой бус бөгөөд ямар боловч XIX зууны үед дахин тонож, нүхээ булалгүй орхисон нь археологийн малтлага болон түүнээс илэрсэн олдвор хэрэглэгдэхүүн, лабораторийн үр дүнгээс тодорхой мэдэгдэж байна.

Энэхүү дурсгал нь одоогийн байдлаар эртний Түрэгийн томоохон дурсгалууд дотроо хамгийн зүүн захад орших, олон арван тамга тэмдэг, эртний түрэг, хятан бичээстэй 14 гэрэлт хөшөө бүхий сүрлэг цогцолбор дурсгал болж байгаагаараа онцлог юм. Цаашид уг цогцолбор дурсгалыг бүрэн малтан судлах, бичээсийг тайлах, тамгыг харьцуулан судлах, энэ бүс нутгаас шинээр илэрсэн ижил төрлийн дурсгалуудыг харьцуулан судлах, гэрэлт хөшөөдийг сэргээн засварлах, хадгалж хамгаалах зэрэг олон талт ажлуудыг төлөвлөж байна.



Зураг 1. Донгойн ширээний дурсгалын дэвсгэр тойм зураг

Зураг 2. Малтлагын талбайд гэрэлт хөшөөдийг ил гаргасан байдал

Зураг 3. Гэрэлт хөшөөдийн хуулгыг авч байгаа нь



Зураг 4. Гэрэлт хөшөөд болон тэдгээрийн ёзооруud илэрсэн байдал

表2 放射性炭素年代測定結果（δ^{13}C未補正値、暦年較正用^{14}C年代、較正年代）

測定番号	δ^{13}C補正なし Age (yrBP)	δ^{13}C補正なし pMC (%)	暦年較正用(yrBP)	1σ暦年代範囲	2σ暦年代範囲
IAAA-150923	1,190 ± 20	86.21 ± 0.25	1,323 ± 23	658calAD - 690calAD (60.8%) 752calAD - 760calAD (7.4%)	654calAD - 715calAD (79.2%) 744calAD - 765calAD (16.2%)
IAAA-150924	60 ± 20	99.28 ± 0.25	236 ± 21	1649calAD - 1665calAD (49.4%)* 1785calAD - 1793calAD (18.8%)*	1641calAD - 1670calAD (59.7%)* 1780calAD - 1800calAD (32.2%)* 1943calAD - ... (3.5%)*
IAAA-150925	Modern	100.35 ± 0.26	126 ± 21	1684calAD - 1706calAD (12.4%)** 1719calAD - 1734calAD (8.2%)** 1807calAD - 1820calAD (7.2%)** 1833calAD - 1883calAD (31.3%)** 1914calAD - 1929calAD (9.0%)**	1680calAD - 1764calAD (32.3%)** 1801calAD - 1894calAD (48.5%)** 1906calAD - 1939calAD (14.6%)**
IAAA-150926	1,320 ± 20	84.86 ± 0.25	1,321 ± 24	659calAD - 690calAD (58.0%) 751calAD - 761calAD (10.2%)	655calAD - 715calAD (76.9%) 743calAD - 766calAD (18.5%)

[参考値]

Зураг 5. Малтлагаар илэрсэн ясны дээжний лабораторийн үр дүн
(Япон улс, Institute of Accelerator Analysis Ltd.)



Зураг 6. Дурсгалыг сэргээн зурсан байдал

Зураг 7. Судалгааны ангийн бүрэлдэхүүн 2016 он

ЖАРГАЛАНТЫН АДГИЙН ШИРЭЭ, РАШААНЫ ТЭЭГ БА ЧУЛУУТ ГОЛД ХИЙСЭН ХАДНЫ ЗУРГИЙН СУДАЛГАА

Ц.Төрбат, Н.Батболд, Д.Батсүх

"Монголын хүрэл ба түрүү төмрийн үеийн археологийн судалгааны тулгамдсан асуудлууд ба шинэлэг шийдлүүд" суурь судалгааны сэдэвт ажлын хүрээнд 2016 оны 7 дугаар сарын 2-ноос 7 дугаар сарын 11-ний хооронд хадны зургийг бүртгэн баримжуулах, шинээр нээн илрүүлэх ажлыг Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбарын ажилтнууд хийж гүйцэтгэв. Судалгааны ажил Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Жаргалантын Адгийн ширээ хад, Рашааны Тээг ба Архангай аймгийн Тариат сумын Чулуут голын хөндий дэх зарим хадны зургийн дурсгалт газруудад явагдаж гэрэл зураг, микалент хуулга, полиэтилен хуулгыг авч баримтжуулах ажлыг хийжээ.

Жаргалантын Адгийн ширээ хадны зураг

Тус шинжилгээний анги Дорноговь аймгийн Эрдэнэцагаан сумын нутгаас чулуун зэвсгийн үеэс төмөрлөг зэвсгийн үеийн заагт холбогдох Монголын археологийн судалгаанд томоор тэмдэглэгдэх хэмжээний ач холбогдол бүхий нэн ховор цогцолбор дурсгал болох Жаргалантын Адгийн ширээ хадны зургийг илрүүлэн бүрэн баримтжуулсан болно. Уг дурсгалыг "Сувдан Сондор" түүх соёлын аяллын үеэр СГЗ Г.Мэнд-Оёо тэргүүтэй судлаачид анх илрүүлэн мэдээлжээ. Мөн Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэн баримтжуулах ажлын хүрээнд БСШУЯ-ны харьяа Соёлын өвийн төвийн судлаачид 2008 онд үзэж 2011 онд гэрэл зургийг хэвлүүлсэн байна [Энхбат, Даваацэрэн, 2011: 73].

Жаргалантын Адгийн ширээ хад хэмээх газар нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын төвөөс баруун хойд зүгт 30-аад км зайд Жаргалант багийн нутагт оршино. Жаргалантын Адгийн ширээ хад нь эртний голын сайр болоолтой хөндийн дагуу үргэлжлэх эргийн дагуу байрлах хад чулуу бүхий өндөрлөг газар юм. Энэ эргийн дагуух хад чулууны гадаргуу дээр олон тооны хадны зурагтай ажээ. Бид 26 хадан дээр зуу илүү дүрс тэмдгийг баримтжуулж авсан болно.

Жаргалантын Адгийн ширээ хадны зураг дахь хүний нүүрний дүрслэл

Жаргалантын Адгийн ширээ хадны зургууд нь ихэвчлэн хүний нүүрний дүрслэл, буга, адуу зэрэг амьтдын дүрслэл байна.Хад чулуунаа хүний нүүр дүрслэх явдал нь эртний хүмүүсийн сүсэг бишрэл, ертөнцийг үзэх үзэл, тодорхой төрлийн зан үйлтэй салшгүй холбоотой. Юуны түрүүнд эдгээр нь бөөгийн шашинтай нягт уялдаатай нь тодорхой юм. Судлаачдын бүтээлээс үзэхэд бөө нар хүчирхэг жигүүртэн, араатан амьтад шүтэхийн зэрэгцээ өөрсдийн өвөг дээдсийг онголон шүтэх болсон цагаас бөөгийн малгайд хүний нүүр толгойн долоон сүвийг дүрсэлдэг болсон гэж үздэг ажээ. Одоо ч гэсэн бөөгийн өмсгөл малгай дээр хүний ам, хамар, хөмсөг зэргийг дүрсэлсэн байдаг нь хадны зураг дахь зарим дүрслэлтэй тун төстэй байдаг. Бөө нар малгайгаа уг бөөд залран ирж буй онгод сахиусны толгой гэж үздэг нь эрт үеэс уламжлагдан одоог хүрч ирсэн байх магадлалтай тул хадны зураг дахь хүний нүүрний дүрслэл нь тохиолдлын чанартай зурагдаагүй гэдэг нь тодорхой байна.



Жаргалантын адгийн ширээ хадны зарим дүрслэл

Жаргалантын Адгийн ширээ хадны зураг дахь хүний нүүрний дүрсүүд Хятадын хойд бүс нутгийн хадны зураг дахь багны дүрстэй ихэд төстэй байдал ажиглагдаж байна. Тухайлбал, Хятадын Иншань уулын хадны зураг дахь хүний

нүүрний дүрслэлтэй бараг адилхан байх ажээ. Хүний нүүрний дүрслэлийг утга санааны хувьд хятадын судлаачид энэ нь балар эртний хүний сахиусан буюу сэтгэшгүй ад чөтгөрийг дүрсэлсэн төдий биш, харин тэнгэрийн сахиусан наран саран ба од эрхэс зэрэг шүтээний дүр, тэдний хүншүүлсэн хэлбэрийн тусгал хэмээн тайлбарласан байдаг [Эрдэнэбат, 2008: 33].

Монголын говь болон зүүн бүс нутгаас эртний хүмүүсийн шүтлэг бишрэлтэй холбогдолтой зураг, тухайлбал, хүний нүүрний дүрслэл, нар сарны дүрслэл бусад нутаг дахь зургийг бодвол их тоотой олдож байгаа нь чулуун зэвсгийн сүүл энеолит, хүрэл зэвсгийн үед энэ бүс нутаг өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой соёлын нэгэн бүс нутаг байсныг харуулж байна.

Жаргалантын Адгийн ширээ хад хэмээх газраас шинээр илэрч олдсон хүний нүүрний баг бүхий зургууд нь ихээхэн сонирхолтой бөгөөд шинэ чулуун зэвсгийн сүүл, энеолитын үед холбогдох магадлалтай юм.

Рашааны Тээгийн тамга тэмдгүүд

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт сумын төвөөс хойш 70 км орчим зайд Рашааны тээг гэх эртний дурсгалт газар оршино. Уг дурсгалыг "Сувдан Сондор" түүх соёлын аяллын үеэр СГЗ Г.Мэнд-Оёо тэргүүтэй судлаачид анх илрүүлэн мэдээлжээ.

Уг дурсгал нь эртний тамга тэмдэг бүхий 3 хүрмэн чулуунаас бүрдэх юм. Одоогийн байдлаар эдгээр чулууд сул задгай хэвтэж буй бөгөөд тамга тэмдэггүй бусад чулуудаас ялгагдах юмгүй байдалтай юм.

Манай судалгааны баг Рашааны тээгийн тамгат чулуудыг үзээд монголчуудын дээд өвөг болох хүннү нарын тамга тэмдэг болохыг тогтоосон болно. Тэгэхдээ Хүннүгийн язгууртан ургийн тамга мөн хэмээн үзсэн болно.

Рашааны Тээгийн тамга тэмдэг бүхий чулуунууд

Үүнтэй ижилсэх тамга тэмдгүүд Говь-Алтай аймгийн Цагаан гол, Ховд аймгийн Ямаан ус ба Харгайтын бэлчир зэрэг газрын хаднаа сийлэгдсэн байхаас гадна Ноён

уул, Гол Модны Хүннүгийн хаад язгуууртны бунханаас гардаг билээ. Түүгээр зогсохгүй Төв аймгийн Тэрэлжийн дөрвөлжингийн дээврийн нүүр ваар, Буриадын Дөрөөгийн суурин, Хятадын Шэньси мужийн Дабаодангийн булш зэргээс илэрсэн нь бүгд Хүннүгийн хаад язгууртантай холбоотой юм. Судлаачид эдгээр бүх тамга тэмдгийг Хүннүгийн хаан ураг болох люаньди буюу Сюйляньти овгийн тамга гэдэгт эргэлзээгүй итгэж байна [Төрбат нар, 2012:136-161].

Манай улсын зүүн өмнөд хилийн бүс нутагт Хүннүгийн хаан ургийн тамга тэмдэг илэрсэн нь эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой үйл явдал болсон билээ. Иймд уг дурсгалын ач холбогдол, хадгалалтын эмзэг байдал зэргийг харгалзан үзэж хамгаалалтын арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай болно.

Чулуут голын хадны зураг

Архангай аймгийн Тариат, Өндөр-Улаан сумын нутаг Чулуут голын эрэг дагуух олон газрын бул чулуунууд дээр эртний хүмүүсийн цоолборлон урласан олон тооны зурагтай ажээ. Эндэхийн хадны зургийг анх 1977 онд нээн илрүүлсэн ба МЗТСХЭ-ийн Хүрэл, төмөр зэвсгийн дурсгал судлах анги олон тооны хадны зураг бүртгэсэн мэдээтэй боловч бүхэлд нь нийтэлсэн зүйл одоо хэр үгүй байна [Монгол ..., 1999: 63].

Чулуут голын нэгэн хэсэг

Эндэхийн хадны зурагт гараа өргөн дэлж тохойгоороо нугалан унжуулсан, хөлөө алцайлгаад төрж буй зургаан эмэгтэй, хүүхэд төрүүлж буй бугын эвэртэй эмэгтэй, хоорондоо нь залгуулан дээрээс доош цувуулж дүрсэлсэн гурван эмэгтэй зэрэг тухайн үеийн хүмүүсийн үржил, нөхөн үрхижүйг илтгэн харуулсан сонин зургууд дүрслэгдсэн байдаг [Новгородова, 1984; Санжмятав, 1993] ба хоорондоо нь залгуулан дүрсэлсэн эмэгтэйчүүдийн дүрсээр нэг эхээс удамтай хэдэн үеийг харуулсан бололтой хэмээн судлаачид үзсэн байдаг [Монгол ..., 1999: 63].

Чулуут голын хадны зургийн дотроос гурван хуруутай гараа дэлж өргөсөн эрэгтэй эмэгтэй хүн, багтай хүн, эрээлсэн биетэй үхэр, буга, аргаль зэрэг амьтны дүр бүхий зохиомжтой зургуудын насыг судлаачид Өмнөд Сибирийн нутгаас олдсон ижил төстэй хадны зургуудтай харьцуулан неолит, энеолитын үед холбогдуулан үздэг [Монгол ..., 1999: 63].

Энэ удаад бид дээрх сэдэв зохиомж бүхий зургуудыг олж баримтжуулах зорилгоор Чулуут голын сав дагуух Хамрын булан, Аваргын булан зэрэг газруудад хайгуул хийсэн болович тийм зургуудыг олж чадаагүй болно. Гэхдээ тухайн газруудад өөр сэдэв зохиомж бүхий олон тооны хадны зургуудыг үзэж бүртгэн баримтжуулсан юм.

Чулуут голын хөндийд бодит ба загварчилсан аргаар урласан буга, морин тэрэг, янгир, аргаль, ирвэс, шилүүс, чоно, нохой, үхэр, адуу, ан гөрөө хийж байгаа, хоорондоо байлдаж буй сэдэв бүхий олон тооны зураг бий бөгөөд тэдгээрийн ихэнх нь хүрэл, түрүү төмрийн үед холбогдоно. Бид дараа дараагийн судалгаагаар Чулуут голын хадны зургийг бүгдийг нь бүртгэн баримтжуулж хэвлэн нийтлэх төлөвлөгөөтэй байгаа болно.

Чулуут голын хадны зураг дахь амьтдын дүрслэл

Тэрэгний дүрслэл

Ашигласан ном

Монгол ..., 1999 - Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал. УБ. 286 тал.

Новгородова, 1984 - Э.А. Новгородова. Мир петроглифов Монголии. М.

Санжмятав, 1993 - Т.Санжмятав. Архангай аймгийн түүх, соёлын дурсгалууд. УБ.

Төрбат нар, 2012 – Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү. Хүннүгийн археологийн тамгууд Дюаньди овгийн тамга болох нь. – Археологийн судлал. Боть XXXII, Дэвтэр 9. УБ., тал 136-161.

Энхбат, Даваацэрэн, 2011 – Г.Энхбат, Б.Даваацэрэн. Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. Сүхбаатар аймаг. II дэвтэр. –Улаанбаатар. - 82 тал.

Эрдэнэбат, 2008 – У.Эрдэнэбат. Хахуулын голын хадны зураг. //Археологийн судлал. T.(VI) XXVI, fasc. 3. –Улаанбаатар. - Тал 32-56.

МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН “ДОРНОД МОНГОЛ: АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГАА” ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Ч.Амартүвшин, З.Батсайхан, Г.Галдан, Б.Батдалай,
Б.Бадма-Оюу, У.Ханичёрч, Ж.Врайт, Р.Нельсон

Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол: археологийн хайгуул судалгаа” төсөл нь 2013 оноос эхлэн монгол орны зүүн бүс нутагт археологийн нарийвчилсан хайгуул, чулуун байгууламжит дурсгалын малтлага судалгааг үргэлжлүүлэн хийж байна.

Уг хамтарсан төслийн багийнханы гол зорилго бол эртний нүүдэлчдийн төрт улсын нийгэм, эдийн засгийн зохион байгуулалтыг археологийн хэрэглэгдэхүүнээр тодруулах явдал юм. Энэхүү зорилгот хүрэхийн тулд Монголын газар зүйн хувьд ялгамжтай бүс нутгуудад үе шаттайгаар археологийн хайгуулын арга зүйг шинээр боловсруулж эртний нүүдэлчдийн бууц суурин, булш оршуулга, хөшөө дурсгалыг шинээр илрүүлэн олж мэдээллийн санг бүрдүүлэх, шинжлэх ухааны олон талт нягт судалгааг гүйцэтгэсээр ирсэн билээ.

2016 онд тус төсөлд Монголын талаас ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Археологи, угсаатны зүйн авран хамгаалах салбарын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, Археологийн судалгааны төвийн музей-лабораторийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Г.Галдан, Археологи, Угсаатны зүйн авран хамгаалах салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б.Батдалай, Археологи, Угсаатны зүйн авран хамгаалах салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор Б.Бадма-Оюу, МУИС-ийн Археологи-Антропологийн тэнхимийн багш, доктор, профессор З.Батсайхан, АНУ-ын талаас Ийелийн Их сургуулийн профессор, доктор У.Ханичёрч, Их Британи улсын Абердины Их сургуулийн Археологийн тэнхимийн доктор Ж.Врайт, АНУ-ын антропологич доктор Р.Нэльсон, ХБНГУ-ын Килийн Их сургуулийн докторант С.Плэугэр нараас гадна МУИС, ШУС-ийн Антропологийн тэнхимийн 10 оюутан оролцон Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан ууланд 2016 оны 7-р сарын 20-ноос 8-р сарын 18-ны өдөр хүртэл ажиллав.

Хайгуул судалгаа

Тус судалгааны багийнхан энэ жил тус тус 5 хүний бүрэлдэхүүнтэй хоёр хайгуулын багт хуваагдан нийт 30км^2 талбайд археологийн нарийвчилсан хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Хайгуул судалгааны явцад 425 хайгуулын дугаарт, 698 тооны дурсгал илрүүлэн бүртгэн баримтжуулжээ. Эдгээрт, чулуун байгууламжит дурсгал 307 хайгуулын дугаарт 550, эртний нүүдэлчдийн бууц суурингийн дурсгал 147, хад чулуунаа дүрсэлсэн зураг бичээс 2 багтаж байна.

Чулуун байгууламжит дурсгал. Энэхүү төрлийн дурсгалуудад хүрэл зэвсгийн үеэс дундад зууны үе хүртлэх дурсгалууд багтаж байгаа ба үүнд, шоргоолжин булш,

Улаан зуух хэлбэрийн булш, хиргисүүр, дөрвөлжин булш, хүннү булш, дундад зууны үеийн булш оршуулгын дурсгал, түрэгийн үеийн тахилын чулуун байгууламж, балбал чулуу зэргээс гадна он цаг, үүрэг зориулалт тодорхойгүй олон тооны чулуун байгууламжит дурсгалууд багтаж байна.

Үүнд, хүрэл зэвсгийн үед хамаарах чулуун байгууламжит дурсгалуудад шоргоолжин булш 9, улаан зуух хэлбэрийн булш 147, хиргисүүр 8, дөрвөлжин булш 15 байгаагаас гадна тухайн үед хамаарч болзошгүй чулуун байгууламж 51 байна. Эдгээр хүрлийн үеийн цогцолбор дурсгалуудтай зэрэгцэн байгаад тулгуурлан бид тухайн үеийн дурсгалын төрөлд хамруулан авч үзэж байна.

Харин хүннүгийн үед холбогдох булш оршуулга 21, түрэгийн үед хамаарах тахилын болон бусад чулуун байгууламжит дурсгалууд 25, дундад зууны үед хамаарах булш оршуулгын дурсгал 74 байна.

Хүснэгт 1: Хайгуул судалгааны ажлын үр дүн

Он цаг	№	Дурсгалын төрөл	Тоо
Чулуун зэвсгийн үе	1	Хуучин чулуун зэвсгийн үеийн бууц суурин	1
	2	Шинэ чулуун зэвсгийн үеий бууц суурин	30
Хүрэл зэвсгийн үе	3	Хүрэл зэвсгийн үеийн бууц суурин	14
	4	Хиргисүүр	8
	5	Шоргоолжин булш	9
	6	“Улаан зуух” хэлбэрийн булш	147
	7	Дугуй булш	9
	8	Дөрвөлжин булш	15
	9	Бусад чулуун байгууламж	51
Хүннүгийн үе	10	Хүнну булш	21
	11	Хүннүгийн үед холбогдох бууц суурин	7
Эртний улсуудын үе	12	Түрэгийн үед холбогдох бууц суурин	19
	13	Түрэгийн үеийн чулуун байгууламжит дурсгал	25
Дундад зууны үе	14	Дундад зууны үеийн булш	74
	15	Бууц суурин	43
Он цаг тодорхойгүй	16	Чулуун хороо	15
	17	Чулуун байгууламж	195
	18	Бууц суурин	9
	19	Хөшөө	5
НИЙТ			697

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул нь боржин чулуун үеэлсэн хавтгай хадтай уулсаас тогтох бөгөөд чулуун байгууламж байгуулах түүхий эд болох хад чулуу элбэгтэйн учраас энэхүү бүс нутагт түүхийн олон үед хамаарах

чулуун байгууламжит дурсгалууд маш их байх ба түүхийн үечлэлийн аль үед хамаарах нь тодорхойгүй, мөн манай археологийн үечлэл болон ангилалын төрөлд урьд өмнө илэрч тэмдэглэгдэж байгаа өвөрмөц сонин гадаад зохион байгуулалтай чулуун байгууламжит дурсгалууд олон тоогоор (195 ш) илрээд байна.

Малтлага судалгаа

Тус төслийн хээрийн шинжилгээний ангийн малтлага судалгааны багийнхан 10 газарт нийт 16 малтлага судалгааны ажил хийжээ. Малтлагад хүрэл зэвсгийн үед хамаарах хиргисүүрийн дагуул байгууламж, Улаан зуух хэлбэрийн булш, төмрийн түрүү үед холбогдох дөрвөлжин булш, дундад зууны үеийн булш болон тахил тайлагын чулуун байгууламжуудыг малтан судалжээ. Ингэхдээ хиргисүүрийн дагуул байгууламжаас он цаг тогтоох дээж авах зорилготойгоор малтсан бол Улаан зуух хэлбэрийн булшнаас он цаг тогтоох дээж болон эд өлгийн (ваар, ваарны хагархай) зүйлс илрүүлэх зорилготойгоор малтахад хиргисүүрийн дагуулаас шатсан ясны хэсгүүд болон адууны ясны хэсэг зэрэг найдвартай он цагийг тогтоох баттай баримт илрүүсэн. Ингэснээр бид тухайн бүс нутгаас илрүүлсэн хиргисүүрийн байгуулагдах үеийн үнэмлэхүй он цагийн багцаатай болох ба энэ нь манай төслийн багийн судалгаанд төдийгүй Монголын археологийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулах мэдээ хэрэглэгдэхүүн болно гэдэгт найдаж байна.

Улаан зуух хэлбэрийн булшны малтлаганаас чулуун дараасны гадна талаас адууны ясны цөөн тооны хэсгүүд мөн чулуун дараасны дотор талаас мөн адил адууны ясны хэсгүүд илрүүлснээс өөр зүйлс олж чадаагүй болно.

Харин төмрийн түрүү үеийн дөрвөлжин булшны малтлагаар тоногдож сүйдсэн оршуулга болон товгор наамал хээтэй ваарны хагархай илэрсэн. Бид энэхүү дурсгалаас он цаг тогтоох болон бусад лабораторийн шинжилгээнд өгөх дээжнүүд авсан болно.

Мөн энэ жил малтлага судалгааны багийнхан Дэлгэрхаан ууланд хийсэн өмнөх жилүүдийн хайгуул судалгаагаар илрүүлсэн өвөрмөц онцлог гадаад байгууламжтай дурсгалуудыг малтан судалсан бөгөөд эдгээр дурсгалууд нь дундад зууны үеийн оршуулга болон тахил тайлагад зориулсан дурсгалууд болох нь малтлагаас илэрсэн олдвор хэрэглэгдэхүүнээр тогтоогдоод байна.

Угсаатны зүйн судалгаа

Монгол-Америкийн хамтарсан "Дорнод Монгол, археологийн хайгуул судалгаа" төслийн нэгэн онцлог бол тухайн бүс нутагт археологийн хайгуул, малтлага хийхээс гадна угсаатны зүйн судалгаа хийж тухайн бүс нутгийн хүн амын аж ахуй, соёлын онцлогийг судлан археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнгээ баяжуулах зорилготойгоор ажилладаг билээ. Энэ жил манай угсаатны зүйн багийнхан 2016 оны 8 сарын 6-14-ний хооронд 8 хоногийн хугацаатай ажиллав.

Энэ удаагийн угсаатны зүйн хээрийн судалгаагаар Дэлгэрхаан уулын орчмын хүн ам, аж ахуй соёлын онцлогийг тодруулах зорилт тавьсан ба судалгаанд нийт 1 гал голомтоос салбарласан нэг удмын 16 айл хамрагдлаа.

Түвшинширээ сумын Дэлгэрхаан баг бол Дэлгэрхаан уулын орчим нутаглах багахан баг бөгөөд багийн даргын өгсөн мэдээгээр тус баг 150 гаруй хүн амтай ба тэдгээр хүмүүсийн ургийн овог нь ерөнхийдөө Дэлгэрхаан овогтой 60 хүн, Боржигин овогтой 20 хүн, Агий овогтой 10 хүн, Хүүхэн бошигт овогтой 17 хүн, Зүүн чулуу овогтой 10 гаруй хүн болон бусад овгоос бүрдэж байдаг ажээ.

Дараа дараагийн жилүүдэд угсаатны зүйн багийнхан ажлын цар хүрээгээ илүүтэйгээр тэлэх ба ажиллах хугацаа бүрэлдэхүүнээ нэмэгдүүлэн зөвхөн Дэлгэрхаан уул төдийгүй бүс нутгийн хэмжээнд судалгаа үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байгаа ба үүнийгээ дагаад судалгааны үр дүн маань илүү нарийн олон талыг хамрах нь тодорхой билээ.

Төгсгөл

Төслийн багийн нийт 30 хоногийн хугацаатай ажиллахдаа нийт 30 $км^2$ талбайд археологийн нарийвчилсан хайгуул судалгааны ажлыг хийн 425 хайгуулын дугаарт, 698 тооны дурсгал илрүүлэн бүртгэн баримтжуулжээ. малтлага судалгааны багийнхан 10 газарт нийт 16 малтлага судалгааны ажил хийв. Үүнд, хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүрийн дагуул байгууламж, Улаан зуух хэлбэрийн булш, төмрийн түрүү үед холбогдох дөрвөлжин булш, дундад зууны үеийн булш болон тахил тайлагын чулуун байгууламжуудыг тус тус малтан судалжээ.

Хиргисүүрийн малтлага судалгаа нь түүний дагуул байгууламжаас он цаг тогтоох дээж авах, түүний бүтэц зохион байгуулалтыг тодруулах зорилготой байв. Мөн Улаан зуух хэлбэрийн булшнаас нарийвчилсан он цагийг тогтоох дээж болон эд өлгийн (ваар, ваарны хагархай) зүйлс илрүүлэх, булшны гадаад зохион байгуулалт, оршуулгын бүтцийг тодруулах, өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулах зорилго тавин ажилласан юм. Ингэснээр хиргисүүрийн дагуул байгууламжаас шатсан ясны хэсэг болон адууны ясны хэсэг, Улаан зуух хэлбэрийн булшны дараасны гадна талаас мөн адууны ясны хэсгийг илрүүлэн олж он цаг тогтоох боломжит дээжнүүдийг цуглуулж чадсан нь тухайн бүс нутгаас илрүүлсэн хиргисүүрийн байгуулагдах үеийн үнэмлэхүй он цагийн багцаатай болох өөр бүс нутгуудад судлагдсан нэгэн төрлийн дурсгалуудтай харьцуулан судлах боломжтой болж байна.

Манай төслийн багийн 2015 болон 2016 онд хийсэн хайгуул болон малтлага судалгаагаар илрүүлсэн зарим олдвор хэрэглэгдэхүүнээс он цаг тогтоох болон бусад лабораторийн нарийн шинжилгээ судалгаанд дээж бэлтгэн АНУ-д илгээн үр дүн хүлээж байна.

Зураг 1. Хайгуул судалгаа

Зураг 2. Ex16.03 малтлага судалгааны явц

МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДАХЬ ХҮННҮГИЙН ХОТ СУУРИНЫ СУДАЛГАА ТӨСЛИЙН 2016 ОНЫ АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА СУДАЛГАА

Л.Эрдэнэболд, Н.Н.Крадин,
А.Л.Ивлиев, С.А.Васютин, Р.Төгссайхан

Монгол-ОХУ-ын хамтарсан “Монгол улсын нутаг дахь Хүннүгийн хот суурин” төслийн хүрээнд 2016 оны 8-р сард Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Тэрэлжийн дөрвөлжин хэмээх дурсгалд малтлага судалгаа хийсэн юм.

Тэрэлжийн дөрвөлжин хэмээх энэхүү хуучин хотыг анх 1930-аад оны үед Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов, буриад эрдэмтэн Базар Бараадин нар илрүүлэн олсон байдаг. Дараа нь Монголын эрдэмтэн Х.Пэрлээ 1960-аад оны үед бага хэмжээний сориц малтлага хийж Хүннү улсын үед холбогдох боломжтой гэсэн дүгнэлтийг гаргажээ.

Тэрэлжийн дөрвөлжин хот нь Мөнгөнморьт сумын нутаг, Хэрлэн голын зөв талаас цутгадаг Тэрэлж голын зүүн хөвөөнд Баянжаргалан уулын урд дэвсэг торшино. Тэрэлжийн дөрвөлжин хэмээх уг хот нь шороо дагтаршуулсан дөрвөн тал хэрэм бүхий дөрвөн талдаа дөрвөн хаалгатай байсан бөгөөд хэрмийн гадуур суваг гүн сувагтай байжээ.

2007, 2008, 2014, 2015 онуудад Монгол Оросын хамтарсан Хүннүгийн дурсгал судлах ангийнхан дээрх дурсгалт газарт өргөн хэмжээний малтлагыг хийсэн бөгөөд хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлжээ. Бидний 2016 оны судалгаа нь дээр өгүүлсэн судалгааны ажлын үргэлжлэл болно.

2016 онд бид Тэрэлжийн дөрвөлжин хотын туурind дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд,

- Тэрэлжийн дөрвөлжин хотын ерөнхий дэвсгэр зургийг нарийн мэргэжлийн багаж хэрэгсэлийн тусламжтайгаар хийж дуусгав.
- Тэрэлжийн дөрвөлжин балгасны орчин тойронд археологийн нарийвчилсан хайгуул судалгааг явуулав.

  Хэрмийн дотор болон ойр орчимд нь геофизикийн болон гео соронзоны орны судалгааг үргэлжлүүлэн явуулав.
- Тэрэлжийн дөрвөлжин хотын хэрмийн дотор нэгэн жижиг балгасны туурind өнгөрсөн жилийн малтлагыг үргэлжлүүлэн 12х6,0 метр хэмжээтэй малтлагыг явуулж уг хотын түүхэн он цаг барилгын бүтэц зохион байгуулалт, барилга архитектурийн онцлог, эдийн соёлын хөгжил, мэдлэг ухаан зэрэг олон асуудлуудад хариулт өгөхийг зорьлоо.

Бид өмнөх жилийн малтлагыг үргэлжлүүлсэн бөгөөд 2015 онд малтсан өмнө талын 1-3 хүртэлх дугаарласан секторуудын малтлагыг үргэлжүүлэн 4, 5, 6-р секторт

явуулав. Үүний үр дүнд өнгөрсөн жилийн малтлагаар төдийлөн тодорхойгүй байсан олон асуудал тодорхой болов.

Ингэхдээ малтлагыг тодорхой болгох үүднээс өмнөөс хойш 18 метр, баруунаас зүүнш 6 метр малтлагын тэгийг татаж, түүнийгээ дотор нь 6х6 метрээр 1 сектор болгон хуваав. Мөн баруунаас зүүн тийш тоогоор буюу өмнөх жилийн малтлагыг үргэлжлүүлэн 7-12 хүртэл дугаарлан, хойноос урагш латин цагаан толгойн үсгийн дараалалаар A-R хүртэл нарийвчлан дугаарлаж тэдгээрийн хооронд таарч байгаа хэсгийг 1х1 метрийн хэмжээ бүхий өргөөр нарийвчлан тодорхойлов. 4.5.6-р сектор нь малтлагын талбайн төв хэсгийг дайрна. Тэрчлэн сектор тус бүрийн хооронд 50см өргөнтэй зүсэлтийн даланг үлдээн малтсан юм. Хойноос урагш үргэлжилсэн зүсэлтийн даланг малтлагын талбайн баруун хананд үлдээсэн бол баруунаас зүүн тийш үргэлжилсэн зүсэлтийн даланг хойт талын малтлагын талбайд үлдээж зураглалд тэмдэглэн баримтжуулав. Бүх талбайдад малтлагыг жигдхэн үргэлжүүлсэн бөгөөд тухай бүр нь гэрэл зургийн болон гар зургийн баримтжуулалт хийлээ. Малтлагын гүн дунджаар 25 -130м үргэлжилсэн бөгөөд байгалийн хөрсөнд тулсанаар малтлагыг зогсоов. Мөн зарим тохиолдолд түүхий тоосгоор өрсөн хана бололтой хэсгүүд таарч байсан бөгөөд тэдгээрийг үлдээж малтлагыг үргэлжлүүлсэн юм.

Малтлагын 1-р үеийн тодорхойлолт

Эхний үеийн малтлагыг ихэвчлэн ургамалын бүрхэвчийг цэвэрлэх ажлаар эхлүүлсэн бөгөөд их хэмжээтэй ургамалын үндэс бор хүрэн ялзмагжсан хөрс зонхилон илэрлээ. Зарим газартаа газрын гүнээс мэрэгчийн хөлөөр зөөгдөн гарсан бололтой чулуурхаг хайрган хөрс илэрч байв. Малтлагын талбайд хэд хэдэн мэрэгчийн нүх байлаа. Тэрчлэн малтлагын талбайн хойт хэсэг нь барилгын овгороос буусан нам дор хэсэг учир бороо цасны усаар угаагдан нилээд тарсан шинжтэй холимог хөрс гарч байв. 1-р үеийн малтлагыг 10-12 см орчим гүнтэйгээр бүрэн цэвэрлэж үзвэл бор саарал шаварлаг хөрс бүхий талбай ил гарав.

Малтлагын 2-р үеийн тодорхойлолт

2-р үеийн малтлагыг мөн адил 10 орчим см гүнтэйгээр малтсан бөгөөд хөрсний бүтэц нь ялзмагжсан зөөлөн бор хүрэн хөрс дуусаж цагаан шаргал шаварлаг хөрс зонхилон илрэв.

Энэ хөрс нь барилгын нурангиас бороо усны улмаас зөөгдөн урсаж тогтсон бололтой. Энэ үеэс эхлэн бүх талбайгаас барилгын хэрэглэгдэхүүн дээврийн ваарны хагархай бөөн нэг дор байдалтайгаар олон тоотой илэрч олдлоо. Секторын төв хэсэг 1-р үеэс илэрч байсантай ижил зурвас байдлаар мөлгөр нарийн ширхэгтэй хайрган хөрс зурвас байдлаар илэрсээр байв. Энэ үеийн малтлагаас 1108 ш барилгын хэрэглэгдэхүүний хагархай олдлоо.

Малтлагын 3-р үеийн тодорхойлолт:

3-р үеийн малтлага мөн *л* өмнөх үеийн адил 12-15см орчим гүнтэйгээр үргэлжилсэн бөгөөд бор саарал, шаргал өнгөтэй нунтаг нуугисан хөрс үргэлжлэн илэрсээр байлаа. Энэ үеэс эхлэн 1-р үеийн хувьд барилгын доор барьж өндөрлөсөн шавар суурьт хүрсэн бололтой. Учир нь энэ үеэс эхлэн барилгын хэрэглэгдэхүүн

материал илрэхгүй бол зөөлөн шаргал шавар хөрс нь ихээхэн хатуу дагтаршуулсан хөрсөнд тулсан юм. Гагцхүү малтлагын талбайн хойт хэсэг буюу барилгын суурийн зах хаяа хэсгүүдэд цөөн тооны дээврийн ваарны хагархай илэрсээр байв. Энэ нь барилгын өндөрлөсөн довжооноос нурж тарсанаас үүдэлтэй бололтой. Малтлагын талбайн зүүн хэсэг буюу A-F 2, 3-р өргөөс зүүн тийш хатуу дагтаршуулсан шар шавар хөрсөнд тулсанаар малтлага дууссан бол малтлагын талбайн баруун захаар хөрс нь зөөлөн олдвор илэрсээр байсан тул бид цааш малтлагыг үргэлжлүүлсэн юм. Энэ үеийн малтлагаас нийт 121 ширхэг олдвор хэрэглэгдэхүүн цугларав.

Малтлагын 4-р үеийн тодорхойлолт:

Энэ үеийн малтлагыг малтлагын талбайн бүр үеэр бус харин талбайн баруун хэсгээр дагтаршуулсан шар шавар тавцанд тулаагүй хэсэгт үргэлжлүүлэв. Хөрсний бүтэц нь дээр 2-р үеэс гарч байсантай ижил нарийн ширхэгтэй бор шаргал хөрс үргэлжлэн гарсан бөгөөд түүний дундаас олон цөөнгүй тооны дээврийн ваар савны хэлтэрхий хагархай илэрч олдсоор байлаа. Энэ үеийн малтлагаар бид малтлагын талбайн зүүн хэсгийг эзлэн илэрсэн хатуу шар хөрсийг сайтар цэвэрлэн үзвэл баруунаас зүүн, хойноос урагш сүлжилдсэн мэрэгчийн бололтой нүхний ул мөр илэрсэн юм. Барилгын дор суурь маягаар дэлдэн босгосон шар шавар тавцанд хожим мэрэгч үүрлэн ухсан бололтой. Харин 4-р үеэс илэрсэн сонирхолтой зохион байгуулалт нь A-F1-р өрөгт хойноос урагш цуварсан байдалтай зурвас зурвас үргэлжилсэн улаан шаргал шатсан мэт толбо илэрсэн билээ. Энэ үеийн малтлагаас 420 ширхэг олдвор хэрэглэгдэхүүн илэрлээ.

Малтлагын 5-р үеийн тодорхойлолт:

Энэ үеийн малтлагыг бид зөвхөн секторын баруун хэсгээр үргэлүүлсэн бөгөөд 4-р үеэс илэрсэн улаан шаргал өнгийн шатсан модын үлдэгдэл бүхий толбуудыг цэвэрлэх замаар малтлагыг үргэлжлүүлэв. Ингэхэд тэдгээр илэрсэн толбууд нь нилээд өргөн том болж ирсэн бөгөөд хойноос урагш цуварсан байдалтай 5 хэсэг газар илрэв. Эдгээр нь чухам юуны үлдэгдэл, ямар зохион байгуулалттай болох нь тодорхой бус байв. Юутай ч эл барилгын туурьтай холбоотой болох нь тодорхой бөгөөд барилга орхигдон хаягдсаны дараа нуранги нь ус бороонд нүүж барилгын суурийн баруун хэсэгт хуралдсан болов уу хэмээн таамаглав.

Бид дагтаршуулсан суурийн бүтэц зохион байгуулалтыг үзэх зорилгоор бага зэрэг зүсэлтийг хийсэн боловч тодорхой зохион байгуулалт мэдэгдсэнгүй.

Малтлагын 6-р сектор талбай бүхэлдээ дээврийн тосгуур ваарны хагархайгаар хучигдсан байлаа. Зарим хэсэгт уг барилгын нуранги анхны байрлалаараа бөгөөд өөрөөр хэлбэл барилга анх нурахад ханарч унасан дээврийн ваарууд нь бөөн байдалтай нэг дор унасан байлаа. Эдгээрээс бид цөөнгүй дээврийн бүтэн ваар эвлүүлэн авав. Малтлагын талбайн хойт зах хаяа урсаж тогтсон бололтой ихэвчлэн жижиг хэмжээтэй дээврийн ваарны хагархай бутархай хэсгүүд бөөгнөрсөн байдалтай илрэв.

Төгсгөл

Бидний малтан судалсан барилга нь хотын туурийн зүүн хойт талд байрлах бөгөөд 20х9,0 метр хэмжээтэй. Барилгын бүтэц зохион байгуулалт, өмнөх жилийн малтлагыг үргэлжлүүлэх зорилгоор туурийн төв хэсэгт 18х6 метр хэмжээтэй малтлагыг явуулсанаар гүн нь дунджаар 25-130см үргэлжилсэн бөгөөд уг барилга нь шавар дэлдэн босгосон өндөр тавцан дээр байрлаж байсан ба шар шавар дэлдэж хийсэн ханатай байсан нь мэдэгдэнэ. Тэрчлэн шавар ханаас гадна эл барилга нь бүхэлдээ сайтар шатаасан вааран дээвэртэй байжээ.

Малтлагаар илэрсэн голлох олдвор нь барилгын хэрэглэгдэхүүн байлаа. Барилгын хэрэглэгдэхүүнийг дотор нь нөмрөг, тосгуур, нүүр ваар, өнгөлгөөний хавтан тоосго гэж ангилж болмоор байна.

2016 оны археологийн малтлага судалгаагаар Тэрэлжийн дөрвөлжин балгасны малтлагаас 18,853 ш дээврийн нөмрөг болон тосгуур ваарны хагархай илэрч олдлоо. Сонирхолтой нь өмнөх жилүүдэд болон энэ жилийн малтлага судалгаагаар ахуйн чанартай эд өлгийн зүйл олдвор илэрч мэдэгдсэнгүй.

Малтлагаас илэрсэн дээврийн тосгуур ваарууд нь ихэвчлэн тууш самнасан сам хээтэй, түүний дээгүүр нь хөндлөн усан буюу долгион хэлбэрийнхээ, олон эгнээ хээтэй байв. Ваар савны хагархай хэсгүүдийг ажиглахад хэлбэр хэмжээ, хээний хувьд хоорондоо ялгаатай олон төрөл байсан нь мэдэгдэнэ.

Дээврийг хучсан нөмрөг ваар нь нумарсан гүдгэр гадаргуутай, түүний дээр нь янз бүрийн тууш урт зураасан хээг дүрсэлсэн байжээ. Мөн түүний дундуур хөндлөн долгион усан хээг мөн дүрсэлжээ. Басхүү дээврийн нөмрөг ваарны бөгжин хэсгийг даавуугаар бүрж бороо уснаас хамгаалж байсан бололтой бөгөөд энэ нь дээврийн бага зэрэг төвийсөн хэсэгт ул мөр нь үлдсэн байна.

Барилгын гадна өнгөлгөөний хавтангууд нь ихээхэн өвөрмөц гоёмсог хийцтэй байжээ. Тэдгээр нь ихэвчлэн саарал шавраар хийж сайтар хатууруулсан 20х20х2-3см хэмжээтэй ажээ. Малтлагаас илэрсэн дээрх хавтангууд ихэд нимгэн, нэг талдаа хээтэй, өнгөлгөөний зориулалттай, хананд нааж чимэглэдэг байсан бололтой. Тэрэлжийн дөрвөлжин хотын туурийн малтлагаас илэрсэн олдвор хэрэглэгдэхүүн, дээврийн ваарны хагархайнууд болон хотын бүтэц зохион байгуулалт олон зүйлүүд нь Монгол улсын нутаг дэвсгэрт өдгөө малтан судлаж байгаа болон өмнө малтан судлагдсан хүннүгийн хот суурины дурсгалуудтай ижил байна.

2007 оноос бидний эхлүүлсэн Тэрэлжийн дөрвөлжин хотын туурийн малтлага судалгааны урьдчилсан үр дүнгээр энэ хотод оршин суугчид төдийлөн удаан хугацаагаар төвлөрч суугаагүй буюу эсвэл тахил тайлгын шинжтэй улирлын чанартай суурин байсан болов уу хэмээн таамаглаж байна. Нөгөө талаар эрдэмтэн Х.Пэрлээ Тэрэлжийн дөрвөлжинг Хүннүгийн үеийн шүтлэгийн чанартай суурин байсан гэж үзжээ. Энэ нь ч бидний малтлага судалгаагаар ямар нэгэн байдлаар нотлогдож байна. Учир нь малтлагаас голчлон барилгын хэрэглэгдэхүүн их хэмжээгээр олдож байснаас бус ахуйн чанартай эдлэл цөөхөн илрэв.

Малтлагаар барилгын материал, тоосго, дээврийн олон төрлийн ваар савны хагархай барилгын хэрэглэгдэхүүн илрэн олдсон нь тухайн цаг үеийн хот суурины хөгжлийг тодруулан харуулах чухал баримт болсон юм. Эдгээр хэрэглэгдэхүүнүүд нь хэлбэр хэмжээ, хээ чимэглэлээрээ монгол нутгаас олдсон бусад Хүннүгийн хот суурингуудаас олддог хэрэглэгдэхүүнтэй ихэд адилшаалтай бөгөөд Төв Азийн хот суурины судалгаанд чухаг олдворууд цугласан хэмээн бид үзэж байна.

Зураг. 1. Тэрэлжийн дөрвөлжин балгасны малтлага судалгааны явцаас

Зураг. 2. Тэрэлжийн дөрвөлжин балгасны малтлага судалгааны явцаас

Зураг. 3. Тэрэлжийн дөрвөлжин балгасны малтлага судалгааны явцаас

МОНГОЛ-ГЕРМАНЫ ОРХОН ЭКСПЕДИЦИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТОВЧ ДҮНГЭЭС

У.Эрдэнэбат, К.Франкен, Т.Батбаяр, Х.Рооланд

Монгол-Германы Орхон экспедици (MONDOrEx) Архангай аймгийн Хотонт сумын нутагт орших Уйгурын Харбалгасын цайзат их хэрмийн цитадельд хийж буй малталт судалгаагаа 2016 оны 7 сарын 24-нөөс 8 сарын 22-ны хугацаанд үргэлжлүүлэв. Хээрийн шинжилгээнд, Германы талаас, ХБНГУ-ын Археологийн хүрээлэнгийн Европын бус соёлын археологийн комиссийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор К.Франкен, докторант Х.Рооланд тэргүүтэй 6 судлаач, Монголын талаас, МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхмийн профессор, доктор У.Эрдэнэбат, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, докторант Т.Батбаяр, БНХАУ-ын Жилиний их сургуулийн магистрант Д.Содномжамц, Монгол Улсын Батлан хамгаалах их сургуулийн Цэргийн түүх судлалын төвийн ажилтан, магистр Ц.Бямба-Эрдэнэ, МУИС-ийн Антропологи, Археологийн салбарын магистр Г.Олзбаяр, Г.Төмөрчулуун, туслах ажилтан 15 оюутан, 2 жолооч,2 тогоочийн бүрэлдэхүүнтэй ажиллав.



Зураг 1: Архангай, Хотонт, Хар балгасын дэвсгэр зураг. Монгол-Германы Орхон экспедицийн 2016 онд малтлага судалгаа явуулсан газрыг тэмдэглэсэн нь

2016 онд цитаделийн төв хэсэгт ноднин жил явуулсан малтлагын талбайг хамгаалж булж орхисон шороог буцаан гаргаж, хойд зүгт 13х8м хэмжээтэй өргөсгөн малтав. Өмнөх жилүүдийн судалгааны дүнд Хар балгасын цитадель дээрх цогцолбор

барилгын зохион байгуулалт, хийц загварыг тодруулахад чухал хэрэглэгдэхүүн болох хэрмэн хана, хаалга үүд ба шатны үлдэгдэл, барилгын өрөө тасалгааг зааглаж байсан модон хийц, баганын суурь чулуу, тоосгон хавтан дэвсмэл шалны үлдэгдэл, ус зайлуулах системзэрэг цогц олдворуудыг баримтжуулсан билээ. Энэ байдлаас үзэхэд, цитадель дээрхи барилгын цогцолбор нь зүүн болон өмнөд талаараа гаднах хэрмэн ханатайгаа холбоо бүхий, төв хэсэгтээ задгай талбайтай, дотроо нэлээд хэдэн өрөө тасалгаатай, нарийн зохион байгуулалттай, тав тухтай газар байжээ.

Зураг 2: Архангай, Хотонт, Хар балгас.
Цитадель дээрх малтлагын явц, хойд талаас

2016 оны судалгаагаар цитадель дээрх барилгын баруун хэсгийн нүүрэн талын 80см зузаан дагтаршуулсан шавар тавцангийн үлдэгдлийг малтаж гаргав. Түүний дээр тогтсон 60-80см нурангийг малтах явцад барилгын дээврийн ваарны хагархай, бадам цэцгэн хээтэй нүүр ваар, малын ясны үлдэгдэлнэлээд олдов. Тавцангийн дээд хэсэг нь барилгын шалны төвшинг үүсгэх бөгөөд цагаан өнгийн шохойн шаваасыг 0,5см зузаантай жигд дэвсэж гадаргууг нь сайтар өнгөлсөн ажээ. Шалны зах хөвөө хэсгээр хоорондоо 3м зайтай, тус бүрийг нь бадам цэцгэн хээгээр чимэглэсэн гоёмсог хийцтэй боржин чулуун суурь гурав анхны байрлалаар олдов. Өндөрлөж зассан барилгын суурин дээрээс, эдгээр баганын чулуун сууриас гадна 32х32х7 см хэмжээтэй, тэг дөрвөлжин тоосгон хавтан дэвссэн шалны үлдэгдэл зурвас байдалтай илэрсэн нь зөвхөн барилгын зах хөвөөгөөр байх ажээ. Түүнчлэн тавцангийн нүүрэн хэсэгт, нийт 7м урт талбайг эзэлсэн, 40-50см зузаан ханын суурийн үлдэгдэл гарав. Энэ хэсгийн малтлагаас ихэвчлэн барилгын дээврийн зах хөвөөг чимэглэж байсан дээврийн тамгатай ваарны хагархай, нүүр ваар, дээврийн давхарлигийн буланг чимэглэх домгийн амьтны дүрстэй толгой ваарны хагархай гарсны зэрэгцээ төмөр хадаас, хятад

бичээстэй гантиг чулуун самбарын хугархай, цэцгэн хээ бүхий тавтай хүрэл хадаас цөөн тоогоор олдов.

Барилгын суурь довжооноос үргэлжилсэн тоосгон шалтай талбайн зохион байгуулалтыг өмнөх жилийн хуучин малтлагын талбайтай нийлүүлээд нийт 11х10м талбайд өргөтгөн малтав. Уг талбайгаас илэрсэн шалны хэсэг ихэд эвдэгдэж бараг бүтэн тоосго үлдээгүй байлаа. Шалны хавтан тоосгонууд дундажаар 30х30х6см хэмжээтэй.

Зураг 3: Малтлагын явц, наана нь: тоосгон шалны үлдэгдэл, баганы суурь чулуу;цаана нь: хэрмэн ханын үлдэгдэл харагдаж байна.

Зураг 4: Монгол-Германы Орхон экспедицийн 2016 онд малтлага явуулсан талбайн агаараас авсан гэрэл зураг

Тоосгон шалны үлдэц илэрсэн талбайн ойр орчим барилгын хана, баганын суурь зэрэг тулгуур даацын үүрэг бүхий хийц байхгүй. Түүнээс гадна тоосгон шалан дээр барилгын дээврийн налуугаас бууж ирэх бороо цасны усыг зайлуулах зориулалт бүхий тусгайлан төлөвлөсөн ус зайлуулах ховил гаргасан. Энэхүү суваг нь баруун, урд, хойд гэсэн гурван үндсэн чиглэлтэй бөгөөд тэдгээрийн уулзвар хэсэг тун сайн хадгалагджээ. Эдгээр байдлаас үзэхэд, цитадель дээрхи барилгын цогцолбор төв гол хэсэгтээ дээвэргүй, задгай талбай бүхий төлөвлөлттэй байсан бололтой.



Зураг 5: Хятад бичээстэй гантиг чулууны хугархай

Зураг 6: Хятад бичээстэй гантиг чулууны хэв

2016 онд Хар балгасын цитаделийн төв ба хэрмийн хойд хана дагууд нийтдээ 160 орчим метр ам дөрвөлжин талбайд малталт судалгаа хийсэн байна. Судалгаагаар шавар дэлдэж хийсэн өвөрмөц хийцтэй ханын үлдэгдэл, баганын чулуун сууриуд, дээврийн элдэв янзын чимэглэл, шал, суурь довжоо зэрэг барилга байгууламжийн

үндсэн хэрэглэгдэхүүнүүд олдсон төдийгүй цөөн тооны вааран савны хагархай, төмөр сөргөө, цэцгэн хээтэй шармал хадаас зэрэг онцлог олдвор гарсан болно. Барилгын хойд ханын хэсэгт шатаасан тоосгоор гадарласан дотроо модон бэхэлгээ бүхий шавар дагтаршуулж хийсэн ханын үндсэн хийц бүтцийг тодруулав. Энэ нь цитаделийн зүүн ба өмнө талын хэрмэн хананаас хийц бүтцээрээ ялгаатай бөгөөд 260см хүртэл өндөр хадгалагдан үлджээ.

Өмнөх жилийн хээрийн шинжилгээний хүрээнд цитаделийн зүүн баруун хэсэгт илэрсэн барилгын зохион байгуулалт төв хэсэгтээ хоорондоо ямар холбоотой байгааг судлах зорилгоор сорилтын малталт хийж үзэхэд, одоо мэдэгдсэн задгай талбайн шалыг эвдсэн, ихэвчлэн барилгын дээврийн ваар, тоосгоны хагархай, шатсан модны нүүрс, үнс нуранги агуулсан том нүх илэрсэн юм. Цаг хугацааны байдлаас бүрэн малтаж амжилгүй орхисон тэр гүнзгий нүхнээс барилгын хог хаягдлаас гадна чулуун тулгуур, мал амьтны яс гарсан бөгөөд дарагдаж хэлбэрээ алдсан том савны дороос, хөл далавчийг нь тайрсан шонхор шувууны бүтэн араг яс олдсон нь маш сонирхолтой байв. Шувууны ясаар тогтоосон C^{14}-ийн он цагийн мэдээнд үндэслэвэл, энэхүү нүхийг бичгийн түүхийн сурвалжид өгүүлдэг Хар балгасын оршин тогтнож байсан гэх хугацаанаас хойш буюу XI зууны үед үйлдсэн аж. 2016 онд уг нүхний толбыг ханыг нь дагуулан доош үргэлжлүүлэн малтахад, дугуй хэлбэртэй толбоны хэмжээ доошлох тусам багасах (голч 280см) боловч цитадель дээрхи одоогийн гадаргын хөрснөөс доош 670см гүн болсон ч ул хөрсөнд хүрсэнгүй. Нүхийг дүүргэсэн шорооноос бог бод малын ясны жижиг хэсгүүдээс гадна Уйгурын үеийн барилгын дээврийн чимэглэл, тоосгоны хагархай, алт суулгасан ухмал бичигтэй гантиг чулуун самбарынхагархай цөөнгүй олдов. Эндээс олдож буй нангиад бичээстэй самбар бүгд хугарч гэмтсэн боловч бүтэн үлдсэн үсэг зурлаг нь маш тод сайхан хэвээр тул уншиж болно. Жишээ нь, хоёр талаасаа хугарсан 10,8x2,2x1,1см хэмжээтэй нэгэн хугархай дээрх дөрвөн үсгийг хамтарсан шинжилгээний ангийн гишүүн Д.Содномжамц “寶暦元年” буюу “Бао-лигийн тэргүүн он” гэж тайлж байна.

Бао-ли хэмээх нь Тан улсын Жинзун хааны оны цол бөгөөд даруй нийтийн он тооллын 825 он болно. Хар балгасаас олдсон нангиад бичигтэй чулуун самбарууд нь Тан улсын эзэн хааны зарлигаар хааны гэр бүлийн өндөр дээд язгууртныг нас нөгчихөд сүмийн сүнсэн тахил болгож бүтээлгэдэг нэг ёсны эмгэнэлийн ном байжээ. Олон хэсэг самбар нийлж нэг ном болдог. Энэ зүйлийг Уйгурын хаадад богтлогдож ирсэн Тан улсын гүнжийг нас нөгчихөд тахилын сүмийн дотор буюу ордон хотын доторхи эрхэм хүндтэй газар байрлуулдаг байжээ. Дурдсан бичиг үсгийн холбогдолтой олдворууд нь Тан улсаас Хар балгасанд нийслэлж асан Уйгурын хаад ноёдтой энх ураг барилдаж байсан түүхэн хэрэг явдлыг тодруулах чухал баримт юм.

"XVII ЗУУНЫ МОНГОЛЫН ХОТУУД ТӨСӨЛ" САРЬДАГИЙН ХИЙД БА ӨВГӨН ХИЙДИЙН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ АЖЛЫН УРЬДЧИЛСАН ҮР ДҮНГЭЭС

С.Чулуун Ч.Энхтуул

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн захирал С.Чулуун санаачлан 2013-2016 онд хэрэгжүүлж буй "XVII зууны Монголын хотууд" төслийн хүрээнд 2013 оноос Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг орших Сарьдагийн хийдийн туурьд, 2016 оноос Булган аймгийн Рашаант сумын Өвгөн хийдийн туурind малтлага судалгааны ажил хийгдэж байна.

Сарьдагийн хийд

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагторших Хийдийн сарьдагийн өвөрт буй Халхын анхдугаар Богд Өндөр Гэгээн Занабазарын 1654 онд анх шавыг нь тавьсан Рибогэжайганданшадублин буюу Төгс баясгалант Номын их хүрээг малтлтан судлах ажил хийгдэж байна. Тус хийдийн туурийг нутгийн иргэд Сарьдагийн хийд хэмээн нэрийдсээр иржээ.

2016 оны малтлага судалгааг 7 дугаар сарын 8-наас 8 дугаар сарын 23-ны өдөр хүртэл 45 хоног, 16 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна. Тус төслийг доктор С.Чулуун ахлан ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн ЭША Ч.Энхтуул, Т.Батбаяр, Н.Нандинцэцэг, Б.Батболд, С.Өлзийсайхан болон бусад залуу судлаачдаас бүрдсэн судалгааны баг, оюутнууд оролцов.

Энэ онд цогчин дуганы хэрмийн зүүн хойд буланд залган байрлах барилга №6 хэмээн дугаарласан туурind болон суварга №3-т тус тус малтлага судалгаа явуулав. Малтлага эхлэхээс өмнө барилга №6 дээгүүр ургасан өвс ургамал, бут, модыг цэвэрлэн зохион байгуулалтыг тодруулсан байна.

2016 оны малтлага судалгааны үр дүнд барилга №6-ын баруун жигүүрт 10х4м хэмжээтэй барилгын хана дагуу малтлага хийхэд баруун талд 185см урт, 110см өргөн зүүн талын хаалганы хүрээндээ монгол төмөр цоож өлгөөстэй түвэд хийцийн модон хаалга, гэрийн тоононы хэлбэр бүхий модон эдлэл илэрсэн байна. Мөн хоорондоо 2,8 м зайтай ёроолоосоо дээш нарийссан дөрвөлжин 2 багана, түүний дээр даралтын хүчийг тараах зорилго бүхий их нум мөн хэд хэдэн төрлийн барилгын модон чимэглэлээр давхарлан хучсан байгууламжтай түвэд загварын барилгын баганын чимэглэлүүд тус тус илрэв. Тасалгааг банзаар шалласан байна. (зураг 1-2).

Суварга №3-ыг чулуун ханан өрлөг дотор таллан 2х3,5 м хэмжээтэй малтлага хийв. Тус байгууламжийг дан чулуугаар дүүргэж түүний дээд хэсгээр 30-40см зузаан янз бүрийн хэмжээтэй шавар цац хийж нямбай давхарлан өрсөн байна. Сувярганы хойд хананд 1,10см өргөн хаалганы хоёр хатавч илрэв. Бид гадаад зохион байгуулалтын бүтэцийг тодруулах зорилгоор сувярганы баруун болон хойд талд 1 мертийн өргөнтэй суваг малтаж үзэхэд сувярганы доод суурьас дээш 70-80см өргөнтэй 4 эгнээ шаталсан өрлөгтөй байв. (зураг 3).

Зураг 1. Малтлага судалгаа

Барилга №6 анхны байдал



Цэвэрлэгээний дараах байдал

Малтлагын явц

Модон хаалга, шал илэрсэн байдал.

Зураг 2. Түвэд хийцийн модон хаалга, баганын модон чимэглэл, фото зураг болон гар зураг



Зураг 3. Суврага №3-ын анхны малтлагын дараахи байдал

Хөгнө-Тарнын "Өвгөн хийд"

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Дундад зууны судалгааны салбарын 2015-2017 онд хэрэгжүүлж буй «Эзэнт гүрний дараах үеийн монголчууд ба гадаад ертөнц: нийгэм, соёл, харилцаа» сэдэвт ажлын хүрээнд үргэжилж буй “XVII зууны Монголын хотууд” төсөл 2016 оноос Булган аймгийн Рашаант сумын Хөгнө тарнын “Өвгөн хийд”-д малтлага судалгааг эхлүүлээд байна.

Булган аймгийн Рашаант сумын нутаг дахи Хөгнө хааны таван хиа хэмээх таван цохио, Хөгнө ханы нярав гурван омбо гэдэг нэн үзэсгэлэнтэй цул боржин хад цохиотой уулын хөндийд оршино.

Уг хийдийг түвэдийн Лхандарма хааныг дарж бурханы шашныг мандуулсан Лхаламбалдорж ламтан Түвдийг орхин зугтаж Монгол орноор дахин явах үедээ Хөгнөхаан уулын дунд анх үндэслэн байгуулсан хэмээдэг. Халх Ойрадын их үймүүн самууны үеэр хийдийг ололгүй буцахад Галдан бошигтын цэргүүдийн сүүлд явсан цэрэг эргэж харж байгаад оройн наранд гялалзан харагдах сүмийн ганжирыг олж харснаар цэргүүд эргэн ирж Өвгөн хийдийн лам нарыг хөгнөж хороож хийдийг сүйтгэсэн домогтой бөгөөд өдгөө зөвхөн туурь үлджээ.

Малтлага судалгааг 8-р сарын 28-наас 9-р сарын 9-ний хооронд 12 хүний бүрэлдэхүүнтэй хийв. Судалгааны багийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн ЭША Ч.Энхтуул, Г.Одмагнай, М.Энхбаатар болон бусад судлаачид оролцож ажилласны дээр багийг Дундад зууны судалгааны салбарын эрхлэгч доктор Ц.Цэрэндорж ахлав.

Уг малтлага судалгаагаар Өвгөн хийдийн дэвсгэр зургийг үйлдэж, барилга №1 дотор сорьц малтлага хийж, дромоор агаарын зураг авав *(зураг 4,5)*. Хөгнө-Тарнын “Өвгөн хийд” нь гол байгууламж ба түүнийг тойрсон 13 чулуун болон шавар ханатай барилгын туурьтай байна. Гол байгууламжийг ухаа боржин чулуугаар голлон барьсан бөгөөд нийт 70 гаруй тасалгаатай байна. Одоогоор эвдрэн нураагүй бүтэн хана туургын хамгийн өндөр нь 7 м хүрнэ.

Барилга №1 хэмээн дугаарласан байгууламж дотор 5,1x4,7м хэмжээтэй тасалгаанд сорьц малтлага хийхэд хойморт хэсэгтээ 2.75x 1.80м хэмжээтэй чулуун өрлөг илрэв. Тасалгааны шалыг хайрга шороогоор дагтаршуулан хийжээ. Малтлагаар саарал өнгийн дээврийн ваарны хагархайнууд, тоосго цөөн тоогоор олдож байв *(зураг 6)*. Мөн хийдийн тухай түүхийн мэдээлэл цуглуулах зорилгоор хийдийн орчмоор угсаатны зүйн судалгаа хийв.

Зураг 4. Дроноор авсан зураг (Барилга №1, 2)

Зураг 5. Дэвсгэр зураг (Барилга №9, 2)



Зураг 6. Барилга №1 дэх тасалгааны малтлагын анхны болон дараах байдал

2016 ОНД АЙРАГИЙН ГОЗГОРТ ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Ц.Одбаатар, Ц.Эгиймаа

Монголын Үндэсний Музейн судалгааны баг 2014 оноос эхлэн Орхон аймгийн Жаргалант сумын нутаг Айрагийн гозгор хэмээх газарт малтлага судалгаа хийж байна. Айрагийн гозгорт гадаад зохион байгуулалтын хувьд үүдэвч бүхий дөрвөлжин хэлбэрийн чулуун далантай, мөн цагираг хэлбэрийн чулуун дараастай жижгэвтэр булшууд байна. Тус музейн хээрийн судалгааны анги 2014-2016 он хүртэлх хугацаанд малтлага хийж, үүдэвч бүхий дөрвөлжин хэлбэрийн чулуун далантай 3 булш, цагирган хэлбэрийн чулуун дараастай 7 булшийг малтан судлаад байна.

Бид 2016 онд 7 сарын 4-нөөс 8 сарын 10-ны хооронд АГ86 булшийг малтан судалсан юм. Судалгааны ангийн бүрэлдэхүүнд МҮМ-н Археологи, антропологийн секторын эрхлэгч, доктор Ц.Одбаатар, эрдэм шинжилгээний ажилтан Ц.Эгиймаа болон МУБИС, Маргад Дээд сургуулийн оюутнууд оролцон ажиллав. Мөн малтлагын хугацаанд АНУ-ын Калифорнийн Их Сургуулийн багш, доктор Кристине Лее /Christine Lee/ хүний ясанд палеоантропологийн судалгаа, Японы Нара Их Сургуулийн докторант М.Оюунтулга, Сунвуук Рю /Sungwook Ryu/ нар модон эдлэлийг сэргээн засварлах, будагны судалгаа, мөн тус сургуулийн оюутан Мөнхбат АГ86 дурсгалд 3D зураглал хийх зэрэг ажлыг тус тус гүйцэтгэв.

АГ86 булш Айрагийн гозгорын оршуулгын баруун хойт талд оршино. Дөрвөлжин хэлбэрийн 9х9.5м чулуун өрлөгтэй, уг хашлагаас урагш чиглэсэн урт үүдэвчтэй. Үүдэвч урдаас хойд зүг налуу байдлаар 16.3м урт, 1-1,3м өргөн, хойт талдаа 6м гүн. Үүдэвчний амсар дээр хавтгай чулуугаар тагласан хаалт байсан бололтой. Үүдэвчний төгсгөлд газрын хөрсийг хөндийлөн ухаж үйлдсэн хөмөг буюу бунхантай. Уг бунханы өргөн 144-150см, урт нь 350см хэмжээтэй. Бунханы дотор 310х170см, 90см өндөр дүнзэн бунхантай. Бунхан дотор 220х60см, 36см өндөр банзан авс байв. Хүний гавлыг бунханы зүүн талын дүнзэн хашлага дээр гаргаж хаясан байлаа. Тонуулчид бунхан доторх эд зүйлийг тоножж, авсны байрлалыг хөдөлгөсөн бололтой. Авс зүүн урдаас баруун хойд зүг чиглэжээ. Дүнзэн бунханы таг дотогш цөмөрч авсыг дарсан байна. Тонуулчид бунханы толгой болон хөлийн хэсгээр цөмлөн оржээ. Авсны баруун талаас жижиг модон байшингийн үлдэгдэл гарсан нь нимгэн банзаар үйлдсэн, гурвалжин оройтой бөгөөд хаалга, үүд гэх зүйл мэдэгдэхгүй болсон байв. Уг байшингийн дээврийг авмагц дотор талд нь түрүүлгэ нь харуулж байрласан модон хүний сийлбэр илрэв. Уг хүүхэлдэй урт ханцуй бүхий өргөн хормойтой, ташуу энгэртэй дээл өмссөн, хар өнгийн гуталтай аж. Хүний нүүрний төрх эвдэрч мэдэгдэхгүй болжээ. Авсны ойр орчмоос бугын эврийг тайрч хийсэн голдоо төмрийн үлдэц бүхий 5 ширхэг чимэглэл, алт шармал бариул бүхий чий будагтай аяга, модон тавагны үлдэгдэл, ясан савхны хугархай, хүрэл толь зэрэг олдворууд илрэв.



Айрагийн гозгорын дэвсгэр зураг

АГ86 булш

АГ86 булшны дүнзэн бунхан

Хүний гавал

Бүрэлдэхүүн

Авсны хажуугаас илэрсэн модон байшин

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН УУ ХӨТЛИЙН ЦАГААН ТОЛГОЙ, ХҮҮШИЙН ӨВДӨГТ ЯВУУЛСАН АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ АЖЛЫН УРЬДЧИЛСАН ҮР ДҮНГЭЭС

Д.Эрдэнэбаатар, Т.Идэрхангай, А.В.Варенов,
А.А.Ковалев, Э.Мижиддорж, Ж.Эрдэнэ, Б.Өнөрбаяр

Удиртгал

Монгол-Оросын хамтарсан хээрийн шинжилгээний анги 2016 оны 7-9 сарын хооронд Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг Их хануй нуурын зүүн өмнөд бие Уу хөтлийн Цагаан толгой хэмээх газарт хүрэл зэвсгийн үеийн 5 дөрвөлжин булш, тэгш өнцөгт хэлбэрийн 1 тахилын байгууламж, Түрэгийн үеийн 1 тахилын онгон, Зүүн салааны голын Хүүшийн өвдөгт хүрэл зэвсгийн эрт үед холбогдох Афанасьевийн соёлын нэгэн булшийг тус тус малтан судаллаа. Судалгааны ажлын гол зорилго нь Монгол орны баруун бүсийн хүрэл зэвсгийн үеийн соёлуудыг монгол орны төвийн бүс нутгийн энэ үеийн соёлтой харьцуулан тэдгээрийн хооронд орон нутгийн ялгаа хэрхэн буй эсэхийг тодруулахын зэрэгцээ тэдний угсаа соёлын асуудлыг тодорхойлох явдал болно.

Уг археологийн хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд Монгол, Оросын эрдэмтэн судлаачдын баг хамтран ажилласан болно. Үүнд: Төслийн Монголын талын удирдагчаар Д. Эрдэнэбаатар (Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхмийн эрхлэгч, Археологич), Оросын талын эрдэм шинжилгээний удирдагчаар А.В. Варенов (ОХУ, Новосибирскийн Улсын Их Сургуулийн доцент, түүхийн ухааны дэд доктор), Эрдэм шинжилгээний ажилтнаар монголын талаас Т. Идэрхангай (Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхмийн багш, Археологич), Э. Мижиддорж (Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхмийн багш, Антропологич), Ж. Эрдэнэ (БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тунлаугийн Их сургуулийн магистрант), Б. Өнөрбаяр (Хэнтий аймгийн Баянмөнх сумын Соёлын Төвийн эрдэм шинжилгээний ажилтан, археологич) болон ОХУ-ын Санкт-Петербургийн Их сургууль, Москвагийн Их сургууль, Новосибирскийн Их сургуулийн түүх, археологийн оюутнууд оролцон ажиллав.

Уу хөтлийн Цагаан толгойн дурсгалууд

Эрдэнэмандал сумын төвөөс зүүн урагш 9км зайд Их нуурын Зүүн урд тал, Их Өлөнтийн голын баруун тал, Алаг уулын баруун талын төгсгөл наран ээвэр өндөрлөг дэнжийг нутгийн ардууд Уу хөтлийн Цагаан толгой хэмээн нэрлэх ажээ. Харин энэхүү дурсгалт газрыг Их жаргалантын ам[1] хэмээн зарим бүтээлд тэмдэглэсэн нь бий. Их жаргалантын ам хэмээх газар нь уг дурсгалт газрын урд тал, Их Өлөнтийн

[1] *Н.Батболд. Буган хөшөө бүлэг III. // Монгол нутаг дахь соёлын үл хөдлөх өвийн хадгалалт хамгаалалт, Улаанбаатар, 2006, т. 82*

голын өмнө этгээдэд орших хойш харсан жижиг амыг нэрлэдэг байна. Тиймээс энэ дурсгалт газрыг нутгийн иргэдийн нэрлэж заншснаар тэмдэглэн судалгааны ажилдаа оруулав. Уг газарт хүрэл зэвсгийн үеийн томоохон цогцолбор дурсгал бий. Үүнд: дугуй хүрээтэй хиргисүүр 3, дөрвөлжин хүрээтэй хиргисүүр 2 буюу нийт 5 хиргисүүр, хамгийн баруун урд талд орших дөрвөлжин хүрээтэй хиргисүүрийн зүүн талд баруун хойноос зүүн урагшаа зэрэгцэн орших 8 дөрвөлжин булш, тэгш өнцөгт хэлбэрийн тахилын байгууламж 2 байна. Мөн энэ дөрвөлжин хүрээтэй хиргисүүрийн зүүн хойд талд буган хөшөөний цогцолбор болох 3 хэсэг тахилын байгууламжууд, үүний хойд талд 2, зүүн урд талд нь 3 дөрвөлжин булштай бөгөөд энэхүү 3 дөрвөлжин булшны хамгийн зүүн хойд талын томоохон хэмжээний 1 дөрвөлжин булшны хашлагад 5 буган хөшөөг хана болгон ашиглажээ. Харин энэ дөрвөлжин булшны зүүн урд талд тэгш өнцөгт хэлбэрийн зэрэгцээ тахилын 4 цогцолбор байгууламж, дөрвөлжин булшнаас урагш 200м зайд Түрэгийн үеийн 1 дөрвөлжин тахилын хашлага тус тус байна. Эдгээр дурсгалуудаас бид буган хөшөө ашиглан үйлдсэн том дөрвөлжин булш, түүний баруун талд орших 2, дөрвөлжин хүрээтэй хиргисүүрийн зүүн талд орших 8 дөрвөлжин булшнаас хамгийн урд талын зэрэгцээ 2 дөрвөлжин булш, 1 тэгш өнцөгт хэлбэрийн чулуун байгууламж, уг дурсгал газрын урд бусад дурсгалаас арай зайдуу орших Түрэгийн үеийн тахилын онгоныг тус бүр сонгон малтан судалсан болно(Зураг 1).

Дөрвөлжин булшны малтлага судалгаа

Бид уг дурсгалт газрыг Улаанбаатарын Их Сургуулийн Түүх, Археологийн тэнхмийн оюутны зуны хээрийн танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын хүрээнд 2009-2012 оны хооронд байнга үзэж оюутнууддаа танилцуулдаг байсан бөгөөд 2014 оны намар Эрдэнэмандал сумын Улаанбаатар хот дахь Нутгийн Зөвлөлийн захиалгаар тус сумын нутагт бүрэн хэмжээний археологийн хайгуулыг гүйцэтгэх үед ч үзэж дахин бүртгэж байсан билээ. Ийнхүү судалгаа хийх явцад уг дурсгалт газрын буган хөшөө ашигласан дөрвөлжин булш ихэд анхаарал татаж байсан тул 2016 онд малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Уу хөтлийн Цагаан толгойн дурсгалт газрын дунд орчимд байрлах буган хөшөөний 3 цогцолбор байгууламж байсны зүүн урд талд уг цогцолборын буган хөшөөдийг хожим дөрвөлжин булшны соёлынхон өөрсдийн оршуулгыг үйлдэхдээ уг цогцолборын бүрэлдэхүүнд байсан буган хөшөөдийг булшныхаа хананд хашлага болгон ашигласан нь судалгааны явцад тодорхой харагдаж байв. Бид буган хөшөө ашигласан дөрвөлжин булшийг 1-р дөрвөлжин булш хэмээн дугаарлан судалгааны ажлаа эхлүүлсэн юм. Булшны дараас чулууг бүрэн багтаан баруунаас зүүн тийш 18 м, хойноос урагш 19м хэмжээтэй дөрвөлжин талбайгаар цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэхэд булшны баруун урд талын дараасны дундаас 1 ширхэг жижиг цутгуурын чулуун шанага, чулуун шанаганы баруун хойноос хүний хос шилбэний яс тахилзуур ясны хамт илрэн олдсон бол булшны нүхний урд талын дараас чулуун дундаас хүний гавлын яс, дараас чулууны зүүн урд дараас дунд чөмөгний хугархай тус тус илрэн олдсон билээ. мөн дараас чулууны энд тэндээс бог болон бод малын ясны хугархай,

хэлтэрхийнүүд их хэмжээгээр гарч байв. Булшны цэвэрлэгээг хамгийн гүн хэсэгт 60 см, гүехэн хэсэгт 30 см явуулахад дөрвөлжин булшны урд хашлагад 3, баруун хананд 1, хойд хананд 2, зүүн хананд 2 буган хөшөөг хашлага болгон ашигласан бол булшны баруун урд талын дараас чулууны гадна талд 1, зүүн урд талын дараас чулуун дээр 2, зүүн хойд дараас чулууны дунд 1 буган хөшөө 5 хэсэг болон бутарсан байдалтай илрэн олдсон болно. Тиймээс энэ дөрвөлжин булшны хашлага болон дараас чулууны дундаас нийт 11 буган хөшөө илрэн олдлоо. Буган хөшөөдийг баримтжуулан малтлагыг булшны төв хэсэгт явуулахад булшны нүхний дээд хэсгээс гурван дэлбээт хүрэл сумын зэв 2 ширхэг илрэн олдсоноос өөр ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн үлдээгүй тонуулчдын гарт өртөж сүйтгэгдсэн байв (Зураг 2-4).

Бид уг дөрвөлжин булшийг малтан судлахын зэрэгцээгээр энэ дурсгалын баруун талд орших 2 дөрвөлжин булш, мөн энэ хоёр булшны баруун урд талд байх дөрвөлжин хүрээтэй хиргисүүрийн зүүн талын хүрээний гадна талд 8 дөрвөлжин булш байсны хамгийн урд талын зэрэгцээ 2 дөрвөлжин булшийг тус тус сонгон малтан судалсан болно. Бидний сонгон малтсан 4 дөрвөлжин булшны 1-р дөрвөлжин булшны баруун талд зэрэгцээ орших 2-р дөрвөлжин булш бүрэн тоногдсон ч хагас сар хэлбэрийн 1 ширхэг алтан ялтсан эдлэл үлдэж хоцорсон бол 3-р дөрвөлжин булш тонуулчдын гарт өртсөн ч булшнаас халбаган хэлбэрийн хүрэл зүүлт, тугалган зүүлт 17 ширхэг тус тус илрэн олдов(Зураг 5-8). Харин 4-5–р дөрвөлжин булшнууд огт хөндөгдөөгүй ч хүний яс ихэд өгөршиж мөчдийн том яснууд анхны байрандаа хадгалагдан үлдсэнээс өөр ямар нэгэн зүйл илрээгүй болно. Мөн манай судалгааны баг 5-р дөрвөлжин булшны урд талд наалдуулан үйлдсэн тэгш өнцөгт хэлбэрийн 1 чулуун байгууламжийг малтан судлахад ямар нэгэн эд хэрэглэгдэхүүн, шатсан галын ором зэрэг зүйл огт илрээгүй тул нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэв.

Түрэгийн үеийн тахилын онгоны малтлага судалгаа

Манай хээрийн шинжилгээний анги уг дурсгалт газрын дөрвөлжин булшнуудыг малтан судлахын хажуугаар энэ дурсгалт газраас ялимгүй зайдуу ганцаараа орших 150x190см хэмжээтэй Түрэгийн үеийн нэг дөрвөлжин тахилын хашлагыг малтан судалсан билээ. Бид тахилын хашлаганы төв хэсгээр баруунаас зүүн тийш 30см өргөн хөндлөн огтлолын хамрыг үлдээн 480x330м хэмжээтэй талбайгаар цэвэрлэгээний ажлыг гүн хэсэгт 40см, гүехэн хэсэгт 30см явуулахад тахилын хашлаганы төв хэсэгт тахилын ул мөр болох ямар нэгэн зүйл илэрсэнгүй эх газрын хөрсөнд хүрсэн тул хашлага чулууны төв хэсгээр дайруулан татсан хөндлөн огтлолын 30см өргөн хамрыг авч цэвэрлэх явцад зүүн талын хашлага чулууны зүүн талаас босоо цомцогор хэлбэрийн бүтэн шавар ваар илрэн олдсон болно. Шавар ваарын амсарыг зориуд эмтлэн хагалж тавьснаас гадна ваaран савны ёроолыг мөн адил цоолж авсан байв. Мөн ваарны ёроолын арай дээхнүүр ижил зайд тойруулж жижиг 3 нүхийг гаргажээ.

Афанасьев булшны малтлага судалгаа

Манай судалгааны анги 2014 онд тус бүс нутагт археологийн хайгуул судалгаа хийж гүйцэтгэх явцдаа хүрэл зэвсгийн эрт үед холбогдох Афанасьевийн соёлын булшнуудыг Хүүшийн Өвдөг, Зөөлөнгийн ам, Хараат уул зэрэг газарт илрүүлэн олж бүртгэн баримтжуулсан билээ. Тиймээс бид 2016 оны намар дээрх дурсгалт газруудаас Хүүшийн Өвдөгт орших хэмжээний хувьд хамгийн жижигд тооцогдох Афанасьевийн соёлын нэгэн булшийг сонгон малтан судаллаа.

Уг булшны анхны хэмжээ нь 10,3х11,2м байсан бөгөөд булшнаас баруун тийш 4,3м зайд 4 ширхэг зэл чулууг цувруулан босгосон нь ихэд сонирхолтой. Бид булшийг малтан судлахаас өмнө булшны төв хэсгээр дайруулан + тэмдэг үүсгэн хөндлөн огтлолын хамрыг 30см өргөн үлдээж цэвэрлэгээний ажлыг явуулахад дараас чулуу тал тал тийш тэлсээр баруунаас зүүн тийш 15,0м, хойноос ураш 16,0м болов. Тиймээс уг булшийг үйлдэхдээ 9,5м голчтой хүрээг нимгэн хавтгай чулуудаар хавиргалуулан суулгаж тавьсны төв хэсгийн дараас хөндөгдсөн байв. Булшны цэвэрлэгээг хийсний дараа хавиргалуулан үйлдсэн хашлага чулууны төв хэсгийн 4-5м орчим хөндөгдсөн чулуудыг авч газрын хөрстэй тэгшлэн цэвэрлэхэд булшны төв хэсэгт хойноос урагш 180см, баруунаас зүүнш 250см өргөн булшны нүхний толбо илрэн тодров. Булшны толбоор доош малтлагыг үргэлжлүүлэхэд 95см гүн хүрээд байгалын хөрсөнд тулсан тул малтлагын баримтжуулалтыг хийгээд нөхөн сэргээлтийг хийлээ(Зураг 9-14). Энэхүү булшийг эрт үед тоножс сүйтгэсэн тул ямар нэгэн олдвор хэрэглэгдэхүүн үлдээгүй бололтой. Мөн манай судалгааны баг уг дурсгалын өмнө талд 330х270м хэмжээ бүхий битүү чулуун дараастай 1 дурсгал байсныг малтан судлахад тахилын дурсгал байлаа.



Зураг 1. Уу хөтлийн Цагаан толгойн хүрлийн үеийн дурсгалуудын ерөнхий дэвсгэр зураг

Зураг 2. 1-р дөрвөлжин булшны цэвэрлэгээний дараах ерөнхий байдал

Зураг 3. *1-р дөрвөлжин булшны 3-р үе.*

Зураг 6. *3-р дөрвөлжин булшны 5-р үе*

Зураг 4. *1-р дөрвөлжин булшнаас илрэн олдсон чулуун шанага*

Зураг 7. *3-р дөрвөлжин булшны оршуулга*

Зураг 5. *3-р дөрвөлжин булшны 4-р үе*

Зураг 8. *3-р дөрвөлжин булшнаас илэрсэн халбаган зүүлт*

Зураг 9. *Афанасьевийн соёлын булшны ерөнхий байдал*

Зураг 10. *Афанасьевийн соёлын булшны цэвэрлэгээний дараах байдал*



Зураг 11. *Афанасьевийн соёлын булшны дараас чулууны зүүн талын хэсгийг таллаж авсан байдал*

Зураг 12. *Афанасьевийн соёлын булшны төв хэсгийн дараас чулууг авсан байдал*

Зураг 13. *Афанасьевийн соёлын булшны төв хэсгийн дараас чулууг авсны дараах байдал*

Зураг 14. *Афанасьевийн соёлын булшны оршуулгын нүхний толбоор малтсан байдал*

МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН "УМАРД МОНГОЛ" ТӨСЛИЙН СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Ж.Баярсайхан, Жулиа Кларк, Ч.Баяндэлгэр,
Вильям Тэйлор, Т.Түвшинжаргал

Монголын Үндэсний Музей, Америкийн Питссбургийн их сургууль, Америкийн Монгол судлалын төвийн хамтарсан "Умард Монгол" археологийн судалгааны төсөл нь 2016 оны 7 дугаар сарын 5-наас 7 дугаар сарын 25 хүртэлх хугацаанд Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Соёо багийн нутаг Хөгийн голын сав нутаг, Соёо толгойн дурсгалт газарт ажиллав. Төслийн Хүрээнд Монголын Үндэсний Музейн Эрдэм шинжилгээний төвийн дарга, доктор Ж.Баярсайхан, эрдэм шинжилгээний ажилтан Ч.Баяндэлгэр, Америкийн Монгол судлалын төвийн судлаач, доктор Жулиа Кларк болон Австралийн Флиндерсийн их сургуулийн геофизикч, доктор Иан Моффат, АНУ-ын Мэйн их сургуулийн гео-археологич, эртний цаг уур судлаач доктор, Дейв Путнам, Австралийн Макюари их сургуулийн эртний ургамал судлаач Шиан Бэстэл, АНУ-н Эмори их сургуулийн угсаатан судлаач доктор Поол Хүүпэр, Питсбургийн их сургуулийн докторант Камилла, Вашингтоны их сургуулийн докторант Стеффани Клабтри зэрэг олон улсын эрдэмтэн судлаач нар нэг баг болж ажиллав.

Соёо толгойн дурсгалт газар археологийн хайгуул, малтлага судалгаа явуулахаас гадна эртний геологи, газар зүй, геофизик, ургамал зүй, угсаатан болон этноархеологийн цогц судалгааг нэг газар төвлөрүүлэн явуулсан нь энэхүү төслийн давуу тал болно.

Хайгуул судалгааны ажил:

Соёо толгойгоос Багсагийн булан хүртэлх 9км квадрат талбайд 20м нарийвчлалтай явган хайгуул (зураг 1) судалгааны ажлыг доктор Жулиа Кларкын удирдлагаар хийсэн бөгөөд хайгуулын явцад уг талбайгаас 67 археологийн дурсгал, 166 ширхэг мал амьтны яс тэдгээрийн хугархай хэсэг, 162 ширхэг ваар савны хагархай хэсгүүд, 364 ширхэг чулуун зэвсгийн хаягдал, цахиур чулуунууд, 7 ширхэг төмөрлөгийн үлдэгдэл буюу нийт 699 ширхэг түүвэр олдвор цуглуулжээ.

Эртний геологийн тогтоцын судалгаа:

Доктор Дейв Путнам Соёо толгойн дурсгалт газрын геологийн эртний хурдас, давхаргуудыг ойлгох үүднээс Хөгийн голын гарам бүхий элст эргээс урагш модны зах хүртэл 50x50 см хэмжээтэй 6 талбайд (зураг 2) туршилтын малтлага хийсэн. Үүний үр дүнд дурсгалт газрын хөрсний бүтэц, соёлт давхаргын тогтоц, гүний хэмжээг тодорхойлсон билээ.

Гео-физикийн судалгаа:

Доктор Иан Моффатийн, Ч.Баяндэлгэр нарын баг хөрсийг гэмтээхгүйгээр дурсгалт газрын соёлт давхаргыг бүхэлд нь тодорхойлох зорилгоор нийт 500x90м талбайд геофизикийн радар /GPR/ ашиглан судалгаа хийв. Судалгааг хийхдээ тэгш хэмд тэг татаж 0.5 м-ийн нарийвчлалтай тэг татаж GPR-ийн судалгааг явуулав. Судалгааны урьдчилсан үр дүнд дараа жилийн судалгааны талбайг тодорхойлох, мөн эртний хүмүүсийн ул мөрөөр үлдсэн соёлт давхарга бүхий хэсгүүдийг тодорхойлох боломжтой болох юм. Мөн өндөр нарийвчлал бүхий газар зүйн байршил тогтоогч багажаар Соёо толгойд хийсэн малтлагын талбайг сантиметрийн нарийвчлалтай тодорхойлж, дурсгалт газрын дэвсгэр зурагт буулгах, агаараас авсан гэрэл зургаар дурсгалт газрын гурван хэмжээст дэвсгэр зургийг гаргажээ. (зураг 3)

Ургамал зүйн судалгаа

Доктор Шиан Бэстэл (Shehan Bestel) дурсгалт газрын орчимд ургадаг ихэнх ургамлыг ажиглаж, Соёо толгой орчмын өнөөгийн монголчууд тэдгээрийн хэрхэн амьдрал ахуйдаа ашигладаг талаар зарим мэдээлэл цуглуулсан. Соёо толгойн дурсгалт газраас макро болон микро ботаникийн үлдцүүд цуглуулсан бөгөөд уг цуглуулгын нарийвчлан судалж, дурсгалт газрын орон нутгийн байгал цаг уурын өөрчлөлт, ургамлын аймгийн түүхэн өөрчлөлтийг гаргаж ирэх зорилгоор ургамал зүйн судалгааг явуулсан байна.

Малтлага судалгаа

Соёо толгойн неолитийн бууц суурины орчим гурван газарт 2x2м хэмжээтэй туршилтын малтлага хийв. Бид урьд жилийн судалгаа болон энэ жилийн судалгаанд үндэслэн энэхүү дурсгалт газар нь шинэ чулуун зэвсгийн сүүл үеийн нэг соёлт давхаргатай болохыг олж мэдсэн юм. 2003 оны судалгаагаар илрүүлсэн мод, ваар болон хөрсний дээжид хийсэн он цаг тогтоох радио-карбоны шинжилгээгээр 6090+/-70 BP3., 5440+/-130 BP жилийн өмнө холбогдох нь тогтоогдсон [The Hovsgol Deer Stone Project 2003 Field Report. Washington., May 2004. page 10] билээ. Энэ жилийн малтлагаар илрүүлсэн олдворууд нь бүхэлдээ монгол орны бусад неолитын дурсгалт газруудаас олддог чулуун зэвсгүүдтэй ижил төстэй байна.Өмнөх жилүүдэд малтсан малтлагын дугаарыг үргэлжлүүлэн №6,7,8 хэмээн дугаарлан малтав(зураг 3).

Туршилтын малтлага №6 (Unit 6): Энэхүү малтлага нь Соёо толгойн баруун хэсэг болон 50x50см хэмжээтэй геологийн туршилтын малтлагын үргэлжлэлийг тодорхойлох зорилгоор хийгдсэн болно. Өөрөөр хэлбэл эртний соёлын үлдэц болон геологийн үйл явцыг нэгэн зэрэг ойлгоход тус дэм болсон билээ. Өнгөн хөрснөөс доош 125см гүн хүртэл соёлын ул мөр үргэлжилсэн болон түүнээс цааш цэвдгийн төвшин хүртэл 165см гүн хүртэл малтсан. Энэхүү туршилтын малтлагаас амьтны ясны хугархай хэсгүүд 376 ш, ваар савны хагархай 6 ширхэг, чулуун зэвсгийн хаягдал цахиур 1ш гарсан. (Зураг 4)

Туршилтын малтлага №7 (Unit 7): Энэхүү малтлага нь дурсгалт газрын зүүн хойд хэсгийн талаар мэдээлэл цуглуулах зорилготой хийгдсэн. Малтлагын талбай нь голын эргийн дагуу нурж, борооны усаар угаагдсаны улмаас гадаргуун дээр ил

харагдаж байсан бүлэг чулуун зэвсгийн хаягдал цахиур бүхий гадрын ойролцоо байсан бөгөөд өнгөн хөрснөөс доош 115см гүн хүртэл соёлын ул мөр (олдвор) үргэлжилж байсан бол түүнээс доош 150см гүн хүртэл малтахад ямар нэгэн олдвор гарсангүй. Уг малтлагаас нийт мал, амьтны ясны хугархай хэсэг 25 ш, чулуун зэвсгийн хаягдал цахиур 22 ширхэг тус тус илрүүлэн олсон болно. (Зураг 5)

Туршилтын малтлага №8 (Unit 8): Энэхүү малтлага нь галын ор бүхий бөөн чулууд болон ваар савны хагархай, чулуун зэвсгийн хаягдал зэрэг олноор байсан хэсэг газрын ойролцоо хийгдсэн. Мөн 2015 онд шинэ чулууны үед хамаарах олон тооны ваар савны хагархай илрүүлэн олсон туршилтын малтлага №5-ын ойролцоо байв. Энэ малтлагын талбайг өнгөн хөрснөөс доош 80см гүн хүртэл малтсан бөгөөд 50см гүнээс хамгийн сүүлийн олдвор гарсан. Малтлагаас нийт ваар савны хагархай 3 ш, мал амьтны ясны хугархай хэсэг 9 ширхэг гарав. (Зураг 6,7)

Зураг 1

Зураг 2



Зураг 3

Зураг 4

Зураг 5

Зураг 6 *Зураг 7*

Монгол-Америкийн хамтарсан "Умард Монгол" археологийн төслийн Баянхонгор аймагт хийсэн судалгааны ажил

"Умард Монгол" судалгааны ангийн хоёр дахь шатанд Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Морин мөрт, Баянбулаг сумын Хөшөөт нуурын дурсгалт газруудад буган хөшөөний тахилгын байгууламж малтан судалж, дурсгалт газрын нарийвчилсан он цаг тогтоох, агаарын зураг авах зорилготой ажиллав. Уг судалгаанд Монголын талаас МҮМ-н ЭША, археологич Т.Түвшинжаргал, Америкийн талаас доктор Жулиа Кларк, судлаач Вильям Тейлор нар хамтран ажиллав. Судалгааны баг Морин мөртөд 2 тахилгын байгууламж малтан судалсны 1-ээс нь аман хүзүүтэй адууны толгой, 4 ш туурай илрэв. Мөн морин мөртийн хаданд сийлсэн адууны туурай тамгыг нарийвчлан тоолж бүртгэн баримтжуулав. Хөшөөт нуурын буган хөшөөний дурсгалт газарт 1 тахилгын байгууламж малтан судалсан боловч ямар нэгэн олдвор илэрсэнгүй. Түүнчлэн Гурванбулаг сумаас Баянбулаг сум орох замд Өндөр хиригсүүр хэмээх нэгэн том хиригсүүрийн дэргэдээс нэгэн буган хөшөө илрүүлэн бүртгэж баримтжуулав.

Зураг 1. Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Морин мөртийн буган хөшөөний 2-р тахилгын байгууламжийн малтлага

Зураг 2. Морин мөртийн буган хөшөөний 2-р тахилгын байгууламжийн малтлагаас илэрч буй адууны толгой

МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН "ТАРВАГАТАЙН ХӨНДИЙН АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА" ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН ТОВЧ ҮР ДҮН

Б.Жаргалан, У.Гарднер

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн ба АНУ-ын Йелийн их сургуулийн хамтарсан археологийн "Тарвагатайн хөндийн археологийн судалгаа" төсөл нь 2010 оноос хойш тус нутагт археологийн судалгаа хийсэн билээ. Уг төслийн гол зорилго нь тус нутгийн археологийн дурсгалуудын бүртгэн судалгааны эргэлтэнд оруулахаас гадна эртний хүн амын аж ахуй, амьдралын хэв маяг, соёл заншилтай холбоотой асуудлуудыг тодруулах явдал болно. Ингэхдээ судалгааны гол чиглэлийг эртний нүүдэлчдийн бууц, сууринг олж тогтоох явдалд хандуулсаар ирсэн. Энэ хугацаанд нарийвчилсан хайгуулын арга зүйгээр хэдэн арван эртний бууц илрүүлж малтлага судалгаанд хамруулав.

Харин малтлаганд хамрагдаад байгаа эдгээр бууцнууд гол төлөв төмрийн түрүү болон Хүннүгийн үед хамрагдаад байна. Хэдийгээр бидний боловсруулсан хайгуулын болон сорьц малтлагын арга зүй нь орчин үеийн өнгөн хөрсөн дор дарагдсан эрт үеийн бууцнуудын ул мөрийг амжилттай илрүүлж эртний нүүдэлчдийн ахуйн амьдралыг ойлгоход их хувь нэмэр оруулж байгаа боловч төмрийн түрүү үеэс өмнөх үед, тэр тусмаа хиргисүүр, буган хөшөөтэй нэгэн он цагт хамаарагдах бууц, суурин хараахан илрүүлээгүй байна. Энэхүү төслийн судалгааны гол зорилгуудын нэг бол хүрлийн үеийн дурсгалуудыг судлан хиргисүүр барих болсон зан заншлын гарал үүсэл, он цаг зэргийг олж тогтоох явдал юм. Үүнд хүрлийн үеийн бууц, суурин илрүүлэн судалвал ихээхэн ач холбогдолтой байх юм. Тухайлбал, сүргийн бүтэц, нүүдлийн хэв маяг ба давтамж, гадаад ба дотоод харилцаа зэрэг олон асуудлын хариуг олж тогтоох боломжтой билээ.

Зорилго. Өмнө нь дурсанчлан, хүрэл зэвсгийн үед хамаарагдах эртний нүүдэлчдийн оромж, бууцны ул мөр хараахан олдоогүй байна. Сорьцын малтлагыг хайгуулын үр дүн дээр тулгуурлан хэд хэдэн газар 2012, 2013 онуудад хийж орчин үеийн өнгөн хөрснөөс доош 30-50см гүнд галын ором, хурц иртэй зэвсгээр хийсэн зүсэлтийн ул мөртэй малын яс, жижиг бэлдэц зэрэг чулуун зэвсгүүд илэрч байлаа. Эдгээр гүний түвшинд буй олдвор, галын ормоос он цаг тогтоох дээж авч шинжилгээнд явуулсан боловч эсвэл хамаагүй хожуу үед хамрагдаж (8-9 зууны үе), эсвэл хөрсний соёлт давхаргын байдал мэргэчийн үйл ажиллагаанаас болж маш ихээр гэмтэснээр өмнөх үеийн соёлт давхаргууд хожуу үеийн соёлт давхаргаас дээш зөөгдсөн байдалтай олдож байлаа. Энэхүү байдал эдгээр дурсгалыг малтах боломжгүй байдалд оруулж байна. Шалгалт хийсэн эдгээр дурсгалууд гол төлөв уулын дэнж дээр байрлаж. Эдгээр газруудад мэргэчний нүх их байхаас гадна урт хугацааны турш хүмүүс дэнжийн налууг тэгшлэн орон гэрээ байрлуулж байсан нь харагдаж байна. Энэхүү явдал эртний соёлт давхаргуудыг босоо тэнхлэгийн дагуу

ихээр зөөвөрлөгдөн холилдсон явдалд багагүй хувь нэмэр оруулж байсан гэж үзэж байна. Уулын урд энгэрийн эдгээр дэнжнүүд салхинаас нөмөртэй, зуны улиралд ялаа шумуул багатай байдаг учраас нүүдэлчид бууц, оромжоо олон үеийн турш байрлуулах зохимжтой газар байсан бололтой.

Харин эдгээр дэнжнээс бусад газруудад, тухайлбал уулын бэл, энгэр, Тарвагатайн болон бусад жижиг голын хөндийгөөр хүрлийн үеийн бууц олдоогүй байгаа шалтгааныг олж тодруулахыг 2016 оны хээрийн шинжилгээний ажлын гол зорилго болголоо. Бид хэдийгээр 1 м гүн хүртэл хайгуул ба сорьцын малтлагуудыг хийж байгаа боловч эдгээр газруудад одоогоос 3000-аад жилийн өмнөх соёлт давхаргууд бүртгэгдээгүй байгаа нь хөрсний идэвхтэй шилжилт хөдөлгөөн ба гулгалтын үр дүнд үгүй болсон уу, эсвэл бидний шалгаад байгаа 1 м гүнээс доош хүрлийн үеийн соёлт давхаргууд байгаа юу зэрэг нь тодорхойгүй байна. Иймээс 2016 оны 6 сарын 6-аас 20-ны хооронд нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй хээрийн судалгааны анги Тарвагатайн хөндийд ажиллав. Үүнд, Йелийн их сургуулийн докторант Б. Жаргалан, Их Британы Кембриджийн их сургуулийн докторант, хөрс судлаач Иан Остерикер, археологийн мэргэжлийн ангийн оюутнууд нар оролцон ажиллав.

Арга зүй. Тарвагатайн хөндийн хөрсний шилжилт, гулгалтын хүч ба давтамж, мөн уулын энгэр, голын хөндийд ямар үеийн хөрсний давхарга барагцаагаар ямар гүнд байх зэрэг байдлыг тодруулахын тулд тус хөндийн хэд хэдэн хэсэгт хоёр байдлаар дээж авав. Эдгээр хөрсний шинжилгээнүүд эртний бууц, суурингийн байрлал, гүний хэмжээг тогтооход дэм болсноор бидний судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

Хөрсний дээж цуглуулах нэгдүгээр арга зүй нь хөндийн нэг хэсэгт өмнө ба хойд зүгийн дагуу тэнхлэг татаж тодорхой давтамжтайгаар 1х1м хэмжээтэй нүх ухаж хананаас босоо тэнхлэгийн дагуу хөрсний дээжнүүдийг авах явдал болно. Уг тэнхлэгт уулын дээд энгэр, уулын бэл, голын хөндий, голын намаг зэрэг газрууд багтана. Нэг амны хөрсний гулгалтын чигийг дагасан энэхүү тэнхлэгийн дагуу дээж цуглуулснаар бид эрт үед хөрсний гулгалтын хэмжээ, цаг уурын ба ургамалжилтын байдал, хөрсний үеүдийн он цаг зэргийг тогтоох боломжтой юм. Хойд ба өмнө зүгийн тэнхлэгээс гадна яг тэр амандаа зүүнээс баруун тийш чиглэлтэй бас нэгэн тэнхлэг татан адил аргаа дээж авав (зураг 1, 2). Нэгэн амын хоёр тэнхлэгийн мэдээг хооронд нь харьцуулснаар дээрх мэдээллүүдийг илүү нарийвчлалтай гаргах боломжтой юм. Хоёр тэнхлэгийн дагуу дээжийг гол хөндийд нэг газраас авсан бол нэг тэнхлэгийн дагуух дээжийг дахин хоёр амнаас авч ерөнхийд нь харьцуулах зорилготой болно. Хөрсний дээжийг төмөр хайрцаганд бүхэл байдлаар авч байлаа. Ингэснээр хөрсний давхаргууд холилдох, эсвэл гадны ямар нэгэн нөлөө үзүүлэх боломжийг багасгаж байгаа юм (зураг 3). Цаашид төмөр хайрцагаар авсан хөрсөн давхаргуудыг лабораторид аваачин хөлдөөгч шингэн шахан нягтрал ихтэй цул шороон биет болгоно. Улмаар хөндлөн зүсэлт хийж 1-5 мм зузаантай хавтангуудыг жагсаан микроскопоор ажиглах болно (зураг 4). Хөрсөн дэх бичил биетүүдийн

төрөл, нягтрал, чиглэл зэргээс хамааран Тарвагатайн хөндийн газар бүр хөрсний давхаргуудын үүссэн түүхийг мэдэх төлөвлөгөөтэй болно.

Хоёр дахь төрлийн дээжийг голын намгаас авлаа. 1м-ээс доош хөрс гэсээгүй байв. Энэхүү намагт 2-2.5м урттай төмөр хоолойг босоогоор нь газарт шаан дотор нь орсон хөрсний давхаргуудыг гаргаж тодорхой давтамжтайгаар он цаг болон макро, микро ботаникийн дээжүүдийг авч байлаа.

Товч үр дүн. Дээрх хоёр аргаар Тарвагатайн хөндийн хэмжээгээр нийт 10 газраас нийт 210кг орчим хөрсний дээж цуглуллаа. Үүнд хөрсний найрлага, ботаникийн, он цагийн дээжүүд хамрагдана. Одоогийн байдлаар дээрх бүх дээж Кембриджийн их сургуулийн лабораторид очоод байна. Хөлдөөлтийн шингэнээр хөрс царцуулах алхам ойролцоогоор 6 сар болдог. Үүний дараагаар 6 сарын турш зүсэлт болон микроскопийн анализ хийх болно. Тарвагатайн хөндийн хөрсний түүхийг харуулах дээрх шинжилгээнүүдийн анхны үр дүн 2017 оны намраас гарч эхлэх төлөвтэй байна.



Зураг 1. Дээж цуглуулсан байршлууд

Зураг 2. Тарвагатайн хөндийн дунд хэсэгт сорьцын малтлага хийж хөрсний дээж авч буй байдал

Зураг 3. Хөрсний дээж авч буй байдал



Зураг 4. Хөрсний дээжийг авсны дараагаар бэхжүүлж, нарийн зүсэлт хийж микроскопоор харахад бэлдсэн байдал

"МОНГОЛЧУУДЫН УГСААТНЫ БҮРЭЛДЭХҮҮН, УГСАА ГАРЛЫН ЦОГЦ СУДАЛГАА" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БОСООГИЙН ХОНХОРТ ЯВУУЛСАН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

А. Очир, Ж. Цамбагарав

Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Босоогийн хонхор хэмээх дурсгалт газрын тухай анх 2012 онд нутгийн иргэд хүн малын хөлөөр ил гарсан ваар савыг ухаж гарган гадаад дотоодын жуулчид болон Хархорум музейд худалдсан авснаар[1] мэдэгдэх болжээ. Мөн 2012 оны зун Орхоны хөндийд ажиллаж байсан Монгол, Хятадын хамтарсан судалгааны ангийн судлаачид нутгийн иргэдийн дам ярианаас тус газрыг сурвалжлан очоод, нэгэн малчнаас хүрэл толь зэрэг зүйлийг худалдан авч Монголын үндэсний музейд хүлээлгэн өгчээ[2]. Харин 2014 оны хавар МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологийн тэнхмийн багш судлаачид Эрдэнэ зуугийн ойролцоо явуулсан археологийн авран хамгаалах судалгааны хүрээнд Босоогийн хонхорт 2 булш малтаад илэрсэн олдворыг Хархорум музейд шилжүүлэн өгчээ[3]. Тус дурсгалт газар удаа дараа очсон судалгааны тайлан, худалдан авсан хэрэглэгдэхүүнийг түшиглэнүзвэл XIII-XIV зууны үе буюу Монголын эзэнт гүрний үед холбогдох боломжтой байлаа. Тэрчлэн сүүлийн жилүүдэдэлдэв ашиг хөөгч нөхдийн хөл хүрэх болсон чимээ гарсан тул Хархорум музейн зүгээс "Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн, угсаа гарлын цогц судалгаа" төслийн удирдлагад танилцуулснаар судалгааны анги томилон ажлуулсан билээ.

Босоогийн хонхор нь Хархорин сумын төвөөс зүүн хойш сангийн аж ахуйн үр тарианы 1-р тасгийн дэргэдэх усжуулах сувгийн ард, Хөгшин Орхон голын гармын зүүн энгэрт буй урдуураа хонхордуу, хад асгагүй элсэрхэг сул хөрс бүхий намхавтар ухаа эрэг нугачаат газар юм. Байршил нь умард өргөргийн 47°14'56.15", дорнод уртрагийн 102°57'09.55", далайн түвшнээс дээш 1464 метр. Босоогийн хонхорын баруунаас зүүн сунан тогтсон нэгэн жижиг ухаагийн энгэрт голын хайрга, уулын чулуу болонтоосгон дараастай 28 булш, чулуу, тоосгон өрлөгтэй суурь бүхий дөрвөлжин хэлбэртэй 5 байгууламж бүртгэн баримжуулав. Энэ удаа тус дурсгалт газрын 9 булш, 1 байгууламжид малтлага явууллаа.

Булшны малтлагын товч танилцуулга: Малтлага хийсэн 9 булшны 1 -ээс бусад нь модон авс бүхий оршуулгатай, огт хөндөгдөөгүй аж. 12A, 12B, 22 дугаартай булшууд өнгөн хөрсөн дээр голын хайргаар үйлдсэн дараастай, гүн бус нүхтэй, хүний толгойг зүүн хойш хандуулаадбог малын шагайт чөмөг, хүрэл толь, төмөр зэв гэх мэт эд өлгийн зүйлс дагалдуулсан байв. Харин 7, 9, 13, 24A, 24B дугаартай булшууднь уулын жижиг чулууашигласан дугуйвтар дараастай болон тоосгоор

[1] *2012 онд Хархорум музейн хөмрөгт худалдан авсан үзмэрийн бүртгэл.*

[2] *А. Очир, Ц. Одбаатар, Б. Анхбаяр. Монгол, БНХАУ-ын хамтарсан археологийн судалгааны 2012 оны ажлын тайлан.УБ., 2012 он. НСИСОУХ-ийн гар бичмэлийн сан хөмрөг*

[3] *У.Эрдэнэбат нар. Монгол улсын ССАЖЯ-ны захиалгаар Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт 2014 оны 4 сард явуулсан археологийн авран хамгаалах малтлага, хайгуул судалгааны ажлын тайлан. 2014 он. Хархорум музейн гар бичмэлийн хөмрөг.*

хөвөөлдөж өрсөн гонзгой дөрвөлжин дараастай, нас барагчийн толгойг баруун хойш хандуулсан,дагалдуулсан олдворгүй байлаа.

Байгууламжийн малтлагын товч танилцуулга: Оршуулгын газрын дунд биед тоосго болон чулуун өрлөг бүхий дундажаар 5х5м хэмжээтэй 5 байгууламжийн суурь бий. Тэдгээрээс хамгийн өмнөд захад буй 5-р байгууламжийг сонгон малтав. Өнгөн хөрсөн дээр барилгын булан мэт тоосгон өрлөг мэдэгдэж байсан бөгөөд 20см орчим гүн болоход дундаа холбоотой дөрвөлжин хэлбэртэй том жижиг 2 хэсэг тоосгон өрлөгтбайгууламж илэрлээ. 1а байгууламжийн хэмжээ нь 4,4х5,2м бол 1Ь байгууламжийн хэмжээ нь 3,2х2,8м аж.

Босоогийн хонхорт явуулсан судалгааны урьдчилсан үр дүнд оршуулгын газар нь Монголын эзэнт гүрний нийслэл агсан Хархорум хоттой ямар нэгэн байдлаар холбоотой бололтой. Харин оршуулгын газар буй чулуу, тоосгон байгууламжууд нь тухайн нас барагчдад зохиулсан тахил мөргөлийн сүм мэт сэтгэгдэл төрүүлж байна.

Хүснэгт 1. Малтлага судалгаа хийсэн булшны товч мэдээлэл

Д/д	Булшны дугаар	Булшны нүхний хэмжээ	Олдвор хэрэглэгдэхүүн	Булшны чиглэл	Авсны байдал	Дараас
1	7-р булш	82 x 230см	-	353º	Модон австай	Уулын чулуу
2	9-р булш	50 x 205см	-	340º	Модон австай	Тоосго
3	12А булш	90 x 280см	Хүрэл толь	43º	Модон австай	Голын хайрга
4	12В булш	90 x 150см	Шагайт чөмөг	30º	-	Голын хайрга
5	13-р булш	80 x 260см	-	340º	Модон австай	Голын хайрга
6	20-р булш	-	-	-	-	Уулын чулуу
7	22-р булш	50х180см	Төмөр зэв,төмөр эдлэл	20º	Модон австай	Голын хайрга
8	24А булш	301х174см	-	336º	Модон австай	Тоосго
9	24В булш	224х145см	-	336º	Модон австай	Тоосго

Байгууламжийн малтлагын явц

Булшны малтлагын явц

Оршуулгын хэсийн малтлагын явц

Гэрэл зургийн баримтжуулалт хийж буй байдал

Тоосгон дараалст булшны малтлагын явц

“МОНГОЛЧУУДЫН УГСААТНЫ БҮРЭЛДЭХҮҮН, УГСАА ГАРЛЫН ЦОГЦ СУДАЛГАА” ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮН

Л.Эрдэнэболд, Р.Төгссайхан

Монгол угсаатны бүрэлдэн тогтсон түүхэн асуудлыг шинжлэх ухааны үүднээс цогцоор нь судлах асуудал өнөөгийн даяарчлалын эрин зуунд хурцаар тавигдаж байна. Монголчуудын угсаа гарлын асуудлыг XlX-XX зуун хүртэл дотоод гадаадын олон арван эрдэмтэн судлаачид тодруулахыг оролдож хэдэн зуун эрдэм шинжилгээний өгүүлэл, ном бүтээл туурвисан боловч өнөөг маргаантай, шийдвэрлэгдээгүй олон асуудлууд байсаар байгаа юм. 2014 оноос Монгол улсын эрдэмтэн судлаачид өөрсдийн угсаа гарвалын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх зорилготой “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн, угсаа гарвалын цогц судалгаа”-ны төслийг санаачлан хэрэгжүүлж эхлээд байна. Энэ ажлын хүрээнд ШУТИС-ийн судалгааны баг 2016 оны 7-р сарын 1-16 хүртэл хугацаанд Төв аймгийн Өндөрширээт сумын Баярт хайрхан уул хэмээх газар малтлага судалгааг хийж гүйцэтгэсэн юм.

Дурсгалт газрын байршил зүйн тодорхойлолт

Төв аймаг Өндөрширээт сумын нутагт орших Баярт хайрхан нь сумын төвөөс зүүн урагш 32км зайтай, Туул голын хойд эрэгт, голоос 3км зайд оршино. Баярт уулын хойно Шовх хайрхан хэмээх уул, түүний баруун талд Бурхант уул зэрэгцэн оршино.Эл 2 уулын ард Хар магнай хэмээх уул хойморлон байрлаж байна. Энэхүү газарт нийтдээ хэлбэр төрхийн хувьд болон гадаад зохион байгуулалтын хувьд харицан адилгүй 80 гаруй оршуулгын дурсгал байна. Эдгээр дурсгалууд нь Баяртхайрхан болон Бурхант уулын урд бэл, баруун хормойгоор таран байрлах бөгөөд Бурхант уулын баруун хойно орших Хар магнай уулын урд хормойгоор мөн тус тус бүлэглэн оршиж байна. Бурхант уулын урд бэлд байх эдгээр булшнуудын дунд нэгэн хиргисүүр байх ба хиргисүүрийг тойрон энд 60 гаруй дурсгал байна. Эдгээр дурсгалууд нь хэд хэдээрээ хойноос урагш цувран байрлажээ. Мөн Бурхант уулын баруун хормойд дугуй хүрээт хиргисүүр байх ба түүний баруун талаар хойноос урагш цуварсан байрлалтай 5 дурсгал байна. Хар магнай хэмээх уулын урд хормойд мөн дөрвөлжин хүрээт хиргисүүр түүнийг дагаад 4 дөрвөлжин булш, мөн дугуй хүрээт хиргисүүр болон түүний баруун талаар хагас тойрсон маягтай хойноос урагш цувран байрласан 12 булш байна. Эдгээр оршуулгын дурсгалуудыг нийтэд нь бид Баярт хайрханы дурсгалт газар хэмээн нэрийдэв. Газарзүйн солбицол нь N47^{0}18`19` E105^{0}24`45 далайн түвшнээс дээш 1077м болно.

Малтлага судалгаа:

Судалгааны багийнхан Баярт хайрхан уулын дурсгалт газар нийт 12 дөрвөлжин булш, 1 шоргоолжин булш малтан судаллаа. Бидний ажилласан дурсгалт газар нийт 80 орчим дурсгал байгаа ба дурсгалууд нь хоорондоо холгүй 3 өөр газар бүлэглэж байрлаж байгаа юм. Бид энэ газар байрлах дурсгалуудыг өргөрөгийн дагуу A,B,C хэмээн 3 хуваасан юм. Бидний малтсан 12 булшнаас 13, 24-р дурсгалаас хээтэй ваарны

хагархай, мөн хүний яс, С-11, С-13, С- 42, С-43, С-45, С-51, В-3-р булшнуудаас хүний ясны хэсгүүд илэрснээс, С-42-р булшнаас илэрсэн хүний яс харьцангүй бүтэн олдсон нь энэ ажлийн чухал хэрэглэгдэхүүн болж байна.

Булшны зохион байгуулалт:

Малтлага судалгаа явуулсан дурсгалт газрын дөрвөлжин булшуудын хэмжээ болоод гадаад зохион байгуулалт нь харилцан адилгүй бөгөөд хамгийн жижиг нь 1,2×1,7м бол, хамгийн том нь 9,0×7,5м хэмжээтэй байна. Гадаад байгууламжийн хувьд хавтгай чулууг хавиргалан босгож хашлага үйлдсэн дөрвөлжин хэлбэртэй, өндөр бус хашлагатай, зарим дурсгалууд дөрвөн буландаа босоо чулуутай мөн дараасыг гол төлөв уулын хадны хэлтэрхийгээр хийжээ. Гадаад зохион байгуулалын хувьд дөрвөлжин булшний гол хэв шинж болох тэгш өнцөгт хэлбэрийн чулуун хашлага, түүний гадуур хавтгай жижиг олон чулуудтай булш зонхилж байна. Урьд өмнө нь судалгааны эргэлтэнд орсон энэ төрлийн булшнуудтай харьцуулбал хэмжээ, гүний хувьд дунд зэрэгт орно. Дотоод зохион байгуулалтын хувьд оршуулгын нүх нь төдийлөн гүн бус, нас барагчийг тэнэгэр байдлаар зүүн зүгт хандуулан оршоосон, шавар ваар савны хагархай, ясан эдлэл зэрэг зүйлс дагалдуулсан шинжтэй байна. Харин эдгээр газарт орших бүхийл булшууд нь эрт цагт тоногджээ.

Товч үр дүн: Төв аймгийн Өндөрширээт сумын нутаг Баяртхайрханы булшнууд нь гадаад байгууламжийн хувьд Г.П.Сосновскийн ангилалын 2-р төрлийн булш буюу “намхан дөрвөлжин чулуун хашлага, түүний гадуур хавтгай чулуун дараасаар хүрээлсэн булш”-д хамаарч байна. Гадаад болон дотоод зохион байгуулалын хувьд дөрвөлжин булшний гол хэв шинж болох тэгш өнцөгт хэлбэрийн чулуун хашлага хүний ясыг тавьсан зүг чигийн байрлал, илэрсэн олдвор зэргээс харвал эдгээр булш нь хүрлийн үеийн дөрвөлжин булшний зан үйлийн нийтлэгийг илэрхийлж байна (Диков, 1958; Наваан, 1975; Цыбиктараов, 1998; Эрдэнэбаатар, 2002).

Баяртхайрханд бидний малтсан дөрвөлжин булшнуудын гүн дунджаар 0,3-1,1 м байгаа нь Монгол болон Буриадын нутагт малтсан дөрвөлжин булшны хэрэглэгдэхүүнтэй харьцуулбал хэмжээ, гүний хувьд дунд зэрэгт орж байна (Цыбиктараов, 1998).

Ихэнх булш эрт цагт тоногдож, сүйдсэн нь дотоод зохион байгуулалт эвдэгдсэн, дагалдуулсан эд өлгийн зүйлс байхгүй, булшийг тойрсон олон тооны жижиг том чулууд эмх замбараагүй тарсан байгаагаас харагдана. Баяртхайрханы С-13, С-24-р булшнаас самнаа хээтэй ваарны хагархай гарсан нь энэ соёлын булшнаас илэрч олддог ваарны материалын найрлага, хээ чимэглэлтэй төстэй байна (Цыбиктараов, 1998, рис 82, 87 ; Эрдэнэбаатар, 2002).

Бидний малтсан 12 булшнаас С-11, С-13, С-42, С-43, С-45, С-51, В-3-р дурсгалуудаас хүний ясны хэсгүүд илэрсэнээс С-42-р булш нь бусад дурсгалуудаа бодволхарьцангүй бүтэн,хөндөгдөөгүй, хүний яс анхны байрлалаараа бүтэн гарсан юм. Тиймээс эдгээр булшны олдворт байгалийн ухааны шинжилгээг хийж он цагийг нарийвчлан тогтоож антропологийн хэмжилт хийжүзэх нь Монголчуудын угсаа гарвалыг тодоттох энэхүү судалгааны ажилд чухал хэрэглэгдэхүүн болж байгаа юм.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд бид нэгэн шоргоолжин булш малтан судалсан нь уг оршуулгын газрын толгой талд сондгойдуу орших байлаа. Эл шоргоолжин булшны гадаад зохион байгуулалт нь харьцангуй бүтэн, мөн дотоод зохион байгуулалт буюу нас барагчийн оршуулгын чулуун хашлага нь бүтэн эвдэгдээгүй байснаараа онцлог юм. Гэвч уг оршуулгын байгууламжаас ямар нэгэн хүний яс илрээгүй, цөөн тооны адууны шүдний хэлтэрхийнээс өөр онцлох олдворгүй байсан хэдий ч оршуулгын байгууламж, зан үйлийн онцлог нь ихээхэн сонирхолтой байлаа.



Зур. 1. Төв аймаг, Өндөрширээт, Баярт хайрхайны 4-р булш

Зур. 2. Төв, Өндөрширээт, Баярт хайрхан. Шоргоолжин булшны малтлагаас

МОНГОЛЧУУДЫН УГСААТНЫ БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН МОНГОЛЧУУДЫН УГСАА ГАРЛЫН ЦОГЦ СУДАЛГАА” ТӨСӨЛ: АРХАНГАЙ, ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГТ ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн, Б.Батдалай

Монгол улсын Засгийн Газрын захиалга, санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголчуудын угсаатны бүрэлдэхүүн ба угсаа гарлын цогц судалгаа” төслийн хүрээнд хэд хэдэн хээрийн шинжилгээний ангийг томилон ажиллуулж байгаа билээ. Түүний нэг ангийг ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Археологи, Угсаатны авран хамгаалах судалгаан салбарын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, Хүннү ба эртний түүхийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор Г.Эрэгзэн нар удирдан хэд хэдэн газарт малтлага судалгааны ажил хийжээ. Тухайлбал, 2015 онд Хөвсгөл аймгийн Алага-Эрдэнэ сумын нутагт орших Худгийн халзан, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Булан тойром зэрэг газруудад сорилт малтлага хийсэн. Харин энэ жил буюу 2016 онд Архангай аймгийн Хотонт, Булган аймгийн Рашаант сумын нутагт археологийн малтлага судалгааны ажил хийв.

Энэ жилийн хээрийн судалгааны ажлын зорилго нь Монгол орны өмнөд болон зүүн, мөн төвийн бүс нутгаар тархсан шоргоолжин булш, зүүн болон төвийн бүс нутгаар тархсан дөрвөлжин булш хэмээх 2 дурсгалыг сонгон судлах, ялангуяа Монголын төвийн бүс нутгаас илэрсэн тухайн төрлийн дурсгалуудыг сонгон малтлага судалгаа хийж тэдгээр нь бүтэц зохион байгуулалт, оршуулгын зан үйлийн хувьд ямар онцлогтой байгаа, бусад бүс нутгийн дурсгалтай харьцуулан үзэх зорилго тавьсан юм. Шоргоолжин булш хэмээх дурсгал нь хүрэл зэвсгийн дунд үеийн гол төлөөлөл болох бол дөрвөлжин булш нь хүрэл зэвсгийн төгсгөл, улмаар түрүү төмөр зэвсгийн үед холбогдох Монгол орны зүүн болон төвийн бүс нутгийн голлон археологийн дурсгал болж байна. Монголын судлаачид дөрвөлжин булшийг Хүннүгийн соёлын өмнөх шатны соёлын дурсгал, өөрөөр хэлбэл Хүннүгийн соёлын угтал болох түрүү үеийн соёл хэмээн үзэх нь нийтлэг байна. Тиймээс ч сүүлийн үед дөрвөлжин булшийг монголчуудын өндөр өвгийн үлдээсэн дурсгал хэмээн үзэх болж, энэ үеэс монголчуудын оршуулгын зан үйл, соёлын үндсэн хэв шинжүүд бүрэлдэн бий болж, угсаатны ялгарал үүсэх нөхцөл тавигдсан хэмээн таамаглах болсон юм.

“Монголчуудын угсаа гарвал, угсаатны бүрэлдэхүүн” төслийн удирлагын зүгээс дээрх таамаглалыг батлах баримт хэрэглэгдэхүүн цуглуулах зорилгоор энэ жилээс төслийн хүрээнд зохион байгуулж буй хээрийн судалгааны ангиудад шоргоолжин булш болон дөрвөлжин булш хэмээх 2 төрлийн дурсгалыг түлхүү анхаарч судлахыг санал болгосон тул бид энэ жил дурдан буй газруудад буй шоргоолжин булш, дөрвөлжин булшийг малтан судлахаар шийдсэн болно.

Тус хээрийн шинжилгээний ангид ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Археологи, Угсаатны авран хамгаалах судалгаан салбарын эрхлэгч, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, Хүннү ба эртний түүхийн судалгааны салбарын эрдэм

шинжилгээний ажилтан, доктор Г.Эрэгзэн, Археологи, Угсаатны авран хамгаалах судалгаан салбарын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б.Батдалай болон МУИС-ийн НУС-ийн ШУС-ийн Антропологи-Археологийн тэнхимийн оюутан О.Алтаннаран, Б.Дашзэвэг, Б.Амгаланбаатар, Д.Буян-Орших, Б.Батбаяр, Б.Цогт-Эрдэнэ, жолооч Д.Ганбат, С.Эрдэнэ, Т.Энхтөр, тогооч Н.Цэвэлмаа нар оролцон ажиллав.

Баянголын Хулхийн амны дурсгал

Архангай аймгийн Хотонт сумын нутагт Хангайн нурууны зүүн биед Баяголын ам хэмээх зүүн тийш харсан өргөн амны адагт амны хойд биед урагш харсан жижиг амыг Хулхийн ам хэмээн нэрлэх бөгөөд уг аманд хүрэл зэвсгийн үеэс дундад зууны үеийг хүртэлх олон үеийн археологийн дурсгалтай билээ.

Баянголын Хулхийн аманд байх Уйгарын үеий бунхант булшийг 2006-2007 онд Монгол улсын нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Монголын үндэсний музей болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Соёлын өв, Археологи судлалын төвтэй хамтарсан Монгол-Хятадын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн хүрээнд Уйгурын үеийн бунхант булш болон чулуун дарааст монгол булшны малтлага судалгааг хийж байжээ.

Баянголын амны шоргоолжин булшны малтлагын ажлын тодорхойлолт

Баянголын амны адагт голын хойд биед байх урагш түрсэн хошууны орой дээр байна. Зүүн хойд зүгт 20 хэмд чиглэсэн намхан дараастай шоргоолжин булш. Булшны захын хүрээг дундажаар 30х25х15см хэмжээтэй чулуу ашиглан хэлбэрт хашлага хийж дотор нь жижиг чулуу битүү дэвсэж үйлджээ. Дараасны урт 13.5м, хойд хэсгийн өргөн 6.2м, голын нарийн хэсгийн өргөн 4.0м, урд хэсгийн өргөн 7.5м байна. Өнгөн хөрсний цэвэрлэгээ хийж дуусгахад захын зарим дараас чулуу гадагш тарсан байдалтай байсан бөгөөд гол хэсгийн дараас хөндөгдөөгүй байв. Цэвэрлэгээний явцад дараасны хойд хэсэгт хашлага чулууны орчмоос залтас 1 ширхэг, шавар ваарны хагархай 5 ширхэг гарав.

Зураг 1. Гадаад дараасыг цэвэрлэсний дараах байдал

Голын жижиг дараас чулууг аван цэвэрлэхэд булшны баруун талын хашлага чулууг хавиргалан босгож тавьсан ба бусад хэсгийн хашлага чулууг хэвтүүлэн тавьж үйлдсэн нь мэдэгдэж байв.

Хашлаганы дотор талд 0.1м гүн малтахад шаргал өнгийн байгалын шаварлаг хөрс нийт талбайд гарч байсан тул талбайн хойд хэсэгт 2.0х2.0м хэмжээтэй талбайд болон талбайн гол хэсэгт 7.0х0.5м хэмжээтэй суваг татан сорилт малтлага явуулахад байгалын шаварлаг хөрс гарч байсан тул 0.4м гүнд малтлагыг зогсоов.

Шавар ваарны хагархай. 1. Самнаа хээ бүхий бор саарал өнгийн шавар ваарны хагархай 2 ширхэг. 2. Хээгүй бор саарал өнгийн шавар ваарны бөөр хэсгийн хагархай 3 ширхэг. 3. Дээрээ товгор зураасан хээ бүхий бор саарал өнгийн ваарны хүзүү хэсгийн хагархай 1 ширхэг тус тус байна.

Чулуун зэвсгийн залтас. Цахиур чулуугаар хийсэн чулуун зэвсгийн хугархай (залтас).

Өвөр Шилүүт уулын дурсгал

Булган аймгийн Рашаант, Өвөрхангай аймгийн Бүрд сумын зааг нутаг Тарнын голын зүүн эрэгт баруунаас зүүн өмнө тийш цуварсан байдалтай тогтсон 2 уулыг Ар, Өвөр Шилүүт хэмээн нэрлэнэ. Хоёр уул засмал замаас ил харагдахын зэрэгцээ замаас өмнө тийш шулуунаар 3км зайд оршино.



Газрын зураг 1. Өвөр шилүүт уулын орчимд буй дурсгалын тархацын дэвсгэр зураг

Эдгээр уулс нь Элсэн тасархай хэмээн нэрлэх элсэн манхан бүхий зурвасын хойд талд шууд залгаа байдалтай байрлах тул уулсын бэлээр элс ихтэй, торлог бут, хайлаас зэрэг мод ургамалтай юм. Ар, Өвөр Шилүүт уул нь Хөгнө Тарнын Байгалийн тусгай хамгаалалттай цогцолбор газарт харьяалагдаж тусгай хамгаалалттай бүсийн өмнөд захад хамаарна.

Ар Шилүүт уулын урд талын амууд болон баруун урд бэлээр хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш, хиргисүүр олон тоотой таарах ба Өвөр Шилүүт уулын баруун хаяа, баруун өмнөд бэл хэсгээр ч олон тооны хиргисүүр, дөрвөлжин булш, мөн он цагийг нарийвчлан тогтооход төвөгтэй чулуун дараас булшнууд тархсан байна.

Уг дурсгалыг Г.Эрэгзэн Монголын Үндэсний Түүхийн музейн археологичоор ажиллаж байхдаа 2001 онд Батхаан уулыг байгалын тусгай хамгаалалтай бүс нутагт оруулах зорилготой хийгдсэн судалгааны ажлын хүрээнд археологийн хайгуулын ажил хийх явцад үзэж тодорхойлолт хийж байжээ. Тиймээс тухайн газарт үзсэн дурсгалын хэлбэр, бүтэц зарим нэг онцлог шинжтэй тул малтлага судалгаа хийхэд тохиромжтой хэмээн үзснээр энэ газарт ажиллах болсон юм.

Гэвч бид малтлага судалгааны зөвшөөрөл авахдаа газрын нэр, сумын хилийн зааг зэргийг зөрүүлсан алдаа гаргасан болох нь газар дээр очиход мэдэгдсэн.

Тухайлбал, Ар Шилүүт хэмээн зөвшөөрөл авсан ч газар дээр очиход малтлага хийх боломжтой онцлог дурсгалууд нь Өвөр Шилүүт уулын дэргэд байсан ба энэ уул Булган аймгийн Рашаант сумын нутаг дэвсгэрт бус Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт багтаж байв. Тиймээс мэргэжлийн зөвлөлөөс авсан зөвшөөрлийн дагуу уг газарт малтлага судалгаа хийх боломжгүй болсон юм.

Тусгай зөвшөөрлийн газрын нэр сольж залруулахаар хөөцөлдөж байх хугацаанд газар дээр очсон баг Өвөр Шилүүт уулын орчимд байсан дурсгалуудыг бүртгэн тархацын зураг хийх ажлыг хийсэн ба малтлага судалгаа хийх 3 дурсгалын өнгөн хөрсний цэвэрлэгээг хийсэн. БСШУСЯ-ны дэргэдэх мэргэжлийн зөвлөл тарсантай холбоотойгоор зөвшөөрлийн нэр солих боломжгүй болж малтлага судалгааны ажил хойшлосон юм. Дор хайгуул хийж бүртгэсэн дурсгалууд болон өнгөн хөрсний цэвэрлэгээ хийсэн 3 дурсгалын талаарх товч тодорхойлолтыг оруулав.

Өвөр Шилүүт уулын археологийн дурсгалууд

Бид Өвөр шилүүт уулын энгэр бэлээр тархсан хүрэл зэвсгийн үеийн дурсгалуудыг бүртгэн баримтжуулж, тархацын дэвсгэр зураг хийсэн. Энэхүү хайгуул ажлын үр дүнд урьдчилсан байдлаар 36 дурсгал бүртгэн баримтжуулснаас хиргисүүр 2, дөрвөлжин булш 17, булш оршуулгын дурсгал 15, чулуун байгууламж 2 тус тус багтаж байна.

Өвөр Шилүүт ууланд өнгөн хөрсний цэвэрлэгээ хийсэн дурсгалууд

1-р булш. Уулын баруун бэлд сондгой байдалтай нэгэн булш байна. 5.0м голч бүхий дугуй чулуун дараастай булш. Баруун хэсгийн дараас чулуу хөндөгдөж булшны баруун хойд хэсэгт бөөгнөрсөн байдалтай байна.

2-р булш. Уулын баруун энгэрт хадны ёроолд налуу газар байрлана. Бусдаас том хэмжээтэй чулуугаар дөрвөлжин хашлага гаргаж хашлаганы гадна талаар хаяалан дарсан дараастай. Хашлаганы дотор талын зарим дараас чулуу байхгүй болжээ. Хэмжээ 4.8х3.5м.

3-р булш. Уулын ар шилд хадны ёроолд дэвсэг газар байрлана. Дугуй, овгор дараастай булш. Булшны дараасыг үйлдэхдээ том хэмжээтэй чулуугаар дугуйлан хашиж дотор нь түүнээс арай жижиг хэмжээтэй чулуу дүүргэн овоолжээ. Голч 7.5м.

Товч дүгнэлт

Шоргоолжин булш нь Монголын Говийн бүс нутгаар хамгийн өргөн тохиолддог бөгөөд Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн нутгаар болон Төв, Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн өмнөд хэсгээр цөөн тоотой тархсан байдаг өвөрмөц хэлбэрийн дараас бүхий дурсгал юм.

Бидний малтлага судалгаа хийсэн шоргоолжин булш нь Архангай аймгийн Хотонт сумын нутагт Хангайн нурууны баруун хэсэгт уулын орой дээр оршино. Гадаад дараасны хувьд дундажаар 30х25х15см хэмжээтэй чулуугаар хүрээ гаргаж дотор нь жижиг чулуу дүүргэж үйлдсэн намхан дараастай бөгөөд гадаад дараас чулуу

хөндөгдөөгүй байсан билээ. Малтлагын явцад дараас чулууны зүүн болон хойд хэсгээс гарч байсан шавар ваарны хагархай нь хийц найрлагын хувьд урьдчилсан байдлаар хүннүгийн үеийн булшнаас гардаг шавар сав суулгатай ижилсэж байгаа билээ. Мөн дараасны зүүн хойд хэсгээс гарсан жижиг чулуун зэвсгийн залтас нь неолитийн үеийн цахиур чулуун зэвсгийн хугархай бололтой байна.

Иймд бидний малтан судалсан уг шоргоолжин булшнаас оршуулга болон нарийн он цаг тогтоох хэрэглэгдэхүүн илэрсэнгүй.

"МОНГОЛЧУУДЫН УГСААТНЫ БҮРЭЛДЭХҮҮН БА МОНГОЛЧУУДЫН УГСАА ГАРЛЫН ЦОГЦ СУДАЛГАА" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 2016 ОНД ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМАНД ХИЙСЭН МАЛТЛАГЫН ҮР ДҮНГЭЭС

Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү, Г.Энхбаяр

Монгол улсын ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн нь Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт археологийн судалгааны ажлыг олон жил хийж ирсэн билээ. Тус хүрээлэнгийн Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбарын эрхлэгч, доктор Ц.Төрбат, эрдэм шинжилгээний ажилтан Д.Батсүх, Н.Баярхүү, Г.Энхбаяр нарын судлаачид Мөнгөнморьт сумын нутаг Номгон уулын баруун, зүүн энгэр, бэл хормойгоор орших эртний нүүдэлчдийн булш оршуулгыг 2016 оны 08 сарын 05-наас 8 сарын 25-н хүртэлхи хугацаанд судалсан билээ. Энэ хугацаанд энд хүрэл зэвсгийн үеэс дундад зууны үеийн монголчуудад холбогдох нийт 18 дурсгалыг малтан судалсан юм. Эдгээр дурсгалыг тус уулын баруун, зүүн энгэрт байснаар нь Номгон I, II хэмээн хоёр тусдаа ангилсан ба Номгон-I дурсгалд нийт 11, Номгон-II дурсгалд 7 булшийг тус тус малтан судалжээ.

Хэнтийн нурууны салбар уулсын жижиг салааны нэг болох Номгон хэмээх урдаас хойш сунан тогтсон уул бий. Түүний зүүн талд мөн урдаас хойш чигтэй сунасан нэгэн уул байх бөгөөд түүнийг нутгийнхан лам хүн өмнө амьдарч байснаад "Ламын хаваржаа" хэмээн нэрлэдэг байна. Хэрлэн гол Мөнгөнморьт сумын зүүн талаар ертөнцийн зүгээр хойноос урагш чигтэй мушгиран Номгон уулын зүүн суга, Ламын хаваржааны баруугаар урсана. Иймд энэ хоёр уулын дунд орших хөндий нь эрт цагаас хүн амьдрах таатай газрын нэг байсан бөгөөд малын сайн бэлчээртэй, ургамал, ус тэгш байгалийн үзэсгэлэнтэй сайхан газар юм.

Номгон уулын ноён оргил дээр "Хар сүлд" бүхий овоотой бөгөөд түүнээс урагш байх нэгэн уужуу ам бүхий намссан хэсгээр автомашин даваа давах замтай юм. Тус овоон дээрээс нутгийнхан Бурхан халдун уулаа тахин шүтдэг ажээ. Номгон уулыг баруун талаасаа давахад харьцангуй аажим налуу бол зүүн талдаа нэлээд огцом, уруу аж. Энэхүү даваны зүүн талд Номгон уулаас зүүн тийш сунасан араараа битүү нарсан ой мод, хадтай нэгэн холбоо толгой бий. Тус толгойн урд болон зүүн энгэрээр нэлээд тархсан байдалтайгаар хиргисүүр, дөрвөлжин, монгол зэрэг олон олон цаг үеийн булш дурсгалууд зэрэгцэн оршино.

Бидний малтан судалсан 18 оршуулгын байгууламжийн 11-ээс нь хүний оршуулга илэрсэн бөгөөд он цагаар нь ангилвал хүрэл зэвсгийн үеийн 4, хүннү 1, монголын үеийн 6 булш байв. Эдгээр булшнуудаас судалгааны ач холбогдолтой олон чухал олдвор хэрэглэгдэхүүн илэрсэн.

Тухайлбал, өмнө судалгааны эргэлтэнд төдийлөн мэдэгдэж байгаагүй хэлбэрийн хүрэл зэвсгийн нэг булшийг малтан судлахад хавтгай намхан дараастай бөгөөд дараасын төв хэсэгт урдаас хойш сунасан зууван дугуй хэлбэрийн чулуун

хүрээтэй мэдэгдэнэ. Булшны чулуун дараасын төвийг дайруулан баруунаас зүүн тийш тэнхлэг татан хөндлөн огтлолыг гаргахад 3 үе чулуун дараастай байв. Энэ үед төвийн чулуун хүрээний дотор ертөнцийн зүгээр хойноос урагш чигтэйгээр оршуулгын нүхний таг болгон хийсэн аварга том чулуудаар хийсэн дараас байсан нь 100×80×50-60см хэмжээтэй чулуудыг ашигласан байлаа. Дараасыг хуулан малтлагыг үргэжлүүлэхэд малтлагын талбайн төвд 160×44см хэмжээтэй оршуулгын нүхний толбо илэрснийг нарийн торгон элсээр битүү дүүргэсэн байв.

Эндээс 120см гүнээс ертөнцийн зүгээр зүүн тийш толгойгоор нь хандуулан дээш харуулж тэнэгэр байдлаар оршуулсан хүний оршуулга илэрсэн юм. Хүний баруун мөр, цээжний тус газар 14 ширхэг хүрэл товруу, хүрэл онго 1 ш, хоёр хөлийн хаpалдаа цагаан өнгийн зуурмагаар хийсэн 116 ш гонзгой, урт сувснууд тус тус гарав. Хүний ясны хадгалалт муу ба дагалдуулсан эд өлгийн зүйлээр нь эмэгтэй хүн байсан бололтой хэмээн урьдчилан дүгнэв. Судлаачдын өмнө хүзүүний зүүлт хэмээн үздэг байсан сувсыг оршуулгын эзний өмсгөл хувцсан дээр хадсан байдалтайгаар илрүүлсэн нь чухал ач холбогдолтой юм. Мөн тус булшнаас илэрсэн хүрэл онго нь хүний дүрсийг ерөнхийлсөн байдлаар зантгар том толгой, бахим гар, нарийн урт бие, хоёр хөлтэйгээр дүрсэлсэн байснаас хоёр хөлийн хэсэг хугарсан. Тус онгыг эсгий эдлэлээр хийсэн уутанд хийсэн байсан бололтой. Хадгалалт сайн. Хэмжээ: урт 4см, өргөн 2.8см, зузаан 0,4см.

Бидний малтан судалсан Номгон уул-II дурсгалын №24 дугаартай дөрвөлжин булш эрт цагт тоногдсон байсан хэдий ч малтлагын явцад хүрэл хутга 1 ш, хүрэл зэв 1 ш тус тус илэрсэн. Энэхүү булш нь хүний нүднээс далд газарт буюу Номгон уулын оройн хадтай толгойн тэгш дэвсэгт орших бөгөөд түүний зэрэгцээ нэгэн хиргисүүр бий. Тус дөрвөлжин булш нь намхан дараастай ба дараас бага зэрэг эвдэрсэн. Дараасын хэмжээ: баруунаас зүүн тийш 3,1м, хойноос урагш 3м. Чулуун хашлагыг азимутын 30 хэмийн чигт сунасан байдлаар хийсэн. Малтлагын явцад хашлагын төв хэсгээс хүний бугалганы хугархай яс гарсан ба 80-86см гүнд байгалийн ургаа чулуун шал илэрсэн бөгөөд хашлагын дотор талын зүүн захаас хугархай хүрэл хутга, урд захаас хүрэл зэв илэрсэн болно. Тэдгээрийг товч тодорхойлбол, хүрэл хутга нь харьцангуй жижиг хэмжээтэй бөгөөд бариул болон үзүүрийн хэсэг хугарсан, бөгтөр мөртэй ба гурвалжин хөндлөн огтлолтой юм. Ирний хэсэг үзүүр лүү бага зэрэг өлгөр ажээ. Хэмжээ: урт 7,6см, өргөн 1,8см, зузаан 0,3см.

Харин хүрэл зэв нь харьцангуй жижиг хэмжээтэй бөгөөд гурван дэлбээтэй, онгин биетэй. Онгин биеийн нэг талд сумны мөсийг сугалж авах зориулалт бүхий нүхтэй. Хэмжээ: урт 2,4см, өргөн 1,2см, зузаан 0,1см.

Мөн Номгон-I дурсгалын №6, 8 дугаартай хоёр дөрвөлжин булшнаас хүний оршуулга илрүүлсэн нь судалгааны чухал хэрэглэгдэхүүн болох юм. Дээрхи дурсгалуудын дундаас ганцхан хүнну булшийг илрүүлэн судалсан нь сонирхолтой.

Энэхүү бүс нутагт илрүүлэн судалсан дундад эртний Монголчуудад холбогдох 6 булшны 4 нь хөмөгтэй байсан нь нэлээд сонирхолтой бөгөөд үйлийн хайч, зоос,

ээрүүлийн шавар дунгуй, хүрэл эдлэл, төмөр хутга, үйс, явуу зэрэг түгээмэл гардаг олдворууд илэрсэн байна.

Эдгээрээс дундад эртний монголчуудад холбогдох Номгон-II дурсгалын №2-р булшны малтлагаас танилцуулъя.

Уг булш нь намхан дугуй чулуун дараастай юм. Малтлагыг 3.2×4.2 м талбайд гүйцэтгэв. Чулуун дараасын хэмжээ: 250×240см. Малтлагын явцад талбайн төв хэсэгт зүүн хойноос-баруун урагш чигтэй хандсан хөмөгт баруун хажуугаар нь хэвтүүлж хоёр хөлийг нь атийлган, толгойгоор нь бага зэрэг зүүн урагш хандуулан оршуулсан хүүхдийн оршуулга илрэв. Хүүхдэд хүзүүний хүзүүний зүүлт, хүрэл зоос, төмөр хутга, хүрэл эдлэл, цагирган ээмэг, төмөр эдлэл зэрэг эд зүйлс дагалдуулсан байжээ. Ясны хадгалалт муу. Хөмөгний хэмжээ: 106×62см, өндөр 50см. Энэхүү илэрсэн хүрэл зоос нь ихээхэн сонирхолтой судалгааны хэрэглэгдэхүүн бөгөөд Тан улсын үеийн Кайюань Тунбао зоос болно.

Энэ жилийн судалгааны ажил их амжилттай болсон бөгөөд цаашид он цаг болон генетик, палеопатологийн нарийвчилсан судалгааны ажил үргэлжлэх бөгөөд нарийн чухал мэдээллийг бидэнд өгөх байхаа хэмээн найдаж байна.

Бидний ажилласан бүс нутагт дөрвөлжин булш, хиргисүүрийн тахилын байгууламж зэрэг дурсгалуудаас нийт 7 дурсгалыг шунахай сэдэлтэйгээр тоносон байв. Бид орон нутгийн удирдлагад холбогдох тайланг өгөхдөө гэрэл зургаар баримтжуулан хавсаргаж өөрсдийн саналыг тусгасан. Цаашид бид энэ тал дээр хамтран ажиллаж дан ганц орон нутгийн удирдлага, байгаль хамгаалагч зэргээр хамрах хүрээгээ хумихгүйгээр холбогдох яам, тамгын газар, тухайн газрын нутгийн зөвлөл, орон нутгуудын нэр хүндтэй хүмүүс зэргийг оролцуулан төр, улс орны хэмжээнд анхааралд авахуулах зэргээр ажиллах хэрэгтэй байна.

Хавсралт №1

Зураг 1. Хүрэл онго

Зураг 2. Хүрэл хутга *Зураг 3. Хүрэл зэв*

"МОНГОЛ УГСААТАН БҮРЭЛДСЭН БОЛОН МОНГОЛЧУУДЫН ГАРАЛ ҮҮСЛИЙН ЦОГЦ СУДАЛГАА" ҮНДЭСНИЙ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ШУА-ИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИ ХЭНТИЙ, ДОРНОД АЙМГИЙН НУТАГТ АЖИЛЛАСАН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ҮР ДҮНГЭЭС

С.Өлзийбаяр, Б.Очир, Г.Одмагнай

Тус төслийн Хэнтий аймгийн нутагт ажиллах экспедиц нь Монгол нутгийн зүүн нутгаар тархсан дөрвөлжин булшны соёлын эздийн он цагийг урьдчилсан байдлаар тогтоох болон генетикийн шинжилгээнд хамруулах судалгааны дээж хэрэглэгдэхүүн олж илрүүлэхэд үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэх явдал болно. Дурдсан газруудад орших дөрвөлжин булшнаас малтан судлах, Онон, Хэрлэн голуудын сав газрын зарим нутгаар сяньби, жужан, кидан зэрэг монгол аймгуудад холбогдож болох дурсгалыг эрэн сурвалжлахад тус экспедицийн зорилго оршино.

Үндэслэл: проф А. Очирын удирдсан "Монгол угсаатан бүрэлдсэн болон Монголчуудын гарал үүслийн цогц судалгаа" Үндэсний төслийн зорилго нь өнөөгийн монголчуудын гарал үүсэл, угсаа соёлын үйл явцыг өргөн хүрээтэй цогц судалгааны үр дүнд тодорхой төвшинд шийдвэрлэхэд оршино. Тухайлбал, хүрэл, төмрийн түрүү эрин үеийн оршин суугчдын чухам ямар бүлэг нь хүннүгийн угсаатны цөм бүрэлдэхэд оролцсон болон улмаар хүннүчүүд хийгээд дундад үеийн монгол оршуулгын эздийн хооронд удмын холбоо байгаа эсэхийг түүхэн сурвалж, археологийн хэрэглэгдэхүүний харьцуулалтын аргаар нягтлан үзэхийн зэрэгцээ генетикийн шинжилгээг өргөн ашиглах явдал болно. Нөгөөтэйгүүр тус төслийн хүрээнд Хүннүгээс Монголын үеийг хүртэл угсаатны гол мөхлөгийг хадгалаж байсан нүүдэлчдийн дурсгалыг шинээр илрүүлэх, олж тогтоох нь бас нэгэн чухал зорилт болно.

Ханангийн дурсгал-1, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын төвөөс баруун зүгт 20км орчим зайд Хэнтийн нурууны баруун урд үзүүр болох "Ханан" хэмээх ханан хадтай хошуу бий. Уг хошууны урд тэгш тал дээр том жижиг 2 дөрвөлжин булш байна. Үүний урд талын том булшийг Ханан-1, жижгийг нь Ханан-2 хэмээн дугаарлан малтав. 5x8м хэмжээтэй. Хашлагын зүүн хойд хэсэгт тарваганы дош тул бусад хэсгээс харьцангуй өндөр шороон овоолго үүсчээ. Толгодын бэл газар тул дурсгалын дээр болон ойр орчмоор хээрийн тачир өвс, мөн бут дэрс ургасан байна. Хавтгай том чулуудыг хавиргалан зоосон хашлагын дотор мөн хавтгай том чулуудыг битүү зулж дүүрэгсэн. Зүүн хойд буланд хэсэгхэн газар чулуу бага. Урд талын хашлагын гол хэсгээр хашлага чулуу байхгүй. Уг ажлын явцад хашлагын зүүн урд булангаас адууны толгой байсан нь өгөршиж муудсан бололтой адууны шүднүүд байрлалаараа олдож байлаа.. малтлагыг үргэлжлүүлэн хөрснөөс 50см болоход зүүнээс баруун чиглэлтэй

хоёр зэрэгцээ оршуулгын толбо илэрлээ. Энэхүү дөрвөлжин булшинд хашлагын төвд бус ялимгүй баруун хойд хэсэгт нь хоёр нас барагчийн толгойг нь зүүн зүгт хандуулан газрын гүний өөр түвшинд зэрэгцүүлэн оршоожээ. Урд талын нүхэн дэх яс тонуулчдын үйлдэлээс үү, элдэв мэрэгч амьтдын уршигаар уу ясны байрлал энд тэнд хагас дутуу болсон байна. Харин хойд талын нүхэн дэх оршуулгын байдал бүтэн урьд өмнө хөндөгдөж хөдлөөгүй байна. Талийгчийг зүүн зүгт толгойг нь хандуулан биеийг нь дээш харуулж тэнэгэр байдлаар хэвтүүлжээ. Уг нүхний толгой талын зүүн хананаас хүний нугалам илэрсэн. Мөн зүүн гарых нь тохой дээр бог малындал дагалдуулан тавьжээ. Бид баримтжуулалыг үйлдээд олдвор хэрэглэгдэхүүнийг авч нүхэн дотор шалгалтыг сайтар гүйцэтгээдмалтлагыгдуусгав.

Ханан №1 дурсгалын гадаад байдал, оршуулга

Хадан хөвийн дурсгал: Дорнод аймгийн Гурванзагал сумын төвөөс баруун зүгт 30 орчим километр зайд 30-аад км зайд эрт цагт ус урсаж байсан өндөр улаан эрэг жалга бүхий голын сайр бий. Үүнийг нутгийн иргэд Улаан эрэг хэмээн нэрийднэ. Улаан эргийн баруун дэнж дээр хойноос урагш жиглэлтэй сунаж тогтсон хадат толгод байх үүнийг нутгийн иргэд хадан хөв гэж нэрлэх бөгөөд энгэр бэлээр нь олон тооны булш дурсгалууд байх ажээ. Эдгээр дурсшалуудаас бид 4 дурсгалыг сонгон малтсан юм. Уг толгодын дунд дэллэж тогтсон жижигхэн хад байх бөгөөд үүний баруун талд орших булшийг №1 гэж дугаарлан малтсан юм. Уг булшны өнгөн хөрсний цэвэрлэгээг хийж баримтжуулан малтлагыг эхлүүлэхэд дөрвөлжин хашлага дотор битүү чулуугаар дүүргэсэн бөгөөд түүний доор том чулуудаар таг маягийн болгож тавьсан ажээ. Уг чулуудыг аван малтлагыг цааш үргэлжлүүлэхэд баруунаас зүүн тийш чиглэсэн толбо илэрч толбоны дагуу малтахад толгойг нь зүүн тийш харуулан тэнэгэр байдлаар тавьсан оршуулга илэрсэн юм. Талийгчийн зүүн хөлийн шилбэнд нь цагаан сувс зүүлт зүүлттэй байснаас өөр эд өлгийн зүйл илэрсэнгүй малтлагыг дуусгав. Энд малтсан бусад 3 булшнаас оршуулга илэрсэнгүй харин 3-р булшнаас тоногдсон байдалтай хүний ясны зарим хэсгүүд илэрсэн юм.

Хадан хөв №1   Малтлагын явц

Бүс хайрханы дурсгал : Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг, сумын төвөөсөө баруун урагш 30 гаран км-т Хэнтийн нурууны урд төгсгөлийн салбар бэсрэг уулсын хэсэг Хэрлэн голын хөндий нуга руу түрж ганц сондгойгоороо орсон нэгэн бэсрэг хайрханыг Бүс хайрхан хэмээнэ. Түүний энгэр бэл эргэн тойрноор эртний булш дурсгалууд элбэг аж. Бүс хайрханы өвөрт хоёр жижиг толгой мөргөцөгийн хооронд тэгш зайд 6х4м хэмжээтэй зууван чулуун хүрээ үүсгэсэн эртний байгууламж байна. Хүрээний гадна болон дотор талаар тарсан чулуутай. Бид хүрээний хэлбэр дагуу тарсан дараасуудыг хамруулан дугариг хүрээ татаж өнгөн хөрсний цэвэрлэгээг хөрснөөс 20см хийн малтлагыг үргэлжлүүлэн хийхэд талийгчийн толгойг зүүн зүгт хандуулан тэнэгэр байдлаар тавьсан оршуулга илэрсэн юм. Байрлалаараа буй бугалганы хойд талд 10 ш хүрэл зэв зэрэгцээ давхралдсан байрлалтай, түүний зүүн талд нь богино бариултай чулуун аяга байна. Мөн жижиг нумын гичирийн 4 наалт хугархай, 1 ш хүрэл товруу олдсон.

Бүс хайрханы оройн баруун талаас урагш чигтэй тогтсон хамар нурууны баруун энгэр хажууд нь сайхан тэгшхэн дэвсэг талбай дээр эрт үеийн оршуулга тахилгын газар байна. Эдгээрээс хойноос урагш чиглэлтэй цуварсан 2 дөрвөлжин хашлагатай булш, хойхно талд нь мөн дугариг хүрээтэй дөрвөлжин хүрээтэй сонирхолтой байгууламжууд байна. Эндээс цуварсан 2 дөрвөлжин булшны хойд талынхыг нь малтсан бөгөөд талийгчийг Зүүн тийш нь харуулан тавьсан оршуулга илэрсэн ба түүнийг тойруулан том чулуудаар хашлага хийжээ. Гавалын орой хэсэг том хашлага

яулуунд тулах бөгөөд уг хашлаганы гадна талд тахилгын хэсэг байх ажээ. Энд адууны толгойг тавьж түүнийг тойруулан олон тооны бог малын толгойнууд тавьсны дотор төл малын толгой ч тавьсан байсан юм.

Бүс хайрхан – 2 дурсгалаас зүүн хойш 30м орчим зайд 3х1.5м хэмжээтэй хойноос урагш гонзгой хэлбэрийн битүү чулуун дараасыг бид цэвэрлэн 130см болоход нүхний хойд хэсгээс үйсний хэсэг илэрч мэдэгдэж эхэлсэн бөгөөд зүүнтэйд нь хүний гавал илэрч мэдэгдэв. Баруун тохойных нь доор нь хүрэл толь цухуйж мэдэгдэнэ. Талийгчийг ялимгүй баруун хойд зүгт 10 градуст толгойг нь хандуулж үйсээр хийсэн богтого малгайг нь толгойных нь баруун талд, хүрэл толийг нь баруун тохойн доор нь төмөр хайч зүүн ташааных нь орчим, Толгойных нь зүүн талд бас нэгэн 30 гаран см урттай нарийн модон эдлэл дагалдуулан нүхийг дан шороогоор дагтаршуулан дүүргээд дээр нь чулуугаар дараас хийж тавьсан байна.

Хүрэл толь Богтого малгай

Дулаан уулын дурсгал

Хэнтий аймгийн Баянмөнх сумын нутаг Хэрлэн голоос урагш Монголын тэгш өндөрлөгийн ойролцоо өндөртэй сүрлэг жигд уулс тус тусаар оршино. Эдгээрийн хойд хэсгийн уулсын нэгэн болох хойноосоо урагш сунан тогтсон хад асга ихтэй Дулаан уул. Баруун хойноо нэлээд өндөр дээр алсуур налуу дэвсэгтэй. Үүн дээр хойноосоо урагш тал саран хэлбэр үүсгэсэн болон энд тэнд байрлах булштай эртний оршуулгын газар байх Үүний дунд хэрд байх нэгэн булшийг бид сонгон малтсан бөгөөд анх харагдах байдал нь голдоо чулуугүй цагариг хэлбэртэй байх ба цэвэрлэгээний дараа харахад зүүн талын хүрээ нь дөрвөлжин өнцөг үүсгэхээр шулуун ба бусад хэсэг нь мэдэгдэхгүй ажээ. Малтлагыг цааш үргэлжлүүлэхэд талийгчийн толгойн талыг зүүн зүгт хандуулж түрүүлгэ нь харуулан оршуулсан байжээ. Бид уг дурсгалаас гадна гадна энд 2 дурсгал малтсан бөгөөд мөн адил түрүүлгэ нь харуулсан оршуулга илэрсэн бөгөөд ямар нэгэн эд өлгийн зүйл илрээгүй юм

МОНГОЛ-АМЕРИКИЙН ХАМТАРСАН "УВС НУУРЫН САВ ДАХЬ НЭН ЭРТНИЙ ХҮМҮҮСИЙН АХУЙ ОРЧИН" ТӨСЛИЙН 2016 ОНЫ СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Ж.Баярсайхан, Лукас Бартон,
Кристофер Морган, Т.Түвшинжаргал

Уг судалгааны төслийг 2015 оноос эхлэн АНУ-ын Питсбургийн их сургуулийн Харьцуулсан археологийн судалгааны төвтэй хамтран хэрэгжүүлж буй бөгөөд хоёр дахь жилдээ 2016 оны 7-р сарын 30-наас 8-р сарын 12-н хүртэлх хугацаанд Увс аймгийн Зүүнговь сумын Баяннуурын сав үргэлжлүүлэн ажиллав.

Энэ оны судалгаанд Монголын талаас МҮМ-н Эрдэм шинжилгээний төвийн дарга, доктор Ж.Баярсайхан, археологич Т.Түвшинжаргал, АНУ-ын талаас Питсбургийн их сургуулийн Харьцуулсан археологийн судалгааны төвийн захирал, доктор Лукас Бартон, Невадагийн их сургуулийн Антропологийн тэнхимийн доктор Кристофер Морган нар хамтран ажиллаа.

Монголын умард бүс нутаг дахь Увс нуурын сав газрын эртний анчид түүвэрлэгчдийн ахуй амьдралын хувьсал, тэдгээрийн мал аж ахуйд шилжсэн үйл явцын талаарх ойлголт нь тун чухал асуудал юм. Харамсалтай нь энэ бүс нутгийн анчин түүвэрлэгчдийн тухай археологийн судалгааны ажил хомс байдаг. Энэ нь нэг талаар судлаачид төдийлөн анхаарал хандуулаагүйгээс гадна нөгөө талаар соёлт давхарга бүхий дурсгалт газар нэн ховор байдагтай холбоотой. Баян нуурын сав газар бол дэлхийн хамгийн хойд бүсэд буй элсэн манхан бөгөөд олон жижиг булаг горхиор тэжээгддэг цэнгэг уст нуур юм.

Өнгөрсөн 40 гаруй мянган жилийн туршид Баян нуурын усны төвшин олон удаа нэмэгдэж, хасагдаж байсан бөгөөд нуурын төвшний энэхүү өөрчлөлт бүрт нуурын эрэг дагуу үржил шимтэй хөрс, ургамлын аймаг бүрэлдэж байсан нь өнөөг хүртэл янз бүрийн төвшинд хадгалагдан үлджээ. Түүнчлэн усны эх үүсвэр бүхий нуурын эрэг орчимд хүмүүс байнга амьдарч эхэлсэн цагаас тэдгээр хүмүүсийн үлдээсэн ямар нэгэн ул мөр энэхүү хөрсөнд хадгалагджээ. Тиймээс хүний үйл ажиллагаатай холбоотой он цаг тогтоох боломж бүхий соёлт давхарга бүхий газрууд энд тэндгүй бий. 2015 онд бидхоёр соёлт давхарга бүхий дурсгалт газарт малтлага судалгаа хийсэн юм. BN001 дугаартай малтлагаас гарсан олдвороос он цаг тогтоох судалгаанд эртний хөрс, модны нүүрс болон хүлрийн дээжийг ашигласан бөгөөд хүлрийн тогтоц болон эртний хөрсний бүтцийн судалгаа нь одоогоос 4160-6880 жилийн хоорондох нуурын усны төвшин, хаялга зэргийг тодорхой харуулж буй юм.

Нуурын хаялгын энэхүү ул мөр нь хэдийгээр салхиар нүүж тогтсон элсэн манхнаар хуваагдсан ч эртний хэлбэрээ тодорхой хэмжээгээр хадгалсан байна (Зураг 1-2). Эндээс Шинэ чулууны үеийн иржгэр хээтэй ваарны хагархай болон чулуун зэвсгийн зүйлс тэдгээрийн дотор хоёр талаас нь засаж үйлдсэн сумны зэв гарсан соёлт давхарга нь одоогоос 4330-3920 жилийн тэртээд хамаарахыг тогтоосон.

BN003 дугаартай малтлагаас гал түлж байсан ор, тулгын чулууд, сүүн тэжээлт амьтны яснууд (буга, хандгай, адуу), ялтсан ирний үлдэц, бэлдэц болон ялтсан ир, залтас зэрэг гарсан. Эдгээр хоёр бүлэг олдворууд нь он цаг тогтоох боломжтой байснаараа хөрсөн дээр ил байрлах олдворуудаас ялгаатай юм. BN001 болон BN003 зэрэг эртний соёлт давхарга бүхий дурсгалаас он цаггогтоож чадсан явдал нь Увс нуурын сав газрын археологийн дурсгалт газруудыг тайлбарлах, таньж мэдэх боломжийг олгож байна. Хэдий тийм боловч Шинэ чулууны үе болон Түрүү хүрлийн үеийн шилжилтийн цаг хугацааг оролцуулаад эрт болон дундад Голоцены үеийн (НТӨ 9500-3000 жил) олдворын цуглуулгад он цаг тогтоох, соёлын болон технологийн өөрчлөлтийн талаар цэгцтэй дараалал гаргах, бэлчээрийн мал аж ахуйн үүсэл болон малыг гаршуулах үйл явцыг ойлгох боломж хомс хэвээр байна.

2016 оны судалгааны ажил урьдын адил Баяннуурын эргэн тойрон дахь эртний хүмүүсийн ул мөрийн талаарх мэдээллийг баяжуулж, ил хадгалагдсан эртний соёлт хөрсийг илрүүлэн байршил болон өндрийн төвшинг, нуурын өнөөгийн усны мандлын төвшинтэй харьцуулан хэмжих ажлыг хийв. Түүнчлэн 2015 онд хайгуул судалгаа хийгдээгүй Цагаан голын савд хайгуул судалгааг үргэлжлүүлж, нуурын цутгалан жижиг голуудыг эртний хүмүүс хэрхэн ашиглаж байсныг судалгааны үр дүнд тодорхойлохыг хичээж байна.

Хайгуул судалгааны дүн: Нийт цуглуулсан олдвор 1668 ш. Үүнд: Чулуун зэвсгийн зүйлс 739 ш, ваар савны хагархай 628 ш, мал, амьтны ясны хэлтэрхий 179 ш, төмөрлөг эд зүйлс 28 ш, бусад (сувс, цацагт хяруулын өндөгний хальсны хагархай, гэх мэт) 94 ш зэрэг багтана(Зураг 3).

Баян нуурын сав нь эртний түүхийн олдвороор маш баялаг. Баяннуурын баруун хойд хэсэг болон Өгөөмөр уулын хооронд эртний булш оршуулга олноор байрлах бөгөөд эртний хүмүүс өөд бологсдоо үдэх зан үйлийн нэгэн том төвлөрсөн газар байсан илэрхий байна(Зураг 4).

Түүврээр цуглуулсан асар олон тооны олдвороос барагцаалан үзвэл Монгол нутгаас маш цөөн тоогоор олдоод буй Шинэ чулууны болон Түрүү Хүрлийн үеийн булш оршуулга байх магадлал өндөртэй. Тиймээс цаашид эдгээр дурсгалаас дээжлэн малтаж, Баян нуурын сав дахь нэн эртний өөр өөр цаг үеийн хүмүүсийн ДНК, хоол хүнсний эх үүсвэр, оршуулгын соёл, газар ашиглалт зэрэг нуурын өмнөх суурин газрын үлдээгчдийн талаарх мэдээллийг цуглуулж, нарийвчлан судалснаар бүс нутгийн хүрээнд энэхүү дурсгалт газрын ач холбогдол, түүхэн үнэ цэнийг тодорхойлох боломж бүрдэнэ. Тэрчлэн, Баяннуурын сав нь дэлхийн хамгийн хойд бүс нутаг дахь цөлөрхөг элсэн манхантай газар нутгийн эртний анчид, түүвэрлэгчдийн ул мөрийг (соёлт давхарга) хөрсөндөө маш сайн хадгалсан газар болох нь судалгааны урьдчилсан үр дүнгээс харагдаж байна. Бид дараа дараагийн судалгааны ажлаар дээрх асуудлуудыг тодруулахыг хичээх бөгөөд 2017 онд илүү өргөн хүрээнд малтлага хийхээр төлөвлөж байна.

Зураг 1. BN001 малтлагын зүсэлт болон он цагийн дээжийн хариуг харуулсан зураг



Зураг 2. Увс нуур болон Баян нуурын усны мандлын төвшний түүхэн өөрчлөлт болон дурсгалт газрын он цагийг харьцуулсан диаграм



Зураг 3. Баян нуурын судалгааны бүс.Шар цэгээр 2015 онд, улаан цэгээр 2016 онд түүвэрлэсэн болон бүртгэсэн дурсгалыг тэмдэглэв



Зураг 4. Өгөөмөр уул болон Баян нуурын хооронд байрлах эртний булш оршуулгын дурсгалын тархалт

ХОВД ГОЛЫН ХӨНДИЙД ХИЙСЭН ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

Ч.Амартүвшин, Л.Ишцэрэн, Я.Мураками

Баруун Монголын бүс нутаг дахь эртний төмөрлөгийн түүхэнд холбогдох дурсгалын талаарх мэдээлэл цуглуулах, шинээр эх хэрэглэгдэхүүн илрүүлэн олох зорилготой энэхүү хайгуул судалгааны ажил 2016 оны 09-р сарын 18-24-ний хооронд 7 хоногийн хугацаатай үргэлжлэв. Судалгааны ангийн бүрэлдэхүүнд Монголын талаас, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, эрдэм шинжилгээний ажилтан, магистр Л.Ишцэрэн, М.Алтаншагай, Японы талаас Эхимэгийн Их сургуулийн профессор Я.Мураками нар оролцон ажиллаа.

Хайгуул судалгааны ажил Баян-Өлгий, Ховд аймгийн зарим сумдын нутгаар урсах Ховд голын хөндий орчимд явуулсан юм. Ховд гол нь манай улсын Төв Азийн урсгалгүй савд багтах хамгийн том гол бөгөөд Алтай Таван богд уулын зүүн хажуугаас эх авдаг ба нийт урт 516км. Том цутгалууд нь Цагаан гол, Согоогийн гол, Сагсай гол ажээ. Ховд гол Хоргон нуураас доош адгаа хүртэл 400км урсдаг бөгөөд уналт нь 1км-т 2м юм. Ховд голыг дээд, дунд, доод хэсэг гэж 3 хуваах үздэг байна[1].

Баян-Өлгий аймагт ажилласан тухай

Баян-Өлгий аймагт 2016 оны 09-р сарын 18-21 хүртэл хайгуул судалгааг Бугат, Ногооннуур сумдад хийлээ. Судалгааны багийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, Япон улсын Эхимэ Их сургуулийн Зүүн Азийн эртний төмрийн соёлыг судлах төвийн захирал Я.Мүраками, ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Л.Ишцэрэн, Философийн хүрээлэнгийн салбар хүрээлэнгийн Баян-Өлгий аймаг дахь ШУА-ийн Фолософийн хүрээлэнгийн харъяа Нийгэм эдийн засгийн бодлогын салбарын түүх, хэл шинжлэлийн секторын эрхлэгч Б.Өмирбек нар оролцон ажиллав.

Хайгуул судалгааг Бугат сумын нутагт орших “Бага төмөртэй”, “Их төмөртэй” хэмээх ууланд хийсэн. Тус хоёр ууланд төмрийн үйлдвэрлэлтэй холбоо бүхий ямар нэгэн эх хэрэглэгдэхүүн илрээгүй ба харин хүрэл зэвсгийн үеийн чулуун овоолгот булш, хадны зураг зэрэг археологийн дурсгалууд баялаг ажээ. Эдгээр булш оршуулга болон хадны зургийг өмнө нь тус аймгийн Нийгэм эдийн засгийн бодлогын салбарын түүх, хэл шинжлэлийн секторын судлаачид бүртгэн баримтжуулсан ажээ.

[1] *Шагдар, 1961 – Шагдар Ш. Монгол орны газар зүйн нэрийн товч тайлбар толь бичиг. Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо. УБ. тал 78-79.*

Дараачийн судалгааг Ногооннуур сумын нутагт Ховд голын хөндий дагуу Ачит нуур хүртэл хийв. Хайгуул судалгааны явцад төмрийн үйлдвэрлэлтэй холбоо бүхий ямар нэгэн эх хэрэглэгдэхүүн илэрсэнгүй.

Харин Ачит нуураас салаалан Ховд гол руу цутгах жижиг голын тохойрсон бургастай хөндийн баруун талд хадтай уулаар хүрээлэгдсэн уулын аманд гол руу шахсан тэгш дэвсэг дээр тахилын цогцолбор дурсгалыг олж бүртгэлээ. Энэхүү дурсгал нь хоорондоо ойрхон зайтай, гадуураа хавтгай чулууг хавиргалуулан зоож дөрвөлжин хашлага хийж түүний дотор гонзгой чулууг бага зэрэг зассаж хийсэн хөшөө чулуу бүхий нийт дөрвөн ширхэг босоо чулуун хөшөөтэй тахилын цогцолбор юм. Эдгээр чулуун хөшөөдийг баруун талаас нь дугаарлав (*зураг 1*).

Газар зүйн байршил нь хойд өргөргийн 49°21′42.9″ солбицол, зүүн уртрагийн 090°38′59.6″ солбицолд, далайн түвшнээс дээш 1438 м өргөгдсөн байна.

1-р хөшөө чулуу нь 180см өндөр, 50см өргөн бөгөөд 150х150см тусдаа хашлагатай ажээ.

2-р хөшөө чулуу нь 150 өндөр, 4см өргөн бөгөөд мөн 150х150см намхан хашлагатай ба өмнөх хөшөөний хашлагаас 20 орчим см зайд байна.

3 болон 4-р хөшөө чулуу нь нэг хашлага дотор байрлана. Хашлага нь 2-р тахилын байгууламжийн хашлага чулуутай залгаад 220х150см хэмжээтэй ажээ.

3-р хөшөө чулуу нь 100см өндөр, 30см өргөн байна.

4-р хөшөө чулуу нь 120см өндөр, 30см өргөн бөгөөд зүүн урагш хазайсан ажээ.

Эдгээр тахилын чулуун хөшөө дурсгалуудын ойр орчимд хайгуул хийхэд сурвалжгүй гурвалжин хэлбэрийн төмөр зэв 1 ширхэг, төмөр хутга 1 ширхэг, мөн нарийн төмөр утсаар хоёр ирмэгт нь давтан нийлүүлж хийсэн төмөр эдлэлийн хэсэг зэрэг зүйлс газарт хөсөр хэвтэж байсныг бүртгэн баримтжуулсан юм.

Мөн тахилын хөшөө чулуун байгууламжын урд талд 50 орчим метр зайд 10м голчтой 1м орчим өндөр чулуун овоолгон дараастай булш байх ба түүний зүүн талд 5м орчим зайд 5м голчтой намхан чулуун дараастай булш байх ажээ.

Эдгээр тахилын цогцолбор байгууламжууд нь Түрэгийн үеийн тахилын чулуун байгууламжтай адилсах тул он цагийн хувьд Түрэгийн үед хамааруулж болох юм.

Баян-Өлгий аймагт 2005 онд “Монгол Алтайн баруун хэсгийн түүх-археологийн дурсгалууд” сэдэвт ажлын хүрээнд нэрт археологич доктор Д.Баяраар ахлуулсан судалгааны анги Бугат сумын нутаг Хар арлын хөндий, Ховд голын эрэгт хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна. Хайгуул судалгааны явцад “дархны хяс зуухны үлдэгдэл”-ийг илрүүлэн олж бэсрэг малтлага судалгааг хийсэн байдаг[2]. Тус дурсгал нь нимгэн хавтгай чулуудыг газарт босоогоор нь суулгаж хоолой хэлбэрээр өрсөн ба тахирласан байдалтай. Нэг үзүүр нь гол руу хандсан бөгөөд энэ хэсэгт хавтангуудын дундах хэсгийг малтаж үзхэд 30 см орчим гүнээс мод шатааж байсны үлдэгдэл болох

[2] *Баяр Д., Бихумар К., Өмирбек Б. 2005 онд Баян-Өлгий аймагт ажилласан хээрийн шинжилгээний ажлын товч үр дүн. // Алтай судлал// УБ., 2005. тал 108-11.*

модны нүүрс үнс гарав. Тэнд байсан хавтангууд нь галд хайрагдаж нүүрс ис болсон байдалтай байв[3].

Манай судалгааны багийнхан тус дархны хяс зуухны үлдэгдэлд малтлага хийсэн дурсгалыг нэхэн үзэж ямар хэлбэрийн дархны хяс зуух байсан (?), хэр хэмжээний талбайд тархаж байсан талаар нарийвчлан судлах зорилготой хайгуул судалгааг хийсэн юм. Харамсалтай Д.Баяр гуайн малтлага хийсэн дурсгалыг олж чадсангүй. Тус дурсгал нь Ховд гол руу шахсан эргийн дагуу байсан хэмээх тодорхойлолтоос үзвэл голын үерт автан үгүй болсон байх магадлалтай хэмээн таамаглав.

Баян-Өлгий аймагт хийсэн хайгуул судалгаагаар бидний сонирхон бүхий төмрийн үйлдвэрлэлийн ул мөр харамсалтай нь илэрсэнгүй. Ирэх жилийн хайгуул судалгааг угсаатны зүйн судалгаа болон нутгийн иргэдийн аман мэдээний дагуу шалгаж тодруулах нь зүйтэй хэмээн үзэж тус аймгийн нутагт хийсэн хайгуул судалгааг дуусгав.

Ховд аймагт ажилласан тухай

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт 2016 оны 9-р сарын 22-25 хүртэл ховд голын сав хөндий дагуу хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Судалгааны багийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, дэд профессор Ч.Амартүвшин, Япон улсын Эхимэ Их сургуулийн Зүүн азийн эртний төмрийн соёлыг судлах төвийн захирал Я.Мүраками, ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Л.Ишцэрэн, М.Алтаншагай нар оролцон ажиллав.

Хайгуул судалгааг Эрдэнэбүрэн сумын нутгаар дайрч өнгөрөх Ховд гол болон түүнд цутгах Улиастай гол, Сүлжээ голуудын сав хөндийд хийлээ.

Эдгээр голуудын баруун гар талд голын элсэн мөргөцгүүдийг ухаж хийсэн нэгэн зүйл зуухыг нутгийнхан "Ааюу" хэмээн нэрлэдэг бөгөөд дотор тал нь өндөр хэмд халж ямар нэг зүйл шатааж байснаас үүдэн хөө тортог болсон нэг төрлийн зуухны үлдэгдлүүд байна. Эдгээр зуухнуудын дотор тал нь 50-150 см хүртэл өндөр бөгөөд таазны хэсгээс дээш 10-30 см хүртэл голч бүхий яндангийн нүх ухаж утааг гаргадаг байсан ажээ.

Нутгийн хүмүүс "Ааюу" хэмээн нэрлэх тус зуухнууд "Бааюу" гэдэг үгийг нутгийн аялгуунд оруулсан хувилбар ажээ. "Бааюу" гэдэг нь "Тоосго, туйпуу: бааюу шатаах (тоосго шатаах)"[4] гэсэн үг бөгөөд нутгийн ардын аман домгоор Галдан хааны үед холбон үздэг ажээ.

Мөн доктор Т.Дисан агсан "1987 онд Улаанбаатар хотод амьдарч буй Ховдын харьяат өөлд ястны дунд ажилласан угсаатан зүйн тайлан, эх хэрэглэгдэхүүн"-нд ... Дээр үед эмгэлжийн хажуугаар нүүрс хийж төмөр ширгээдэг байсан. Энэ мод хатуу,

---

[3] *Баяр Д., Бихумар К., Өмирбек Б. Бугат, Алтанцөгц, Ногооннуур, Сагсай, Улаанхус сумдын нутагт ажилласан хээрийн шинжилгээний ангийн тайлан. – МАСХ-ийн гар бичмэлийн сан. "Монгол Алтайн баруун хэсгийн түүх, археологийн дурсгалууд" төсөл. УБ.,2005.*

[4] *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбайр толь. УБ, 2008.*

тортог гардаггүй гэдэг. Уг нь хусны нүүрс сайн гэдэг. Манай энд хус байхгүй учир тэр нүүрсээ бэлдэхдээ: галд эмгэлжийнхээ үндсийг шатаана. Тэгээд дутуу дөлтэй байх үед нь усанд хийнэ. Тэгэхдээ бөөрөөр нь шатаахгүй. Хэрэв бөөрөөр шатаавал бүгд тортог болоод алга болох жишээтэй. Усанд хийснээ хатаана. Үүнээс өөрийн хэрэгцээгээр авч хэрэглэнэ. Нэг атга хэрий нүүрсээр 3, 4 цоож хийнэ. Нэг цогшсон үед их хэрэглэнэ. Урд нүүрсийг бүүр шуудайгаар бэлтгэж авдаг байсан. Эмгэлжийн нойтныг (хожуулыг) авч байгаагүй. Дагнан өгөршсөн хожуулыг эрж олж байсан[5].

Мөн тэрээр өөрийн тайландаа "... Манайд Ховдын амбаны алба их байсан. Энэ нь нүүрсний алба, эмгэлжний алба, түлшний алба юм. Үүнийг голдуу хэдхэн багууд хийж байсан. Нүүрсний албыг Шижигт багийхан хийж шатаасан нүүрсийг наана нь байдаг. Битүү эрэг, Бураа багийнхан үхрийн ширээр ширлэсэн арганд хийж тэмээнд ачиж энд авчирна. Үүнийгээ нүүрсний араг, эмгэлжний алба гэдэг нутгийн ардаас алба гаргана. Хуучин Бура багийнхан хийж байсан. Тарагтай Их эмгэлжтэй, тэндээс эмгэлжний хожуулыг түүж авчирна. Албыг жингээр ноогдуулж байсан. Эмгэлжийг түүхэнд хэцүү төвөгтэй байна. Эмгэлжийг түлшинд хэрэглэхэд маш их илчтэй, илчийн хувьд загаас илүү заг шиг хортой халахгүй. Угааргүй, цаг нь чандар болсоор байгаад дуусна, үнс гэж ер байхгүй. Ялангуяа их түлэхэд их сайн даарахын зовлонгүй байна. Эмгэлж Тарагтайн хавцал, Цамбагаравын өвөр, Мянгадын Хөхийн Алтанд ургана. Эмгэлж их хатуу учир түлш төдийгүй хорол шатар, цацал зэргийг нойтон дээр нь сийлнэ. Хатсан хойноо хүчрэхгүй. Хятадууд нойтон хожуулын аваад хэдэн жил эл хатаана. Түүнээсээ түлнэ"[6] хэмээн дурдсан байна.

Манай судалгааны багийнхан тус "Бааюу" хэмээх зуух нь тоосго шатаах зориулалттай бус, модны нүүрс шатаах зориулалттай хэмээн таамаглав. Зуухны дотор талын хананд 10-20 см хүртэл зузаан хөө тортогтой, зуухны амсар хэсэгт голын мөлгөр том чулууд овоорсон, мөн яндангийн нүхийг мөн том чулуугаар тагласан зэргээс үүдэн дээрх таамаглалыг дэвшүүлсэн юм.

Модны нүүрс шатаах зуухны онцлог нь нүүрс хийх модыг жижиглэн нэг хэмжээтэй болгоод зууханд өрөөд цогшиж улайстал нь шатааж 400-500° хэмд хүрхтэй нь зэрэг зуухны үүд болон яндang битүүлдэг байна. Ингэснээр модны нүүрс нь хагас шатаж битүү орчинд улайсаж цогшсон модонд нүүрстөрөгч орсноор хатуурч модны нүүрс болдог ажээ.

Бидний илрүүлэн олсон эдгээр зуухнууд нь дээрх модны нүүрс шатаах зуухтай ижил бөгөөд зуухны бүтэц зохион байгуулалт ч мөн таарч байна хэмээн үзсэн юм.

Төмрийн үйлдвэрлэлийн арга ажиллагаа нь дараах хэдэн дараалаар явуулдаг ажээ. Үүнд, Төмрийн хүдрийн орд газраас төмрийн хүдрийг ухаж аван үйлдвэрийн газарт авчирсны дараа модны нүүрсийг тусгай зориулалтын зууханд бэлтгээд, төмрийн хүдрийг хайлуулах зуухыг шавраар барина. Ийнхүү бэлтгэсэн модны нүүрс

---

[5] *Т.Дисан. 1987 онд Улаанбаатар хотод амьдарч буй Ховдын харъяат өөлд ястны дунд ажилласан угсаатан зүйн тайлан, эх хэрэглэгдэхүүн //Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн. IX. УБ., 2011. Тал 276.*

[6] *Т.Дисан. 1987 онд Улаанбаатар хотод амьдарч буй Ховдын харъяат өөлд ястны дунд ажилласан угсаатан зүйн тайлан, эх хэрэглэгдэхүүн //Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн. IX. УБ., 2011. Тал 314.*

болон төмрийн хүдрийг үелүүлэн төмрийн хүдэр хайлуулах зууханд хийж 1350° хэмд хүртэл шатааж хайлуулдаг байна.

Бид эдгээр дурсгалыг модны нүүрс шатаах зуух хэмээн тодорхойлсны үндсэн дээр Ховд голын эрэг дагуу төмрийн үйлдвэрлэл эрхэлж байсан газар ойрхон байна хэмээн үзэж хайгуул судалгааг үргэлжлүүлэн хийсэн билээ. Нутгийн хүмүүсийн аман мэдээнд тулгуурлан "Төмрийн баасан" хэмээх Ховд голын баруун эрэгт голын олон салаа урсаж одоо усгүй болсон бут, бургас ихтэй хүрээлэгдсэн сайрт төмрийн хаягдал шлактай газрыг олсон юм. Харамсалтай нь Ховд гол ихээр үеэрлэхэд эдгээр салаанууд усаар дүүрдэг учир тус төмрийн шлак олдсон газарт зуухны үлдэгдэл олдсонгүй. Харин төмрийн хүдрийг боловсруулах явцад гардаг хаягдал шлак болон зуухны ханын жижиг хэсгүүдийг олсон нь тухайн газарт төмрийн үйлдвэрлэл явуулж байсны баримт хэмээн үзэж болохоор ажээ (*Зураг 4*).

Хүснэгт 1: Шинээр илрүүлэн олсон дурсаглуудын мэдээлэл

№	Дурсгалын дугаар	Солбицол	ДТД өндөр
1	Тохойн улиасан-1	N48 37 30.4 E91 22 31.5	1222 m
2	Тохойн улиасан-2	N48 37 29.7 E91 22 22.3	1235 m
3	Тохойн улиасан-3	N48 37 37.8 E91 21 53.6	1240 m
4	Тохойн улиасан-4	N48 37 38.2 E91 21 53.1	1226 m
5	Тохойн улиасан-5	N48 37 38.2 E91 21 53.1	1226 m
6	Тохойн улиасан-6	N48 37 38.3 E91 21 53.0	1223 m
7	Хавцалын амны эх-1	N48 37 54.3 E91 21 29.0	1229 m
8	Хавцалын амны эх-2	N48 37 54.5 E91 21 29.2	1231 m
9	Хавцалын амны эх-3	N48 37 58.8 E91 21 15.1	1229 m
10	Хустын булаг-1	N48 40 36.1 E91 20 08.5	1269 m
11	Хустын булаг-2	N48 40 36.8 E91 20 08.6	1285 m
12	Хустын булаг-3	N48 40 36.4 E91 20 08.5	1276 m
13	Улиастайн гол-1	N48 36 35.8 E91 15 17.1	1392 m
14	Улиастайн гол-2	N48 36 35.9 E91 15 17.4	1387 m
15	Улиастайн гол-3	N48 36 35.0 E91 15 19.2	1386 m
16	Улиастайн гол-4	N48 36 27.9 E91 15 30.1	1373 m
17	Улиастайн гол-5	N48 36 27.7 E91 15 30.0	1376 m
18	Улиастайн гол-a	N48 36 35.1 E91 15 19.6	1386 m
19	Улиастайн гол-b	N48 36 35.7 E91 15 18.1	1389 m
20	Улиастайн гол-c	N48 36 38.9 E91 15 08.7	1393 m
21	Сүлжээ гол-1	N48 36 04.0 E91 14 16.0	1433 m
22	Төмрийн баасан	N48 37 14.0 E91 29 15.3	1207 m
23	Тахилын хөшөө чулуун байгууламж, булш	N49 21 42.9″ E090 38 59.6	1438 m

Энэ удаагийн хайгуул судалгааны үр дүнд Баян-Өлгий аймгийн нутаг Ногооннуур сумаас Түрэгийн үед холбогдох тахилын цогцолбор дурсгал нэг, булш оршуулгын хоёрыг тус тус бүртгэн баримтжуулав.

Ховд аймагт хийсэн судалгаагаар модны нүүрс шатаах зуух 21, төмрийн хаягдал шлак бүхий газар 1, чулуун байгууламж 2-ийг тус тус шинээр бүртгэв. Эдгээрээс төмрийн үйлдвэрлэлийн нэгэн чухал хэсэг болох модны нүүрс шатаах зуухыг Монгол орноос анх удаа илрүүлэн олсон нь томоохон үр дүн боллоо. Эдгээр зуухнаас авсан модны нүүрснээс авсан дээжийг Япон улсад илгээж үнэмлэхүй он цагийг тогтоолгов.

Энэхүү үнэмлэхүй он цагийн мэдээлэл харьцангуй өндөр хэлбэлзэлтэй байгааг дээрх хүснэгтээс харагдана. Гэхдээ ямартай ч 2 сигма бүхий хүснэгтийн хамгийн өндөр магадлалтай он цагаар Хустын булагийн 1-р зуух нь НТ 1805-1895 он, Тохойн улиасангийн 2-р зуух нь НТ 1798-1887 он хэмээн гарч байна.

Хустын булагийн зуух нь Эрдэнэбүрэн сумаас баруун хойш 20 орчим км зайтай орших Хавцалын аманд Хустын булаг хэмээх цөөн тоотой хусан төгөл бүхий нэгэн булагийн дээхнэ Ховд голын цавчим эргийг ухаж хийсэн байна. Харин он цаг тогтоох шинжилгээнд хамрагдсан зуухыг ухахдаа хөрс гэхээр зүйлгүй хад асгыг доош ташуу маягтай ухсан байв. Ухах явцад тээг болж байсан бололтой нэг улиасыг хөрөөдөж зайлуулсан ул мөр байгаа нь он цагийн хувьд нилээд хожуу болохыг мөн батлаж байна.

Харин Тохойн улиасангийн 2-р зуух буюу НТ 1798-1887 онд хамаарч буй энэхүү дурсгал нь мөн Ховд голд шахсан эргийг ухаж хийсэн. Гэхдээ Хустын булагийн зуухыг бодвол хэлбэрийн хувьд харьцангуй өөр, хэмжээний хувьд арай жижиг, газарзүйн байршлын хувьд ч гэсэн ялгамжтай юм.

Эдгээр зуухнуудыг лабораторийн он цагт дулдуйдан хугацааг баримжаалбал Зүүнгарын хаант улс доройтон мөхөж Манжийн эрхшээлд орсон үеэс XIX зууны сүүл үед буюу 90 орчим жилийг хамаарахаар байна. Энэ үе нь Баруун Монголчуудын хувьд аж ахуй, нийгмийн салбар бүрэн уналтанд орж доройтсон цаг хугацаа бөгөөд нэг голын савд ижил хэлбэр хэмжээтэй олон тооны зуухнуудыг барьж байгуулах боломж байгаагүй болов уу хэмээн санана. Гэхдээ дээр дурдсан Ховдын амбаны нүүрсний, эмгэлжний, түлшний алба[7] гэсэн гурван албаны талаар мэдээг анзаарахгүй орхиж болохгүй юм. Магадгүй өөлдүүд амбаны албанд эмгэлжээр нүүрс бэлдэн өгч байсан байж болох юм. Гэвч нутгийн түүхч Н.Намсрай "Өөлдийн соёл, түүхийн бичиг оршивой" (УБ.,1999) бүтээлдээ "Өөлд дархчуудын хийдэг төмөр эдлэл нь гэр зуурын ба хүмүүсийн хэрэгцээний зүйл байжээ ... Дархан хүмүүст материал багаж зэвсэг ховор олддог ... Ер нь модон ба төмрийн үйлдвэрлэл хийхэд дархан мужаан заах хүн ховор, үзэж харах зүйл маш бага байжээ .."[8] хэмээн бичсэн байгаа нь түүний мэдэлд

[7] Т.Дисан. онд Улаанбаатар хотод амьдарч буй Ховдын харъяат өөлд ястны дунд ажилласан угсаатан зүйн тайлан, эх хэрэглэгдэхүүн //Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн. IX. УБ., 2011. Тал 314.
[8] Намсрай Н. Өөлдийн соёл, түүхийн бичиг оршивой. УБ., 1999. Тал 46.

амбаны албаны тухай мэдээ байсангүй юу, эсвэл өмнөх мэдээг нягтлах шаардлагатай юу гэдэг асуулт хэвээр үлдэв.

Харин бидний санахад эдгээр зуухны хэлбэр хэмжээ, цар хүрээ, бусад дурсгалтай харилцан хамаарал зэргээс үзвэл Галдан бошигтын 1685 онд Ховд голын эрэгт анх үүсгэн байгуулсан хоттой нэг он цагтай нэг баймаар байгаа юм. Нэрт түүхч Ч.Далай “Ойрад Монголын түүх” (2006) бүтээлдээ “Галдангийн байгуулсан суурин газруудаас бидний үед уламжлагдан ирсэн нь Ховд, Улаангом, Гулз, Хайнаг хотууд юм. Галдан 1695 он хүртэл Ховд нутагт байрлаж, цэргийн гол хүчээ Үенч, Бодончийн хавцалд байрлуулан суурьшуулж, хамгаалах цэргээ Цамбагарав уулын хавьд байлгаж байв. Цамбагарав уулаа өөрийн шүтээн болгож тахина. Галдан 1685 оны орчим Ховд голын хөвөөнд анх Ховд хотыг барьж байгуулсан билээ. Тэрхүү үзэсгэлэнт жижиг хот Манжийн түрэмгийллийг эсэргүүцсэн тулалдааны үед ихэд эвдрэн сүйдэж, сүүлдээ үлдсэн хэсэг нь усны үерт нурж эвдэрсэн бололтой. Ховд хотын хуучин туурь нь эдүгээ Эрдэнэбүрэн сумын нутаг дахь Онгоцны улаан гэж нэрлэдэг уулын хойт тал, Урд Согоот уулын зүүн хойт зүгт Ховд голын хөвөөний Улаан харгана хэмээх газар байдаг. Галдангийн үүсгэсэн Ховдын хуучин бэхлэлтийг 1762 онд Буянт голын хөвөөнд нүүлгэн байгуулсан бөгөөд тэр нь одоогийн Ховд хот юм”[9] хэмээн тодорхой бичжээ. Мөн тэрээр цаашлаад “... Галдангийн үед хот суурин, хаадын орд өргөөг барихад мэргэжлийн урчууд, алт, мөнгө, зэсийн дархчууд, чулуучид ажилладаг байжээ. Гар урлалын дотроос цэргийн зэр зэвсэг үйлдвэрлэх салбарыг арай түлхүү хөгжүүлж байсан байна. Ер нь Ойрадууд галт зэвсгийг тун сайн хийдэг байсан бөгөөд тийм чухал үйлдвэрлэлд Зүүнгарын хаад ч их анхаардаг байсан тухай сурвалжид олонтаа тэмдэглэсэн байдаг. Зэр зэвсгээ өөрсдөө хийж байсан тухай Лянь Фэньгийн 1691 онд бичсэн “Цин улсын хязгаарын товч тэмдэглэл” гэдэг номонд тодорхой бичсэн байдаг” хэмээжээ.

Мөн зарим судлаачид Зүүнгарын хаант улсад үйлдвэрлэлийн нилээд өргөн цар хүрээтэй хөгжүүлж байсан бөгөөд Ховд хотын хуучин сууриас хойшоо, Ховд голын баруун хөвөөнөө Төмрийн баасан гэж нэртэй газар бий. Тэр газар битүү бургасан дунд байдаг. Төмрийн баасан хэмээх тэрхүү газар нүүрс түлээд, ширэм хайлуулж зэр зэвсэг, мөн тарианы анжис зэргийг хийж байжээ. Өөрөөр хэлбэл, Зүүнгарын нэгэн чухал төмрийн үйлдвэр тэнд байсан байна. Одоо ч тэр газраас үнс, ширэмний хайлшны үлдэц, төмрийн шаар баас олддог[10] тухай бичсэн байдаг бол “... тэр үйлдвэрийг нутгийн настайчууд Галдангийн үеэс улбаатай гэж ярьдаг. Хожим нь түүнийг үе үеийн дархчуул мэр сэр ашиглан тариалангийн багаж зэвсэг хийдэг байсан гэж хуучилдаг[11] тухай өөр судлаачид дэлгэрүүлэн авч үзсэн байдаг.

---

[9] *Далай Ч. Ойрад Монголын түүх. //Bibliotheca Oiratica. III. Тэргүүн боть, Хоёрдахь хэвлэл. Редактор А.Очир, Ц.Гантулга. УБ.,2006. Тал 112.*

[10] *Цолмон С. Хээрийн шинжилгээний тайлан. УБ.,1989. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн номын сан.*

[11] *Бат-Отгон Б., Цэндээ Б. Галдан бошигт хаантай холбоотой биет дурсгалууд //Галдан бошигт судлал (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл). УБ.,2015. Тал 55.*

Нэрт түүхч Ч.Далай дээрх зохиолдоо өөр нэгэн сонирхолтой баримтыг өгүүлсэн байдаг. Тэрээр “Тэрхүү Төмрийн баасан хэмээх газраас баруун тийш 3-4 км-т Өндөр дов хэмээх шороон дов байдаг. Тэр том шороон довоос бас төмөр хайлуулж байсныг гэрчлэх төмрийн шаар элбэг олддог”[12] хэмээн дурджээ. Мөн тэрээр “... Үүнээс гадна Галдан хаан тэр үед Ховд болон бусад газар зэвсгийн гар үйлдвэрүүд байж тэдгээрийн заримд нь 1000 шахам гар үйлдвэрлэгчид ажиллаж байсан тухай мэдээ сэлт сурвалж бичигт гарч байна” гэж бичсэн нь бий.

Галдангийн анхны Ховд хотыг археологийн талаас судлан шинжлэх ажлыг сүүлийн жилүүдэд хийж эхэлсэн бөгөөд судлаачид тухай туурийн хэрмийн хэмжээ нь 1558 м, 1676 м, 1764 м, 1735 м тус тус бөгөөд “далавч”-ны урт 80 м, 56 м, 45 м, 65 м тус тус болохыг тодорхойлон бичээд тэд зарим сорилтын малтлага хийхэд хятад шаазангийн хагархай, малын яс зэрэг зүйл гарсан тухай өгүүлсэн байдаг. Мөн тэдгээр судлаачид малтлагаас гарсан малын ясанд радиокарбоны он цагийг тогтоолгоход Монголын түүхийн дундад хожуу үе болон XVIII зууны сүүл үед холбогдоно[13] хэмээн бичжээ.

Бидний илрүүлэн олсон Тохойн улиасан, Хавцалын амны эх, Хустын булаг, Улиастайн гол, Сүлжээ гол гэсэн 5 газарт буй 21 зуух нь 247 км^2 талбайд буюу хоорондоо дунджаар 5-9 км зайтай Ховд гол, түүнд цутгах жижиг голын эрэгт байрлаж байна. Ийнхүү харьцангуй бага талбайд хоорондоо ойрхон зайтай олон тооны эдгээр зуухнууд нь магадгүй тухайн үед зохион байгуулалттайгаар томоохон бүтээл байгуулалт эсвэл цэрэг дайны бэлтгэл ажилд зориулагдсан байж болох юм.

Зүүнгарын хаант улс 1678 онд байгуулагдаж түүнээс 7 жилийн дараа буюу 1685 онд Ховд хотыг анх байгуулсан байна. Үүнээс 3 жилийн дараа 1688 онд Галдан Халхын нутагт довтлох 4 жил үргэлжилсэн томоохон дайнаа эхлүүлсэн байна. Үнэхээр түүхэн үйл явцтай харгалдуулан үзвэл бидний олсон эдгээр зуухнууд нь Галдангийн Халхад хийх дайны бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн зүйл байж болох талтай. Яагаад лабораторийн он цагийг үгүйсгэх болсон доорхи хэдэн шалтгаан байна. Үүнд, нэгдүгээрт, он цагийн мэдээний алдаа хэтэрхий өндөр, хоёрдугаарт, тухайн зуухнуудад хожим нутгийн иргэд ахуйн хэрэгцээний зүйлээ хадгалж байсан тухай мэдээ тааралдаж байна, гуравдугаарт, тухайн зуухнуудаас авсан он цагийн дээжний контекст хангалттай бус зэрэг хэд хэдэн шалтгааныг дурдаж болно. Дараагийн ахисан түвшингийн судалгаагаар илүү найдвартай контексттэй дээжинд лабораторийн он цаг тогтоолбол магадгүй бидний хүсэж буй үр дүн гарахыг үгүйсгэх аргагүй юм.

Галдангаас хойших Зүүнгарын хаант улсын хаадууд төмөрлөг боловсруулах тал дээр олон зүйлийг санаачилж, хийж байсныг түүхэн сурвалж мэдээнээс мэдэж болно. Үүний нэгэн жишээ бол, Цэвээнравдан хааны үед (1694-1727 он) хаант улсын аж ахуйн хэрэгцээг үндэслэж, Хойд аймгийн хүмүүсийг Урад отог хэмээн зохион байгуулав.

[12] *Далай Ч. Ойрад Монголын түүх. //Bibliotheca Oiratica. III. Тэргүүн боть, Хоёрдахь хэвлэл. Редактор А.Очир, Ц.Гантулга. УБ.,2006. Тал 113-114.*

[13] *Мөнхбаяр Ч. Ховд хотын хуучин туурийн судалгааны байдал. //Галдан бошигт судлал (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл) УБ.,2015. Тал 113.*

Урад отгийн нэгэн бүлэг хүмүүс нь Баянбулгийн тал газар даган мал аж ахуйг оролдож, бас нэгэн бүлэг хүмүүс нь уурхай малтаж, төмөр зэс, гууль, мөнгө, хөнгөн цагаан, хүхэрийг хайлуулан боловсруулж байсан. Уурхай малтаж хүдэр хайлуулах ажилд цөөндөө таван зуун хүн, хамаг олондоо гурван мянган хүн оролцож байжээ. Тэд нар Орос цэргээс олзолж авсан мэргэжилтний боловсруулсан төмөр, зэс, гууль, мөнгөөр жад, сэлэм, хуяг, дуулга, буу цутган үйлдвэрлэж чадсан. Урад отгийн хүмүүс бас бүдүүн буу цутгаж буу (бүдүүн буу)-г хэдэн арваар цутгаж, тус буундаа хэрэглэх сумыг бас (их, бага адилгүй) түм шахам үйлдэж гаргав. Энэ буугаа хөгшин Мамудын удирдах Захчин отогт тохируулан, Зүүнгарын Буучин хэмээн нэрийдэж байсан. Умард замын Хотон нуурын дайнд морь тэмээгээр чирүүлж аваачсан их буу нь маш их үйлдэл үзүүлжээ[14].

Мөн Зүүнгарын Галданцэрэн хааны үед (1727-1745 он) Илийн ар талын Цагаан ус хавиар нутаглах Алтчин отог нь хаант улсын доторх бүх үйлдвэрлэлийн ажлыг хариуцана. Тухайлбал, төмөр, зэс, гууль боловсруулах, төмөр хайлуулан зэр зэвсэг хийхээс гадна өдөр тутмын амьдралд хэрэглэгдэ багаж, сав, суулга, хүрз, савар мэт зүйлийг хийдэг[15] байсан байна.

Эцэст нь лабораторийн он цагийн мэдээ болон түүхэн баримт сэлтэнд тулгуурлан доорхи байдлаар төсөөлж болохоор байна. 1685 онд Ховд голын эрэгт баригдсан Ховд хотын бүтээн босголт болон Галдангийн Халх руу хийсэн дайны үйл явцтай уялдан эмгэлж шатаан нүүрс гаргах дээрх зуухнуудыг анх хийж байгаад хожим энэхүү уламжилд тулгуурлан хуучны зуухыг нутгийнхан Манжийн амбаны газраас нүүрсний албыг залгуулахад ашиглаж байсан бололтой.

Мөн нүүрс боловсруулах зуухны төвлөрөл бүхий газраас Төмрийн баасан хэмээх төмрийн шлакны үлдэгдэлтэй газар нь 8-15 км орчим зайтай Ховд голын улиасан төгөл дотор байх бөгөөд мөн түүхч Н.Намсрайн бичснээр тус сумын нутагт төмрийн хүдэр[16] бий гэсэн мэдээлэл зэргээс үзэхэд энэ газарт түүхий эд, ашиглагдах материал зэрэг нь цөм бүрдсэн төмөрлөг боловсруулах бүрэн боломжтой мэт харагдана.

Цаашид хамтарсан судалгааны багийнхан тус сумын нутаг, тодруулбал Ховд голын хөндийд буй зуухнуудыг малтан шинжилж, он цагийг тодорхой гаргах, зорилтот нарийвчилсан хайгуулын ажлыг зохион байгуулах, орон нутгийн иргэдээс сэдэвт хамааргдах аман мэдээ цуглуулах зэрэг олон ажил хийхээр төлөвлөж байна.

Одоогоор сэдэвт хамааргдаж болзошгүй болон эртний түүхийн дурсгалын талаарх газар усны нэр бидэнд багагүй цуглараад байна. Жишээлбэл, тус сумын 1-р багийн нутагт буюу усны тал Хүүр, Аюу тохой, Тохой улиасан, Төмрийн баасан, Яст, Довоос дээш улиастын голын дагуу Түлэнхий завсар (89), Улаан богочийн Хөшөө, Улаан бэлийн Хөшөөтэй бууц, Буурын амны хүн оршуулдаг (90), Баянзуслангийн Шар зуух, Ямаан үхдэгийн адарганы Шовгор чулуун, Тариалангаас дээш Өвдөгийн ба

---

[14] *Намсрай. Зүүнгар хаант улсын түүх. //Bibliotheca Oiratica. XLIV. УБ.,2015. Тал 128.*
[15] *Мөн тэнд. Тал 209.*
[16] *Мөн тэнд. Тал 84.*

Хусны голын баруун талын Аюу тохой, Хөх зуух, Тариалангаас дээш Өвдөгийн ба Хусны голын зүүн тал, Цагаан гол, Гангын эхийн Хөшөө хавцал, Шивээн ам (93) Сүм чулуун (94), Бяцхан хагийн хөтлөөс дээш Хөшөө (95), Гараацатын адарганы Ухмал бууц (95), Жангуутын харын Зост, Саагиур, хуурай, салаа, шүүтийн Булшит (95), Цахирын хөндийн Бунхат цахир (98), 3-р багийн нутагт Хавчигийн амнаас өөд усны баруун талд Баюун цагаан дэрс (Манжийн захиргаанд байхад эмгэлжийн хожуул түлж нүүрс бэлтгэдэг баюу байжээ) (108), Адаг үзүүрээс Хавчигийн ам хүртэл гол дагуу буюу Бунханы үүдэн[17] гэх зэргийг нэрлэж болно.

Энэ удаагийн хайгуул судалгааны ажилд гүн туслалцаа үзүүлсэн Баян-Өлгий аймаг дахь ШУА-ийн Философийн хүрээлэнгийн харъяа Нийгэм эдийн засгийн бодлогын салбарын түүх, хэл шинжлэлийн секторын эрхлэгч Б.Өмирбек, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын ЗДТГ-ын дарга М.Баянжаргал, тус сумын Баянгол багийн иргэн Ц.Баатаржав, А.Энхтайван, Х.Эрдэнэчулуун нарт гүн талархснаа илэрхийлье.



Хустын булагийн 1-р зуухны дэвсгэр болон зүсэлтийн зураг

[17] *Намсрай Н. Өөлдийн соёл, түүхийн бичиг оршивой. УБ., 1999.*



Тохойн улиасан 2-р зуухны дэвсгэр болон зүсэлтийн зураг



Тохойн улиасан 4-р зуухны дэвсгэр болон зүсэлтийн зураг

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВӨӨС 2016 ОНД ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТАЛААР ЯВУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Г.Энхбат, Г.Анхсанаа, Б.Алтансүх

БСШУСЯ-ны харьяа Соёлын өвийн төв нь үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд 2016 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх заалтыг хэрэгжүүлэх үүднээс түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллого: Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу ССАЖ-ын (хуучин нэрээр) Сайдын 2014 оны А/63 тоот тушаал, БСШУ-ны (хуучин нэрээр) Сайдын 2015 оны А/108 тоот тушаалаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогыг орон даяар 2015-2016 ондорон нутгийн засаг захиргаатай хамтран зохион явууллаа.



Зураг 1. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогод хамрагдсан дурсгалын тоо, хувь хэмжээ

Орон нутагт уг тооллогын ажлыг гүйцэтгэх хүмүүст ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, ШУТИС-ийн эрдэмтэн судлаачидтай хамтран сургалт, семинар зохион байгуулж, цахим бүртгэлийн гарын авлагаар[1] хангасан болно. Мөн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаа болон ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Геологи, Палеонтологийн хүрээлэнгүүдэд бүртгэлтэй дурсгалуудын мэдээллийг аймгуудын тооллогын салбар комисс хүргүүлэн мэдээллээр хангаж ажиллаа. Нийт түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг 8 ерөнхий төрөл, 99 зүйлд ангилан бүртгэв.

Энэ хугацаанд ажлын хэсгээс Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг болон Хэнтий, Төв, Баян-Өлгий, Хөвсгөл, Баянхонгор, Өмнөговь, Увс, Говь-Алтай зэрэг аймгийн 12 сумдад очиж тооллогын явцтай танилцан, заавар зөвлөмж өгч ажилласан ба тооллогын явцын дүн мэдээг 2015 оны 7 ба 9 дүгээр сард, 2016 оны 8 дугаар сард (Сэлэнгэ), 12 дугаар сард (Ховд, Увс) аймгуудаас хүлээн авч нэгтгэв.

[1] *Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг тооллогын бүртгэлийн RICH 3.0 програмын гарын авлага. Эмхэтгэж боловсоруулсан Б.Алтансүх, Г.Анхсанаа, Б.Эрдэнэцогт. Ред: Г.Энхбат. УБ., 2014*

2016 онд үзлэг тооллогоор түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар, дурсгал бүрд бүртгэлийн дугаар өгч[2], UTM тусгагийг[3] хэрэглэн газар зүйн байршлыг тодорхойлж, хэмжээ тоо ширхгийг тоолж бүртгэн, гэрэл зургаар баримтжуулж, хамгаалалтын бүсийг тогтоох зорилгоор хамрах хүрээг тодорхойлон, сэргээн засварлах шаардлагатай болон хамгаалалтын ангилалд нэмэлт өөрчлөлт оруулах санал, байгалийн болон нийгмийн сөрөг хүчин зүйлсийн нөлөөллийн судалгаа гаргаж, тооллогын бүртгэлийг цахимд шилжүүлэх ажлууд хийгдэжнийт нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумын нутаг дахь 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг хамруулаа (Зураг 1).

Ажлын хэсгийн календарчилсан төлөвлөгөөнд үзлэг, тооллогын тайлан мэдээг 2015 оны 9 дүгээр сард хүлээн авахаар тусгагдсан боловч зарим аймгуудад хээрийн бүртгэлийн ажил оройтож эхэлсэн, бүртгэлийг програм хангамжид шилжүүлэх ажил удааширсан зэрэг шалтгаанаар тайланг 2016 оны 12 дугаар сард бүрэн ирүүлж дуусган, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд нэгтгэсэн байна. Энэ удаагийн үзлэг, тооллогын үр дүнгээр улсын хэмжээнд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтын талаар нэгдсэн бодлого боловсруулах боломж бүрдсэн бөгөөд орон нутгийн удирдлага, ард иргэд өөрийн нутаг орондоо орших дурсгалын талаар мэдлэг, мэдээлэлтэй болж, бүртгэл хийж авснаараа онцлог ажил болсон юм.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нөлөөллийн судалгаа: Монгол нутагт оршиж байгаа түүхэн тодорхой цаг үеийг төлөөлж чадах байгаль дээр хээр хөдөө ил задгай орших хүний оюун ухаан, гараар бүтээгдсэн эртний чулуун зэвсгийн бууц, булш оршуулга, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, эртний хотын туурь, барилга архитектур зэрэг нь олон улсын соёлын өвийг хамгаалах конвенц, Монгол Улсын соёлын өвийг хамгаалах хууль, эрх зүйн бичиг баримтад түүх, соёлын үл хөдлөх дурсгал гэсэн ангилалд хамааран хэрэглэгдэж иржээ.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь өнөөдрийн нөхцөл байдалд, уул уурхай, дэд бүтэц, хотжилт суурьшлын бүс, суурин болон нүүдлийн соёл иргэншлийн хөгжил, дайн, тулаан зэрэг олон талын учирч болох нийгмийн болоод байгалийн эерэг ба сөрөг хүчин зүйлийн нөлөөнд газрын хөрсөн дээр хийгээд доор хадгалагдаж байдаг онцлогтой. Энэ бүхэнтэй уялдан газрын харилцааны асуудал бүхий л салбарт хөндөгдөж байгаа энэ цаг үед газар зүйн мэдээллийн системийн тусламжтайгаар археологийн дурсгалын байршил, тухайн дурсгалыг хадгалж хамгаалах, бусад салбаруудтай уялдуулан төлөвлөх асуудал онцгой ихээр тавигдах болсон байна. Гэвч өнөөдрийн байдлаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамаарах олон төрөл зүйлийн дурсгалыг бүртгэлжүүлэх, газар зүйн мэдээллийн системтэй холбох, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, судалгааны байгууллагуудын мэдээллийн сангийн сүлжээ,

[2] *Дурсгалт газарт 10 оронтой, дурсгалд 12 оронтой дугаар өгсөн бөгөөд 1-2 орон аймгийн код, 3-4 орон сумын код, 5-8 орон суман дахь дурсгалт газрын дэс дугаар, 9 орон төрөл зүйлийн ерөнхий ангилал, 10-12 орон тухайн дурсгал доторх нэгж дурсгалын дэс дугаар байна.*

[3] *Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоол*

харилцаа бий болгон, хадгалж хамгаалах талаар нэгдсэн ойлголт, зарчим, үйл ажиллагааны тогтолцоонд хараахан хүрээгүй байна.Тиймээс бид Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалагдаж байгаа тус төвөөс 15 аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалыг бүртгэн баримтжуулсан ажил, 2015 оны үзлэг тооллын ажил,мэргэжлийн судалгааны байгууллагуудын эрдэм шинжилгээний болон авран хамгаалах тайлан зэрэголон эх сурвалжаар цуглараад байгаа дурсгалт газрын талаарх мэдээллийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэж байна. Эдгээрт хамгийн ихээр сөргөөр нөлөөлж буй байгаль, нийгмийн хүчин зүйлсийг тодорхойлж эрсдэлийн зураглалыг хийх ажлыг эхлүүлэн ажиллаж байгаа билээ. Энэхүү түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эрсдэлийн зураглалыг хийснээр дурсгалын хадгалалт хамгаалалтыг эрсдэлийг тодорхойлох, энэ талын мэдээллийг шийдвэр гаргагчдад бодитоор хүргэх зэрэг ач холбогдолтой юм (Зураг 2).



Зураг 2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогод хамрагдсан дурсгалын тархалтын зураг

“Хэрлэн барс” хотын цамхагийн сэргээн засварлалтын ажил: Монгол улсын Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолоор “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг баталсан ба хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.2.6-д Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын нутаг дахь Хэрлэн барс хотын цамхгийг сэргээн засварлахаар тусгасан байдаг.

“Хэрлэн барс” хотын цамхаг байгаль, цаг агаарын нөлөөлөл болох салхи, борооны уснаас шалтгаалан суурь нимгэрэх, тоосгоны барьцалдаагаа шавар, лагшин ховхорч унах, ханын тоосго суларч унах, хүний хүчин зүйлийн нөлөөлөл болох тоосгыг сугалж, эмчилгээнд хэрэглэх, углуурга, бэхэлгээ модыг ховхлон шүтлэг зан үйлд хэрэглэх зэргээс шалтгаалан түүхийн олон зуун жилийн туршид элэгдэж гэмтсээр хазайлт үүсэн нурах эрсдэлтэй болсон байв (Зураг 3).

Зураг 3. Сэргээн засварлалтын өмнө

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хооронд 2010-2013 онд хэрэгжүүлэх Соёлын солилцооны төлөвлөгөөний 6 дугаар зүйл, 2014 онд Монгол улсын Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Соёлын өвийн удирдах газар хооронд Хэрлэн барс хотын цамхагийн сэргээн засварлах талаар хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан, мөн оны4-6 сар БНХАУ-ын Соёлын өвийн академи болон Монгол улсын Соёлын өвийн төвийн хооронд тус хотын цамхгийг бэхжүүлэх,

хамгаалах чиглэлээр 3 жилийн хугацаандхамтран ажиллах тухай Улаанбаатар болон Бээжин хотноо зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, ажлын төлөвлөгөө, сэргээн засварлах арга зүй боловсруулснаарсэргээн засварлах ажил эхэлсэн.Үүнээс хойш 7-8 сард ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн (хуучин нэрээр) судалгааны баг Хэрлэн барс хотын цамхагт археологийн малталт, судалгааг явуулж олон тооны сонирхолтой олдвор илрүүлэн судалсан байна. Дээрх олдворуудыг Соёлын өвийн төвд сэргээн засварлан, ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Дорнод аймгийн музейд хүлээлгэн өгсөн.

Үүний дараа сэргээн засварлалтын үед ашиглах зөөврийн ажлын байрыг бэлтгэх, Монгол, Хятадын хамтарсан судалгааны баг дурсгалын эвдрэл гэмтлийн болон сэргээн засварлах ажлын зургийн хийв.

2015 онд сэргээн засварлалтад шаардлагатай шавар, элс, чулуу зэргийг орон нутгаас олборлох, цамхгийн орчимд уламжлалт аргаар 10,000 ширхэг хөх тоосго хийх (цохих), цамхгийн нэгдүгээр давхарт сэргээн засварлалт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

2016 онд цамхгийн суурийг нэмж, өргөтгөн бэхжүүлж, 2-7 дугаар давхарт сэргээн засварлалт хийх, өмхөрч муудсан модон углуургыг солих, зарим углуурга модыг бэхжүүлж, унахаас сэргийлсэн бэхэлгээ, борооны ус орохоос сэргийлж дээвэр болон ус зайлуулах хоолой бүхий систем суурилуулав. Мөн шувуу, амьтан орж биологийн бохирдол үүсэхээс сэргийлж цонхонд төмөр хаалт, үүдний хэсэгт хаалга зэргийг хийсэн. 2016 оны 9-р сард Хэрлэн барс хотын цамхгийг сэргээн засварлаж дуусган, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, орон нутагт хүлээлгэн өгсөн болно (Зураг 4).

Зураг 4. Сэргээн засварлалтын дараа

Хоёр орны судлаачид Хэрлэн барс хотын цамхагийг сэргээн засварлах ажлын явцад Хөшөө дурсгал болон Дурсгалт газрын хадгалалт хамгаалалтын Олон улсын зөвлөл (ICOMOS)-өөс соёлын өвийг хадгалж хамгаалахад тавьдаг үндсэн зарчим болох ”Эх төрх байдал”, “Бүрэн бүтэн цогц байдал”-ыг аль болохоор хэвээр нь хадгалан үлдээх зарчмыг баримталсан болно. Дурсгалыг сэргээн засварлахдаа дараах олон улсын баримт бичгүүдийг үндэслэв. Үүнд,

- 1994 оны Эх төрх байдлыг хамгаалах тухай Нарагийн баримт бичиг,
- 1996 оны Хөшөө дурсгал, цогцолбор барилга байгууламж, дурсгалт газрын хадгалалт хамгаалалт, хамгаалалтын талаар тэмдэглэл хийж, баримтжуулах зарчмууд,
- 2003 оны Уран барилгын өвийг шинжилж дүгнэх, хадгалж хамгаалах болон бүтэц, бүрдлийг нь сэргээн засах зарчмууд гм

Сэргээн засварлалтын өмнөх судалгаагаар цамхгийн 60% -нь эвдрэл гэмтэлтэй, 40%-нь анхны эх төрх байдлаараа байсан бөгөөд цамхгийн дээвэр хэсгээс бусад хэсгийг анхны эх төрх байдалд ойртуулан сэргээн засварлалаа. Тэрчлэн сэргээн засварлахад ашигласан үндсэн түүхий эд болох хөх тоосго, шавар, шохой зэргийг орон нутгаас олборлон хөх тоосгыг уламжлалт аргаар дурсгалт газрын орчимд хийсэн нь энэ ажлын онцлог, үр дүн болсон хэмээн үзэж байна.

МОНГОЛ-СОЛОНГОСЫН ХАМТАРСАН "МОНГОЛ НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛ БОЛОХ БАРИЛГА АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫГ 3D-ЭЭР БАРИМТЖУУЛАХ, ТЕХНИКИЙН ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ" ТӨСӨЛ

Архангай аймгийн Өлзийт сумын Өөлд бэйсийн хүрээ

З.Оюунбилэг Г.Бүрэнтөгс, Б.Алтансүх, П.Чинбат, Ж.Даваацэрэн, Г.Халиун
КанХён Т.Эрдэнэцогт, Пак Сон-Ху, Чон Чүн-Хуа, Ким Сон-Ми

Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны харъяа Соёлын өвийн төв, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнтэй (NRICH) Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох барилга архитектурын дурсгалыг 3D-ээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах чиглэлээр хамтран ажиллах талаар 2015 онд санамж бичиг байгуулсны дагуу 2016 оны 8 дугаар сарын 1-20-ны хооронд Архангай аймгийн Өлзийт сумын Өөлд бэйсийн хүрээний Цогчин дуган, Жүд дацан болон Цамын асар, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Үнстийн хийдийн Цогчин дуган дээр тус тус хэмжилт судалгааг хийлээ. Төсөлд Монголын талаас зөвлөх архитектор, доктор З.Оюунбилэг, Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Г.Бүрэнтөгс, Б.Алтансүх, П.Чинбат, Ж.Даваацэрэн Г.Халиун, Солонгосын талаас БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Архитектурын хэлтсийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, архитектор, доктор Кан Хён, эрдэм шинжилгээний ажилтан Т.Эрдэнэцогт, Пак Сон-Ху, Чон Чүн-Хуа, Ким Сон-Ми нарын бүрэлдэхүүнтэй хамтран ажиллаа.

Архангай аймгийн Өлзийт сумын төв нь Улаанбаатар хотоос баруун зүгт 340 км, аймгийн төв Цэцэрлэг хотоос 134 км зайд байрлана. Сумын нутаг дэвсгэр зүүн өмнө болон урд талаараа Архангай аймгийн Өгийнуур сум, баруун өмнөд, баруун талаараа Батцэнгэл сум, баруун хойт талаараа Хайрхан сум, хойд талаараа Булган аймгийн Сайхан сум, зүүн хойд ба зүүн талаараа Могод сумтай хиллэдэг. Өлзийт сум нь монголын өөлд ястнууд амьдран суудаг нутаг бөгөөд түүх, угсаа гарлын хувьд бусад сумаасаа өвөрмөц онцлогтой.

Өөлд бэйсийн хүрээний үүсэл анх Равдан ноёны үед буюу 1703 оны үед үүссэн бөгөөд анхандаа нүүдлийн байдалтай байснаас үүдэн бурхан шүтээн нь Монгол гэрт байсан бололтой. Харин 1761 онд төв халхын нутагт нүүн ирснээр суурьшмал шинжтэй болж сүм дуганаа барих болжээ.

Архангай аймгийн Өлзийт сумын төв дэх (хуучнаар Сайн ноён хан аймгийн Бишрэлт бэйсийн хошууны нутаг) Өөлд бэйсийн хүрээний анхны эх шавыг 1797 онд одоогийн Бодонт багийн Олзод ууланд тавьжээ. Энд 13 жил болоод 1810 онд Норжинчинбо уулын дунд эх Рашааны баруун зүүн салааны бэлчир дээр шилжүүлэн суурьшиж олны дунд Өөлдийн өвгөн хүрээ хэмээн алдаршсан байна.

2016 оны байдлаар Өөлд бэйсийн хүрээний барилгуудын одоогийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын асуудлыг сумын Засаг даргын Тамгын газар хариуцаж байна.

Өөлд бэйсийн хүрээний төлөвлөлт нь уламжлалт "хүрээ" төлөвлөлтийн дагуу урагшаа задгай, бүх барилгын үүдийг урд зүг рүү харуулж, гол тэнхлэг дээр гол сүм Цогчин дуган болон шүтээний барилгыг төлөвлөж, түүний урд ар тал, баруун зүүн талд бусад 16 сүм дуган, барилга, суваргыг эрэмбэ дараалал, зориулалтын дагуу тойруулан төлөвлөсөн байжээ.

Бид 2015 оны 6-р сарын 9-17-ны хооронд Өөлд бэйсийн хүрээнээс үлдсэн Цогчин дуган, Жүд дацангийн барилгын одоогийн байдлыг гараар зурж хэмжиж, архитектурын деталийн дардсыг авсан бөгөөд Leica C10, Mantis vition 3D гар скайн ашиглан хэмжилт хийлээ.

Зураг	Төхөөрөмжийн нэр	хэмжих зарчим	Дээд түвшин	Хэмжих хүрээ	Скайн хүрээ	Нарийвчлал (зай)	нягтаршил (өнцгийн хэмжээ)
	Leica C10	Pulse Ranging	50,000 pps	0.1m/300m @90% reflectivity	270°/360°	± 4mm @50m	0.0033°
	Mantis vision	flash light	0.5㎜	Black and white support	38° X 44°	10 frames per second	3㎜

2016 оны 8-р сарын 1-7- ны хооронд Өөлд бэйсийн хүрээний агаарын зургийг JDI Inspire дрон ашиглан баримтжуулж, Цамын асрын хэмжилтийн ажил Цогчин дуган болон Жүд дацангийн барилгын дээд хэсэг, дээврийн дотор талын хэмжилтийг хийж, Жүд дацангийн шал малын өтөг бууцанд дарагдан шалны бүтэц, модон шал байгаа эсэх нь мэдэгдэхгүй байсан тул хаалганы баруун баганаас хойш 3 дахь багана үүнээс баруун зүгт баруун талын гадна галерей хүртэл 75см хэмжээтэй (өргөн) суваг татан шалган, Цамын асрын шугаман хэмжилт болон 3D скайн хийснээр Өөлд бэйсийн хүрээг өнөөгийн байдлаар нь баримтжуулах ажлыг амжилттай дуусгалаа.

Цогчин дуганы нүүр талын фото зураг болон 3D зураг



Цогчин дуганы хэмжилтийн зураг

Цамын асрын нүүр тал болон баруун талын 3D зураг

Жүдийн дацангийн нүүр талын фото болон 3D зураг

Үлдсэн барилгын 3D зураг




Жүд дацангийн байгуулалт болон сувгийн 3D зураг

ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ТЕХНОЛОГИЙГ АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНД АШИГЛАН ГАЗРЫН ЗУРАГ ЗОХИОХ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭС

М.Нямхүү, Ч.Амартүвшин, Г.Эрэгзэн

Оршил

Археологийн судалгаанд газарзүйн мэдээллийн систем (GIS[1])-ийн технологийг ашиглаж ирснээр багагүй хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд археологийн дурсгалт газруудыг байршил тогтоогч багажаар хэмжин (GPS[2]) ГМС-д оруулан цэгэн, шулуун, талбайн давхаргуудыг (газарзүйн мэдээллийн системд геометрийн биет болон объектийн илэрхийлэгч) бүрдүүлж, төрөл бүрийн масштабтай газрын зураг зохиожээ. Цаашид өндөр нарийвчлал бүхий байршил тогтоогч хиймэл дагуулын систем (GNSS[3]) ашиглан орчны зураглал хийх, ГМС-ийн технологийг ашиглан мэдээллийн сан үүсгэх, том масштабын газрын зургийг зохион тоон болон хэвлэмэл байдлаар архивлан хадгалах, засварлах, баяжуулах, мөн түүнчлэн тухайн өгөгдлийн метадата үүсгэх асуудал нэн чухал бөгөөд энэхүү мэдээллийн сан нь Монгол улсын MNS5774:2007 стандартад нийцсэн байх шаардлагатай байна.

Судалгааны талбай

Энэхүү судалгаанд Сэлэнгэ аймгийн Мандал сумын Бороогийн дөрвөлжин, Төв аймгийн Баянцагаан сумын Чихэртийн зоо, Төв аймгийн Баянжаргалан сумын Гуа Дов, Булган аймгийн Бүрэгхангай сумын Шувуутайн хэрэм зэрэг археологийн дурсгалт газрууд хамрагдсан. Судалгааг ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн олон улсын болон үндэсний хээрийн судалгааны ангийн бүрэлдүүхэнтэй хамтран 2016 оны 5-9 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаа нь хээрийн хэмжилт хийн өгөгдөл цуглуулах, хагас суурин боловсруулалт, суурин боловсруулалт гэсэн 3 үе шаттайгаар хийгдсэн.Судалгаанд дараах багаж, програм хангамжуудыг ашиглалаа.

1	Байршил тогтоогч – GPS	Garmin ETrex 30x
2	Байршил тогтоогч – GNSS	GPS/GNSS Surveying System
3	Нисгэгчгүй онгоц - UAV	Phantom 3
4	Мэдээлэл дамжуулах програм	HcLoader, Convert to RINEX, Project Manager, LisCAD
5	Мэдээлэл боловсруулах програм	AutoCAD, ArcGIS

[1] Geographical Information System
[2] Global Positioning System
[3] Global Navigation Satellite System

Хээрийн хэмжилт: Судалгааны талбайд хөдөлгөөнгүй хатуу цэгийг байрлуулна. Байршил тогтоогч GPS-ээр тухайн цэгийн солбицлын тогтооно. Дараа нь тухайн цэгтээ байршил тогтоогч GNSS-ээ байрлуулан хээрийн хэмжилт хийнэ. Хээрийн хэмжилтийн хүрээнд тухайн судалгааны талбайд байрлаж буй объектууд (археологийн дурсгалт байгууламж, далан, суваг шуудуу гэх мэт), мөн тухайн орчмын газрын гадаргын хэлбэрийг (хаялбар зурах) тодорхойлох хэмжилтийг хийж гүйцэтгэнэ.

Хагас суурин боловсруулалт: Хээрийн хэмжилтийн мэдээ нь цэгэн хэлбэрээр ГМС-д орох бөгөөд тухайн цэгийн солбицол, өндрийн утгыг агуулна. ГМС-д орсон цэгэн мэдээлэлд анхан шатны боловсруулалт хийх(цэгэн давхарга үүсгэх), объектуудыг зурах, хаялбар татах(шугаман болон талбайн давхарга үүсгэх) зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ. Судалгааны энэ үед газрын зураг зурах, мэдээллийн сан үүсгэхэд шаардлагатай мэдээллээ бүрэн дүүрэн, үнэн зөв цуглуулж авах нь маш чухал. Цуглуулсан мэдээ дутуу болон алдаатай байвал хээрийн хэмжилтийг дахин хийх хэрэгтэй.

Суурин боловсруулалт: Хээрийн хэмжилтийн мэдээллийг AutoCAD болон ArcGIS програмын тусламжтайгаар боловсруулалт хийж, том масштабын газрын зургийн хэвлэлийн эх бэлтгэх, газрын зурагт зурагдсан бүх объектуудын метадатаг үүсгэх, архивлан хадгалах зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ.

Судалгааны ажлын үр дүн

Энэхүү судалгааны ажлын үр дүнд дараах зургуудыг зохиосон. Тухайн газрын талбайн хэмжээ, судалгааны ажлын зорилгоос хамааран зургийн масштаб нь өөр өөр байна(Зураг 1).

ГУА ДОВ М1:2000	ШУВУУТАЙН ХЭРЭМ М1:1000
БОРООГИЙН ДӨРВӨЛЖИН М1:500	ЧИХЭРТИЙН ЗОО М1:15000



Зураг 1. Судалгааны үр дүнд зохиосон газрын зургууд

Дээрх зургуудын ГМС-ын мэдээллийн санг дараах байдлаар үүсгэсэн.Үүнд: ArcGIS програмаас экспортлон гаргасан *.jpg зурган файл, судалгаанд ашигласан зурган мэдээлэл (растер мэдээ), хээрийн хэмжилтийн эх мэдээ, бусад цэгэн, шулуун, талбайн мэдээллүүд (вектор мэдээ), газрын зургийн хэвлэлийн эх (*.mxd) зэрэг файлууд багтана(Зураг 2).



Зураг 2. ArcCatalogy-д харагдаж буй байдал

Дүгнэлт

ГМС-ийн технологийг археологийн судалгаанд ашигласнаар том масштабын газрын зураг зохиох, мэдээллийн сан үүсгэх бүрэн боломжтой. Энэхүү судалгааг хийхэд өндөр хүчин чадал бүхий компьютер, нарийвчлал сайтай байршил тогтоогч хиймэл дагуулын төхөөрөмж шаардлагатай. Судалгааны зорилгоос хамааран зургийн масштабыг томсгох болон багасгаж болно. Цаашид мэдээллийн санг өөрчлөх, баяжуулах, өгөгдлийн метадатаг олон улсын болон монгол улсын стандартад нийцүүлэн хийх, мэдээллийн сангийн файлыг вэб хуудсанд байршуулснаар судалгааны ажлаа сурталчлах, мөн ишлэл авах бололцоог бий болгох зэрэг ач холбогдолтой юм.

Талархал

Энэхүү судалгааг явуулах боломжийг олгосон ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн ЭШАА, доктор Ч.Амартүвшин, доктор Г.Эрэгзэн, хээрийн судалгааны багийн гишүүн Б.Батбаяр, багаж, тоног төхөөрөмжийн дэмжлэгүзүүлсэн Дирекцион ХХК-ны захирал Д.Лүндэнбат нарт талархал илэрхийлье.

Ашигласан материал

1. Д.Амарсайхан, М.Ганзориг, М.Саандарь, Ц.Адъяасүрэн. Зайнаас тандах судлал, газарзүйн мэдээллийн системийн зарчмууд (3 дах хэвлэл). УБ. 2006
2. MNS5774:2007 – Монгол улсын стандарт
3. Приемник СНС Х20. Руководство пользователя
4. Меркулов А. Создание проекта в AutoCAD «От идеи до печати». Иллюстрированный самоучитель. // https://cloud.mail.ru/public/Gijh/5azeJnDsE
5. GNSS – https://www.egnos-portal.eu/discover-egnos/about-egnos/what-gnss
6. Археологийн судалгааны ажлын тайлангууд

УМАРД, ТӨВ, БАРУУН БҮСИЙН ЗАРИМ НУТГУУДАД АРХЕОЛОГИЙН МЭДЭЭ ШАЛГАСАН ТУХАЙ

Г.Галдан, Б.Батдалай, Ч.Амартүвшин

Тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын салшгүй нэг хэсэг бол орон нутгийн ард иргэд, байгууллагаас ирсэн түүх, соёлын дурсгалын хадгалалт хамгаалалт, археологийн судалгааны шинэ мэдээ сэлтийг газар дээр нь очиж нягтлан шалгах, хууль тогтоомжийн хүрээнд тэдгээрийг авран хамгаалах асуудал билээ. Энэ ажлын хүрээнд бид энэ жил Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Шивэртийн эх, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Хагтын хадны оршуулга, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт илэрсэн хүрэл тогоо, мөн аймгийн Сүхбаатар хотын ойролцоо орших сонирхолтой байгууламжийг нягтлан судлах, тодорхойлох, авран хамгаалах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Шивэртийн эхийн хадны оршуулга

Тус хүрээлэнгийн Бүс нутаг, орчин үеийн түүхийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан Ч.Батдоржийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Шивэртийн амны эхэнд цавчим өндөр цохионы зүүн хойш хандсан амтай хадны хонгилд нэгэн хадны оршуулга тоногдож сүйтгэгдсэн тухай мэдээллийн дагуу очиж танилцав. Уг хадны оршуулгын газарзүйн байршил нь хойд өргөргийн 48°10'02.2", зүүн уртрагийн 100°56'25.9", далайн түвшнээс дээш 1858м өндөрт өргөгджээ. Хонгилын хэмжээ 400х250см, өндөр нь 200см. Хонгил үүдэн хэсгээрээ намхан хавчиг хэдий ч дотроо уужим зайтай ажээ. Хонгилын бүх шороог гаргаж хадны зүүн талд овоолжээ. Энэ хадны хонгилд хоёр хүний оршуулга байсан бололтой гавлын яс хоёр, зарим мөчдийн яс хоёр байна. Бид тус сумын Азарга багийн төвөөс иргэн О.Алтангэрэлээс Шивэртийн амны эхний хадны оршуулгаас гарсан эмээлийн модны хэсэг, модон аяганы хагархай зэргийг цуглуулж авав.

Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Хагтын хадны оршуулга

Баян-Өлгийн аймгийн Алтанцөгц сумын нутагт Цамбагарав уулаас хойд баруун хойд зүгт 30 орчим км зайд байх далайн төвшинөөс дээш 3345.7м өндөр өргөгдсөн Сайхан дэвсэг хэмээх уулын зүүн урд энгэрт Тагт хэмээх газарт хойд өргөрөгийн 48 43 07.4 зүүн уртрагийн 90 29 20.4 солбицолд далайн түвшинөөс дээш 2364м өндөр газар байрлана. Уг дурсгалыг анх нутгийн иргэн “барагшуун” түүж байхдаа илрүүлэн олж хадны хөмөгт байсан ухмал модон авс бүхий хүний шарилыг ил гарган орхиж сум, орон нутгийн захиргаанд мэдэгдсэн ажээ. Энэхүү мэдээллийг цаг тухайд нь бидэнд мэдэгдэж, хууль журмын дагуу хамгаалалтанд авсан тус сумын засаг дарга Н.Бекет, засаг даргын орлогч Х.Бахытхан, аймгийн Цагдаагийн хэлтэсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн ахмад Бакаагийн Ганболд Эрүүгийн цагдаагийн тасгийн

Эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад Алимжан Серикжан нарт талархснаа илэрхийлэх нь зүйтэй юм.

Бид уг дурсгалт газарт очиж үзэхэд модон австай шарилыг хадны хөмөгт буцаан хийж гаднаас нь дахин таглаж хамгаалалтанд авсан байсныг бид баримтжуулан малтлага судалгаа хийв. Уг дурсгалын анхны байдал нь том үхэр чулууны доод хөмөгт хүнээ оршуулан гаднаас нь жижиг чулуугаар хаялан дарж таглсан байсан бололтой. Хөмөгний доторхи хэмжээ урт 2.4м, өргөн 1.4м, хөмөгний өндөр 0.8м. Хөмөгний зүүн хэсэгт ухмал авсанд хийсэн хүнээ толгойг хойш харуулан тавьж авсны баруун талд хөвчилж тавьсан эвэр нум дагалдуулсан ба нумыг баруун тийш харуулан тавьсан бөгөөд нумны хойд талд ясан арал бүхий дээсэн бүс, нумны урд (доод гичирний доор) хэсэгт доор нь хүний дүрс бүхий даавуун онго дагалдуулан тавьжээ. Нум болон бүс зэргийг баримтжуулан авахад нумны хойд хэсгийн доороос дугуйлан гөрж хийсэн унжлага бүхий модон ташуурын толгойг хойш хандуулан тавьсан байна. Даавуун онгоны доороос төмөр цагариг гарсан ба цагариганд 3 сурны залгаа хэсэг байсан нь тасарчээ. Мөн хөмөгний дотор баруун хананд 1.2х0.4м хэмжээтэй том хавтгай чулуу байх ба уг чулуун дээр саадагны амсарыг хойш харуулан тавьсан ба чулууны хойд талд төмөр дөрөөтэй модон эмээлийн урд бүүргийг хойш хандуулан тавьжээ. Эсгийн дотортой дээлний үлдэгдэл байсан бөгөөд дээлийг эмээлийн дээр эвхэж тавьсан байсан бололтой. Ийнхүү бид тухайн дурсгалыг устаж сүйтгэгдэхээс нь өмнө авран хамгаалах малтлага судалгааны ажлыг явуулав.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумаас олдсон хүрэл тогоо

Сэлэнгэ Хүдэр сумын Бүдүүний гол хэмээх газар үйл ажиллагаа явуулж буй "Бэйсик металл майнинг" ХХК-ний зам засварлах ажлын явцад олдсон хүрэл зэвсгийн үед холбогдох олдворыг тус аймаг дахь Цагдаагийн газрын Хэрэг бүртгэл, мөрдөн байцаах тасгийн 2016 оны 11-р сарын 02-ны өдрийн Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тогтоолын дагуу очиж танилцан олдворуудыг авч ирсэн билээ.

1-р тогоо. Задгай босоо амсартай, амсарын дээд ирмэгээс илүү гарсан 2 сэнжтэй, цөгцөн ёроолтой, намхан тогоо байна (Зураг 1).

Тогооны сэнж нь их биеэс гадагш дугуйран, амсараас доош 2.5см үргэлжлэн их биед бэхлэгдсэн ба бэхлэх хэсгээс доош үл ялиг илүү гарсан сэртэн гаргаж өгсөн нь тухайн тогооны үзэмжийг илүү нэмсэн байна. Нэг сэнж нь хуучин ахуй үедээ их биеэс салан эвдэрч байсныг тухайн үед нь эргүүлэн гагнаж засварлаж байсны ул мөр үлджээ. Их биеийн өндөр 12см, сэнжний өндөр 2.2см, ёроолын өндөр 1см байна. Амсарын диаметр 22см, ёроолын диаметр 8.7см байна. Сэнж нь их биеэс 3см илүү гарсан байх ба бэхлэх хэсгээс доош илүү гарсан сэртэн нь 1 болон 0.5см хэмжээтэй байна. Тогооны их биеийн зузаан 0.3см, сэнжний зузаан 0.4см байгаа бол бэхлэх хэсгийн зузаан 0.6см байна.

2-р тогоо. Задгай дэрэвгэр амсартай, амсарын ирмэгээс илүү гарсан үргэлж сэнжтэй, амсарын доод хэсгээр зүмбэрдэж, товойлгон хээлсэн, гурван хөлтэй жижиг тогоо байна (Зураг 2). Хөлийг хавтгай давтсан хүрлийг дотогш хуйлан, "П" хэлбэртэй

болгон их биед гагнан залгасан байна. Тогоо хүнд юманд дарагдан хэлбэрээ ихэд алдан эвдэрсэн ажээ. Сэнжний өндөр 3.6см, их биеийн өндөр (одоо байгаа) 11.5см, хөлний өндөр 5.7, 5.5, 5.5см байна. Амсарын диаметр 26.6 см, амсарын зузаан 0.7см, сэнжний зузаан 0.3см, их биеийн зузаан 0.2см, хөлний зузаан 0.2см байна.

3-р тогоо. Задгай дэрэвгэр амсартай, амсарын ирмэгээс илүү гарсан үргэлж сэнжтэй байсан бололтой, сэнж нь эрт цаг хугарч үгүй болжээ. Амсарын доод хэсгээр зүмбэрдэж, товойлгон хээлсэн, гурван хөлтэй жижиг тогоо байна (Зураг 3). Хөлийг хавтгай давтсан хүрлийг дотогш хуйлан, "П" хэлбэртэй болгон их биед гагнан залгасан байна. Тогоо хүнд юманд дарагдан хэлбэрээ алдан, хагарч зарим хэсэг нь үгүй болсон, хөлний үзүүр хэсгүүд бүгд хугарч алга болсон байна. Амсарын голч 23.5см, өндөр нь 0.3, их биеийн өндөр 8.7см, хөлний өндөр (одоо байгаа) 3, 3, 2.4см байна. Амсарын зузаан 1 см зузаан, их биеийн зузаан 0.3, хөлний зузаан 0.2см байна.

4-р тогоо. Задгай дэрэвгэр амсартай, босоо дугуй, их биеийг дагасан, үргэлж биш, залгаж гагнасан сэнжтэй, сэнжний дээд үзүүрт босоо сэртэнтэй, амсарын доод хэсэгт товойлгон гаргасан нарийн хээгээр бөгжлөн хээлсэн, мөр, бөөргүй шувтан их биетэй, цөгцөн ёроолтой том хүрэл тогоо байна (Зураг 4). Тогоо эрт үед хүнд юманд дарагдан нэг сэнж тогооны дотор тал руу гулзайн орсноос гадна цөгцөн ёроол нь мөн адил эвдэрч бүтэн биш болжээ. Сэнжний өндөр 7.6см, сэнжний дээд хэсэгт байх сэртэн нь 1.3см өндөртэй. Их биеийн өндөр 30см, амсарын өндөр 1.1см, ёроол 0.7см (одоо байгаа) өндөртэй. Амсарын голч 31см, ёроолын голч 9см байна. Сэнжний зузаан 1.2см, амсарын зузаан 1, их биеийн зузаан 0.5, ёроол 0.2см зузаантай.

5-р тогоо. Задгай дэрэвгэр амсартай, босоо дугуй, их биеийг дагасан, үргэлж биш, залгаж гагнасан сэнжтэй, сэнжний дээд үзүүрт босоо сэртэнтэй, амсарын доод хэсэгт товойлгон гаргасан нарийн хээгээр бөгжлөн хээлсэн, мөн их биеийн гол хэсэг мөн товгор нарийн зураасан хээтэй, мөр, бөөргүй шувтан их биетэй, цөгцөн ёроолтой том хүрэл тогоо байна(Зураг 5). Тогоо эрт үед хагарч их биеийн зарим хэсэг үгүй болсноос гадна цөгцөн ёроол нь мөн адил эвдэрч бүтэн биш болжээ.
Сэнжний өндөр 8.8см, сэнжний дээд хэсэгт байх сэртэнгийн өндөр, 1.8см, их биеийн 32.2см, ёроолын өндөр (одоо байгаа) 5см байна. Амсарын голч 30.7см, ёроолын голч (одоо байгаа) 11.2см байна. Сэнжний голч 9.3см, өргөн 1.7см, зузаан нь 1см байгаа бол амсарын зузаан 1.3см, өндөр нь 0.6 - 1.1см байна. Их биеийн зузаан 0.6см, ёроолын зузаан 0.3см ажээ.

6-р тогоо. Энэхүү тогоо эрт цагт эвдэгдэн хагарч, тал хэсэг нь үгүй болжээ. Гэвч бага боловч мэдээлэл авах боломжтой ажээ. Тус тогоо нь задгай дэрэвгэр амсартай, их биеийн хажуу хэсэгтэй сэнжтэй байсны ул мөр үлдсэн (жижиг хэсэг нь үлдэж хоцорсон), босоо өндөр тогоо байсан нь тодорхой байна. Тогооны өндөр (одоо байгаа) 36см, амсарын голч ойролцоогоор 35см байсан бололтой. Их биеийн зузаан 1см, амсарын зузаан 2.2см байна.

Хөрш зэргэлдээ орнуудад явуулсан археологийн судалгааны мэдээ баримтуудыг гүймэг шүүн үзвэл Өмнөд Сибирь, Кашкар, Өрөмч, Хами, Уулын Алтай, Илийн гол, Турфаны хойд хэсгүүдээс илэрсэн ижил хүрэл тогоонуудтай зарим

тогоонууд (4 болон 5-р тогоо) ихэд төстэй байгааг харгалзан дээрх тогоонуудын он цагийг НТӨ VI зуун буюу түрүү төмөр зэвсгийн үед хамааруулж болох байна.

Сэлэнгэ мөрний савд илэрсэн үл мэдэгдэх байгууламж

Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Д.Энхбаяр "Газарзүйн нэр" хээрийн судалгаагаар Сэлэнгэ аймгийн Шаамар, Зүүнбүрэн, Сүхбаатар сумдын нутгаар урсах Орхон-Сэлэнгэ мөрний сав дагуух газар усны нэрийг тодруулан судлах ажлыг Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай хамтран гүйцэтгэх явцад Сайханы хөтлөөс баруун, баруун хойш (279^{0} чигт) 3.8км-т, Тавтын заставаас баруун тийш 2.5км-т, Монгол улсын хилээс урагш 1.6 км зайд "Цагаан арал" дотор хүн бүр очиж үзэх боломжгүй газарт орших байгууламж байгааг агаарын зураг дээр анх болжээ. Тэрээр байгууламжийн өрсөн дэс дараалал янз бүр, байгуулламжийн ерөнхий дүрс хэлбэр, хандах зүг чиглэл зэрэг өөрчлөлт, булш бол түүн дээрх чулуун овоолго бүрийн тоо олон цөөнөөс гадна дүрс тэмдэг, үсэг, бичээс юм уу, ямар нэгэн утга санаа илэрхийлж байж магадгүй хэмээн бидэнд хандсан бичигтээ тодорхой өгүүлсэн юм. Иймээс цаашид энэхүү газрыг нягтлан шалгах, баримтжуулах шаардлагатай байгаа билээ.

Төгсгөл

Манай оронд түүх соёлын дурсгал санамсаргүй байдлаар болон ашиг эрэгч хүмүүсийн санаатай үйл ажиллагааны улмаас илэрч ихээр сүйтгэгдэж байгаа билээ. 2016 оны байдлаар Монгол орны баруун, умард болон төвийн бүс нутгаас санамсаргүй байдлаар илэрч олдсон хадны оршуулга зэрэг эртний дурсгалын талаар бидэнд ирүүлсэн мэдээллийн дагуу цаг алдалгүй газар дээр нь очин танилцаж баримтжуулж авах ажлыг хийлээ. Бид Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Шивэртийн амны эх болон Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Тагтын хадны оршуулгыг газар дээр нь очин малтан судалж олвор хэрэглэгдэхүүнийг авч ирсэн бол Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Бүдүүний гол хэмээх газраас илэрсэн хүрэл зэвсгийн үед холбогдох хүрэл тогоонуудыг Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн хэлтэсээс авч ирэн мэргэжлийн шинжээчийн дүгнэл гаргаж өгсөн байна. Харин Сэлэнгэ мөрний савд мэдэгдэж буй эртний нүүдэлчдийн үлдээсэн байж болох өвөрмөц байгууламж бүхий газарт 2017 онд очиж ажиллахаар төлөвлөж байгаа билээ.

Хавсралт

Зураг 1. Шивэртийн амны хадны оршуулганы ерөнхий байдал

Зураг 2. Тагтын хадны оршуулганы ерөнхий байдал

Зураг 3. Тагтын хадны оршуулганаас илэрсэн олдворууд



Зураг 4. Бүдүүний голоос олдсон хүрэл тогоо (гар зураг)



**

Зураг 5. Сэлэнгэ мөрний савд буй өвөрмөц дурсгал бүхий газрын ерөнхий байдал



Зураг 6. Сэлэнгэ мөрний савд буй өвөрмөц дурсгал бүхий газрын агаарын зураг

УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН АРХЕОЛОГИЙН ТЭНХИМИЙН АВРАН ХАМГААЛАХ ХАЙГУУЛ СУДАЛГАА

Э.Мижиддорж, Д.Цэнд

Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхим 2016 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны №16-4 тоот Археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийх зөвшөөрлийн дагуу Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл заалтуудыг баримтлан 1. Уул уурхайн компаний захиалга, 2. Экологийн үнэлгээний компанитай хамтарсан, 3. Орон нутгийн захиалгын дагуу гэсэн үндсэн чиглэлээр археологийн хайгуул судалгааг хийж гүйцэтгэлээ(Хүснэгт 1).

Нэг. Уул уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн хайгуул. Археологийн тэнхим нь 2016 онд “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан “Терра Инержи”, “Ар голд”, “Гурван тамга”, “Наран гоулд”, “Ориент майнинг Инвестмент”, “Билэгт гүнж”, “Кеестон Ресурс Моторс”, “Их Баялаг Ундрага”зэрэг 8 компанийн 12 тусгай зөвшөөрлийн талбай буюу нийт 36667 га талбайд археологийн хайгуул судалгааг хийж гүйцэтгэсэн болно.

Дээрх 12 тусгай зөвшөөрлийн талбайд авран хамгаалах хайгуул судалгаа явуулснаас 4 талбайгаас түүх соёлын ямар нэгэн дурсгал илэрсэнгүй. Харин үлдсэн 8 талбайгаас нийт 247 дурсгал илэрснээс хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүр 77, дөрвөлжин булш 16, дугуй дараастай булш 103, мөнгөн тайга хэлбэрийн булш 13, тахилын байгууламж 14, хадны зургийн дурсгалт газар 5, хөшөө чулуу 8, зохион байгуулалтаа алдсан булш 8, хүннү булш 2, монголын үеийн 1 булш тус тус илрүүлэв (Хүснэгт 2). Эдгээрийн заримыг товч дурьдвал: Увс аймгийн Давст сумын Гурван Тэрмэс уулнаа явуулсан хайгуул судалгааны үр дүнд 1 дурсгалт газар 89 хаданд 200 гаруй хадны зургийн дүрслэл бүхий дурсгалыг баримтжуулсан юм[1]. Мөн Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Туул голын баруун эрэг Гурван толгойн орчмоос дөрвөлжин хүрээтэй хиргисүүрийн хүрээ чулуун дээр хэнгэргээ дэлдэж буй бөөгийн (бамбай барьсан баатар эр?) дүрслэл бүхий хадны сийлмэл зураг[2] илрүүлсэн зэргийг дурьдаж болно.

---

[1] *Эрдэнэбаатар Д., Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С.,Амгаланбат Б., Даваахүү Э., Эрдэнэпүрэв П. Увс аймгийн Давст, Сагил сумдын нутагт орших “Терра-энержи” ХХК-ий“Баруун-тэрмэс” нэртэй XV-018142, “Баруун-тэрмэс 1” нэртэй XV-018797, “Баруун-тэрмэс 2” нэртэй XV-018802, “Баруун-тэрмэс 3” нэртэй XV-020281, “Давст” нэртэй XV-020539 дугаар бүхий явуулсан археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан. УБИС-ийн Археологийн тэнхимийн ГБСХ. Улаанбаатар, 2016*

[2] *Эрдэнэбаатар Д., Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С., Галбадрах Б., Өнөрбаяр Б. Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дахь “Ориент майнинг инвестмент” ХХК-ий XV-020466 дугаар бүхий лицензийн “Туулын зүүн дэнж” талбайд явуулсан археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан. УБИС-ийн Археологийн тэнхимийн ГБСХ. Улаанбаатар, 2016*

Дээрх талбайдаас илэрсэн дурсгалуудыг бүртгэн баримтжуулж, зохих дүгнэлт тайланг үйлдэн авран хамгаалах малтлага судалгаа явуулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг талбайн эзэмшигч компаниудад хүргүүлээд байна.

Хоёр. Экологийн үнэлгээний компанитай хамтарсан. Археологийн тэнхимийн багш, судлаачид Экологийн үнэлгээний Экотон ХХК –ний захиалгын дагуу "Дархан Сэлэнгийн районд Төмөрлөгийн үйлдвэр байгуулах" төслийн багт 2016 оны 6-р сард оролцон ажилласан болно. Энэхүү судалгааны ажил нь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ний Төмөр толгойн орд 10738А, Төмөртэйн орд 13319А, Хуст уул 13851А зэрэг уул уурхайн ашиглалтын талбай болон Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сумын нутгийг дамнасан авто зам болон төмөр замын трасст археологийн хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэсэн болно.

Төмөр толгойн орд, Төмөртэйн орд, Хуст уул зэрэг тусгай зөвшөөрлийн талбайдад ашигт малтмалын олборлолт өмнө нь явагдаад эхэлсэн, хөрс хуулалт хийгдсэн байсан тул түүх соёлын ямар нэгэн дурсгал илэрсэнгүй. Харин Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сумдын нутгийг дайран өнгөрсөн, шинээр тавьсан хатуу хучилттай замын трасс, төмөр замын трассын зарим хэсэгт археологийн хайгуул судалгаа явуулахад түүх, соёлын үл хөдлөх 44 дурсгал илрэв. Эдгээр нь хиргисүүр 21, хүннү булш 1, буган чулуу 1, мөнгөн тайга хэлбэрийн 1 булш, он цаг тодорхойгүй 4 дурсгал, 16 дөрвөлжин булш байв. Зарим дурсгал замын ажлын бүтээн байгуулалтын үед хөндөгдсөний улмаас эвдэрч сүйдсэн байна.

Энэхүү замын ажлыг гүйцэтгэхээс өмнө түүх, соёлын авран хамгаалах ажил хийлгээгүй болох нь тодорхой харагдаж байв. Тиймээс бид судалгааны ажлын тайланг Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газар болон Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн захиргаанд замын трассын дагуух эдгээр дурсгалыг авран хамгаалах малтлага судалгааг хийх зайлшгүй шаардлагатай гэсэн албан тоотыг судалгааны ажлын тайлангийн хамт хүргүүлээд байна.

Гурав. Орон нутгийн захиалгын дагуу. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Тост-Тосонбумбын нуруug улсын тусгай хамгаалалтанд авах асуудлын хүрээнд тус сумын удирдлагууд бүхий л төрлийн судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгүүлэх талаар тусгай мэргэжлийн байгууллагуудад хандаж, хийлгэсэн бабидний хувьдорон нутгийн хүсэлтийн дагуу археологийн урьдчилсан хайгуул судалгааг тухайн бүс нутагт явуулсан юм. Тост-Тосонбумбын нурууны нийт газар нутгийн дөнгөж 5% орчмоос 51 дурсгал илрүүлэн бүртгэснээс дөрвөлжин булш 1, шоргоолжин булш 1, дугуй дараастай булш 15, тахилын байгууламж 2, монголын үеийн 9 булш, 23 байршилд нийт 174 хадны зураг зэрэг дурсгалуудыг бүртгэн баримтжуулж,судалгааны ажлын тайлан мэдээг нутгийн удирдлагад хүргүүлсэн билээ.

Мөн Өмнөговь аймгийн "Гайхамшигт говь" аялал жуулчлалын холбооны захиалгаар тус аймгийн Булган сумын нутагт орших Баруун Сайхан уулын Хавцгайтын аман дахь хадны зургийн цогцолбор газарт нарийвчилсан хайгуул судалгаа явуулсан. Үүний үр дүнд уг газраас 84 хадны зураг илрүүлэн бүртгэсэн ба тухайн дурсгалт газрыг хэдий үед холбогдох эсэхийг тодруулахын тулд хүрээлэн буй орчны судалгааг

давхар гүйцэтгэсэн болно. Тус газрын ойр орчмоос нийт 28 булш оршуулгын дурсгал илрүүлсэнээс хиргисүүр 6, дөрвөлжин булш 3, шоргоолжин булш 7, дугуй дараастай булш 10, зохион байгуулалтаа алдсан 2 булш байлаа. Хүрээлэн буй орчинд байгаа түүх, соёлын дурсгалууд болон хадны зургийн дүрсэлсэн арга барил зэрэгт үндэслэн Хавцгайтын хадны зургийн дурсгалын ихэнхийгхүрэл зэвсгийн үед холбогдуулан үзэж болохоор байна. Тус 84 хадны зургаас онц сонирхолтой нь 52 дугаартай хадны зураг юм. Энэ дурсгал нь тухайн газрынхаа хамгийн том дурсгал бөгөөд налуу байрлалтай, баруун урагш хандсан хадан дээр 30 орчим дүрслэл буйгаас төв болон баруун дээд хэсэгт орших дүрслэлүүдийг монголын үед холбогдуулан үзэж болох ба цохилт, илэгдэл, дүрслэлийн арга барил зэргээрээ бусдаасаа эрс ялгарч байв. Хавцгайтын амны дурсгалт газар нь Өмнөговь аймгийн аялал жуулчлалын голлох бүсүүдийн нэг бөгөөд мэргэжлийн археологийн судалгааг явуулснаар энэхүү дурсгалт газар нь дотоод гадаадын аялагч, сонирхогч нарт илүү ойр дөхөм болсон юм.

Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн авран хамгаалах судалгаа
Хүснэгт. 1

№	Захиалагчаж ахуйн нэгж байгууллага	Лиценз дугаар	Талбай хэмжээ	Оршин буй засаг захиргаа	Оршин буй газар нутгийн нэр	Дурсгал илэрсэн эсэх
Нэг. Уул уурхайн компаний тусгай зөвшөөрлийн талбай						
1	Ориент майнинг Инвестмент	XV-020466	902.44 га	Булган аймаг Бүрэгхангай сум	Туулын зүүн дэнж	+
2	Ар голд	XV-017137	235 га	Төв аймаг Заамар сум	Баян овоот уул	-
3	Гурван тамга	XV-017151	1042.94 га	Төв аймаг Заамар сум	Бумбат-6	-
4	Наран гоулд	MY-015424	257.71 га	Булган аймаг Бүрэгхангай сум	Ар тамсаг	-
5	Терра Инержи	XY-018142	11204.30	Увс аймаг Давст сум	Баруун тэрмэс	+
6	Терра Инержи	XY-018797	3187.24	Увс аймаг Давст, Сагил сум	Баруун тэрмэс-1	+
7	Терра Инержи	XY-018802	5006.83	Увс аймаг Давст сум	Баруун тэрмэс-2	-
8	Терра Инержи	XY-020281	6068.09	Увс аймаг Давст сум	Баруун тэрмэс-3	+
9	Терра Инержи	XY-020539	8598.57	Увс аймаг Давст сум	Давст	+
10	Билэгт гүнж	16/R057	108 га	Сонгинохайрхан дүүрэг 32-р хороо	Эмээлт Уул	+
11	Кеестон Ресурс Моторс	X16/021	25.4 га	Төв аймаг Алтанбулаг сум	Ташгайн даваа	+
12	Их баялаг Ундрага	X16/005	30.72 га	Төв аймаг Алтанбулаг сум	СүүлОвоот	+
Хоёр. Экологийн үнэлгээний компанитай хамтарсан						
14	Экотон	10738A	424 га	Дархан-Уул Хонгор сум	Төмөр толгойн орд	-
15	Экотон	13319A	1200 га	Сэлэнгэ аймаг Хүдэр сум	Төмөртэйн орд	-
16	Экотон	13851A	39 га	Сэлэнгэ аймаг Ерөө сум	Хуст-Уул	-
17	Экотон	-	-	Сэлэнгэ аймаг Ерөө, хүдэр сум	Замын трасс	+
Гурав. Орон нутгийн захиалгын дагуу						

17	Өмнөговь ЗДТГ	-	-	Өмнөговь аймгийн Булган сум	Хавцгайтын ам	+
18	Өмнөговь ЗДТГ	-	-	Өмнөговь аймгийн Гурвантэс сум	Тост Тосон – бумбын нуруу	+
Нийт			38330.21 га талбайд		Дурсгал 371	

Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн авран хамгаалах судалгаагаар илэрсэн дурсгалын нэгдсэн мэдээлэл

Хүснэгт. 2

№	Аймаг, сум	Захиалагч компани	Газрын нэр	Дурсгалын төрөл	Тоо	Он цаг
1.	Увс аймгийн Сагил, Давст сум	Терра Энержи ХХК	Гурван Тэрмэс уул	Хиргисүүр	73	Хүрэл зэвсгийн үе
				Дөрвөлжин булш	4	
				Дугуй дараастай булш	89	
				Мөнгөнтайга хэлбэрийн булш	13	
				Тахилын байгууламж	4	
				Хадны зураг	5	
				Хөшөө чулуу	8	
				Зохион байгуулалтаа алдсан булш	4	Он цаг тодорхойгүй
				Хүнну булш	1	Хүннүгийн үе
				Монгол булш	1	Монголын үе
2.	Булган аймгийн Бүрэгхангай сум	Ориент майнинг инвестмент ХХК	Туулын зүүн дэнж	Хиргисүүр	2	Хүрэл зэвсгийн үе
				Тахилын байгууламж	9	
				Зохион байгуулалтаа алдсан булш	4	Он цаг тодорхойгүй
				Хүнну булш	1	Хүннүгийн үе
3.	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг	Билэгт гүнж ХХК	Эмээлт уул	Дөрвөлжин булш	7	Хүрэл зэвсгийн үе
				Дугуй дараастай булш	5	
				Хиргисүүр	1	
				Чулуун байгууламж	1	
4.	Төв аймаг Алтанбулаг сум	Кеестон ресурс моторс ХХК	Ташгайн даваа	Дөрвөлжин булш	5	Хүрэл зэвсгийн үе
				Дугуй дараастай булш	9	
				Хиргисүүр	1	
5.	Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө сум	Экотон ХХК	Авто замын трасс	Хиргисүүр	21	Хүрэл зэвсгийн үе
				Дөрвөлжин булш	16	
				Буган чулуун хөшөө	1	
				Мөнгөнтайга	1	

				хэлбэрийн булш		
				Хүнну булш	1	Хүннүгийн үе
				Зохион байгуулалтаа алдсан булш	4	Он цаг тодорхойгүй
6.	Өмнөговь аймгийн Гурвантэс сум	Гурвантэс сумын ЗДТГ	Тост-Тосонбумбын нуруу	Дөрвөлжин булш	1	Хүрэл зэвсгийн үе
				Шоргоолжин булш	1	
				Дугуй дараастай булш	15	
				Тахилын байгууламж	2	
				Хадны зураг	23	
				Монгол булш	9	Монголын үе
7.	Өмнөговь аймгийн Булган сум	Гайхамшигт говь АЖХ	Хавцгайтын ам	Хиргисүүр	6	Хүрэл зэвсгийн үе
				Дөрвөлжин булш	3	
				Шоргоолжин булш	7	
				Дугуй дараастай булш	10	
				Хадны зураг	1	
				Зохион байгуулалтаа алдсан булш	2	Он цаг тодорхойгүй
8.	**Нийт**				**371**	



Зураг 1. УБИС-ийн Археологийн тэнхимийн Авран хамгаалах хайгуул судалгаа явуулсан газруудын байршил

1. 2. 3. 4. 5. Увс аймаг Давст сум Гурван тэрмэс, 6. Төв аймаг Заамар сум Баян-Овоот уул, 7. Сонгинохайрхан дүүрэг Эмээлт уул, 8. Төв аймаг Заамар сум Бумбат-6, 9. Дархан-Уул аймаг Хонгор сум Төмөр толгойн орд, 10. 11.Сэлэнгэ аймаг Хүдэр сум Төмөртэйн орд, Авто замын трасс, 12. Сэлэнгэ аймгийн Ерөө сум Хуст уул, 13. Төв аймаг Алтанбулаг сум Ташгайн даваа, 14. Төв аймаг Алтанбулаг сум Сүүл овоот, 15. Булган аймаг Бүрэгхангай сум Ар тамсаг, 16. Булган аймаг Бүрэгхангай сум Туулын баруун дэнж, 17. Өмнөговь аймаг Гурвантэс сум Тост-Тосон бумбын нуруу, 18. Өмнөговь аймаг Булган сум Хавцгайтын ам

МҮМ-Н 2016 ОНД ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН АВРАН ХАМГААЛАХ СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Ж.Баярсайхан, Ц.Одбаатар, Ч.Баяндэлгэр, Т.Түвшинжаргал

Манай улсад уул уурхайн салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа билээ. Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.8-д заасны дагуу Монголын Үндэсний Музейн Эрдэм шинжилгээний төв 2016 онд хоёр удаагийн археологийн авран хамгаалах хайгуул судалгаа хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Өндөр-Улаан, Өндөр зэрэг газруудад “Редгранат”ХХК-ны захиалгаар археологийн авран хамгаалах хайгуул судалгаа хийж гүйцэтгэв. Хайгуулын явцад газрын хөрсөн дээр ил мэдэгдэхүйц эртний түүх соёлын дурсгал ажиглагдаагүй (Зураг-2) бөгөөд айлын хаваржаа, өвөлжөө цөөн хэд байна. Мөн талбайн өмнө захад 260 орчим м зайтай хүрэл зэвсгийн үеийн нэгэн булш байсан нь тус компаний талбайд орохгүй ажээ.

Зураг 1

Зураг 2

2. “Кожеговь” ХХК-ны захиалгаар Сүхбаатар аймгийн Онгон, Дарьганга, Асгат, Эрдэнэцагаан сумдын нутгийг хамарсан Хартойром, Ухаа-Овоо, Хүрээн, Хайрхан, Шүүт зэрэг нийт 5 талбайд (Зураг-1) археологийн авран хамгаалах хайгуул судалгаа хийж гүйцэтгэв. Хайгуул судалгааны үр дүнд:

Хар тойром: булш-832, Ухаа-овоо: тахилын байгууламж-2, сувагтай байгууламж-1, хороо-2, худаг-2, булш-14, Хүрээн: байхгүй, Шүүт: тахилын байгууламж-55, булш-320, хороо-2, Хайрхан: хөшөө чулуу-2, булш-184, хүн чулуу-1, худаг-1, айл-2, тахилын байгууламж-25, хороо-4, зассан чулуу-1-ийг илрүүлэн бүртгэсэн болно.

Сүхбаатар аймгийн Онгон, Дарьганга, Асгат, Эрдэнэцагаан сумдын нутаг “Хар тойром, Хүрээн, Ухаа-овоо, Шүүт, Хайрхан” зэрэг талбайгаас нийт түүх соёлын **1452** дурсгал бүртгэв.







Зураг 1

Зураг 2





Зураг 3

Зураг 4

Зураг 5. Чулуун хөшөө /Хайрхан/

Зураг 6. Хайгуулын талбай

2016 ОНД ШУА-ИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН АРХЕОЛОГИЙН АВРАН ХАМГААЛАХ ХАЙГУУЛ, МАЛТЛАГА СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Ч.Амартүвшин, Б.Батдалай, Д.Бөхчулуун

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн нь Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн (шинэчлэн найруулсан) 5-р бүлгийн 27-р зүйлийн 8-т “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах”, тус зүйлийн 9-т “Урьдчилсан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна” хэмээх заалтын дагуу 2016 онд ААН, байгууллага, хувь хүний захиалгаар 18 аймгийн 40 гаруй сумын нутагт нийт 56 удаагийн археологийн авран хамгаалах судалгааны ажлыг зохион явуулсан байна.

График 1. Авран хамгаалах судалгааны жилийн тоон үзүүлэлт

Хайгуул судалгаа. 2016 оны байдлаар 16 аймгийн 38 сумын нутагт 40 компани, ААН-ийн хүсэлтийн дагуу нийт 42 тусгай зөвшөөрлийн талбай, 3 автозамын шугамын дагуу археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажил зохион явуулж Баянхонгор аймагт 10, Говь-Алтай аймагт 27, Дорноговь аймагт 25, Дундговь аймагт 60, Өвөрхангай аймагт 29, Өмнөговь аймагт 146, Сүхбаатар аймагт 99, Төв аймагт 89, Увс аймагт 12, Улаанбаатар хотод 27, Хэнтий аймгийн нутагт 45 нийт 588 дурсгал шинээр илрүүлэн баримтжуулсан байна. Үүнд: чулуун зэвсгийн дурсгалт газар 4, хүрэл

зэвсгийн үеийн хиргисүүр 55, шоргоолжин булш 2, дөрвөлжин булш 74, чулуун дарааст булш 136, хадны зургийн дурсгалт газар 6, хүннү булш 51, түрэг булш 1, тахилын онгон 12, зэл чулуут дурсгал 5, монгол булш 91, харуулын цонж 1, чулуун байгууламж 84, чулуун хороо 1, барилгын турь 1, он цаг тодорхойгүй булш оршуулгын дурсгал 77 тус тус багтаж байна.



График 2. Авран хамгаалах хайгуул судалгаагаар илэрсэн дурсгалын тоон үзүүлэлт

Малтлага судалгаа. Нийт 6 аймгийн 7 сумын нутагт 5 удаагийн археологийн авран хамгаалах малтлага судалгаа явуулсан ба үүний 4 нь авто замын шугамын дагуу 1 нь уул уурхайн ашиглалтын талбайд хийгдсэн байна. Малтлага судалгаанд хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр 3, шоргоолжин булш 1, дөрвөлжин булш 12, хүрэл зэвсгийн үеийн хөшөө бүхий хашлага 3, хүрлийн үеийн булш 21, эртний бууц суурингийн дурсгал 1, хүннүгийн үеийн төмрийн хүдэр хайлуулж байсан зуух 1, түрэг булш 2, монгол булш 7, хотын турь 1, он цаг тодорхойгүй чулуун байгууламж 34 нийт 86 дурсгал хамрагджээ.



Газрын зураг. 2016 онд археологийн авран хамгаалах судалгаа хийсэн газрууд

Малтлага судалгаанд хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр, шоргоолжин булш, дөрвөлжин булш 10 гаруй хамрагдсанаас Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг хөндөгдөөгүй бүтэн оршуулга бүхий шоргоолжин булш малтаж цагаан шавар сувс, улаан өнгийн чулуун хув зүүлт зэрэг олдорууд илрүүлсэн бол Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт малтан судалсан дөрвөлжин булшнаас цөгцөн хэлбэрийн хүрэл тогооны хагархай, хүрэл зэв, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутаг Өвөр гүнтэд малтсан дөрвөлжин булшнаас хүний бүтэн оршуулга илрүүлжээ.

Харин дундад зууны үеийн монголчуудын үлдээсэн 7 булш малтан судалсанаас Өмөнговь аймгийн Гурвантэс сумын нутагт малтсан булшнаас хүрэл аяга, малгайн соновтор, богтаг малгай, модон эмээл зэрэг олдворууд илэрсэн бол Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг Гацууртын аманд малтан судалсан монгол булшнаас модон эмээл, төмөр хутга, хүрэл гаанс зэрэг сонирхолтой олдворууд илэрсэн байна.

МОНГОЛ-СОЛОНГОСЫН ХАМТАРСАН "СОЁЛЫН ӨВИЙГ СУДАЛЖ ХАМГААЛАХ" ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН

Н.Батболд, Д.Батсүх, Г.Энхбаяр

2016 оны 5-6 сард ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн "Хүрэл, төмрийн үеийн судалгааны салбар"-ын эрдэм шинжилгээний ажилтан, доктор Н.Батболд, магистр Д.Батсүх, Г.Энхбаяр, "Археологийн судалгааны төв"-ийн сэргээн засварлагч Н.Нандинцэцэг, "Угсаатан судлалын салбар"-ын эрдэм шинжилгээний ажилтан Н.Гонгоржав, ШУА-ийн Философийн хүрээлэнгийн харъяа Баян-Өлгий аймгийн Нийгэм, эдийн засгийн бодлогын салбарын түүх, хэл шинжлэлийн секторын эрхлэгч, доктор Б.Өмирбек, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн судлаач, доктор Хван Бүн Ён, Кан Со Хи, Ким Кеон Вү, Жү Ван Лип нарын судлаачид бүхий Монгол-Солонгосын хамтарсан "Соёлын өвийг судалж хамгаалах" төслийн баг Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Шивээт хайрхан уулын баруун урд энгэрт орших түрүү төмөр зэвсгийн үеийн нүүдэлчдэд холбогдох Пазырыкийн соёлын 2 булшийг малтан судаллаа. Бид өмнөх жил Баян-Өлгий аймгийн хэд хэдэн сумдын нутгаар бүртгэлийн ажил хийсэн бөгөөд энэ жил тус газарт малтлага судалгааны ажлыг хийхээр төлөвлөсөн байсан билээ [Батболд нар, 2015].

Шивээт хайрхан уулын энэхүү дурсгал нь Шивээт хайрхан уулын урд энгэрийн бэлд буй хадтай, жижиг довцгийн урд энгэрт, Хар чулуутын голын зүүн эргийн өндөр дэнж дээр хойноос урагш цуварсан байдалтай 3 ш пазырык булш, 12 ш эртний түрэгийн тахилгын байгууламж, 1 ш буган чулуун хөшөөнөөс тус тус бүрдэнэ. Хар чулуутын гол Шивээт хайрхан уулын өмнө орших том уулын хойд хаяагаар урсах ба ерөнхийдөө хоёр уулын дундах өргөн хөндийд эдгээр дурсгал байрлана.

Пазырык булшнуудыг хойноос урагш чиглэлтэйгээр 1, 2, 3 хэмээн дугаарлаж дэвсгэр зургийг үйлдсэн болно. Урд талын 2 булш цувраа байдлаар хаяа нийлэн орших бол харин тэдгээрийн хойд талын жижиг булш хойд талынхаас нь 20м-ийн зайд байрлаж байлаа. Тус жижиг булшийг дунд талын булштай 2 ш тахилгын байгууламжаар холбосон байв. Эдгээрийн 2, 3 дугаар булшнууд том хэмжээний дараас чулуутай.

1-р булш.

Цувраа гурван булшны хамгийн хойд талд оршино. Овгор, дугуй дараастай бөгөөд чулуун дараасын голч 8,8м, өндөр 0,5м. Малтлагын явцад богийн яс, эмх замбараагүй хаягдсан модон шургааг гарч байсан ба оршуулгын нүхийг тойруулан чулуугаар чигжин хүрээлсэн байв. Илэрсэн моднууд 110-155см урт, 20-30см өргөн, 14см зузаантай байлаа. Чулуун дараасаас доош 270см гүнд модон хайрцганд хийсэн ховд илэрсэн бөгөөд модон хайрцагны гадуур дунд зэргийн хэмжээтэй голын хайрган чулуудаар хүрээлж нүхний хойд талын төв хэсгээр нарийн хавтгай чулуудаар

баруунаас зүүн тийш эгнүүлэн хашсан нь нарийн ширхэгтэй хайрган чулуун хөрсийг нурахаас хамгаалсан бололтой.

Хүнийг толгойгоор нь зүүн хойш хандуулан, тэнэгэр байдлаар дээш харуулж зүүн хөлийг өвдгөөр нь бага зэрэг нугалаад хоёр гарыг тохойгоор нугалан ташаан дээр тавьсан байдлаар оршуулжээ. Модон хайрцгийн зүүн хойд буланд буюу хүний толгойн хаpалдаа улаан өнгийн будагтай хагарсан шавар сав, бог малын ууцны ясны хэсгүүд тус тус илрэв. Тахилын идээ болох махны дор модон цар нь ялзарч алга болсон. Шавар савын бөөрцгийн хэсэг дээр нэг үзүүрийг мушгин эргүүлж үзүүрийг шулуун доош буулган өөд өөдөөс харуулж хээлсэн хээ тодорхой мэдэгдэнэ. Шалгалтын явцад модон хайрцгийн зүүн хойд хэсгийн дороос төмөр хутга илэрсэн нь хадгалалт муу байв.

Булшны нүхний хэмжээ: 340×220см, модон хайрцгийн урт 240см, өргөн баруун захаар 100см, төвөөр 90см, зүүн захаар 110см, өндөр 20-27см байв. Ховдны урт 200см, өргөн 40см, өндөр 12см. Энэ булш тоногдоогүй байснаараа нэлээд их чухал ач холбогдолтой дурсгал болно.

Хүний ясны хадгалалт харьцангуй сайн байсан ба ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн "Археологийн судалгааны төв"-ийн антропологч Ц.Амгалантөгс 40-45 настай, 168 (±3.27) см өндөртэй эрэгтэй хүн хэмээн тодорхойлсон байна [Амгалантөгс, Дэлгэрмаа, 2016: 1]. Мөн тус төвийн палеозоологч Л.Дэлгэрмаа тус булшнаас илэрсэн бог малын ясанд судалгаа хийж 1-2 настай 2 хонины ясыг дагалдуулсан хэмээн тодорхойлсон байна [мөн тэнд: 3].

2-р булш.

Өндөр, овгор дугуй дараастай булш. Дараасын төвд хонхор бөгөөд голч нь 18,2м, өндөр 1м юм. Энэхүү булшны зүүн талд талд 1м зайд эртний түрэгийн 4 ш тахилгын байгууламж байх бөгөөд тэдгээрт тус булшны дараас чулуунаас авч ашигласан байна. Малтлагын явцад чулуун дараасын анхны хязгаарыг гаргасан бөгөөд том хавтгай, урт чулуудаар хаяаг хашсан байсан нь цаг хугацааны явцад нурж унасан бололтой. Хэрэв үүгээр дараасын голчийг хэмжиж үзвэл 14,7м болж байна. Мөн чулуун дараасын захад хавтгай чулуудыг дараасын төв рүү чиглэсэн байдлаар босгон тасалгаа маягтай хийсэн зохион байгуулалт байсан бололтой ажиглагдав. Гэвч үүнийг баттай байсан эсэхийг дараагийн малтлага судалгаагаар тодруулах болно.

Малтлагын явцад 3 хэсэг газарт галын ором, бог малын шатсан яс, эмх замбараагүй байдалтай тарсан нарийн гуалин, хойноос урагш хөндөлдсөн шургааг, шилмүүст модны жижиг навч зэрэг гарсан байсан нь уг булш маш их тоногдсоныг илтгэж байв. Чулуун дараасаас доош 3,8 метрийн гүнд том гуалинг цавчин 2 хуваагаад дээр нь углуурга гарган банз хийж эвлүүлэн угсарсан бунханд насанд хүрсэн 2 хүн, 1 хүүхдийг хамт оршуулсан байжээ. Гэвч булш эрт цагт тоногдсон тул бүх зүйл самрагдан холилдсон байв. Малтлагын явцад тус оршуулгад 3 морь дагалдуулсан нь тодорхой болсон ба бугын эвэр, 3 янзын шавар сав, 3 ш төмөр хутга, хазаарын төмөр амгай 2 ш, ясан арал 1 ш, хазаарын модон унжлага 1 ш, сүлжмэл эдлэлийн хэсэг зэрэг

зүйлсийг тус тус дагалдуулсан байлаа. Мөн энэхүү булш хагас цэвдгийн байдалтай байсан нь малтлагын явц харьцангуй удаан явагдахад хүргэсэн болно. Насанд хүрсэн хүмүүсийн гавал, дунд чөмөгний яс анхны байрлалаар үндэслэвэл хүнийг толгойгоор нь зүүн хойш хандуулан оршуулсан байжээ. Хүн морины толгойг нэг чигт хандуулсан байв. Бунханы хэмжээ: 232см урт, толгой талдаа 105см өргөн, хөл талдаа 72см өргөн, 30-32см өндөр байжээ.

Булшнаас илэрсэн хүний ясанд хийсэн судалгаагаар a) 50-55 настай эрэгтэй хүн, b) нурууны нугаламд остеохондрозийн шинж тэмдэгтэй, 65 насны эрэгтэй хүн, c) 6-8 орчим настай хүүхэд гэсэн гурван хүн оршуулсан болохыг тус тус тогтоосон [мөн тэнд: 1-3] болно.

Дүгнэлт

Энэ жил тус хээрийн шинжилгээний анги далайн түвшинөөс дээш 2466 метрийн өндөрт ажиллаж хагас цэвдэгтэй булшийг малтан шинжилсэн болно. Энэхүү булшны гадаад бүтцэд зарим онцлог шинжүүд илэрсэн тул зохион байгуулалтыг тодруулахаар нэлээд хичээн ажилласан юм. Иймд ажиллах цаг хугацаа, хүч бололцоондоо тааруулан төмөр зэвсгийн түрүү үеийн нүүдэлчдэд холбогдох 3 булшны хамгийн том болон жижиг хэмжээтэй 2 дурсгалыг сонгон малтав. Ийнхүү малтсан 2 булш маань хоёул төмөр зэвсгийн түрүү үеийн нүүдэлчдэд холбогдох булш болох нь олон үзүүлэлтээр тодорхой болсон боловч оршуулгын зан үйлийн хувьд зарим нэг сонирхолтой зүйлс ажиглагдав. Тухайлбал, 1-р булш тоногдоогүй ба адуу дагалдуулаагүй байснаараа онцлог байв. Мөн эдгээр булшнууд 20 метрийн зайтай байсан хэдий ч хадгалалтын нөхцөл байдал эрс тэс өөр байлаа. Энэхүү хоёр булшнаас нийт 4 хүн, 3 морины яс болон хангалттай олон судалгааны хэрэглэгдэхүүн, оршуулгын зан үйлийн сонирхолтой элементийг бүрдүүлж авсан нь судалгааны чухал ач холбогдолтой хэрэглэгдэхүүн болно. Бид цаашид он цаг, паталог болон генетикийн нарийвчилсан судалгааг үргэлжлүүлэн хийх бөгөөд бүтэц зохион байгуулалтын ажиглалтуудыг цааш улам гүнзгийрүүлэн судлах болно. Мөн энэ жил INSPIRE 1 дроныг ашиглан баримтуулалтын ажлыг гүйцэтгэсэн. Хэдийгээр бидний ажиллах явцад цаг агаарын хүндрэл, саад бэрхшээл тохиолдож байсан боловч цаг хугацаандаа ажил үүргээ хангалттай гүйцэтгэсэн болно. Мөн ирэх жилийн хувьд үлдсэн 3 дугаартай булшийг малтан судлах юм.

Ашигласан ном бүтээл

Амгалантөгс, Дэлгэрмаа, 2016 - Ц.Амгалантөгс, Л.Дэлгэрмаа. Баян-Өлгий аймаг, Цэнгэл сум, Шивээт хайрханы 1, 2-р пазырык булшны хүн, малын ясанд хийсэн судалгааны тайлан //Түүх, археологийн хүрээлэнгийн баримт, мэдээллийн сан. УБ., 7 тал.

Батболд нар, 2015 - Н.Батболд, Б.Өмирбек, Л.Эрдэнэбат. Монгол-Солонгосын хамтарсан “Соёлын өвийг судалж хамгаалах” төслийн 2015 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. //Түүх, археологийн хүрээлэнгийн баримт, мэдээллийн сан. УБ.

Баян-Өлгий аймаг, Цэнгэл сум, Шивээт хайрханы ерөнхий байдал

Шивээт хайрханы дурсгалт газрын ерөнхий байдлын агаарын зураг

Малтан судлахын өмнө (урдаас)

Малтлага хийж буй үеийн агаарын зураг

1-р булшны оршуулга

2-р булшны оршуулга

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН “БАРКОР” ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Гантулга, У.Бросседер

Монгол-Германы хамтарсан “БАРКОР” төслийн хээрийн шинжилгээний анги Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутаг Майхан толгой хэмээх газарт 2016 оны 05-р сарын 20-ноос 06-р сарын 20 болон 08-р сарын 21-нээс 09-р сарын 21-ний өдөр хүртэл хоёр удаа нийт 60 хоног малтлага судалгаа хийв.

Дурдсан хугацаанд Майхан толгойд булш, хиргисүүр, тахилгын байгууламж, чулуун зураа зэрэгнийт 14 дурсгал малтан шинжилсэн болно. Эдгээрээс 7, 9, 24, 50, 65А, В, 66, 67, 106-р дурсгал нь хүрэл, түрүү төмрийн үед холбогдох оршуулга, тахилгын байгууламж, 19, 111-р дурсгал нь эртний түрэгийн үед холбогдох булш, тахилгын байгууламж юм. Түүнчлэн оршуулгын дурсгалт газарт орших чулуун зураанд хамаарах зууван хэлбэрт чулуун байгууламж болох 86, 115-р дурсгалыг малтсан болно.

Малтан судалсан 7, 9, 24, 65 а, в, 66, 67-р дурсгалаас тус бүр оршуулга илэрсэн бол 106-р чулуун байгууламжаас ямар нэг тахилгын ул мөр илрээгүй. Харин 66-р булшны хүрээний гадна тал болон зүүн урд талын дугуй байгууламжийн хажуугаас бог, бод малын яс, 67-р хиргисүүрийн хүрээний гадна, дотор, булангийн хөшөө чулууны хажуу,голын овгор дараас дундаас бог, бод малын яс тус тус олдсон болно. Эдгээрээс гадна Майхан толгойн оршуулгын газарт өнгөрсөн жил илрүүлсэн чулуун зурааг үргэжлүүлэн хэмжиж баримтжуулав. (Зураг 1, Хүснэгт 1).

Булш

7-р булш. Энэхүү дурсгал нь жижиг хэмжээтэй дөрвөлжин булш юм. Хашлаганы 4 булангийн хөшөө чулуудаас зүүн талынх нь хажуу тийш налж унасан байна. Хойд талын хашлаганд шахаж тавьсан булшны нүхний таг болох гурван том хавтгай чулууны доороос өргөргийн дагуу буюу 90° чиглэлтэй 80см гүн нүхнээс хүүхдийн оршуулга илэрсэн. Нас барагчийг дээш харуулан тэнэгэр байдлаар тавьжээ. Хүүхдийн яснаас нурууны 3 үе, сүүж, хоёр дунд чөмөг үлдсэн ба ясны хадгалалт нь дунд зэрэг. Булшны нүхнээс хясаа(?) -ны ясаар хийсэн зүүлтний сондор 9 ш, улаан өнгийн чулуун (хув?) сондор 1 ш тус тус олдсон (Зураг 2, Хүснэгт 1).

9-р булш. Энэ дурсгал нь дугуй хэлбэртэй, намхан чулуун дараастай булш юм.Дараасны хүрээг том чулуугаар хийж түүний доторх зайг том чулуугаар дүүргэж дээрээс нь жижиг чулуугаар чигжиж гадаргууг тэгшилжээ. Дараасны төв хэсгээс булшны нүхийг тагласан 3 том чулуу гарсан ба түүний доороос 325° чиглэлтэй, 77см гүн,хавчиг нүхэнд оршуулга үйлджээ. Нас барагчийг баруун хойш хандуулан, баруун хажуугаар нь, нүүрийг баруун тийш харуулж хэвтүүлээд хоёр гарыг нь биеийн урд давхарлан тавьж оршуулжээ. Энэхүү булш нь огт хөндөгдөөгүйгээс гадна хүний яс сайн хадгалагдсан байна. Нас барагчид эд өлгийн зүйл дагалдуулаагүй бололтой (Хүснэгт 1).

19-р булш. Энэхүү дурсгал нь эртний түрэгийн морьтой оршуулга юм. Булшны дараас нь дугуй хэлбэртэй, дунд хэсгээрээ хонхойсон нь эрт цагт тоногдсон байж болохыг илтгэнэ. Дараасыг авахад том жижиг хоёр давхар цагариг хэлбэртэй чигжээс чулуу илрэв. Чигжээсийг том чулуугаар хийж хоорондын зайг жижиг чулуугаар дүүргэжээ. Булшны гол хэсгээс зууван хэлбэрийн 38-85 см гүн нүхнээс толгойг нь баруун хойш хандуулан хоньчлон хэвтүүлсэн адууны бүтэн яс гарав. Адууны ясны зүүн талд оршуулга байрлах боломжтой сул зай байх боловч хүний яс илэрсэнгүй, энэ хэсгээс гурван дэлбээт төмөр зэв 1 ш, ясан чагт 3 ш олдсон (Зураг 3, 4, Хүснэгт 1).

24-р булш. Уг дурсгал нь дөрөө хэлбэрийн булш юм. Гонзгой урт чулууг дөрөө маягийн хэлбэр үүсгэн 1-2 үе давхарлан өрж түүний дотор гадна талыг жижиг чулуугаар дүүргэжээ. Булшны гол хэсгээс зүүн хойш 80° чиглэлд ухсан нүхнээс түрүүлгэ нь харуулсан оршуулга илэрсэн. Булшны нүхний толгой талаас ороомог хэлбэртэй алтан эдлэл 1 ш, нүхний хөл талаас оюу сондор 1 ш, цагаан өнгийн сондор 1 ш тус тус илэрч олдсон. Хүний ясны хадгалалт маш муу, бүрэн бус байв (Зураг 5. 1, 2, Хүснэгт 1).

65А, В булш. Энэхүү хоёр дурсгал нь зэрэгцэн орших ба дугуй хэлбэрийн овгор чулуун дараастай булшнууд юм. Хоёр булшны гол хэсэгт зүүн урагшаа буюу 115°, 107° чиглэлд ухсан нүхнүүдээс түрүүлгэ нь харуулан тавьсан хоёр оршуулга илэрсэн (Хүснэгт 1).

66-р булш. Тус булш нь зууван дугуй хэлбэрийн дараастай Сагсай хэлбэрийн булш юм. Дараасны дөрвөн талд байрлах хөшөө чулууд гадуураа зууван хэлбэрийн чулуун байгууламжтай. Хөшөө чулуудаас зөвхөн баруун урд талын хөшөө болон чулуун байгууламж нь эвдэгдсэн. Булшны голын чулуун дараасны дороос баруун хойноос зүүн урагшаа буюу 335° чиглэлд ухсан 103 см гүн нүхнээс оршуулга илэрсэн. Хүний ясны хадгалалт маш муу, зөвхөн гавлын ясны хэсэг, нуруу, хавирганы зарим хэсэг л хадгалагдан үлджээ. Эдгээр ясны байрлалаас харахад нас барагчийг зүүн хажуугаар нь тавьж оршуулсан бололтой. Мөн баруун урд талын эвдэгдсэн байгууламжийн үлдэгдэл чулууны хажуугаас богийн яс, зүүн урд талын байгууламжийн хөшөө чулууны хойд талаас бодын ясны үлдэгдэл гарав (Хүснэгт 1).

67-р хиргисүүр. Уг хиргисүүр нь оршуулгын газрын урд хэсэгт байрлах ба дөрвөлжин хүрээтэй, хүрээний хойд талдаа цагираг хэлбэрийн 9-10, хүрээний урд талдаа битүү чулуун дарааст нэг тахилгын байгууламжтай. Тус хиргисүүрээс оршуулга илэрсэн. Нас барагчийг дээш харуулан тэнэгэр байдлаар хэвтүүлж, хоёр гарыг биеийг дагуулантавьж баруун хойш буюу 330°-т хандуулан оршуулжээ. Хүний ясны хадгалалт харьцангуй сайн. Дөрвөлжин хүрээний булан болон гадна дотор талаас бог, бод малын ясны хэсгүүд олдсон. Мөн голын овгор дараас чулуун дундаас боржин чулууг засч хийсэн бөмбөлөг хэлбэрт эдлэл 2 ш гарсан. Энэ жил цаг хугацааны боломжоос шалтгаалан тахилгын байгууламжуудыг малтан судалж амжаагүй болно (Хүснэгт 1).

Тахилгын байгууламж

50-р хиргисүүрийн тахилгын байгууламж. Энэхүү хиргисүүр нь дөрвөлжин хүрээтэй, хойд талдаа зүүнээс баруун тийш цуварсан 10 гаруй тахилгын байгууламжтай. Тэдгээрээс бид 7 тахилгын байгууламжийг малтан шинжлэхэд хамгийн зүүн талын нэг байгууламжаас 16см гүнээс шатсан ясныхэсэг 1 ш гарснаас өөр зүйл илэрч олдоогүй. Тахилгын байгууламжийг 3-5 чулуу ашиглан хийсэн байна (Зураг 7, Хүснэгт 1).

106-р дурсгал. Энэхүү дурсгал нь зууван дугуй хэлбэртэй чулуун байгууламж юм. Малтлагын явцад ямар нэгэн тахилгын ул мөр илрээгүй (Хүснэгт 1). Энэ нь 10-р дурсгал (дөрвөлжин хэлбэрийн чулуун дарааст тахилгын байгууламж) -ын зүүн талд оршино. 10-р дурсгалыг 2012 онд малтан шинжлэхэд цөөн тооны шатсан ясны үлдэгдэл гарсан болно.

111-р дурсгал. Тус дурсгал нь дөрвөлжин хашлагатай, хөшөө чулуу бүхий тахилгын байгууламж юм. Хөшөө чулуу нь голоороо хугарч, цуурснаас гадна хашлага чулууд нь гадагш налж унажээ. Хөшөөний баруун хажуугаас 11см гүнээс хавтгай төмөр зэв 1 ш олдсоноос өөр зүйл илрээгүй (Зураг 6, Хүснэгт 1).

Чулуун зураа

Майхан толгойн оршуулгын газарт өнгөн хөрсөн дээршугам мэт цувуулан байрлуулсан чулуун зураа тохиолддог нь зарим хэсэгтээ жижиг чулуун байгууламжтай мэт байдаг. Тэдгээр нь оршуулгын газрын гадаад хүрээ эсвэл булшны бүлэг тус бүрийг заагласан шугам мэт үзэгдэнэ. Шугам татсан чулууд нь хэмжээгэр жижиг тул зарим хэсэгтээ хөрсөнд дарагдаж мэдэгдэхгүй болсон байдгаас нийт хэмжээ, байршил, зориулалтыг тодорхойлоход хүндрэлтэй юм. Гэсэн хэдий ч бид хээрийн судалгааны явцад өөрсдийн ажиглалтад үндэслэн илэрсэн чулуун зураа бүрийг нягтлан шат дараатай хэмжин баримтжуулж оршуулгын газрын дэвсгэр зурагт байрлуулах, зарим хэсэгт сорилтын малтлага хийж зориулалт, хамрах хүрээг тодорхойлохыг зорьж байгаа билээ. Энэ удаад оршуулгын газрын баруун талд хойноос урагш чиглэлтэй байрлах чулуун зураа бүхий хоёр газарт сорилтын малтлага хийв.

86, 115-р дурсгал. Дэвсгэр зурагт чулуун зурааны зууван хэлбэртэй хоёр байгууламжийн хойд талынхыг 86, урд хэсэгт орших нэгийг 115 гэж дугаарлан бүртгэж баримтжуулсан юм. Малтлагын явцад 86-р байгууламжийн урдаас,мөн дээрх хоёр байгууламжийн (86, 115) голд байрлах ганц нэг чулууны хажуугаас малын яс (?)-ны жижиг хэсгүүд илэрч олдсоноос өөр зүйл гараагүй болно (Зураг 8, Хүснэгт 1). Дээрх байдлаас үзвэл ямар боловч чулуун зураа болон зууван байгууламжийг газрын өнгөн хөрсөн дээр байрлуулдаг, нүх ухаж тахилгын зүйлс хийдэггүй нь мэдэгдсэн.

Үүний дараа дээрх чулуун зураанаас хойшоо 263м зайд, нилээд урт үргэлжлэх чулуун зурааны зарим хэсэгт 20см гүн сорилтын малтлага хийв. Энэ хэсгийн чулуудыг нилээд эмх цэгтэй 324° чиглэлд цувруулан тавьжээ. Уг сорилтын малтлагаас тахилгын ул мөр илэрсэнгүй (Зураг 9).

Энэ жилийн малтлага судалгаагаар илэрсэн хүн, малын ясны дээжийг ХБНГУ-ын Мюнхен хотын Людвиг Максимиланы их сургуулийн Био төв, Биологийн I тасгийн лабораторид радио-карбоны аргаар он цаг тогтоох, изотопын судалгаа хийлгэхээр илгээгээд байна.

Хүснэгт 1

Малтан шинжилсэн дурсгалуудын товч мэдээллийн хүснэгт

№	Дурсгалын дугаар	Дурсгалын төрөл	Дараасны хэлбэр хэмжээ (см)	Хашлаганы хэмжээ (см)	Нүх			Хүний яс	Малын яс	Олдвор
					Хэмжээ (см)	Чиглэл	Гүн (см)			
1	7	Дөрвөлжин булш	Дөрвөлжин 400x420	230x240	51x128	90°	80	Хүүхдийн хоёр дунд чөмөг, сүүж, нуруу яс 3 ш	-	Хясааны (?) ясаар хийсэн зүүлтний сондор 9 ш, улаан өнгийн чулуун (хув ?) сондор 1 ш
2	9	Булш	Дугуй 1350x1390	-	44x170	325°	77	Гар хөлийн үений жижиг яснаас бусад нь бараг бүрэн	-	
3	19	Түрэг булш	Дугуй 744x750	423, 577	144x175	-	38-85	-	Адууны яс	Гурван дэлбээт төмөр зэв 1ш, ясан чагт 3 ш
4	24	Дөрөө хэлбэрийн булш	Зууван дугуй 600x630	280x300	60x170	80°	50-74	Хоёр гарын бугалга, шуу, хавирганы хугархай, сүүжний хэсэг, хоёр дунд чөмөг	-	Оюу сондор 1ш, цагаан өнгийн сондор 1ш, пүрш хэлбэрийн алтан эдлэл 1ш
5	65а	Булш	Дугуй 495x527	146x257	60x188	115°	41	Хоёр гарынбугалга, шуу, нуруу, сүүжний хэсэг, хоёр дунд чөмөг	Богийн шагай	Чулуун зэвсгийн зүйл 1 ш
6	65в	Булш	Дугуй 577x581	-	70x182	107°	103	Хүзүү, хоёр гарын	Бодын шагай	-

№	Дурсгалын дугаар	Дурсгалын төрөл	Дараасны хэлбэр хэмжээ (см)	Хашлаганы хэмжээ (см)	Нүх			Хүний яс	Малын яс	Олдвор
					Хэмжээ (см)	Чиглэл	Гүн (см)			
								бугалга, шуу, нуруу, хавирга, сүүж, дунд чөмөг, шилбэ, хоёр өсгий, хөлийн сарвууны яс		
7	66	Сагсай хэлбэрийн булш	Зууван дугуй 2030, 760	300x380	61x209	335°	103	Хүүхдийн (?) гавлын ясны хэсэг, нуруу, хавирганы үлдэгдэл	Бог, бодын ясны жижиг хэсгүүд	-
8	67	Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр	Дөрвөлжин 1100x1400,	320x450	70x190	330°	63	Гар хөлийн үений жижиг яснаас бусад нь бараг бүрэн	Бог, бодын ясны хэсгүүд	Боржин чулуун бөмбөлөг 2ш
9	106	Чулуун байгууламж	Дугуй 330x340	-	-	-	-	-	-	-
10	111	Тахилгын байгууламж	Дөрвөлжин	82x91	-	-	11	-	-	Төмөр зэв 1 ш
11	86	Чулуун зураа	Зууван дугуй 217	-	-	-	-	-	Бодын ясны хэсэг	-
12	115	Чулуун зураа	Зууван дугуй 230	-	-	-	-	-	-	-
13	-	Чулуун зураа	Цуварсан -	-	-	324°	20	-	-	-
14	50	Тахилгын байгууламж	Цагираг 52-70	-	-	-	16	-	Шатсан ясны жижиг хэсэг	-

Зураг 1. Майхан толгойн дурсгалт газрын дэвсгэр зураг

Зураг 2. 7-р булшнаас илэрсэн хясааны ясан зүүлтний сондор

Зураг 3. 19-р булшнаас илэрсэн ясан чагт

Зураг 4. 19-р булшнаас илэрсэн гурван дэлбээт төмөр зэв

1. 2.

Зураг 5. 24-р булшнаас илэрсэн олдворууд:
1. Ороомог хэлбэртэй алтан эдлэл, 2. Оюу сондор

Зураг 6. 111-р дурсгалаас олдсон төмөр зэв

Зураг 7. 50-р хиргисүүрийн тахилгын байгууламжууд

Зураг 8. Сорилтын малтлага хийсэн 86, 115-р дурсгал буюу чулуун зураа

Зураг 9. Сорилтын малтлага хийсэн чулуун зурааны хэсэг

"БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТОЗАМЫН ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ"-ИЙН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АРХЕОЛОГИЙН АВРАН ХАМГААЛАХ МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

А.Энхтөр, Я.Цэрэндагва, Д.Батсүх, Л.Мөнхбаяр, Т.Батбаяр, Г.Батболд, Б.Эрдэнэ, Т.Хантөгс, С.Далантай, Б.Энхбаяр

ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний анги 2016 оны 10 дугаар сарын 5-наас 11 дүгээр сарын 5-ныг дуустал нэг сарын хугацаанд Ховд аймгийн төвөөс Баян-Өлгий аймгийн төв чиглэлийн шинээр тавигдаж буй авто замын трасст орсонАлтайн бүс нутгийн эртний нүүдэлчдийн түүхэнд холбогдох нийт 42 дурсгалыг малтан судлав. Мөн археологийн хайгуул судалгаагаар тус замын трасс дайран өнгөрч байгаа чулуун зэвсгийн 2 дурсгалт газрыг шинээр нээн илрүүлэн олж,512 ширхэг чулуун зэвсэг түүвэрлэн цуглуулж төрөл зүйлээр нь ангилан чулуун зэвсэг үйлдвэрлэлийн байдлыг нэхэн сэргээх судалгааг хийв. Тус хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд Соёлын өвийн төв, Ховд аймгийн музей, Ховд их сургууль зэрэг байгууллагын эрдэмтэн судлаачид оролцон хамтран ажиллав.

Малтан судалсан 42 дурсгалын 20 нь хүрэл зэвсгийн үед холбогдох булш оршуулга, 16 нь хүрэл зэвсгийн үеийн чулуун байгууламж, 3 нь хүрэл зэвсгийн үеийн хөшөө бүхий хашлага, 2 нь түрэгийн үеийн булш, 1 нь эртний овоо байв. Замын трасс дайран өнгөрч байгаа чулуун зэвсгийн 2 дурсгалт газраас түүвэрлэн цуглуулсан чулуун зэвсгийн олдворуудад хийсэн төрөл зүйн ангилал, боловсруулалтаас харахад эдгээр нь дунд палеолитоос дээд палеолитод шилжих шилжилтийн үеийн чулуун зэвсгийн залтсан арга барил дээр суурилсан томоохон дурсгалт газар болох нь батлагдаж байна.

Судалгааны ангийн бүрэлдэхүүн

Нийт 8 газар хүрэл зэвсгийн үеийн 20 булш малтан судалсан бөгөөд эдгээр нь ихэнхдээ ямар нэг оршуулгын газарт хамаарах трасст өртсөн ганц нэг дурсгал болно. Цөөн тохиолдолд дангаараа байрлаж байсан. Нэг тохиолдолд 15 дурсгал бүхий оршуулгын газрыг цогцоор нь Хонгиогийн голд малтан судлаж энэ үеийн палеоантропологийн ховорт тооцогдох баялаг хэрэглэгдэхүүнийг цуглуулсан юм. Малтан судалсан энэ төрлийн булшнууд гадаад зохион байгуулалтаараа үндсэн хоёр төрөлд хуваагдана. Үүнд, нэгдүгээрт голдоо овгор өндөр зузаан овоолго бүхий дугариг чулуун дараастай булш. Зарим тохиолдолд голын овгор дараасны дундаас авсны таг чулууд ил цухуйж байсан онцлогтой. Ийм булшны дараасны хөвөөг ихэвчлэн том чулуугаар хөвөөлсөн болох нь ажиглагдсан. Харин нөгөө хоёрдугаар төрлийн булш гадаад зохион байгуулалтаар дээрхээс ихээхэн ялгаатай. Нэгээс хоёр үе бүхий намхан дүгрэг болон дөрвөлжин хэлбэрийн битүү чулуун дараастай бөгөөд дараасны захыг том чулуугаар хүрээлэн хашиж өгсөн байдаг. Зарим булшны дөрвөн талд газарт унасан хөшөө чулуу мэдэгдэж байсан онцлогтой. Ихэнхдээ дараасны төвөөс зүүнээс баруун тийш чиглүүлэн тавьсан авсны таг мэдэгдэх төдий ил цухуйсан байсан нь бас нэг онцлог болох юм. Эдгээр хоёр төрлийн булшны дараасын хэмжээ дундажаар 20-190 см бүхий зузаантай 4-17 метрийн голчтой байжээ.



Малтлагын явцыг агаараас авсан гэрэл зураг

Эдгээр булшны дараас болон тагны доор баруун ба баруун хойд зүгт чиглүүлэн үйлдсэн оршуулгын нүх бүхий дөрвөн тал чулуун хашлага бий нь нийтлэг байдал болно. Гэхдээ цөөн ганц нэг тохиолдолд газрын өнгөн хөрсөн дээр талийгаачийг тавьсан тохиолдол гарсан. Эдгээрээс түрүүлгэ нь харуулсан, нүүрийг нь урагш

харуулан баруун хажуугаар нь тавьсан, нүүрийг хойш хандуулан зүүн хажуугаар нь тавьсан оршуулгууд тус тус илэрсэн байна. Оршуулгын зан үйлтэй холбоотой өвөрмөц нэг онцлог байдал ажиглагдсан нь нэлээд олон тохиолдолд хүний гар эсвэл хөлийг зөрүүлж буюу солбиулж тавьсан байв. Бараг бүх булшнаас огт тоногдоогүй бүрэн бүтэн оршуулга гарсан бөгөөд зөвхөн баруун ба баруун хойд зүгт чиглүүлэн тавьсан байна. Эдгээрийн 3 нь балчир хүүхдийн оршуулга байсан бөгөөд насанд хүрсэн хүний адилаар зан үйл үйлдэж оршуулдаг байсан нь илэрхий болсон билээ. Эдгээрийн оршуулгын нүх нь дундажаар 30-70 см хүртэл гүнтэй, харин авс буюу чулуун хашлагын ханыг чулуугаар 1-6 давхарлаж өрсөн байсан нь тус бүрдээ 1-3 хүртэлх эгнээ өрлөг бүхий байв. Зарим нүхний ёроолд тусгайлан элс дэвсэж тэгшилсэн байсан ба авс болох чулуун хашлагын доторх хөндий зайг ихэнхдээ жижиг чулуулагтай дан шороогоор дүүргэсэн байжээ.



Хүрэл зэвсгийн үеийн эдгээр булшны 11 дурсгалаас үр тариа цайруулах самбар чулуу, бог болон бод малын яс, богийн шагай, шавар ваарны хагархай, хүрэл болон төмөр зэв, хүрэл эдлэлийн хэлтэрхий зэрэг эд өлгийн зүйл гарчээ. Гэхдээ ихэнх тохиолдолд оршуулгын түвшинд ямар нэгэн дагалдуулсан эд зүйлс илэрч мэдэгдээгүй байна.

Ийнхүү Монгол Алтайн бүс нутагт малтан судалсан гадаад хэв шинжийн хувьд үл мэдэг ялгаатай хоёр төрлийн булшны малтлага судалгааны үр дүнгээс үзэхэд энэ нь хоорондоо оршуулгын зан үйлийн хувьд онц ялгаагүй байлаа. Иймээс бид урьдчилсан байдлаар хүрэл зэвсгийн шилжилтийн үеийг харуулах нэг төрлийн хоёр өөр он цагийн дурсгал байж болох юм хэмээн таамаглаж байна.

Нийт малтан судалсан 42 дурсгалаас 16 нь хүрэл зэвсгийн үеийн байгууламж байсан бөгөөд үүрэг зориулалтын хувьд тахилга тайлгын дурсгалд хамаарна хэмээн бид үзлээ. Эдгээр дурсгалууд гадаад зохион байгуулалтаараа дүгрэг болон тэгш дөрвөлжин өнцөгт гэсэн үндсэн хоёр төрөл бий. Нэгдүгээр төрөл нь булш мэт дүгрэг чулуун дараастай. Ийм төрлийн хэд хэдэн томоохон дурсгалын голын овгор дараасны доороос огт тоногдож хөндөгдөөгүй таг бүхий бүрэн бүтэн хов хоосон авс буюу хашлага илэрч мэдэгдсэн нь ихээхэн сонирхолтой юм. Харин заримаас нь ямар нэгэн олдворгүй жижигхэн нүх, ганц тохиолдолд дараас дотроос ваарны хагархай олджээ. Гэхдээ ихэнхдээ ямарч олдворгүй зохион байгуулалт бүхий өрлөг зонхилж байна. Дараасны голч нь 4,5-19 м хүртэлх хэмжээтэй ажээ.

Хоёрдугаар төрлийн тэгш өнцөгт дөрвөлжин байгууламжууд нь нэгээс хоёр үе бүхий намхан чулуун дараастай бөгөөд дараасны захыг хавтгай чулуугаар хашиж өгсөн байдаг. Энэ төрлийн хашлаган дотроос нэг тохиолдолд галын ором илэрчээ. Бусад тохиолдолд зөвхөн өрлөгийн зохион байгуулалт мэдэгджээ. Энэ төрлийн байгууламжууд 180х220-320х470 см хэмжээтэй. Өгүүлэн буй хоёр янзын хэлбэр бүхийдурсгалуудтай үүрэг зориулалтын хувьд ижил төрлийн байгууламжууд илэрхий танигдах хүрэл зэвсгийн үеийн оршуулгын газарт, эсвэл түүний ойролцоо ганц нэгээрээ онцгой орших тул он цагийн хувьд дурдсан үед хамаарах нь дамжиггүй юм.

Хавтгай чулуугаар дөрвөлжлөн үйлдсэн хашлага чулуут 3 дурсгал малтан судалсныг хүрлийн үед холбогдох тахилын байгууламж хэмээн үзсэн болно. Учир нь эдгээр дурсгалууд хүрлийн үеийн дурсгалын ойр орчимд байрлахаас гадна малтан судалсан хүрлийн үеийн булшнуудтай нэг дор цогцолбор маягаар оршиж байна. Эдгээр хашлагууд бүгд дотор талдаа 1-2 хөшөөтэй байсны ул мөр малтлагын үед мэдэгдсэн төдийгүй унасан хөшөө чулууд одоо ч хашлагын дотор болон ойролцоох газарт сул хэвтэж байв. Эдгээр хөшөөний дээр ямар нэгэн дүрслэл байхгүй. 3 хашлагаас нэг нь бүтэн хадгалагдсан бол бусад нь эвдэгдэж зохион байгуулалтгүй болсон байв. 270х220 см хэмжээ бүхий бүтэн хашлагын өмнө талаас цувраа 3 жижиг цагирган байгуулж мэдэгдсэний бүгдийнх нь дотроос галын ором маш тодорхой илэрсэн нь тухайн дурсгалуудын үүрэг зориулалтыг тодруулахад чухал баримт болсон билээ.

Малтан судалсан 2 түрэг булш хоёулаа хүрэл зэвсгийн үеийн булшны дараасан дороос гарсан оруулмал оршуулга байсан онцлогтой. Эдгээрийн нэг нь морьтой оршуулга байсан бол нөгөөх нь морьгүй, нэлээд өвөрмөц сонин оршуулга байжээ. Морь дагуулсан булшинд хүнийг адууны дээр тавьсан байсан нь ихэд тоногдож эмх замбараагүй болсон байв. Харин хүний оршуулгын дороос хоньчилон хэвтүүлсэн

байдалтай эмээл, хазаар бүхий тоног хэрэгсэлтэй морины яс анхны тавилтаараа олджээ. Нөгөө нэг түрэг булш хэмээн үзэж байгаа оршуулганаас даавуу бүхий ширэн уут мэт зүйлд боолттой чандар маягийн зүйл бүтэн хоромсого, хүрэл тоногтой агсарга бүс, чичлүүр хутга, харвуулын зэв, төмөр ооль зэрэг уг булшны он цагийн баримжааг гарцаагүй илтгэх эд өлгийн зүйлсийн хамт илэрч олдсон нь тус бүс нутгийн төдийгүй манай орны нутаг дэвсгэрээс ийм төрлийн дурсгал олдсон анхны тохиолдол боллоо. Энэ нь түүхэн эх сурвалжийн мэдээг бататгах шинэ сэргэг баримт болж буйгаараа эрдэм шинжилгээний онцгой ач холбогдолтой юм.

Малтлага судалгааны ажлын гэрэл зургийн баримтжуулалт

Дурсгалуудын дараас ба оршуулга

Малтлага судалгааны ажлын гар зургийн баримтжуулалт



Булшны дэвсгэр зургууд



Оршуулгын дэвсгэр зургууд

ШУА-ИЙН ТҮҮХ, АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН, СУИС-ИЙН СУС-ЫН ХҮРЭЭЛЭН ХАМТАРСАН "ХАТНЫ БУЛГИЙН НУУЦААС" ТӨСӨЛ

С.Өлзийбаяр, Б.Баатархүү, Б.Очир

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг Хатны булаг орчимд: Хэрэм шивээнүүдийн холбогдох он цагийн талаар тодруулах бололцоотой байж болох байгууламжуудаас сонгон малталт хийсэн болно. Тухайлбал, №1-р хэрмийн дотор (Б-1 буюу байршилын дэвсгэр зураг дээр 1 гэж тэмдэглэгдсэн), Бунхант болон Тахилт хоорондын аманд хүрэл, төмрийн түрүү үед холбогдох бунхант булш (Б-2 буюу байршилын зурган дээр 5 дугаартай тэмдэглэгдсэн), Бунхант хүрэнд тахилын байгууламж (Б-3), Зүүн шивээ уулын энгэрт 2 ш хоосон өрлөг (Зүүн шивээ Б-1, Б-2), дундад үеийн булш (Зүүн шивээ Б-3 байршилын зурган дээр 18 дугаартай), Баруун хөшөөтөд 2 хоосон байгууламж (Баруун хөшөөт Б-1,2 буюу дэвсгэр зурган дээр 24 дугаартай) тус бүр малтав.

Б – 1: Хэрмийн дотор барилгын илт мэдэгдэх туурь байхгүй тул эдгээрийн он цагийг баримжаалах, зориулалтыг тодруулах боломжийг олохын тулд энд малталт хийж үзэв. Хөрсөн дээр мэдэгдэх чулуунуудыг үндсэнд нь хамруулан, 3х3м хэмжээтэй талбайд өнгөн хөрсний цэвэрлэгээг 10см гүн хийв. Цэвэрлэгээний явцад талбайн хойд болон төв хэсгээс үнсний ором, шатсан модны үлдэгдэл, шатсан болон шатаагүй явуунууд олон тоогоор илэрч байлаа. Талбайн бүх л хэсгээс хар, шар, саарал өнгийн паалантай, паалангүй янз бүрийн вааран савны хагархайнууд, хөх хээтэй цагаан шаазангийн эмтэрхий олдож байв. Талбайг цэвэрлэж дуусахад төв хэсгээс төмөр тогооны амсар хэсгийн хагархайнууд илрэв.

Б – 2: Бунхант хүрээний баруун бэл, булгийн арын уулсын зүүн хярыг заагласан жалгын зүүн дэнж дээр уг байгууламж оршино (уг жалганы баруун дэвцэгт ууланд шахан үйлдсэн 3м орчим чулуун овоолго буюу өл бий). Энэ зайнд хойноос урагш уулнаас доош буух гүнзгий жалгын баруун ирмэг дээр 9х7м дундаж хэмжээтэй эрт цагт хүний гараар бүтээгдсэн шороо чулуун овгор байх ажээ. Гол байгууламжийн баруун талд 20м зайд хоорондоо 1м зайгаар тусгаарлагдсан 8 ш зэл чулууд 15м-т нэгэн эгнээ үүсгэн байрлана. Зэл чулууд дөрөв дөрвөөрөө хоёр хэсэгт хуваагдсан байдалтай ба хоорондоо 3м зайтай. Өнгөн хөрсний цэвэрлэгээний дараа уг байгууламжийн анхны төрхийг тодруулав. Түүний голын өндөр хормойгоос 150см, дөрвөлжин суурьтай ба дээш шууж, өрсөн бунхан хэлбэртэй. Бунхны зүүн талын хашлагын төв хэсгийн суурийг хавтгай том чулуудыг босгож үйлдсэн. Урд, баруун талыг зүүн хэсгийн адил хавтгай чулуудыг хавиргалан босгож хийгээгүй, том хэлбэргүй чулуудыг давхарлан өрөх замаар хийжээ. Хойд талыг тэр чигт нь том чулуудыг давхарлан өрж гаргасан хана хашлагатай. Бунхны орой хэсэгт үлдээсэн өрх буюу цооног нь 2х1,5м хэмжээтэй баруунаас зүүн тийш сунасан дугариг зууван хэлбэрийн чулуугүй хоосон хонхорхой болно. Хөрсний цэвэрлэгээний дараа орой хэсэгт мэдэгдсэн өрх буюу чулуугүй хонхор өнгөн хөрс хүртэл үргэлжилсэн нь уг бунхны төвд хоосон зай үлдээн

түүнийг тойруулан чулуу өрж өндөрлөх аргаар хийснийг харуулна. Бунхны үндсэн хэсэг болох хоёр хашлагын дотор зай (ханын дотор талын хэмжээсээр) 520см болох бол голын чулуугүй хоосон зай дунджаар 200см байна. Баруун хашлагын гадна манаас суурь хэсгээрээ 230см хүртэл үргэлжлэх бөгөөд захаасаа хана хүртэл аажим өндөрсөж, ханын хэсгээр хамгийн өндөр буюу 120см хүрнэ. Энэхүү байгууламжийн төв хэсэгт, бунхны түвшингөөс 30см, байгууламжийн оройгоос 180см-ийн доор чулуун хашлагын хэлбэр дагуу буюу толгойн талыг нь зүүн хойд зүгт хандуулан түрүүлгээр хэвтүүлсэн оршуулга илрэв.Ясны хадгалагдалт маш муу, гавал байхгүй ч нэг ширхэг шүд илэрсэн. Нугалам нурууны 3-н үе, зүүн гарынх нь бугалга хэдэн хэсэг хугархай, шууных дээд хэсгийн хугархай, зүүн хөлийх нь шилбэний ясны гол хэсэг, баруун хөлийх нь шилбэний доод хэсэг зэрэг хэдэн хэсэг хугарч бяцарсан ч анхны тавилтаараа байв. Дагалдуулсан элдэв эд өлгийн зүйл байсангүй. Оршуулгын ясыг авч доош болон хашлагын бусад хэсэгт шалгалт хийхэд байгалийн хөрс гарсан тул малтлага дууслаа. (Зураг № 1. Б-2. Бунхны дотоод бүтэц, оршуулга).

Дэвсгэр зураг № 1. Б-2. Байгууламжийн дэвсгэр зураг (бунхан ба түүнтэй холбоотой байж болох зэл чулуудын хамт)

Б – 3: Б-2 дурсгалаас урд зүгт 300м зайд харьцангуй жижиг чулуу түүж овоолсон өрлөг байна. Чулуун овоолгын дээгүүр элс шороо шигэж, хажуу хормойгоор нь бут харгана ургажээ.Нэгэн ижил төрлийн дурсгалын төлөөлөл болох эдгээр сул чулуун овоолгуудыг зориулалт, он цагийг урьдчилан тогтоох зорилгоор малтан судлах шаардлагатай хэмээн үзэж, эдгээрээс арай тусдаа (дагуул биш) байгууламжийг ийнхүү Б-2 гэж дугаарлан малтав. Энэхүү өрлөгийн эхний бүтцийг тодруулах үүднээс өрлөгийн дээгүүр бүрхсэн сул элс, шороог буулган цэвэрлэв. Энэхүү өрлөг чулуу нүхний амсар тагласан бус, газрын хөрсөн дээр сул овоолжээ. Зүүн хагасын чулуудыг авах явцад чулуун дундаас булгийн орчмын хэрмүүдийн дотроос түүврээр олддогтой адил хэв шинж бүхий ваар савны хагархайнууд болон төмөр эдлэлийн хугархай үлдэгдэлүүд, малын ясны хугархай хэлтэрхийнүүд илэрч байсан юм. Тиймээс энэхүү байгууламж овоолго нь уг хэрмийн оршин байсан цагаас эртгүй үйлдэгдсэн болох

илэрхий. Уг овоолго нь сууриараа дунджаар 3м голчтой, зөв дугуй хэлбэртэй дороос нь дээш овоолох замаар үйлдсэн өрлөг болно. Овоолгын дотор ямар нэгэн хашлага, хүрээ, дараас гм дотоод бүтэц илрээгүй, тойргийн захаас гол хэсгийг өндөрлөх маягаар чулуу овоолжээ. Овоолгын өндөр гол хэсэгтээ 85см болно.



Дэвсгэр зураг №2. Б-3 байгууламжийн чулуун өрлөг, хөндлөн огтлол

Зүүн шивээ Б – 1, Б-2: Зүүн шивээ хэмээх хэрмийн дотор шивээ орших толгойн урд энгэрт ойролцоо орших, тус бүр 2–3м голч бүхий хэмжээний гурван цагариг байгууламж байгаагийн зүүн талд зэрэгцээ оршино. Эдгээр нь ойролцоогоор 1м голч бүхий өрхтэй (голд нь ганц нэг л чулуу бий), түүнийг хүрээлээд 80-аад см өргөн далан бүхий цагирагтай. Өргөрөгийн чиглэлд ялимгүй сунасан буюу бүх гадна хаяаг хамруулаад 380х360см харьцаатай цүлхэрдүү далан болно. Бид эдгээр байгууламжийг цөөхүүл бүлэглэсэн хүннү булш байх магадлалтай хэмээн урьдчилан үзсэн билээ. Баримтжуулалтын дараа төв цэг дайруулан хөндлөн зүсэн урд хэсгийн талыг авч доош үргэлжлүүлэв. Далангийн өрлөг дан чулуун үе болох ба ихээхэн сийрэг байдалтай болно. Чулуун өрлөг нүхний амсар дарсан болон эмжсэн шинж үл мэдэгдэх тул бүх талбайгаар өрлөгийг хуулан өнгөн үеийг ховхлон 25см хүртэл гүнзгийлэн тэгшлэв. Малтлагын талбайн төв хэсэгт 1х0,5м харьцаатай хөндлөн байрлалтай нүхний толбо мэт зурвас мэдэгдсэн ч дахин 20см гүнзгийлэн үзэхэд алга болж, байгалийн хөрс үргэлжлэв. Эдгээр байгууламж нь хөрсөн дээр сул чулуу

цагираг хэлбэртэй өрсөн ямар нэгэн нүхний амсар дарж эсвэл хүрээлүүлэн эмжсэн дараас биш нь тодорхой болов.



Дэвсгэр зураг № 3. Зүүн шивээ Б-1, Б-2 байгууламжийн дэвсгэр зураг

Зүүн шивээ Б – 3: Зүүн шивээг тойрсон хэрмийн дотор зүүн урд ханаы ойролцоо 3м голчтой голдоо чулуугүй, одоо цагийн хөрснөөс дээш дунджаар 30см орчим өндөр цухуйсан цагариг чулуун дараас байна. Энд оршуулсан булшийг үйлдэхдээ зүүн хойш ялимгүй хазайсан 45-50см өргөн, 180см урт дугуйвтар булантай нүх 90см гүн ухаж, нэжгээд төмөр гархи, зэс хадаасан тоногтой нарийн банзан хүрээ засан түүний дотор эрүүг нь зааж салгасан хонины толгойг хоншоорыг хойш нь чиглүүлэн зулай хэсгээр нь хөнтрүүлэн тавиад магадгүй уг хонины дөрвөн шийр, нуруунаас салган төлөөлүүлэн зулж (магадгүй шийрийг салгалгүй үлдээсэн нэхийнд нь таван цул эрхтэн, нурууны нугаламаас төлөөлүүлэн боож зүлдэлсэн байж болно) дэвсээд хүнээ баруун хажуугаар атируулан хойш чиглүүлэн хэвтүүлжээ. Хонины толгойн дээр талийгчийн эдлэж асан шаазан аягийг хөмрүүлэн тавьсан ба нурууны тушаа нумын элэгний наалт тавин нүхийг шороогоор дүүргэн, чигжиж овоолоод хормойг нь чулуугаар эмжин хүрээлүүлэн манасан байна. Уг булшны оршуулгын зан үйл онцгой анхаарал татах бөгөөд дундад зууны монгол оршуулгаас олон талаар ялгарч байна. Эндээс илэрсэн шаазан аяга нь манай улсын нутгаас анх удаа олдож буй төдийгүй тухайн булшны он цагийг нарийвчлалтай тогтооход чухал хэрэглэгдэхүүн болно. Үүний зэрэгцээ ижил төрлийн шаазангийн хагархай булгийн орчмын хэрмийн тууриудаас түүврээр олдсон (Хэрэм №1, Зүүн шивээ) явдал нь энэ булш хийгээд хэрмийн он цагийг тодруулахад үнэт хэрэглэгдэхүүн болно.



Дэвсгэр зураг № 4. Зүүн шивээ Б-3 байгууламжийн дэвсгэр зураг

Цахим сүлжээнд тавигдсан шаазангийн каталоги зэргээс үзэхэд уг эдлэл Мин улсын үед дэлхийн шаазангийн нийслэл гэгдэх **Цзиндэчжэнь, 景德鎮 хотод** хийгдсэн хөх, цагаан төрлийн луу дүрслэлтэй хэлбэрт багтах нь дамжиггүй байна. Мин улсын эхэн үе буюу XV зуун[1], мөн Мин улсын сүүл хир буюу 1560-1590 ээд онд[2] хийгдсэн тухай ялимгүй зөрүүтэй мэдээлэл тавигджээ. Уг булшны он цаг нь ийнхүү хожуу дундад үе буюу XV-XVI зуунаар тогтоогдож байгаа нь шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой. Булшинд бурхны шашны соёлын эдлэл илрээгүй нь магадгүй халх даяар шарын шашин суртал нэвтрэхээс өмнөх үед холбогдож болно. Энэ цагаас хойш монгол нутагт нас барагчаа газарт булшлан оршуулах зан үйл улирч, шашны суртлын ёсоор ил задгай хөдөөлүүлэх болсон бололтой. Тиймээс бид уг оршуулгыг Шарын



шашны суртал хүчтэй дэлгэрэх болсон үеэс өмнө буюу XV зуунаас хожуугүй хийгдсэн хэмээн үзэж байна.

[1] http://ancientpoint.com/imgs/a/b/d/v/u/15thc_ming_dynasty_blue_white_vase_designed_plate_bowl_signed_5_lgw.jpg

[2] *late Ming blue and white bowls (Part 2)//* https://www.youtube.com/watch?v=HveqhmMY2Nc, http://www.trocadero.com/stores/brianpage/items/1343902/Chinese-Ming-Dynasty-Porcelain-Bowl-Dragon/enlargement11

Баруун хөшөө Б-1, Б-2: Хатны булгаас баруун зүгт 5км орчим зайд арын өндөр хүрэн зоо нурууны баруун үзүүр хэсгийн нэгэн толгойн урд энгэрт цагариг чулуун дараас бүхий хэдэн дурсгал бий. Уг дурсгал байршилын зургийн № 26-т тэмдэглэгдсэн болно. Эдгээрээс зүүн урд захын буюу толгойн арын харьцангуй тэгш талбай дээр орших (бусад ижил төрлийн булш уулын энгэр, жалгын нөгөө этгээдэд байрлах аж)хоёр байгууламжийг сонгон малтав. Хөрсөн дээр дээрх байгууламжууд дунджаар 3х2,5м харьцаатай, өргөрөг чиглэлд ялимгүй сунасан зуувандуу хэлбэртэй. Бүх баримтжуулалт хийсний дараа чулуун дараасын талбайгаар тус бүр 25см хүртэл малтахад ямар нэгэн нүхний толбо эс илрэв.



Зураг № 5. Баруун хөшөө Б-1, Б-2 Байгууламжийн дэвсгэр зураг

Дүгнэлт: Хатны булаг орчимд оршуулгатай 2 булш (Зүүн шивээ № Б-3, Хатны булаг № Б-2), оршуулгын зориулалтгүй 5 байгууламж (Хатны булаг № Б-3, Зүүн шивээ № Б-1, Б-2, Баруун хөшөөт № Б-1, Б-2) нийт 7 хэсэг газар малтлага хийлээ. Эдгээрээс бунхант булш буюу Б-2 байгууламж нь манай орны говь, тал хээрийн нутгаар цөөнгүй тэмдэглэгдсэн м.э.ө. II мянган жилийн эхэн, дунд үед голдуу холбогдох элгээр нь харуулж хэвтүүлэн оршуулах зан үйлийн төлөөлөл болно. Харин нөгөөх нь буюу Зүүн шивээ № Б-3 булш дундад зууны монгол оршуулгын газарт булшлах зан үйлийн сүүлийн хэлбэр болох ба урьд өмнө мэдэгдэж байгаагүй шинэ хэлбэрийн дурсгал болно.



Дэвсгэр зураг №4. Хатны булаг орчмоор тэмдэглэгдсэн дурсгалуудын байршил улаанаар м тэмдэглэгээтэй нь малтсан дурсгал

Илтгэлийн зохиогчдын танилцуулга

Монгол судлаачид

Алдармөнх П.	БНСУ-ын Сөүлийн их сургууль
Алтансүх Б.	Соёлын өвийн төв
Амарболд Э.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Амартүвшин Ч.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Амгалантөгс Ц.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Ангарагдөлгөөн Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Анхбаяр Б.	Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
Анхсанаа Г.	Соёлын өвийн төв
Ариунболд Г.	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Баатархүү Б.	Соёл Урлагийн Их Сургууль
Бадма-Оюу Б.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Батбаяр Т.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Батболд Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Батболд Н.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Батдалай Б.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Батсайхан З.	Монгол Улсын Их Сургууль
Батсүх Д.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Баттулга Ц.	Монгол Улсын Их Сургууль
Бат-Эрдэнэ С.	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Баяндэлгэр Ч.	Монголын үндэсний музей
Баярсайхан Ж.	Монголын Үндэсний Музей
Баярхүү Н.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Болдбаатар Ю.	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Болорбат Ц.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Болормаа С.	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Бөхчулуун Д.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Буянхишиг Ц.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Бүрэнтөгс Г.	Соёлын өвийн төв
Бямба-Очир Ц.	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Бямбасүрэн Х.	Ховд Их Сургууль
Ванчигдаш Ч.	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Галдан Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Гантулга Ж.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Гүнчинсүрэн Б.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Далантай С.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Дэлгэрмаа Л.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Ерөөл-эрдэнэ Ч.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Жаргалан Б.	АНУ-ын Ийелийн Их сургууль
Идэрхангай Т.	Улаанбаатарын Их Сургууль
Ишцэрэн Л.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Лхүндэв Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Мандах Д.	БНХАУ-ын Ухань Их Сургууль
Маргад-Эрдэнэ Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн

Мижиддорж Э.	Улаанбаатарын Их Сургууль
Мөнхбаяр Л.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Мөнхбат Н.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Мөнхбаяр Ч.	Ховд Их Сургууль
Мөнхтулга Р.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Мягмарсүрэн Б.	Соёлын өвийн төв
Нямхүү М.	Өвөрмөц шийдэл ХХК
Одбаатар Ц.	Монголын Үндэсний Музей
Оюунбилэг З.	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Одбаяр З.	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Одмагнай Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Одсүрэн Д.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Олзбаяр Г.	Монгол Улсын Их Сургууль
Оргилбаяр С.	Улаанбаатарын Их Сургууль
Очир А.	Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
Очир Б.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Өлзийбаяр С.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Өнөрбаяр Б.	Хэнтий аймгийн Баянмөнх сумын Соёлын Төв
Пүрэвдорж Г.	Ховд Их Сургууль
Сүхбаатар Б.	Ховд Их Сургууль
Төгссайхан Р.	Монголын Цэргийн Түүхийн Музей
Төрбат Ц.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Төрбат Р.	Монгол Улсын Их Сургууль
Түвшинжаргал Т.	Монголын Үндэсний Музей
Түмэн Д.	Монгол Улсын Их Сургууль
Халиун Г.	Соёлын өвийн төв
Хантөгс Т.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Хатанбаатар Д.	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Цамбагарав Ж.	Хархорум музей
Цогтбаатар Б.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Цэвээндорж Д.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Цэнд Д.	Улаанбаарын Их Сургууль
Цэрэндагва Я.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Цэцэгжаргал Ц.	Монгол Улсын Их Сургууль
Чинбат Ч.	Соёлын өвийн төв
Чулуун С.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Эгиймаа Ц.	Монголын Үндэсний Музей
Энхбат Г.	Соёлын өвийн төв
Энхбаяр Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Энхболд С.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Энхтөр А.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Энхтуул Ч.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Эрдэнэ Б.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Эрдэнэ М.	Монгол Улсын Их Сургууль
Эрдэнэ Ж.	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тунлаугийн Их Сургууль
Эрдэнэбаатар Д.	Улаанбаатарын Их Сургууль

Эрдэнэбат Л.	БНСУ-ын Тежоны Их Сургууль
Эрдэнэбат У.	Монгол Улсын Их Сургууль
Эрдэнэболд Л.	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Эрдэнэ-Очир Н.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Эрдэнэсувд С.	Хэнтий аймгийн музей
Эрдэнэцогт Т.	Соёлын өвийн төв
Эрэгзэн Г.	ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн

Гадаад судлаачид

Ахмэт Ташагыл.	БНТУ-ын Едитэпэ Их Сургууль
Ашык А.	БНТУ-ын Эгумэнэ Их Сургууль
Базаров Б. А.	ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Түвэд, Буддын судлалын хүрээлэн
Бартон Л.	АНУ-ын Питсбургийн Их Сургууль
Бернард В.	Францын Ренний Их Сургууль
Бросседер У.	ХБНГУ-ын Бонны Райны Фридрих-Вильхельм Их Сургууль
Варенов А.В.	ОХУ, Новосибирскийн Улсын Их Сургууль
Врайт Ж.	ИБУИВУ-ын Абердины Их Сургууль
Гарднер У.	АНУ-ын Ийелийн Их Сургууль
Гиллиланд С.	АНУ-ын Калифорнийн Үндэсний Парк
Заззо А.	Францын Байгалийн Түүхийн Музей
Звинс Н.	АНУ-ын Калифорнийн Девисийн Их Сургууль
Ивлиев А.Л.	ОХУ-ын Алс дорнодын түүх, археологи, этнографийн хүрээлэн
Изүхо М.	Япон улсын Токио Метрополитан Их Сургууль
Йылмаз А.	БНТУ-ын Едитепе Их Сургууль
Кан Хён.	БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн
Крадин Н.Н.	ОХУ-ын Алс дорнодын түүх, археологи, этнографийн хүрээлэн
Ким Сон-Ми.	БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн
Кыдырали Д.	БНТУ-ын Олон улс судлалын хүрээлэн
Ковалев А.А.	Санкпитербургийн Их Сургууль
Ковычев Е.В.	ОХУ-ын Өвөр Байгалын Хүмүүнлэг-Боловсролын Их Сургууль
Коннорс Р.	Anza Borrego Dessert State Park
Лепец С.	Францын Байгалийн Түүхийн Музей
Магай Ж.	Монакогийн Нэн Эртнийн Түүхийн Музей
Масойч М.	БНПольш улсын Врославын Их Сургууль
Мацукава Т.	Япон улсын Отани их сургууль
Мацуда К.	Япон улсын Осакагийн олон улсын их сургууль
Муроака Х.	Япон улсын Рюкокү их сургууль
Мураками Я.	Япон улсын Эхимэ Их Сургууль
Миямото К.	Япон Улсын Кюүшү Их Сургууль
Миягашев Д. А.	ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Түвэд, Буддын судлалын хүрээлэн
Миякэ Т.	Япон Улсын Шүкүтокү Их Сургууль
Морган К.	АНУ-ын Невада Их Сургууль

Напил Б.	БНТУ-ын Олон улс судлалын хүрээлэн
Нельсон Р.	АНУ Вайоминг
Осава Т.	Япон улсын Осака Их Сургууль
Пак Сон-Ху.	БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн
Розен А.	АНУ-ын Техасын Их Сургууль
Рооланд Х.	Монгол Германы хамтарсан Орхон экспедици
Рыбин Е.П.	ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Археологи, угсаатан зүйн хүрээлэн
Сагава М.	Япон Улсын Тоохокү Гакүин Их Сургууль
Сайто Ш.	Япон Улсын Осака Их Сургууль
Салисис К.	Францын Альп, Газрын дундад тэнгисийн эртний археологийн хүрээлэн
Саранбилэг Ч.	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Соёлын өв, Археологийн хүрээлэн
Шикүлски Ю.	БНПольш улсын Врославын Их Сургууль
Сасада Т.	Япон Улсын Эхимэ Их Сургууль
Ташагыл А.	БНТу-ын Эгумэнэ Их Сургууль
Тэйлор У.	АНУ-ын Нью Мексикийн Их Сургууль
Умиров К.	БНТУ-ын Олон улс судлалын хүрээлэн
Үсүки И.	Япон Улсын Саппора Гакүин Их Сургууль
Фаркухар Ж.	АНУ-ын Питсбургийн Их Сургууль
Франкен К.	ХБНГУ-ын Археологийн хүрээлэн
Ханичёрч У.	АНУ-ын Ийелийн Их Сургууль
Чарьлз Ф.	АНУ-ийн Аризонагийн Их Сургууль
Чон Чүн-Хуа.	БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэн
Чэн Ёнжи.	БНХАУ-ын Өвөр Монголынөөртөө засах орны Соёлын өв, Археологийн хүрээлэн
Чен Пэнфэй.	БНХАУ-ын Өвөр Монголынөөртөө засах орны Соёлын өв, Археологийн хүрээлэн
Р.Чиолек-Торелло,	АНУ-ын "Statistical reasearch" төв
Ширайши Н.	Япон Улсын Нийгата Их Сургууль
Шнайдер Ж.	АНУ-ын Калифорнийн Үндэсний Парк
Янз Л.	Канадын Терентийн Их Сургууль